



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
СУРГАЛТЫН
ХҮРЭЭЛЭН

ПАРЛАМЕНТ



СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

БОТЬ
40

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

“ПАРЛАМЕНТ”

(Судалгааны эмхэтгэл)



- Эрх зүй, төрийн байгууллын судалгааны хэсэг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ННА-67.3
ДАА-340.009
П-183

“Парламент” судалгааны эмхэтгэл (40 дүгээр боть)-ийг
Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа,
сургалтын хүрээлэнгээс эрхлэн гаргав.

Хянасан: Ц.Цогзолмаа
Ц.Норовдондог (Ph.D)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл
Р.Оргилмаа

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Т.Цэнд-Аюуш

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УИХ-ын Тамгын газар ©
“ПАРЛАМЕНТ” СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ - БОТЬ 40

ISBN 978-9919-9806-9-6

ГАРЧИГ

I БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

- 1.1. Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо ба эрх зүйн зохицуулалтын зарим асуудал: Бусад орнуудын туршлага (СТ-22/204)..... 6
Б.Буянзаяа, Г.Билгээ, П.Уранчимэг, Ц.Ариунаа, Б.Туул
- 1.2. Ерөнхий сайдын мэдээлэл, асуулт хариултын дэгийн зарим зохицуулалт: Бусад орнуудын туршлага (СТ-22/206)..... 41
Ц.Норовдондог (Ph.D), Р.Нургүл, Б.Батцэцэг, Б.Туул, П.Уранчимэг
- 1.3. Гүйцэтгэх ажлын эрх зүйн орчин, хэрэгжүүлэгч байгууллагууд ба хяналтын тогтолцоо: Монгол Улс болон гадаадын зарим улсын туршлага (СТ-22/210) 61
Б.Буянзаяа, Г.Билгээ, Ц.Ариунаа, Б.Туул, П.Уранчимэг
- 1.4. Шүүхийн шинжээчийн дүгнэлт, түүнийг үнэлэх эрх зүйн зохицуулалт: Гадаадын зарим орны туршлага (СТ-22/211)..... 125
Б.Буянзаяа, Г.Билгээ, П.Уранчимэг, Ц.Ариунаа, Б.Туул
- 1.5. Дэлхийн улс орнуудын хууль тогтоох байгууллагын бүтэц (СТ-22/304)..... 143
О.Нарантуяа
- 1.6. Дэлхийн улс орнуудын хууль тогтоох байгууллагын бүрэлдэхүүн (СТ-22/305)..... 168
Р.Оргилмаа
- 1.7. Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн тогтолцоо (СТ-22/306)..... 189
Д.Халиун
- 1.8. Парламентын гишүүний үүрэгт үл хамаарах ажил, албан тушаал хавсран ажиллах тухай Үндсэн хуулийн зохицуулалт (СТ-22/307)..... 254
Д.Жигваагүнсэл
- 1.9. Ерөнхийлөгчийн сонгуулийн талаарх парламентын засаглалтай орнуудын Үндсэн хуулийн зохицуулалт (СТ-22/308)..... 284
Г.Билгээ

1.10. ХБНГУ, АНУ-ын хууль зүйн толь бичгийн талаарх товч мэдээлэл (СТ-22/401).....	340
<i>Б.Буянзаяа, Г.Алтан-Оч (Ph.D), П.Уранчимэг</i>	
1.11. Гадаадын зарим орны Засгийн газрын бүтэц (СТ-22/402).....	350
<i>Г.Билгээ, Ц.Ариунаа, Б.Туул</i>	
1.12. Парламентын сонгуулийн тогтолцоо, парламентын гишүүдийн тоо ба түүнийг тогтоох, тооцох зарчим (СТ-22/405).....	376
<i>Г.Билгээ, Д.Халиун</i>	
1.13. Улс төрийн намын үзэл баримтлал, дэлхий нийтийн чиг хандлага, улс төрийн нам байгуулах босго, гишүүнчлэл болон сонгуулийн пропорциональ систем: Олон улсын туршлага (СТ-22/406).....	398
<i>Ц.Норовдондог (Ph.D), Г.Билгээ, Д. Аюуш, Б.Буянзаяа, П.Уранчимэг, Б.Туул, Р.Дэлгэрмаа</i>	

БҮЛЭГ I

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

ТОЙМ АГУУЛГА

- Зөвшөөрлийн тухай
- Ерөнхий сайдын мэдээлэл
- Шинжээчийн дүгнэлт
- Үндсэн хуулийн зохицуулалт
- Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн
- Парламентын бүтэц, бүрэлдэхүүн
- Сонгуулийн тогтолцоо
- Улс төрийн нам

**ЗӨВШӨӨРӨЛ (ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ)-ИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ ТАВИХ ТОГТОЛЦОО БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ:
БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Б.Буянзаяа, Г.Билгээ П.Уранчимэг,
Ц.Ариунаа, Б.Туул*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

ЗӨВШӨӨРӨЛ (ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ)-ИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ ТАВИХ ТОГТОЛЦОО БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ:
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

- 1.Эрх зүйн орчны хүрээ ба зохицуулалтын зорилго
- 2.Зөвшөөрлийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо
- 3.Зөвшөөрлийн нэр төрөл, тоог тогтоох, өөрчлөлт оруулах процедур
- 4.Зөвшөөрлийг дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаар олгох

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Зөвшөөрлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо ба эрх зүйн зохицуулалтын зарим асуудал: бусад орнуудын туршлага” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг гүйцэтгэв.

Судалгаанд захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу гадаадын зарим орнуудад олгодог зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн төрөл, зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн жагсаалтад өөрчлөлт оруулах, зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийг дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаар олгох, зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-д хяналт тавих механизм зэрэг асуудлуудыг эрх зүйн орчны хүрээнд харьцуулан судаллаа.

Судалгаанд дараах орнуудыг хамруулсан:

- Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ);
- Шотланд Улс;
- Сингапур Улс;
- Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг (ТУХН)-ийн улсууд:
 - Азербайжан Улс;
 - Армени Улс;
 - Гүрж Улс;
 - Казахстан Улс;
 - Киргиз Улс;
 - ОХУ;
 - Узбекистан Улс.

Судалгааны хамрах хүрээ:

Судалгаанд авагдсан орнуудын холбогдох хууль, эрх зүйн орчны хүрээнд төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) эрхлэх үйл ажиллагааны зохицуулалтад хамаарах асуудлуудыг доорх хүрээнд судаллаа. Үүнд:

- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо буюу арга механизмын талаар;
- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, санал, дүгнэлт гаргах болон хяналт тавих чиг үүрэг бүхий зохион байгуулалтын бүтэц (тухайлбал, Олон нийтийн зөвлөл)-ийн эрх зүйн байдал, бүтэц бүрэлдэхүүн, санхүүжилтийн талаар;
- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн тоо буюу төрлүүдийг тогтоох, түүнд өөрчлөлт оруулах талаар;
- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийг дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаар олгох гэх мэт асуудлуудыг хамруулсан.

Түлхүүр үг: тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, лицензийн зөвлөл, лиценз, лиценз олгох, лицензтэй эрхлэх үйл ажиллагаа, зөвшөөрөл болон лицензийн систем, лицензийн комисс

Key words: licences, permits, licensing-board.

Ключевые слова: лицензия, лицензирования, лицензируемый вид деятельности, разрешение, система лицензий и разрешений, лицензионный совет, лицензионный комиссия.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Оксфордын англи хэлний толь бичигт “**тусгай зөвшөөрөл**” (licence) гэж “эрх бүхий байгууллагаас хэн нэгэнд олгосон ямар нэгэн зүйлийг хийх, өмчлөх, эзэмших, ашиглах зөвшөөрөл” гэж тодорхойлсон бол “**зөвшөөрөл**” (permission) гэдгийг “хэн нэгэнд ямар нэгэн зүйл хийхийг албан ёсоор зөвшөөрөх ажиллагаа, эсхүл эрх олгосон албан ёсны баримт бичиг” хэмээн тайлбарласан.

Түүнчлэн Кембрижийн толь бичигт “**тусгай зөвшөөрөл**” (license) гэдгийг “хэн нэгэнд ямар нэгэн зүйлийг хийх болон эзэмших эрх буюу албан ёсны зөвшөөрөл олгох” гэж тайлбарласан бол “**зөвшөөрөл**” (permission) гэдгийг “хэн нэгэнд ямар нэгэн зүйл хийхийг зөвшөөрөх, эсхүл ямар нэгэн зүйл тохиолдохыг зөвшөөрсөн баримт бичиг” хэмээн тус тус тайлбарлажээ.

Хэл зүйн тайлбар талаас нь үзвэл “тусгай зөвшөөрөл” гэдэг нь аливаа үйл ажиллагаа явуулах, өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон өргөн цар хүрээтэй үйлдэл бол “зөвшөөрөл” гэдэг нь зөвхөн аливаа зүйлийг хийх зөвшөөрөл олгох үйлдэл буюу үүнийг гэрчилсэн баримт бичиг хэмээн ойлгогдож байна. Тиймээс хууль зүйн нэр томъёо талаас нь “тусгай зөвшөөрөл” болон “зөвшөөрөл”-ийн ялгаа, заагийг тодорхой болгох нь хуулийн зохицуулалт талаасаа ч, хэрэглээнд хэвшүүлэх талаасаа ч чухал ач холбогдолтой хэмээн үзэж дээрх тайлбарыг авч үзсэн болно.

Улс орнуудын хувьд, тухайлбал, Канад Улсад “тусгай зөвшөөрөл” (licence) нь тухайн үйл ажиллагааг эрхлэх мэргэжлийн үйл ажиллагааны нарийвчилсан стандарт шаардлагыг тодорхойлдог бол “зөвшөөрөл” (permission, permit) нь ерөнхий шинжтэй байна. Жишээлбэл, архины худалдаа эрхлэхэд “зөвшөөрөл” авдаг бол архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэхэд “тусгай зөвшөөрөл” авах шаардлагатай болдог байна.

Монгол Улсын хувьд 2021 онд Хууль зүйн яамнаас эмхэтгэн гаргасан Монгол Улсын “Хууль зүйн нэвтэрхий толь бичиг”-т “**тусгай зөвшөөрөл**” (licentia; license¹) гэж “тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичиг” гэж томъёолсон бөгөөд тус толь бичигт “**зөвшөөрөл**”-ийн талаарх хууль зүйн нэр томъёоны тайлбар одоогоор байхгүй байна.

Иймд Зөвшөөрлийн тухай хуулийн нэгтгэсэн төсөлд “тусгай зөвшөөрөл”, “зөвшөөрөл”-ийн ялгаа зааг, хамрах хүрээ, хууль зүйн тайлбарыг нэр томъёоны хувьд илүү нарийвчлах нь зүйтэй болов уу.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагыг хурангуйлан авч үзвэл:

1. Эрх зүйн орчны хүрээ ба зохицуулалтын зорилго

Судалгаанд нийт 10 орныг хамруулсан. Захиалагчийн хүсэлтэд нийцүүлэн ихэвчлэн бие даасан хуультай орнуудыг сонгон авч судалсан бөгөөд Сингапур Улсаас бусад нь зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн тухай бие даасан хуультай орнууд байна. Эрх зүйн орчны хүрээг авч үзвэл эдгээр орнуудад зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-тэй холбоотой харилцааг тусгайлсан хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам болон холбогдох салбарын хуулиудаар зохицуулж байна.

Судалгаанд авагдсан орнуудад зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг дараах бие даасан хуулиудаар зохицуулж байна:

¹ Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 424 дэх тал.

- 1.Азербайжан *Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хууль (Закон О лицензиях и разрешениях);*
- 2.Армени *Тусгай зөвшөөрөл олгох тухай хууль (Закон О лицензировании);*
- 3.Гүрж *Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хууль (Закон О лицензиях и разрешениях);*
- 4.Казахстан **Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хууль (Закон О разрешениях и уведомлениях);**
- 5.Киргиз *Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тогтолцооны тухай хууль (Закон О лицензионно-разрешительной системе);*
- 6.ОХУ *Зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хууль (Закон О лицензировании отдельных видов деятельности);*
- 7.Узбекистан *Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл ба мэдэгдэл олгох журмын тухай хууль (Закон О лицензировании, разрешительных и уведомительных процедурах);*
- 8.БНХАУ *Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль (Administrative License Law of the People's Republic of China);*
- 9.Шотланд *Тусгай зөвшөөрлийн тухай хууль (Licensing (Scotland) Act 2005);*
- 10.Сингапур Тусгайлсан хуулиар зохицуулаагүй.

Эдгээр хуулиудын зорилго нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, үндэстэн болон олон нийтэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, хамгаалахын зэрэгцээ хязгаарлагдмал нөөцийг зохистой ашиглах, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор тодорхой зарим үйл ажиллагаа, үйлдэлд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгодог байх нийтлэг зорилгод чиглэгдсэн.

Дээрх хуулиудаар зохицуулсан харилцааны зорилго, цар хүрээг багцлан авч үзвэл:

- хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгө, олон нийт, төрийн аюулгүй байдалд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх болон хязгаарлагдмал нөөцийг зүй зохистой ашиглуулах;
- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-өөр зохицуулагдах хүрээг тодорхойлох;
- хувиараа аж ахуй эрхлэгчид болон бусад этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох журмыг тодорхойлох;
- тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих процедур, зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн ангилал, төрлүүд болон холбогдох бусад харилцааг зохицуулахад чиглэгдсэн байна.

Судалгаанаас үзэхэд, зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-тэй холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулахаас гадна тухайн салбарын эрх зүйн орчны хүрээнд нарийвчлан зохицуулж байна. Тухайлбал, **Армени Улсад** эрчим хүч, цахим харилцаа холбоо, усны салбарын тусгай зөвшөөрлийг Эрчим хүчний тухай, Цахим харилцаа холбооны тухай, Телевиз, радиогийн тухай хуулиуд болон Усны тухай кодексоор, **Азербайжан Улсад** зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-тэй холбоотой харилцааг Аж ахуйн нэгжийн тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль болон бусад хууль тогтоомжоор, **Киргиз Улсад** банк санхүүгийн тусгай зөвшөөрлийг банкны тухай хууль тогтоомжоор, **Гүрж, ОХУ**-д ашигт малтмал олборлолт, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Газрын хэвлийн тухай хуулиар, **Шотланд Улсад** театрын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг Театрын тухай хуулиар, кино театрын тусгай зөвшөөрлийг Кино театрын тухай хуулиар тус тус зохицуулах жишээтэй.

Сингапур Улсад зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой бие даасан хууль байхгүй бөгөөд уг харилцааг салбарын хуулиудаар зохицуулж байна. Тухайлбал, банкны тусгай зөвшөөрлийг *Банкны тухай* хуулиар, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг *Барилгын хяналтын тухай* хуулиар, даатгалын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг *Даатгалын тухай* хуулиар, цахилгаан, эрчим хүчний тусгай зөвшөөрлийг *Цахилгаан, эрчим хүчний тухай* хуулиар, тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг Тамхины тухай хуулиар гэх мэтээр зохицуулж байна.

2.Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо:

Судалгаанд хамрагдсан ихэнх орнуудад буюу Армени, Гүрж, Киргиз, ОХУ, Узбекистан, БНХАУ, Сингапур, Шотландад зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хуулийн хэрэгжилтэд түүнийг **олгож буй эрх бүхий байгууллага** хяналт тавьж байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд эрх бүхий байгууллагууд шаталсан, хавсарсан байдлаар хяналт тавих бөгөөд төрийн болон олон нийтийн хяналтыг хослуулан улс орон бүр өөр өөрийн онцлогт нийцүүлэн хяналтын тогтолцоогоо бүрдүүлсэн байна. Түүнчлэн зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) олгох, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах цахим систем, платформуудыг хөгжүүлэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал:

Казахстанд аливаа зөвшөөрөлд төрийн хяналт тавих эрх бүхий байгууллагууд болон **орон нутгийн гүйцэтгэх байгууллагууд, Азербайжанд** зөвшөөрөл олгосон байгууллагууд болон төрийн хяналт тавих эрх бүхий байгууллагууд хяналтыг хамтран хэрэгжүүлж байна.

Судалгааны захиалгад зөвшөөрөл олгох, бүртгэх эрх бүхий этгээд зөвшөөрлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих, зөвшөөрлийн тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөлтэй холбоотой зохицуулалтын талаар дурдсан байв.

Үүний дагуу гадаадын 13 улсын зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн тухай хууль тогтоомжийг судалж үзэхэд **Шотланд Улсад** дээрхтэй төстэй зөвлөл үйл ажиллагаа явуулж байна. Тус улсын тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал, дүгнэлтийг боловсруулах эрх, үүрэгтэй **Абердиний Лицензийн зөвлөл** ажилладаг байна. Зөвлөл нь зарим төрлийн зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй бөгөөд энэхүү эрхээ орон нутагт лицензийн стандарт хариуцсан ажилтнуудыг томилон ажиллуулж хэрэгжүүлдэг. Абердиний Лицензийн зөвлөл нь зарим төрлийн зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй. Тус зөвлөл нь 12 хороотой² ба хороо тус бүр өөрийн хариуцсан асуудлын хүрээнд салбарын асуудлыг нарийвчлан зохицуулсан хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэр гаргах боломжоор хангагдсан байдаг. Тухайлбал, *Лицензийн хороо* нь тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, өөрчлөх, түдгэлзүүлэх асуудлыг хариуцан ажилладаг. *Аудит, эрсдэл, хяналтын хороо* нь дотоод, гадаад аудит, эрсдэлийн удирдлага, засаглал, санхүүгийн асуудлаас гадна хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх эрхтэй.

БНХАУ-д тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллага нь тухайн тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавьж үнэлэлт өгөх боловч захиргааны дээд шатны байгууллага нь тухайн эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрөл олгож буй үйл ажиллагаа, захиргааны

² Энэ тайлангийн 15-р хуудас

тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог улам чангатгах хэлбэрээр ажилладаг бөгөөд гарсан хууль бус үйлдлийг цаг тухайд нь арилган ажилладаг байна. Түүнээс гадна захиргааны тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж гарсан санал, дүгнэлтээ тусгай зөвшөөрлийг тогтоох эрх бүхий байгууллагад хүргүүлэн ажилладаг Захиргааны тусгай зөвшөөрлийн гүйцэтгэх байгууллага ажилладаг байна.

Сингапур Улсад зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг холбогдох салбарын хууль, түүнийг даган гарсан журмаар зохицуулдаг тул зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд тавих хяналтыг тухайн зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) олгосон байгууллага нь хэрэгжүүлдэг байна. Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийг Сингапур Улсын Засгийн газрын холбогдох агентлагууд олгох ба зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) авахаас өмнө Засгийн газрын бүртгэлийн агентлаг болох Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн нэгжийг зохицуулах газарт заавал бүртгүүлсэн байх шаардлагатай бөгөөд бүртгүүлэхдээ зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) авах хүсэлтээ цуг гаргаж болдог. Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийг Засгийн газрын цахим үйлчилгээний платформ болох <https://www.gobusiness.gov.sg> цахим хуудсаар дамжуулан олгох, олон нийтэд мэдээлэл хүргэх, ил тод нээлттэй байдлыг хангах онцлогтой байна.

Тусгаар Улсын хамтын Нийгэмлэгийн (ТУХН)-ийн ихэнх орнуудад зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хуулийн хэрэгжилт, тухайн зөвшөөрөлд тавигдах нөхцөл, тусгай шаардлагын биелэлтэд тухайн зөвшөөрлийг олгосон байгууллагууд хяналт тавьж байна.

Арменид Төв Банк, Төрийн үйлчилгээний зохицуулах хороо, Телевиз, радиогийн үндэсний хороо, Засгийн газраас эрх олгосон яам, агентлагууд зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) олгодог. Эдгээр байгууллагууд нь **Тусгай зөвшөөрлийн хороо** (ТЗХ)-г байгуулах бөгөөд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, цуцлахад тус хорооны дүгнэлтийг үндэслэнэ.

ТЗХ нь өргөдөл гаргагч болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг хорооны хурлаараа хэлэлцэж дүгнэлт гаргах ба энэхүү дүгнэлтээ тусгай зөвшөөрөл олгох байгууллагын даргад шилжүүлнэ.

Тухайлбал, тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий **Телевиз, радиогийн үндэсний хороо** (ТРҮХ) нь телевиз, радиогийн хувийн хэвшлийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөлд заасан нөхцөлийн биелэлт болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх, үүрэгтэй. ТРҮХ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба Ерөнхийлөгчөөс зургаан жилийн хугацаагаар томилно. Тус хорооны дарга, дэд даргыг гишүүдээсээ сонгоно.

Азербайжан Улсад холбогдох тусгай зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-д тавих хяналтыг тухайн зөвшөөрөл олгох салбарын эрх бүхий байгууллага болон хуулиар эрх олгосон төрийн эрх бүхий байгууллага гэсэн 2 субъект хэрэгжүүлдэг байна. Төрийн эрх бүхий байгууллага нь Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуульд заасан үйл ажиллагааны зөвшөөрлүүдэд, харин зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) олгох салбарын байгууллагууд нь салбарын хуулиар олгож байгаа зөвшөөрлүүдэд тус тус хяналт тавина.

Киргизэд зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) олгогч байгууллага нь хууль, Сайд нарын танхимаас баталсан “Зарим төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай журам”-аар тогтоосон тусгай зөвшөөрлийн шаардлагыг тухайн зөвшөөрөл эзэмшигч хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийдэг. Хяналт шалгалтыг дараах байдлаар зохион байгуулдаг. Үүнд:

- тусгай зөвшөөрөл олгохоос өмнөх шалгалт;
- тусгай зөвшөөрөл олгосны дараах шалгалт;

- төлөвлөгөөт бус шалгалт – энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн зөвшөөрлийн шаардлагыг зөрчсөн тухай хувь хүн, хуулийн этгээдийн өргөдөл хүлээн авах, эсхүл хувь хүн, хуулийн этгээдийн мэдээлэл хүлээн авсны дараа тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас хийдэг шалгалт, мөн өмнөх шалгалтаар илрүүлсэн тусгай зөвшөөрлийн шаардлагын зөрчлийг арилгасан эсэхэд хяналт тавих шалгалт;
- төлөвлөгөөт шалгалт – энэ нь тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас өөрийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний дагуу хийдэг шалгалт юм.

ОХУ-д зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хяналтыг зохион байгуулахдаа Төрийн болон хотын хяналт (аудит)-ыг хэрэгжүүлэх, Хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчдийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан журмыг баримталдаг байна. Хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахдаа мөн төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус шалгалт хэлбэрээр хийдэг бөгөөд энэхүү шалгалтын зохион байгуулалтын хэлбэр нь дээр дурдсан Киргиз Улстай ижил байна.

Узбекистанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгогч байгууллага хяналт шалгалтын ажлыг зохион байгуулдаг бөгөөд зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн болон мэдэгдлийн шаардлага, нөхцөлийн биелэлтэд тавих хяналтыг:

- тусгай цахим системээр дамжуулан зайнаас шалгах;
- хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу газар дээр нь очиж шалгах;
- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл), мэдэгдлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх болон тэднээс шаардлагатай мэдээллээ хүсэх зэргээр хэрэгжүүлдэг бөгөөд холбогдох этгээдээс хамааралгүй мэдээлэл хүсэх, шаардахыг хориглодог байна.

Казахстанд аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа хууль тогтоомжоор тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхэд тавих хяналтыг төрийн эрх бүхий байгууллагууд болон орон нутгийн гүйцэтгэх байгууллагууд хэрэгжүүлнэ. Тус улсад Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрлийн хяналтыг:

- аливаа зөвшөөрлийг олгохоос өмнө букуу өргөдөл гаргагчийн тухайн зөвшөөрлийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд,
- аливаа зөвшөөрлийг олгосны дараа тухайн зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжийг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг байна. Зөвшөөрөл олгохоос өмнөх хяналтыг тухайн субъект (объект) дээр очиж шалган тогтоодог байна.

3.Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн тоог тогтоох, жагсаалтад өөрчлөлт оруулах процедур:

Судалгаанд хамрагдсан улс орнуудын хувьд зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн тоог тогтоох, өөрчлөлт оруулах эрх зүйн харилцааг холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохицуулдаг (БНХАУ, Азербайжан, Армени, Гүрж, Казакстан, Киргиз, ОХУ, Узбекистан) байна. Харин зарим орнуудын хувьд зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл) **олгох эрх бүхий** төрийн захиргааны байгууллага (Сингапур) нь үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, өөрчлөх, сунгах, цуцлах асуудлыг шийдвэрлэдэг бол зарим улс оронд Засгийн газрын тодорхой бодлогын асуудлуудыг хариуцан зохицуулах үүрэг бүхий орон тооны зөвлөл (Шотланд) ажилладаг байна. Мөн зарим улсад (БНХАУ) хэдийгээр зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн **харилцааг хуулиар тогтоосон байдаг ч шаардлагатай тохиолдолд Засгийн газар, орон нутгийн хэмжээнд захиргааны зөвшөөрөл олгож болох эрх зүйн зохицуулалтыг ч мөн адил хуульд тусгаж өгснөөрөө онцлогтой байна.**

Тухайлбал, **БНХАУ-д** Захиргааны тусгай зөвшөөрлийг хуулиар тогтоохоор заасан байдаг боловч шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг захиргааны журмаар (Төрийн зөвлөлийн шийдвэр, захиргааны журам, мужийн түвшний Ардын засгийн газрын тогтоолууд хамаарна) тогтоож болохоор тус хуульд зааж өгсөн байдаг.

Захиргааны тусгай зөвшөөрлийг хуулиар тогтоох³ дараах 6 үндэслэлийг заасан байдаг. Үүнд:

- улсын болон олон нийтийн аюулгүй байдал, экологи, хүрээлэн буй орчныг хамгаалах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдалтай шууд холбоотой тусгай үйл ажиллагааг хуулийн шаардлагад нийцүүлэн батална;
- байгалийн хязгаарлагдмал нөөцийг хөгжүүлэх, ашиглах, нийтийн баялгийг хуваарилах, нийтийн ашиг сонирхолд шууд хамааралтай тусгай худалдааг зах зээлд нэвтрүүлэх;
- төрөөс үйлчилгээ үзүүлдэг, нийтийн ашиг сонирхол шууд хамааралтай, тусгай ур чадвар, тусгай нөхцөл шаардсан мэргэжлүүд;
- орчин тойрондоо аюул учруулж болзошгүй тоног төхөөрөмж, барилга байгууламж, бүтээгдэхүүн, эд зүйлсийг стандарт, шалгуурын дагуу үзлэг, туршилт, хорио цээрийн аргаар шалгаж баталгаажуулсан байх;
- мэргэшлийн түвшин тогтоож тусгай зөвшөөрөл олгох байгууллага байгуулах;
- хууль тогтоомжийн дагуу захиргааны тусгай зөвшөөрөл олгож болох бусад асуудлууд.

Хэдийгээр Захиргааны тусгай зөвшөөрлийг хуулиар тогтоохоор заасан ч хуулийн 14 дүгээр зүйлд шаардлагатай тохиолдолд Төрийн зөвлөл тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргаж болох эрхтэй байхаар заасан байна.

Мөн Захиргааны тусгай зөвшөөрлийн талаарх хууль, захиргааны журам хараахан гараагүй ч нэн даруй тусгай зөвшөөрөл тогтоох шаардлага гарсан бол тус хуулийн 12 дугаар зүйлд заасан асуудлын хүрээнд тусгай зөвшөөрлийг орон нутаг захиргааны журмаар тогтоож болохоор хуульчилжээ. Ингэхдээ тухайн аймгийн Ардын засгийн газрын журмаар автономит муж, эсхүл төв Засгийн газрын шууд харьяа хотын захиргаа нь захиргааны түр тусгай зөвшөөрлийг олгох эрхтэй байх бөгөөд уг түр тусгай зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгож, хугацааг сунгах шаардлагатай бол Ардын их хурал, түүний Байнгын хороонд анх олгосон байгууллага санал гаргаж шийдвэрлүүлнэгэж заасан байна.⁴

Шотланд Улсын Абердиний Лицензийн зөвлөл нь тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл бүхий санал дүгнэлтийг боловсруулдаг.

Энэхүү зөвлөл нь 2005 онд батлагдсан Тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан "тусгай зөвшөөрөл олгох" дээд түвшний 5 зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд үйл ажиллагааны бодлогыг боловсруулан ажиллах эрхийг хуулиар өгсөн байна.

Эдгээр 5 зорилго нь:

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
- Олон нийтийн таагүй байдлаас урьдчилан сэргийлэх;
- Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах; болон
- Хүүхдийг хор хөнөөлөөс хамгаалах гэх мэт.

Сингапур Улс нь бие даасан хуульгүй учраас салбарын хууль, түүнийг дагаж гарсан журмаар зохицуулдаг байна. Тухайлбал, тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг Засгийн

³ БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 12 дугаар зүйл

⁴ БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 15 дугаар зүйл

газрын агентлаг болон Анагаах ухааны газар олгох бөгөөд Тамхины тухай хууль, түүнийг дагаж гарсан Тамхины (зар сурталчилгаа, борлуулалтын хяналт, тусгай зөвшөөрөл олгох) журамд заасан нөхцөл шаардлагын дагуу олгох, өөрчлөх, сунгах, цуцлах, хүчингүй болгох шийдвэрийг гаргана.

Армени, Гүрж, Казахстан, Киргиз, ОХУ, Узбекистан улсуудад тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн төрлүүд, эсхүл аливаа зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны төрлүүдийг хуульд тодорхой жагсааж хуульчилжээ. Ийнхүү хуулиар тогтоосон байгаа нь зөвхөн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар уг жагсаалтыг өөрчлөх боломжтойг харуулж байна.

Эдгээр улсууд жагсаалтад өөрчлөлт оруулах шалгуурууд тогтоосон байх тул тэдгээрийг дараах байдлаар багцаллаа. Үүнд:

- эдийн засгийн хөгжлийг дэмжих;
- хүний ба иргэний амь нас, эрүүл мэндэд, хүний амьдрах болон соёлын орчинд хохирол учруулахгүй байх;
- хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахгүй байх;
- үндэсний болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах зэрэг болж байна.

ОХУ-д 2014 оноос орон сууцны барилга барих тусгай зөвшөөрлийг, 2018 оноос биоанагаахын эсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, амьтны хүрээлэн, цирк, усан сан зэрэг зориулалтын газарт амьтдыг арчлах, ашиглах зэрэг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус шинээр олгож эхэлжээ. Цаашид ч техник, технологи хөгжихийн хэрээр тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны жагсаалтыг өргөжүүлэх шаардлага гарч ирж байна. Жишээлбэл, криптовалюта, блокчэйнийг дурдаж болно.

4.Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийг дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаар олгох:

Судалгаанд хамрагдсан улс орнуудад (Азербайжан, Армени, Гүрж, Узбекистан, БНХАУ) сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийг тендер, дуудлага худалдаа зэрэг өрсөлдөөний аргаар зохион байгуулахаар эрх зүйн хувьд хуульчилсан бол зарим улс орнуудад эрх зүйн бусад актаар энэхүү асуудлыг зохицуулж өгсөн байна.

Тухайлбал, **БНХАУ**-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хуульд сонгон шалгаруулалт, дуудлага худалдаатай холбоотой дараах зохицуулалтыг тусгасан байна.

Тус хуулийн 53 дугаар зүйлд зааснаар Захиргааны байгууллага байгалийн хязгаарлагдмал нөөцийг хөгжүүлэх, ашиглах, нийтийн баялгийг хуваарилах, нийтийн ашиг сонирхолд шууд хамааралтай тусгай худалдааг зах зээлд нэвтрүүлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо тендер, дуудлага худалдаа зэрэг шударга өрсөлдөөний аргыг хэрэглэн шийдвэр гаргадаг байна.

Тусгай зөвшөөрлийг тендер, дуудлага худалдаагаар олгох журам нь холбогдох хуульд нийцсэн байх шаардлагыг хуулиар тавьж өгсөн бөгөөд журмын дагуу тендерт ялагч, худалдан авагчийг тодруулсны дараа ялагчид тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгодог.

Захиргааны байгууллага нь Захиргааны тусгай зөвшөөрлийн хуулийг зөрчиж тендер, дуудлага худалдааны хэлбэрийг батлаагүй байх, эсхүл тендер, дуудлага худалдаа явуулах журмыг зөрчсөн нь өргөдөл гаргагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд өргөдөл гаргагч нь хуулийн дагуу нэхэмжлэл гаргах эрхтэй хэмээн хуульчилжээ.

Азербайжан, Армени, Гүрж, Узбекистан улсын зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн харилцааг зохицуулж байгаа бие даасан хуулиудад тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрлийг сонгон шалгаруулах буюу дуудлага худалдаагаар олгож болохоор хуульчилсан.

Гүрж Улсын Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар энэ асуудлыг илүү тодорхой зохицуулжээ. Харин **ОХУ**-ын Зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хуулиар тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах буюу дуудлага худалдаагаар олгох харилцааг зохицуулаагүй байна. Газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдаа явуулах нийтлэг журмыг Газрын хэвлийн тухай хуулиар, нарийвчилсан харилцааг Холбооны улсын Газрын хэвлий ашиглалтын агентлаг (Роснедр)-ийн регламентаар тус тус зохицуулсан байна. **Узбекистанд** тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалт (тендер)-ын үндсэн дээр олгох бөгөөд түүнийг сонгон шалгаруулалт (тендер)-аар олгох журам, нөхцөлийг тус улсын Сайд нарын танхим тогтооно.

Гүрж болон **ОХУ**-д хуулиар тогтоосон, эсхүл тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас тавьсан нөхцөл, шаардлагыг хангасан тусгай зөвшөөрөл хүсэгч бүхэн дуудлага худалдаанд оролцох эрхтэй. ОХУ-д газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдаанд ялагчийг тодруулахад тухайн оролцогчийн шинжлэх ухаан, техникийн түвшин, тухайн бүс нутагт ажилласан туршлага, тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулсан хувь нэмэр, мөн газрын хэвлий ашиглах эрхийн нэг удаагийн төлбөрийн хэмжээ зэргийг гол шалгуураа болгодог.

Сингапур, Шотланд улсуудын холбогдох хууль тогтоомж, түүнийг даган гарсан журмын хүрээнд мэдээллийн хайлт хийж үзэхэд дуудлага худалдаа болон сонгон шалгаруулалтаар олгож байгаа зохицуулалт байхгүй байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

ЗӨВШӨӨРӨЛ (ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ)-ИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТОГТОЛЦОО БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ: ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

1.Эрх зүйн орчны хүрээ ба зохицуулалтын зорилго

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-д зөвшөөрөлтэй холбоотой харилцааг бие даасан хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бусад журмаар зохицуулдаг. Үүнд:

- БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль;⁵
- Захиргааны тусгай зөвшөөрлийн хуулийн тайлбар;⁶
- Захиргааны тусгай зөвшөөрлийг хатуу хянах тухай тогтоол.⁷

БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль⁸ (Administrative License Law of the People's Republic of China) 2003 онд Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (БХАТИХ)-ын Байнгын хорооны IV хуралдаанаар баталсан, 8 бүлэг 83 зүйлтэй хууль юм.

Хуулийн зорилго: Хуулийн 1 дүгээр зүйлд “Захиргааны тусгай зөвшөөрөл тогтоох, олгох, хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулах, иргэн, хуулийн этгээд, бусад байгууллагын хууль ёсны эрх, ашгийг хамгаалах, нийтийн ашиг сонирхол, нийгмийн хэв

⁵ БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль.

<http://www.lawinfochina.com/display.aspx?lib=law&id=3076&CGid=#menu2>

⁶ БНХАУ-ын захиргааны тусгай зөвшөөрлийн тухай хууль-ийн тайлбар.<http://xzspj.nc.gov.cn/ncspj/zcjd/201912/4151afa2a3f1463eaab35ee76e7b792b.shtml>

⁷ Захиргааны тусгай зөвшөөрлийг хатуу хянах тухай тогтоол. http://www.gov.cn/zhengce/content/2013-09/26/content_1228.htm

⁸ БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль.

<http://www.lawinfochina.com/display.aspx?lib=law&id=3076&CGid=#menu2>

журмыг хамгаалах, захиргааны удирдлагын хэрэгжилтийг хангах, хяналт тавих зорилготой” гэж заасан байна.

Захиргааны тусгай зөвшөөрөл гэж “захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээд, бусад байгууллагад өргөдлийн дагуу тусгай үйл ажиллагаа эрхлэхийг хуульд заасан журмын дагуу зөвшөөрч буй үйлдлийг хэлнэ” хэмээн уг хуулийн 2 дугаар зүйлд хуульчилсан байна.

Хятадын Төрийн зөвлөлөөс 2022 онд захиргааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой бүх асуудлыг нэгтгэн журамлах зорилгоор “Захиргааны тусгай зөвшөөрлийн жагсаалтыг улс орон даяар нэгтгэн нийгэмд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг цогцоор нь судалж, дүгнэн ажиллахаар шийдвэрлэсэн. Ингэхдээ бүх шатны захиргааны тусгай зөвшөөрлийн жагсаалтад тусгай зөвшөөрлийн нэр, хариуцсан хэлтэс, хэрэгжүүлэх байгууллага, хэрэгжилтийн үндэслэл, хэрэгжүүлэх протоколыг жагсаалтын зүйл тус бүрээр нэг бүрчлэн зааж өгөх бөгөөд энэхүү ажлын хүрээнд дараах өөрчлөлтүүдийг хийхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1. ижил төрлийн тусгай зөвшөөрлүүдийг өөр бүс нутагт ижил стандартаар хэрэгжүүлэх;
2. орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрөл, түүний тоо, зориулалт нь дээд шатны байгууллагаас баталсан тусгай зөвшөөрлийн жагсаалтаас хэтрэхгүй байх;⁹
3. тусгай зөвшөөрлийн шаардлага, өргөдлийн материал, батлах журам, хураамжийн хэмжээг тодорхой тогтоож, нийтэд мэдээлэх бөгөөд хэрэгжүүлэх явцад нэмэлт нөхцөл, хязгаарлалт тавихгүй байх.

Энэхүү арга хэмжээний үр дүнд:

Засгийн газар, эрх бүхий байгууллагууд захиргааны тусгай зөвшөөрлийг хэрэгжүүлэхдээ жагсаалтыг чанд мөрдөж зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох.

Хууль тогтоомжид заасан хяналт шалгалтыг эрчимжүүлснээр жагсаалтад байгаа захиргааны тусгай зөвшөөрлийн зүйл бүрийн дор харьяалах хяналтын байгууллагууд, гол холбоосууд, дүрэм, стандартуудыг зааж өгөх бөгөөд ингэснээр нийгмийн аюулгүй байдал, эрүүл мэндтэй шууд холбоотой, эсхүл томоохон эрсдэлтэй газруудад хяналт тавихад тэргүүлэх ач холбогдолтой болох юм.

Тусгай зөвшөөрөл олгох, түүнтэй холбоотой хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг нэг цэгээр онлайн байдлаар хэрэгжүүлэх бөгөөд аж ахуйн нэгж, иргэдэд төрийн үйлчилгээг хялбар хүртээмжтэй болгоно.¹⁰

БНХАУ-ын Төрийн зөвлөл “Захиргааны тусгай зөвшөөрлийн жагсаалтыг хатуу батлан хэрэгжүүлж, бизнес эрхлэгчдээс дээрх жагсаалтаас гадуурх зөвшөөрөл шаардахгүй байх, ингэснээр нээлттэй, ил тод орчинд ижил тэгш өрсөлдөөнийг бий болгохыг зорьж ажиллаж байна.”¹¹

Шотланд Улсад тусгай зөвшөөрөл (лиценз) болон зөвшөөрөлтэй холбоотой үндсэн харилцааг 2005 онд батлагдсан **Тусгай зөвшөөрлийн тухай хуулиар**¹² Licensing Act Scotland зохицуулахаас гадна аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийг холбогдох салбарын хуулиудаар зохицуулдаг. Тухайлбал, орон сууцны бүртгэл - Орон сууцны тухай хууль, хувийн орон сууц эзэмшигчийн бүртгэл - Нийгмийн эсрэг зан үйлийн тухай хууль, театрын лиценз - Театрын тухай хууль, кино театрын лиценз

⁹ БНХАУ-ын Төрийн зөвлөлийн цахим хуудас.

¹⁰ http://english.www.gov.cn/policies/latestreleases/202201/30/content_WS61f64f28c6d09c94e48a4906.html

¹¹ http://english.www.gov.cn/premier/news/202201/05/content_WS61d4d454c6d09c94e48a3213.html

¹² http://english.www.gov.cn/premier/news/202201/05/content_WS61d4d454c6d09c94e48a3213.html

¹² <https://www.aberdeencity.gov.uk/services/business-and-licensing/licences-and-permits/licensing-scotland-act-2005>

- Кино театрын тухай хууль, спортын талбайн аюулгүй байдал - Спортын талбайн аюулгүй байдлын тухай хууль.

Сингапур Улсад аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийг холбогдох салбарын хуулиудаар зохицуулдаг. Тухайлбал, банкны тусгай зөвшөөрлийг Банкны тухай хуулиар, барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Барилгын хяналтын тухай хуулиар, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Даатгалын тухай хуулиар, цахилгаан, эрчим хүчний тусгай зөвшөөрлийг Цахилгаан, эрчим хүчний тухай хуулиар, Тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг Тамхины тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөл авахаас өмнө Засгийн газрын бүртгэлийн агентлаг болох Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн нэгжийг зохицуулах газар¹³ (Accounting and Corporate Regulatory Authority - ACRA)-т бүртгүүлсэн байх шаардлагатай. Тус газар нь бизнесийн үйл ажиллагааны бүртгэл болон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэлийг хариуцдаг.¹⁴

Хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан орнууд буюу **Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөл** (ТУХН)-ийн гишүүн зарим улсад бие даасан дараах хуулиудаар тусгай зөвшөөрөл, зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулж байна. Үүнд:

- 1.Азербайжан Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хууль¹⁵ (2016);
- 2.Армени Тусгай зөвшөөрөл олгох тухай хууль¹⁶ (2001);
- 3.Гүрж Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хууль¹⁷ (2005);
- 4.Казахстан **Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хууль**¹⁸ (2014);
- 5.Киргиз Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тогтолцооны тухай хууль¹⁹ (2005);
- 6.ОХУ Зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хууль²⁰ (2011);
- 7.Узбекистан Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл ба мэдэгдэл олгох журмын тухай хууль²¹ (2021).

Дээрх бие даасан хуулиудын зорилго, зохицуулах харилцааг багцлан авч үзвэл:

- хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгө, олон нийт, төрийн аюулгүй байдалд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх болон төрийн хязгаарлагдмал нөөцийг зүй зохистой ашиглах (Гүрж, Киргиз);
- зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-өөр зохицуулагдах харилцааны хүрээг тодорхойлох (Азербайжан, Гүрж);
- тодорхой үйл ажиллагааны төрөлд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох журмыг тогтоох (Азербайжан, Армени, Гүрж, Казахстан, Киргиз, ОХУ, Узбекистан);

¹³ Сингапур Улсын Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн нэгжийг зохицуулах тухай хууль (Accounting and Corporate Regulatory Authority Act, 2004)-ийн 1 бүлгийн 2.1 дэх зүйл. <https://sso.agc.gov.sg/Act/ACRAA2004>

¹⁴ <https://www.acra.gov.sg>

¹⁵ Закон Азербайджани О лицензиях и разрешениях от 15.03.2016 года.

https://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=85079

¹⁶ Закон Армении О Лицензировании от 30.05.2001 года. <https://www.arlis.am/DocumentView.aspx?docID=67471>

¹⁷ Закон Грузии О лицензиях и разрешениях, 24.06.2005 года.

<https://matsne.gov.ge/ru/document/view/26824?publication=87>

¹⁸ Закон Казахстана “О разрешениях и уведомлениях” от 16.05.2014 года.

https://online.zakon.kz/Document/?doc_id=31548200&pos=3;-109#pos=3;-109

¹⁹ Закон Кыргызии О лицензионно-разрешительной системе в Кыргызской Республике от 19.10.2013 года № 195. <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/205058>

²⁰ Закон РФ О лицензировании отдельных видов деятельности. Принят ГД 22.04.2011 года. Одобрен СФ 27.04.2011 года. <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102147413>

²¹ Закон Узбекистан О лицензировании, разрешительных и уведомительных процедурах. Принят Законодательной палатой 5 марта 2021 года. Одобрен Сенатом 23.04.2021 года. <https://www.lex.uz/acts/5511900?ONDATE=15.07.2021%2000#5518717>

- тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн төрлүүдийг тогтоох (Армени, Гүрж, Казахстан, Киргиз) гэх мэт.

Эдгээр улсуудад тусгай зөвшөөрөл, зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн харилцааг дээрх бие даасан хуулиас гадна холбогдох салбарын хуулиудаар зохицуулж байна. Тухайлбал, **Гүрж Улсад** байгаль орчны салбарын зөвшөөрлийг Байгаль орчинд нөлөөлөх зөвшөөрлийн тухай, Усны тухай, Агаар мандлын агаарыг хамгаалах тухай, ашигт малтмал олборлолт, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Газрын хэвлийн тухай хуулиар, нефть, байгалийн хийн олборлолт, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Нефть ба байгалийн хийн тухай хуулиар, цэргийн зориулалттай бүтээгдэхүүний зөвшөөрлийг Цэргийн болон давхар зориулалттай бүтээгдэхүүнд хяналт тавих тухай хуулиудаар тус тус зохицуулж байна.

Азербайжан Улсын тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тухай хууль тогтоомж нь тус улсын Үндсэн хууль, Аж ахуйн нэгжийн тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль болон бусад хууль тогтоомжоос бүрдэх бол **Киргиз Улсад** Үндэсний банк, банк, банкны үйл ажиллагааны тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

Казахстан Улсад аж ахуй эрхлэх эрхийг хангах эрх зүй, эдийн засаг болон нийгмийн нөхцөл, баталгааг тодорхойлж, аж ахуйн нэгж, төр хоорондын харилцаа, тэр дундаа аж ахуй эрхлэхэд төрийн зохицуулалт, дэмжлэгтэй холбоотой харилцааг **Аж ахуйн үйл ажиллагааны кодексоор** зохицуулдаг. Энэ кодексын **106 дугаар зүйлд зааснаар тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл ба мэдэгдлийн талаарх төрийн зохицуулалт мөн Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хуулийн дагуу аж ахуйн нэгжид тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоно.**

Армени, ОХУ-ын хувьд зөвхөн тусгай зөвшөөрлийг зохицуулжээ. **ОХУ-д** тусгай зөвшөөрлийн хууль тогтоомж нь тус улсын Үндсэн хууль, холбооны болон ОХУ-ын субъектүүдийн хууль тогтоомжоос бүрдэнэ. Тухайлбал, Үндсэн хуулийн хэм хэмжээ нь тусгай зөвшөөрлийн харилцааг шууд бус байдлаар зохицуулж, эрх зүйн хязгаар, түүний үндсийг тогтоосон. Үүний дараа Иргэний кодекс тухулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчдийн тусгай зөвшөөрөл шаардагдах тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх нь тусгай зөвшөөрөл авсны дараа үүсэх зэрэг журмыг хамгийн нийтлэг байдлаар тодорхойлжээ. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой зөрчилд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

ОХУ-ын зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай холбооны хууль нь төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэд, хувиараа бизнес эрхлэгчдийн хоорондын тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах үндсэн баримт бичиг юм. Энэ хуулиар тусгай зөвшөөрлийн зохицуулалтын хамрах хүрээг тодорхойлох, хязгаарлах, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны төрөл, олгох байгууллагын зарчим, тогтолцоо, бүрэн эрх, тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг олгох журмыг тогтоожээ.

Харин дээрх хуульд хамаарахгүй тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн харилцааг холбогдох салбарын хуулиудаар зохицуулдаг. Жишээлбэл, цөмийн энерги ашиглах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх, түүний дотор цөмийн байгууламжийн ажилтанд зөвшөөрөл олгох журмыг Цөмийн энергийг ашиглах тухай хуулиар зохицуулж байна. Мөн боловсрол, харилцаа холбоо, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл зэрэг салбарын тусгай зөвшөөрлийг холбогдох хуулиудаар зохицуулж байна.

Үүний дараа тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудын бүрэн эрхийг тогтоох, тусгай зөвшөөрлийн шаардлага, нөхцөл, журмыг зохицуулсан ОХУ-ын Ерөнхийлөгч, ОХУ-ын Засгийн газрын актууд хамаарч байна.

Харин **Армени Улсад** эрчим хүч, цахим харилцаа холбоо, усны салбарын тусгай зөвшөөрлийг Эрчим хүчний тухай, Цахим харилцаа холбооны тухай, Телевиз, радиогийн тухай хуулиуд болон Усны тухай кодексоор зохицуулдаг.

2.Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо

Шотланд Улсын Тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлд зааснаар Лицензийн зөвлөлтэй байна. Тус зөвлөл нь зарим төрлийн зөвшөөрөл олгохоос гадна, тусгай зөвшөөрлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавихаар хуульчлагдсан байна. Лицензийн зөвлөл нь орон нутагт салбар нэгжтэй байна. Тухайн нутаг дэвсгэртээ лицензийн стандарт хариуцсан ажилтныг томилон ажиллуулахыг хуульд тусгажээ.

Тус хуулиар “тусгай зөвшөөрөл олгох” 5 зорилтыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
- Олон нийтийг таагүй байдлаас урьдчилан сэргийлэх;
- Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах;
- Хүүхдийг хор хөнөөлөөс хамгаалах зэрэг байна.

Абердиний Лицензийн зөвлөл:²²

Шотланд Улсад Тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл бүхий санал дүгнэлтийг боловсруулах эрх бүхий Абердиний лицензийн зөвлөл ажилладаг байна. Абердиний лицензийн зөвлөл нь 9 гишүүнтэй 2 сар тутамд нэг удаа Мягмар гарагт 10:30 цагт хуралддаг. Абердиний лицензийн зөвлөлөөс авах боломжтой тусгай зөвшөөрлийн дараах төрлүүд байдаг. Үүнд:

- архи согтууруулах ундаа худалдах;
- мөрийтэй тоглоом тоглох;
- амьтан тэжээх байгууламжаар хангах;
- усан онгоц түрээслэх;
- караван болон кемпийн газар ашиглах;
- хөргөх байгууламжийн үйл ажиллагаа эрхлэх;
- спортын үйл ажиллагаа эрхлэх;
- металл борлуулах;
- оройн цагаар үйл ажиллагаа эрхлэх;
- оператор ажиллах;
- буяны байгууллагын үйл ажиллагаа эрхлэх;
- морин спортоор хичээллэх;
- насанд хүрэгчдэд зориулсан дэлгүүр ажиллуулах;
- шивээс хийх, арьс цоолох үйлчилгээ эрхлэх;
- спортын талбайн аюулгүй байдлыг ханган ажиллуулах;
- газрын тосны агуулах байгуулах;
- цонх цэвэрлэгээний үйлчилгээ эрхлэх;
- шөнийн цагаар үйлчилгээ эрхлэх;
- амьтны хүрээлэн ажиллуулах.

Абердиний лицензийн зөвлөл нь бүтцийн хувьд Аудит эрсдэл, хяналтын хороо, Лицензийн хороо, Олон нийтийг хамгаалах хороо зэрэг 12 хороотойгоор үйл ажиллагаа эрхэлдэг байна.

²² <https://www.aberdeencity.gov.uk/services/business-and-licensing/licences-and-permits/licensing-board>

Абердиний лицензийн зөвлөл болон хороодын үйл ажиллагааг тус зөвлөлийн байнгын захирамжаар зохицуулдаг.

Судалгааны асуудалтай холбогдуулан Лицензийн хороог²³ товч судаллаа. Тус хороо нь тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, өөрчлөх, түдгэлзүүлэх зэргийг хуулийн дагуу шийдвэрдэнэ. Тус хорооноос олгож буй зөвшөөрлийн төрлүүдийг дараах байдлаар оруулав.

Лицензийн хорооноос олгож буй тусгай зөвшөөрлийн төрлүүд: металл диллерийн, олон нийтийн зугаа цэнгэлийн байгууламжийн лиценз, зэвсэг борлуулах, такси захиалгын албаны лиценз.

Лицензийн хорооноос олгож буй зөвшөөрлийн төрлүүд: такси болон түрээсийн машин ашиглах зөвшөөрөл, такси болон хувийн түрээсийн машины жолооч, онгоц түрээслэх, гудамжны худалдаа эрхлэх, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, шөнийн цагаар үйлчилгээ эрхлэх, спорт заал, хутга, сэлэм зэрэг зэвсэг эзэмших, жагсаал цуглаан зохион байгуулах зэрэг байна.

Орон нутагт лицензийн стандарт хариуцсан ажилтныг томилно гэж Лицензийн тухай хуульд заажээ. Лицензийн стандарт хариуцсан ажилтныг томилохдоо хуульд заасан шаардлагын дагуу ур чадвар, туршлагыг харгалзан үзэж тогтоосон журмын дагуу томилно. Лицензийн стандарт хариуцсан ажилтан нь тухайн нутаг дэвсгэртээ хуулийн дагуу олгосон чиг үүргийн дагуу эрх мэдлээ хэрэгжүүлнэ. Үүнд:

- тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх, хяналт тавих;
- тусгай зөвшөөрлийн эрхийн шаардлага хангаагүй болон тухайн нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл өргөдөл гаргагчын аливаа үйлдлийн талаар Лицензийн зөвлөлд мэдэгдэх;
- хоорондын маргаан, үл ойлголцлоос зайлсхийх, шийдвэрлэх зорилгоор эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлэх;
- лиценз эзэмшигчийн ажлын байранд хэдийд ч нэвтэрч тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг шалгах;
- хяналт шалгалт хийх хуульд заасан бусад шаардлагыг тавих;
- стандарт хариуцсан ажилтан шаардлагатай гэж үзвэл ажлын байранд илэрсэн зөрчил болон олдсон эд зүйлс, баримт бичигт шалгалт хийх, хураах, хуулбарлан авах, авах эрхтэй.

Лицензийн стандарт хариуцсан ажилтан нь тусгай зөвшөөрөл эсхүл зөвшөөрлийн нөхцөлийг зөрчсөн буюу зөрчиж байгаа гэж үзвэл мэдэгдэл хүргүүлж дараах арга хэмжээг авна. Үүнд:

- мэдэгдэлд заасан зөрчлийг арилгах, арга хэмжээ авахуулахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- мэдэгдэл аваад шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг дахин хянах, зөвлөлд мэдээлэл хүргүүлэх.

БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хуульд хяналт, шалгалттай холбоотой дараах зохицуулалт туссан байна.

Захиргааны тусгай зөвшөөрлийг үнэлэх, цуцлах, хяналт тавих²⁴ Тусгай зөвшөөрөл тогтоосон (бий болгосон) байгууллага нь тухайн тусгай зөвшөөрлийг үнэлнэ.

²³ <https://www.aberdeencity.gov.uk/services/business-and-licensing/licences-and-permits/licensing-committee>

²⁴ БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 20 дугаар зүйл.

Захиргааны тусгай зөвшөөрлийн гүйцэтгэх байгууллага нь захиргааны тусгай зөвшөөрлийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл байх шаардлагатай эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох дүгнэлтийг тусгай зөвшөөрөл тогтоосон байгууллагад мэдээлнэ.

Иргэн, хуулийн этгээд, бусад байгууллага захиргааны тусгай зөвшөөрөл тогтоох, хэрэгжүүлэх талаар тухайн зөвшөөрлийг тогтоосон байгууллага, гүйцэтгэх байгууллагад санал гаргаж болно.

Захиргааны тусгай зөвшөөрлийн хуулийн 52 дугаар зүйлд зааснаар Төрийн зөвлөл тусгай зөвшөөрлийг хэрэгжүүлэх журмыг холбогдох хууль тогтоомж, захиргааны журмаар зохицуулна.

Захиргааны дээд байгууллага нь тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд доод шатны байгууллагад тавих хяналт, шалгалтыг чангатгаж, хууль бус үйлдлийг цаг тухайд нь арилгана.²⁵ Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд баримт бичгийн шалгалт хийх замаар хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Захиргааны байгууллага хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлдвэрлэж буй бараа, бүтээгдэхүүнд гэнэтийн шалгалт хийх, үйлдвэрт газар дээр нь үзлэг хийж болдог.

Шалгалт явуулахдаа хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зөвлөлдөх бөгөөд холбогдох материалыг бүрдүүлж өгөхийг шаардаж болно.

Мөн олон нийтийн аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийн аюулгүй байдалд шууд хамааралтай чухал техник, тоног төхөөрөмжид хууль тогтоомж, захиргааны журмын дагуу үе үе үзлэг шалгалт хийх ба тэнцсэн бол нотлох баримт бичиг олгодог.²⁶

Хувь хүн, байгууллага захиргааны тусгай зөвшөөрлийн хууль зөрчсөн аливаа үйл ажиллагааг илрүүлсэн бол энэ тухай холбогдох захиргааны байгууллагад мэдэгдэх бөгөөд зөрчлийг цаг тухайд нь хянан шийдвэрлэнэ.

Залилан мэхлэх, хахууль өгөх замаар тусгай зөвшөөрөл авсан бол хуульд заасан журмын дагуу захиргааны шийтгэл ногдуулна. Тусгай зөвшөөрөл нь нийтийн аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийн аюулгүй байдалд шууд хамаарах бол өргөдөл гаргагч нь түүнээс хойш 3 жилийн дотор дахин хүсэлт гаргахгүй ба тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөрчил нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 79 дүгээр зүйлд заасан байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах зөрчлийг гаргасан бол хуулийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх ба гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:

1. тусгай зөвшөөрлийн гэрчилгээг өөрчлөх, худалдах, худалдан авах, түрээслэх, зээлдүүлэх, бусад хууль бус аргаар тусгай зөвшөөрлийг шилжүүлэх;
2. тусгай зөвшөөрлийн хүрээнээс хэтэрсэн үйл ажиллагаа явуулах;
3. хяналт, шалгалт хариуцсан захиргааны байгууллагаас холбогдох мэдээллийг нуун дарагдуулах, хуурамч материал илгээх, үйл ажиллагааг нь харуулсан жинхэнэ материал илгээхээс татгалзах;
4. хууль, тогтоомжид заасан бусад хууль бус үйлдэл.²⁷

Төрийн зөвлөлөөс Захиргааны тусгай зөвшөөрлийн хуулиас гадна БНХАУ-ын **Захиргааны**

²⁵ БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 60 дугаар зүйл.

²⁶ БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 62 дугаар зүйл.

²⁷ БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 80 дугаар зүйл.

тусгай зөвшөөрлийг хатуу хянах тухай тогтоолыг 2013 онд батлан хэрэгжүүлж байна. Энэ тогтоол нь тусгай зөвшөөрлийн зохицуулалтад хатуу хяналт, зохицуулалт хийх зорилготой юм. Уг зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд

- тусгай зөвшөөрлийн стандартыг хатуу тогтоох;
- тусгай зөвшөөрөл олгох хяналтыг стандартчилах;
- тусгай зөвшөөрөл бий болгоход тавих хяналтын чангатгах цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

2001 оноос хойш Хятадын Төрийн зөвлөл Бизнес хийх таатай орчныг бүрдүүлэх үүднээс 2400 зөвшөөрлийг цуцалсан буюу доод шатны эрх баригчдад шилжүүлсэн. Өнгөрсөн хугацаанд захиргааны тусгай зөвшөөрлийг тогтоосон олон тооны дүрэм журмыг цуцалж, эдгээр газраас тусгай зөвшөөрөл тогтоохыг хатуу хязгаарласан. Хууль, захиргааны дүрэм, орон нутгийн дүрэм журам, мужийн түвшний ардын засгийн газраас бусад норматив баримт бичигт захиргааны тусгай зөвшөөрөл тогтоохыг хатуу хориглосон байна.

Сингапур Улс нь үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийг бие даасан хуулиар бус холбогдох салбарын хуулиудаар зохицуулдаг. Иймээс аж ахуйн нэгжийн зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөлд тавих хяналтыг тухайн зөвшөөрөл олгосон байгууллага хэрэгжүүлдэг байна. Иймээс зарим төрлийн тусгай зөвшөөрлийг зохицуулдаг хууль болон хяналт тавих эрх бүхий байгууллагыг үзүүлбэл:

Хүснэгт. Тусгай зөвшөөрлийн зарим төрлүүдийг зохицуулдаг хууль, түүнийг олгодог, хянадаг байгууллага

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Зохицуулж буй хууль	Зөвшөөрөл олгох, хяналт тавих байгууллага
1.	Банкны тусгай зөвшөөрөл	Банкны тухай хууль ²⁸	Валют зохицуулалтын газар
2.	Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	Барилгын хяналтын тухай хууль ²⁹	Барилга, угсралтын газар
3.	Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	Даатгалын тухай хууль ³⁰	Валют зохицуулалтын газар
4.	Цахилгаан, эрчим хүчний тусгай зөвшөөрөл	Цахилгаан, эрчим хүчний тухай хууль ³¹	Эрчим хүчний удирдах газар
5.	Эмийн сангийн тусгай зөвшөөрөл	Эрүүл мэндийн бүтээгдэхүүний тухай хууль ³²	Анагаах ухааны газар
6.	Согтууруулах ундаа нийлүүлэх тусгай зөвшөөрөл	Согтууруулах ундааны хяналтын (нийлүүлэлт ба хэрэглээ) тухай хууль ³³	Цагдаагийн газар
7.	Тамхи импортлох, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл	Тамхины тухай хууль ³⁴	Анагаах ухааны газар

Тухайлбал, Засгийн газрын агентлаг болох Анагаах ухааны газар нь тамхи импортлох, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Тамхины тухай хууль, Тамхины (зар сурталчилгаа, борлуулалтын хяналт, тусгай зөвшөөрөл олгох) журам³⁵ болон

²⁸ Банкны тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/BA1970>

²⁹ Барилгын хяналтын тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/BCA1989>

³⁰ Даатгалын тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/IA1966>

³¹ Цахилгаан, эрчим хүчний тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/EA2001>

³² Эрүүл мэндийн бүтээгдэхүүний тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/HPA2007>

³³ Согтууруулах ундааны хяналтын тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/LCSCA2015>

³⁴ Тамхины тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/TCASA1993>

³⁵ Tobacco (Control of Advertisements and Sale) (Licensing) Regulations 2017 <https://sso.agc.gov.sg/SL/TCASA1993-S763-2017?DocDate=20211230>

дагалдах бусад хууль, тогтоомжид³⁶ заасан нөхцөл, шаардлагыг үндэслэн олгох, өөрчлөх, сунгах, цуцлах, хүчингүй болгох шийдвэрийг гаргадаг.

Армени Улсад Төв Банк, Төрийн үйлчилгээний зохицуулах хороо, Телевиз, радиогийн үндэсний хороо, Засгийн газраас эрх олгосон яам, агентлагууд нь Тусгай зөвшөөрөл олгох тухай хуульд заасан үйл ажиллагааны төрлүүдийн тусгай зөвшөөрлийг олгоно. Эдгээр байгууллагуудын талаар тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулиудаар зохицуулдаг.

Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудын нэг болох **Телевиз, радиогийн үндэсний хороо** (ТРҮХ) нь төрийн байгууллагын статустай хараат бус байгууллага бөгөөд Телевиз, радиогийн тухай хууль³⁷ болон тус хорооны дүрмийг үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг. Түүний дүрмийг тус улсын Үндэсний Ассамблейгаас батална.

ТРҮХ нь дараах эрх, үүрэгтэй:

- радио давтамжийн олон нийтийн болон өрсөлдөөнт хуваарилалтыг явуулдаг тусгай зөвшөөрлийн маягтыг батлах;
- телевиз, радиогийн хувийн хэвшлийн байгууллага (цаашид “телевиз, радиогийн компани”)-д тусгай зөвшөөрөл олгох;
- тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэрсийн жагсаалтыг гаргаж, нийтлэх, тусгай зөвшөөрөлд заасан нөхцөлийн биелэлтэд хяналт тавих;
- телевиз, радиогийн байгууллагад кодтой нэвтрүүлэг явуулахыг зөвшөөрөх;
- холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- телевиз, радиогийн нэвтрүүлэг бэлтгэх техникийн үзүүлэлтүүд, түүнчлэн техникийн хэрэгсэл нь стандарт, олгосон тусгай зөвшөөрлийн нөхцөлд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;
- Телевиз, радиогийн тухай хуулийг зөрчсөн тохиолдолд тухайн телевиз, радиогийн нэвтрүүлгийн үйл ажиллагааг шүүхийн шийдвэр гартал түдгэлзүүлэх;
- хуульд заасан журмын дагуу олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.

Тус хороо нь ажлын албатай ба түүний бүтэц, орон тоог ТРҮХ-ны даргын санал болгосноор ТРҮХ батална. ТРҮХ-ны үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ. ТРҮХ нь жил бүр үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа тус улсын Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлэхээс гадна хэвлэлд нийтэлнэ.

ТРҮХ-ны бүрэлдэхүүний хувьд 9 гишүүнтэй, тэднийг тус улсын Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно. Нэг хүнийг ТРҮХ-ны гишүүнээр хоёроос дээш удаа томилохгүй. Тус хороо нь дарга, дэд даргаа гишүүдээсээ сонгоно.

ТРҮХ-ны гишүүнээр дараах хүмүүс байж болохгүй:

- намын удирдах байгууллагын гишүүн;
- гадаадын иргэн;
- аливаа телевиз, радио компанийн үүсгэн байгуулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хувьцаа эзэмшигч, эсхүл оролцогч;
- төрийн болон хувийн хэвшлийн телевиз, радиогийн байгууллагын дарга, ажилтан.

ТРҮХ-ны гишүүд нь сурган хүмүүжүүлэх, шинжлэх ухаан, уран бүтээлийн ажлаас бусад цалинтай ажлыг нэгэн зэрэг гүйцэтгэхгүй.

Дээр дурдсан тусгай зөвшөөрөл олгодог байгууллагууд нь **Тусгай зөвшөөрлийн хороо** (ТЗХ)-г (лицензирующие комиссия) байгуулах бөгөөд тусгай зөвшөөрөл олгох,

³⁶ Дагалдах хууль тогтоомж. <https://sso.agc.gov.sg/Act/TCASA1993?ViewType=SI>

³⁷ Закон Республики Армения О телевидении и радио. Принят 09.10.2000.
<http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=1464&lang=rus#5>

түдгэлзүүлэх, цуцлахад тус хорооны дүгнэлтийг үндэслэнэ. Харин тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, дахин олгоход ТЗХ-ны дүгнэлт шаардлагагүй.

ТЗХ-ны дүгнэлтийг Тусгай зөвшөөрлийн тухай хууль болон тусгай зөвшөөрөл олгодог дээрх байгууллагуудын баталсан ТЗХ-ны дүрэмд заасан журмын дагуу гаргана.

ТЗХ-ны хурлыг дараах журмаар явуулна:

- ээлжит хурлын зарыг тухайн асуудлыг хэлэлцэхээс 7 хоногийн өмнө өргөдөл гаргагч буюу тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “уригдсан этгээд”)–д мэдэгдэх ба 5-аас доошгүй хоногийн өмнө тус улсын олон нийтийн мэдээллийн албан ёсны цахим хуудас (<http://www.azdarar.am>)–д нийтэлнэ;
- ТЗХ-ны гишүүдийн талаас илүү хувь нь оролцсон хурлыг хүчинтэйд тооцно;
- хурлын дарга хамгийн түрүүнд хэлэлцэх асуудлыг, хуралдаанд уригдсан этгээдийг болон өргөдөл, бусад материалын агуулгыг танилцуулах ба асуудлыг хэлэлцэхэд оролцож байгаа хүмүүст эрх, үүргийг тайлбарлана;
- хурлаар асуудлыг нээлттэй хэлэлцэнэ. Төрийн, албаны болон банкны нууцыг агуулсан мэдээлэлтэй холбоотой асуудлыг хаалттай хэлэлцэнэ;
- асуудлыг хэлэлцэх явцад арилжааны нууц агуулсан мэдээлэл илэрсэн тохиолдолд уригдсан этгээдийн хүсэлтээр хаалттай хуралдаж болно;
- асуудлыг хэлэлцэхэд сэтгүүлч, мэргэжилтэн, албан тушаалтан болон бусад хүмүүс нээлттэй оролцож болно. Хурлын аудио болон дүрс бичлэг хийж болно;
- асуудлыг хэлэлцэж дууссаны дараа ТЗХ шийдвэрээ гаргана. Шийдвэрээ тусдаа өрөөнд, хаалттай хаалганы цаана гаргах буюу шийдвэр гарах үед тус өрөөнд зөвхөн ТЗХ-ны гишүүд байна;
- ТЗХ-ны шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн энгийн олонхын саналаар хаалттай, нууц санал хураалтаар гаргана. Хэрэв санал тэнцсэн бол уригдсан этгээдийн талд шийдвэр гаргасан гэж үзнэ;
- асуудал хэлэлцэх явцад хурлын тэмдэглэл үйлдэнэ. Тэмдэглэлд ТЗХ-ны дүгнэлтийн агуулгыг тусгаж, хурлын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна;
- хууль зөрчиж гаргасан ТЗХ-ны дүгнэлтийг хүчингүйд тооцно;
- ТЗХ-ны дүгнэлтийг олон нийтийн мэдээллийн албан ёсны цахим хуудас (<http://www.azdarar.am>)–д нийтэлж, урьсан этгээдэд илгээнэ.

Уригдсан этгээд дараах эрхтэй:

- мэргэжилтэн, шинжээч, аудитор, хуульч, орчуулагчийг урих;
- үг хэлэх, ТЗХ-ны гишүүдийн асуултад хариулах, өргөдөл гаргах (мөн түүний ашиг сонирхлыг хамгаалагчид).

ТЗХ-ны дүгнэлт гаргасан өдөр нь тусгай зөвшөөрөл олгох байгууллагын даргад шилжүүлнэ. Зөвшөөрөл олгох байгууллага нь ийнхүү дүгнэлт ирүүлснээс хойш 2 хоногийн дотор тус дүгнэлтийг үндэслэн шийдвэрээ гаргана. Хэрэв заасан хугацаанд шийдвэр гаргаагүй бол зөвшөөрөл олгох байгууллагын шийдвэрийг хорооны шийдвэр гэж үзнэ.

Зөвшөөрөл олгох байгууллагын татгалзсан шийдвэрийг шүүхэд, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж болно.

Тусгай зөвшөөрлийг дараах журмаар түдгэлзүүлнэ. Үүнд:

- тусгай зөвшөөрөл олгох байгууллага зөвхөн ТЗХ-ны дүгнэлтээр хуульд заасан шаардлагыг зөрчсөний улмаас үйл ажиллагааг нь түдгэлзүүлнэ;
- ТЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргана;

- хуульд заасан шаардлагыг зөрчсөн өдрөөс хойш 3 сарын дотор, зөрчлийг үргэлжлүүлсэн буюу удаан хугацаагаар гаргасан бол түүнийг илрүүлснээс хойш 3 сарын дотор тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг түдгэлзүүлж болно;
- тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг ТЗХ хэлэлцэж дүгнэлт гарснаас хойш 15 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг зохих ёсоор шилжүүлээгүй, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигчид илгээгээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг татгалзсанд тооцно. Энэ тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох байгууллага ижил үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах тухай асуудлыг дахин гаргахгүй.

Азербайжан Улсын Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуульд зааснаар “тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тогтолцоо” гэдэгт дараах үйл явцыг багтаана. Үүнд:

- тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны төрлийг тогтоох;
- тэдгээрийг олгох;
- тэдгээрийн хуулбар, нэмэлт материалыг гаргаж өгөх;
- тэдгээрийг дахин олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;
- тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтэд хяналт тавих зэрэг болно.

Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар хэд хэдэн төрийн байгууллагууд бүх зөвшөөрөлд хяналт тавьж ажиллана. Үүнд:

- 1) тусгай зөвшөөрөл олгох байгууллага;
- 2) зөвшөөрөл олгох байгууллага;
- 3) төрийн эрх бүхий байгууллага.

Тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөл олгох байгууллагуудыг хуулиар болон Засгийн газрын холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтооно. Эдгээр байгууллагууд нь аливаа зөвшөөрөл олгохтой холбоотой бүхий л ажиллагаа (тэдгээрийн хуулбар, нэмэлт материалыг гаргаж өгөх, тэдгээрийг дахин олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох)-г хэрэгжүүлэх, олгогдсон бүх зөвшөөрлийн бүртгэлийг хөтлөх ба тэдгээрт хяналт тавихтай холбоотой дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- аливаа зөвшөөрлийн бүртгэлд мэдээлэл оруулах, шинэчлэгдэх бүрд энэ тухай мэдээллийг тухайн зөвшөөрөлд хяналт тавих эрх бүхий байгууллагад илгээх;
- салбарын хуулиар олгож байгаа зөвшөөрлүүдэд хяналт тавих.

Харин **төрийн эрх бүхий байгууллага** нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд буюу Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуульд заасан үйл ажиллагааны төрөлд олгох зөвшөөрлүүдэд хяналт тавина.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг Аж ахуй эрхлэгчдэд тавих хяналтыг зохицуулах, бизнес эрхлэгчдийн эрхийг хамгаалах тухай хуулийн дагуу хэрэгжүүлнэ. Энэ хуулиар аж ахуйн үйл ажиллагааны чиглэлээр явуулж буй хяналтын зорилго, зарчим, түүнийг зохион байгуулах журам, хяналтын байгууллага, тэдгээрийн албан тушаалтны эрх, үүрэг, аж ахуй эрхлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдуулан тавих шаардлагыг зохицуулсан байна. (Энэхүү хууль³⁸ нь төлбөртэй мэдээлэл болно.)

Гүрж Улсад Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулийн дагуу үндэслэл бүхий өргөдлийн үндсэн дээр үйл ажиллагааны цар хүрээ, хэлбэрээс хамаарч тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийг холбогдох төрийн захиргааны байгууллагууд олгодог. Аливаа зөвшөөрөл

³⁸ Закон Азербайджанской Республики О регулировании проверок, проводимых в области предпринимательства и защите прав предпринимателей от 2 июля 2013 года №714-IV.Q.
http://base.conform.ru/show_doc.php?doc=64236

олгох байгууллагууд нь тухайн зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтэд тавих хяналтыг дараах нийтлэг журмаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- зөвшөөрөл эзэмшигчид шалгалт явуулах тухай шийдвэрийг танилцуулна;
- зөвшөөрөл эзэмшигчээс аливаа зөвшөөрлийн нөхцөлийг биелүүлэхтэй шууд холбоогүй асуудлыг танилцуулахыг, эсхүл баталгаажуулахыг шаардахгүй;
- зөвхөн зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтэд газар дээр нь шалгах ба үүнд эрх бүхий байгууллагын шийдвэрээр захиргааны бусад байгууллагын төлөөлөгчид хамрагдаж болно;
- шалгалтын үед тусгай бүртгэл хөтөлж, дүгнэлт гаргана;
- хуульд өөрөөр заагаагүй бол жилд зөвхөн нэг удаа аливаа зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтэд хяналт тавина.

Тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтэд дараах журмаар хяналт тавина. Үүнд:

- тусгай зөвшөөрлийн нөхцөлийг биелэлтэд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тайланг хянах замаар хяналтаа хэрэгжүүлнэ –
 - тусгай зөвшөөрөл эзэмшигч нь жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдрийн хооронд тусгай зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтийн тайланг ирүүлнэ;
- хэрэв ирүүлсэн тайланд тусгай зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтийн талаар тодорхой мэдээлэл байхгүй бол эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийн нөхцөлийн биелэлтийг баталгаажуулсан тайланг гаргаж өгөх тодорхой хугацаа өгөх ба шаардлагатай бол тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй холбоо барина –
 - тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дээрх шаардлагыг биелүүлээгүй бол хуулиар тогтоосон хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Казахстан Улсад аливаа зөвшөөрлийн хяналтыг **төрийн хяналт, шалгалтын байгууллагууд** болон **орон нутгийн гүйцэтгэх байгууллагууд** хэрэгжүүлнэ.

Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хуулиар “зөвшөөрлийн хяналт”-д зөвшөөрөл олгох байгууллагуудын хэрэгжүүлэх дараах хяналтыг хамааруулсан байна. Үүнд:

- аливаа зөвшөөрлийг олгохоос өмнө – өргөдөл гаргагчийн тухайн зөвшөөрлийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд;
- аливаа зөвшөөрлийг олгосны дараа – тухайн зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хууль тогтоомжийг мөрдөж байгаа эсэхэд тус тус хяналт тавина.

Зөвшөөрлийн хяналтыг шалгалт болон урьдчилан сэргийлэх хяналт гэсэн хоёр хэлбэрээр хэрэгжүүлнэ. Зөвшөөрөл олгосны дараах хяналтыг энэ хоёр хэлбэрээр нь шалгах бол зөвшөөрөл олгохоос өмнөх хяналтыг тухайн субъект (объект) дээр очиж шалгана.

Аж ахуйн үйл ажиллагааны кодексын 87 дугаар зүйлд зааснаар төрийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх байгууллагууд, тэдгээрийн нэгж, нутаг дэвсгэрийн нэгж болон орон нутгийн гүйцэтгэх байгууллагууд байх ба тэд аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа хууль тогтоомжоор тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийнэ.

Киргиз Улсад “тусгай зөвшөөрлийн хяналт” нь **тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны чиглэлээр эрх бүхий төрийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах үйл ажиллагаа бөгөөд үүнийг** Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тогтолцооны тухай хуулийн 4 бүлэгт зохицуулсан байдаг.

Тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас дээрх хууль, Сайд нарын Танхимаас баталсан “Зарим төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай журам”-аар тогтоосон тусгай

зөвшөөрлийн шаардлагыг тухайн зөвшөөрөл эзэмшигч хангаж байгаа эсэхэд шалгалт хийнэ.

Тусгай зөвшөөрлийн хяналтыг шалгалтын хэлбэрээр явуулах ба шалгалтыг дараах байдлаар ангилна. Үүнд:

- тусгай зөвшөөрөл олгохоос өмнөх шалгалт – энэ шалгалтаар өргөдөл гаргагч тусгай зөвшөөрөл авахаас өмнө тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэргэжилтэн, байр, тээвэр тоног төхөөрөмж, бичиг баримт байгаа эсэхэд шалгалт хийнэ;
- тусгай зөвшөөрөл олгосны дараах шалгалт – энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрөл хүчинтэй байх хугацаанд хийсэн төлөвлөгөөт шалгалт болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хийх шалгалт;
- төлөвлөгөөт бус шалгалт – энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн зөвшөөрлийн шаардлагыг зөрчсөн тухай хувь хүн, хуулийн этгээдийн өргөдөл хүлээн авах, эсхүл хувь хүн, хуулийн этгээдийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл хүлээн авсны дараа тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас хийдэг шалгалт, мөн өмнөх шалгалтаар тусгай зөвшөөрлийн шаардлагын зөрчлийг илрүүлсэн бөгөөд тухайн зөрчлийг арилгасан эсэхэд хяналт тавих шалгалт;
- төлөвлөгөөт шалгалт – энэ нь тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас өөрийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний дагуу хийдэг шалгалт.

Тусгай зөвшөөрөл олгогч байгууллага нь төлөвлөгөөт бус шалгалтыг дараах үндэслэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэлгүйгээр хийх эрхтэй. Үүнд:

- тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн зөвшөөрлийн шаардлагын зөрчлийг арилгах тухай актыг биелүүлэх хугацаа дууссан;
- **тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн зөвшөөрлийн шаардлагыг зөрчсөн тухай хувь хүн, хуулийн этгээдийн өргөдөл хүлээн авсан, эсхүл хувь хүн, хуулийн этгээдийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл хүлээн авсан (үүнд төрийн эрх бүхий байгууллага, орон нутгийн засаг захиргаа, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ирүүлсэн мэдээлэл хамаарна);**
- тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа дууссан;
- тогтоосон тусгай зөвшөөрлийн шаардлагын зөрчлийг эрт арилгасан баримтыг тогтоох зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс төлөвлөгөөт бус шалгалт хийлгэх тухай өргөдөл гаргасан зэрэг болно.

ОХУ-д тусгай зөвшөөрөл олгох ажиллагаанд түүнийг олгох, бүртгэл хөтлөх зэргээс гадна түүний хяналт багтаж байдаг. Тусгай зөвшөөрлийн хяналтыг зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хуулийн дагуу хэрэгжүүлэхдээ Төрийн болон хотын хяналт (аудит)-ыг хэрэгжүүлэхэд хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчдийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан журмыг баримтална.

Тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус шалгалт явуулна. Төлөвлөгөөт шалгалтыг дараах тохиолдолд хийх ба үүнийг тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас өөрийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөндөө тусгана. Үүнд:

- тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан өдрөөс хойш нэг жилийн дараа;
- сүүлчийн төлөвлөгөөт шалгалт хийсэн өдрөөс хойш 3 жилийн дараа;
- эрсдэлд суурилсан хандлагыг ашиглан явуулах тусгай зөвшөөрлийн хяналтыг тусгай зөвшөөрлийн журмаар тогтоосон давтамжийн дагуу;

- эрүүл мэнд, боловсрол, нийгмийн чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигчийг ОХУ-ын Засгийн газраас төлөвлөгөөт шалгалт хийх давтамжийн дагуу.

ОХУ-ын тусгай зөвшөөрлийн төлөвлөгөөт бүс (газар дээр нь хийх) шалгалт хийх үндэслэл нь Киргиз Улсын зохицуулалттай адил байна. ОХУ-ын мөн тус улсын Ерөнхийлөгч, эсхүл Засгийн газрын зааврын дагуу тусгай зөвшөөрөл олгох байгууллагаас гаргасан тушаал, заавраар төлөвлөгөөт шалгалтыг хийдэг байна.

Узбекистан Улсад тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, мэдэгдэл олгох төрийн эрх бүхий байгууллагууд нь энэхүү үйл явцад хяналт тавих хэрэгжүүлэхдээ дараах эрхтэй. Үүнд:

- хувь хүн, хуулийн этгээд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, мэдэгдлийн шаардлага, нөхцөлийг дагаж мөрдөж байгаа эсэхэд газар дээр нь шалгалт хийх;
- шалгалт хийх явцад гарсан асуудлын талаар шаардлагатай мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардах, хүлээн авах;
- хяналт шалгалтын дүнг үндэслэн хувь хүн, хуулийн этгээд холбогдох шаардлага, нөхцөлийг зөрчсөн тухай акт гаргах;
- илэрсэн зөрчлийг арилгахыг иргэн, хуулийн этгээдэд үүрэг болгосон шийдвэр гаргах, зөрчлийг арилгах хугацааг тогтоох;
- тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай өргөдөл шүүхэд гаргах;
- мэдэгдэл эзэмшигчийн үйл ажиллагаа (үйлдэл)-г түдгэлзүүлэх, сэргээх тухай шийдвэр гаргах, үйл ажиллагаа (үйлдэл)-г нь зогсоох тухай өргөдөл шүүхэд гаргах, мөн түүнд тухайн үйл ажиллагаа (үйлдэл) хийхийг хориглох;
- зөрчил гаргасан хуулийн этгээдийг хуулийн дагуу торгууль ногдуулах тухай өргөдөл гаргах;
- тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, мэдэгдэл олгоход тухайн иргэн, хуулийн этгээдийг улсын хураамж төлөхгүйгээр бүрэн эрхээ хэрэгжүүлэх тухайн хүсэлт шүүхэд гаргах.

Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл болон мэдэгдлийн шаардлага, нөхцөлийн биелэлтэд тавих хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:

- тусгай цахим системээр дамжуулан зайнаас шалгах;
- хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу газар дээр нь очиж шалгах;
- тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, мэдэгдлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх ба тэднээс шаардлагатай мэдээллээ хүсэх.

Дээрх ажиллагааг хэрэгжүүлэхдээ холбогдох этгээдээс холбоогүй мэдээлэл хүсэх, эсхүл шаардахыг хориглоно.

Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, мэдэгдэл олгох төрийн эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, мэдэгдлийн шаардлага, нөхцөлийг зөрчсөнийг илрүүлсэн тохиолдолд хяналтын болон хууль сахиулах байгууллага эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

3. Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн нэр төрөл, тоог тогтоох, өөрчлөлт оруулах процедур

БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль батлагдахаас өмнө тусгай зөвшөөрөл тогтоох эрх, үүсгэн байгуулах субъект нь тодорхой бус байсны улмаас тусгай зөвшөөрлийн

тоо тасралтгүй нэмэгдэж, үүнээс улбаалан эдийн засаг, нийгмийн хөгжилд саад учирч, иргэн, хуулийн этгээд болон бусад байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байжээ. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Захиргааны тусгай зөвшөөрлийн тухай хууль нь Нэгдүгээрт, захиргааны тусгай зөвшөөрлийн төрлийг тогтоох, Хоёрдугаарт, тусгай зөвшөөрөл тогтоох субъектийг хуульчлах, тусгай зөвшөөрөл олгох субъектийг хатуу хязгаарлаж, багасгах зорилготой батлагдсан байна.

Захиргааны тусгай зөвшөөрлийг тогтоохдоо эдийн засаг, нийгмийн хөгжлийн зарчимд нийцсэн, иргэд, хуулийн этгээд, бусад байгууллагын санаачлагаар хамгаалагдсан, нийтийн ашиг сонирхол, нийгмийн дэг журмыг хамгаалахыг зорьдог байна.³⁹

Захиргааны тусгай зөвшөөрлийг тогтоох субъект: Захиргааны тусгай зөвшөөрлийг БХАТИХ, түүний Байнгын хорооноос баталсан хуулиар болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоодог.

Дараах тусгай зөвшөөрлийг зөвхөн хуулиар тогтооно.⁴⁰ Эдгээрт:

- улсын болон олон нийтийн аюулгүй байдал, экологи, хүрээлэн буй орчныг хамгаалах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдалтай шууд холбоотой тусгай үйл ажиллагааг хуулийн шаардлагад нийцүүлэн батална;
- байгалийн хязгаарлагдмал нөөцийг хөгжүүлэх, ашиглах, нийтийн баялгийг хуваарилах, нийтийн ашиг сонирхолд шууд хамааралтай тусгай худалдааг зах зээлд нэвтрүүлэх;
- төрөөс үйлчилгээ үзүүлдэг, нийтийн ашиг сонирхол шууд хамааралтай, тусгай ур чадвар, тусгай нөхцөл шаардсан мэргэжлүүд;
- орчин тойрондоо аюул учруулж болзошгүй тоног төхөөрөмж, барилга байгууламж, бүтээгдэхүүн, эд зүйлсийг стандарт, шалгуурын дагуу үзлэг, туршилт, хорио цээрийн аргаар шалгаж баталгаажуулсан байх;
- мэргэшлийн түвшин тогтоож тусгай зөвшөөрөл олгох байгууллага байгуулах;
- хууль тогтоомжийн дагуу захиргааны тусгай зөвшөөрөл олгож болох бусад асуудлууд.

Шаардлагатай тохиолдолд Төрийн зөвлөл тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргах хэлбэрийг баталж болохыг БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 14 дүгээр зүйлд заасан байна.

Бусад захиргааны тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ. Эрх бүхий байгууллагад мужийн болон аймгийн Ардын засгийн газрууд, автономит муж, эсхүл төв засгийн газрын шууд харьяа хотын захиргаа, орон нутгийн эрх бүхий байгууллагууд хамаарна.

Тусгай зөвшөөрлийг орон нутгийн журмаар тогтоох: Орон нутгийн эрх бүхий байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох хялбаршуулсан журмыг хэрэгжүүлдэг байна. Энэ нь Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль, захиргааны журмаар зохицуулагдаагүй үйл ажиллагаанд нэн яаралтай тусгай зөвшөөрөл олгох шаардлага гарсан бол дээрх хуулийн 12 дугаар зүйлд заасан зохицуулалтын хүрээнд тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагаас шийдвэрлэн холбогдох тусгай зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгодог. Ингэхдээ тухайн аймгийн Ардын засгийн газар журмаар, автономит муж, эсхүл төв засгийн газрын шууд харьяа хотын захиргаа захиргааны түр тусгай зөвшөөрлийг олгож болдог. Уг түр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах шаардлагатай бол

³⁹ БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 11 дүгээр зүйл

⁴⁰ БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 12 дугаар зүйл

Ардын их хурал, түүний Байнгын хороонд анх олгосон байгууллага санал гаргана.⁴¹

Хууль тогтоомж батлах замаар тусгай зөвшөөрөл тогтоохдоо төсөл боловсруулагч байгууллага нь тусгай зөвшөөрөл олгох зайлшгүй шаардлага, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар сонсгол, санал асуулгыг иргэд, олон нийтээс авна. Энэ талаарх санал, дүгнэлтийг хууль тогтоомж батлах эрх бүхий байгууллагад өгнө.⁴²

Гүрж Улсын Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар тусгай зөвшөөрөлд тавигдах тусгай нөхцөлүүдийг хангасан эсэхийг бодит байдал дээр танилцсаны үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгоно. Тус улсад тусгай зөвшөөрлийг үйл ажиллагааны болон ашиглалтын гэж хоёр ангилна:

а) үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар тодорхойлсон үйл ажиллагаа эрхлэх эрх. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан тусгай нөхцөлүүдийг хангах үүрэгтэй бөгөөд уг тусгай зөвшөөрлийг өв залгамжлалаар болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэхгүй;

б) ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар тогтоосон тус улсын тодорхой нөөцийг ашиглах эрх. Зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийн тухай, Цахим харилцаа холбооны тухай хуулиудад зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгоно. Уг тусгай зөвшөөрлийг бусдад ашиглуулах, бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх, өв залгамжлуулж болно.

Казахстаны Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хуулиар зөвшөөрлийг аюулын түвшингээр нь дараах байдлаар хуваасан бөгөөд аюулын түвшинг зохицуулалтын нөлөөллийн дүн шинжилгээнд үндэслэж тогтооно:

а) нэгдүгээр зэргийн зөвшөөрөл буюу тусгай зөвшөөрөл - аюулын өндөр түвшингийн үйл ажиллагааны төрөлд олгоно;

б) хоёрдугаар зэргийн зөвшөөрөл буюу зөвшөөрөл - аюулын дунд түвшингийн үйл ажиллагааны төрөлд олгоно.

Судалгаанд хамрагдсан улсуудын хуулиар **зөвшөөрөл** бол тодорхой төрлийн үйл ажиллагааны хүрээнд тодорхой үйлдэл хийх, ажиллагаа хэрэгжүүлэх эрх бөгөөд зөвшөөрөл эзэмшигч нь хуулиар тогтоосон, эсхүл тухайн зөвшөөрөлд заасан нөхцөлийг хангах үүрэгтэй. **Азербайжаны** Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуульд зөвшөөрлийг дан ганц “зөвшөөрөл” (“разрешение”, “согласие”) гэхээс гадна “сертификат”, “гэрчилгээ” (“свидетельство”), “магадлан итгэмжлэл” (“аккредитация”) зэрэг нэр томъёог хэрэглэжээ.

Казахстанд хоёрдугаар зэргийн зөвшөөрөл буюу зөвшөөрлийг тухайн объектоос хамаарч дараах байдлаар **6 ангилна:**

- ангилал 1 - үйл ажиллагаанд олгох зөвшөөрөл;
- ангилал 2 - объектод олгох зөвшөөрөл;
- ангилал 3 - нэг удаагийн зөвшөөрөл;
- ангилал 4 - хязгаарлагдмал нөөцтэй, эсхүл квоттой үйл ажиллагаанд олгох зөвшөөрөл;
- ангилал 5 - хувь хүмүүст мэргэжлийн үйл ажиллагаанд олгох зөвшөөрөл;
- ангилал 6 - бүтээгдэхүүнд олгох зөвшөөрөл.

⁴¹ БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 15 дугаар зүйл

⁴² БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 19 дүгээр зүйл

Киргизэд тусгай зөвшөөрөл болон зөвшөөрлийг тухайн үйл ажиллагааны хугацаа, нутаг дэвсгэрийн хамрах хүрээ, өмчлөх эрх болон тусгай зөвшөөрлийн хэлбэрээр нь төрөлжүүлжээ:

1) үйл ажиллагааны хугацаагаар нь:

- а) хугацаагүй - хүчинтэй байх хугацааг хязгаарлахгүйгээр гаргасан;
- б) хугацаатай - тодорхой хугацаагаар олгосон (Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг зөвхөн улсын хязгаарлагдмал нөөц ашиглах, гадаад худалдааны болон тэсрэх бодис, бүтээгдэхүүн, зэвсэг, сумтай холбоотой үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл болон Үндэсний банкнаас олгосон тусгай зөвшөөрөл, мөн зэвсэг, сум, өндөр хортой бодис, аюултай ачаа зэрэгтэй холбоотой үйл ажиллагааны зөвшөөрөлд тогтооно.)

2) нутаг дэвсгэрийн хамрах хүрээгээр нь:

- а) үр нөлөө нь олон улсын гэрээний үндсэн дээр Киргиз Улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан, түүнчлэн түүний хилээс гадуур;
- б) үр нөлөө нь Киргиз Улсын тодорхой нутаг дэвсгэрт, түүнчлэн зөвхөн улсын хязгаарлагдмал нөөцийг ашиглах тусгай зөвшөөрөл, Үндэсний банкнаас олгосон тусгай зөвшөөрөл, мөн зэвсэг, сум, нууцаар мэдээлэл авах зориулалттай техникийн тусгай хэрэгсэлтэй холбоотой үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй холбоотой;

3) өмчлөх эрхээр нь:

- а) салгаж болохгүй (неотчуждаемые);
- б) салгаж болох (зөвхөн улсын хязгаарлагдмал нөөцийг ашиглах тусгай зөвшөөрөлтэй холбоотой);

4) тусгай зөвшөөрлийн хэлбэрээр нь:

- а) цаасаар олгосон тусгай зөвшөөрөл;
- б) цахим тусгай зөвшөөрөл;
- в) үйл ажиллагааны хэмжээ, эрхийн багцаар (бараа экспортлох, импортлох үед);
- г) ерөнхий лиценз;
- д) нэг удаагийн тусгай зөвшөөрөл;
- е) тусгай лиценз.

Мөн **Казахстан, Узбекистан** улсуудад **мэдэгдэл** байх бөгөөд энэ нь мэдэгдэл гаргагчаас холбогдох журмын дагуу өөрийн үйл ажиллагаа (үйлдэл) эхлүүлэх (дуусгавар болгох) тухай эрх бүхий байгууллагад илгээсэн мэдээлэл юм.

Судалгаанд хамрагдсан ТУХН-ийн орнуудад тусгай зөвшөөрөл буюу зөвшөөрлийн төрлүүд, эсхүл аливаа зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны төрлүүдийг хуульд тодорхой жагсааж хуульчилсан байна. Жагсаалтыг хуулийн заалт дотор (Армени, Гүрж, Киргиз, ОХУ), эсхүл хавсралтад (Азербайжан, Казахстан, Узбекистан) тусгасан байна. (Хүснэгтээс үзнэ үү.)

Хүснэгт. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны тоо

№	Улсын нэр, эрх зүйн зохицуулалт	Тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны (тусгай зөвшөөрлийн) тоо	Зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны (зөвшөөрлийн) тоо
1.	Азербайжан – Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулийн 1, 2, 3 дугаар хавсралт	Нийт 29 чиглэлийн 67 үйл ажиллагаа: • Тусгай зөвшөөрөл шаардлагатай 24 чиглэлийн 51 үйл ажиллагаа (үндэсний аюулгүй байдлын асуудлаас бусад) • Үндэсний аюулгүй байдалтай холбоотой тусгай зөвшөөрөлтэй 5 чиглэлийн 16 үйл ажиллагаа	Аж ахуй эрхлэх 86 зөвшөөрөл
2.	Армени – Тусгай зөвшөөрөл олгох тухай хуулийн §43	Тусгай зөвшөөрөл олгох 19 чиглэлийн 78 үйл ажиллагаа	–
3.	Гүрж – Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулийн §6, 24	Нийт 61 төрлийн тусгай зөвшөөрөл: • үйл ажиллагааны 50 • ашиглалтын 11	64 төрлийн зөвшөөрөл
4.	Казахстан – Зөвшөөрөл ба мэдэгдлийн тухай хуулийн 1, 2 дугаар хавсралт	29 чиглэлийн 76 нэгдүгээр зэргийн зөвшөөрөл буюу тусгай зөвшөөрөл	Нийт 212 хоёрдугаар зэргийн буюу зөвшөөрөл: • ангилал 1 - үйл ажиллагааны 55 • ангилал 2 - объектын 34 • ангилал 3 - нэг удаагийн 54 • ангилал 4 - хязгаарлагдмал нөөцтэй, эсхүл квот ашиглан үйл ажиллагааны 26 • ангилал 5 - хувь хүмүүст мэргэжлийн үйл ажиллагаа явуулах 26 • ангилал 6 - бүтээгдэхүүний 17
5.	Киргиз – Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тогтолцооны тухай хуулийн §15-17	Нийт 63 төрлийн үйл ажиллагаа: • тусгай зөвшөөрөлд хамаарах энгийн 56 төрлийн үйл ажиллагаа • тусгай зөвшөөрөлд хамаарах төрийн хязгаарлагдмал нөөцийг ашиглах 7 төрлийн үйл ажиллагаа	31 төрлийн үйл ажиллагаа
6.	ОХУ – Зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хуулийн §12	Нийт 77 төрлийн үйл ажиллагаа тусгай зөвшөөрөлд хамаарна (Зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай болон Агаарын тухай, Газрын хэвлийн тухай, Зэвсгийн тухай, Даатгалын үйл ажиллагаа зохион байгуулах тухай, Төрийн нууцын тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Эмийн эргэлтийн тухай хуулиар) • зөвхөн зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хуулиар 54 төрлийн үйл ажиллагаа тусгай зөвшөөрөлд хамаарна	–
7.	Узбекистан – Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл ба мэдэгдэл олгох журмын тухай хуулийн 1, 2 дугаар хавсралт	49 тусгай зөвшөөрөл	120 зөвшөөрөл

Мэдэгдлийн хувьд Казахстан Улсын хуулиар **56**, Узбекистан улсын хуулиар **33** мэдэгдлийг тус тус тусгасан байна.

Судалгаанд хамрагдсан ТУХН-ийн улсуудад тусгай зөвшөөрөл буюу зөвшөөрлийн төрлүүд, эсхүл аливаа зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны төрлүүдийг ийнхүү хуулиар тогтоосон нь зөвхөн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар уг жагсаалтыг өөрчлөх боломжтой. Мөн энэ талаар эдгээр улсуудын хуульд ч тусгасан байна. Тухайлбал, **Арменид** тусгай зөвшөөрөл олгох бол зөвхөн Тусгай зөвшөөрөл олгох тухай хуульд заасан үйл ажиллагааны төрөл тус бүрд тусгай зөвшөөрөл олгохоор, **Азербайжанд** зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны төрлийг (санхүүгийн зах зээлийн салбараас бусад) зөвхөн Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар тогтоосны дараа холбогдох салбарын хууль тогтоомжид тусгахаар тус тус хуульчилжээ.

Армени, Гүрж, Киргиз, ОХУ-ын хуульд тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрөл олгохдоо эдийн засгийн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ хүний амь нас, эрүүл мэндийн, хүний амьдрах болон соёлын орчны, төрийн болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах зарчмыг баримтална.

Арменид тусгай зөвшөөрөл олгохдоо тус улсын нутаг дэвсгэрт эдийн засгийн үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хангах, тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны төрлүүдийн нэгдсэн жагсаалт гаргах, тусгай зөвшөөрөл олгох нэгдсэн журмыг тогтоох зэрэг зарчмыг баримтална. Харин **Гүржид** тодорхой үйл ажиллагаа нь хүний амь нас, эрүүл мэндэд, төрийн болон олон нийтийн ашиг сонирхолд аюул заналхийлж байгаа харилцааг тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тусламжтайгаар хэрэгжүүлж байна. Төрийн зохицуулалтыг гагцхүү тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгосноор энэ аюулыг бууруулах, улсын болон олон нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх боломжтой тохиолдолд хэрэгжүүлнэ.

Казахстан, Киргиз, ОХУ, Узбекистаны хуульд уг жагсаалтыг өөрчлөх шалгуурыг тогтоосон байна. Тухайн **үйл ажиллагаа** нь хүний ба иргэний амь нас, эрүүл мэндэд, мөн хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй тухайн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгодог байна.

Тухайлбал, **Узбекистанд** хувь хүн, хуулийн этгээд тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх нь иргэний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, олон нийтийн аюулгүй байдал болон байгаль орчинд хохирол учруулж болзошгүй байдал нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох үндэслэл болно. **Казахстан Улсад тухайн үйл ажиллагааны аюулын түвшингээс нь хамаарч** тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн төрөлд өөрчлөлт оруулах **ба аюулын түвшинг нөлөөллийн дүн шинжилгээнд үндэслэж тогтооно.**

Киргизэд тусгай зөвшөөрлийг олгохдоо дараах шалгуурыг баримтална. Үүнд:

а) тухайн үйл ажиллагааны төрийн зохицуулалтын бусад арга нь энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгө, олон нийтийн болон төрийн аюулгүй байдалд учирч болзошгүй хохирлыг бууруулахгүй байх (тус улсын Сайд нарын танхимаас баталсан эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу хийсэн үнэлгээнд үндэслэнэ);

б) төрийн хязгаарлагдмал нөөцийг оновчтой удирдах зэрэг болно.

ОХУ-д тодорхой төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг мөн иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол, амь нас, эрүүл мэнд болон байгаль орчин, тус улсын ард түмний соёлын өвд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор

хийдэг. Харин тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрлийг хуулиар тогтоох нь тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үндсэн зарчмуудын нэг юм.

Гэвч тус улсад тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчны тулгамдсан асуудлуудын нэг нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны төрлүүдийн тоо аж. Нэг талаас, тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа цөөрсөн (жишээлбэл, барилга, аялал жуулчлал, тур операторын үйл ажиллагаа гэх мэт), тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулалтын бусад аргуудаар зохицуулах болсон (жишээлбэл, аудит, үнэлгээ болон барилгын үйл ажиллагаанууд өөрөө өөрийгөө зохицуулна (саморегулирование)). Нөгөө талаас, зарим тохиолдолд тусгай зөвшөөрлийн хүрээ өргөжсөн. 2014 онд Орон сууцны тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор орон сууцны барилга барих тусгай зөвшөөрлийг шинээр нэвтрүүлсэн. Энэ нь орон сууцны менежментэд гарч байсан олон зөрчлийг арилгахад эерэг нөлөө үзүүлсэн байна.⁴³

Мөн 2018 оноос биоанагаахын эсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, амьтны хүрээлэн (зоопарк, зоосад), цирк, амьтны театр (зоотеатр), далайн усан сан (океанариум) зэрэгт амьтдыг арчлах, ашиглах зэрэг үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгож эхэлжээ.

Цаашид ч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны жагсаалтыг өргөжүүлэх шаардлага гарч ирсээр байна. Жишээлбэл, Япон, АНУ, Их Британи зэрэг улсуудад криптовалют, блокчэйн үйл ажиллагаа эрхлэхэд зөвшөөрөлтэй байдаг. Уламжлалт төдийгүй дижитал валютын солилцооны үйлчилгээ нь олон улсын санхүүгийн харилцан үйлчлэлийн шинэ түвшинг илэрхийлэх болсон. Иймд олон улсын санхүүгийн зах зээлд бүрэн нэвтрэх, энэ чиглэлээр гарч болзошгүй зөрчлөөс зайлсхийхийн тулд ОХУ-д криптовалют, блокчэйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг нэвтрүүлэх шаардлагатай хэмээн тус улсын судлаачид үзэж байна.⁴⁴

ОХУ-д аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл шаардлагагүй болсон талаар өмнө дурдсан. Гэвч судлаачдын үзэж байгаагаар, аялал жуулчлалын, мөн зочид буудлын үйл ажиллагаанд тусгай зөвшөөрлийг эргүүлж нэвтрүүлэх шаардлагатай. Жишээ нь, зочид буудлын бизнес нь АНУ, Герман болон бусад орнуудад тусгай зөвшөөрөл авдаг эерэг туршлага байна. ОХУ-ын хэмжээнд тусгай зөвшөөрлийн нэгдсэн шаардлагыг бий болгосноор аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээ шинэ түвшинд гаргах боломжийг олгох аж.⁴⁵

4.Зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийг дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаар олгох

БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хуульд сонгон шалгаруулалт, дуудлага худалдаатай холбоотой дараах зохицуулалтыг тусгасан байна.

Дуудлага худалдаа⁴⁶ Захиргааны байгууллага нь байгалийн хязгаарлагдмал нөөцийг хөгжүүлэх, ашиглах, нийтийн баялгийг хуваарилах, нийтийн ашиг сонирхолд шууд хамааралтай тусгай худалдааг зах зээлд нэвтрүүлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо тендер, дуудлага худалдаа зэрэг шударга өрсөлдөөний аргыг хэрэглэн шийдвэр гаргадаг.

Тусгай зөвшөөрлийг тендер, дуудлага худалдаагаар олгох журам нь холбогдох хууль, захиргааны журамд нийцсэн байна. Дээрх журмын дагуу тендерт ялагч, худалдан авагчийг тодруулсны дараа ялагчид тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгодог.

⁴³ Л.В.Стандзнь. Система федерального законодательства о лицензировании: проблемы и перспективы законодательного регулирования. Актуальные проблемы российского права. 2018. No 12 (97).

⁴⁴ <https://cyberleninka.ru/>

⁴⁵ Мөн тэнд.

⁴⁶ Мөн тэнд.

⁴⁶ БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль 53 дугаар зүйл

Захиргааны байгууллага Захиргааны тусгай зөвшөөрлийн хуулийг зөрчиж тендер, дуудлага худалдааны хэлбэрийг батлаагүй, эсхүл тендер, дуудлага худалдаа явуулах журмыг зөрчсөн нь өргөдөл гаргагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд өргөдөл гаргагч нь хуулийн дагуу нэхэмжлэл гаргаж болно.

БНХАУ-д Дуудлага худалдааны тухай хууль⁴⁷ (Auction Law of the People's Republic of China), Тендерийн урилга, тендерийн хууль⁴⁸ (Law of the People's Republic of China on Bid Invitation and Bidding) байдаг боловч эдгээр хуулиудаар зөвшөөрлийн сонгон шалгаруулалт, дуудлага худалдааг нарийвчлан зохицуулаагүй байна.

Сингапур, Шотланд улсуудад холбогдох хууль тогтоомж, түүнийг даган гарсан холбогдох журмын хүрээнд судлан үзэхэд дуудлага худалдаа болон сонгон шалгаруулалтаар олгож байгаа зохицуулалт байхгүй байна.

Азербайжан, Армени, Гүрж, Узбекистан зэрэг улсын зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл)-ийн харилцааг зохицуулж байгаа бие даасан хуулиудад тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрлийг сонгон шалгаруулах буюу дуудлага худалдаагаар олгож болохыг заасан байна. Тухайлбал, **Арменийн** хуульд телевиз, радиогийн нэвтрүүлэг цацах болон хувийн мультиплексийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулах уралдааны үр дүнд тусгай зөвшөөрөл олгохоор хуульчилсан байна.

Узбекистанд тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалт (тендер)-ын үндсэн дээр олгох бөгөөд түүнийг сонгон шалгаруулалт (тендер)-аар олгох журам, нөхцөлийг тус улсын Сайд нарын танхим тогтооно. Тусгай зөвшөөрлийн шаардлага, нөхцөлийг зохих ёсоор хангасан өргөдөл гаргагч нь тухайн зөвшөөрлийг сонгон шалгаруулалт (тендер)-д давуу эрх эдлэх ба түүний санал нь сонгон шалгаруулалт (тендер)-д оролцож буй өөр өргөдөл гаргагчийн оновчтой саналтай тэнцсэн бол энэхүү давуу талыг хэрэглэнэ.

Гүрж Улсад ашиглалтын тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгох ба журмыг нь Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар судалгаанд хамрагдсан бусад орны бие даасан хуультай харьцуулахад илүү тодорхой зохицуулжээ.

Тус улсад баялаг ашиглах тусгай зөвшөөрлийн олголтыг уг зөвшөөрөл хүсэгчийн хүсэлтэд үндэслэн тусгай зөвшөөрөл олгогч байгууллагын шийдвэрээр хэрэгжүүлнэ. Уг зөвшөөрлийг олгоход тухайн объектыг ашиглахтай холбоотой нэмэлт нөхцөл тавьж болох ба нэмэлт нөхцөлийг хуулиар тогтоох аж.

Тусгай зөвшөөрөл олгогч байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ашиглалтын тусгай зөвшөөрлийн объектын тоо, хэмжээ, ашиглах журмыг батлах;
- олон нийтийн болон төрийн эрх ашгийн үүднээс ашиглалтын тусгай зөвшөөрлийн объектын тоо хэмжээ, чанар, цаг хугацаа ба ашиглалтын хязгаарлалтыг тогтоох;
- дуудлага худалдааг олон нийтэд мэдээлэх;
- дуудлага худалдаанд оролцох хүсэлт хүлээн авах эцсийн хугацааг тухай бүр тогтоох;
- дуудлага худалдааны анхны үнийг болон тухайн тусгай зөвшөөрлийн хугацааг харгалзан тогтоох (Тухайн тусгай зөвшөөрлийн объектын шинж чанар, ашиглалтын технологийг харгалзан хугацааг нь тогтооно. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгохгүй);
- тусгай зөвшөөрлийн хугацааг Гүрж Улсын Засгийн газрын зөвшөөрлөөр сунгах;
- дуудлага худалдаа зохион байгуулах, ялагчийг тодруулах;
- тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгох журмыг батлах.

⁴⁷ БНХАУ-ын Дуудлага худалдааны тухай хууль <http://www.asianlii.org/cn/legis/cen/laws/alotproc366/>

⁴⁸ БНХАУ-ын Тендерийн урилга, тендерийн хууль <http://www.asianlii.org/cn/legis/cen/laws/biabi226/>

Тухайн нэг нөөц ашиглах тусгай зөвшөөрлийн хүрээнд өөр тусгай зөвшөөрөл буюу зөвшөөрөл шаардлагагүй. Тухайн нэг нөөц ашиглах тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангасан, дуудлага худалдаагаар хамгийн өндөр үнийн санал болгосон этгээдэд уг тусгай зөвшөөрлийг олгоно.

Тусгай зөвшөөрөл олгогч байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээсэн, тусгай зөвшөөрлийн нөхцөлийг бүрэн хангасан тусгай зөвшөөрөл хүсэгч бүр дуудлага худалдаанд оролцох эрхтэй бөгөөд дуудлага худалдааг зарласнаас хойш 15-аас багагүй хоногийн дотор түүнд оролцох хүсэлтээ гаргана.

Дуудлага худалдааг дараах журмын дагуу зохион байгуулна. Үүнд:

- тусгай зөвшөөрөл олгогч байгууллага нь дуудлага худалдаа болохоос 1 сарын өмнө энэ талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсандаа байршуулна:
 - дуудлага худалдааг өөр цахим хуудсаар явуулах бол тусгай зөвшөөрөл олгогч байгууллага нь энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дуудлага худалдаа болохоос 3-аас багагүй хоногийн өмнө өөрийн цахим хуудсандаа байршуулна;
 - дуудлага худалдаа явагдах тухай мэдээллийг бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно;
- олборлолтын хэмжээ нь 500,000 куб метр/тонноос хэтрэхгүй бол эрчим хүч, түлш (газрын тос, байгалийн хийнээс бусад), уул уурхай-химийн түүхийн эд, эрдсийн бус түүхий эд, барилгын түүхий эд олборлох тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг зохион байгуулах тухай мэдээллийг тусгай зөвшөөрөл олгогч байгууллага дуудлага худалдаа болохоос 15-аас багагүй хоногийн өмнө олон нийтэд зарлана:
 - дуудлага худалдааг өөр цахим хуудсаар явуулах бол тусгай зөвшөөрөл олгогч байгууллага нь энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дуудлага худалдаа болохоос 3-аас багагүй хоногийн өмнө өөрийн цахим хуудсандаа байршуулна;
 - дуудлага худалдаа явагдах тухай мэдээллийг бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно;
- олон нийтэд зарлахад дор дурдсан мэдээллийг оруулна:
 - a) тусгай зөвшөөрөл олгогч байгууллагын нэр;
 - b) ашиглалтын тусгай зөвшөөрлийн объект;
 - c) тусгай зөвшөөрөл хүсэгчийн хүсэлтийг хүлээн авах, дуудлага худалдаа болох хугацаа;
 - d) хуулиар тогтоосон тусгай зөвшөөрлийн нөхцөл;
 - e) тухайн объектыг ашиглахад тавигдах шаардлага;
 - f) ялагчийг тодруулах шалгуур;
 - g) тусгай зөвшөөрөл олгогч байгууллагын шийдвэртэй холбоотой бусад мэдээллүүд;
 - h) тусгай зөвшөөрөл зэрэг болно.

Гүржийн Тусгай зөвшөөрөл ба зөвшөөрлийн тухай хуулиар **гадна зар сурталчилгаа байршуулах зөвшөөрлийг** дуудлага худалдаагаар олгоно. Энэхүү зөвшөөрөл нь төрийн өмчит буюу нутгийн өөрөө удирдах байгууллагын өмчид байгаа газар болон эд хөрөнгийн гадна байршуулах зар сурталчилгаанд хамаарна. Нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөллийн байгууллага нь уг зөвшөөрлийг олгох шийдвэрийг гаргах бөгөөд дуудлага худалдаа явуулах, дуудлага худалдааны анхны үнэ тогтоох журмыг батална. Уг

зөвшөөрлийн нөхцөлийг биелүүлсэн, хамгийн өндөр үнэ санал болгосон этгээдэд уг зөвшөөрлийг олгоно.

ОХУ-ын Зарим төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай хуулиар тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах буюу дуудлага худалдаагаар олгох харилцааг зохицуулаагүй, харин холбогдох салбарын хуулиудаар зохицуулжээ. Тухайлбал, тус улсын **Газрын хэвлийн тухай хуулийн**⁴⁹ дагуу ОХУ-ын хуульд заасны дагуу газрын хэвлийг ашиглахад геологийн болон ашигт малтмалын хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл олгодог. Газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдаа явуулах нийтлэг журмыг Газрын хэвлийн тухай энэ хуулиар, нарийвчилсан харилцааг Газрын хэвлий ашиглалтын холбооны агентлаг (Роснедр)-ийн регламентаар тус тус зохицуулсан байна.

Холбооны болон орон нутгийн ач холбогдол бүхий газрын хэвлий, мөн түүнд хамааралгүй газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдаа Засгийн газраас тогтоосон журмын дагуу цахим хэлбэрээр явагдана. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу төрийн болон төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай адил тогтолцоогоор гүйцэтгэнэ.

Дуудлага худалдаа явуулах шийдвэр, дуудлага худалдааны комиссын бүрэлдэхүүнийг дараах байдлаар гаргана:

- 1) ОХУ-ын Засгийн газар – холбооны ач холбогдол бүхий газрын хэвлийн талбайтай холбоотой;
- 2) ОХУ-ын субъектүүдийн төрийн байгууллагууд – орон нутгийн ач холбогдол бүхий газрын хэвлийн талбайтай холбоотой;
- 3) газрын хэвлийн улсын санг удирдах холбооны байгууллага, эсхүл түүний орон нутгийн албууд – дээрхээс бусад газрын хэвлийн талбайтай холбоотой.

ОХУ-ын Засгийн газар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- холбооны ач холбогдол бүхий газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдаа явуулах журмыг тогтоох;
- газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдаанд оролцогчдод тавигдах тусгай шаардлагыг тогтоох (ингэхдээ ОХУ-ын төрийн эрх бүхий байгууллагаас баталсан стратеги төлөвлөлтийн баримт бичгүүд, мөн ОХУ-ын бүх иргэд болон тухайн нутаг дэвсгэрт амьдарч буй хүн амын нийгэм, эдийн засаг, байгаль орчин, бусад ашиг сонирхлыг харгалзана).

Дуудлага худалдааны зарыг дуудлага худалдаа болох өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө ОХУ-ын мэдээлэл, харилцаа холбооны “Интернет” албан ёсны цахим платформд байршуулна. Энэхүү цахим платформд мөн төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зарыг байршуулдаг байна.

Дуудлага худалдааны комисс нь дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг хянан хэлэлцсэн тухай болон дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө, мөн дуудлага худалдаанд оролцохыг зөвшөөрөөгүй өргөдөл гаргагчийн талаарх мэдээлэл, үүнд оролцохоос татгалзсан шалтгааныг тэмдэглэнэ. Дуудлага худалдаанд оролцох эрхтэй гэж хүлээн зөвшөөрөгдсөн өргөдөл гаргагч нь дуудлага худалдааны комиссын гишүүд өргөдлийг хэлэлцэх протоколд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн дуудлага худалдааны оролцогч болно.

Газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдаанд ялагчийг тодруулахад тухайн оролцогчийн шинжлэх ухаан, техникийн түвшин, тухайн бүс нутагт ажилласан туршлага,

⁴⁹ Закон РФ "О недрах" от 21.02.1992. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_343/

тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулсан хувь нэмрийг, мөн газрын хэвлий ашиглах эрхийн нэг удаагийн төлбөрийн хэмжээг гол шалгуураа болгоно.

Зөвхөн нэг этгээдийн өргөдөл нь хуулийн шаардлага болон зарласан дуудлага худалдаа явуулах нөхцөлийг хангасан бол, эсхүл дуудлага худалдаанд зөвхөн нэг оролцогч оролцсон бол тухайн дуудлага худалдааг хүчингүй болсонд тооцно. Энэ тохиолдолд тухайн оролцогчид газрын хэвлийг ашиглах эрхийг нь дуудлага худалдааны нөхцөлөөр олгосонд тооцно.

Дуудлага худалдааны үр дүнгийн талаарх протоколд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- дуудлага худалдаанд оролцогчдын өргөдөл хуулийн шаардлага хангасныг;
- дуудлага худалдааны дүнг үндэслэн газрын хэвлийг ашиглах эрх буюу тусгай зөвшөөрөл олгох тухай комиссын шийдвэрийг;
- дуудлага худалдааны үр дүнгээр ялагчаар тодорсон (эсвэл дуудлага худалдаанд цорын ганц оролцогч) тухай мэдээллийг;
- газрын хэвлийн талбай ашигласны төлбөрийн нэг удаагийн төлбөрийн эцсийн дүн, түүнийг төлөх эцсийн хугацааны талаарх мэдээллийг.

Хэрэв дуудлага худалдааны ялагч нь газрын хэвлийн талбайг ашигласны төлбөрийн эцсийн дүнг төлөөгүй бол түүний дараагийн үнэ санал болгосон этгээдийг ялагчаар тодруулна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

БНХАУ

- “Хятад дахь лицензийн сорилтууд ба шилдэг туршлагууд тайлан” (2014) АНУ-Хятадын бизнесийн зөвлөл:
<https://www.uschina.org/sites/default/files/Licensing%20Challenges%20and%20Best%20Practices%20in%20China-Jan%202014.pdf>
- БНХАУ-ын Төрийн зөвлөлийн цахим хуудас:
http://english.www.gov.cn/policies/latestreleases/202201/30/content_WS61f64f28c6d09c94e48a4906.html
- БНХАУ-ын Захиргааны тусгай зөвшөөрлийн хууль:
<http://www.lawinfochina.com/display.aspx?lib=law&id=3076&CGid=#menu2>
- БНХАУ-ын захиргааны тусгай зөвшөөрлийн тухай хууль"-ийн тайлбар:
<http://xzspj.nc.gov.cn/ncspj/zcjd/201912/4151afa2a3f1463eaab35ee76e7b792b.shtml>
- Захиргааны тусгай зөвшөөрлийг хатуу хянах тухай тогтоол:
http://www.gov.cn/zhengce/content/2013-09/26/content_1228.htm
- БНХАУ-ын Дуудлага худалдааны тухай хууль:
<http://www.asianlii.org/cn/legis/cen/laws/alotproc366/>
- БНХАУ-ын Тендерийн урилга, тендерийн хууль:
<http://www.asianlii.org/cn/legis/cen/laws/biabl226/>

Шотланд Улс

- Шотланд Улсын Тусгай зөвшөөрлийн тухай хууль:
<https://www.aberdeencity.gov.uk/services/business-and-licensing/licences-and-permits/licensing-scotland-act-2005>
- Абердиний лицензийн зөвлөлийн цахим хуудас:
<https://www.aberdeencity.gov.uk/services/business-and-licensing/licences-and-permits/licensing-board>
- Абердиний лицензийн хороодын цахим хуудас:
<https://www.aberdeencity.gov.uk/services/business-and-licensing/licences-and-permits/licensing-committee>

Сингапур Улс

- Сингапур Улсын Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн нэгжийг зохицуулах тухай хууль: (Accounting and Corporate Regulatory Authority Act, 2004)-ийн 1 бүлгийн 2.1 дэх зүйл
<https://sso.agc.gov.sg/Act/ACRAA2004>
- Сингапур Улсын Аж ахуйн нэгжийн бүртгэлийн тухай хууль:
<https://sso.agc.gov.sg/Act-Rev/32/Published/20040731?DocDate=20040731>
- Банкны тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/BA1970>
- Барилгын хяналтын тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/BCA1989>
- Даатгалын тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/LA1966>
- Цахилгаан, эрчим хүчний тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/EA2001>
- Эрүүл мэндийн бүтээгдэхүүний тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/HPA2007>
- Согтууруулах ундааны хяналтын тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/LCSCA2015>
- Тамхины тухай хууль: <https://sso.agc.gov.sg/Act/TCASA1993>
- Tobacco (Control of Advertisements and Sale) (Licensing) Regulations 2017:
<https://sso.agc.gov.sg/SL/TCASA1993-S763-2017?DocDate=20211230>
- Тамхины тухай хуулийн дагалдах хууль тогтоомж:
<https://sso.agc.gov.sg/Act/TCASA1993?ViewType=SI>
- Сингапур Улсын Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн нэгжийг зохицуулах агентлаг:
<https://www.acra.gov.sg>
- <https://www.gobusiness.gov.sg>
- Засгийн газрын агентлаг Анагаах ухааны газар: <https://www.hsa.gov.sg/tobacco-regulation/>

ТУХН-ийн гишүүн зарим улсууд

- Закон Азербайджани О лицензиях и разрешениях от 15.03.2016 года:
https://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=85079
- Закон Армении О Лицензировании от 30.05.2001 года:
<https://www.arlis.am/DocumentView.aspx?docID=67471>

- Закон Грузии О лицензиях и разрешениях, 24.06.2005 года:
<https://matsne.gov.ge/ru/document/view/26824?publication=87>
- Закон Казахстан “О разрешениях и уведомлениях” от 16.05.2014 года:
https://online.zakon.kz/Document/?doc_id=31548200&pos=3;-109#pos=3;-109
- Закон Кыргызии О лицензионно-разрешительной системе в Кыргызской Республике от 19.10.2013 года № 195: <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/205058>
- Закон РФ О лицензировании отдельных видов деятельности. Принят ГД 22.04.2011 года. Одобрен СФ 27.04.2011 года:
<http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102147413>
- Закон Узбекистан О лицензировании, разрешительных и уведомительных процедурах. Принят Законодательной палатой 5 марта 2021 года. Одобрен Сенатом 23.04.2021 года:
<https://www.lex.uz/acts/5511900?ONDATE=15.07.2021%2000#5518717>
- Л.В.Стандзонь. Система федерального законодательства о лицензировании: проблемы и перспективы законодательного регулирования. Актуальные проблемы российского права. 2018. No 12 (97): <https://cyberleninka.ru/>



**ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ, АСУУЛТ ХАРИУЛТЫН ДЭГИЙН ЗАРИМ
ЗОХИЦУУЛАЛТ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Р.Нургүл,
Б.Батцэцэг, Б.Туул, П.Уранчимэг*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ, АСУУЛТ ХАРИУЛТЫН ДЭГИЙН ЗАРИМ
ЗОХИЦУУЛАЛТ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

1. ИХ БРИТАНИ
2. ИРЛАНД УЛС
3. КАНАД УЛС
4. АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС

ХАВСРАЛТ. БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГЫН ХАРЬЦУУЛАЛТ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Ерөнхий сайдын мэдээлэл, асуулт хариултын дэгийн зарим зохицуулалт: бусад орнуудын туршлага” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Парламентын нэгдсэн чуулганд Ерөнхий сайд мэдээлэл хийх, гишүүдийн асуултад хариулах дэгийн зохицуулалтын хүрээнд Ерөнхий сайд болон сайд нар Ерөнхий сайдын (Засгийн газрын) цагт нэгдсэн чуулганы хуралдаанд хэрхэн оролцож мэдээлэл хийдэг, асуулт хариултыг ямар дэгээр явуулдаг, парламентын олонх болон цөөнхийн зүгээс хэрхэн асуулт асууж хариулт авдаг зэрэг зарим тодорхой асуудлаар бусад орнуудын туршлагыг судалж харьцуулсан судалгаа хийх.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд Ерөнхий сайдын мэдээлэл, асуулт хариултыг парламентын хяналтын уламжлалт аргад тулгуурлан явуулж байгаа Их Британи, Ирланд болон Канад, Австрали зэрэг 4 орны туршлагыг дэлгэрүүлэн судалснаас гадна Сингапур, Малайз, Герман, Болгар улсуудын туршлагыг тоймлон авч үзсэн болно. Сэдвийн хүрээнд захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Ерөнхий сайдаас парламентын чуулганд оролцож мэдээлэл хийх, гишүүдийн асуултанд хариулах, өөрийгөө төлөөлүүлэх болон бусад сайд нарыг оролцуулахтай холбоотой дэгийн асуудлуудыг нарийвчлан судалсан бөгөөд мэдээллийг дараах 2 багц асуудлын хүрээнд нэгтгэж, харьцуулалт хийсэн болно. Үүнд:

1. Ерөнхий сайдын мэдээллийн цагт парламентын гишүүд Ерөнхий сайдаас асуулт асууж хариулт авах дэгийн зарим асуудал (олонх асуулт асуудаг эсэх, асуулт хариултын дараалал ба хугацааны хязгаарлалт)
2. Ерөнхий сайдын мэдээллийн цагт Ерөнхий сайд хэрхэн оролцдог талаар (Ерөнхий сайд биечлэн оролцох, бусад сайд нараар өөрийгөө төлөөлүүлэх, бусад сайд нар байлцах, Ерөнхий сайд өөрөө оролцох боломжгүй тохиолдлууд)

Судалгааны явцад Ерөнхий сайдын мэдээллийн цаг нь яагаад парламентын хяналтын чухал арга хэрэгсэлд тооцогддог, дэлхийн улс орнуудын парламентууд энэхүү арга хэрэгслийг хэрхэн нутагшуулж, ашиглаж байгаа талаарх Олон улсын парламентын холбоо (IPU) болон бусад судлаачдын гаргасан харьцуулсан судалгааг ашигласан болно.

Судалгааны арга зүй: Судалгааг гүйцэтгэхдээ холбогдох мэдээллийг гадаад хэлнээс хөрвүүлэх, судалгааны захиалгад өгсөн асуултуудын хүрээнд мэдээллийг судлах, нэгтгэн дүгнэх, харьцуулах зэрэг арга зүйг ашиглав.

Keyword: *prime minister question time, question time*

Түлхүүр үг: *Ерөнхий сайдын асуултын цаг, асуултын цаг*

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Парламентын ардчилалд Ерөнхий сайд болон парламент хоорондын харилцааны асуудал чухал үүрэгтэй. Дэлхийн улс орнуудын парламент дахь Ерөнхий сайдын цаг нь парламентаас баталсан бодлого, хөтөлбөрийг Засгийн газар хэрхэн хэрэгжүүлж, ямар үр дүнд хүрч байгааг асууж танилцах, нэгдсэн ойлголцолд хүрэх, шуурхай арга хэмжээ авч үр дүнд хүрэх зорилгод чиглэгдэнэ. Парламентаас Ерөнхий сайдыг асуух ажиллагааны арга механизм, түүний төрлүүд улс орон бүрд харилцан адилгүй байна. Тухайлбал, Их Британийн парламент дахь “Ерөнхий сайдын цаг” хэмээх асуулт хариултын цаг бол Ерөнхий сайдаас асуулт асуух уламжлалт хэлбэрт тооцогддог.

Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон засаглалын эрх мэдлийн хуваарилалтын дагуу хууль тогтоох байгууллагаас гүйцэтгэх засаглалд хяналт тавих нэгэн чухал арга хэрэгсэл бол Ерөнхий сайдын мэдээлэл, асуулт хариултын ажиллагаа юм.

Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд зохицуулснаар чуулганы хуралдаан дахь Ерөнхий сайдын мэдээллийн үеэр зөвхөн цөөнх асуулт асуудаг нь олонхын зүгээс Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавихад тодорхой хүндрэлүүдийг үүсгэж байна гэж үзсэн. Ялангуяа 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Ерөнхий сайдын эрх мэдлийг нэмэгдүүлж, УИХ-ын зарим тодорхой эрхийг хязгаарласан энэ үед олонхын зүгээс Ерөнхий сайдын мэдээллийн үеэр асуулт асууж хариулт авах эрхийг нээх шаардлагатай байна гэж захиалагчийн зүгээс үзэж чиглүүлэх асуултуудыг асуусан учраас энэхүү асуултуудын хүрээнд судалгааг гүйцэтгэв.

Олон улсын нийтлэг туршлага

Олон Улсын Парламентын Холбоо (IPU)-ноос 2007 онд хийсэн “Парламентаас Засгийн газарт хяналт тавих арга хэрэгслүүд”⁵⁰ сэдэвт судалгааны хүрээнд дэлхийн 88 орны парламентын хяналтын арга хэрэгслүүдийг судалж харьцуулсан мэдээлэл бэлтгэсэн бөгөөд энэхүү судалгаанаас үзэхэд Ерөнхий сайдаас парламентад мэдээлэл хийх дараах 3 хэлбэр байна. Үүнд:

- Парламентын чуулганд шинээр байгуулагдсан Засгийн газрын тэргүүний мэдээллийг сонсох;
- Парламентын чуулганы нээлтэн дээр Засгийн газрын тэргүүн үг хэлэх;
- Парламентын чуулганд Ерөнхий сайдын мэдээллийг сонсож, асуулт асууж хариулт авах (Ерөнхий сайдын цаг).

2017 онд Лондонгийн их сургуульд докторын зэрэг хамгаалсан Ruhandra Serban-ны “Парламентын ардчилал дахь Ерөнхий сайдын асуулга: Дэг, практик үйл ажиллагаа”⁵¹ сэдэвт судалгааны ажлын зарим харьцуулсан мэдээлэл, дүгнэлтийг энэхүү судалгаанд ашиглав.

Судалгааны сэдэв нь парламентын чуулганаар Ерөнхий сайдыг сонсох дэгийн зохицуулалтыг харьцуулан судлахад чиглэгдсэн ба нийт 31 орны парламентыг хамруулж, холбогдох асуудлаар судалгааны асуулга, зөвлөлдөх уулзалтуудыг хийсэн байна.

Судалгааны үр дүнд Ерөнхий сайдаас асуух “Хамтын буюу Засгийн газрын гишүүд хамтран хариулах хэлбэр”, “Ганцаарчилсан буюу зөвхөн Ерөнхий сайд хариулах хэлбэр”-ийг судлаач тодорхойлсон байх бөгөөд аль хэлбэрийг сонгосноос шалтгаалан Ерөнхий сайдын асуулт хариултын дэг өөр өөр байна хэмээн судлаач дүгнэсэн. Тухайлбал, Канад

⁵⁰ <http://archive.ipu.org/pdf/publications/oversight08-e.pdf>

⁵¹ https://discovery.ucl.ac.uk/id/eprint/10090111/9/Serban_10090111_Thesis_revised.pdf

(Question period), Австрали (Question time) улсад хамтын асуулга буюу Ерөнхий сайдыг засгийн газрын сайд нартай нь цуг дуудаж асуудаг бол Их Британи (Prime Minister's Question), Ирланд (Oral Questions to the Taoiseach) улсад ганцаарчилсан асуулга буюу Ерөнхий сайдаас ганцаарчлан асуух хэлбэрийг ашигладаг байна.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагыг тоймлон авч үзвэл

Их Британи болон Ирланд Улс нь Вэстминстерийн уламжлалт загварыг хадгалсан бөгөөд Их Британид “Ерөнхий сайдын асуултын цаг”, Ирландад “Аман асуултын цаг” гэж нэрлэдэг. Эдгээр орнуудад асуултын цагт зөвхөн Ерөнхий сайд гишүүдийн асуултад хариулдаг. Тэгвэл Канад, Австрали улсад “Асуултын цаг” гэж нэрлэх бөгөөд Ерөнхий сайд болон сайдууд хариулдаг онцлогтой байна.

Асуултын цагт Ерөнхий сайд (сайд)-аас асуулт асууж хариулах процесс нь Вестминстерийн загвартай орнуудад дэгийн зохицуулалтын практик гарын авлага болон уламжлалын хослолоор зохицуулагдаж байна. Парламентын дэгээс гадна парламентын үйл ажиллагаанд удирдамж болгон ашигладаг хүлээн зөвшөөрөгдсөн эх сурвалжууд байдаг.

Парламентын үйл ажиллагааны үе үеийн туршлагыг агуулдаг эмхэтгэлийг парламентын нарийн бичгийн дарга нар бичдэг бөгөөд процедурын хөгжлийг тусган шинэчилсэн хэвлэлийг үе үе хэвлүүлдэг. Эдгээр эмхэтгэлүүдэд өмнө байгаагүй нөхцөл байдал үүсэхэд Парламентын дарга нарын гаргаж байсан шийдвэрүүдийг мөн тэмдэглэсэн байдаг. Энэ нь хууль, журамд тусгаагүй асуудлыг зохицуулахад ашиглагддаг байна. Жишээлбэл, Канадын Нийтийн танхимын Асуултын цагт гишүүдийн асуулт асуух дарааллын талаар Нийтийн танхимын дэгийн зохицуулалтад заагаагүй бөгөөд үүнийг уламжлалт туршлагаар зохицуулдаг.

Судалгаанд авагдсан Их Британи, Канад, Австрали улсуудад Парламентын дэгийн зохицуулалтад тусгаагүй асуудлыг дараах үндсэн эмхэтгэлүүдийг ашиглан зохицуулж байна. Үүнд: Их Британийн Erskine May, Канадын Нийтийн танхимын журам ба практик, Австралийн Төлөөлөгчдийн танхимын практик зэрэг нь орно. Харин Ирландад дээрх 3 улстай адил төстэй эмхэтгэл байдаггүй бөгөөд асуулт хариултын процесс нь Дайл Эйранны дэгийн дагуу зохицуулагдаж байна.

Судалгаанд авсан 4 орны хувьд Ерөнхий сайдад асуулт тавихад парламент дахь олонх, цөөнхийн гишүүд аль аль нь асуулт асуух эрхтэй байна.

Аль ч орны хувьд цөөнх буюу сөрөг хүчний гишүүдэд асуулт асуух дараалал, асуултын тооны хувьд давуу эрх олгодог боловч олонх буюу эрх баригч намын гишүүдийн асуух эрх нээлттэй.

Ерөнхий сайдаас асуулт асуухад олонхын гишүүдийн оролцоо дээрх 4 оронд ялгаатай байна. Их Британид Ерөнхий сайдаас олонхын гишүүд сөрөг хүчний гишүүдээс дутахгүй олон асуулт асуудаг бөгөөд асуултын агуулга нь ихэвчлэн мэдээллийн шинжтэй байдаг байна. Тухайлбал, Ruhandra Serban-ы судалгаанд тэмдэглэснээр Ерөнхий сайдад тавьсан нийт асуултын 42% нь олонхын гишүүдээс тавигдсан байна. Харин Австралид парламентын олонх нь Ерөнхий сайд гэхээс илүү Засгийн газрын сайд нарт түлхүү асуулт тавьдаг. Тухайлбал, олонхоос асуусан 250 асуултын 41 (16%) нь Ерөнхий сайдад хандсан байна. Тэгвэл Ирланд, Канадад олонхын гишүүд харьцангуй цөөн асуулт тавьдаг болох нь судалгаанаас харагдаж байна.⁵²

⁵² Serban, Ruxandra; (2020) Questioning Prime Ministers: Procedures, Practices and Functions in Parliamentary Democracies. Doctoral thesis (Ph.D), UCL (University College London)
https://discovery.ucl.ac.uk/id/eprint/10090111/9/Serban_10090111_Thesis_revised.pdf

Судалгаанд хамрагдсан орнуудад асуултыг хэрхэн асуух байдал нь зарим талаараа ялгаатай байна. Тухайлбал, асуултыг урьдчилан мэдэгддэг үү, эсхүл шууд асуудаг уу, мөн асуулт асуух болон хариулах хугацаанд хязгаарлалт тавьдаг уу гэх мэт.

Их Британид Ерөнхий сайдад тавих асуултыг заавал бичгээр урьдчилан мэдэгдэх шаардлагагүй. Асуулт асуух хүсэлтэй гишүүд өмнөх долоо хоногийн Пүрэв гарагт багтаан нэрээ өгдөг. Тэдгээрээс санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон гишүүд Ерөнхий сайдаас асуулт асууна.

Харин Ирландад гишүүд асуултаа урьдчилан бичгээр илгээдэг бөгөөд асуух асуултыг сонгох ажлыг парламентын дарга удирдан хийх, асуултууд Дайл Эйранны дэгтэй нийцэж байгаа эсэхийг хянадаг байна. Нэмэлт асуултууд нь бичгээр урьдчилан мэдэгдсэн асуулттай холбоотой байх ёстой.

Дээрх 2 улсад асуултад Ерөнхий сайд хариулдаг бол Канад, Австрали улсуудын хувьд асуултын цагт Ерөнхий сайдаас гадна сайдууд оролцож хамтын зарчмаар асуултад хариулдаг. Асуулт асуухад эдгээр улсын аль аль нь бичгээр урьдчилан мэдэгдэх шаардлагагүй байдгаараа Их Британитай төстэй байна.

Асуулт хариултын хугацаа маш богино байдаг учраас цагийг үр дүнтэй ашиглах нь чухал байдаг.

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын асуултын цагт асуулт асуух, хариулах хугацаа

Улсын нэр	Асуулт асуух хугацаа	Хариулах хугацаа
Их Британи	Тодорхой заагаагүй	1 мин (Erskine May-д зааснаар) ¹
Ирланд	Тодорхой заагаагүй.	3 мин, нэмэлт асуултад 90 сек
Австрали	Засгийн газрын болон Сөрөг хүчний гишүүд 30 сек, бусад гишүүд 45 сек	5 мин
Канад	35 сек	35 сек

Эх сурвалж: Serban, Ruxandra; (2020) Questioning Prime Ministers: Procedures, Practices and Functions in Parliamentary Democracies. Doctoral thesis (Ph.D), UCL (University College London https://discovery.ucl.ac.uk/id/eprint/10090111/9/Serban_10090111_Thesis_revised.pdf

¹Тайлбар: Их Британид Erskine May нь “Парламентын дэгийн Библи” гэж нэрлэгддэг бөгөөд парламентын үйл ажиллагааны талаарх практик туршлагыг агуулдаг. Энэ нь парламентын гишүүд болон ажилтнуудад, бусад хүмүүст практик гарын авлага болдог бөгөөд парламентын процедурын удирдамж болгон ашигладаг.

Австрали Улсын хувьд асуултад богино хугацааны хязгаарлалт тавьдаг ч хариулахад арай илүү хугацаа өгдөг. Тиймээс асуултууд нь маш товч бөгөөд хариултууд нь богино ярианы хэлбэртэй байдаг. Канадад цагийн хязгаарлалт нь илүү хатуу байдаг тул асуулт, хариулт хоёулаа маш товчхон байна. Энэ нь асуултын цагт илүү олон асуулт асуух боломжийг бий болгодог.

Богино хугацааны хязгаарлалт нь сэдэв тус бүрээр илүү олон асуулт асуух боломжийг олгодог ч зарим судлаачид үүнд шүүмжлэлтэй хандаж байна. Тэдний үзэж байгаагаар богино хугацааны хязгаарлалт нь гишүүдийг нягтлан шалгахын оронд улс төрийн оноо авах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуугиан дэгдээх зорилготой товч асуулт асуухад түлхэц болно гэж үздэг (Райн, 2009; Чонг, 2008).

Их Британид асуулт тавих хугацааг заагаагүй бөгөөд зөвхөн асуулт асуух гишүүдийн тоо (15) болон Ерөнхий сайдын цагийн нийт үргэлжлэх хугацаа (30 минут) зэргийг тодорхой заасан байна. Erskine May-д зааснаар асуултад хариулах хугацаа 1 минут үргэлжилнэ.

Ирландад асуулт тавих хугацааг заагаагүй, үндсэн (3 мин) болон нэмэлт (90 сек) асуултад хариулах хугацааг заасан байдаг. Асуултын цагийн нийт үргэлжлэх хугацаа 45 минутаас хэтрэхгүй байхаар зохицуулжээ.

Асуултын цагт Ерөнхий сайдын оролцоо чухал асуудлын нэг байдаг. Судалгаанд авагдсан орнуудаас Их Британи, Ирландад зөвхөн Ерөнхий сайд гишүүдийн тавьсан асуултад нэг бүрчлэн хариулдаг бол Канад, Австралид Ерөнхий сайд, сайд нар хамтран хариулах зарчмыг хэрэгжүүлдэг.

Тэгвэл сайд нар Ерөнхий сайдын хамтаар оролцдог, хамтын зарчмаар гишүүдийн асуултад хариулдаг эдгээр орнуудын хувьд Ерөнхий сайдыг заавал өөрөө оролцох, заавал өөрөө асуултад хариулахыг шаарддаг уу, бодит байдал дээр Ерөнхий сайдын оролцоо ямар байсан бэ гэдэг асуудал сонирхол татаж байна. Судалгаанаас үзэхэд, Ерөнхий сайдыг заавал оролцохыг шаарддаггүй эдгээр орнуудад Ерөнхий сайдын идэвх, оролцоо өндөр байгаа нь харагдаж байна. Тухайлбал:

Канад, Австралид дэгийн болон бусад зохицуулалтаар Ерөнхий сайдыг Асуултын цагт заавал өөрөө оролцож асуултад хариулах талаар албан ёсны шаардлага тавигдаагүй, гэхдээ зайлшгүй албан ажилтай байхаас бусад тохиолдолд Ерөнхий сайд нь өөрөө оролцож гишүүдийн асуултад хариулдаг (бүх асуултад, эсхүл зарим асуултад) жишиг тогтсон байна. Тухайлбал, Канадад 2007 онд Нийтийн танхимын хуралдаан нийт 117 удаа хуралдсанаас 114-д Асуултын цаг явагдсан, үүнд Ерөнхий сайд нь 70 удаа оролцсон байна. Мөн Австралийн Ерөнхий сайд байсан Жулиа Гиллард 2011 онд Асуултын цаг 61 удаа явагдсаны 60-д нь оролцжээ⁵³.

Эдгээр 4 улсын хувьд асуултад зөвхөн Ерөнхий сайд нь өөрөө хариулах үүрэгтэй, эсхүл Ерөнхий сайд болон сайдууд хариулах үүрэгтэй байх аль ч тохиолдолд Ерөнхий сайдууд асуултын цагт онцгой ач холбогдол өгч, идэвхтэй оролцдог туршлагыг хэрэгжүүлж байна. Жишээ нь 2014 онд Их Британийн Ерөнхий сайдын Дэвид Камерон Ерөнхий сайдын асуултын цаг 33 удаа болсны 30-д нь оролцсон. Мөн 2012 онд Ирландын Ерөнхий сайд Аман асуултын цаг 34 удаа болоход бүгдэд нь оролцжээ.

Их Британид Ерөнхий сайд оролцох боломжгүй тохиолдолд Шадар сайд эсхүл, өөр сайд орлодог. Үлдсэн 3 орны хувьд мөн ижил зохицуулалттай байна.

Судалгаанд авагдсан 4 орны Ерөнхий сайдын асуултын цагийн тов, гишүүдийн асуулт асуух эрх, асуултын тоо, асуулт асууж хариулах хугацаа, асуултын цагт хариулж амжаагүй асуултыг хэрхэн зохицуулах, мөн Ерөнхий сайд, эсхүл асуултад хариулах сайд оролцох боломжгүй тохиолдолд хэн хэрхэн орлодог туршлагыг хүснэгтээр тоймлон харуулав.

⁵³ Serban, Ruxandra; (2020) Questioning Prime Ministers: Procedures, Practices and Functions in Parliamentary Democracies. Doctoral thesis (Ph.D), UCL (University College London)
https://discovery.ucl.ac.uk/id/eprint/10090111/9/Serban_10090111_Thesis_revised.pdf

Хүснэгт 2. Судалгаанд авагдсан орнуудын туршлагын тойм

	Их Британи ⁵⁴	Ирланд ⁵⁵	Канад ⁵⁶	Австрали ⁵⁷
Ерөнхий сайдын асуултын цагийн нэршил, тов	Prime minister's question time (PMQs) Лхагва 12.00-12.30 цагт	Oral Questions to the Taoiseach ⁵⁸ Даваа, Мягмар 14.00 цагт	Question period Чуулган хуралдах хугацаанд өдөр бүр 14.15 цагт Баасан 11.15 цагт	Question time Чуулган хуралдах хугацаанд өдөр бүр 14.00-15.00 цагт
Асуулт асуух эрх	Бүх гишүүн асуулт асуух эрхтэй. Сөрөг хүчин нь асуух дараалал болон асуултын тооны хувьд давуу эрхтэй.	Бүх гишүүн асуулт асуух эрхтэй. Сөрөг хүчинд давуу эрх олгодог.	Бүх гишүүн асуулт асуух эрхтэй. Сөрөг хүчин давуу эрхтэй.	Бүх гишүүн асуулт асууна.
Асуух дараалал, асуултын тоо	- Гол сөрөг хүчний тэргүүн 6 асуулт - 2 дахь сөрөг хүчний тэргүүн 2 асуулт - Захиалгын хуудсанд бүртгүүлсэн гишүүдээс санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 15 гишүүн тус бүр 1 асуулт - Захиалгын хуудсанд бүртгүүлээгүй ч Нийтийн танхимын дарга зөвшөөрсөн тохиолдолд асуултын цагийн үеэр хүсэлт гаргасан гишүүн урьдчилан мэдэгдээгүй "нэмэлт асуулт" асууна.	Дайл Эйрэанны дэгийн зохицуулалтаар нэг гишүүн 3 хүртэл асуулт асуух эрхтэй. Асуух дараалал: - Гол сөрөг хүчний тэргүүн - 2 дахь сөрөг хүчний тэргүүн - Захиалгын хуудсанд бүртгүүлсэн дарааллын дагуу 15 гишүүн.	- Гол сөрөг хүчний тэргүүн 3, гишүүн 2 асуулт - 2 дахь сөрөг хүчний тэргүүн 2, гишүүн 2 асуулт - 3 дахь сөрөг хүчний төлөөлөгч 3 асуулт - Бусад гишүүд асуулт асуух ба ихэнх нь сөрөг хүчний гишүүд байна.	Сөрөг хүчин эхэлж асууна. Асуултын цагийн хугацаанд аль болох парламент дахь бүх намын бүлгүүдийн болон бие даагч гишүүдийг хамруулдаг. Эрх баригч нам болон сөрөг хүчний гишүүд ээлжлэн асуудаг. Нийт 10 хүртэл тооны асуулт асууна.
Асуулт асууж, хариулах хугацаа	Тодорхой зохицуулалтгүй Уламжлалт практикаар асуулт, хариулт товч, богино хэмжээтэй явагдана. Erskine May-д зааснаар асуултад хариулах хугацаа 1 мин байна.	Асуулт асуух хугацаа тодорхой зохицуулалтгүй, хариулах хугацаа 3 мин, нэмэлт асуултад хариулах 90 сек. Асуултын цаг нийтдээ 45 мин үргэлжилнэ. Эхний 30 мин уламжлалт аман асуултад хариулж, дараа 15 мин цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж болно.	Асуулт асуух хугацаа 35 сек, хариулт 35 сек Асуултын цагийн эхэнд Засгийн газрын гишүүн 15 минут мэдээлэл хийж араас нь асуулт хариулт явагдана. Асуултын цагийн нийт хугацаа 45 мин үргэлжилнэ.	Асуулт асуухад 30 сек - 1 мин, хариулах 5 мин
Асуултын цагт хариулж амжаагүй асуулт	Хариулж амжаагүй асуултын хариултыг бичгээр хүргүүлнэ. Эсхүл дараагийн асуултын цагт шилжүүлж болно.	Хариулт өгч амжаагүй бол хариултыг бичгээр хүргүүлнэ.	Гишүүн асуултын хариултад сэтгэл дундуур байвал дэлгэрэнгүй хариултыг бичгээр хүргүүлнэ.	Хариулж амжихааргүй дэлгэрэнгүй асуултын хариултыг бичгээр хүргүүлнэ.
Ерөнхий сайд, эсхүл асуултад хариулах сайд оролцох	Зайлшгүй хүндэтгэх шалтгаанаар Ерөнхий сайд оролцох боломжгүй бол Шадар сайд, эсхүл бусад сайд орлоно.	Шадар сайд орлоно. Хэрэв энэ албан тушаал эзгүй эсхүл, оролцох боломжгүй бол Төрийн нэгдүгээр нарийн бичгийн	Асуултын цагт бүх сайд оролцох бөгөөд эзгүй байгаа сайдын чиг үүргийн талаар асуулт	Ерөнхий сайд асуулт эхлэхээс өмнө сайд төрийн ажилтай, өвчтэй, гадаадад томилолттой бол

⁵⁴ UK parliament, MPs Guide to Procedure, Prime Minister's questions, <https://guidetoprocedure.parliament.uk/collections/nPylcSv3/prime-ministers-questions>

⁵⁵ DAIL ÉIREANN, STANDING ORDERS RELATIVE TO PUBLIC BUSINESS, 2020, https://data.oireachtas.ie/ie/oireachtas/parliamentaryBusiness/standingOrders/dail/2021/2021-01-27_consolidated-dail-eireann-standing-orders-january-2021_en.pdf

⁵⁶ Standing Orders of the House of Commons, <https://www.ourcommons.ca/about/standingorders/Index-e.htm>

⁵⁷ Rules governing questions, https://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7/HTML/Chapter15/Rules_governing_questions

⁵⁸ Ирландын парламентыг Taoiseach гэж нэрлэдэг.

боломжгүй тохиолдолд		дарга орлоно.	асуувал Ерөнхий сайд, өөр сайд, эсхүл Нийтийн танхимын нарийн бичгийн дарга хариулж болно. Ерөнхий сайд оролцох боломжгүй бол бусад сайд орлоно.	шалтгаан болон орлох сайдыг танилцуулна, эсхүл өөрөө сайдаа орлож асуултад хариулна. Асуултын цагт Ерөнхий сайд өөрөө оролцох боломжгүй тохиолдолд түүнийг төлөөлөх сайд мэдээлэл хийж асуултад хариулна.
----------------------	--	---------------	--	---

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ, АСУУЛТ ХАРИУЛТЫН ДЭГИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Ерөнхий сайд болон Засгийн газрын мэдээллийг сонсох ажиллагаа нь парламентаас Засгийн газарт хяналт тавих хяналтын нэг арга хэрэгсэл юм. Энэхүү үйл ажиллагаа нь парламентын чуулганд Ерөнхий сайд (эсхүл холбогдох сайд) мэдээлэл хийж араас нь асуулт асууж, хариулт авах хэлбэрээр явагдана. Асуулт болон хариултын зорилго нь Засгийн газрын баримталж буй бодлогын чиглэлийг тодорхой болгох, албан ёсоор зарласан бодлогын чиглэл болон түүний хэрэгжилтийн үйл явц, үр нөлөө нь бодлогын зорилтуудыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэгдэнэ.

Парламент бол ардчиллын амин чухал институт бөгөөд иргэд болон Засгийн газрыг хооронд нь холбож хамтын шийдвэр гаргадаг, Засгийн газрыг хяналтандаа байлгах үүрэгтэй. Ялангуяа Ерөнхий сайдын парламентын өмнө ажлаа тайлагнах хяналтын арга механизмыг ихэнх орнууд Үндсэн хуулиар баталгаажуулсан байдаг бол Австрали зэрэг зарим оронд Үндсэн хуулиндаа бичээгүй ч гэсэн хяналтын чухал хэрэгсэл болгон ашиглаж байна.

Ерөнхий сайд хэд хэдэн үүрэг рольтой байна: Засгийн газрын кабинетыг тэргүүлэх, Засгийн газрыг төлөөлж ярих, Засгийн газрын бусад сайд нартай үүрэг, хариуцлагаа хуваалцаж хамтын шийдвэр гаргах, Ерөнхий сайдын хувьд өөрт оногдсон тодорхой эрх мэдлийг хэрэгжүүлэх гэх мэт.

Ерөнхий сайд кабинетыг удирдан чиглүүлэх үүрэг рольтой байдаг бол салбарын сайд нар тодорхой салбарын бодлогын багцыг хариуцан ажилладаг. Засгийн газрын доторх кабинетын хамтын эрх мэдэл, сайд нарын бие даасан эрх мэдэл, Засгийн газрын тэргүүн буюу Ерөнхий сайдын эрх мэдлийн хуваарилалт, зааг ялгаа нь парламентаас хяналтаа хэрэгжүүлэхэд харгалзах гол асуудал юм.

Ерөнхий сайдын мэдээллийн цаг, асуулт хариулттай холбоотой дэгийн олон улсын судалгааны дүгнэлтээс үзэхэд дараах асуудлуудад судлаачид анхаарал хандуулан авч үзсэн байна.⁵⁹

Ерөнхий сайдын эрх хэмжээ, үүрэг, хариуцлага

Эрх хэмжээ. Улс орон бүрд Ерөнхий сайдад Үндсэн хууль болон хуулиар олгосон эрх хэмжээ харилцан ялгаатай байна. Улс төрийн шинжлэх ухааны онолын үүднээс авч үзвэл

⁵⁹ Serban, Ruxandra; (2020) Questioning Prime Ministers: Procedures, Practices and Functions in Parliamentary Democracies. Doctoral thesis (Ph.D), UCL (University College London)
https://discovery.ucl.ac.uk/id/eprint/10090111/9/Serban_10090111_Thesis_revised.pdf

энэ нь Ерөнхий сайдын статус, сайд нарын танхим дахь үүрэг роль, Засгийн газрыг төлөөлөх чадамжийн тухай асуудал юм. Эдгээрээс Ерөнхий сайдын цаг буюу Ерөнхий сайдын парламент дахь аман асуулт хариултын цагийн хувьд дараах үндэслэл болон ангилал, төрлүүдийг нэрлэсэн байна.

Асуулгын механизмын төрөл ба ангилал

Парламент дахь Ерөнхий сайдын цаг дээрх асуулт хариулт нь хууль тогтоогчид болон Ерөнхий сайдыг холбох, ажлын уялдаа тогтоох чухал арга механизмд тооцогдох бөгөөд хэд хэдэн төрөлтэй байна.

1. Уламжлалт арга буюу парламентаас Засгийн газрыг хяналтандаа байлгаж үүрэг хариуцлагажуулах арга механизмууд. Парламентын гишүүд Ерөнхий сайдын зан төлөв, хандлага, үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй болж хариуцлага тооцох, урамшуулах арга механизм.

Олон янзын судалгаанаас үзэхэд, улс орон бүрд парламентын хяналтын олон хэлбэрүүдийг ашиглаж байна. Тухайлбал, аман болон бичгийн асуулт, Байнгын хороодын асуулга, Байнгын хороодын сонсгол, лавлагаа авах гэх мэт. Цаг хугацааны хувьд эдгээр хяналт нь ex-ante болон ex-post хяналт хэлбэрээр хэрэгжих бөгөөд парламентын асуулга асуулт нь ex-post хяналтанд тооцогдоно. Ерөнхий сайдын асуулга, асуулттай холбоотой асуудлыг дэгийн талаас болон хувь хүний зан төлвийн талаас судлах нь зүйтэй хэмээн судлаачид үздэг.

2. Нээлттэй болон хаалттай мэдээллийн цаг. Энэхүү арга механизмын хувьд дэгийн зохицуулалт чухал. Дэгийн зохицуулалтын хүрээнд парламентын гишүүд энэхүү асуулт, хариултын процесст ямар хэмжээтэй, ямар хүрээнд оролцохыг авч үзэх ёстой. Европын 17 парламентын туршлагыг судалсан судалгааны үр дүнд⁶⁰ Ерөнхий сайдын асуулт хариултыг явуулах дэгийн зохицуулалтанд дараах 4 асуудлыг зайлшгүй журамлах шаардлагатай гэж үзсэн. Үүнд: Ерөнхий сайдаас хариулт өгөх хэлбэр (амаар/бичгээр), хариулт өгөх хугацаа (урьдчилан бэлтгэх/шууд хариулах), Засгийн газрын бусад гишүүд уг хэлэлцүүлэгт оролцох эсэх, процедурын төгсгөлд аливаа асуудлаар санал хураалт явуулах эсэх. Энэхүү дэгийг хэрхэн яаж тогтоосноос нээлттэй эсхүл хаалттай эсэхийг тодорхойлно. Тодорхойлох гол критер нь асуулт хариултын хугацаа ба ямар асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг хийх вэ, ямар асуудлыг хаалттай сонсох гэдэг хязгаарлалтаас шалтгаална.

Ерөнхий сайдаас асуулт асуух механизм.

Судалгаанаас үзэхэд, зарим орнуудад Англи, Канад, Австралид Ерөнхий сайдын асуулгын механизм парламентын хяналтын чухал арга хэрэгсэлд тооцогддог бол зарим орнуудад энэхүү механизм харьцангуй сул хөгжсөн байна. Жишээ нь, Италид Ерөнхий сайдын асуулгын механизм маш сул байдаг бол Германд 7 хоногт 1 удаа Ерөнхий сайдын цаг гэж зохион байгуулдаг ба энэ нь олон нийт, хэвлэл мэдээлэлд нээлттэй байхаас гадна сайд нарыг байлцуулдаг байна. Сүүлийн үед Германы Бундестаг Ерөнхий сайдын цагийг сард 1 удаа зохион байгуулахаар болж Английн загварт шилжүүлсэн бөгөөд парламентын гишүүд Ерөнхий сайдаас асуулт асуух эрх нээлттэй болсон байна.

Иймд дэлхий нийтэд парламентын ардчиллын хүрээнд Ерөнхий сайдын цаг буюу асуулт, хариултын цагийг хяналтын механизм болгон ашиглаж байгаа нээлттэй, хаалттай загварын сонгодог төлөөлөл болох Англи, Ирланд (хамтын), Австрали, Канад (ганцаарчилсан) улсын туршлагыг дэлгэрүүлэн авч үзлээ.

⁶⁰ Russo and Wiberg (2011)

(Эх сурвалж: “*Ruxandra Sebran Ерөнхий сайдын асуулга: Парламентын ардчилал дахь Ерөнхий сайдын асуулгын дэгийн зохицуулалт ба практик туршлага*”, 2020 он)

Мөн түүнчлэн ОУПХ-ноос 2007 онд парламентаас Засгийн газарт тавьж буй хяналт, хэрэгжүүлэх арга механизмууд болон дэгийн зохицуулалтын асуудлаар дэлхийн 88 орны туршлагыг харьцуулсан судалгаа хийсэн байна.⁶¹ Эдгээр арга хэрэгслүүдээс парламент дахь Ерөнхий сайдын мэдээллийн цагтай холбоотой мэдээллүүдийг тоймлон авч үзвэл Ерөнхий сайдаас дараах тохиолдлуудад парламентад мэдээлэл хийдэг нийтлэг туршлага байна.

Нэг. Шинээр байгуулагдсан Засгийн газрын тэргүүний мэдээллийг сонсох

Судалгаанд авагдсан 88 орноос 27 орны шинээр байгуулагдсан Засгийн газар нь парламентад бүрэн эрхийн хугацаандаа баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн жагсаалтаа танилцуулдаг гэсэн бол 61 орны хувьд энэ талаарх мэдээлэл тодорхойгүй байна. Энэхүү танилцуулгыг шинэ Засгийн газар байгуулагдахын өмнө, эсхүл дараа хийж болно. Энэ нь Засгийн газар парламентын өмнө тодорхой үүрэг хариуцлага хүлээж нэгдсэн ойлголцолд хүрч буйн илэрхийлэл юм.

Ерөнхийлөгчийн засаглалтай орнуудад шинээр сонгогдсон Ерөнхийлөгч нь засгийн газрын бодлого, хөтөлбөрийг танилцуулдаг бөгөөд Ерөнхийлөгч ард түмнээс сонгогддог субъект тул хийж байгаа мэдээллийн агуулга нь парламентаас Ерөнхийлөгчид итгэл үзүүлэх эсэхэд хамааралгүй. Парламентын болон хагас Ерөнхийлөгчийн засаглалтай орнуудад энэхүү мэдээллийн араас томоохон хэлэлцүүлэг өрнүүлдэг бөгөөд ингэх нь ядаж онолын хувьд парламентаас Засгийн газарт хэр зэрэг итгэл үзүүлж байгааг илэрхийлэх чухал ач холбогдолтойд тооцогддог. Судалгаанд авагдсан 6 орны Засгийн газрын тэргүүн шинээр байгуулагдсан Засгийн газрын бодлого, хөтөлбөрийн талаарх мэдээллийг парламентад хийдэг гэж хариулсан байна.

Хоёр. Чуулганы нээлтэн дээр Засгийн газрын тэргүүн үг хэлэх

Төрийн тэргүүн болон Засгийн газрын тэргүүн парламентын чуулганы нээлтэн дээр үг хэлдэг нийтлэг туршлага байна. Төрийн тэргүүн болон Засгийн газрын тэргүүн парламентын чуулганы нээлтэн дээр үг хэлэхэд ямар нэгэн хязгаарлалт тогтоодоггүй. Парламентын бүрэн эрхийн хугацаанд чуулганы нийт үргэлжлэх хугацаа хэд хэдэн чуулганд хуваагддаг тул (хавар, намрын ээлжит, ээлжит бус гэх мэт) ээлжит чуулган бүрийн эхэнд тухайн жилд Засгийн газраас баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөтөлбөрийн талаар мэдээлэл хийдэг.

Судалгаанд авагдсан 88 орноос 33 оронд тухайн жилд хуралдаж буй чуулганы нээлтэн дээрээ Төрийн тэргүүний мэдээллийг сонсдог, 9 парламентад Засгийн газрын тэргүүний мэдээллийг сонсдог гэсэн байна. Зарим орнуудад Төрийн тэргүүн болон Засгийн газрын тэргүүний чуулганы нээлтэн дээр хийсэн мэдээллийн араас хэлэлцүүлэг хийдэг бол зарим оронд урьдчилан бэлтгэсэн асуултуудаа өгч хариулт авах нь үр нөлөөтэй гэж намын бүлгүүд нь үздэг байна.

Энэхүү хэлэлцүүлэг, асуулт хариулт нь 2-оос дээш 7 хоног хүртэл хугацаагаар үргэлжилж, хэвлэл мэдээлэлд нээлттэй өрнөдөг байна. Ийм төрлийн хэлэлцүүлгийг хийх сонирхол парламентын гишүүд болон парламент дахь намын бүлгүүдийн аль алиных нь хүсэл сонирхолд нийцдэг бөгөөд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөр нь бодлогын үндсэн чиглэл болон сөрөг хүчний тавьж буй шаардлагад нийцэж буй эсэхэд хяналт тавих зорилготой юм.

⁶¹ <http://archive.ipu.org/pdf/publications/oversight08-e.pdf> “Tools for Parliamentary oversight: A comparative analysis for 88 national parliaments” IPU, 2007

Ерөнхий сайдын чуулганы нээлтэн дээр хэлэх үг нь үндэсний хэмжээний бодлогын өргөн цар хүрээтэй асуудлуудыг хамрах ба зарим оронд тодорхой салбар хариуцсан сайд өөрийн эрхлэх асуудлын хүрээний бодлогын асуудлаар үг хэлдэг туршлага ч бас байна. Тухайлбал, Японы парламентад нээлтийн чуулган дээр парламентын 2 танхим тус бүрд дараах байдлаар нээлтийн үг хэлдэг: Ерөнхий сайд бодлогын ерөнхий асуудлаар, Сангийн сайд төсвийн бодлогын асуудлаар, Гадаад харилцааны сайд гадаад харилцааны бодлогын асуудлаар, Эдийн засгийн хөгжлийн сайд төсөв болон эдийн засгийн бодлогын асуудлаар тус тус үг хэлж, парламентын гишүүд араас нь асуулт асууж хоног дамнуулан хэлэлцүүлэг хийдэг байна.

Гурав. Парламентын чуулганд Ерөнхий сайд мэдээлэл хийж, асуултад хариулах (Ерөнхий сайдын цаг)

Их Британи, Ирланд, Канад, Австрали зэрэг улсуудын туршлагыг дараах 2 асуудлын хүрээнд авч үзлээ.

- Ерөнхий сайдын асуултын цагаар гишүүдийн асуулт асуух эрх (олонх асуулт асуудаг эсэх, асуултад цаг, дарааллын хязгаарлалт хийдэг эсэх, хэрхэн хийдэг талаар)
- Ерөнхий сайд өөрөө оролцох боломжгүй тохиолдолд хэн, хэрхэн орлох

1. ИХ БРИТАНИ

Их Британийн Парламентын доод танхим буюу Нийтийн танхимыг авч үзлээ.

Ерөнхий сайдын асуултын цагаар гишүүдийн асуулт асуух эрхийн талаар (олонх асуулт асуудаг эсэх, асуултад цаг, дарааллын хязгаарлалт хийдэг эсэх)

Их Британийн парламентын Нийтийн танхим нь Ерөнхий сайдын асуултын цагтай байдаг бөгөөд “Prime minister’s questions” (PMQs) гэж нэрлэдэг. Ерөнхий сайдын асуултын цаг Лхагва гараг бүрийн парламентын хуралдааны хугацаанд 12.00 - 12.30 цагийн хооронд явагдана. Энэ нь парламентын гишүүд мэдээлэл авах, Засгийн газарт шаардлага тавих, хариуцлага тооцох зорилготой байна.

Их Британид Ерөнхий сайдын асуултын цагийг дэгийн хууль, тусгайлан баталсан журмаар бус уламжлалт практикаар зохицуулж ирсэн байна. Ерөнхий сайдын асуултын цаг дээр Нийтийн танхимын гишүүд Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах загвар нь Ерөнхий сайд ба сөрөг хүчний тэргүүн хоёрын хооронд, үргэлжлүүлээд бусад гишүүдийн (олонх, цөөнх) асуултад хариулах хэлбэрээр явагдана.

Асуултын цагийн эхэнд гол сөрөг хүчний тэргүүн 6 асуулт асуух ба түүний дараа хоёр дахь сөрөг хүчний тэргүүн 2 асуулт асуухаар зохицуулагдсан байдаг.

Гол сөрөг хүчний тэргүүн асуух эрхээ янз бүрийн хэлбэрээр хэрэгжүүлж болно. Ерөнхий сайдаас нэг сэдвийн хүрээнд асуух, эсхүл олон сэдвийг хөндөн асууж болно. Ихэнх тохиолдолд асуултын цагийн эхэнд бүх асуултаа дараалан асуудаг ч заримдаа хувааж асуудаг.

Уламжлалт загвар ёсоор хоёр дахь сөрөг хүчний тэргүүн арай цөөн тооны асуулт (2 асуулт) асуух эрхтэй байна. 2010 оноос өмнө Нийтийн танхимын гурав дахь сөрөг хүчний (Либерал ардчилсан нам) тэргүүн Ерөнхий сайдаас асуулт асууж хариулт авах эрхтэй байсан байна.

Сөрөг хүчний тэргүүнүүдээс гадна дараах гишүүд асуулт асуух эрхтэй байна.

- Ерөнхий сайдын асуултын цагт асуулт асуухаар урьдчилан мэдэгдэж Захиалгын хуудсанд нэрээ бүртгүүлсэн гишүүд. Захиалгын хуудсанд гишүүн бүр бүртгүүлэх эрх нээлттэй бөгөөд тэдгээрээс санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 15 гишүүн Ерөнхий сайдаас тус бүр 1 асуулт асууна (Захиалгын хуудсанд өмнөх 7 хоногийн Пүрэв гараг хүртэл бүртгүүлнэ). Асуултын цагт гишүүний асуултад хариулж амжаагүй тохиолдолд хариултыг бичгээр хүргүүлнэ. Эсхүл дараагийн асуултын цагт шилжүүлж болно.
- Захиалгын хуудсанд нэр бүртгүүлээгүй боловч Ерөнхий сайдын асуултын цагийн үеэр асуулт асуух хүсэлт гаргасан гишүүн Нийтийн танхимын дарга зөвшөөрсөн тохиолдолд асуух эрхтэй. Үүнийг захиалгад ороогүй, урьдчилан мэдэгдээгүй "нэмэлт асуулт" гэж үздэг. Олонх болон сөрөг хүчний гишүүд ээлжилж асуухаар зохицуулагдсан байна.

Асуулт асууж, хариулах хугацааг тодорхой зохицуулаагүй бөгөөд практикаар товч тодорхой, богино хэмжээтэй явагддаг. Erskine May-д зааснаар асуултад хариулах хугацаа 1 минут байна.

Тайлбар: Их Британид Erskine May нь "Парламентын дэгийн Библи" гэж нэрлэгддэг бөгөөд парламентын үйл ажиллагааны талаарх практик туршлагыг агуулдаг. Энэ нь парламентын үйл ажиллагаанд нөлөөлөх парламентын процедур болон үндсэн хуулийн конвенцын талаарх хамгийн нөлөө бүхий бүтээл юм. Erskine May нь багц журам гэхээсээ илүү Нийтийн танхим, Лордуудын танхимын процедур хэрхэн өөрчлөгдөж ирсэн, түүнд хамаарах конвенцуудын тухай тайлбар юм.

Парламентын дарга шийдвэр гаргахдаа Erskine May-г байнга иш татдаг бөгөөд Нийтийн танхим дахь мэтгэлцээний үеэр байнга ашигладаг. Түүнээс гадна мэдээллийн эх сурвалжийн хувьд олон нийтийн сонирхлыг татдаг бөгөөд Их Британиас гадна, ялангуяа үндсэн хуулийн зохицуулалтаа Вестминстерийн системээр загварчилсан улс орнуудад нөлөөтэй байна.

Одоогийн байдлаар Erskine May-н 25 дахь хэвлэлийг онлайнаар үзэх боломжтой. Энэ нь парламентын гишүүд болон ажилтнуудад, бусад хүмүүст практик гарын авлага болдог бөгөөд парламентын процедурын удирдамж болгон ашигладаг.

Ерөнхий сайд өөрөө оролцох боломжгүй тохиолдолд хэн, хэрхэн орлох вэ?

Ерөнхий сайдын цагт зайлшгүй хүндэтгэх шалтгаанаас бусад тохиолдолд Ерөнхий сайд нь өөрөө биечлэн оролцож асуултад хариулдаг (хүндэтгэх шалтгааныг заасан тодорхой зохицуулалт байхгүй). Ерөнхий сайд өөрөө оролцох боломжгүй тохиолдолд Шадар сайд, эсхүл бусад сайд орлож оролцоно. Энэ тохиолдолд сөрөг хүчний тэргүүнүүд сайдад асуулт тавихгүй, харин Сүүдрийн Засгийн газар (Shadow government)-ын сайд, эсхүл тэргүүнийг төлөөлж (Spokesperson) асуулт асууна.

Практикаас харахад Их Британийн үе үеийн Ерөнхий сайдууд Ерөнхий сайдын асуултын цагт онцгой ач холбогдол өгч идэвхтэй оролцож ирсэн байна.

Хүснэгт 3. Их Британийн Нийтийн танхимын хуралдааны Ерөнхий сайдын цагт
Ерөнхий сайдуудын оролцсон байдал (1979 – 2021.10.04-ний байдлаар)

Ерөнхий сайдын нэр/он	Ерөнхий сайдын асуултын цагийн тоо/удаа	Ерөнхий сайд биечлэн оролцсон		Ерөнхий сайд биечлэн оролцоогүй	
		тоо	хувь	тоо	хувь
Маргарет Тэтчер					
1979-83	268	250	93.3	18	6.7
1983-87	262	241	92.0	21	8.0
1987-90	222	203	91.4	19	8.6
Нийт	752	694	92.3	58	7.7
Жон Мейжор					
1990-92	88	79	89.8	9	10.2
1992-97	310	272	87.7	38	12.3
Нийт	398	351	88.2	47	11.8
Тони Блер					
1997-01	140	134	95.7	6	4.3
2001-05	135	129	95.6	6	4.4
2005-07	68	63	92.6	5	7.4
Нийт	343	326	95.0	17	5.0
Гордон Браун					
2007-10	85	75	88.2	10	11.8
Дэвид Кэмерон					
2010-15	157	146	93.0	11	7.0
2015-16	33	31	93.9	2	6.1
2016-17 ¹	6	5	83.3	1	16.7
Нийт	196	182	92.9	14	7.1
Тереза Мэй					
2016-17	25	24	96.0	1	4.0
2017-19 ²	77	70	90.9	7	9.1
Нийт	102	94	92.2	8	7.8
Борис Жонсон					
2017-19	2	1	50.0	1	50.0
2019	2	2	100.0	0	0.0
2019-21	54	29	53.7	2	3.7
2021-22*	13	12	92.3	1	7.7

Жич:

¹ Тереза Мэй 2016 оны 7-р сарын 13-нд Консерватив намын тэргүүний өрсөлдөөний үр дүнд Ерөнхий сайд болсон.

² Борис Жонсон 2019 оны 5-р сарын 24-нд шинэ тэргүүний сонгууль явуулсны дараа 2019 оны 7-р сарын 24-ний Ерөнхий сайдын асуултын цагаас хойш Тереза Мэйгийн оронд Ерөнхий сайд болсон.

* 2021 оны 10-р сарын 04-ний байдлаар

Эх сурвалж: House of Commons Library Standard Note, Attendance of the Prime Minister at Prime Minister's Questions since 1979, SN/PC/4401, 15 December 2014, <https://commonslibrary.parliament.uk/research-briefings/sn04401/>

2. ИРЛАНД УЛС

Судалгаанд холбогдох асуудлыг Парламентын доод танхим болох Дайл Эйрэанны хувьд авч үзлээ.

Ерөнхий сайдын асуултын үеэр асуулт асуух эрх (олонх асуулт асуудаг эсэх, асуултад цаг, дарааллын хязгаарлалт хийдэг эсэх)

Аман асуултын цаг нь Парламентын гишүүдийн оролцоог хангаж, нээлттэй байх мөн сөрөг хүчний тэргүүн нарыг оролцуулдаг онцлогтой байна.

Энэхүү цаг нь 7 хоногт 2 удаа буюу Даваа, Мягмар гарагт 14.00 цагт болдог. Асуулт асуух эрхийн хувьд эхлээд сөрөг хүчний тэргүүн асуулт асууж, удаах асуултуудыг бусад намын гишүүд болон олонх асууна. Ерөнхий сайд биечлэн оролцох ба асуултад нэг бүрчлэн хариулна. Дайл Эйрэанны дэгийн⁶² дагуу нэмэлт асуултыг “шаардлагатай мэдээллийг тодруулах” зорилгоор тавьдаг. Нэмэлт асуултад хариулахдаа бусад сайд нарыг оролцуулж болно.

Асуулт хариултын нийт хугацаа 45 минутаас хэтрэхгүй. Асуултад хариулах хугацаа 3 минут, нэмэлт асуултад 90 секунд олгодог.

Энэхүү асуулт, хариултууд нь Дайл Эйрэанны Парламентын мэтгэлцээний албан ёсны тайланд ном хэлбэрээр хэвлэгдэж, 24 цагийн хугацаанд вэбсайтаар олон нийтэд түгээдэг байна.

Ирландад асуулт асуух дарааллын талаар процедурын болон уламжлалт заалт байдаггүй ч сөрөг хүчний оролцоог хангалттай сайн хангасан байдаг.

Танхимд асуулт асуух хүсэлтэй гишүүд Мягмар гарагийн 11 цагаас өмнө Дайл Эйрэанны даргад хүсэлтээ ирүүлнэ. Гишүүд асуултаа урьдчилан бичгээр илгээдэг. Асуултын цагаар асуух асуултыг сонгох ажлыг парламентын дарга удирдах бөгөөд асуултууд Дайл Эйрэанны дэгт нийцэж байгаа эсэхийг хянадаг байна.

Асуултын цагтай өдөр буюу Даваа, Мягмар гарагийн Дайл Эйрэанны хуралдааны танхимд тус бүр 15 гишүүн бүртгүүлсэн дарааллын дагуу асуултаа асуух ба тухайн өдөр хариулж амжаагүй үлдсэн асуултад бичгээр хариу өгнө.

Асуулт тавьж буй гишүүн нэмэлт асуулт тавих эрхтэй. Нэмэлт асуулт тавих эсэхийг Парламентын доод танхим буюу Дайл Эйрэанны дарга шийднэ. Нэмэлт асуулт нь анхны асуулттай холбоотой байх ёстой бөгөөд асуултад аль болох тодорхой, бүрэн хариулна.

Ерөнхий сайд өөрөө оролцох боломжгүй тохиолдолд хэн, хэрхэн орлох вэ?

Ерөнхий сайдын эзгүйд Шадар сайд түүнийг орлодог. Хэрэв энэ албан тушаал эзгүй эсхүл Шадар сайд байхгүй тохиолдолд Төрийн нэгдүгээр нарийн бичгийн дарга орлож оролцоно. Асуултыг сөрөг хүчний тэргүүн эхэлж асуудаг. Сөрөг хүчний тэргүүн эзгүй тохиолдолд ихэвчлэн сөрөг хүчний Сүүдрийн Засгийн газрын дараагийн өндөр албан тушаал бүхий гишүүн орлохоор зохицуулагдсан байна.

3. КАНАД УЛС

Канад Улсын парламентын доод танхим буюу Нийтийн танхимын туршлагыг авч үзлээ.

7 хоногийн бүх өдрүүдэд буюу чуулганы нэгдсэн хуралдааны Даваа-Пүрэв гарагийн 14.15 цагт, Баасан гарагийн 11.15 цагт “Асуултын цаг” (Question period) болдог. Нийтийн танхим

⁶² DÁIL ÉIREANN, STANDING ORDERS RELATIVE TO PUBLIC BUSINESS, 2020, https://data.oireachtas.ie/ie/oireachtas/parliamentaryBusiness/standingOrders/dail/2021/2021-01-27_consolidated-dail-eireann-standing-orders-january-2021_en.pdf

дахь Засгийн газрын сайд нарын мэдээлэл хийх, гишүүдийн асуулт асуух, хариулах энэхүү үйл явцыг Нийтийн танхимын дэгээр (Standing order)⁶³ зохицуулдаг байна.

Засгийн газраас мэдээлэл авах эрх, Засгийн газарт хариуцлага тооцох эрх нь Парламентын засаглалын үндсэн зарчим юм. Гишүүд энэхүү эрхээ танхимд асуулт асуух замаар хэрэгжүүлдэг.

Асуултын цагт эхлээд Засгийн газрын гишүүн 15 минут мэдээлэл хийх ба араас нь асуулт хариулт явна. Нийт үргэлжлэх хугацаа 45 минут байна. Асуултын цаг нь хамтын журмаар хэрэгждэг бөгөөд Ерөнхий сайд, сайд нартай хамт асуултад хариулдаг.

Ерөнхий сайд бол эрх барьж буй намын дарга бөгөөд Засгийн газрын тэргүүн юм. Ерөнхий сайдын үүрэгт:

- Засгийн газрын хуралдааныг даргалах;
- Нийтийн танхимд асуултад хариулах гэж тусгайлан заасан.

Чуулганы өдөр бүрийн 14.15 цагт (Баасан гарагийн 11.15 цагт) Парламентын дарга сөрөг хүчний тэргүүнд асуулт асуух боломжийг олгосноор Асуултын цаг эхэлнэ. Дараа нь гол сөрөг хүчний хоёр дахь гишүүн хоёр асуулт асуух эрхтэй. Сөрөг хүчний хоёр дахь намын хоёр гишүүн тус бүр хоёр асуулт асуух эрхтэй бөгөөд эцэст нь сөрөг хүчний гуравдагч талын төлөөлөгч гурван асуулт асуухыг хүлээн зөвшөөрсөн байна.⁶⁴

Өдөр бүрийн асуултын цагийг Нийтийн танхимын дарга удирдан явуулах бөгөөд асуултын цагийг иргэний журмаар явуулах, асуулт хариултыг мэтгэлцээнд хүргэхгүй байх, танхимын бүх талын оролцоог хангах боломжийг бүрдүүлэхийг эрмэлзэх ёстой байна.

Асуултын дараалал нь Нийтийн танхим дахь намын төлөөлөл болон нам тус бүрийн гишүүдийн тоонд үндэслэн тохиролцсон ротацын жагсаалтыг дагаж мөрддөг.

Эрх баригч намын гишүүд сөрөг хүчний намын гишүүд шиг олон удаа асуулт асуух эрхтэй байна. Танхимд намын бүлэггүй гишүүд болон бие даагч гишүүд асуулт асуухыг зөвшөөрдөг боловч олон удаа асуулт асуух боломжгүй байдаг.

Ерөнхий сайд (эсхүл Шадар сайд болон Ерөнхий сайдын нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэж байгаа бусад сайд) асуултын цагт тавьсан зарим асуултад эсхүл бүх асуултад хариулж болно. Тухайн асуултад зөвхөн нэг сайд хариулах бөгөөд нэмэлт мэдээлэл өгөх зорилгоор өөр сайд хариулж болно.

Асуултын цагт бүх сайд нар оролцох бөгөөд эзгүй байгаа сайдын чиг үүргийн талаар асуулт асуувал Ерөнхий сайд, өөр сайд, эсхүл Нийтийн танхимын нарийн бичгийн дарга хариулж болно.

Нийтийн танхимын дарга нь сайдын хариултыг дүрэм журам, ёс зүй, парламентын хэл ярианы стандартад нийцэж байгаа эсэхийг хянах боловч асуултын хариултын чанар, агуулгад хариуцлага хүлээдэггүй байна.

Засгийн газрын гишүүдийн мэдээлэл.⁶⁵ Өдөр бүр Засгийн газрын гишүүдэд улс, бүс нутаг, орон нутгийн чанартай асуудлаар мэдээлэл хийх 15 минутын хугацаа өгдөг. Сайд нарын мэдээллийн дараа Ерөнхий сайд Засгийн газрын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийн талаар богино хэмжээний мэдээлэл хийж болно.

Гишүүд сайд нарт урьдчилан мэдэгдэлгүйгээр хариуцсан салбарынх нь талаар ямар ч асуулт тавьж болдог. Энэ нь хариуцлага тооцох нэг хэлбэр юм. Асуултын хариултад сэтгэл

⁶³ Standing Orders of the House of Commons, <https://www.ourcommons.ca/about/standingorders/Index-e.htm>

⁶⁴ <https://discovery.ucl.ac.uk/id/eprint/10090111/>

⁶⁵ Канадын Нийтийн танхимын газрын авлага, https://learn.parl.ca/sites/Learn/default/en_CA/GuideToHOC/Day

дундуур байгаа гишүүн тухайн өдрийн төгсгөл, эсхүл завсарлага авах үеэр уг асуултыг дахин хөндөх хүсэлтийг бичгээр гаргана.

Хүснэгт 4. Канад Улсын Нийтийн танхимын өдөр тутмын ажлын хуваарь

Hours	Monday	Tuesday	Wednesday	Thursday	Friday	Hours
10:00 - 11:00		ROUTINE PROCEEDINGS ----		ROUTINE PROCEEDINGS ----	Government Orders	10:00 - 11:00
11:00 - 11:15	Private Members' Business				Statements by Members	11:00 - 11:15
11:15 - 12:00					Oral Questions	11:15 - 12:00
12:00 - 1:00					ROUTINE PROCEEDINGS ----	12:00 - 1:00
1:00 - 1:30	Government Orders	Government Orders	Review of Delegated Legislation*	Government Orders	Government Orders	1:00 - 1:30
1:30 - 2:00					Private Members' Business	1:30 - 2:00
2:00 - 2:15	Statements by Members	Statements by Members	Statements by Members	Statements by Members		2:00 - 2:15
2:15 - 2:30	Oral Questions	Oral Questions	Oral Questions	Oral Questions		2:15 - 2:30
2:30 - 3:00						2:30 - 3:00
3:00 - 5:30	ROUTINE PROCEEDINGS ----- Government Orders	ROUTINE PROCEEDINGS ----- Government Orders	ROUTINE PROCEEDINGS ----- Notices of Motions for the Production of Papers --- Government Orders	ROUTINE PROCEEDINGS ----- Government Orders		3:00 - 5:30
5:30 - 6:30		Private Members' Business	Private Members' Business	Private Members' Business		5:30 - 6:30
6:30 - 7:00	Adjournment Proceedings	Adjournment Proceedings	Adjournment Proceedings	Adjournment Proceedings		6:30 - 7:00

* If required, House to sit at 1:00 p.m. for the review of Delegated Legislation pursuant to Standing Order 128(1).

Please note that certain proceedings (notably Private Members' Business and Adjournment Proceedings) may be suspended, delayed or rescheduled in accordance with the Standing Orders as a result of events such as recorded divisions, "Statements by Ministers" and "Introduction of Government Bills".

4. АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС

Австрали Улсын хувьд асуултын цагт парламентын Төлөөлөгчдийн танхим болон Сенатын танхимын гишүүд хамтран оролцдог. Асуултын цаг нь Австралийн парламент нь гүйцэтгэх засаглалын ажлыг шалгах арга замуудын нэг юм. Вестминстерийн тогтолцооны дагуу сайд нар парламентын гишүүн байх бөгөөд хариуцлагатай байж, шийдвэрлэсэн шийдвэр, гүйцэтгэсэн ажлаа төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд асуултын цаг дээр тайлбарладаг байна. Мөн сайд нарт өөрсдийн үзэл бодол, манлайлах чадвар, улс төрийн ур чадвараа танилцуулах боломжийг олгодог ч нөгөөтэйгүүр сайд нарын ажлыг хянах механизмын нэг арга нь болдог байна.

Ерөнхий сайдын асуултын цагт гишүүдийн асуулт асуух эрхийн талаар (олонх асуулт асуудаг эсэх, асуултад цаг, дарааллын хязгаарлалт хийдэг эсэх)

Австралийн парламент дахь Ерөнхий сайдын асуултын цагийг **Question Time**⁶⁶ гэж нэрлэдэг бөгөөд парламентын дэгийн тухай зохицуулалт, тусгайлан баталсан журмаар бус уламжлалт практикаар зохицуулж байна. Асуултын цаг нь парламентын чуулганы хуралдааны өдөр бүрийн 14.00 цагт эхэлж 1 цагийн хугацаатай үргэлжилдэг.

Асуулт асуух гишүүд 30 секундээс 1 минутын хугацаатай асуултаа асууж Ерөнхий сайд болон сайд нар 5 минутад багтааж хариулт өгнө. Асуултын цагийн хугацаанд 10 хүртэлх асуулт асуух боломжтой байна.

⁶⁶ Question time, <https://peo.gov.au/understand-our-parliament/how-parliament-works/parliament-at-work/question-time-in-the-australian-parliament/>

Хамгийн эхний асуулт асуух эрхийг Парламентын дарга сөрөг хүчинд олгодог. Дараагийн асуултаас эхлээд тогтсон практикийн дагуу танхимын баруун жигүүрээс зүүн жигүүрийн дагуу эрх баригч нам, сөрөг хүчний намын болон бие даагч гишүүдээс ээлжлэн асуулт асуудаг.

Зураг 1. Австралийн парламентын Асуултын цаг



Эх сурвалж: Parliamentary education office, <https://peo.gov.au/understand-our-parliament/how-parliament-works/parliament-at-work/question-time-in-the-australian-parliament/>

Асуултын цагт сайд нар өөрийн чиг үүргийн дагуу асуултад хариулахаас өөрөөр намын үзэл баримтлал, хувь гишүүний хувьд хариулт хэлэх ёсгүй. Хэрэв тус сайдын чиг үүргээс өөр тухайн цаг үеийн асуудалтай холбоотой асуулт асуувал Ерөнхий сайд хариулна.

Асуултын цагт асууж амжаагүй нэмэлт асуултын хариултыг хариуцсан сайд бичгээр хүргүүлнэ. Асуултын цаг нь зөвхөн гишүүдэд төдийгүй олон нийтийн анхаарлын төвд байдаг учраас үндэсний телевиз болон парламентын сувгаар шууд дамжуулдаг. Мөн парламентын цахим хуудсанд байршуулна.

Ерөнхий сайд өөрөө оролцох боломжгүй тохиолдолд хэн хэрхэн орлох вэ?

Парламентын дарга асуултын цаг эхэлснийг зарлахад Ерөнхий сайд асуулт асуухаас өмнө оролцож байгаа сайд нарын ирцийг танилцуулна. Асуултын цагт оролцоогүй сайд нарын шалтгааныг (төрийн яаралтай ажилтай, өвчтэй, гадаадад томилолттой байгаа) танилцуулж, оронд нь аль сайд асуултад хариулахыг танилцуулна, эсхүл өөрөө тухайн сайдаа орлож асуултад хариулдаг байна. Харин Ерөнхий сайд өөрөө мэдээлэл хийх, асуултын цагт оролцох боломжгүй тохиолдолд Ерөнхий сайдыг төлөөлөх сайд мэдээлэл хийж асуултад хариулна.

Хүснэгт 5. Асуултын цагт тавьсан асуултын тоо (2007-2019 оны байдлаар)

Он	Асуулт / бичгээр урьдчилан мэдэгдсэн /	Асуулт / шууд буюу урьдчилан мэдэгдээгүй/	Чуулган хуралдааны нийт тоо
2007*	1046	904	50
2008	554	1290	69
2009	616	1187	68
2010*	421	948	55
2011	621	882	64
2012	540	899	63
2013*	239	817	48
2014	644	1433	76
2015	1445	1371	75
2016*	711	945	51
2017	255	1155	64
2018	340	1304	65
2019*	16	206	10

* Сонгуулийн жил

ХАВСРАЛТ. Бусад орнуудын туршлагын харьцуулалт

	Сингапур <u>Question time</u>	Малайз <u>Minister's Question Time</u>	Герман <u>Questions to the Federal Government</u>	Болгар <u>Questions</u>
Ерөнхий сайд, сайдад асуулт тавих цаг тов, нэршил	Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан гарагийн Парламентын хуралдаан бүрийн эхний 1 цаг 30 минутад Засгийн газарт асуулт тавих цаг байна.	Засгийн газрын гишүүд долоо хоногт 2 удаа Мягмар, Пүрэв гарагт Парламентын гишүүдийн асуултад хариулт өгдөг. 2018 оны сонгуулиар Парламентад 3 гол шинэчлэл хийх болсны нэг нь” Ерөнхий сайдад асуулт тавих цагтай болох” байсан. Одоогоор хэрэгжүүлээгүй байна.	Засгийн газрын хуралдааны дараа Лхагва гараг бүрийн 13 цагаас Засгийн газрын хуралдааны талаар товч танилцуулгыг 30 минут хийдэг бөгөөд гишүүд асуулт асуух эрхтэй байдаг. 2018 онд анх удаа Ангела Меркель Бундестагт Ерөнхий сайдын асуулт, хариултын цаг”-тай болгосон.	Долоо хоног бүрийн Баасан гарагийн хуралдааны сүүлийн 3 цагт Засгийн газрын асуултын цаг байна. Үндэсний Ассамблейн дэгийн дагуу Засгийн газрын нийт үйл ажиллагаа, бодлого арга хэмжээний талаарх асуултад Ерөнхий сайд хариулт өгнө.
Гишүүдийн асуулт асуух эрх	Парламентын бүх гишүүд асуулт асууж, хариулт авах эрхтэй.	Парламентын бүх гишүүд асуулт асууж, хариулт авах эрхтэй.	Парламентын бүх гишүүд асуулт асууж, хариулт авах эрхтэй.	Парламентын бүх гишүүд асуулт асууж, хариулт авах эрхтэй.
Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийн асуулт хариултын үргэлжлэх нийт хугацаа	Асуулт, хариултын нийт үргэлжлэх хугацаа нь 90 минут хүртэл байж болно. Шаардлагатай тохиолдолд Парламентын дарга асуулт, хариултыг богиносгосон хугацаагаар явуулж болно.	Засгийн газрын асуултын цаг нь 30 минут үргэлжилнэ.	Асуултын цаг нь 30 минут үргэлжилнэ.	Засгийн газрын асуултын цагийн нийт үргэлжлэх хугацаа 3 цаг байна.
Гишүүдийн асуулт тавих тоо, хугацаа	Гишүүн 3 асуулт асууж болно. Хариултыг тодруулах үүднээс нэмэлт асуулт асууж болох ба Парламентын дарга шаардлагагүй гэж үзвэл нэмэлт асуулт асуухыг зөвшөөрөхгүй байж болно.	Гишүүн үндсэн асуултаас гадна нэмэлт 3 асуулт асууж болно. Үндсэн болон нэмэлт асуулт хариулт нь 10 минутаас хэтэрч болохгүй.	Асуултын цагт 2 асуулт тавьж болно. Мөн 2 нэмэлт асуулт тавьж болно. Парламентын дарга хуралдааны хугацаа хангалттай гэж үзвэл гишүүдээс нэмэлт асуулт тавихыг зөвшөөрнө.	Гишүүн 2 асуулт асууна. Асуулт тавих хугацаа нь 3 минут байх бөгөөд хариулт өгөх хугацаа нь 5 минут байна. Тодруулга авах үүднээс нэмэлт 2 асуулт асууж болох бөгөөд нэмэлт асуултын хугацаа 2 минут байна. Нэмэлт асуултад хариулах 2 минут байна.
Асуулт хариултын хугацаанд асуултад хариулж амжаагүй тохиолдолд	Гишүүний асуултад хариулж амжаагүй бол бичгээр хариу ирүүлнэ.	Гишүүний асуултад хариулж амжаагүй бол бичгээр хариу ирүүлнэ.	Гишүүний асуултад хариулж амжаагүй бол долоо хоногт багтаан бичгээр хариу ирүүлнэ.	Гишүүний асуултад хариулж амжаагүй бол бичгээр хариу ирүүлнэ.
Ерөнхий сайд, сайд хуралдаанд оролцох боломжгүй	Ерөнхий сайд, сайд оролцох боломжгүй бол асуултыг тухайн Засгийн газрын гишүүн оролцсон хуралдаанд тавьж хариулт авах, эсхүл хариуг бичгээр авч болно.		Ерөнхий сайд, сайд оролцох боломжгүй бол асуултыг тухайн Засгийн газрын гишүүн оролцсон хуралдаанд тавьж хариулт авна.	Ерөнхий сайд, сайд оролцох боломжгүй бол энэ тухай мэдэгдэж асуултыг хойшлуулах хүсэлт гаргана.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Их Британи

- Prime Minister's Questions, Richard Kelly, Parliament and Constitution Centre, 9 February 2015, <https://researchbriefings.files.parliament.uk/documents/SN05183/SN05183.pdf>
- UK parliament, Question time, https://www.parliament.uk/about/how/business/questions/?__cf_chl_managed_tk__=5Hh2FR7IMebZwCAJ1J2LZvxEW69qbYWnouQhTOUaoDM-1642474192-0-gaNycGzNDT0
- STANDING ORDERS, PUBLIC BUSINESS 2021, https://publications.parliament.uk/pa/cm5802/cmstords/so_804_2021/so-804_02122021.pdf
- UK parliament, MPs Guide to Procedure, Prime Minister's questions <https://guidetoprocure.parliament.uk/collections/nPylcSv3/prime-ministers-questions>

Ирланд

- DÁIL ÉIREANN, STANDING ORDERS RELATIVE TO PUBLIC BUSINESS, 2020, https://data.oireachtas.ie/ie/oireachtas/parliamentaryBusiness/standingOrders/dail/2021/2021-01-27_consolidated-dail-eireann-standing-orders-january-2021_en.pdf
- House of the Oireachtas, Parliamentary questions, <https://www.oireachtas.ie/en/debates/questions/>
- Канад
- House of Commons Canada, Question https://www.ourcommons.ca/about/OurProcedure/Questions/c_g_questions-e.htm
- House of Commons Canada, Oral Question https://learn.parl.ca/sites/Learn/default/en_CA/GuideToHOC/Day
- Standing orders of House of Commons <https://www.ourcommons.ca/About/StandingOrders/Index-e.htm>

Австрали

- Rules governing questions, https://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7/HTML/Chapter15/Rules_governing_questions
- Question Time in the Australian Parliament, <https://peo.gov.au/understand-our-parliament/how-parliament-works/parliament-at-work/question-time-in-the-australian-parliament/>

Герман

- Rules of Procedure of the German Bundestag and Rules of Procedure of the Mediation Committee <https://www.btg-bestellservice.de/pdf/80060000.pdf>
- https://www.bundestag.de/en/parliament/function/scrutiny/instruments_scrutiny-245710

Сингапур

- <https://www.parliament.gov.sg/about-us/parliament-information/sitting-of-parliament>
- STANDING ORDERS OF THE PARLIAMENT OF SINGAPORE, <https://www.parliament.gov.sg/docs/default-source/default-document-library/standing-orders-of-the-parliament-of-singapore.pdf>

Болгар

- RULES of Organization and Procedure of the National Assembly, <https://www.parliament.bg/en/podns>
- Малайз
- Malaysian Parliamentary Procedure: A Guide to the Standing Orders of the Dewan Rakyat <https://drive.google.com/file/d/1Fd-PIdvqDZupXDCjPm85MGc2jb2yaQNV/view>

Бусад

- Serban, Ruxandra; (2020) Questioning Prime Ministers: Procedures, Practices and Functions in Parliamentary Democracies. Doctoral thesis (Ph.D), UCL (University College London) https://discovery.ucl.ac.uk/id/eprint/10090111/9/Serban_10090111_Thesis_revised.pdf

**БА ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО: МОНГОЛ УЛС БОЛОН ГАДААДЫН
ЗАРИМ УЛСЫН ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Б.Буянзаяа, Г.Билгээ,
Ц.Ариунаа, Б.Туул, П.Уранчимэг*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

НЭГ. ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ХЭЛБЭР
(Зарим орны туршлагаас)

- 1.1. Парламентын хяналтын хороо
- 1.2. Ерөнхий хянан шалгагч
- 1.3. Хөндлөнгийн хяналтын мэргэшсэн бүтэц

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ,
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД, ГҮЙЦЭТГЭХ АЖИЛД ТАВИХ ХЯНАЛТ

- 2.1. Оросын Холбооны Улс
- 2.2. Бүгд Найрамдах Солонгос Улс
- 2.3. Бүгд Найрамдах Турк Улс


ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ,
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД БА ХЯНАЛТ

- 3.1. Эрх зүйн зохицуулалт
- 3.2. Гүйцэтгэх байгууллагуудын гүйцэтгэх ажлын зорилго, хүний эрхийг хангах нь
- 3.3. Гүйцэтгэх ажилд тавих хяналт

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ

Монгол Улсын гүйцэтгэх ажлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн лавлагаа



УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Гүйцэтгэх ажлын эрх зүйн орчин, хэрэгжүүлэгч байгууллагууд ба хяналтын тогтолцоо: Монгол Улс болон гадаадын зарим улсын туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Гүйцэтгэх ажлын тухай хуулийг боловсронгуй болгохтой холбогдуулан гадаадын зарим орны гүйцэтгэх ажлын талаарх эрх зүйн зохицуулалтын талаар судлав.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын болон гадаадын зарим улсын (Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс болон Бүгд Найрамдах Турк Улс) тагнуулын үйл ажиллагаа болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг мөрдөн шалгах хүрээнд хийгддэг нууц мөрдөн шалгах ажиллагаа буюу гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчин, гүйцэтгэх ажил явуулдаг байгууллагууд, тэдгээрийн эрх, үүрэг, гүйцэтгэх ажлын үед хүний эрх, эрх чөлөөг хангах болон гүйцэтгэх ажиллагаанд тавих хяналт зэрэг асуудлуудыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд харьцуулан судаллаа.

Судалгааны бүтэц: Судалгааны тайлан нь гурван бүлэгтэй бөгөөд Нэгдүгээр бүлэгт, тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих хэлбэр; Хоёрдугаар бүлэгт, гадаадын зарим улсын гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэгч байгууллагууд, гүйцэтгэх ажилд тавих хяналт; Гуравдугаар бүлэгт, Монгол Улс дахь гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэгч байгууллагууд, гүйцэтгэх ажилд тавих хяналтын талаар судлав.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 247 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д гүйцэтгэх ажил, түүний үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг, мэдээллийг төрийн нууцын “онц чухал нууц”, “маш нууц” зэрэглэлд орно гэж заасан байдаг. Иймээс уг судалгааг гүйцэтгэх ажиллагаатай холбоотой батлан гаргасан хууль, журам болон олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээллийн хүрээнд бэлтгэн танилцуулж байна.

Түлхүүр үг: гүйцэтгэх ажил, тагнуулын үйл ажиллагаа, сөрөх тагнуул, мөрдөн шалгах нууц ажиллагаа, мөрдөн байцаах, нууц ажиллагаа.

Key word: investigation, confidentiality, criminal, punitive actions, operational investigation.

Ключевые слова: оперативно-розыскная деятельность, оперативно-розыскные мероприятия.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагууд хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ ихэвчлэн нууц, далд хэлбэрээр зохион байгуулдаг. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ хийгээд гүйцэтгэх ажлыг явуулах арга аргачлал нь тодорхой үндэслэл бүхий шалтгааны улмаас хүний эрх, эрх чөлөөнд халдах шаардлагатай тулгардаг.

Иргэд олон нийтийн зүгээс татвар төлөгчдийн мөнгөөр явуулж байгаа энэхүү ажиллагаа нь өөрийн болон хэн нэгний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдаж байгаа эсэх, гүйцэтгэх ажиллагаагаар олж авсан мэдээллүүд өөр зорилгоор ашиглагдаж байгаа эсэхэд үргэлж анхаарал хандуулж мөн эргэлзсээр ирсэн. Учир нь гүйцэтгэх ажиллагаанд өндөр түвшний нууцлал шаардлагатай байдаг тул эдгээр байгууллагууд үйл ажиллагаагаа төрийн бусад

байгууллагатай адилаар нээлттэй тайлагнах боломжгүй байдаг учраас тэдгээр байгууллагуудын явуулж буй гүйцэтгэх ажил хуулийн хүрээнд явагддаг эсэх, хүний эрхэнд хууль бусаар халддаг эсэхэд бүрэн дүүрэн эргэлзээ тайлах хариулт авах боломжгүй байдаг. Тиймээс гүйцэтгэх ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээ, нийгмийн шаардлага өдрөөс өдөрт өсөн нэмэгдсээр байна.

Тусгай албадын үйл ажиллагаа нь тусгай албад холбогдох төрийн бодлого, хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг мөрдөж буй эсэх, үйл ажиллагаагаа үр дүнтэйгээр явуулж буй эсэхийг баталгаажуулж чадсан хяналтын боловсронгуй тогтолцоотой эсэхээр тодорхойлогдоно гэж гадаад улсын зарим судлаачид үздэг байна.

Хэдийгээр хууль, журмыг сахин биелүүлж буй эсэхийг хянах үйл явц харьцангуй хялбар, боломжтой байж болох хэдий ч нөгөө талаас үр дүн, ашигт байдлыг хянахын тулд тогтолцоог цогцоор нь авч үзэх шаардлагатай болдог. Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудын томилогдсон удирдлага, тэдгээрийн албан хаагчид салбарынхаа стратеги, чиг үүргийг бодитой тодорхойлж, ойлгож чадаж буй эсэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн сахих өндөр ёс суртахуунтай эсэх, аюул заналхийлэл, боломж бололцоонд тохирсон гүйцэтгэх ажиллагааны шалгуур үзүүлэлт, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж чадаж буй эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй гэж судлаачид үзэж байна.

1.Эрх зүйн зохицуулалт:

Судалгаанд авагдсан орнууд болон Монгол Улсад тагнуулын үйл ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг мөрдөн шалгах хүрээнд хийгддэг гүйцэтгэх ажил (нууц мөрдөн шалгах ажиллагаа, шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа)-тай холбоотой эрх зүйн харилцааг **багц хуулиар** зохицуулж байна.

Оросын Холбооны Улс (ОХУ)-д гүйцэтгэх ажлыг “шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа” (оперативный розыск) (ШЭСА) гэх бөгөөд түүнтэй холбоотой эрх зүйн үндсэн харилцааг Холбооны улсын шуурхай эрэн сурвалжлах ажиллагааны тухай хуулиар (Закон об оперативно-розыскной деятельности) (цаашид “ШЭСА-ны тухай хууль”) зохицуулахаас гадна дараах багц хууль тогтоомжоор зохицуулна:

- ОХУ-ын Үндсэн хууль;
- Холбооны улсын үндсэн хуульчлагдсан хуулиуд - үүнд, ОХУ-ын Шүүхийн тогтолцооны тухай холбооны үндсэн хуульчлагдсан хууль (Федеральный конституционный закон о Судебной системе Российской Федерации) зэрэг хамаарна;
- Холбооны улсын бусад хуулиуд - үүнд, Эрүүгийн кодекс (Уголовный кодекс), Эрүүгийн байцаан шийтгэх кодекс (Уголовно-процессуальный кодекс), Төрийн нууцын тухай хууль (О государственной тайне), Прокурорын байгууллагын тухай хууль (О прокуратуре), Мансууруулах эм, сэтгэгээд нөлөөт бодисын тухай хууль (О наркотических средствах и психотропных веществах), мөн холбогдох байгууллагуудын эрх зүйн байдлыг зохицуулсан хуулиуд, тухайлбал, Цагдаагийн тухай (О полиции), Холбооны аюулгүй байдлын албаны тухай (О федеральной службе безопасности) хуулиуд хамаарна;
- Холбооны улсын төрийн байгууллагуудаас гаргасан эрх зүйн хэм хэмжээний актууд, ОХУ-ын Ерөнхийлөгчийн болон ОХУ-ын Засгийн газрын шийдвэрүүд хамаарна.

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-д мөрдөн шалгах ажиллагааг дараах багц хуулиудаар зохицуулж байна:

- Үндэсний тагнуулын албаны тухай хууль (National Intelligence Service Act);
- Цэргийн гэмт хэргийн тухай хууль (Military Criminal Act);
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль (National Security Act);
- Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөн шалгах албаны тухай хууль (Corruption Investigation Office for High-Ranking Officials Act);
- Прокурорын байгууллагын тухай хууль (Prosecutor's Office Act);
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Criminal Procedure Act).

Бүгд Найрамдах Турк Улс (БНТУ)-ын тагнуулын мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилтай холбоотой харилцааг дараах хуулиудаар зохицуулж байна:

- Тагнуулын байгууллагын тухай 3201 дүгээр хууль (Emniyet teşkilat kanunu);
- Цагдаагийн байгууллагын үүрэг, хариуцлагын тухай 2559 дүгээр хууль (Polis vazife ve salâhiyet kanunu);
- Төрийн тагнуулын байгууллагын үйлчилгээ ба Үндэсний тагнуулын байгууллагын тухай 2937 дугаар хууль (Devlet İstihbarat Hizmetleri ve Milli İstihbarat Teşkilatı Kanunu);
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 5271 дүгээр хууль (Ceza muhakemesi kanunu);
- Эрүүгийн 5237 дугаар хууль (Türk ceza kanunu).

Монгол Улсад гүйцэтгэх ажлыг тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон авлигатай тэмцэх байгууллагууд явуулах ба эдгээр байгууллагуудын гүйцэтгэх ажил явуулах нийтлэг үндэслэл, гүйцэтгэх ажлын зарчим, арга хэрэгсэл, гүйцэтгэх ажил явуулах нийтлэг журам зэргийг Гүйцэтгэх ажлын тухай хуулиар зохицуулж байна.

Харин гүйцэтгэх байгууллагуудын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, гүйцэтгэх ажил явуулах хэрэг шалгах ажиллагааг дээрх байгууллагуудын эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулиудаар нарийвчлан зохицуулж байна. Үүнд:

- Тагнуулын байгууллагын тухай хууль (1999);
- Цагдаагийн албаны тухай хууль (1999);
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017);
- Авлигын эсрэг хууль (2006) зэрэг болно.

2. Гүйцэтгэх байгууллагуудаас гүйцэтгэх ажил явуулах зорилго:

Судалгаанаас үзэхэд, тагнуулын үйл ажиллагаа болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг мөрдөн шалгах хүрээнд хийгддэг **гүйцэтгэх ажил (нууц мөрдөн шалгах ажиллагаа, шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа)** гэсэн нэр томьёо нь үндэсний (нийгэм, төрийн) аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэнд, хүний (иргэний) эрх, эрх чөлөө, эд хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор хуулиар эрх олгосон төрийн байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглах ажиллагааг илэрхийлэх ба дараах чиглэлийн ажиллагаануудыг хамарч байна. Үүнд:

- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, түүнчлэн гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, бэлтгэсэн, эсхүл үйлдсэн этгээдийг олж тогтоох;
- хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс нуугдаж, эрүүгийн ялаас зайлсхийсэн, эсхүл сураггүй алга болсон хүмүүсийг эрэн сурвалжлах;
- төрийн, батлан хамгаалахын, эдийн засгийн, мэдээллийн болон байгаль орчны аюулгүй байдалд заналхийлж буй үйл явдал, үйлдэл (эс үйлдэхүй)-ийн талаар мэдээлэл олж авах үүргийг хэрэгжүүлнэ.

ОХУ-д шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа (ШЭСА)-г дараах эрх бүхий байгууллагууд өөр өөрийн зорилго, чиглэлийн дагуу явуулж байна:

1) **Дотоод хэргийн яам** хар тамхи, эдийн засгийн аюулгүй байдал ба авлигал, ачаа тээвэрт халдах гэмт хэрэг болон экстремизм буюу хэт туйлшралтай тэмцэх, шуурхай эрэн хайх, төрийн хамгаалалтад байгаа этгээдийн аюулгүй байдлыг хангах;

2) **Аюулгүй байдлын холбооны алба** чиг үүрэг нь хууль эрх зүй, зохион байгуулалт, аюулгүй байдал, шуурхай-эрэн сурвалжлах, техникийн болон бусад арга хэмжээний үндсэн дээр хийгддэг төрийн объектын аюулгүй байдлыг хангах;

3) **Аюулаас хамгаалах алба** нь тагнуулын болон террорист үйл ажиллагаа зохион байгуулсан, төрийн нууцыг задруулсан, эх орноосоо урвасан, хил зөрчсөн, мансууруулах болон бусад бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх зэрэг эрүүгийн хэрэг дээр мөрдөн байцаах ажиллагаа явуулах;

4) **Гаалийн алба** - хууль бус наймаатай тэмцэх болон гаалийн салбар дахь бусад гэмт хэрэгтэй тэмцэх, түүнчлэн өөрийн аюулгүй байдлыг хангах;

5) **Гадаад тагнуулын алба** - Ерөнхийлөгч, Холбооны Хурал, Засгийн газрыг улс төр, эдийн засаг, цэрэг-стратегийн, шинжлэх ухаан-техникийн болон байгаль орчны чиглэлээр шийдвэр гаргахад шаардлагатай тагнуулын мэдээллээр хангах;

6) **Холбооны шийтгэл гүйцэтгэх алба** - ялтан, засан хүмүүжүүлэх байгууллагын ажилтан болон бусад хүмүүсийн хувийн аюулгүй байдлыг хангах, хорих байгууллагад гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хорих ангиас оргон зайлсан, хорих ялаас зайлсхийсэн ялтныг эрэн сурвалжилна;

7) Батлан хамгаалах яамны **Гадаад тагнуулын байгууллагын шуурхай ажиллагааны хэлтэс** - зөвхөн тухайн гадаад тагнуулын байгууллагын аюулгүй байдлыг хангах зорилгоор, мөн дээр дурдсан байгууллагуудын бүрэн эрхэд хамаарахгүй бол ШЭСА явуулна.

БНСУ-д дараах эрх бүхий байгууллагууд мөрдөн байцаах ажиллагааг хэрэгжүүлнэ:

1) **Үндэсний тагнуулын алба** - үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл, энх тайван, дэг журам сахиулах, эрүүгийн хэрэг мөрдөн байцаах үндсэн чиг үүрэгтэйгээр Ерөнхийлөгчийн дэргэд ажиллана;

2) **Батлан хамгаалахын аюулгүй байдлын командлал** - цэргийн аюулгүй байдлыг хангах, цэргийн сөрөх тагнуул, цэргийн мэдээлэл цуглуулах, бэлтгэх, боловсруулах, мөн Цэргийн шүүхийн тухай хуульд заасан гэмт хэргүүдийг (§44) мөрдөн шалгана;

3) **Дээд прокурорын газар** - хууль ёс, дэг журмыг тогтоож хүний эрхийг хамгаалдаг үндэсний хууль сахиулах дээд байгууллага бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэх, гэмт хэргийг мөрдөн байцаах, мөрдөн байцаалтын ажиллагаанд шүүхийн цагдаагийн ажилтнууд (judicial police officer⁶⁷) -ыг чиглүүлэх, хяналт тавих, шүүхийн шийдвэрийн биелэлтийг удирдан чиглүүлнэ;

4) **Үндэсний цагдаагийн газрын** бүтцэд байдаг Үндэсний Мөрдөн байцаах алба нь мөрдөн байцаалтыг хариуцдаг Мөрдөн байцаалтын төлөвлөлт, зохицуулалтын товчоо, Шүүхийн шинжилгээний удирдлагын газар, Мөрдөн байцаах товчоо, Мөрдөх товчоо, Кибер мөрдөн байцаах товчоо, Үндэсний аюулгүй байдлын мөрдөн байцаах товчоотой,⁶⁸

⁶⁷ Шүүхийн цагдаагийн ажилтан (judicial police officer) нь Ерөнхий прокурор, эсхүл прокурорын аливаа байгууллагын даргын томилсон прокурорын байгууллагын VI зэргийн албан тушаалтнууд, VI - IX зэргийн ажилтнууд, хар тамхины хэргийн VII, IX зэргийн мөрдөн байцаагчид байх ба Эрүүгийн процессын тухай хуулийн 169 дүгээр зүйлд заасан журмын дагуу ажиллана.

⁶⁸ <https://www.police.go.kr/eng/knpa/org/org01.jsp>

5) **Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөх алба**⁶⁹ - төрийн өндөр албан тушаалтнууд тэдгээрийн гэр бүлийнхний үйлдсэн авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах өргөн эх мэдэлтэй хараат бус байгууллага юм.

БНТУ-д дараах эрх бүхий байгууллагууд гүйцэтгэх ажил хэрэгжүүлнэ:

1) Цагдаагийн ерөнхий газрын харьяа **Гүйцэтгэх ажиллагааны газар** нь тус улсын нутаг дэвсгэр, бүрэн бүтэн байдал, Үндсэн хуулийн байгууламж, аюулгүй байдлын талаар урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах, дэг журмыг сахиулах зорилгоор улсын хэмжээнд мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг;

2) **Үндэсний тагнуулын байгууллага** - тагнуулын үйл ажиллагааг нээлттэй болон хаалттай эх сурвалжаас иргэн, байгууллага болон орон нутгийн бусад байгууллагуудын талаарх мэдээллийг цуглуулж, тухайн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үнэлэх замаар дүгнэлт гаргана;

3) Цагдаагийн ерөнхий газрын харьяанд байгуулагдсан **Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах газар** нь гэмт хэргийн шинжтэйгээр олсон орлого, терроризмыг санхүүжүүлэх зэрэг эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хяналт, дүн шинжилгээ хийх, судлах, шалгах;

4) Цагдаагийн ерөнхий газрын **Мөрдөн шалгах хороо** - ирүүлсэн мэдэгдэл, гомдлыг үнэлэх, үр дүнгийн дагуу шаардлагатай арга хэмжээг авах зорилготой бөгөөд хүний эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг газар дээр нь мөрдөн шалгах үүрэгтэй.

Монгол Улсад гүйцэтгэх ажлыг дараах эрх бүхий байгууллагууд өөр өөрийн зорилго, чиглэлийн хүрээнд явуулж байна:

1) **Тагнуулын ерөнхий газар** - үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, аюул, занал, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор гадаад тагнуул, цэрэг-стратегийн болон хилийн тагнуул, сөрөх тагнуулын чиглэлээр;

2) **Цагдаагийн ерөнхий газар** - тагнуулын байгууллагад хамаарахаас бусад гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэмт этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, сураггүй алга болсон болон бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан эд зүйлийг эрж олох зэрэг зорилгоор;

3) **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар** - хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх, оргосон хоригдлыг баривчлах, бусад гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор;

4) **Авлигатай тэмцэх газар** - авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор.

3. Гүйцэтгэх ажлын явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах:

Гүйцэтгэх ажлын явцад түүнд оролцогчдын эрх, эрх чөлөөг хангах нь нэгдүгээрт, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах, хоёрдугаарт, гэмт хэрэгт холбогдогчдын эрх, эрх чөлөөг хязгаарлахдаа түүний Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хангах асуудал хамаарч байна.

⁶⁹ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=53133&lang=ENG

ОХУ-ын хувьд ШЭСА-нд Үндсэн хуулийг үндэслэж, ОХУ-ын хууль тогтоомж, олон улсын гэрээ, тэр дундаа Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц (Европейской конвенцией о защите прав человека и основных свобод)-ын дагуу **хүн ба иргэний эрх, эрх чөлөөг хамгаална**.

ШЭСА-нд хүний ба иргэний эрхийг хамгаалахыг бодитоор хангах гэдэг нь Үндсэн хуулиар тогтоосон дараах баталгаагаар хангах учиртай:

- шуурхай эрэн сурвалжлах байгууллагууд, тэдгээрийн албан тушаалтны үйлдэл, шийдвэрт гомдол гаргах боломжтой эсэх;
- шуурхай эрэн сурвалжлах байгууллагаас мэдээлэл авах боломжтой эсэх;
- ШЭСА-нд хөндлөнгийн (салбарын бус) хяналт, түүний дотор шүүхийн хяналт байгаа эсэх;
- ШЭСА-нд прокурорын хяналт тавих;
- хүн бүр хууль зүйн мэргэшсэн туслалцаа авах эрхтэй байх.

ШЭСА-нд Үндсэн хуулиар олгогдсон **хүний ба иргэний тодорхой зарим эрхийг хязгаарлах** нь ШЭСА-ны тухай хуульд заасан журмын дагуу, шүүхийн шийдвэрийн үндсэн дээр хэрэгжинэ. Үндсэн хуулиар олгогдсон хүний ба иргэний тодорхой зарим эрхийг хязгаарлах нь төрөөс гэмт хэрэгт нөлөөлөх нэн шаардлагатай, хууль ёсны арга хэрэгсэл юм.

ШЭСА-нд хязгаарлаж болох эрхийн хүрээг Үндсэн хуульд тодорхой заасан байдаг. Хууль ёсны үндэслэл байгаа бол Үндсэн хуулиар олгогдсон дараах эрхийг хязгаарлаж болно:

- хувийн амьдрал, хувийн болон гэр бүлийн нууцад халдашгүй байдал, нэр төр, сайн нэрийг хамгаалах;
- захидал харилцаа, утасны яриа, шуудан, телеграф болон бусад харилцаа холбооны нууцлал;
- орон сууцны халдашгүй байдал;
- мэдээлэл чөлөөтэй хайх, авах, дамжуулах, бэлтгэх, түгээх;
- хувийн өмчтэй байх, түүнийг ашиглах, захиран зарцуулах.

ШЭСА-нд хүний ба иргэний эрхийг хязгаарлахыг зөвхөн ШЭСА-ны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үндэслэлээр зөвшөөрнө. Үндэслэл нь нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдэж болзошгүй байх, эсхүл бодитой үйлдсэн байхыг шаардана.

БНСУ-ын Хүний эрхийн үндэсний комисс нь тус улсын үндэсний хууль тогтоомж, нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцод заасан хүний эрх, нэр төр, эрх чөлөөг өргөн хүрээнд хангахаар ажилладаг.

Тус комисс нь гэмт хэргийг мөрдөн шалгах хүрээнд хүний эрхийг зөрчсөн хэргүүдийг шалгаж, арга хэмжээ авах боломжоор хангах, хүний эрхийн боловсролыг түгээх, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, Олон улсын хүний эрхийн гэрээний хэрэгжилтийг сурталчлах, хяналт тавих, төрийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, НҮБ-ын хүний эрхийн байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллагуудтай (APF, ICC) хамтран ажиллах, хүний эрхийг хамгаалах, дэмжихэд шаардлагатай гэж үзсэн бусад чиг үүргийг гүйцэтгэдэг.

Монгол Улсын Үндсэн хуульд “хуульд заасан үндэслэл журмаас гадуур иргэний эрх, эрх чөлөөг нь хязгаарлах”-ыг хориглож “иргэний хувийн болон гэр бүлийн нууц, халдашгүй байдал”⁷⁰-ыг хангаж өгсөн байдаг. Мөн хүн бүхэн “үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулахгүй”-гээр эрх, эрх чөлөөгөө

⁷⁰ Монгол Улсын Үндсэн хууль, 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэг: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

эдлэх ёстой хэмээн хуульчилсан боловч зөвхөн **“хуульд заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд эрх, эрх чөлөөг нь түр хязгаарлах”** эрх зүйн зохицуулалтыг мөн адил суулгаж өгсөн байна.

Гүйцэтгэх ажлын хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой эрх зүйн харилцааны бас нэгэн шүүмжлэл дагуулдаг сэдэв бол мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг журмаар зохицуулж байгаа явдал юм. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7-ын 6 дахь хэсэгт “мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам зааврыг Тагнуулын ерөнхий газрын дарга Улсын ерөнхий прокурортой хамтран батална” гэж зааснаас үзэхэд хүний эрх, эрх чөлөөнд халдах, хязгаарлахтай холбоотой үйл явц нь Засгийн газрын 2 агентлагийн даргын хамтран баталсан журмаар зохицуулагдаж байгаагаас хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, түүнд тавих хяналтын механизмыг сулруулах эрсдэлтэй гэж үзэж болохоор байна.

Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагууд нь иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлахад хүргэх гүйцэтгэх ажлын аливаа арга хэмжээг зохион байгуулахдаа дараах асуудлуудыг анхаарч ажиллах нь зүйтэй гэж судлаачид үздэг. Үүнд:

- түүнийг зохион байгуулах зайлшгүй шаардлага байгаа эсэх;
- хууль, эрх зүйн үндэслэл байгаа эсэх;
- гарч болох үр дүнг бодитой тооцсон эсэх зэргээс гадна тухайн арга хэмжээг зохион байгуулах явцад хүний эрх, эрх чөлөөнд халдаж байгаа гэдгээ ухамсарлаж, оновчтой шийдвэр гаргах нь чухал гэж үздэг.

Хэрэв тийм арга хэмжээг зохион байгуулах зайлшгүй шаардлага, хууль зүйн үндэслэл байна гэж үзвэл холбогдох хууль, журмын дагуу **“аль болох богино хугацаанд хэрэгжүүлэх”**-ийг эрмэлзэх нь чухал юм. Гэвч гүйцэтгэх ажлыг зохион байгуулах цар хүрээ, нөхцөл байдал, онцлогоос шалтгаалан үргэлжлэх хугацааны хувьд харилцан адилгүй байдаг. Тухайлбал, Тагнуулын байгууллагаас явуулж байгаа гүйцэтгэх ажлын хувьд зорилго, төсөв, цар хүрээ, технологи, нөхцөл байдал зэргээс шалтгаалан урт хугацаанд зохион байгуулах шаардлага үүсдэг бөгөөд бусад эрх бүхий байгууллагуудаас ихээхэн ялгаатай байдаг.

Хууль тогтоомжуудад хамгийн гол нь гүйцэтгэх ажлын явцад хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчим баримтлахыг заасан байна. Тухайлбал: **Тагнуулын байгууллагын тухай хуульд** Тагнуулын байгууллага нь үйл ажиллагаандаа хүний эрх, эрх чөлөөг хангах зарчмыг удирдлага болгоно гэж заасан бөгөөд Тагнуулын ажилтанд тавих ёс зүйн тусгай шаардлагад хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах эрхийг нь хязгаарлахаар заасан.

Тухайлбал, **Цагдаагийн албаны тухай хуульд** Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн⁷¹ ажиллаж аливаа хэлбэрээр ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалан зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авна;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн аливаа байдлаар ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно гэж тус тус зааж өгсөн байна.

Авлигын эсрэг хуульд үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хараат бус, ил тод байх, нууцыг чанд сахих зарчмыг баримталж ажиллахаар хуульчилж хүний эрх, эрх чөлөөг

⁷¹ Цагдаагийн албаны тухай хууль, 22 дугаар зүйл. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага: <https://legalinfo.mn/mn/detail/12469>

хангахтай холбоотой асуудлыг нарийвчлан тусгаагүй ч хувь хүний нууцийг хамгаалахтай холбоотой зохих заалтуудыг суулгаж өгчээ.

Түүнчлэн гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны улмаас эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа хувь хүн, хуулийн этгээд нь зохих дээд шатны байгууллага, албан тушаалтан, прокурорт гомдол гаргах эрхтэй, цаашлаад эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг нь хохироосон бол тухайн этгээдийн зөрчигдсөн эрхийг нь сэргээж, учирсан хохирлыг арилгах арга хэмжээг авах хэлбэрээр гүйцэтгэх ажлын явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалахаар Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 7 дугаар зүйлд тусгасан байна.

Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагууд тусгай арга хэрэгслийн тусламжтайгаар мэдээлэл цуглуулах явцад объектын хувийн нууцад халдаад зогсохгүй, мөрдлөгийн объект биш хэдий ч тухайн этгээдтэй харилцсан бүх хүний эрхэнд мөн адил халдаж байдаг. Мөн объект болон түүнтэй харьцсан хүмүүсийн талаар тусгай арга хэрэгсэл ашиглан цуглуулсан хувийн мэдээллийг эрх бүхий байгууллага хуулан авч, тухайн мөрдөн шалгах ажиллагааны хугацаа дууссан ч устгалгүй хадгалах, улмаар өөр зорилгоор ашиглах тохиолдол байж болзошгүй юм. Энэ тохиолдолд иргэн өөрийн эрх, эрх чөлөөнд хуулийн дагуу эсхүл хууль бусаар халдаж байгааг мэдэх боломжгүй юм.

Тиймээс эрх бүхий байгууллагад хандаж зөрчигдсөн эрх, эрх чөлөөгөө сэргээхтэй холбоотой өргөдөл, гомдол гаргах үйл явц нь хүний эрх, эрх чөлөөг зөрчигдсөний дараа авах арга хэмжээний тухай буюу зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг арилгахтай холбоотой зохицуулалт юм.

Дээр дурдсан хуулиудаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой зарчмыг Тагнуулын байгууллагын тухай хуульд “хүний эрх, эрх чөлөөг хангах” гэж үйл ажиллагааны үндсэн зарчимдаа тусгаж өгсөн бол Гүйцэтгэх ажлын тухай, Цагдаагийн албаны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудын үндсэн зарчимд “хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх” гэж тусгаж өгчээ.

Я.Цэвэлийн тайлбар тольд “хангах” гэж “ханахын үйлдүүлэх хэв” гэж тайлбарласан бол “хүндэтгэх” гэж “эрхэм чухал болгож хичээнгүйлэн хүндэлж үзэх”, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газраас гаргасан Монгол хэлний их тайлбар тольд “хангах” гэж “эрэлт хэрэгцээ, хүсэл шаардлагыг биелүүлэх” гэсэн бол “хүндэтгэх” гэж “эрхэм чухал болгож хичээнгүйлэн хүндэлж үзэх” хэмээн мөн адил тайлбарласан байна.

АНУ-ын хүний эрхийн шүүхийн тайлбарт “Хүний эрх гэдэг бол хүний нэр төрийн салшгүй нэг хэсэг гэдэг бодит байдлаас үүссэн бөгөөд төрийн эрх хэмжээнээс дээгүүр байх, төрийн байгууллага эрхээ хэрэгжүүлэхдээ тодорхой хязгаарлалтад байхыг хэлнэ” гэжээ.

Үндэсний аюулгүй байдал нь хамгийн онцгой чухал нөхцөлд ч гэсэн ардчиллын суурь зарчим болох эрх дээдлэх зарчмыг зөрчих шалтгаан болох учиргүй гэж үздэг.

4. Гүйцэтгэх ажлын хяналт:

Судалгаанд авагдсан гадаадын болон Монгол Улсад тагнуулын үйл ажиллагаа болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг мөрдөн шалгах хүрээнд хийгддэг гүйцэтгэх ажил (нууц мөрдөн шалгах ажиллагаа, шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа)-нд тавих хяналтыг гүйцэтгэх засаглалаас гадна Парламент болон түүний хяналтын хороод, Ерөнхий хянан шалгагч, Хөндлөнгийн хяналтын мэргэшсэн бүтэц, прокурор, шүүх хэрэгжүүлж байна.

ОХУ-д ШЭСА-нд тавих хяналт нь ШЭСА хэрэгжүүлэгч байгууллага, тэдгээрийн албан тушаалтнуудын үйл ажиллагаа Үндсэн хууль, ШЭСА-ны хууль тогтоомжоор тогтоосон зорилго, зорилт, зарчим, дүрэмд нийцэж байгаа эсэхийг хянах тогтолцоо юм. Энэхүү

хяналтын эцсийн зорилго нь ШЭСА-нд тогтоосон хэм хэмжээг мөрдөөгүйг мэдээлэх явдал бөгөөд шаардлагатай бол ШЭСА хэрэгжүүлэгч байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагааг зохицуулах, үр дүнтэй ажиллахад нь саадыг арилгах юм.

Төрийн зүгээс тавих хөндлөнгийн хяналтыг **Ерөнхийлөгч, Холбооны Хурал, Засгийн газар** өөрийн бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ. Мөн **прокурорын хяналтыг** ОХУ-ын Ерөнхий прокурор болон эрх бүхий прокурорууд хэрэгжүүлэх ба тэд гомдол хянан үзэх, хувь хүний эрхийг сэргээх арга хэмжээ авах, холбогдох шийдвэрийн хууль ёсны байдлыг шалгах, гэмт хэргийн тухай болон сураггүй алга болсон этгээдийн тухай мэдүүлэг, мэдээг хүлээн авах, бүртгэх, шалгахад тавигдах шаардлагуудын биелэлтийг хянах зэрэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Харин **шүүхийн хяналт** - ШЭСА-ны явцад Үндсэн хуулиар олгогдсон иргэдийн эрхийг хязгаарласан тухай бүх материал (захидал харилцаа, утасны яриа, цахилгаан болон шуудангаар дамжиж байгаа шуудан, телеграф болон бусад харилцааны нууцлал, гэр орны халдашгүй байдал гэх мэт)-ыг шүүгч хянаж.

ОХУ-д ШЭСА-ны санхүүжилтийн зарцуулалтын шалгалтыг **Сангийн яам тусгайлан томилогдсон эрх бүхий төлөөлөгч**өөрөө дамжуулан хийдэг онцлогтой байна.

Мөн гадаадын зарим улсад тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд тавих дараах хяналтын үндсэн хэлбэрийг өргөн хэрэглэж байна:

- 1) Парламентын хяналтын хороо;
- 2) Ерөнхий хянан шалгагч;
- 3) Хөндлөнгийн хяналтын мэргэшсэн бүтэц.

1) Парламентын хяналтын хороо: Конгрессын болон парламентын хяналтын бусад хэлбэр гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваагддаг.

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын **Конгрессын хяналтын хороо:** Конгрессын хоёр танхимд байнгын ажиллагаатай тагнуулын хороо байдаг. Хороодын үндсэн үүрэг нь АНУ-ын тагнуулын бүхий л албан ёсны үйл ажиллагааг хянаж, хууль ёсны дагуу үр дүнтэй явагдаж байгаа эсэхийг авч үздэг.

Парламентын хяналтын бусад хороо: Дээрх Конгрессын хяналтаас ялгаатай төдийгүй, өөр хоорондоо ч харилцан адилгүй байдаг. Ингэхдээ нууц мэдээлэлтэй танилцах эрх, боловсон хүчин болон бусад нөөц бололцооны хүртээмж, хяналтын хорооны эрх мэдэл, гишүүдийн томилгоо зэргээрээ голлон ялгардаг байна.

Парламентаас тагнуулын хяналтыг хэрэгжүүлж буй таван хэлбэр байдаг. Үүнд:

• **Нууц мэдээлэлтэй танилцах эрхгүй парламентын хороо** (Канад, Ирланд зэрэг) - Парламентын хороодын нууц мэдээлэлтэй танилцах нөхцөлийг хангах тусгай зохицуулалт хийдэггүй бөгөөд нууц мэдээ, мэдээлэлтэй харьцах эрх бүхий албан тушаалтан парламентын гишүүдэд мэдээллийг задалсан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээнэ. Тиймээс эдгээр ардчилсан орны Парламентын хороод тагнуулын үйл ажиллагааны талаарх аливаа “дотоод” мэдээлэлгүйгээр ажиллах шаардлагатай болдог байна;

• **Ерөнхий сайдаас байгуулсан парламентын гишүүдээс бүрдсэн (тагнуулын хяналтын) Хууль зүйн хороо** (Их Британи) нь Парламентын хороодын эдэлдэг хянан шалгах эрх мэдлийг эдэлдэггүй, харин Парламентын бусад нөөц бололцоог дайчлах болон бусад давуу эрх байдаггүй байна. Нэг үгээр хэлбэл, энэ нь Парламентын хороо бус харин Парламентын гишүүдээс бүрдсэн хороо юм. Хорооны гол давуу тал нь нууцын баталгаа гаргасан ажилтнуудтай нууц хүрээнд, нууц байдалд үйл ажиллагаагаа явуулдаг;

• **Парламентаас байгуулсан (тагнуулын хяналтын) Хууль зүйн байнгын хороо** (Австрали) - Парламентын аль ч танхим тагнуулын голлох байгууллагуудтай холбоотой аливаа асуудлыг тус хороонд шалгуулахаар өгөх эрхийг хуулийн дагуу эдэлдэг;

• **Тагнуулын хуулийн хяналтын тусгай хороо** (Канад) - Аюулгүй байдлын тагнуулын албаны тухай, Аюулгүй байдлын гэмт хэргийн тухай хуулийг хянан үзэх (түр) хороо нь хуулийн зүйл заалт, үйлчлэлийг хянан үзэж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийн талаарх санал зөвлөмж гаргана;

• **Холимог хороо** - Швед Улсын Аюулгүй байдал болон нэгдмэл байдлыг хамгаалах хороо нь гэмт хэрэгтэй тэмцэх албадын зүгээс нууц ажиглалт, халхавч нэр болон холбогдох бусад тусгай арга хэрэгслийн ашиглалтыг хянах; Аюулгүй байдлын албаны зүгээс хувь хүний мэдээллийг хэрхэн ашиглаж байгаад хяналт тавих гэсэн хоёр үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг.

Дээрх үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж буйг нягтлах, хянан шалгах ажиллагаа явуулах замаар чиг үүргээ гүйцэтгэдэг байна.

2) Ерөнхий хянан шалгагч (ЕХШ): АНУ, Канад, Австрали зэрэг орнуудын хүрээнд авч үзсэн.

АНУ-ын Тагнуулын төв газрын ЕХШ нь байгууллагын дотоод санхүүгийн хэмнэлт, үр ашигт байдал, ажлын үр дүн, хариуцлагатай байдлыг сайжруулах болон шамшигдуулах, үр ашиггүй байдал, эрх мэдлээ урвуулан ашиглах үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох үндсэн үүрэгтэй. ЕХШ нь Тагнуулын төв газрын хөтөлбөр, үйл ажиллагаанд бие даасан аудит, хянан шалгалт явуулдаг. Үр дүнгээ Тагнуулын төв газрын захирал болон Конгрессын дээд, доод танхимын тагнуулын асуудал эрхэлсэн хороодод тайлагнаж, хууль зөрчсөн үйлдэл гарсан гэж үзэх үндэслэлтэй тохиолдолд Нэгдсэн Улсын Ерөнхий прокурорт давхар мэдэгддэг байна.

Канад Улсын Аюулгүй байдлын тагнуулын албаны ЕХШ-ийн үндсэн үүрэг нь тус албаны үйл ажиллагаа тус улсын хууль тогтоомж, дүрэм журам, бодлогод нийцэж буй эсэхэд анхаарч ажиллах юм. ЕХШ нь жил бүр Аюулгүй байдлын тагнуулын албаны захирлаас холбогдох сайдад илгээх үйл ажиллагааны тайланг хянан үзэж, Аюулгүй байдлын тагнуулын албаны тухай хууль болон тухайн сайдаас гаргасан тушаал, зааврыг зөрчсөн эсэхийг хянан баталгаажуулна. Түүнчлэн эрх мэдлээ хэтрүүлсэн буюу шаардлагагүй үед хэрэглэсэн аливаа үйл ажиллагааг тогтоох үүрэгтэй.

Австрали Улсын Тагнуул, аюулгүй байдал (ТАБ)-ын ЕХШ-ийн албан тушаал нь хуульчлагдсан байдлаараа АНУ, Канад улсынхтай төстэй. ЕХШ-ийн эрх нь харьцангуй өргөн цар хүрээтэй буюу Австралийн тагнуулын нийгэмлэгийг бүхэлд нь хамардаг байна. ЕХШ-ийн гүйцэтгэх чиг үүргийг нь дараах дөрвөн хэлбэрт ангилж болно. Үүнд:

- тагнуулын алба тус бүрийн үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж, дүрэм журмын биелэлтийг хянах;
- үйл ажиллагааны зүй зохист байдлыг үнэлэх;
- үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлэх;
- үйл ажиллагаа нь хүний эрхийг зөрчсөн эсэхийг тогтоох зэрэг.

3) Хөндлөнгийн хяналтын мэргэшсэн бүтцийн жишээ болгон **Канад Улсын** Аюулгүй байдлын тагнуулын хяналтын хороо болон Харилцаа холбооны аюулгүй байдлын албаны комиссарын талаар судалсан.

Тус улсад хяналтын хоёр байгууллага байдаг нь Аюулгүй байдлын тагнуулын хяналтын хороо (АБТХХ) болон Харилцаа холбооны аюулгүй байдлын албаны комиссар (Комиссар) юм.

АБТХХ нь хараат бусаар ажилладаг бөгөөд Хатан хааны дээд зөвлөлийн гишүүнээр ажиллаж, нууцын тангараг өргөсөн тав хүртэлх тооны гишүүнтэй байх ба парламентын гишүүн байх ёсгүй.

АБТХХ нь ЕХШ-ийн тайланг хүлээн авахаас гадна өөрөө Аюулгүй байдлын тагнуулын албаны үйл ажиллагаанд хяналт тавина. Тухайлбал, тус албатай холбогдуулан гаргасан өргөдөл гомдлын мөрөөр хянан шалгах ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд АБТХХ нь Аюулгүй байдлын тагнуулын албаны ЕХШ-д, эсхүл Аюулгүй байдлын тагнуулын албанд өөрт нь тодорхой үйл ажиллагааны мөрөөр хянан шалгах ажиллагаа явуулахыг даалгах эрхтэй.

Канад Улсын хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянах хязгаарлагдмал эрх мэдлийг Комиссарт өгсөн байна. Түүнээс гадна тэрээр тус албатай холбоотой гомдол хүлээж авах эрхтэй байдаг.

Монгол Улсад эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын гүйцэтгэх ажилд дараах байдлаар хяналт тавина:

- Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай танилцана;
- УИХ, Засгийн газар шаардлагатай гэж үзвэл өөрийн бүтэц дэх зохих нэгж, албан тушаалтнаар дамжуулан гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина;
- гүйцэтгэх байгууллагын дарга нь гүйцэтгэх ажилд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлнэ;
- прокурорын хяналт.

Гүйцэтгэх байгууллагуудын дарга нар тухайн байгууллагынхаа гүйцэтгэх ажил явуулах хүрээнд дотоод хяналтыг тавьж ажилладаг бол Гүйцэтгэх ажлын тухай хуульд зааснаар гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналтыг Улсын Ерөнхий прокурор, түүний тусгайлан эрх олгосон прокурор дараах байдлаар нууцаар сонсох, харах тусгай техник хэрэгсэл ашиглаж хэрэгжүүлнэ.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ХЭЛБЭР

(Зарим орны туршлагаас)

Сэдвийн хүрээнд гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын хуульд заасан чиг үүргийн дагуу гүйцэтгэх ажлын зохион байгуулалт, түүнийг хэрхэн хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг судлах ёстой боловч үүний цаана гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой асуудал хөндөгдөж байна. Гадаадын улс орнуудын хувьд энэ талаарх мэдээлэл хязгаарлагдмал байх тул ардчилсан орнуудад өргөн хэрэглэгддэг Тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын хэлбэр, чиг хандлагыг дараах түвшинд дэлгэрүүлэн авч үзсэн болно. Үүнд:

- 1) Парламентын хяналтын хороо;
- 2) Ерөнхий хянан шалгагч;
- 3) Хөндлөнгийн хяналтын мэргэшсэн бүтэц

1.1. Парламентын хяналтын хороо:

Гадаадын улс орнуудад тухайлбал, АНУ-ын Конгресс болон парламентын ардчилал бүхий орнуудын хууль тогтоох байгууллагын хяналтын хороодоос тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт, зарим ялгааг энд оруулахыг хичээлээ.

Эрх мэдлийн хяналт-тэнцэл буюу төрийн эрх мэдлийн салаа бүрд харилцан хяналт тавих зарчмыг чухалчлан үздэг АНУ зэрэг орнуудад парламентын хороодын хуралдаанаар мэдээлэл, сонсгол хийхэд хэлэлцэх асуудлуудыг тогтоох эрхийг Конгресс дангаараа эдэлдэг. АНУ-ын Конгрессын хороод гүйцэтгэх засаглалын ахлах албан тушаалтан, тэр дундаа тагнуулын албадын удирдлагыг дуудан ирүүлж мэдүүлэг авах эрхтэй бөгөөд тэдгээр албан тушаалтнууд нь бодлого, үйл ажиллагааны талаарх асуултуудад бүрэн бүтэн, үнэн зөв, хариулт өгөх үүрэг хүлээдэг.

Гэвч парламентын тогтолцоотой ихэнх улс оронд эрх баригч улс төрийн хүчин Парламент дахь олонхын бүлгийг хянадаг учир нууц мэдээллийн чухам аль хэсгийг Парламентад өгөх тухай эцсийн шийдийг гүйцэтгэх засаглал гаргадаг байна. Түүнээс гадна Парламентын хорооны сонсголд ямар албан тушаалтан оролцож, ямар сэдвийн хүрээнд хариулт өгөх вэ? гэдэгт зарчмын томоохон ялгаа бий. Парламентын засаглал бүхий зарим оронд гүйцэтгэх засаглалын сонгуульт албан тушаалтнууд Парламентын хороодод бодлогын асуудлаар мэдээлэл өгч, асуултад хариулдаг бол зарим улсад албан тушаалтнууд хүрэлцэн ирэх, асуултад хариулах эсэх нь тэдний өөрсдийн хүсэл зоригийн асуудал байдаг байна.

АНУ-ын Конгрессын хяналт:

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Төлөөлөгчийн танхим болон Сенатын аль алинд нь байнгын ажиллагаатай тагнуулын хороо байдаг. Эдгээр хороодын үндсэн үүрэг нь АНУ-ын тагнуулын бүхий л албан ёсны үйл ажиллагааг хянаж, хууль ёсны дагуу үр дүнтэй явагдаж байгаа эсэхийг авч үздэг. Эдгээр хороод өндөр хамгаалалт бүхий байршилд хуралддаг бөгөөд урьдчилсан хяналтад хамрагдсан, өндөр мэргэжилтэй ажлын албатай байх ба хороод нь үйл явдлын өмнө, хойно болон явцын дунд хяналт тавих эрх, нөөц бололцоогоор хангагдсан байдаг. Хорооны ажлын албаны ажилтнуудыг эрх баригч болон сөрөг хүчнээс томилох бөгөөд тус тусын намын гишүүдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлдэг байна.

Парламентын хяналтын бусад хороо:

Парламентын тагнуулын хяналт нь хэлбэрийн хувьд Конгрессын хяналтаас ялгаатай төдийгүй өөр хоорондоо харилцан адилгүй байдаг. Ингэхдээ нууц мэдээлэлтэй танилцах эрх, боловсон хүчин болон бусад нөөц бололцооны хүртээмж, хяналтын хорооны эрх мэдэл, гишүүдийн томилоо зэргээрээ голдуу ялгаатай байна.

Парламентын түвшинд тагнуулын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлж буй бүтцийн 5 хэлбэр байна. Үүнд:

- нууц мэдээлэлтэй танилцах эрхгүй парламентын хороо (parliamentary committees outside the secrecy loop);
- Ерөнхий сайдаас байгуулсан парламентын гишүүдээс бүрдсэн (тагнуулын хяналтын) Хууль зүйн хороо (statutory committees of parliamentarians);
- Парламентаас байгуулсан (тагнуулын хяналтын) Хууль зүйн байнгын хороо (statutory committees of parliamentarians);
- тагнуулын хуулийн хяналтын тусгай хороо (special statutory review committees);
- холимог хороо (blended committees).

- Нууц мэдээлэлтэй танилцах эрхгүй парламентын хороо:

Парламентын ардчилал бүхий зарим оронд (Канад, Ирланд зэрэг) гүйцэтгэх засаглалаас Парламентын хороодын нууц мэдээлэлтэй танилцах нөхцөлийг хангах тусгай зохицуулалт хийдэггүй бөгөөд нууц мэдээ, мэдээлэлтэй харьцах эрх бүхий албан тушаалтан парламентын гишүүдэд мэдээллийг задалсан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээнэ. Тиймээс эдгээр ардчилсан орны Парламентын хороод тагнуулын үйл ажиллагааны талаар

аливаа “дотоод” мэдээлэлгүйгээр ажиллах шаардлагатай болдог байна. Гэхдээ тэдгээр хороодод парламентын хянан шалгах бүрэн эрх, нөөц бололцоо байдаг бөгөөд чухал асуудлуудад хяналт тавьж, засгийн газрын анхаарлыг хандуулах боломжтой.

- Ерөнхий сайдаас байгуулсан парламентын гишүүдээс бүрдсэн (тагнуулын хяналтын) Хууль зүйн хороо:

Их Британи Улсад парламентын гишүүдээс бүрдсэн хууль зүйн хороо ажилладаг. Их Британийн Тагнуул, аюулгүй байдлын хороо (Intelligence and Security Committee) нь парламентын үндсэн эрх, үүрэг гэхээс илүүтэй хуульд заасан тусгай үүрэгтэй байгуулагддаг. Парламентын хорооны гишүүдийг улс төрийн намуудын төлөөллөөс сонгодог бол энэхүү хороог Ерөнхий сайд өөрөө парламентын доод танхим болох Нийтийн танхим болон дээд танхим болох Лордын танхимын гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулах бөгөөд хороо нь Ерөнхий сайдад ажлаа тайлагнах үүрэгтэй. Уг хороо нь парламентын хороодын эдэлдэг хянан шалгах эрх мэдэл болон парламентын бусад нөөц бололцоог дайчлах бусад давуу эрх эдэлдэггүй байна. Нэг үгээр хэлбэл, энэ нь парламентын ердийн хороо бус харин Ерөнхий сайдын байгуулсан парламентын гишүүдээс бүрдсэн тусгай чиг үүрэг бүхий хороо юм.

Тус хорооны гол онцлог нууцын баталгаа гаргасан гишүүд, ажилтнуудын хүрээнд нууц мэдээлэлтэй харьцаж, нууц байдалд үйл ажиллагаагаа явуулдаг. Түүнчлэн Лордын танхимаас сонгогдсон хорооны гишүүдийг дахин сольж өөрчилдөггүй тул залгамж чанар хадгалагдах, байгууллагын ой санамж тасралтгүй хөгжих боломжтой, албан ёсны эрх хэмжээ нь тагнуулын албадын зардал, удирдлага, бодлогын хүрээгээр хязгаарлагдах бөгөөд тус хорооны хянан шалгах ажиллагаа явуулах нөөц бололцоо мөн адил хязгаарлагдмал байдаг байна. Хорооны эрх мэдэл нь хангалттай хэмжээнд хуульчлагдаагүйгээс хяналтын үйл ажиллагааг тасралтгүй явуулах боломж сул байдаг байна.

- Парламентаас байгуулсан (тагнуулын хяналтын) Хууль зүйн байнгын хороо:

Тагнуулын асуудал хариуцсан Парламентын Хууль зүйн байнгын хорооны гишүүдийг улс төрийн намууд томилох бөгөөд парламентын нөөц бололцоог шаардлагатай хэмжээгээр ашиглах боломжтой байдаг.

Ерөнхий сайдаас байгуулсан тус хорооны ажилтнууд гүйцэтгэх засаглалын өмнө үүрэг хүлээдэг бол Парламентаас байгуулсан байнгын хороо нь хэнийг авч ажиллуулах (нууцын баталгаатай байх), хаана уулзах (уулзалтын байрны аюулгүй байдлыг хангасан байх) зэрэг үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргах эрхтэй.

Австрали Улсад уг хорооны бүрэлдэхүүнд Холбооны улсын парламентын дээд, доод танхимын аль алиных нь төлөөлөл орсон байдаг. Холбогдох хууль тогтоомжоор уг хороо эрх хэмжээнийхээ хүрээнд ямар байгууллагыг хянах ёстойг тодорхойлж өгсөн байдаг бөгөөд улсынхаа тагнуулын голлох бүх байгууллагыг хянах эрхтэй байдаг.

Парламентын байнгын хороо нь өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, нэн ялангуяа баримт бичиг, мэдээлэл гаргаж өгөх үүргийг биелүүлээгүй этгээдэд хариуцлага тооцох эрхтэй бөгөөд Австрали Улсын Парламентын аль ч танхим тагнуулын голлох байгууллагуудтай холбоотой аливаа асуудлыг Хууль зүйн байнгын хороонд шалгуулахаар өгөх эрхийг хуулийн дагуу эдэлдэг.⁷²

⁷² Ireland, Garda Síochána Act 2005, No. 20 of 2005, Section 67.

- *Тагнуулын хуулийн хэрэгжилтийн хяналтын тусгай хороо:*

1984 онд баталсан Канад Улсын Аюулгүй байдлын тагнуулын албаны тухай хууль (Security Intelligence Service Act) болон Аюулгүй байдлын гэмт хэргийн тухай хууль (Security Offences Act) хэрэгжиж эхэлснээс хойш таван жилийн дараа эдгээр хуулийг хянан үзэх хороо байгуулах үүргийг Парламентад хүлээлгэсэн байдаг.⁷³ 2001 онд батлагдсан тус улсын Терроризмтой тэмцэх тухай хуулийн (Anti-Terrorism Act) дагуу уг хуулийг хянан үзэх хороог гурван жилийн дараа байгуулахыг Парламентад даалгасан байна.⁷⁴ Парламентын хороо нь хуулийн зүйл заалт, үйлчлэлийг хянан үзэж, нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой санал зөвлөмжөө тайланд тусгах үүрэгтэй. Түр хорооны шинжтэй эдгээр хороод нь нэг жилийн хугацаатай байгуулагдаж, тайлан гаргасан байна.

- *Аюулгүй байдал болон нэгдмэл байдлыг хамгаалах хороо:*

Швед Улсын Аюулгүй байдал болон нэгдмэл байдлыг хамгаалах хороо (Commission on Security and Integrity Protection)-ны (АБНБХХ) дарга болон дэд даргаар өмнө нь шүүгчээр ажиллаж байсан, эсхүл хуулийн чиглэлээр туршлагатай хүнийг томилдог байна. Хорооны бусад гишүүдийг тус улсын Парламент (Риксдаг) дахь намын бүлгүүдээс санал болгосон нэр дэвшигчдийн дундаас томилох ба тэд заавал Парламентын гишүүн байх албагүй байдаг.

АБНБХХ нь:

- гэмт хэрэгтэй тэмцэх албадын зүгээс **нууц ажиглалт, халхавч нэр болон холбогдох бусад тусгай арга хэрэгслийг хэрхэн ашиглаж байгааг хянах;**
- Швед Улсын Аюулгүй байдлын албаны зүгээс **хувь хүний мэдээллийг хэрхэн ашиглаж байгаад хяналт тавих** гэсэн хоёр үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг.

Тус хороо нь дээрх үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж буйг нягтлах, хянан шалгах ажиллагаа явуулах замаар чиг үүргээ гүйцэтгэдэг байна.

АБНБХХ-ны үйл ажиллагаанд туслах үүрэг бүхий Ажлын албыг Засгийн газраас томилогдсон дарга удирдах бөгөөд хуулиар хорооны хяналтад хамаарах байгууллагуудаас мэдээлэл, мэргэжлийн туслалцаа авах эрх мэдлийг олгосон байна. Түүнчлэн АБНБХХ нь өөрийн хяналтад хамаардаггүй байгууллагуудаас ч мэдээлэл гаргуулан авах боломжтой. Тус хороо нь жил тутам Засгийн газарт тайлангаа хүргүүлдэг байна.

1.2.Ерөнхий хянан шалгагч:

Ерөнхий хянан шалгагч (inspectors general) (ЕХШ) гэсэн албан тушаалын хэлбэр анх АНУ-д бий болсон байна. Гэхдээ ЕХШ-ийг хэн ажиллуулдаг, ЕХШ ажлаа хэнд тайлагнадаг, тайландаа чухам ямар асуудлыг хамруулдаг зэрэг нь хоорондоо ихээхэн ялгаатай байгаа бөгөөд чиг үүрэг нь амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгаа, тухайлбал, гол хүмүүстэй уулзах болон шаардлагатай мэдээлэлд нэвтрэх эрх мэдлийн хэмжээ нь улс орон бүрд харилцан адилгүй байдаг.

АНУ-ын хувьд Тагнуулын төв газрын (Central Intelligence Agency) ЕХШ нь Тагнуулын төв газрын ажилтан бөгөөд Тагнуулын төв газрын захиралд ажлаа тайлагнана. ЕХШ-ийн албан тушаалд нэр дэвшигчийг АНУ-ын Ерөнхийлөгчөөс санал болгож, Сенатаар баталгаажуулдаг ба Ерөнхийлөгч албан тушаалаас нь чөлөөлөх эрхтэй байдаг.

⁷³ Canadian Security Intelligence Service Act (31 August 2004), R.S.C., Chapter C-23, Section 41 (available at <http://www.csis-scrs.gc.ca/pblctns/ct/cssct-eng.asp>).

⁷⁴ United States, Inspector General for the Central Intelligence Agency, U.S. Code 50, §403q (e)(3).

ЕХШ нь байгууллагын дотоод санхүүгийн хэмнэлт, үр ашигт байдал, ажлын үр дүн, хариуцлагатай байдлыг сайжруулахаас гадна шамшигдуулах, үр ашиггүй байдал, эрх мэдлээ урвуулан ашиглах үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох үндсэн үүрэгтэй. ЕХШ нь эдгээр чиг үүргийнхээ хүрээнд Тагнуулын төв газрын хөтөлбөр, үйл ажиллагаанд бие даасан аудит, хянан шалгалт явуулдаг. Үйл ажиллагааныхаа хүрээнд олж илрүүлсэн үр дүнгээ Тагнуулын төв газрын захирал болон Конгрессын дээд, доод танхимын тагнуулын асуудал эрхэлсэн хороодод тайлагнаж хууль зөрчсөн үйлдэл гарсан гэж үзэх үндэслэлтэй тохиолдолд Нэгдсэн Улсын Ерөнхий прокурорт давхар мэдэгддэг байна.

Канад Улсын Аюулгүй байдлын тагнуулын албаны (Security Intelligence Service) ЕХШ нь хариуцаж буй байгууллагынхаа ажилтан бус харин Засгийн газраас томилогдох бөгөөд Нийгмийг аюулаас хамгаалах яамны Дэд сайдын өмнө ажлаа хариуцдаг Нийгмийг аюулаас хамгаалах газрын ажилтан байна.

1984 онд батлагдсан Канад Улсын Аюулгүй байдлын тагнуулын албаны тухай хууль (Security Intelligence Service Act)-аар Аюулгүй байдлын тагнуулын албаны ЕХШ-ийн албан тушаалыг бий болгосон бөгөөд түүний үндсэн үүрэг нь Аюулгүй байдлын тагнуулын албаны үйл ажиллагаа тус улсын хууль тогтоомж, дүрэм журам, бодлогод нийцэж буй эсэхэд анхаарч ажиллах юм. ЕХШ нь жил бүр Аюулгүй байдлын тагнуулын албаны захирлаас холбогдох сайдад илгээх үйл ажиллагааны тайланг хянан үзэж, Аюулгүй байдлын тагнуулын албаны тухай хууль болон тухайн сайдаас гаргасан тушаал, зааврыг зөрчсөн эсэхийг хянан баталгаажуулна. Түүнчлэн эрх мэдлээ хэтрүүлсэн буюу шаардлагагүй үед хэрэглэсэн аливаа үйл ажиллагааг тогтоох үүрэгтэй.

ЕХШ нь чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд албаны захирал болон бусад албан тушаалтнаас шаардлагатай бүх мэдээлэл, баримт бичиг, тайлбарыг гаргуулж авах эрхтэй байдаг байдаг.

Австрали Улсын Тагнуул, аюулгүй байдлын ЕХШ (Inspector General of Intelligence and Security)-ийн албан тушаал нь хуульчлагдсан байдлаараа АНУ, Канад Улсынхтай төстэй. 1986 онд батлагдсан Тагнуул, аюулгүй байдлын Ерөнхий хянан шалгагчийн тухай хууль (Inspector General of Intelligence and Security Act)-аар эрх, үүргийг нь хуульчилж өгсөн бөгөөд Ерөнхий сайдын дор, хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг байна.

Тус улсын Ерөнхий амбан захирагч ЕХШ-ийг томилох бөгөөд ЕХШ-ийн эрх нь харьцангуй өргөн цар хүрээтэй буюу Австралийн тагнуулын нийгэмлэгийг бүхэлд нь хамардаг байна. ЕХШ-ийн гүйцэтгэх чиг үүргийг дараах дөрвөн хэлбэрт ангилж болно. Үүнд:

- тагнуулын алба тус бүрийн үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж, дүрэм журмын биелэлтийг хянах;
- үйл ажиллагааны зүй зохист байдлыг үнэлэх;
- үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлэх;
- үйл ажиллагаа нь хүний эрхийг зөрчсөн эсэхийг тогтоох зэрэг.

ЕХШ хянан шалгах үйл ажиллагааныхаа дийлэнхийг Австрали Улсын Аюулгүй байдлын тагнуулын байгууллагад (Security Intelligence Organisation) хандуулдаг бөгөөд энэхүү байгууллагын чиг үүрэг нь ихэвчлэн дотоодод чиглэсэн байдаг тул тус улсын иргэд, оршин суугчдын эрхийг зөрчих магадлал гадаад болон батлан хамгаалахын тагнуулын байгууллагатай харьцуулахад илүү байдаг. ЕХШ бүрэн хэмжээний хянан шалгах ажиллагаа явуулж буй үедээ Хатан хааны Хянан шалгах комисстой ижил түвшний эрх эдэлдэг бөгөөд гэрчүүдийг сонсголд оролцуулахаар дуудах, үнэн зөв мэдүүлэг авах, тагнуулын албадаас шаардлагатай мэдээлэл, баримт бичиг гаргуулж авах, албан байранд нэвтрэх эрхтэй байдаг байна. Мөн ЕХШ-ийн албан тушаалын халдашгүй байдлыг хуулиар зөвхөн үндэслэлтэй шалтгаанаар л чөлөөлж болохоор зохицуулсан байдаг.

Хуулийн дагуу ЕХШ нь үйл ажиллагааныхаа тайланг Ерөнхий сайдад жил тутам гаргаж өгөх бөгөөд Ерөнхий сайд тайланг парламентын дээд, доод танхимд танилцуулдаг байна.

Австрали Улсын Парламентын Тагнуул, аюулгүй байдлын хамтарсан хорооноос гадна тус улсын тагнуулын албадыг Австралийн Үндэсний аудитын газраас мөн хянадаг байна.

1.3.Хөндлөнгийн хяналтын мэргэшсэн бүтэц:

Хөндлөнгийн хяналтын мэргэшсэн бүтэц (expert oversight bodies)-үүдийг хуулиар байгуулдаг бөгөөд чиг үүрэг, гүйцэтгэх болон хууль тогтоох засгаас хараат бус байдлын түвшин, гишүүдийг нь хэрхэн сонгох, гишүүнчлэлийн аливаа шаардлага бий эсэхээрээ ялгаатай байдаг.

Канад Улсын Аюулгүй байдлын тагнуулын хяналтын хороо (Security Intelligence Review Committee) болон Харилцаа холбооны аюулгүй байдлын албаны комиссар (Communications Security Establishment Commissioner):

Канад Улсын энэ төрлийн хяналтын хоёр байгууллага байдаг нь Аюулгүй байдлын тагнуулын хяналтын хороо (АБТХХ) болон Харилцаа холбооны аюулгүй байдлын албаны комиссар (цаашид “Комиссар”) юм.

АБТХХ нь гүйцэтгэх болон хууль тогтоох засгийн аль алианаас нь хараат бусаар ажилладаг бөгөөд Хатан хааны дээд зөвлөлийн гишүүнээр ажиллаж, нууцын тангараг өргөсөн тав хүртэлх тооны гишүүнтэй байна. Мөн АБТХХ-ны гишүүн нь парламентын гишүүн байх ёсгүй. АБТХХ-ны хуралдааныг аюулгүй байдлыг хангасан орчинд явуулах ба ажлын албаны ажилтнуудыг урьдчилан шалгаж, баталгаажуулсан байна. АБТХХ нь ЕХШ-ийн тайланг хүлээн авахаас гадна өөрөө Аюулгүй байдлын тагнуулын албаны (Security Intelligence Service) үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй. Тухайлбал, тус албатай холбогдуулан гаргасан өргөдөл гомдлын мөрөөр хянан шалгах ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд АБТХХ нь Аюулгүй байдлын тагнуулын албаны ЕХШ-д, эсхүл Аюулгүй байдлын тагнуулын албанд өөрт нь тодорхой үйл ажиллагааны мөрөөр хянан шалгах ажиллагаа явуулахыг даалгах эрхтэй.

АБТХХ нь хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тус улсын Аюулгүй байдлын тагнуулын албаны ЕХШ болон Аюулгүй байдлын тагнуулын албанаас шаардлагатай гэж үзсэн тайлан, тайлбарыг оролцуулан аливаа мэдээллийг гаргуулж авах эрхтэй. Түүнчлэн тус хорооноос шаардлагатай гэж үзсэн үедээ асуудал хариуцсан сайдад тайлан илгээх эрхтэй бөгөөд харин жил тутмын тайланг сайдад заавал хүргүүлж, улмаар парламентад танилцуулна. АБТХХ-ноос тайлангийн агуулгыг шийдэх эрхтэй ч нууцын зэрэгтэй аливаа мэдээ мэдээлэл оруулахыг хориглодог байна.

Засгийн газрын шийдвэрээр Комиссарын албан тушаалыг 1996 онд бий болгож Терроризмтой тэмцэх тухай хуулиар Комиссар болон түүний эрх, үүргийг хуульчилж өгсөн байна. Уг хуулиар Канад Улсын хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянах хязгаарлагдмал эрх мэдлийг Комиссарт өгсөн байна. Түүнээс гадна Комиссар нь тус албатай холбоотой гомдол хүлээж авах эрхтэй болсон. Комиссарын албан тушаалд нэр дэвшигчдэд дээд шатны шүүхийн шүүгчээр ажилласан байх шаардлага тавигддаг бөгөөд түүнийг зөвхөн тодорхой үндэслэлээр л ажил үүргээс нь чөлөөлөхөөр зааж өгсөн байна.

Комиссар нь нууцлалын горимоор ажиллах бөгөөд урьдчилан шалгагдсан цөөн тооны ажилтантайгаар нууц байранд хуралддаг. Түүнээс гадна Хянан шалгах ажиллагааны тухай хуулийн дагуу тэрээр бусад бүх Комиссартай нэгэн адил хянан шалгах бусад эрхийг эдэлж, АБТХХ-ны нэгэн адил хариуцсан сайдаар дамжуулан парламентад жил тутмын тайлангаа хүргүүлэх ёстой.

**ХОЕР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД, ГҮЙЦЭТГЭХ АЖИЛД ТАВИХ
ХЯНАЛТ**

2.1.Оросын Холбооны Улс**2.1.1.Эрх зүйн орчин:**

Оросын Холбооны Улс (ОХУ)-ын шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа (оперативный розыск) (ШЭСА)-тай холбоотой эрх зүйн харилцааг багц хууль тогтоомжоор зохицуулах бөгөөд үүнийг тус улсын Шуурхай эрэн сурвалжлах ажиллагааны тухай хууль (Закон об оперативно-розыскной деятельности)-ийн 4 дүгээр зүйлд тодорхойлсон байна. Үүнд:

- **ОХУ-ын Үндсэн хууль** (§2; 17; 19; 23; 25; 46; 49; 55 гэх мэт);
- **холбооны улсын үндсэн хуульчлагдсан хуулиуд:** Үндсэн хуулийн хэм хэмжээ нь ШЭСА болон хүний, иргэний үндсэн эрх, эрх чөлөөний талаар тусгасан байдаг;
- **Шуурхай эрэн сурвалжлах ажиллагааны тухай холбооны хууль** (цаашид “ШЭСА-ны тухай хууль”) нь 1995 онд батлагдсан бөгөөд ШЭСА-г зохицуулсан үндсэн хууль юм;
- **холбооны улсын бусад хуулиуд:** үүнд, Эрүүгийн кодекс (Уголовный кодекс), Эрүүгийн байцаан шийтгэх кодекс (Уголовно-процессуальный кодекс), Төрийн нууцын тухай хууль (О государственной тайне), Прокурорын байгууллагын тухай хууль (О прокуратуре), Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль (О наркотических средствах и психотропных веществах), мөн холбогдох байгууллагуудын эрх зүйн байдлыг зохицуулсан хуулиуд, тухайлбал, Цагдаагийн тухай (О полиции), Холбооны аюулгүй байдлын албаны тухай (О федеральной службе безопасности) хуулиуд хамаарна;
- **холбооны улсын төрийн байгууллагуудын гаргасан эрх зүйн хэм хэмжээний актууд:** үүнд, ОХУ-ын Ерөнхийлөгчийн (тухайлбал, “Техник хэрэгсэл ашиглан шуурхай эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулах, явуулах тухай” 1995 оны 673 дугаар зарлиг), ОХУ-ын Засгийн газрын (тухайлбал, “ОХУ-ын гаалиар хяналттай тээвэрлэсэн барааг хураах, солих журам батлах тухай” 2003 оны 671 дүгээр тогтоол) шийдвэрүүд хамаарна;
- **ШЭСА-г хэрэгжүүлэгч байгууллагуудаас гаргасан эрх зүйн хэм хэмжээний актууд:** үүнд, хууль тогтоомжийн дагуу шуурхай эрэн сурвалжлах байгууллагын бүрэн эрхийн хүрээнд ШЭСА-ны зохион байгуулалт, тактикийг зохицуулахаар гаргасан эрх зүйн хэм хэмжээний актууд хамаарна. Эдгээр актууд нь иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн, салбар хоорондын шинж чанартай бол ОХУ-ын Хууль зүйн яаман дээр улсын бүртгэлд бүртгүүлнэ.

2.1.2.ШЭСА болон хүний ба иргэний эрх, эрх чөлөө:

ШЭСА нь хүний амь нас, эрүүл мэнд, хүний ба иргэний эрх, эрх чөлөө, эд хөрөнгийг хамгаалах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор холбооны хуулиар эрх олгосон төрийн байгууллагууд эрх мэдлийнхээ хүрээнд илээр, эсхүл нууцаар явуулдаг ажиллагааны төрөл хэмээн тус улсын ШЭСА-ны тухай хуульд тодорхойлжээ. (ШЭСА-ны тухай хуулийн §1)

ШЭСА нь дараах үүрэгтэй (ШЭСА-ны тухай хуулийн §2):

- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, түүнчлэн гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, бэлтгэсэн, эсхүл үйлдсэн этгээдийг олж тогтоох;
- хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс нуугдаж, эрүүгийн ялаас зайлсхийсэн, эсхүл сураггүй алга болсон хүмүүсийг эрэн сурвалжлах;

- ОХУ-ын төрийн, батлан хамгаалахын, эдийн засгийн, мэдээллийн болон байгаль орчны аюулгүй байдалд заналхийлж буй үйл явдал, үйлдэл (эс үйлдэхүй)-ийн талаар мэдээлэл олж авах зэрэг болно.

ШЭСА нь хууль ёсны байх, хүний ба иргэний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, сахин биелүүлэх зэрэг зарчмуудыг баримталж, ил болон нууц арга, хэрэгслийг хослуулан хэрэглэнэ. (ШЭСА-ны тухай хуулийн §3)

ШЭСА-ны үндсэн объект бол хүний ба иргэний эрх, эрх чөлөөг гэмт хэргийн халдлагаас, түүний дотор хүний амь нас, эрүүл мэнд, хууль ёсны ашиг сонирхол болон эд хөрөнгийг хамгаалах (§1) ба үүнийг хангахын тулд ШЭСА-г зөвшөөрч, дараах үндсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- Үндсэн хууль (§23; 25)-ийн хэм хэмжээ болон ШЭСА-ны тухай хуульд үндэслэн хүний зарим эрхийг хууль ёсны дагуу хүчээр хязгаарлах;
- хүний эрхийг зөрчсөн холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэх (Эрүүгийн хуулийн §137-139 гэх мэт).

ШЭСА-нд дор дурдсаныг хориглоно (ШЭСА-ны тухай хуулийн §5):

- шуурхай эрэн сурвалжлах байгууллагууд, тэдгээрийн алба хаагчид ШЭСА-ны явцад иргэдийн хувийн амьдрал, хувийн болон гэр бүлийн нууц, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нууцыг зөрчихийг;
- зорилгодоо хүрэх, асуудлыг шийдвэрлэхийн тулд ШЭСА-ны тухай хуульд заагаагүй ШЭСА явуулахыг;
- шуурхай эрэн сурвалжлах байгууллагууд, тэдгээрийн алба хаагчид дор дурдсан үйлдлийг хориглоно:
 - улс төрийн нам, олон нийтийн болон шашны холбоодын ашиг сонирхлын үүднээс ШЭСА явуулахыг;
 - төрийн аливаа байгууллагуудын, хуулийн дагуу бүртгэгдсэн, хориглоогүй улс төрийн намуудын, олон нийтийн болон шашны холбоодын үйл ажиллагааны шинж чанарт нөлөөлөх зорилгоор тэдний үйл ажиллагаанд нууцаар оролцохыг;
 - ШЭСА явуулах явцад ил болсон хувийн болон гэр бүлийн нууц, хувийн амьдралын халдашгүй байдал, иргэдийн нэр төр, сайн нэрийг хөндсөн мэдээллийг тухайн иргэний зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг (хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд);
 - хууль бус үйлдлийг шууд болон шууд бусаар өдөөх (өдөөн хатгах)-ийг;
 - ШЭСА-ны үр дүнг хуурамчаар үйлдэхийг.

ШЭСА-нд Үндсэн хуулийг үндэслэж, ОХУ-ын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу (тэр дундаа Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц) **хүний ба иргэний эрх, эрх чөлөөг хамгаална**. ШЭСА-нд дараах ажиллагаа хамаарна:

- болзошгүй, эсхүл бодит хууль бус зөрчлөөс идэвхтэй хамгаалах;
- үр дүнтэй урьдчилан сэргийлэх;
- ШЭСА-ны улмаас гарсан хохирлыг нөхөн төлөх;
- бусад шаардлагатай арга хэмжээг авах.

ШЭСА-нд хүний ба иргэний эрхийг хамгаалахыг бодитоор хангах гэдэг нь Үндсэн хуулиар тогтоосон дараах баталгаагаар хангах учиртай (ШЭСА-ны тухай хуулийн §5):

- шуурхай эрэн сурвалжлах байгууллагууд, тэдгээрийн албан тушаалтны үйлдэл, шийдвэрт гомдол гаргах боломжтой эсэх;

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхээс ШЭСА-нд хамрагдсан этгээд нь эрх, эрх чөлөөгөө төрөөр, тэр дундаа шүүхээр хамгаалуулах эрхтэй, хэрэв ШЭСА-ны үр дүнд түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл ШЭСА-г гүйцэтгэгчийн дээд шатны байгууллага, прокурор, шүүхэд гомдол гаргах эрхтэй хэмээн тайлбарлажээ. (ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн 2005 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 327 дугаар тогтоол)

- шуурхай эрэн сурвалжлах байгууллагаас мэдээлэл авах боломжтой эсэх;
- ШЭСА-нд хөндлөнгийн (салбарын бус) хяналт, түүний дотор шүүхийн хяналт байгаа эсэх;
- ШЭСА-нд прокурорын хяналт тавих;
- хүн бүр хууль зүйн мэргэшсэн туслалцаа авах эрхтэй байх.

ШЭСА-нд Үндсэн хуулиар олгогдсон **хүний ба иргэний тодорхой зарим эрхийг хязгаарлах** нь ШЭСА-ны тухай хуульд заасан журмын дагуу, шүүхийн шийдвэрийн үндсэн дээр хэрэгжинэ.

Үндсэн хуулиар олгогдсон хүний ба иргэний тодорхой зарим эрхийг хязгаарлах нь ШЭСА-тай нягт холбоотой бөгөөд төрөөс гэмт хэрэгт нөлөөлөх нэн шаардлагатай, хууль ёсны арга хэрэгсэл юм. (Үндсэн хуулийн §23.2; 25; 55.3; ШЭСА-ны тухай хуулийн §7; 8 гэх мэт)

Мэдээж Үндсэн хуулиар олгогдсон хүний ба иргэний бүх эрхийг ШЭСА-нд хязгаарлаж болохгүй бөгөөд хязгаарлаж болох эрхийн хүрээг Үндсэн хуульд тодорхой заасан байдаг.

Хууль ёсны үндэслэл байгаа бол дараах Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хязгаарлаж болно:

- хувийн амьдрал, хувийн болон гэр бүлийн нууцад халдашгүй байдал, нэр төр, сайн нэрийг хамгаалах (Үндсэн хуулийн §23.1; 24.1);
- захидал харилцаа, утасны яриа, шуудан, телеграф болон бусад харилцаа холбооны нууцлал (Үндсэн хуулийн §23.2; ШЭСА-ны тухай хуулийн §8);
- орон сууцны халдашгүй байдал (Үндсэн хуулийн §25; ШЭСА-ны тухай хуулийн §8.2);
- мэдээлэл чөлөөтэй хайх, авах, дамжуулах, бэлтгэх, түгээх (Үндсэн хуулийн §29.4);
- хувийн өмчтэй байх, түүнийг ашиглах, захиран зарцуулах (Үндсэн хуулийн §35.2; 35.3).

ШЭСА-нд хүний ба иргэний эрхийг хязгаарлахыг зөвхөн ШЭСА-ны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үндэслэлээр зөвшөөрнө. Үндэслэл нь нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдэж болзошгүй байх, эсхүл бодитой үйлдсэн байхыг шаардана. (ШЭСА-ны тухай хуулийн §8.2)

2.1.3.ШЭСА-г хэрэгжүүлэгч байгууллагууд:

Тус улсын нутаг дэвсгэр дээр дараах байгууллагууд гүйцэтгэх ажил буюу ШЭСА-г хэрэгжүүлнэ. (§13) Үүнд:

- 1) ОХУ-ын дотоод хэргийн байгууллага;
- 2) Холбооны аюулгүй байдлын албаны байгууллага;
- 3) Улсыг аюулаас хамгаалах салбар дахь холбооны гүйцэтгэх засаглалын байгууллага;
- 4) ОХУ-ын гаалийн байгууллага;
- 5) ОХУ-ын Гадаад тагнуулын алба;
- 6) Холбооны шийтгэл гүйцэтгэх алба;
- 7) ОХУ-ын Батлан хамгаалах яамны Гадаад тагнуулын байгууллагын шуурхай ажиллагааны хэлтэс.

Эдгээр байгууллагуудын ШЭСА-ны хүрээг авч үзье.

1) ОХУ-ын дотоод хэргийн байгууллага буюу **Дотоод хэргийн яам** (Министерство внутренних дел) (ДХЯ)-ны тогтолцоонд ШЭСА-г хэрэгжүүлэгч байгууллагуудыг бүрэн болон бүрэн бус хэрэгжүүлэгч байгууллагууд гэж хоёр ангилна. ШЭСА-г бүрэн хэрэгжүүлэгч байгууллагад уг ажиллагааг хэрэгжүүлэхдээ бүхий л хүчин чадал, арга хэрэгсэл ашиглах эрхтэй байгууллагууд хамаарах ба энэ ангилалд ДХЯ-ны дараах нэгжүүд багтана:

- эрүүгийн мөрдөн байцаах нэгж;
- хар тамхитай тэмцэх нэгж;
- эдийн засгийн аюулгүй байдал ба авлигатай тэмцэх нэгж;
- хувийн аюулгүй байдал нэгж;
- экстремизм буюу хэт туйлшралтай тэмцэх нэгж;
- ачаа тээвэрт халдах гэмт хэрэгтэй тэмцэх нэгж;
- төрийн хамгаалалтад байгаа этгээдийн аюулгүй байдлыг хангах нэгж;
- шуурхай эрэн хайх нэгж;
- тусгай техник ашиглах нэгж;
- ДХЯ-ны харьяа муж хоорондын ШЭСА.

ШЭСА-г бүрэн бус хэрэгжүүлэгч байгууллагад уг ажиллагааг хэрэгжүүлэхдээ хүчин чадал, арга хэрэгслийг бүрэн бус ашиглах эрхтэй байгууллагууд багтах ба энэ ангилалд ДХЯ-ны дараах нэгжүүд багтана:

- мэдээлэл шуурхай мөрдөн хайх нэгж;
- Эрүүгийн цагдаагийн олон улсын байгууллагын гишүүн болох Интерпол болон Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын газартай харилцах нэгж.

2) Холбооны аюулгүй байдлын албаны байгууллага болох **ОХУ-ын Аюулгүй байдлын холбооны алба** (Федеральная служба безопасности РФ)-ны чиг үүрэг нь хууль эрх зүй, зохион байгуулалт, аюулгүй байдал, шуурхай-эрэн сурвалжлах, техникийн болон бусад арга хэмжээний үндсэн дээр хийгддэг төрийн объектын аюулгүй байдлыг хангахад чиглэнэ.

3) Аюулаас хамгаалах салбар дахь холбооны Засгийн газрын байгууллага болох **ОХУ-ын Аюулаас хамгаалах алба** (Федеральная служба охраны РФ) нь тагнуулын болон террорист үйл ажиллагаа зохион байгуулсан, төрийн нууцыг задруулсан, эх орноосоо урвасан, хил зөрчсөн, мансууруулах болон бусад бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх зэрэг эрүүгийн хэрэг дээр мөрдөн байцаах ажиллагаа явуулна.

4) ОХУ-ын гаалийн байгууллага болох **Холбооны гаалийн алба** (Федеральная таможенная служба) нь хууль бус наймаатай тэмцэх болон гаалийн салбар дахь бусад гэмт хэрэгтэй тэмцэх, түүнчлэн өөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ШЭСА явуулах эрхтэй;

5) **ОХУ-ын Гадаад тагнуулын алба** (Служба внешней разведки РФ) нь дараах зорилгоор тагнуулын үйл ажиллагаа явуулна:

- ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны Хурал, Засгийн газрыг улс төр, эдийн засаг, цэрэг-стратегийн, шинжлэх ухаан-техникийн болон байгаль орчны чиглэлээр шийдвэр гаргахад шаардлагатай тагнуулын мэдээллээр хангах;
- ОХУ-ын аюулгүй байдлын бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлэх;
- улс орны эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн дэвшил, ОХУ-ын цэрэг-техникийн аюулгүй байдлыг хангахад туслах.

6) Холбооны шийтгэл гүйцэтгэх алба (Федеральная служба исполнения наказаний) нь заасны дагуу дор дурдсан зорилгоор ШЭСА явуулахыг Эрүүгийн шийтгэл гүйцэтгэх кодекс (Уголовно-исполнительный кодекс)-ийн 84 дүгээр зүйлд хуульчилсан байна:

- ялтан, засан хүмүүжүүлэх байгууллагын ажилтан болон бусад хүмүүсийн хувийн аюулгүй байдлыг хангах;
- хорих байгууллагад гэмт хэрэг, зөрчил, ял эдлэх тогтоосон журмыг зөрчихөөр бэлтгэж байгааг тогтоох, эсхүл ийм зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд түүнийг илрүүлэх;
- хорих ангиас оргон зайлсан, түүнчлэн хорих ялаас зайлсхийсэн ялтныг тогтоосон журмын дагуу эрэн сурвалжлах;
- хорих ангид ирэхээс өмнө ялтнуудын үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх.

7) ОХУ-ын Батлан хамгаалах яамны Гадаад тагнуулын байгууллагын шуурхай ажиллагааны хэлтэс (Оперативное подразделение органа внешней разведки) нь Шуурхай эрэн сурвалжлах ажиллагааны тухай хуулийн 13.9-д зааснаар зөвхөн тухайн гадаад тагнуулын байгууллагын аюулгүй байдлыг хангах зорилгоор, мөн дээр дурдсан байгууллагуудын бүрэн эрхэд хамаарахгүй бол ШЭСА явуулна.

2.1.4.ШЭСА-нд тавих хөндлөнгийн хяналт:

ШЭСА-нд тавих салбарын бус буюу хөндлөнгийн хяналт бол тус улсын төрийн болон олон нийтийн зүгээс тавих хууль ёсны хяналт юм. Энэ нь ШЭСА хэрэгжүүлэгч байгууллага, тэдгээрийн албан тушаалтнуудын үйл ажиллагаа Үндсэн хууль, ШЭСА-ны хууль тогтоомжоор тогтоосон зорилго, зорилт, зарчим, дүрэмд нийцэж байгаа эсэхийг хянах тогтолцоо юм. Энэхүү хяналтын эцсийн зорилго нь ШЭСА-нд тогтоосон хэм хэмжээг мөрдөөгүйг мэдээлэх явдал бөгөөд шаардлагатай бол ШЭСА хэрэгжүүлэгч байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагааг зохицуулах, үр дүнтэй ажиллахад нь саадыг арилгах юм.⁷⁵

Төрийн зүгээс тавих хөндлөнгийн хяналтыг дор дурдсан субъектүүд өөрийн бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэхээр ШЭСА-ны тухай хуулийн 19.3, 20-д заасан байна. Үүнд:

- 1) ОХУ-ын Ерөнхийлөгч;
- 2) ОХУ-ын Холбооны Хурал;
- 3) ОХУ-ын Засгийн газар;
- 4) санхүүгийн хяналт тавих Сангийн яамны эрх бүхий төлөөлөгчид;
- 5) Прокурорын хяналт;
- 6) Шүүхийн хяналт зэрэг болно.

1) ОХУ-ын Ерөнхийлөгч:

Үндсэн хуулийн 80-90 дүгээр зүйлд зааснаар ОХУ-ын Ерөнхийлөгч нь өргөн хүрээний эрх мэдэлтэй байдаг. Хамгийн гол нь ОХУ-ын Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийн, хүний ба иргэний эрх, эрх чөлөөний баталгаа болж байдаг. Үндсэн хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэгт заасны дагуу тэрээр тус улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, төрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах арга хэмжээ авдаг.

Ерөнхийлөгч нь төрийн хамгийн дээд албан тушаалтны хувьд дараах эрхтэй:

⁷⁵ Шумилов А.Ю. Курс основ оперативно-розыскной деятельности. Издательский дом Шумиловой И.И., 2008. 152 дахь тал.

- батлан хамгаалах, аюулгүй байдал, дотоод хэрэг болон бусад асуудал эрхэлсэн холбооны гүйцэтгэх байгууллагууд, тэр дундаа шуурхай эрэн сурвалжлах байгууллагуудын үйл ажиллагааг удирдана. Удирдлага, хяналтын явцад дор дурдсаныг үнэлнэ:
 - ОХУ-ын нутаг дэвсгэрт бүхэлд нь болон холбогдох яам, албадын үйл ажиллагааны хүрээнд ШЭСА-ны тухай хуулийн хэрэгжилтийн бүрэн байдал, үр дүнтэй байдал;
 - ШЭСА-ны зохион байгуулалтын бүтэц нь бодит нөхцөл байдалд гэмт хэрэгтэй амжилттай тэмцэхэд нөлөөлж байгаа эсэх;
 - ШЭСА-ны оролцогчдын мэргэжлийн ерөнхий түвшин;
 - ШЭСА-ны эрх зүйн зохицуулалтын тогтолцооны байдал, түүний холбооны хууль тогтоомжид нийцсэн байдал;
 - ШЭСА-ны оролцогчдод тогтоосон эрх зүйн болон нийгмийн дэмжлэгийн баталгааг төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж байгаа эсэх;

Мөн ерөнхийлөгчийн хяналтад ШЭСА-тай холбоотой асуудлаар түүний гаргасан эрх зүйн хэм хэмжээний актын хэрэгжилт, даалгаврын биелэлт багтдаг;

- Ерөнхий сайдын санал болгосноор ШЭСА-тай холбоотой журмыг баталж, шуурхай эрэн сурвалжлах байгууллагууд удирдлагыг томилно;
- ОХУ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн даргын хувьд бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх (ОХУ-ын Засгийн газрын тухай хуулийн §32).

2) ОХУ-ын Холбооны Хурал:

Үндсэн хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар тус улсын Парламент буюу Холбооны Хурлын хоёр танхим (Холбооны Зөвлөл ба Төрийн Дум) нь ШЭСА-нд парламентын хяналтын чиглэлээр дараах эрхтэй:

- ШЭСА-ны чиглэлээрх хуулийн төслийг батлах, эсхүл буцаах;
- ШЭСА-г хэрэгжүүлэхэд зарцуулсан санхүүгийн эх үүсвэрийг шалгах.

Парламентын хяналт нь нэгд, холбооны төсвийн гүйцэтгэлийг хянах хүрээнд (Үндсэн хуулийн §101.5), хоёрт, Холбооны Хурлын хоёр танхимаас байгуулагдсан ОХУ-ын Тооцооны танхимаар дамжуулан хэрэгжүүлдэг.

ОХУ-ын Холбооны Хурлын парламентын мөрдөн шалгах ажиллагааны тухай хуульд заасны дагуу, ялангуяа Үндсэн хуулиар баталгаажсан хүний ба иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн баримтууд (Парламентын мөрдөн шалгах ажиллагааны тухай хуулийн §1.1) ийм парламентын мөрдөн шалгалтад хамрагдана.

Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын депутат ШЭСА-нд хөндлөнгөөс оролцохыг хууль тогтоомжоор хориглосон байдаг. Тиймээс ОХУ-ын Холбооны Хурлын парламентын мөрдөн шалгах ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт парламентын мөрдөн шалгах ажиллагаа нь хэрэг бүртгэлт, урьдчилсан мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааг орлохгүй гэж заасан байдаг.

Холбооны Зөвлөл, Төрийн Дум нь ШЭСА-ны чиглэлээр тодорхой мэдээлэл шалгах тусгай хороо байгуулах эрхтэй. Тиймээс ОХУ-ын Холбооны Хурлын танхимууд ШЭСА-ны тухай хуулийн хэрэгжилтэд ерөнхий хяналт тавьдаг. Энэ нь ШЭСА явуулах үндэслэл, журамд хамаарахгүй боловч ШЭСА-ны тухай хуулийн хэм хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсч буй ерөнхий нөхцөл байдлыг үнэлэх зорилготой юм.

3) ОХУ-ын Засгийн газар:

ОХУ-ын Засгийн газрын бүрэн эрхийг Үндсэн хууль, ОХУ-ын Засгийн газрын тухай үндсэн хуульчилсан хуульд тодорхойлсон байдаг. Үүнд, батлан хамгаалах, төрийн аюулгүй байдлыг хангах (Үндсэн хуулийн §20), мөн хууль дээдлэх, иргэдийн эрх, эрх чөлөөг хангах, өмч хөрөнгө, нийгмийн хэв журмыг хамгаалах (§114), гэмт хэрэгтэй тэмцэх (§19), холбооны яамд, бусад гүйцэтгэх байгууллагуудыг удирдлагаар хангах (ОХУ-ын Засгийн газрын тухай хуулийн §12) зэрэг болно.

Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд холбооны гүйцэтгэх эрх бүхий байгууллагаас ШЭСА явуулахдаа эрх мэдэл, нөөц боломжоо бүрэн, үр дүнтэй ашиглаж байгаа эсэхэд хяналт тавина. Засгийн газрын хяналтын чухал чиглэл бол ШЭСА-тай холбоотой шуурхай эрэн сурвалжлах байгууллагуудын гаргасан эрх зүйн хэм хэмжээний актуудын Үндсэн хууль болон холбооны бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгах явдал юм.

Мөн Засгийн газрын бүрэн эрхэд холбогдох шуурхай эрэн сурвалжлах байгууллагуудын ШЭСА-нд хуваарилагдсан санхүүжилтийн зарцуулалтын үндэслэлийг шалгах хамаарна. Энэхүү шалгалтыг Сангийн яам тусгайлан томилогдсон эрх бүхий төлөөлөгчөөрөө дамжуулан хийдэг.

4) Санхүүгийн хяналт тавих Сангийн яамны эрх бүхий төлөөлөгчид:

ШЭСА-нд хуваарилагдсан санхүүжилтийн зарцуулалтад тавих хяналтыг шуурхай эрэн сурвалжлах байгууллагуудын дарга нараас гадна ОХУ-ын Сангийн яамны тусгайлан эрх бүхий төлөөлөгчид хэрэгжүүлнэ. (ШЭСА-ны тухай хуулийн §19.3).

Сангийн яамны эрх бүхий төлөөлөгчид ШЭСА-ны холбооны хууль тогтоомж, Сангийн яамны дүрэм, журмыг мөрдөж ажиллана. Тухайлбал;

- ШЭСА-ны тухай хууль;
- ОХУ-ын төсвийн кодекс;
- Сангийн яамны дүрэм (Засгийн газрын 2004 оны 329 дүгээр тогтоол);
- ШЭСА-ны холбооны төсвийн зардлын гүйцэтгэлийг зохион байгуулах журам (Сангийн яамны 2007 оны 124 дүгээр тогтоол).

Сангийн яамны эрх бүхий төлөөлөгчид нь мөн төрийн нууцад хамаарах мэдээлэлд нэвтрэх журамд хамрагдах ба ийнхүү хамрагдсанаар тэд эрх бүхий албан тушаалтан болж ШЭСА-ны санхүүжилттэй холбоотой бүх баримт бичигтэй танилцах эрхтэй болдог.

5) Прокурорын хяналт:

Холбооны хуульд заасны дагуу ШЭСА-нд прокурорын хяналтыг бүх прокурор хэрэгжүүлэхгүй. ШЭСА-ны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн дагуу ШЭСА-нд прокурорын хяналтыг ОХУ-ын Ерөнхий прокурор болон эрх бүхий прокурорууд хэрэгжүүлнэ.

Эрх бүхий прокурорууд бол Ерөнхий прокуророос ШЭСА-ны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх олгосон прокурорууд юм. Ерөнхий прокурор энэхүү томилгоог өөрийн нэрийн өмнөөс хийх эрхийг прокурорын байгууллагын дараах албан тушаалтнуудад олгож болно:

- Ерөнхий прокурорын орлогч буюу Цэргийн ерөнхий прокурорт;
- холбооны тойргууд, ОХУ-ын бүрэлдэхүүн улсууд дахь Ерөнхий прокурорын орлогч нар, тэдэнтэй дүйцэх цэргийн болон бусад мэргэжлийн прокуроруудад.

Эрх бүхий прокурорууд нь Прокурорын байгууллагын тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу дараах хууль тогтоомжийг баримтлан мөрдөж ажиллана. Үүнд:

- ШЭСА-ны тухай хууль;
- Прокурорын байгууллагын тухай хууль;
- “ШЭСА-ны тухай хуулийн хэрэгжилтэд прокурорын хяналтыг зохион байгуулах тухай” Ерөнхий прокурорын 2007 оны 207 дугаар тушаал;
- бусад эрх зүйн хэм хэмжээний актууд (тухайлбал, ШЭСА явуулах, мөрдөн байцаах)

ШЭСА-нд эрх бүхий прокурор дараах үндсэн үүрэгтэй:

- гомдол хянан үзэх (ШЭСА-ны тухай хуулийн §5.3);
- хувь хүний эрхийг сэргээх арга хэмжээ авах (§5.9);
- холбогдох шийдвэрийн хууль ёсны байдлыг шалгах (§21.2);
- өөрт нь ирсэн баримт бичиг, материалд агуулагдах мэдээллийн хамгаалалтыг хангах (§21.4);
- гэмт хэргийн тухай болон сураггүй алга болсон этгээдийн тухай мэдүүлэг, мэдээг хүлээн авах, бүртгэх, шалгахад тавигдах шаардлагуудын биелэлтийг хянах.

Дээрх үндсэн үүргийнхээ хүрээнд прокурор дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- үйл ажиллагааны болон албан ёсны баримт бичиг, түүний дотор үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн хавтастай танилцах;
- илрүүлсэн хууль тогтоомжийн зөрчлийн талаар шуурхай эрэн сурвалжлах байгууллагын албан тушаалтан, ажилтнуудаас бичгээр тайлбар авах;
- хууль тогтоомжийн зөрчлийг арилгах талаар ШЭСА явуулж буй байгууллагын албан баримт бичиг, материал болон тухайн ажиллагааны нягтлан бодох бүртгэлд бичгээр шаардлага тавих, үүрэг даалгавар өгөх;
- шуурхай эрэн сурвалжлах байгууллагуудын дарга нарын хууль бус, үндэслэлгүй шийдвэрийг эсэргүүцсэн асуудал, түүний дотор ШЭСА-ны үр дүнг мөрдөн байцаагчид, шуурхай эрэн сурвалжлах байгууллагын даргад, шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;
- ШЭСА явуулж байгаа байгууллагын ажилтан, албан тушаалтны хууль зөрчсөн үйлдлүүдийг арилгах талаар санал, дүгнэлт гаргах, уг үйл ажиллагаанд цаашид оролцох эрхийг хасахыг, ШЭСА-г зогсоохыг шаардсан асуудлыг шийдвэрлэх.

Нөхцөл байдлаас шалтгаалан баримт бичгийг гаргаж өгөхөөс хууль бусаар татгалзсан бол эрх бүхий прокурорын шаардлагыг биелүүлээгүй, хууль ёсны үйл ажиллагаанд нь саад учруулсан гэж үзэж, гэм буруутай албан тушаалтанд, эсхүл этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хүртэл арга хэмжээ авна. (ОХУ-ын Ерөнхий прокурорын 2007 оны 207 дугаар тушаал)

ШЭСА-нд прокурор дараах хоёр үндэслэлээр хяналт шалгалт хийнэ:

- прокурорын байгууллагад шуурхай эрэн сурвалжлах байгууллага (түүний албан тушаалтан)-ын хууль зөрчсөн тухай мэдээлэл, өргөдөл хүлээн авсан бол;
- эрх бүхий прокурорын санаачилгаар.

Дээрх хоёр үндэслэлээр тавих хяналт нь шуурхай эрэн сурвалжлах ажилтнуудаас зохих хариу өгөхийг шаарддаг.

Прокурор ШЭСА-г дараах үндэслэлээр шалгана:

- иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны хүсэлтээр;
- илрээгүй гэмт хэргийн эрүүгийн хэргийн материалыг судалсан үр дүнд үндэслэн;
- мөрдөн байцаагч, мөрдөн байцаах байгууллагын дарга, хэрэг бүртгэлийн байгууллагын өгсөн зааварт зүй бус хариу өгсөн тухай мэдээлэл хүлээн авснаар;
- хянан шийдвэрлэх эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрээр;
- эрх бүхий прокурорын шаардлага, даалгаврыг зохих ёсоор биелүүлээгүй;

- төлөвлөгөөний дагуу, тэр дундаа дээд шатны прокурорын заавраар;
- бусад тохиолдолд ШЭСА-ны хууль ёсны байдлыг харгалзан үзэх ба гэмт хэрэг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, бэлтгэсэн, эсхүл үйлдсэн этгээд, эрүүгийн хэрэгт яллагдагч, сэжигтэн, эсхүл сураггүй алга болсон хүмүүсийг эрэн сурвалжлахад эерэг үр дүн гарахгүй бол.

ШЭСА-нд тавих прокурорын хяналтын хүрээ хязгаарыг ШЭСА-ны тухай хуулиар тогтоосон байна. (§21.3) Үүнд дараах этгээдүүд хамаарна:

- зохион байгуулалттай гэмт бүлэглэлд орсон этгээд;
- ШЭСА явуулж буй байгууллагын орон тооны нууц ажилтан;
- ШЭСА-нд нууцын үндсэн дээр тусалж байгаа этгээд (Тэдний тухай мэдээллийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс бусад тохиолдолд зөвхөн эдгээр хүмүүсийн бичгээр өгсөн зөвшөөрөлтэйгөөр холбогдох прокурорт өгнө.)

6) Шүүхийн хяналт:

ШЭСА-ны явцад Үндсэн хуулиар олгогдсон иргэдийн эрхийг хязгаарласан тухай бүх материал (захидал, утасны яриа, цахилгаан болон шуудангаар дамжиж байгаа шуудан, телеграф болон бусад харилцааны нууцлал, гэр орны халдашгүй байдал гэх мэт)-ыг шүүгч хянаж байхаар ШЭСА-ны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан байдаг.

Үүнийг хөндлөнгийн, хараат бус “хянагч” буюу шүүгч нэг талаас, ШЭСА-нд иргэний эрх, эрх чөлөөг хангах, тэдгээрийг хязгаарлах нь хууль ёсны үндэслэлтэй шийдвэр гаргах, нөгөө талаас нийгэм, улсын ашиг сонирхлыг дагаж мөрдөх үүднээс хийдэг.

ШЭСА-нд тавих шүүхийн хяналтын утга учир нь аливаа ШЭСА шүүхийн зөвшөөрөлгүйгээр Үндсэн хуулиар олгогдсон иргэний эрхийг хязгаарлах боломжгүй (тухайн ажиллагааны нэн яаралтай байдлыг эс тооцвол). Түүнчлэн, шүүгч ийм ШЭСА-ийг эхлүүлэхийг зөвшөөрөхгүй, эсхүл үргэлжлүүлэхийг хориглох (ШЭСА-ны хугацааг сунгахгүйгээр), тэр ч байтугай яаралтай хийгдэж, дараа нь шүүгчид мэдэгдсэн ШЭСА-г үндэслэлгүй гэж үзэх эрхтэй.

Тиймээс орчин үед ШЭСА-нд тавих шүүхийн хяналт нь заавал хууль ёсны байх ёстой. Үүний зэрэгцээ энэхүү хяналт нь Үндсэн хуулиар олгогдсон иргэний эрхийг хязгаарлахад ШЭСА-нд зайлшгүй хэрэгжүүлэх үе шат юм. Энэ нөхцөлд шүүгч нь холбогдох ШЭСА-ны заавал байх оролцогч бөгөөд түүний шийдвэрээр ШЭСА-г хэрэгжүүлнэ.

ШЭСА-нд тавих хяналтын хүрээнд шүүх дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- ШЭСА-ны явцад Үндсэн хуулиар олгогдсон хүн бүрийн эрхийг хязгаарлах үндэслэлийг хянаж үзэх (ШЭСА-ны тухай хуулийн §8.2; 8.3; 9.1);
- шуурхай эрэн сурвалжлах байгууллага, түүний албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь хууль ёсны эсэхийг хянах (§8.2; 8.3);
- шуурхай эрэн сурвалжлах байгууллагад гаргасан гомдлыг хянах (§5.2; 5.3);
- шүүгч ШЭСА-ны зөвшөөрөл олгохоос татгалзсантай холбогдуулан анхан шатны шүүхийн шүүгч, шуурхай эрэн сурвалжлах байгууллагын хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх (§9.6).

ШЭСА-нд тавих шүүхийн хяналтын хүрээ хязгаарыг ШЭСА-ны тухай хуульд тогтоосон байдаг. Энэ хүрээнд шүүгч нь шуурхай эрэн сурвалжлах байгууллагуудаас дараах мэдээлэл шаардах эрхгүй:

- зохион байгуулалттай гэмт бүлэглэлд орсон этгээдийн талаар;
- ШЭСА явуулж буй байгууллагын орон тооны нууц ажилтны талаар;
- ШЭСА-нд нууцын үндсэн дээр тусалж байгаа этгээдийн талаар;
- ШЭСА-ны зохион байгуулалт, тактик.

Шүүгч бол ОХУ-ын Үндсэн хууль, Шүүхийн тогтолцооны хуулийн дагуу шударга ёсыг сахиулагч, мэргэжлийн үндсэн дээр үүргээ гүйцэтгэдэг хүн юм. (§11.1)

ШЭСА-ны тухай хуульд аль шүүгч, аль шүүх ШЭСА-нд хяналт тавих талаар шууд заагаагүй. Гэхдээ 1998 онд тус улсын Үндсэн хуулийн шүүхээс Төрийн нууцын тухай хуулиар шүүгч бүрэн эрхийнхээ хугацаанд төрийн нууцад хамаарах мэдээллийг олж авахыг зөвшөөрсөн байдаг (§21¹) нь аливаа шүүгч ШЭСА-ны материалыг хянан үзэж болно хэмээн тайлбарлажээ.

ШЭСА-нд тавих шүүхийн хяналтыг дараах шүүгчид хэрэгжүүлнэ:

- **шүүхийн дарга нар** – дүүргийн (хотын) шүүхэд шуурхай эрэн сурвалжлах байгууллагаас хүлээн авсан ШЭСА-ны баримт бичгийг шүүхийн дарга, эсхүл түүний эзгүйд (амралт гэх мэт) орлогч дарга, эсхүл тодорхой шүүгч хянаана;
- **энэ зорилгоор тусгайлан томилсон шүүгчид** – шүүх бүр хамгийн багадаа хоёр шүүгчийг (үндсэн болон орлогч) томилно.

ШЭСА-нд тавих шүүхийн хяналтын хүрээнд шүүгч дараах үүрэгтэй (ШЭСА-ны тухай хуулийн §9):

- холбогдох материалтай нэн даруй хянаж үзэх;
- хэрэв холбогдох материалыг ирүүлсэн бол түүнийг хянаж үзэхээс татгалзах эрхгүй;
- ШЭСА явуулах тухай үндэслэл бүхий шийдвэр гаргах;
- шүүхийн удирдлага шүүхэд хүлээн авсан ШЭСА-ны баримт бичигт агуулагдах мэдээллийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх.

Энэхүү хяналтын хүрээнд шүүгч нь ШЭСА-ийн тухай хуулийн дагуу дараах эрхтэй:

- ШЭСА-г явуулахыг зөвшөөрөх буюу татгалзах (§9.4);
- нэгжлэг явуулах үндэслэл бүхий нэмэлт материалыг бүрдүүлэхийг шаардах (§9.3);
- Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг хязгаарлах тухай шийдвэрийн хүчинтэй байх хугацааг сунгах (§9.5);
- мэдүүлэг гаргагчид өгөхөөс татгалзсан мэдээллийн талаарх ШЭСА-ны баримт бичгийг гаргаж өгөхийг шуурхай эрэн сурвалжлах байгууллагаас шаардах (§5.4).

2.2.Бүгд Найрамдах Солонгос Улс

2.2.1.Эрх зүйн орчин:

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-д мөрдөн шалгах ажиллагааг дараах хуулиудаар⁷⁶ зохицуулж байна. Үүнд:

- Үндэсний тагнуулын албаны тухай хууль (National Intelligence Service Act);
- Цэргийн гэмт хэргийн тухай хууль (Military Criminal Act);
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль (National Security Act).

2019 оны сүүлээр тус улсад эрүүгийн эрх зүйн орчныг өөрчилсөн хэд хэдэн хуулиуд батлагдан гарсан байна. Тухайлбал:

- Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөн шалгах албаны тухай хууль (Corruption Investigation Office for High-Ranking Officials Act);
- Прокурорын байгууллагын тухай хууль (Prosecutor's Office Act);
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Criminal Procedure Act).

⁷⁶ Korean law information center - <https://www.law.go.kr/LSW/eng/engMain.do?menuId=0>

2020 оны сүүлээр Өндөр албан тушаалтнуудын эрүүгийн хэргийг мөрдөх албаны тухай хууль (High-Ranking Official's Crime Investigation Agency Act)-д нэмэлт, өөрчлөлт орсноор хууль сахиулах тогтолцоонд өөрчлөлт гарсан байна.

Судлаачдын үзэж байгаагаар⁷⁷ энэхүү өөрчлөлтөөр прокурорын болон цагдаагийн байгууллагын эрх, үүрэг ижил болсон байна. Тухайлбал, тус улсад прокурорын байгууллага өмнө нь эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн байцаах ажиллагаа явуулдаг гол байгууллага байсан. Прокурорууд цагдаагийн мөрдөн байцаах ажиллагааг удирдан чиглүүлэх, эхлүүлэх, зогсоох эрхтэй байсныг мөн өөрчилсөн байна. *(Прокурорын болон цагдаагийн байгууллагын эрх, үүрэгт гарсан өөрчлөлтийн талаар судалгааны дараагийн хэсгээс үзнэ үү.)*

2.2.2. Мөрдөн байцаах эрх бүхий байгууллагууд:

БНСУ-д дараах эрх бүхий байгууллагууд мөрдөн байцаах ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1) Үндэсний тагнуулын алба;
- 2) Батлан хамгаалахын аюулгүй байдлын командлал;
- 3) Дээд прокурорын газар;
- 4) Үндэсний цагдаагийн газар;
- 5) Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөх алба.

1) Үндэсний тагнуулын алба⁷⁸-ыг (National Intelligence Service) Төрийн байгууллагын тухай хууль (Government Organization Act⁷⁹)-ийн 17 дугаар зүйлд үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл, энхтайван, дэг журам сахиулах, эрүүгийн хэрэг мөрдөн байцаах үндсэн чиг үүрэгтэйгээр Ерөнхийлөгчийн дэргэд байгуулагдахаар зохицуулжээ.

Тус албаны эрх зүйн байдлыг Үндэсний тагнуулын албаны тухай хууль (National Intelligence Service Act⁸⁰)-аар зохицуулсан байна. (§2)

Үндэсний тагнуулын албаны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу Үндэсний тагнуулын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гадаад тагнуулын үйл ажиллагаа болон дотоодын тагнуулын мэдээ цуглуулах, нэгтгэх, түгээх (Засгийн газрын халдлага, тагнуул, терроризмтой тэмцэх, олон улсын гэмт бүлэглэл);
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлтэй төрийн нууцад хамаарах баримт бичиг, материал, барилга байгууламж, бүс нутгийн талаар хамтран ажиллах;
- Эрүүгийн хуульд заасан бослого, гадаадын түрэмгийллийн гэмт хэрэг, Цэргийн эрүүгийн хуульд заасан бослого, криптограм (cryptogram)-ыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг, Цэргийн нууцыг хамгаалах тухай хуульд заасан гэмт хэрэг, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд заасан гэмт хэргийг мөрдөн шалгах;
- Үндэсний тагнуулын газрын ажилтнуудын ажил үүрэгтэй холбоотой гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгах;

⁷⁷ Sweeping Changes to the Korean Criminal Procedures: Starting in the New Year. Chang Hee SUH and others. Lee & Ko. Newsletter, December 2020. <https://www.leeko.com/upload/upFile/202012//RECR202012291738296019340.pdf>

⁷⁸ 1961-1980 онд Солонгосын Тагнуулын төв агентлаг (Korean Central Intelligence Agency), 1981-1990 онд Үндэсний аюулгүй байдлын төлөвлөлтийн агентлаг (National Security Planning Agency), 1999 оноос Үндэсний тагнуулын газар (National Intelligence Service) нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна. https://eng.nis.go.kr/EID/1_5_2_1.do

⁷⁹ Төрийн байгууллагын тухай хууль: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=44197&type=sogan&key=15

⁸⁰ Үндэсний тагнуулын албаны тухай хууль: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=33396&type=part&key=4

- тагнуул, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг төлөвлөх, зохион байгуулах зэрэг болно.

Мөн хуулийн 11 дүгээр зүйлд албан тушаалын байдлаа урвуулан ашиглахтай холбоотой харилцааг зохицуулжээ. Тухайлбал, Үндэсний тагнуулын албаны захирал, дэд захирал болон бусад ажилтнууд албаны эрх мэдлээ урвуулан буюу хууль ёсны ажиллагаагүйгээр аливаа хүнийг баривчлах, хорьж саатуулахгүй, аливаа байгууллага, хүнийг албадахгүй байх, эсхүл албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглаж аливаа этгээдийг эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглоно.

2) БНСУ-ын Ерөнхийлөгчийн 31796 дугаар зарлиг (Presidential Decree No31796)-ийн дагуу **Батлан хамгаалахын аюулгүй байдлын командлал** (Defense Security Support Command)-д⁸¹ цэргийн аюулгүй байдлыг хангах, цэргийн сөрөх тагнуул, цэргийн мэдээлэл цуглуулах, бэлтгэх, боловсруулах, мөн Цэргийн шүүхийн тухай хуульд заасан гэмт хэргүүдийг (§44) мөрдөн шалгах чиг үүргийг даалгасан байна. Тухайлбал:

- батлан хамгаалахын аюулгүй байдлыг хангах;
- цэргийн сөрөх тагнуул;
- цэргийн холбогдолтой мэдээллийг цуглуулах, боловсруулах;
- цэргийн эрүүгийн мөрдөн байцаах ажиллагаа;
- цэргийн аюулгүй байдлыг дэмжих бусад үйлчилгээ.

Батлан хамгаалахын аюулгүй байдлын командлалын үйл ажиллагааг Үндэсний аюулгүй байдлын тухай хууль болон бусад багц хуулиудаар зохицуулж байна.

2017 онд батлагдсан Үндэсний аюулгүй байдлын тухай хууль (National Security Act)⁸²-ийн зорилго нь үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй төрийн эсрэг үйл ажиллагааг зохицуулах замаар үндэсний аюулгүй байдал, ард түмний оршин тогтнох, эрх чөлөөг хангахад оршино.

Бусад багц хуулиудын хувьд, батлан хамгаалахын аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааг дараах хуулиудаар зохицуулж байна:

- Цэргийн нууцыг хамгаалах тухай хууль;
- Мэдээлэл, харилцааны дэд бүтцийг хамгаалах тухай хууль;
- Цэргийн бааз, байгууллагыг хамгаалах тухай хууль;
- Цэргийн бааз, объектыг хамгаалах тухай хууль;
- Ерөнхийлөгчийн аюулгүй байдлын тухай хууль

Цэргийн сөрөх тагнуултай холбоотой:

- Нэгдсэн хамгаалалтын тухай хууль;
- Үндэсний батлан хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад терроризмтой тэмцэх тухай хууль.

Цэргийн эрүүгийн мөрдөн байцаах ажиллагаа, Сөрөх тагнуулын болон аюулгүй байдлын мөрдөн байцаалтын нотолгоонд хийх дүн шинжилгээ, судалгаатай холбоотой:

- Цэргийн нууцыг хамгаалах тухай хууль;
- Цэргийн шүүхийн тухай хууль;
- Цэргийн эрүүгийн хууль.

⁸¹ Defense Security Support Command - <https://www.dssc.mil.kr/dsscscn/355/subview.do>

⁸² Үндэсний аюулгүй байдлын тухай хууль:

<https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=National+Security+Act&x=26&y=26#liBgcolor20>

Батлан хамгаалахын аюулгүй байдлын командлалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд дараах байгууллагууд байдаг:

- Үндэсний кибер аюулгүй байдлын төв (National Cyber Security Center);
- Солонгосын Интернет, аюулгүй байдлын агентлаг (Korea Internet & Security Agency);
- Солонгосын Мэдээллийн аюулгүй байдлын аж үйлдвэрийн холбоо (Korea Information Security Industry Association);
- Харилцаа холбооны технологийн холбоо (Telecommunications Technology Association);
- Санхүүгийн аюулгүй байдлын институт (Санхүүгийн аюулгүй байдлын хүрээлэн)
- Солонгосын Үндэсний цагдаагийн агентлагийн Кибер товчоо (Korean National Police Agency Cyber Bureau).

3) Дээд прокурорын газар (Supreme Prosecutors' Office)⁸³ нь хууль ёс, дэг журмыг тогтоож хүний эрхийг хамгаалдаг үндэсний хууль сахиулах дээд байгууллага юм.

Прокурорын байгууллагын тухай хууль (Prosecutor's Office Act)-ийн 4 дүгээр зүйлд заасны дагуу прокурор дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- эрүүгийн хэрэг үүсгэх, гэмт хэргийг мөрдөн байцаах;
- мөрдөн байцаалтын ажиллагаанд шүүхийн цагдаагийн ажилтнууд (judicial police officer⁸⁴)-ыг чиглүүлэх, хяналт тавих;
- шүүхийн шийдвэрийн биелэлтийг удирдан чиглүүлэх зэрэг болно.

Прокурорын ажилтан улс төрийн үзэл баримтлалын хувьд төвийг сахиж, олон нийтэд үйлчилдэг албан тушаалтныхаа хувьд үүргээ хэрэгжүүлэхдээ өөрт олгосон бүрэн эрхээ хэтрүүлэн ашиглахгүй байх үүрэгтэй гэж тус хуульд заасан байдаг.

Прокурор нь өөрийн харьяалагдах прокурорын газрын харьяаллын дагуу мөрдөн байцаах ажиллагааг зохион байгуулан ажиллах бөгөөд хууль, тогтоомжид өөрөөр заагаагүй бол мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах шаардлагатай гэж үзвэл тухайн харьяаллаас гадуур үүргээ гүйцэтгэж болохыг Прокурорын байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан байна.

Прокурор мөрдөн байцаах ажиллагаа⁸⁵ явуулах ба энэхүү ажиллагаа нь эрүүгийн хууль зөрчсөн гэмт хэрэгтнүүдийг илрүүлэх, хамгаалах, нотлох баримт цуглуулах, хадгалах, гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа эсэхийг тодруулах, яллах, яллах эсэхийг шийдвэрлэхэд чиглэгдсэн мөрдөн байцаах байгууллагын бүхий л үйл ажиллагааг хэлнэ.

Прокурорын байгууллага нь дор дурдсан хэргүүдийг мөрдөн байцаана.⁸⁶ Үүнд:

- авлигын гэмт хэрэг (хээл хахууль (30 сая воноос дээш), худалдаанд нөлөөлөх, Өмгөөллийн тухай болон Улс төрийн сангийн тухай хуулиудыг зөрчих);
- санхүүгийн гэмт хэрэг (залилан (500 сая воноос дээш), хөрөнгө шамшигдуулах, дотоод худалдаа, аж үйлдвэрийн тагнуул хийх, худалдааны нууцын хулгай, Өрсөлдөөний тухай хуулийг зөрчих;

⁸³ Supreme Prosecutors' Office - <https://www.spo.go.kr/site/spo/main.do>

⁸⁴ Шүүхийн цагдаагийн ажилтан (judicial police officer) нь Ерөнхий прокурор, эсхүл прокурорын аливаа байгууллагын даргын томилсон прокурорын байгууллагын VI зэргийн албан тушаалтнууд, VI - IX зэргийн ажилтнууд, хар тамхины хэргийн VII, IX зэргийн мөрдөн байцаагчид байх ба Эрүүгийн процессын тухай хуулийн 169 дүгээр зүйлд заасан журмын дагуу ажиллана.

⁸⁵ Prosecution Service - <https://www.spo.go.kr/site/spo/01/10101050200002018112210.jsp>

⁸⁶ Sweeping Changes to the Korean Criminal Procedures: Starting in the New Year. Chang Hee SUH and others. Lee & Ko. Newsletter, December 2020. <https://www.leeko.com/upload/upFile/202012//RECR202012291738296019340.pdf>

- төрийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэг (албан үүргээ биелүүлэхгүй байх, эрх мэдлээ урвуулан ашиглах, албан үүргээ гүйцэтгэж байхдаа бусдад халдах, албаны нууц задруулах, хуурамч бичиг баримт үйлдэх);
- сонгуулийн гэмт хэрэг (ард нийтийн санал асуулга, холбоодын болон их сургуулиудын ерөнхийлөгчдийн зэрэг сонгуультай холбоотой гэмт хэрэг);
- батлан хамгаалах салбарын гэмт хэрэг;
- гамшгийн үеийн гэмт хэрэг (их хэмжээний хохирол учруулах гал түймэр, хөрсний нуралт, дэлбэрэлт).

4) Үндэсний цагдаагийн газар (Korean National Police Agency)-ын бүтцэд байдаг Үндэсний Мөрдөн байцаах алба нь мөрдөн байцаалтыг хариуцдаг Мөрдөн байцаалтын төлөвлөлт, зохицуулалтын товчоо, Шүүхийн шинжилгээний удирдлагын газар, Мөрдөн байцаах товчоо, Мөрдөх товчоо, Кибер мөрдөн байцаах товчоо, Үндэсний аюулгүй байдлын мөрдөн байцаах товчоотой;⁸⁷

5) Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөх алба (Corruption Investigation Office for High-ranking Officials)⁸⁸ - төрийн өндөр албан тушаалтнууд тэдгээрийн гэр бүлийнхний үйлдсэн авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах өргөн эх мэдэлтэй хараат бус байгууллага юм.

2.2.3.Мөрдөн байцаах ажиллагаан дахь хүний эрхийн асуудал:

БНСУ-ын Хүний эрхийн үндэсний комисс⁸⁹ нь 2001 онд байгуулагдсан, БНСУ-ын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль⁹⁰-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулах ба БНСУ-ын үндэсний хууль тогтоомж, нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцод заасан хүний эрх, нэр төр, эрх чөлөөг өргөн хүрээнд хангахаар ажилладаг.

Гэмт хэргийг мөрдөн шалгах хүрээнд хүний эрхийг зөрчсөн хэргүүдийг шалгаж, арга хэмжээ авах боломжоор хангах, хүний эрхийн боловсролыг түгээх, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, Олон улсын хүний эрхийн гэрээний хэрэгжилтийг сурталчлах, хяналт тавих, төрийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, НҮБ-ын хүний эрхийн байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллагуудтай (APF, CC) хамтран ажиллах, хүний эрхийг хамгаалах, дэмжихэд шаардлагатай гэж үзсэн бусад чиг үүргийг гүйцэтгэдэг.⁹¹

ХЭҮК нь хүний эрхийн зөрчлийг арилгаж урьдчилан сэргийлнэ. Энэ хүрээнд төрийн байгууллага, цэргийн болон хууль сахиулах байгууллага, хорих анги, түр саатуулах газрууд албан үүргээ гүйцэтгэх явцдаа хүний эрхийг зөрчсөн гэж үзвэл иргэд ХЭҮК-д өргөдөл гаргадаг.

Өргөдлийг шалгах явцад хүний эрх зөрчсөн үйлдэл хийсэн нь тогтоогдвол тухайн төрийн албан хаагчийг албанаас гарах хүртэлх арга хэмжээ авдаг.⁹²

2.3.Бүгд Найрамдах Турк Улс

Бүгд Найрамдах Турк Улс (БНТУ)-ын тагнуулын мөрдөн шалгах нууц ажиллагааг Үндэсний тагнуулын байгууллага (Milli istihbarat teskilat, MİT), гүйцэтгэх ажлыг Цагдаагийн ерөнхий газрын харьяа Гүйцэтгэх ажиллагааны газар (Istihbarat daire başkanlığı) тус тус хэрэгжүүлдэг байна.

⁸⁷ <https://www.police.go.kr/eng/knpa/org/org01.jsp>

⁸⁸ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=53133&lang=ENG

⁸⁹ <http://www.humanrights.go.kr/site/main/index002>

⁹⁰ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=22488&lang=ENG

⁹¹ <http://www.humanrights.go.kr/site/homepage/menu/viewMenu?menuid=002001001001>

⁹² <http://www.humanrights.go.kr/site/homepage/menu/viewMenu?menuid=002004006002>

Тус улсад гүйцэтгэх ажилтай холбоотой харилцааг дараах хуулиудаар зохицуулж байна. Үүнд:

- Тагнуулын байгууллагын тухай 3201 дүгээр хууль (Emniyet teşkilat kanunu);⁹³
- Цагдаагийн байгууллагын үүрэг, хариуцлагын тухай 2559 дүгээр хууль (Polis vazife ve salâhiyet kanunu);⁹⁴
- Төрийн тагнуулын байгууллагын үйлчилгээ ба Үндэсний тагнуулын байгууллагын тухай 2937 дугаар хууль (Devlet İstihbarat Hizmetleri ve Milli İstihbarat Teşkilatı Kanunu);⁹⁵
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 5271 дүгээр хууль (Ceza muhakemesi kanunu);
- Эрүүгийн 5237 дугаар хууль (Türk ceza kanunu).

БНТУ-ын тагнуулын ажиллагааны үүрэг бүхий байгууллага бол **Үндэсний тагнуулын байгууллага** (MIT) юм. Уг байгууллага нь гадаад тагнуул, тагнуулын тусгай ажиллагаа явуулах чиг үүрэгтэй. Үндэсний тагнуулын байгууллагын үүрэг нь тухайн улсад дотоод, гадаадын тагнуулын албаны үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах явдал юм. Яам, төрийн байгууллагууд, нийтийн үйлчилгээний байгууллагуудын архивын мэдээллийг албан хэрэгцээндээ авч ашиглах эрхтэй байна. Мөн Үндэсний тагнуулын байгууллагын гишүүд зэвсэг авч явах тусгай зөвшөөрөлтэй байдаг.

Цагдаагийн ерөнхий газрын харьяа **Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах газар** нь Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх тухай (№4208) хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд хуулийн **зорилго** нь мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх, баримтлах зарчмыг тодорхойлоход оршино. Тус газар нь 2006 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай (№5549) хуулиар байгууллагын эрх, үүрэг, бүрэн эрхээ шинэчлэн тогтоосон.

Гүйцэтгэх ажиллагааны газар нь нийтийн хэв журмыг сахиулах, аюулгүй байдлын талаар урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах зорилгоор улсын хэмжээнд мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 139⁹⁶ дүгээр зүйлд **нууц мөрдөн байцаагчийг** томилох, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулахыг тусгасан байна.

Нууц мөрдөн байцаагч нь байгууллага болон хувь хүний мэдээлэлд нэвтрэх, тагнах, хяналт тавих, тухайн байгууллагын талаар судалгаа хийх, гэмт хэргийн ул мөр, нотлох баримтыг цуглуулж мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй төрийн албан хаагч юм. Мөрдөн байцаалтын шатанд нууц мөрдөн байцаагчийг шүүгч томилон ажиллуулж болно. Нууц мөрдөн байцаагчийн цуглуулсан мэдээлэл, бичиг баримт, эд мөрийн баримт зэргийг Улсын Ерөнхий прокурорын газарт хүргүүлдэг. Нууц мөрдөн байцаагчийн биеийн байцаалтыг өөрчилж болох ба тухайн шийдвэр болон бусад баримт бичгийг Улсын ерөнхий прокурорын газарт хадгална. Бүрэн эрхийн хугацаа нь дууссан ч нууц мөрдөн байцаагчийн мэдээллийг нууцалдаг. Яллах шатанд мөрдөн байцаагчийг гэрчээр сонсох шаардлагатай тохиолдолд шүүх хуралдаанд оролцуулж дуу, дүрсийг нь өөрчлөхгүйгээр хаалттай орчинд сонсоно.

Эрүүгийн хуульд зааснаар зөвхөн дор дурдсан гэмт хэрэгт нууц мөрдөн байцаагчийг томилон ажиллуулна. Үүнд:

⁹³ <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.3.3201.pdf>

⁹⁴ <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.3.2559.pdf>

⁹⁵ <https://www.mit.gov.tr/2937.pdf>

⁹⁶ <https://barandogan.av.tr/5271-sayili-ceza-muhakemesi-kanunu-cmk.html#Madde-139>

- Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үйлдэгдсэн эсэхээс үл хамааран сэргээш, мансууруулах бодис хэрэглэх, үйлдвэрлэх, худалдаалах;
- Гэмт хэрэг үйлдэх зорилгоор аж ахуйн нэгж байгуулах (220 дугаар зүйл, хоёр, долоо, наймдугаар хэсгээс бусад);
- Зэвсэг нийлүүлэх (315-р зүйл);
- Галт зэвсэг, хутга, бусад хэрэгслийг хууль бусаар хил нэвтрүүлэх (12 дугаар зүйл)
- Соёлын өв болон байгалийн үнэт зүйлсийг хамгаалах тухай хуулийн 68, 74 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг зэрэг багтана.


Тус хуулийн 140⁹⁷ дүгээр зүйлд нууц мөрдөн шалгах ажиллагаанд техникийн хэрэгсэл ашиглах тухай заасан байна. Гэмт хэргийн нууц мөрдөн шалгах ажиллагааг шүүхийн шийдвэр, Гүйцэтгэх ажиллагааны газар, Тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтны бичгээр гаргасан хүсэлтийн дагуу сонсох төхөөрөмж ашиглах боломжтой байдаг.

Яаралтай буюу хугацаа алдах эрсдэлтэй тохиолдолд эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр хорин дөрвөн цагийн дотор мэдээлэл хүргүүлнэ. Тагнуулын нууц мөрдөн шалгах ажиллагаа дууссан гэж үзвэл сонсох төхөөрөмж ашиглах эрхийг тэр даруй цуцална. Сонсох төхөөрөмж дэх бичлэгийг 10 хоногийн дотор устган, тайланг аудитаар хянуулахаар архивт хадгална.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

⁹⁷ <https://barandogan.av.tr/5271-sayili-ceza-muhakemesi-kanunu-cmk.html#Madde-140>

Зураг 1. Гүйцэтгэх ажил явуулж байгаа эрх бүхий байгууллагууд



Дараах гэмт хэргийг үйлдсэн гэх бодит нотлох баримтад үндэслэн сэжиглэх үндэслэл байгаа тохиолдолд баримтжуулахын тулд сэжигтэнг тухайн байршилд, ажлын байран дээр техникийн хэрэгслээр хянах, дуу, дүрсийг баталгаажуулах бичлэг хийх нууц ажиллагааг явуулах боломжтой байна. Үүнд:

- цагаачдыг хууль бусаар хил нэвтрүүлэх, хүн худалдаалах, эд эрхтэн худалдаалах;

- санаатайгаар аллага үйлдэх;
- хулгай, дээрэм болон залилах;
- мансууруулах бодис, өдөөгч бодис үйлдвэрлэх, худалдаалах;
- хуурамч мөнгө;
- биеэ үнэлэх;
- тендерийн луйвар;
- авлига;
- гэмт хэргийн улмаас үүссэн хөрөнгийг угаах;
- төрийн нууцын эсрэг гэмт хэрэг, тагнуулын эсрэг гэмт хэрэг;
- Үндсэн хуулийн дэг журам, түүний үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэх мэт.

2.3.1. Гүйцэтгэх ажиллагааны газар (*Istihbarat daire başkanlığı*).⁹⁸

Цагдаагийн ерөнхий газрын харьяа Гүйцэтгэх ажиллагааны газар нь Тагнуулын байгууллагын тухай (№3201) хууль, Цагдаагийн байгууллагын үүрэг, хариуцлагын тухай (№2559) хуулиуд болон Гүйцэтгэх ажиллагааны газрын журмын дагуу мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж байна.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд нийслэлд 5 газар, орон нутагт 81 салбар нэгжтэйгээр мөрдөн шалгах үйл ажиллагааг явуулж байна. Мөн Гүйцэтгэх ажиллагааны газрын сургалтын үйл ажиллагааг Тагнуулын академи (ISAK) явуулдаг. Төрийн аюулгүй байдал, олон нийтийн амгалан тайван байдлыг хангах зэрэг асуудлаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэг бүхий тагнуулын боловсон хүчнийг бэлтгэдэг.

Гүйцэтгэх ажиллагааны газрын эрх зүйн байдал, үйл ажиллагаатай холбоотой харилцааг Цагдаагийн байгууллагын үүрэг, бүрэн эрхийн тухай хуулиар⁹⁹ зохицуулах ба энэ хуулийн **зорилго** нь нийтийн хэв журмыг сахиулах, хүний аюулгүй байдал, амь нас, эд хөрөнгө, оршин суугаа газрын аюулгүй байдлыг хамгаалдаг.

Цагдаагийн байгууллагын үүрэг, бүрэн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар БНТУ-ын нутаг дэвсгэр, хуваагдашгүй бүрэн бүтэн байдал, Үндсэн хуулийн байгууламж, аюулгүй байдлын талаар урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах, дэг журмыг сахиулах зорилгоор улсын хэмжээнд **мөрдөн шалгах** үйл ажиллагаа явуулдаг. Гүйцэтгэх ажиллагааны газар нь мэдээлэл цуглуулах, үнэлэх, холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх ба орон нутгийн бүх тагнуулын байгууллагуудтай хамтран ажилладаг.

Цагдаагийн байгууллагын үүрэг, хариуцлагын тухай хуулийн¹⁰⁰ 2 дугаар зүйлд гүйцэтгэх ажиллагааны байгууллагын хамрах хүрээг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

- иргэдийн амь нас, нэр төр, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хамгаалах;
- төрийн эсрэг дангаар эсхүл бүлэглэн дайрах, үймээн дэгдээгч этгээдүүдийг баривчлах;
- Засгийн газрын эсрэг хүчирхийлэл болон эсэргүүцэл үйлдэгчдийн үйл ажиллагааг таслан зогсоох, арга хэмжээ авах;
- барилга байгууламж, орон сууц болон хүн амьдардаггүй газарт хувь хүн эсхүл бүлэглэн хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх;
- цагдаагийн албанаас хүнд гэмт хэрэгт сэжигтнээр татагдан оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжилж, баривчлах;
- гэмт хэрэг үйлдэх, түүнээс урьдчилан сэргийлэхтэй тэмцэх;
- төрийн болон иргэний гэмт хэрэг үйлдэгчдийг баривчлах, тэдгээрийг нотлох, баримтжуулах;

⁹⁸ <https://egm.gov.tr/istihbarat>

⁹⁹ <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.3.2559.pdf>

¹⁰⁰ <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.3.2559.pdf>

- Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжоор гэмт хэрэгтэн болох нь тогтоогдсон этгээдийн хэргийн нотлох баримтыг илрүүлэх, гэмт этгээдийг баривчлах, эрэн сурвалжлах;
- хууль бусаар зохион байгуулагдаж буй жагсаал, цуглааныг тараах, арга хэмжээ авах;
- Гал түймэр, үер, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшиг болсон газарт шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;
- нийтийн эзэмшлийн талбайд аливаа төрлийн цуглаан, жагсаал, ёслолын үйл ажиллагааны дэг журмыг тогтоох.

2.3.2. Үндэсний тагнуулын байгууллага (Milli istihbarat teskilat):

Тагнуулын үйл ажиллагааг нээлттэй болон хаалттай эх сурвалжаас иргэн, байгууллага болон орон нутгийн бусад байгууллагуудын талаарх мэдээллийг цуглуулж, тухайн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үнэлэх замаар дүгнэлт гаргана. Тагнуулын үйл ажиллагааг нууц журам, зарчим, техникээр гүйцэтгэдэг.

Үндэсний тагнуулын байгууллагын үүрэг:

- нутаг дэвсгэрийн болон үндэсний бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнол, аюулгүй байдал, БНТУ-д тулгарч буй гадаад, дотоод аюул заналхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн байна. Тагнуулын мэдээллийг Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга болон холбогдох байгууллагуудад хүргэх;
- Төрөөс үндэсний аюулгүй байдлын талаар баримтлах бодлого, төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад холбогдох мэдээллийг хүргүүлэх;
- холбогдох байгууллагуудад тагнуулын үйл ажиллагааны талаар чиглэл өгөх тухай саналыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Ерөнхий сайдад оруулах;
- тагнуулын болон сөрөх тагнуулын үйл ажиллагааны талаарх техникийн асуудлаар зөвлөгөө өгөх, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо тогтооход туслалцаа үзүүлэх
- зэвсэгт хүчинд шаардлагатай гэж үзсэн Жанжин штабын мэдээлэл, тагнуулын мэдээллийг Жанжин штабын төв байгууллагад хүргүүлэх;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс тогтоосон бусад дүрэм, журмыг хэрэгжүүлэх;
- сөрөх тагнуулын үйл ажиллагаа эрхлэх;
- гадаад аюулгүй байдал, терроризмтой тэмцэх, үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлуудад Ерөнхийлөгч эсхүл Сайд нарын Зөвлөлийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
- гадаад тагнуул, үндэсний батлан хамгаалах, терроризм ба олон улсын гэмт хэрэг, кибер аюулгүй байдалтай холбоотой бүх төрлийн техникийн тагнуул, тагнуулын журам, хэрэгсэл, системийг ашиглан мэдээлэл, баримт бичиг цуглуулах, бүртгэх, дүн шинжилгээ хийх, шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх

Үндэсний тагнуулын байгууллагын шууд удирдлага дор ажилладаг харьяа газар хэлтсүүдийн талаар товч дурдвал:

Аюулгүй байдлын мөрдөн байцаах газар - Туркийн үндэсний аюулгүй байдлын хүрээнд олон нийтийн байгууллага, архивын мөрдөн байцаалт, аюулгүй байдлын мөрдөн байцаалтыг явуулж, холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Аюулгүй байдлын тагнуулын газар - Туркийн үндэсний бүрэн эрхт байдалд заналхийлж буй аюул, ялангуяа террорист халдлага, террорист үйл ажиллагааны тагнуулын мэдээллийг цуглуулах, эдгээр мэдээллийг боловсруулах, эрх бүхий байгууллагад танилцуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Сөрөх тагнуулын газар - Гадаад улсын тагнуулын байгууллага болон хувь хүмүүс БНТУ-ыг тагнаж буй тагнуулын үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын гүйцэтгэнэ.

Гадаад тагнуулын газар - БНТУ-ын стратегийн ашиг сонирхлыг хамгаалах, хөгжүүлэх хүрээнд гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах, судалгаа шинжилгээ хийх үүрэгтэй.

Цахим техникийн тагнуулын газар - Бүх төрлийн техникийн тагнуулын журам, багаж хэрэгсэл, системийг ашиглан мэдээлэл, баримт бичиг, мэдээ, мэдээллийг цуглуулах, бүртгэх, дүн шинжилгээ хийх, тагнуулын дүн шинжилгээг шаардлагатай байгууллагуудад хүргүүлнэ.

БНТУ-ын хувьд тагнуулын мөрдөн шалгах нууц ажиллагаа нь улсын аюулгүй байдлын чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Тагнуулын мөрдөн шалгах нууц ажиллагаа нь иргэн, бүлэг, байгууллага зэрэг эх сурвалжаас олж авсан мэдээ мэдээлэл, баримт бичгийг боловсруулсны үр дүнд гарсан үйл ажиллагааны чиглэлийг урьдчилан тодорхойлох зорилгоор хийгддэг ажил гэж ойлгож болно. Ирээдүйгээ харж, тулгарч болзошгүй асуудлын талаар урьдчилан сэргийлэх, мэдлэг, мэдээлэлтэй байх, нууц үйл ажиллагааны баримтуудыг илрүүлж ажиллах, болсон үйл явдлын талаар цуглуулсан баримтуудад дүн шинжилгээ хийж, ангилж үнэлнэ.

Тагнуулын үйл ажиллагааг үндсэн 4 үе шаттай гэж үзэж болно. Үүнд:

- **Тагнуулын хэрэгцээг тодорхойлох, дүн шинжилгээ хийх** - Ерөнхийлөгч, Жанжин штабын дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга, холбогдох яамдаас гаргасан хүсэлт, хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдээлэл цуглуулах үе шатуудыг хамардаг. Төрийн үндэсний аюулгүй байдлын бодлоготой холбоотой төлөвлөгөөг Үндэсний тагнуулын байгууллагын тухай 2937 дугаартай хуулийн хүрээнд Төрийн тагнуулын байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг.

- **Мэдээлэл цуглуулах** - Мэдээлэл цуглуулах эх сурвалжуудыг “нээлттэй” ба “хаалттай” мэдээлэл гэж хоёр ангилна. Сонин, сэтгүүл, ном, гарын авлага, радио, телевизийн нэвтрүүлэг, вэбсайт цахим орчинд мэдээлж буй нь нээлттэй эх сурвалж юм. Харин эх сурвалжууд нь тодорхойгүй, мэдээллийг цуглуулахдаа техник технологийн тусламжтайгаар тагнуулын байгууллагын хэрэгцээнд мэдээллийг нэгтгэх нь хаалттай арга хэлбэр гэж үздэг байна.

- **Мэдээлэл боловсруулах** - Мэдээлэл цуглуулах нэгж, байгууллагуудаас ирсэн мэдээлэл, баримт бичгийг ангилж, үнэлгээ хийж боловсруулдаг. Мэдээллийг нэгтгэж, ангилах бол эхний үе шат юм. Харин хоёр дахь үе шат бол үнэлгээ хийх, өөрөөр хэлбэл тагнуулын мэдээллийн үнэ цэнэ, мэдээлэл авсан эх сурвалжийн найдвартай байдал, мэдээллийн үнэн зөв эсэхийг тодорхойлох явдал юм. Энэ алхмыг хийсний дараа ач холбогдлыг тодорхойлж тайлбар хийж болно.

- **Мэдээллийг түгээх, ашиглах** - Үнэлгээ, дүн шинжилгээ хийж боловсруулсан тайланг холбогдох эрх бүхий байгууллагуудад цаг тухайд нь түргэн шуурхай түгээх нь гол ач холбогдол нь юм. Холбогдох байгууллагууд тагнуулын эдгээр тайланг ашиглахаас гадна

хяналт тавьж, үнэлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд тагнуулын шинэ хэрэгцээг тодорхойлдог байна.

2.3.3. Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах газар:¹⁰¹


Дотоод хэргийн яамны 2012 оны 12 сарын 28-ны өдрийн тогтоолоор **Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах газар** нь Цагдаагийн ерөнхий газрын харьяанд байгуулагдсан. Үйл ажиллагаагаа 2013 оны 01-р сарын 28-нд эхлүүлсэн ба мөнгө угаах гэмт хэрэг, терроризмтой тэмцэх үүрэг бүхий байгууллага юм. Үйл ажиллагааны хамрах хүрээ, эрх зүйн орчинг дараах хуулиар зохицуулж байна. Үүнд:

- БНТУ-ын Эрүүгийн хууль;¹⁰²
- Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх тухай 4208 дугаартай хууль;¹⁰³
- Гэмт хэргээс олсон орлогыг угаахаас урьдчилан сэргийлэх тухай 5549 дугаартай хууль;¹⁰⁴
- Эд хөрөнгийн тухай хууль.

Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах газар нь гэмт хэргийн шинжтэйгээр олсон орлого, терроризмыг санхүүжүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хяналт, дүн шинжилгээ хийх, судлах, шалгах ба энэхүү үйл ажиллагааны хүрээнд дараах үүрэгтэй. Үүнд:

- гэмт хэргээс олсон орлого, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх хүрээнд мэдээлэл цуглуулах, сэжигтэй гүйлгээний тайланг илрүүлж дүн шинжилгээ хийх, бүртгэх, тагнуулын мөрдлөг хийх, шаардлагатай мэдээлэл болон тагнуулын дүн шинжилгээний үр дүнг холбогдох байгууллагад мэдээлэх;
- мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдсэн ноцтой сэжиг бүхий тохиолдолд Улсын прокурорын газарт асуудлыг шилжүүлэх;
- гэмт хэргийн нотлох баримт дээр дүгнэлт хийх, бусад хотуудад байрлах салбар нэгжүүдтэйгээ хамтран ажиллах;
- сэжигтэй мөнгөн гуйвуулгын хүрээнд ирсэн мэдээллүүдэд хяналт шинжилгээ хийх;
- хууль бусаар хил нэвтрүүлэх, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;
- БНТУ-ын Эрүүгийн хуулийн (ТСК) 282-ын хүрээнд гэмт хэргийг мөрдөн шалгах;
- Сургалт семинар зохион байгуулах;
- CARIN замаар гэмт хэргээс олсон орлогыг судлан олон улсын тагнуулын албанд харилцан мэдээлэх.

Мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа, шинж чанараасаа шалтгаалан хоёр янзаар хийгддэг. (Зураг 2.)



¹⁰¹ <https://www.egm.gov.tr/>

¹⁰² <https://www.mevzuat.gov.tr/mevzuat?MevzuatNo=5237&MevzuatTur=1&MevzuatTertip=5>

¹⁰³ Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх тухай 4208 дугаартай хууль - Kararın Aklanmasının Önlenmesine Dair Kanun

¹⁰⁴ <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5549.pdf>

Зураг 2. Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах арга замууд



Санхүүгийн мөрдөн байцаах үйл ажиллагаа нь дараах байдлаар явагдана:

- гэмт хэрэг үйлдсэн гэсэн урьдчилсан мэдээлэл;
- судлах хүмүүсийг тодорхойлох;
- орлогын эх үүсвэрийг тодорхойлох;
- хөрөнгийн талаарх мэдээллийг тодорхойлох;
- бүртгүүлсэн орлого, хөрөнгийн харьцуулалт;
- мэдээллийн үнэлгээ (учир шалтгааны холбоо);
- үр дүнг дүгнэх.

2.3.4.Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн шалгах хороо¹⁰⁵

Гүйцэтгэх ажиллагааны газрын эрх зүйн байдал, үйл ажиллагаатай холбоотой харилцааг Цагдаагийн байгууллагын үүрэг, хариуцлагын тухай хуулиар¹⁰⁶ зохицуулах ба энэ хуулийн **зорилго** нь Цагдаагийн байгууллага нийтийн хэв журам, иргэдийн амь нас аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалах явдал юм.

Гүйцэтгэх ажиллагааны газар нь үйл ажиллагаандаа хүний эрх, эрх чөлөөг хангаж ажиллана гэж тусгасан байдаг. Хүний эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг шалгах, мөрдөн байцаах, үр дүнг үнэлэх ажлыг Хүний эрхийн дээд зөвлөл байгуулах тухай¹⁰⁷ 4643 тоот хуулиар зохицуулсан байна. Энэ хуулийн дагуу эрх нь зөрчигдсөн хүмүүс гомдол гаргах боломжтой бөгөөд цахим хуудсыг Цагдаагийн ерөнхий газрын харьяа Гүйцэтгэх ажиллагааны газар ажиллуулдаг. Энэ сайтад ирүүлсэн мэдэгдэл, гомдлыг үнэлэх, үр дүнгийн дагуу шаардлагатай арга хэмжээг авах зорилгоор Дотоод хэргийн яаманд **хүний эрх зөрчсөн нэхэмжлэлийн дагуу** Мөрдөн шалгах хороог байгуулсан. Хүний эрхийг зөрчсөн, ялангуяа эрүүдэн шүүх, хүчирхийлэлд өртсөн гэж үзэх асуудлыг гүйцэтгэх ажиллагааны газрын сайтад мэдээлж "ihb@basbakanlik.gov.tr" хаягаар шууд гомдол гаргах боломжтой байдаг байна. Хороо нь хүний эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг газар дээр нь мөрдөн шалгах үүрэгтэй.

Хүний эрх зөрчсөн тухай гомдлыг мөрдөн шалгах хороог байгуулахдаа Хүний эрхийн дээд зөвлөл байгуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар Ерөнхий сайд, Хууль зүй, Дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам, Үндэсний боловсролын яам, Эрүүл мэндийн яамны төлөөллөөс бүрддэг байна. Мөн хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллагууд хамтран ажилладаг. Эдгээр төлөөлөгчдийг Дотоод хэргийн яам болон Цагдаагийн ерөнхий газар тогтооно.

Мөрдөн шалгах хорооны үйл ажиллагаа, хамрах хүрээ:

- хүний эрхийг хамгаалах, хөгжүүлэхтэй холбогдсон захиргааны болон эрх зүйн зохицуулалтын талаар судалгаа хийж, шаардлагатай санал гаргах;

¹⁰⁵ <https://onlineislemler.egm.gov.tr/Sayfalar/insanhaklari.aspx>

¹⁰⁶ <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.3.2559.pdf>

¹⁰⁷ <https://www.mevzuat.gov.tr/mevzuat?MevzuatNo=6311&MevzuatTur=7&MevzuatTertip=5>

- одоогийн хууль тогтоомж хүний эрхийн үндсэн зарчим, олон улсын баримт бичиг, механизмтай уялдуулан зөвлөмж гаргах;
- хүний эрхийн асуудлаар Ерөнхий сайд, яамд, төрийн бусад байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх;
- НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Туркийн нэгдэн орсон хүний эрхийн тухай олон улсын конвенцод заасны дагуу хүний эрхийг орчин үеийн болон түгээмэл стандартын дагуу хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр хийх ажлыг зохион байгуулах;
- хүний эрхийн зөрчил, салбарт гарч буй өөрчлөлтүүдийн талаар олон нийтэд мэдээлэх зорилгоор судалгаа, дүн шинжилгээ хийх;
- олон нийтийн байгууллагаас хэрэгжүүлж буй хүний эрхийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, төрийн бус байгууллагын хүний эрхийн сургалтын үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах;
- Хүний эрхийн боловсролын үндэсний хороонд ажиллах багш, төлөөлөгчдийг илгээх сайн дурын байгууллагуудыг сонгон шалгаруулж, хорооны ажлыг хянах, үнэлэх, чиглүүлэх;
- байгууллагын төлөөллөөс бусад Хүний эрхийн зөвлөх зөвлөлийн гишүүдийг сонгох, тэдний ажилд хяналт, үнэлгээ хийх;
- хүний эрх зөрчигдсөнтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж гаргах.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД БА ХЯНАЛТ

3.1. Эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсад гүйцэтгэх ажлыг *Гүйцэтгэх ажлын тухай хуулийн*¹⁰⁸ дагуу тагнуул, цагдаа, шүүхийн гүйцэтгэх болон авлигатай тэмцэх байгууллагууд явуулна. (§9.1) Эдгээр байгууллагуудын гүйцэтгэх ажил явуулах нийтлэг үндэслэл, гүйцэтгэх ажлын зарчим, арга хэрэгсэл, гүйцэтгэх ажил явуулах нийтлэг журам зэргийг Гүйцэтгэх ажлын тухай хуулиар зохицуулдаг. (§1)

Гүйцэтгэх байгууллагуудын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, гүйцэтгэх ажил явуулах, хэрэг шалгах журам зэрэг нь харилцан адилгүй, өөр өөрийн гэсэн онцлогтой байдаг тул дээрх байгууллагуудын гүйцэтгэх ажилтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулиудаар нарийвчлан зохицуулж байдаг. Үүнд:

- Тагнуулын байгууллагын тухай хууль (1999)¹⁰⁹
- Цагдаагийн албаны тухай хууль (1999)¹¹⁰
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017)¹¹¹
- Авлигын эсрэг хууль (2006)¹¹² зэрэг болно.

Судлаачдын зүгээс Гүйцэтгэх ажлын тухай хууль батлагдан гарч холбогдох байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдүүлсэн нь гүйцэтгэх ажил явуулах үндсэн зарчим, нөхцөлүүдийг хэлбэрэлтгүй сахиулахад ач холбогдолтой болсны дээр, хуульчлан тогтоосон арга хэрэгслийн амьдралын шалгуур даах чадварыг сорих, гүйцэтгэх

¹⁰⁸ Гүйцэтгэх ажлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1998 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰⁹ Тагнуулын байгууллагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 35 дугаарт нийтлэгдсэн.

¹¹⁰ Цагдаагийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

¹¹¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

¹¹² Авлигын эсрэг хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 35 дугаарт нийтлэгдсэн.

ажил эрхлэн явуулдаг байгууллага, ажилтанг хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зохион хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үндэслэлд прокурорын зүгээс хяналт тавих боломжийг бүрдүүлэхэд тус нэмэртэй болсон¹¹³ хэмээн энэ хуулийн талаар үнэлжээ.

Ийнхүү 20 гаруй жилийн хугацаанд үүргээ “зохих хэмжээнд” гүйцэтгэсэн уг хуулийг шинэчлэх шаардлагатай хэмээн зарим судлаачид үзэж байна. Тодруулбал, ойлголт, нэр томъёог оновчтой тодорхойлох, гүйцэтгэх ажил явуулах үндэслэл, хүрээг зөв тогтоох, гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажилд хяналт тавихтай холбоотой зарим зохицуулалтыг практик хэрэглээнд нийцүүлэх, бусад хууль тогтоомжтой уялдуулан шинэчлэх зайлшгүй шаардлага аль хэдийн үүссэн гэсэн байна.¹¹⁴

Гүйцэтгэх ажлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд:

1997 онд батлагдсан Гүйцэтгэх ажлын тухай хуульд нийт 12 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд тэдгээрийн ихэнх нь гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэгтэй холбоотой өөрчлөлтүүд байжээ.

(Уг хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг огноогоор болон заалтаар нь Хүснэгт 1, 2-оос үзнэ үү.)

Тухайлбал, **1999 онд Тагнуулын байгууллагын тухай хууль** батлагдаж, Улсын аюулгүй байдлыг хангах газар (1996-2000 он) нь Тагнуулын ерөнхий газар гэж нэрээ өөрчилсөн¹¹⁵, **2006 онд** Авлигын эсрэг хууль батлагдаж Авлигатай тэмцэх газар байгуулагджээ.

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр **Үндэсний аюулгүй байдлын тухай хууль** батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Мөн Монгол Улсын Хилийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан Гүйцэтгэх ажлын тухай хуульд хилийн тагнуулын байгууллагатай холбоотой зохицуулалт нэмэгджээ. Тодруулбал, Улсын Их Хурал (УИХ)-ын 2000 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 дугаар бүлгийн 2-т “хилийн цэргийн бие даасан тогтолцоог бий болгоно” гэж, Засгийн газрын 2000 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний 5-2.1-ийн 751-д “улсын хил хамгаалах шаардлагыг үндэслэн тагнуул, хэрэг бүртгэх алба, нисэх бүрэлдэхүүн, сургууль, эмнэлгийн хөдөлгөөнт бүлэгтэйгээр хил хамгаалах байгууллагын бие даасан бүтцийг бий болгож бэхжүүлнэ” гэж тус тус тусгасан байжээ. Эдгээр зорилтыг биелүүлэх үүднээс Монгол Улсын Хилийн тухай хуульд өөрчлөлт оруулж, үүнтэй холбогдуулан Монгол Улсын Тагнуулын байгууллагын тухай, Гүйцэтгэх ажлын тухай, Монгол Улсын Батлан хамгаалах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиуд, “Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндсийг батлах тухай” УИХ-ын 1998 оны 56 дугаар тогтоолын хавсралтад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Харин **2002 онд** Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дүр мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.” гэсэн үзэл санааг Гүйцэтгэх ажлын тухай хуульд тусгах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулжээ.¹¹⁶

2013 онд батлагдсан Тахарын албаны тухай хуулийн дагуу “шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах” чиг үүрэгтэй Засгийн газрын хэрэгжүүлэгч

¹¹³ М.Батсайхан, Л.Батдолгор. Гүйцэтгэх ажил. УБ., 2000. 8 дахь тал.

¹¹⁴ Ч.Доржсүрэн. “Гүйцэтгэх ажлын тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ шаардлага”. “Тусгаар тогтнол” сэтгүүл, 2020 №3 (51), 92-103 дугаар тал.

¹¹⁵ Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/23/item/92>

¹¹⁶ УИХ-ын 2002 оны хаврын чуулганы 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлээс. УИХ-ын цахим хуудас - <http://www.parliament.mn/n?cid=98&page=3>

агентлаг болох Тахарын алба байгуулагдаж байжээ. Харин **2016 онд Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн дагуу Тахарын албаны тухай хууль хүчингүй болж Тахарын алба татан буугдсан байна.

2015 оны 7 дугаар сарын 09-ний өдөр *Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль* батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх ажлын тухай хуульд ихээхэн өөрчлөлт орсон. Тодруулбал, гүйцэтгэх ажил явуулах үндэслэл, гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн нэршил, гүйцэтгэх ажилд хориглох зүйл, гүйцэтгэх ажлын үр дүнг хүлээн авах, танилцах, шилжүүлэх, прокурорын хяналт, гүйцэтгэх ажилтны албан тушаалд иргэнийг судлах, сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах, туслагч, туслах ажилтан ажиллуулах, санхүүжилт, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт орж, 5 заалт хүчингүй болжээ.

2016 онд Төрийн болон албаны нууцын тухай хууль, **2017 онд** Цагдаагийн албаны тухай хууль, хамгийн сүүлд буюу **2020 онд Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль** батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 1. Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байдал (огноогоор)

№	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо	Нэмэлт, өөрчлөлт орсон шалтгаан
1.	1999.07.08	Тагнуулын байгууллагын тухай хууль батлагдсан
2.	2001.12.27	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль батлагдсан
3.	12.27	Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан
4.	2002.04.19	Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд нийцүүлсэн
5.	2006.07.06	Авлигын эсрэг хууль батлагдсан
6.	2013.07.05	Тахарын албаны тухай хууль батлагдсан
7.	2015.07.09	Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан
8.	10.30	Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан
9.	2016.07.21	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан
10.	12.01	Төрийн болон албаны нууцын тухай хууль батлагдсан
11.	2017.02.09	Цагдаагийн албаны тухай хууль батлагдсан
12.	2020.05.14	Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан

Нэмэлт, өөрчлөлт орсон хуулийн зүйл, заалтыг давтамжаар нь авч үзвэл:

Хүснэгт 2. Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байдал (заалтаар)

№	Нэмэлт, өөрчлөлт орсон зохицуулалт	Нэмэлт, өөрчлөлт орсон давтамж
1.	§9. Гүйцэтгэх байгууллагатай холбоотой зохицуулалтад	8 удаа
2.	§11. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэлд	7 удаа
3.	§6. Хуулийн нэр томъёонд	5 удаа
4.	§8. Гүйцэтгэх ажилд хориглох зүйлд	3 удаа
5.	§12. Гүйцэтгэх ажил явуулах хүрээнд	
6.	§13. Гүйцэтгэх байгууллага, тэдгээрийн ажилтны бүрэн эрхтэй холбоотой зохицуулалтад	2 удаа
7.	§18. Гүйцэтгэх ажлын үр дүнг ашиглахтай холбоотой зохицуулалтад	
8.	§2. Гүйцэтгэх ажилтай холбоотой зохицуулалтад	1 удаа

9.	§3.	Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжид
10.	§14.	Туслагч, туслах ажилтан ажиллуулахтай холбоотой зохицуулалтад
11.	§15.	Гүйцэтгэх ажлын санхүүжилттэй холбоотой зохицуулалтад
12.	§21.	Гүйцэтгэх ажлын нууцыг хамгаалах, хадгалахтай холбоотой зохицуулалтад
13.	§23.	Гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналтад
14.	§24.	Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагад

(Гүйцэтгэх ажлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү.)

3.2. Гүйцэтгэх байгууллагуудын гүйцэтгэх ажлын зорилго, хүний эрхийг хангах нь:

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйлд зааснаар **гүйцэтгэх ажил** гэж үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг ойлгоно.

Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт гүйцэтгэх ажил явуулах эрх, 11 дүгээр зүйлд гүйцэтгэх ажил явуулах үндэслэл, 12 дугаар зүйлд гүйцэтгэх ажил явуулах хүрээг тус тус зохицуулсан. Гүйцэтгэх ажил явуулах эрх болон үндэслэлийг гүйцэтгэх байгууллага тус бүрээр хойно авч үзнэ. Харин гүйцэтгэх ажил явуулах хүрээг дараах байдлаар хязгаарласан. (§12) Үүнд:

- гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой бусад мэдээ олох гадаад тагнуулын үйл ажиллагаа;
- Монгол Улсын эсрэг гадаадын улс, байгууллага, иргэн, тэдгээрийн төлөөний этгээдийн зүгээс явуулж байгаа тагнуул, хорлон сүйтгэх ажиллагаа болон тагнуулын байгууллагын харьяаллын гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн сөрөх тагнуулын үйл ажиллагаа;
- дээр зааснаас бусад гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход чиглэсэн эрэн сурвалжлах ажил;
- оргон зайлсан гэмт этгээдийг баривчлах, барьцаанд байгаа хүнийг суллах, сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүнийг эрж олох ажил;
- алдагдсан нууц бичиг баримт, эд зүйл, галт хэрэгсэл, зэвсэг, тэсрэх болон хүчтэй хордуулах, цацраг идэвхт, мансууруулах бодис, түүх, соёлын дурсгалт зүйл, нуугдмал эд хөрөнгийг эрж олох;
- хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаанд шаардлагатай нотлох баримтын эх сурвалжийг олж тогтоох зэрэг болно.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар гүйцэтгэх ажилд дор дурдсан зарчмыг удирдлага болгоно. (§4) Үүнд:

- үндэсний болон нийгэм, төр, иргэний аюулгүй байдлыг хангах;
- хууль дээдлэх;
- шударга ёс, тэгш байдал, **хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх**;
- шуурхай, тасралтгүй байх;
- нууц хамгаалах зэрэг болно.

Гүйцэтгэх ажилын явцад түүнд оролцогчдын эрх, эрх чөлөөг хангах нь нэгд - үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах, хоёрт - гэмт хэрэгт холбогчийн эрх, эрх чөлөөг хязгаарлахдаа түүний Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хангах асуудал хамаарч байна.

Монгол Улсын Үндсэн хуульд **“Монгол улсын иргэн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглох”**¹¹⁷ бөгөөд **“Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”** гэж Монгол Улсын иргэний эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан байдаг. Мөн **“Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй”**¹¹⁸ гэж заасан байна.

Тэгвэл Үндсэн хуульд иргэний эрх, эрх чөлөөг түр хязгаарлахтай холбоотой зарим зохицуулалтыг мөн тусгаж өгчээ. Тухайлбал, **“Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”** гэж заасан бөгөөд энэхүү үүргээ хэрэгжүүлэхдээ **“зөвхөн хуульд заасан үндэслэл бүрдсэн”** тохиолдолд зохих хязгаарлалтыг авч хэрэгжүүлнэ.

Гүйцэтгэх ажлын явцад **хүний эрх, эрх чөлөөг** дараах байдлаар хамгаална. (§7) Үүнд:

- гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны улмаас эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа хувь хүн, хуулийн этгээд зохих дээд шатны байгууллага, албан тушаалтан, прокурорт гомдол гаргах эрхтэй;
- гүйцэтгэх байгууллага, түүний ажилтан нь хуулиар олгосон эрх хэмжээгээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж хууль бусаар иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон бол дээр дурдсан байгууллага, албан тушаалтан болон шүүх зөрчигдсөн эрхийг нь сэргээж, учирсан хохирлыг арилгах арга хэмжээг тус тусын чиг үүрэг, хууль тогтоомжид заасны дагуу авна.

Гүйцэтгэх ажлын явцад хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дор дурдсаныг хориглоно. (§8.7) Үүнд:

- хүний эрх, эрх чөлөөг зөрчих;
- хууль ёсны ашиг сонирхолд нь халдах;
- гүйцэтгэх ажлын үр дүнг хууль бусаар ашиглах;
- гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлтийг хуурамчаар үйлдэх;
- хуульд зааснаас бусад тохиолдолд гүйцэтгэх ажлын явцад олсон хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулах зэрэг болно.

Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагууд нь иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлахад хүргэх гүйцэтгэх ажлын аливаа арга хэмжээг зохион байгуулахдаа дараах асуудлуудыг анхаарч ажиллах нь зүйтэй гэж судлаачид үздэг. Үүнд:

- түүнийг зохион байгуулах зайлшгүй шаардлага байгаа эсэх;
- хууль, эрх зүйн үндэслэл байгаа эсэх;
- гарч болох үр дүнг бодитой тооцсон эсэх зэргээс гадна тухайн арга хэмжээг зохиох явцад хүний эрх, эрх чөлөөнд халдаж байгаа гэдгээ ухамсарлаж, оновчтой шийдвэр гаргах нь чухал юм.

Хэрэв тийм арга хэмжээг зохиох зайлшгүй шаардлага, хууль зүйн үндэслэл байна гэж үзвэл холбогдох хууль, журмын дагуу аль болох богино хугацаанд хэрэгжүүлэхийг эрмэлзэх нь чухал юм. Гэвч гүйцэтгэх ажлыг зохион байгуулах цар хүрээ, нөхцөл байдал, онцлогоос шалтгаалан үргэлжлэх цаг хугацааны хувьд харилцан адилгүй явагддаг. Тухайлбал, Тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажлын зорилго, төсөв, цар хүрээ, нөхцөл байдал зэргээс шалтгаалан илүү урт хугацаанд зохион байгуулах шаардлага үүсдэг


¹¹⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэг: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

¹¹⁸ Монгол Улсын Үндсэн хууль 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.

бөгөөд энэ нь эрх бүхий бусад байгууллагуудаас ихээхэн ялгаатай байдаг.

Гүйцэтгэх ажлыг дараах дөрвөн байгууллага явуулна (§9.1):

Зураг 3. Гүйцэтгэх байгууллагууд



Эдгээр байгууллагуудын гүйцэтгэх ажил явуулах зорилго, үндэслэл, гүйцэтгэх ажлын явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар эрх зүйн актуудад хэрхэн зохицуулсан талаар авч үзье.

3.2.1. Тагнуулын ерөнхий газар

Тагнуулын байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар тагнуулын байгууллага гэж Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг тагнуулын арга замаар хангах зорилго бүхий байгууллагуудын тогтолцоог хэлнэ.

Тагнуулын байгууллага нь дараах **зорилгоор** гадаад тагнуул, цэрэг-стратегийн болон хилийн тагнуул, сөрөх тагнуулын чиглэлээр гүйцэтгэх ажил явуулах тухай Гүйцэтгэх ажлын тухай хуульд тусгасан байна. (§9.1.1) Үүнд:

- гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий бусад мэдээ олох, дэмжлэг үзүүлэх;
- үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй гадаад, дотоод эрсдэл, аюул, занал, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох.

Тагнуулын байгууллага нь гадаад тагнуул, сөрөх тагнуул, цэрэг-стратегийн болон хилийн тагнуулын үйл ажиллагааг тагнуулын байгууллага Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, энэ талаарх төрийн бодлогын үндсийг удирдлага болгон өөрт нь байгаа болон ирсэн мэдээллийг **үндэслэн** өөрийн үзэмжээр явуулна. (§11.1)

Тагнуулын байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар тус байгууллага нь үйл ажиллагааныхаа чиглэлээр дараах гүйцэтгэх ажлыг явуулна:

- Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалах, үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй гадаад, дотоод эрсдэл, аюул, занал, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;
- Монгол Улсын хил, Зэвсэгт хүчин, бусад цэргийн аюулгүй байдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд гүйцэтгэх ажлын шугамаар хамгаалах;
- гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах зэрэг болно.

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа хэд хэдэн **зарчмыг** удирдлага болгохыг хуульчилсны нэг нь **“хүний эрх, эрх чөлөөг хангах”** зарчим багтсан байдаг. (§5.1) Энэхүү зарчмыг дараах байдлаар хангаж ажиллана. (§6) Үүнд:

- хуульд зааснаас бусад тохиолдолд хүний эрх, эрх чөлөөнд халдах, хязгаарлахыг хориглоно;

- иргэн, хуулийн этгээд өөрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг тагнуулын ажилтан хууль бусаар зөрчсөн гэж үзвэл тухайн ажилтныг шууд харьяалах дээд албан тушаалтан, байгууллагад гомдол гаргах эрхтэй;
- иргэн, хуулийн этгээдээс тагнуулын байгууллагад гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэнэ;
- тагнуулын байгууллагын албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцад иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хууль бусаар зөрчсөн бол тагнуулын байгууллага өөрөө, эсхүл прокурор, шүүх нь тухайн иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, эрх чөлөөг сэргээж, учруулсан хохирлыг арилгах, гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үүрэгтэй;
- тагнуулын үйл ажиллагааны явцад тодорхой болсон иргэний нэр төр, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж болох хувийн амьдралтай нь холбоотой мэдээ, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд гагцхүү уг хүний зөвшөөрснөөр ил болгож болно.

Мөн тагнуулын ажилтан нь “хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах, эрхийг нь хязгаарлах”-ыг Тагнуулын тухай хуулийн 19.2.1-т хориглосон.

3.2.2.Цагдаагийн ерөнхий газар:

Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба юм.

Цагдаагийн байгууллага нь Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9.1.3-д заасан зорилгоор **гүйцэтгэх ажил** явуулах эрхийг, 11.2-д заасан үндэслэлээр **эрэн сурвалжлах ажлыг** гүйцэтгэнэ.

Тус байгууллага нь дараах **зорилгоор** гүйцэтгэх ажил явуулна. (§9.1.3) Үүнд:

- тагнуулын байгууллагад хамаарахаас бусад далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох;
- олон нийтийн аюулгүй байдал болон шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх;
- сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах;
- алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олно.

Энд дурдагдсан **эрэн сурвалжлах ажил** гэдэг нь “Тагнуулын байгууллага цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжоор харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх нууц ажиллагаа”-г ойлгохыг Гүйцэтгэх ажлын тухай хуульд тодорхойлсон байна. (§6.2)

Цагдаагийн байгууллага эрэн сурвалжлах ажлыг дор дурдсан **үндэслэлийн** аль нэг нь байвал гүйцэтгэнэ. (§11.2) Үүнд:

- хуулиар харьяалуулсан гэмт хэргийг далд аргаар үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай үндэслэл бүхий мэдээллийг ердийн арга хэрэгслээр шалгах боломжгүй;
- хуулиар харьяалуулсан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг өөр арга, хэрэгслээр олж тогтоох боломжгүй;
- эрүүгийн хэргийн нотолгоог бүрэн гүйцэд шалгах зорилгоор шүүх, прокурор, мөрдөн байцаагчаас даалгавар ирүүлсэн;
- барьцаанд байгаа хүнийг суллах, сураггүй алга болсон хүнийг эрж олох талаар байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт буюу өөрт байгаа баримтыг үндэслэн;
- алдагдсан нууц баримт бичиг, эд зүйлийг эрж олох талаар байгууллага, иргэдээс хүсэлт ирүүлсэн;
- эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг Монгол Улстай байгуулсан гадаад улс, олон улсын байгууллагаас хүсэлт ирүүлсэн зэрэг байна.

Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн алба, алба хаагчдын үйл ажиллагаандаа баримтлах хэд хэдэн **зарчмуудыг** тусгасан бөгөөд түүнд **“хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх”** зарчим багтана. (§5.1) Мөн цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагаандаа **“хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх”** нийтлэг шаардлагыг хэрэгжүүлэх (§22.1), **“хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах”**-ыг хориглосон байна (§69.1).

3.2.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт зааснаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг “гүйцэтгэх ажиллагаа”-г шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлнэ.

Гүйцэтгэх ажлын тухай хуульд зааснаар шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба нь дараах **зорилгоор** гүйцэтгэх ажил явуулна. (§9.1.4) Үүнд:

- хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх;
- оргосон хоригдлыг баривчлах;
- бусад гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх ажилд дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

Мөн хорих ял эдлүүлэх байгууллага нь дээрх зорилт (жич: хуульд ийнхүү томьёоллоор орсон байна)-ыг хэрэгжүүлэхийн тулд хоригдлын дунд, түүнчлэн оргосон ялтныг баривчлах зорилгоор эрэн сурвалжлах ажил явуулна. (§11.4)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дор дурдсан ажиллагаа хамаарна (§6.1). Үүнд:

- иргэний хэргийн;
- захиргааны хэргийн;
- зөрчлийн хэргийн;
- эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зэрэг болно.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байх ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх дээрх дөрвөн ажиллагаа тус бүрийг явуулах шийдвэрийг хуулийн 6 дугаар зүйлд тодорхой заасан байна. (§5)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь төрийн сүлдэндээ “...хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн...” ажиллахаа батлан тангараглагдаараа гүйцэтгэх бусад байгууллагын албан хаагчдын тангаргаас ялгаатай аж. (§274.1)

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа баримтлах **зарчимд** “хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах” гэж заасан байна. (§4) Үүнийг мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлагад тусгагдсан (§7) ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдахыг хориглоно (§273.2).

3.2.4. Авлигатай тэмцэх газар:

2006 оны 7 дугаар сарын 05-ны өдөр Авлигын эсрэг хууль батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь хэсэгт “Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох **зорилгоор** гүйцэтгэх ажил явуулах, гэм буруутай этгээдийг олж тогтоох, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах” гэж нэмж оруулсан.

Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага хэмээн Авлигын эсрэг хуулийн 15 дугаар зүйлд тусгасан байна.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн дагуу тус байгууллага нь авлигын гэмт хэрэг болон хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт дараах **үндэслэлээр** гүйцэтгэх ажил явуулна. (§11.7) Үүнд:

- хуулиар харьяалуулсан гэмт хэргийг далд аргаар үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай үндэслэл бүхий мэдээллийг ердийн арга хэрэгслээр шалгах боломжгүй;
- хуулиар харьяалуулсан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг өөр арга, хэрэгслээр олж тогтоох боломжгүй;
- эрүүгийн хэргийн нотолгоог бүрэн гүйцэд шалгах зорилгоор шүүх, прокурор, мөрдөн байцаагчаас даалгавар ирүүлсэн;
- алдагдсан нууц бичиг баримт, эд зүйл, галт хэрэгсэл, зэвсэг, тэсрэх болон хүчтэй хордуулах, цацраг идэвхт, мансууруулах бодис, түүх, соёлын дурсгалт зүйл, нуугдмал эд хөрөнгийг эрж олох талаар байгууллага, иргэдээс хүсэлт ирүүлсэн;
- эрүүгийн хэргийн талаар эрх зүйн тусалцаа үзүүлэх гэрээг Монгол Улстай байгуулсан гадаад улс, олон улсын байгууллагаас хүсэлт ирүүлсэн.

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэгт зааснаар Авлигатай тэмцэх газар нь тодорхой хэрэгт гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах ба ингэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан журмыг баримтална.

3.3. Гүйцэтгэх ажилд тавих хяналт:

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 22, 23 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэх ажилд эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд дараах байдлаар хяналт тавина. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай танилцана;
- УИХ, Засгийн газар шаардлагатай гэж үзвэл өөрийн бүтэц дэх зохих нэгж, албан тушаалтнаар дамжуулан гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина;
- гүйцэтгэх байгууллагын дарга нь гүйцэтгэх ажилд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлнэ;
- прокурор хяналт тавина.

Судалгаанд гүйцэтгэх байгууллагын дарга болон прокурорын гүйцэтгэх ажилд тавих хяналтыг авч үзсэн болно.

3.3.1.Прокурорын хяналт:

Гүйцэтгэх ажлын тухай хуульд зааснаар гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналтыг Улсын Ерөнхий прокурор, түүний тусгайлан эрх олгосон прокурор дараах байдлаар нууцаар сонсох, харах тусгай техник хэрэгсэл ашиглаж хэрэгжүүлнэ (§23.3). Үүнд:

- харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих;
- шуудан харилцааг хянах;
- орон байр, барилга байгууламж, газар, тээврийн хэрэгсэл, ачаа, тээш, эд зүйлд нууц үзлэг хийх;
- нууцаар ажиглалт явуулах;
- хяналтын худалдан авалт зэрэг болно.

Гүйцэтгэх байгууллага нь прокурорын бичгээр урьдчилан өгсөн зөвшөөрлөөр хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд дээр дурдсан ажиллагааг явуулахаар хуульчилжээ. (§23.3)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд (2017)¹¹⁹ дээрх ажиллагааны нэр томъёоллыг “мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэж хуульчилсан байна. Энэ хуульд “Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах байгууллага, ажилтны үйл ажиллагааны зарчим, эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон энэ хуульд заагаагүй асуудлыг Гүйцэтгэх ажлын тухай хуулиар зохицуулна” хэмээн тусгажээ. (§16.8.3)

Гүйцэтгэх ажлын тухай хуульд прокурор гүйцэтгэх ажлын явцад авагдаж, эрүүгийн хэргийн нотлох баримт болгосон баримт сэлтийг хуульд заасан үндэслэл, нөхцөл, журмын дагуу цуглуулсан эсэхэд хяналт тавина. (§23.5)

Прокурорын тухай хуульд гүйцэтгэх ажил болон мөрдөн шалгах нууц ажиллагаанд тавих прокурорын хяналтыг тусгахдаа гүйцэтгэх ажлын хэрэг нээх, хаах ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаж байгаа эсэхийг хянана. (§25.2) Үүнд:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу мөрдөн шалгах нууц ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхийг хянах;
- Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэх ажилд хяналт тавих (үүнд, харилцаа холбооны сүлжээ, шуудан харилцаа, орон байр, барилга байгууламж, газар, тээврийн хэрэгсэл, ачаа зэрэгт хяналт тавих, үзлэг хийхээс гадна Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн нэгдсэн тоо бүртгэлд прокурор хяналт тавина);
- гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааны заавар, журмын хэрэгжилтэд хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хяналт тавих зэрэг болно.

Мөн прокурор нь мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавихдаа дараах бүрэн эрхтэй. (§25.2) Үүнд:

- гүйцэтгэх ажлын болон мөрдөн шалгах нууц ажиллагааны хэрэг нээх, хаах ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаж байгаа эсэхийг хянах;
- гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн нэгдсэн тоо бүртгэлд хяналт тавих;
- гүйцэтгэх ажлын болон мөрдөн шалгах нууц ажиллагааны нэгдсэн тоо бүртгэлд хяналт тавих;

¹¹⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

- эрх бүхий байгууллагаас явуулж байгаа мөрдөн шалгах нууц ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхийг хянах;
- эрх бүхий байгууллагаас ирүүлсэн мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажил явуулах саналтай танилцаж зөвшөөрөл олгох, зөвшөөрөл олгохоос татгалзах, тухайн ажиллагааны хугацааг сунгах, зогсоох, үр дүнг хянах;
- гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааны холбогдох материалтай танилцах;
- мөрдөгчийн магадалгааг хянаж баталгаажуулах;
- гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахаар эрх бүхий байгууллагад даалгавар бичих;
- хойшлуулшгүй тохиолдолд явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааг хүчинтэйд тооцуулах мөрдөгчийн саналыг хянаж, шийдвэрлэх;
- гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хяналт, шалгалт явуулах;
- гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн, эсхүл эрх бүхий байгууллагын ажилтан хууль тогтоомж зөрчсөн талаарх гомдлыг хянаж, буруутай этгээдэд хариуцлага тооцуулах арга хэмжээ авах.

3.3.2. Гүйцэтгэх байгууллагуудын хяналт:

Гүйцэтгэх байгууллагуудын дарга нар тухайн байгууллагынхаа гүйцэтгэх ажил явуулах хүрээнд дотоод хяналтыг тавьж ажиллана. Үүнд:

- 1) Тагнуулын ерөнхий газрын дарга;
- 2) Цагдаагийн ерөнхий газрын дарга;
- 3) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга;
- 4) Авлигатай тэмцэх газрын дарга зэрэг болно.

1) Тагнуулын ерөнхий газрын дарга:

Тагнуулын тухай хуульд зааснаар Тагнуулын ерөнхий газрын дарга нь гүйцэтгэх ажилтай холбоотой дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. (§15.1) Үүнд:

- тагнуулын болон гүйцэтгэх ажилд дагаж мөрдөх зааврыг хуульд нийцүүлэн гаргах, биелэлтэд нь хяналт тавих ажлыг зохион байгуулах;
- Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу нууц арга хүч, хэрэгсэл ашиглах зөвшөөрөл олгох;
- гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, шийдвэр гаргах;
- үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдыг мэдээллээр хангах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн болон Засгийн газрын хуралдаанд оролцож тагнуулын төв байгууллагын байр суурийг илэрхийлэх, зөвлөх эрхтэйгээр оролцох, мэдээлэл өгөх;
- гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батлах зэрэг болно.

Мөн тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд бусад байгууллага, албан тушаалтанд дараах байдлаар хяналт тавьж ажиллана. (§16) Үүнд:

- УИХ бүтцийнхээ зохих хэсгээр дамжуулан тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийг хэрхэн сахин биелүүлж байгааг хянан шалгаж, тагнуулын байгууллагын даргын илтгэл, мэдээллийг сонсоно;
- Монгол Улсын Ерөнхийлөгч-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн нь шаардлагатай гэж үзвэл тагнуулын байгууллагын даргын илтгэл, мэдээллийг сонсож, тэдгээртэй холбоотой үйл ажиллагаатай танилцаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тогтсоны үндсэн дээр үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар даалгавар өгнө;
- Монгол Улсын Ерөнхий сайд Тагнуулын ерөнхий газрын даргын мэдээллийг сонсож, тус байгууллагаас үндэсний аюулгүй байдлыг хангах талаар тухайн төсвийн жилд анхаарч ажиллах чиглэлийг тогтоож, төрийн бодлого боловсруулахад ач холбогдол бүхий мэдээ, баримт сэлт олох, хуулиар харьяалуулсан гэмт хэрэгтэй тэмцэх талаар даалгавар өгнө;
- Тагнуулын ерөнхий газрын дотоод хяналт-аюулгүй байдал хариуцсан нэгж нь тагнуулын байгууллагын албан хаагчийг гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын болон ашиг сонирхлын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих үүргийг хэрэгжүүлнэ.

2) Цагдаагийн төв байгууллагын дарга:

Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар тус байгууллагын дотоод хяналтыг цагдаагийн төв байгууллагын дарга хэрэгжүүлэх (§95.2) ба Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажилд тавих хяналтыг холбогдох хуулиар зохицуулна (§95.3) гэсэн байна.

Цагдаагийн төв байгууллагын дарга нь гүйцэтгэх ажилтай холбоотой дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ (§21.1.14; 21.1.15):

- халхавчийн байгууллага байгуулах, татан буулгах, нууц гүйцэтгэх ажилтан ажиллуулах, халах шийдвэр гаргах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын төсвийг төлөвлөх, УИХ-ын Тусгай хяналтын дэд хороогоор хянуулах, батлагдсан төсвийг захиран зарцуулах.

Дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлаас бусад асуудлаар Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хяналт тавина. (§95.4)

3) Шийдвэр гүйцэтгэх албаны дарга:

Шийдвэр гүйцэтгэх албаны дарга нь ерөнхий шийдвэр гүйцэтгэгч¹²⁰ байх бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана (§271.3.2). Үүнд:

Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжид заасны дагуу хяналт тавих (§300.1) бол прокурорын байгууллага нь зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавина (§300.2).

¹²⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэг., <https://www.legalinfo.mn/law/details/12701?lawid=12701>

4) Авлигатай тэмцэх газрын дарга:

Авлигатай тэмцэх газрын дарга нь гүйцэтгэх ажилтай холбоотой дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажилтай танилцах (§23.1.7);
- Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу нууц арга, хэрэгсэл ашиглах зөвшөөрөл олгох (§23.1.8);
- гүйцэтгэх ажлын техник хэрэгсэл олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах шийдвэр гаргах (§23.1.9);
- байгууллагынхаа ажилд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх (§23.1.10) зэрэг болно.

Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажилд тавих хяналтыг дараах байгууллагууд хэрэгжүүлнэ. Үүнд:

- Авлигатай тэмцэх газар гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгааг УИХ-ын Тусгай хяналтын дэд хороо хянан шалгана (§26.2);
- Прокурорын байгууллага нь Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд Гүйцэтгэх ажлын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу хяналт тавина (§26.3).

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Монгол Улс

- Монгол Улсын Үндсэн хууль
- Гүйцэтгэх ажлын тухай хууль
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
- Тагнуулын байгууллагын тухай хууль
- Цагдаагийн албаны тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
- Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль
- Прокурорын тухай хууль
- Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт “МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”
<https://www.legalinfo.mn/annex/details/8070?lawid=6163>
- Тагнуулын албадыг хянах нь., Хянан тохиолдуулсан Ханс Борн, Эйдан Уиллс., Улаанбаатар Бодлогын Судалгааны Төв. 2002 он
- Ч.Доржсүрэн. “Гүйцэтгэх ажлын тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ шаардлага”. “Тусгаар тогтнол” сэтгүүл, 2020 №3 (51). 92-103 дугаар тал. Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас <https://gia.gov.mn/50/item/853>

ОХУ

- “Хууль, хүчний байгууллагын албан хаагчид болон төрийн өндөр албан тушаалтнуудад холбогдох хэргийг мөрдөн шалгах хараат бус байгууллагын талаарх харьцуулсан судалгаа: Монгол Улс болон гадаадын зарим орны туршлага” (Харьцуулсан судалгаа, СТ-19/202). УИХТГ-ын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс. УБ., 2019 он.
- “Уголовно-процессуальный кодекс РФ” от 18.12.2001 N 174-ФЗ
- Положение о Следственном департаменте МВД РФ. Утвержден приказом МВД России от 1 июля 2011 г. N 780 “Об утверждении положения о Следственном департаменте Министерства внутренних дел РФ”. ДХЯ-ны цахим хуудас: <https://sledcom.ru>.
- Конституция РФ (12.12.1993). <http://www.constitution.ru>
- Закон О Следственном комитете РФ от 28.12.2010 N 403-ФЗ. https://sledcom.ru/documents/Pravovaja_informacija
- Уголовно-процессуальный кодекс РФ от 18.12.2001 г. № 174-ФЗ. <http://ivo.garant.ru>
- Уголовный кодекс РФ от 13.06.1996 N 63-ФЗ. <http://www.consultant.ru>
- Указ Президента РФ No 1182 от 27.09.2010 “Вопросы Следственного комитета РФ”.
- https://sledcom.ru/documents/Pravovaja_informacija.
- Указ Президента РФ No 14.01.2011 “Вопросы деятельности Следственного комитета РФ”.
- https://sledcom.ru/documents/Pravovaja_informacija.
- МБХ-ны түүх. МБХ-ны цахим хуудас: <https://sledcom.ru>.
- МБХ-ны түүх. МБХ-ны цахим хуудас: <https://sledcom.ru>.
- ФЗ О Следственном комитете РФ от 28.12.2010 г. № 403-ФЗ.
- Указ Президента РФ от 14.01.2011 № 38 “Вопросы деятельности СК РФ”.

БНСУ

- Korean Central Intelligence Agency - https://eng.nis.go.kr/EID/1_5_2_1.do
- Defense Security Support Command - <https://www.dssc.mil.kr/dsscscn/355/subview.do>
- National Human Rights Commission of Korea <http://www.humanrights.go.kr/site/homepage/menu/>
- https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=22488&lang=ENG
- Korean law information center - <https://www.law.go.kr/LSW/eng/engMain.do?menuId=0>
- Prosecution Service - <https://www.spo.go.kr/site/spo/01/10101050200002018112210.jsp>
- Supreme Prosecutors' Office - <https://www.spo.go.kr/site/spo/main.do>

- Sweeping Changes to the Korean Criminal Procedures: Starting in the New Year. Chang Hee SUN and others. Lee & Ko. Newsletter, December 2020.
<https://www.leeko.com/upload/upFile/202012//RECR202012291738296019340.pdf>
- Төрийн байгууллагын тухай хууль:
https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=44197&type=sogan&key=15
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль:
<https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=National+Security+Act&x=26&y=26#lIBgcolor20>
- Үндэсний тагнуулын албаны тухай хууль:
https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=33396&type=part&key=4

БНТУ

- Үндэсний тагнуулын байгууллага: <https://www.mit.gov.tr/>
- Цагдаагийн ерөнхий газар: <https://www.egm.gov.tr/>
- Гүйцэтгэх ажиллагааны газар: <https://www.egm.gov.tr/istihbarat>
- Тагнуулын байгууллагын тухай хууль: <https://www.mit.gov.tr/2937.pdf>
- Аюулгүй байдлын тухай хууль:
<https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.3.3201.pdf>
- Тагнуулын тухай хууль:
<https://www.egm.gov.tr/hukukmusavirligi/3201sayiliemniyetteskilatikanunu>
- Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 139 дүгээр зүйл:
<https://barandogan.av.tr/5271-sayili-ceza-muhakemesi-kanunu-cmk.html#Madde-139>
- Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 140 дүгээр зүйл:
<https://barandogan.av.tr/5271-sayili-ceza-muhakemesi-kanunu-cmk.html#Madde-140>
- Эрүүгийн тухай хууль: <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf>
- Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх тухай 4208 дугаартай хууль: Karararının Aklanmasının Önlenmesine Dair Kanun
- Цагдаагийн ерөнхий газрын мөрдөн шалгах хороо:
<https://onlineislemler.egm.gov.tr/Sayfalar/insanhaklari.aspx>

ХАВСРАЛТ
МОНГОЛ УЛСЫН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ОРСОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙН ЛАВЛАГАА

№	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо	Хуулийн заалт	Нэмэлт, өөрчлөлт орсон хуулийн заалт
1	1999.07.08 Тагнуулын байгууллагын тухай хууль батлагдсантай холбогдуулан	<p>9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага</p> <p>9.1. Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй:</p> <p>9.1.1. улсын аюулгүй байдлыг хангах байгууллага – тагнуул, сөрөх тагнуулын чиглэлээр гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдол бүхий бусад мэдээ олох, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэм буруутай этгээдийг олж тогтоох;</p>	<p>9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага</p> <p>9.1. Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй:</p> <p>9.1.1. улсын аюулгүй байдлыг хангах байгууллага – гадаад тагнуул, сөрөх тагнуулын чиглэлээр гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдол бүхий бусад мэдээ олох, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэм буруутай этгээдийг олж тогтоох;</p>
		<p>11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл</p> <p>11.1. Тагнуул, сөрөх тагнуул, цэргийн тагнуулын ажлыг эдгээр ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын эрх ашиг, энэ талаарх төрийн бодлогын үндсийг удирдлага болгон өөрт нь байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээр явуулна.</p>	<p>11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл</p> <p>11.1. Гадаад тагнуул, сөрөх тагнуул, цэргийн тагнуулын ажлыг эдгээр ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын эрх ашиг, энэ талаарх төрийн бодлогын үндсийг удирдлага болгон өөрт нь байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээр явуулна.</p>
		<p>12 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил явуулах хүрээ</p> <p>12.1. Гүйцэтгэх ажил дараах хүрээгээр хязгаарлагдана:</p> <p>12.1.1. гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой бусад мэдээ олох тагнуулын ажил;</p>	<p>12 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил явуулах хүрээ</p> <p>12.1. Гүйцэтгэх ажил дараах хүрээгээр хязгаарлагдана:</p> <p>12.1.1. гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой бусад мэдээ олох тагнуулын ажил;</p>
		<p>6 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо</p> <p>6.1. "Тагнуулын ажил", "сөрөх тагнуулын ажил", "нууц арга, хэрэгсэл", "нууц гүйцэтгэх ажилтан", "туслагч, туслах ажилтан", "халхавчлах" гэсэн нэр томьёог Монгол Улсын Аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан утгаар ойлгоно.</p>	<p>6 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо</p> <p>6.1. "Гадаад тагнуулын ажил", "сөрөх тагнуулын ажил", "тусгай алба", "нууц арга, хэрэгсэл", "халхавчлах", "нууц гүйцэтгэх ажилтан", "туслагч", "туслах ажилтан" гэсэн нэр томьёог Тагнуулын байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан утгаар ойлгоно.</p>
		<p>3 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж</p> <p>Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Улсын аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p>	<p>3 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж</p> <p>Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p>
		<p>6 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо</p> <p>6.2. "Эрэн сурвалжлах ажил" гэж Улсын аюулгүй байдлыг хангах байгууллага, цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад Эрүүгийн</p>	<p>6 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо</p> <p>6.2. "Эрэн сурвалжлах ажил" гэж Тагнуулын байгууллага, цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад Эрүүгийн байцаан шийтгэх хууль</p>

2	2001.12.27 Үндэсний аюулгүй байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан	байцаан шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжоор харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх нууц ажиллагааг хэлнэ. 9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага 9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй: 9.1.1.Улсын аюулгүй байдлыг хангах байгууллага – гадаад тагнуул, сөрөх тагнуулын тагнуул, сөрөх тагнуулын чиглэлээр гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдол бүхий бусад мэдээ олох, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэм буруутай этгээдийг олж тогтоох. 9.2.Гүйцэтгэх ажилд хууль тогтоомжийг чанд сахиулах, нууцыг хангуулах зорилгоор Улсын аюулгүй байдлыг хангах байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл 11.3.Улсын аюулгүй байдлыг хангах байгууллага өөрт нь хуулиар харьяалуулсан эрүүгийн харьяалуулсан эрүүгийн хэргийн тухай мэдээлэл, эрүү үүсгэсэн хэргийг шалгахдаа энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3, 5, 6-д заасан үндэслэлээр эрэн сурвалжлах ажил явуулах эрхтэй.	болон бусад хууль тогтоомжоор харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх нууц ажиллагааг хэлнэ. 9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага 9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй: 9.1.1.тагнуулын байгууллага – гадаад тагнуул, сөрөх тагнуулын чиглэлээр гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдол бүхий бусад мэдээ олох, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэм буруутай этгээдийг олж тогтоох. 9.2.Гүйцэтгэх ажилд хууль тогтоомжийг чанд сахиулах, нууцыг хангуулах зорилгоор Тагнуулын байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл 11.3.Тагнуулын байгууллага өөрт нь хуулиар харьяалуулсан эрүүгийн хэргийн тухай мэдээлэл, эрүү үүсгэсэн хэргийг шалгахдаа энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3, 5, 6-д заасан үндэслэлээр эрэн сурвалжлах ажил явуулах эрхтэй.
3	2001.12.27 Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан	9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага 9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй: 9.1.5.Хилийн тагнуулын алба нь хил зөрчих, хилийн бүс, зурваст үүсч болох зэвсэгт мөргөлдөөн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, зэвсэгт халдлага болон хилийн дэглэм зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэм буруутай этгээдийг олж тогтоох, улсын хил хамгаалахад шаардлагатай мэдээллээр хил хамгаалах байгууллага, түүний харьяа анги, салбарын удирдлагыг хангах; 11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл 11.6.Хилийн тагнуулын алба хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3, 5, 6-д заасан үндэслэлээр эрэн сурвалжлах ажил явуулах эрхтэй.	9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй: 9.1.5.Хилийн тагнуулын алба нь хил зөрчих, хилийн бүс, зурваст үүсч болох зэвсэгт мөргөлдөөн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, зэвсэгт халдлага болон хилийн дэглэм зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэм буруутай этгээдийг олж тогтоох, улсын хил хамгаалахад шаардлагатай мэдээллээр хил хамгаалах байгууллага, түүний харьяа анги, салбарын удирдлагыг хангах; 11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл 11.6.Хилийн тагнуулын алба хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3, 5, 6-д заасан үндэслэлээр эрэн сурвалжлах ажил явуулах эрхтэй.
4	2002.04.19 Үндсэн хуулийн §16-д нийцүүлэн	8 дугаар зүйл. Гүйцэтгэх ажилд хориглох зүйл 8.6.Хуулиар эрх олгоогүй хувь хүн, байгууллага, албан тушаалтан гүйцэтгэх ажил явуулахыг хориглоно.	

5	2006.07.06 Авлигын эсрэг хууль батлагдсантай холбогдуулан	<p>9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага</p> <p>9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй:</p> <p>9.1.6.Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гэм буруутай этгээдийг олж тогтоох, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах;</p> <p>11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл</p> <p>11.7.Авлигатай тэмцэх газар авлигын гэмт хэрэг болон хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт энэ хуулийн 11.2.1-11.2.3, 11.2.5-11.2.6-д заасан үндэслэлээр гүйцэтгэх ажил явуулах эрхтэй.</p>
6	2013.07.05 Тахарын албаны тухай хууль батлагдсантай холбогдуулан	<p>9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага</p> <p>9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй:</p> <p>9.1.7.Тахарын алба оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, шүүх, шүүгч, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх.</p> <p>11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл</p> <p>11.8.Тахарын алба оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, баривчлах, шүүх, шүүгч, гэрч хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдалд халдлага, хор аюул учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй.</p> <p>6 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо</p> <p>6.2.“Эрэн сурвалжлах ажил” гэж Тагнуулын байгууллага цагдаа, тахарын, хорих ял эдлүүлэх байгууллагад Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжоор харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх нууц ажиллагааг хэлнэ.</p> <p>9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага</p> <p>9.2.Гүйцэтгэх ажилд хууль тогтоомжийг чанд сахиулах, нууцыг хангуулах зорилгоор Тагнуулын байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.2.5.нууцлалыг задруулахгүй байх бүх талын арга хэмжээ авсны үндсэн дээр гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжийн биелэлтийг цэрэг, цагдаа болон хорих ял эдлүүлэх байгууллага дээр хянан шалгах, тэдгээрт байгаа гүйцэтгэх ажлын хэрэгтэй танилцах, шаардлагатай мэдээ баримтыг гаргуулж авах.</p>

<p>2015.07.09</p> <p>Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль</p> <p>батлагдсан</p>	<p>6 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо</p> <p>6.1."Гадаад тагнуулын ажил", "сөрөх тагнуулын ажил", "нууц арга, хэрэгсэл", "халхавчлах", "нууц гүйцэтгэх ажилтан", "туслагч", "туслах ажилтан" гэсэн нэр томьёог Тагнуулын байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан утгаар ойлгоно.</p>	<p>6.1."Гадаад тагнуулын ажил", "сөрөх тагнуулын ажиллагаа", "гадаадын тусгай алба", "нууц арга, хэрэгсэл", "халхавчлах", "нууц гүйцэтгэх ажилтан", "туслагч", "туслах ажилтан" гэсэн нэр томьёог Тагнуулын байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан утгаар ойлгоно.</p> <p>6.3."Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл" гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.</p>
	<p>8 дугаар зүйл. Гүйцэтгэх ажилд хориглох зүйл</p> <p>8.1.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас бусад байгууллага, албан тушаалтан, хувь хүн гүйцэтгэх ажил явуулах, аливаа техник хэрэгслийг гүйцэтгэх ажлын зориулалтаар хэрэглэхийг хориглоно.</p>	<p>8 дугаар зүйл. Гүйцэтгэх ажилд хориглох зүйл</p> <p>8.1.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас бусад байгууллага, албан тушаалтан, хувь хүн гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл ашиглах, аливаа техник хэрэгслийг гүйцэтгэх ажлын зориулалтаар хэрэглэхийг хориглоно.</p>
	<p>8.4.Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан албан тушаалтан, Үндсэн хуулийн цэц, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Монгол Улсын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн дарга нар нууц гүйцэтгэх ажилтан, туслагч, туслах ажилтан байж болохгүй.</p>	<p>8.4.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга нь нууц гүйцэтгэх ажилтан, туслагч, туслах ажилтан байж болохгүй.</p>
	<p>9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага</p> <p>9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй:</p> <p>9.1.1.Тагнуулын байгууллага гадаад тагнуул, сөрөх тагнуулын чиглэлээр гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон хамгаалахад ач холбогдол бүхий бусад мэдээ олох, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэм</p>	<p>8.6.Нууц гүйцэтгэх ажилтан, туслагч, туслах ажилтныг нэгээс илүү гүйцэтгэх байгууллагад ажиллуулах, хуульд зааснаас бусад зорилго, үндэслэлээр ажиллуулах болон хууль бус үйлдэлд татан орлуулахыг хориглоно.</p> <p>8.7.Гүйцэтгэх ажлын явцад хуульд заасан үндэслэл, журмаас гадур хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хууль ёсны ашиг сонирхолд нь халдах, гүйцэтгэх ажлын үр дүнг хууль бусаар ашиглах, гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлтийг хуурамчаар үйлдэх, хуульд зааснаас бусад тохиолдолд гүйцэтгэх ажлын явцад олсон хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулахыг хориглоно.</p> <p>9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага</p> <p>9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй:</p> <p>9.1.1.Тагнуулын байгууллага нь гадаад тагнуул, цэрэг-стратегийн болон хилийн тагнуул, сөрөх тагнуулын чиглэлээр гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий бусад мэдээ олох, дэмжлэг үзүүлэх, үндэсний холбогдол бүхий бусад мэдээ олох, дэмжлэг үзүүлэх, үндэсний харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэм</p>

	буруутай этгээдийг олж тогтоох;	<p>аюулгүй байдалд учирч болзошгүй гадаад, дотоод эрсдэл, аюул, занал, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;</p> <p>9.1.2.цэргийн тангуулын байгууллага- олон улсын болон бүс нутгийн цэрэг, улс төрийн байдал, үүсч болзошгүй цэргийн аюул заналыг судалж, түүнээс Монгол Улсад учирч болох хор аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, төрийн дээд болон зэвсэгт хүчний удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр хангах;</p> <p>9.1.4.шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барыцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх, түүнчлэн оргосон хоригдлыг баривчлах түүнчлэн энэ хуулийн 9.1.1, 9.1.3, 9.1.6-д заасан байгууллагын гүйцэтгэх ажилд дэмжлэг үзүүлэх;</p> <p>9.1.5.Хилийн тангуулын алба нь хил зөрчих, хилийн бүс, зурваст үүсч болох зэвсэгт мөргөлдөөн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, зэвсэгт халдлага болон хилийн дэглэм зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэм буруутай этгээдийг олж тогтоох, улсын хил хамгаалахад шаардлагатай мэдээллээр хил хамгаалах байгууллага, түүний харьяа анги, салбарын удирдлагыг хангах.</p> <p>9.2.Гүйцэтгэх ажилд хууль тогтоомжийг чанд сахиулах, нууцыг хангуулах зорилгоор Тангуулын байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.2.1.гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх;</p> <p>9.2.3.энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллагын мэдэлд байгаа утсан харилцаа хянах, сонсох төхөөрөмжийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих;</p> <p>9.2.4.гүйцэтгэх ажлын техник хэрэгсэл зохион бүтээх, олж авах, ашиглах талаар нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;</p> <p>9.2.5.нууцлалыг задруулахгүй байх бүх талын арга хэмжээ авсны үндсэн дээр гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжийн биелэлтийг цэрэг, цагдаа, тахарын болон хорих ял эдлүүлэх</p>
		<p>аюулгүй байдалд учирч болзошгүй гадаад, дотоод эрсдэл, аюул, занал, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;</p> <p>9.1.2.цэргийн тангуулын байгууллага- олон улсын болон бүс нутгийн цэрэг, улс төрийн байдал, үүсч болзошгүй цэргийн аюул заналыг судалж, түүнээс Монгол Улсад учирч болох хор аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, төрийн дээд болон зэвсэгт хүчний удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр хангах;</p> <p>9.1.4.шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барыцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх, түүнчлэн оргосон хоригдлыг баривчлах түүнчлэн энэ хуулийн 9.1.1, 9.1.3, 9.1.6-д заасан байгууллагын гүйцэтгэх ажилд дэмжлэг үзүүлэх;</p> <p>9.1.5.Хилийн тангуулын алба нь хил зөрчих, хилийн бүс, зурваст үүсч болох зэвсэгт мөргөлдөөн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, зэвсэгт халдлага болон хилийн дэглэм зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэм буруутай этгээдийг олж тогтоох, улсын хил хамгаалахад шаардлагатай мэдээллээр хил хамгаалах байгууллага, түүний харьяа анги, салбарын удирдлагыг хангах.</p> <p>9.2.Гүйцэтгэх ажилд хууль тогтоомжийг чанд сахиулах, нууцыг хангуулах зорилгоор Тангуулын байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.2.1.гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, энэ талаарх холбогдох журмыг баталж мөрдүүлэх;</p> <p>9.2.3.гүйцэтгэх байгууллагаас гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл олж авах, улсын хилээр нэвтрүүлэх, ашиглахад зөвшөөрөл олгох, гүйцэтгэх байгууллагын мэдэлд байгаа гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих;</p> <p>9.2.4.гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл зохион бүтээх, олж авах, ашиглах талаар нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;</p> <p>9.2.5.нууцлалыг задруулахгүй байх бүх талын арга хэмжээ авсны үндсэн дээр гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжийн биелэлтийг цагдаа, авлигатай тэмцэх, тахарын болон хорих ял</p>

	байгууллага дээр хянан шалгах, тэдгээрт байгаа гүйцэтгэх ажлын хэрэгтэй танилцах, шаардлагатай мэдээ баримтыг гаргуулж авах.	байгууллага дээр хянан шалгах, тэдгээрт байгаа гүйцэтгэх ажлын хэрэгтэй танилцах, шаардлагатай мэдээ баримтыг гаргуулж авах.
	<p>11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл</p> <p>11.1.Гадаад тагнуул, сөрөх тагнуул, цэрэг-стратегийн болон илхийн тагнуулын үйл ажиллагааг тагнуулын байгууллага Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын эрх ашиг, энэ талаарх төрийн бодлогын үндсийг удирдлага болгон өөрт нь байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээр явуулна.</p> <p>11.6.Хилийн тагнуулын алба хуулиар харьяалуулсан эрүүгийн үндэслэлээр эрэн сурвалжлах ажил явуулах эрхтэй.</p>	<p>11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл</p> <p>11.1.Гадаад тагнуул, сөрөх тагнуул, цэрэг-стратегийн болон илхийн тагнуулын үйл ажиллагааг тагнуулын байгууллага Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын эрх ашиг, энэ талаарх төрийн бодлогын үндсийг удирдлага болгон өөрт нь байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээр явуулна.</p> <p>11.6.Хилийн тагнуулын алба хуулиар харьяалуулсан эрүүгийн үндэслэлээр эрэн сурвалжлах ажил явуулах эрхтэй.</p>
	<p>12 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил явуулах хүрээ</p> <p>12.1.Гүйцэтгэх ажил дараах хүрээгээр хязгаарлагдана:</p> <p>12.1.1.Гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой бусад мэдээ олох гадаад тагнуулын ажил.</p> <p>12.1.2.Монгол Улсын эсрэг гадаадын улс, байгууллага, иргэн, тэдгээрийн төлөөний этгээдийн зүгээс явуулж байгаа тагнуул, хорлон сүйтгэх ажиллагаа болон тагнуулын байгууллагын харьяаллын гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн сөрөх тагнуулын ажил;</p>	<p>12 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил явуулах хүрээ</p> <p>12.1.Гүйцэтгэх ажил дараах хүрээгээр хязгаарлагдана:</p> <p>12.1.1.Гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой бусад мэдээ олох гадаад тагнуулын үйл ажиллагаа;</p> <p>12.1.2.Монгол Улсын эсрэг гадаадын улс, байгууллага, иргэн, тэдгээрийн төлөөний этгээдийн зүгээс явуулж байгаа тагнуул, хорлон сүйтгэх ажиллагаа болон тагнуулын байгууллагын харьяаллын гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн сөрөх тагнуулын үйл ажиллагаа;</p>
	<p>13.3.Гүйцэтгэх байгууллага, ажилтан дор дурдсан үүрэгтэй:</p> <p>13.3.3.Өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа гүйцэтгэх ажлын зориулалттай техник хэрэгслийн болон нууц арга хэрэглэж зохиосон ажлын тоо бүртгэл хөтөлж, энэ талаар мэдээллийн сан байгуулж ажиллуулах;</p>	<p>13 дугаар зүйл. Гүйцэтгэх байгууллага, тэдгээрийн ажилтны бүрэн эрх</p> <p>13.3.Гүйцэтгэх байгууллага, ажилтан дор дурдсан үүрэгтэй:</p> <p>13.3.3.Өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн болон нууц арга хэрэглэж зохиосон ажлын тоо бүртгэл хөтөлж, энэ талаар мэдээллийн сан байгуулж ажиллуулах, гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлэх;</p> <p>13.5.Гүйцэтгэх ажилтны албан тушаалд иргэнийг судлах, сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулахтай холбогдох харилцааг Тагнуулын байгууллагын тухай хуулийн 17.2-т заасан журмаар зохицуулна.</p>
	<p>14 дүгээр зүйл. Туслагч, туслах ажилтан ажиллуулах</p> <p>14.2.Туслагч, туслах ажилтныг бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр ажиллуулна.</p>	<p>14 дүгээр зүйл. Туслагч, туслах ажилтан ажиллуулах</p> <p>14.2.Шаардлагатай тохиолдолд туслагч, туслах ажилтантай бичгээр гэрээ байгуулах бөгөөд гэрээнд тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх, хүлээх хариуцлагын талаар тодорхой заана.</p>

	<p>14.3.Туслагч, туслах ажилтныг зөвхөн гэрээ байгуулсан байгууллагад хуулиар харьяалуулсан асуудлыг шалгахад оролцуулах бөгөөд гэрээнд гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх, хүлээх хариуцлагын талаар тодорхой заана.</p> <p>14.4.Туслагч, туслах ажилтныг нэгээс илүү гүйцэтгэх байгууллагад ажиллуулахыг хориглоно.</p> <p>15 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын санхүүжилт</p> <p>15.3.Гүйцэтгэх ажлын төсвийн хөрөнгийн зарцуулалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан эрх бүхий албан тушаалтан шалгана.</p>	<p>14.3.Туслагч, туслах ажилтныг зөвхөн гэрээ байгуулсан байгууллагад хуулиар харьяалуулсан асуудлыг шалгахад оролцуулах бөгөөд гэрээнд гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх, хүлээх хариуцлагын талаар тодорхой заана.</p> <p>14.4.Туслагч, туслах ажилтныг нэгээс илүү гүйцэтгэх байгууллагад ажиллуулахыг хориглоно.</p> <p>15 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын санхүүжилт</p> <p>15.3.Гүйцэтгэх ажлын төсвийн хөрөнгийн зарцуулалтыг Төрийн аудитын тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтан шалгана.</p> <p>15.5.Гүйцэтгэх байгууллагын бие бүрэлдэхүүнийг нь нууцлал зохих салбар, нэгжийн үйл ажиллагааны төсвийг төлөвлөх, санхүүжүүлэх, гүйцэтгэлийг нь тайлагнахад баримтлах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тагнуулын төв байгууллагын даргатай хамтран батална.</p> <p>15.6.Гүйцэтгэх ажлын зориулалттай эд хөрөнгийг худалдан авах, үйлдвэрлэх, эргэлтийн хөрөнгөд бүртгэх, захиран зарцуулах, шилжүүлэх, устгахад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан журмыг баримтална.</p>
		<p>18 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын үр дүнг ашиглах</p> <p>18.2.Гүйцэтгэх ажлын үр дүнгийн тухай мэдээ, баримт сэлтийг хүлээн авсан, танилцсан байгууллага, албан тушаалтан нь гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл, мэдээллийн эх сурвалжийг задруулахгүй байх үүрэгтэй.</p> <p>18.3.Дараах тохиолдолд тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажлын үр дүнгийн тухай мэдээ, баримт сэлтийг тагнуулын төв байгууллагын даргын зөвшөөрөлгүйгээр бусад байгууллага, албан тушаалтанд шилжүүлэхийг хориглоно:</p> <p>18.3.1.Гүйцэтгэх ажлын арга хэмжээнд оролцогчдын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй;</p> <p>18.3.2.Гүйцэтгэх ажлын хүч хэрэгсэл, арга, ажиллагааны тухай мэдээ, мэдээлэл задрах бодит нөхцөл байдал үүсч болзошгүй.</p> <p>23 дугаар зүйл. Гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналт</p> <p>23.3.Гүйцэтгэх байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд дор дурдсан ажиллагаа явуулахад прокурор бичгээр урьдчилан зөвшөөрөл өгнө.</p> <p>23.3.1.харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих;</p> <p>23.3.5.хяналтын худалдан авалт;</p>
	<p>23 дугаар зүйл. Гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналт</p> <p>23.3.Гүйцэтгэх байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд дор дурдсан ажиллагаа явуулахад прокурор бичгээр урьдчилан зөвшөөрөл өгнө.</p> <p>23.3.1.угсан харилцааг хянах;</p>	

		<p>24 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага</p> <p>24.1.Албан тушаалтан гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тагнуулын байгууллагаас дараах хариуцлага хүлээлгүүлэхээр харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд санал тавьж шийдвэрлүүлнэ:</p> <p>24.1.1.Энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7, 18.2, 21.5-д заасныг зөрчсөн, 9.2.1, 9.2.3-т заасныг хэрэгжүүлэхэд саад учруулсан этгээдийн албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;</p> <p>24.1.2.Энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7, 18.2, 21.5-д заасныг удаа дараа зөрчсөн, эсхүл 9.2.1, 9.2.3-т заасныг хэрэгжүүлэхэд саад учруулсны улмаас мөн хуулийн 8 дугаар зүйлд заасан хориглосон хэм хэмжээ зөрчигдөх нөхцөл бүрдсэн бол гэм буруутай этгээдийг албан тушаал бууруулах, огцруулах, төрийн албанаас халах.</p> <p>24.2.Энэ хуулийн 24.1-д заасан тохиолдолд тухайн албан тушаалтан холбогдох албан тушаалтандаа хариуцлага хүлээлгэж, энэ тухай 14 хоногийн дотор тагнуулын байгууллагад мэдэгдэнэ.</p> <p>24.3.Энэ хуулийн 24.2-т заасныг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан тохиолдолд тухайн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналыг тагнуулын байгууллага түүнийг томилох, чөлөөлөх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.</p> <p>24.4.Энэ хуулийг зөрчсөн бусад этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.</p>
	<p>24 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага</p> <p>24.1.Хууль зөрчиж гүйцэтгэх ажил явуулсан байгууллага, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.</p>	<p>8 дугаар зүйл. Гүйцэтгэх ажилд хориглох зүйл</p> <p>8.4.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга нь нууц гүйцэтгэх ажилтан, туслагч, туслах ажилтан байж болохгүй.</p>
<p>2015.10.30 Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан</p>	8	

<p>9</p> <p>2016.07.21 Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль</p> <p>батлагдсантай холбогдуулан</p>	<p>6 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо 6.2.“Эрэн сурвалжлах ажил” гэж Тагнуулын байгууллага цагдаа, тахарын, хорих ял эдлүүлэх байгууллагад Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжоор харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх нууц ажиллагааг хэлнэ.</p> <p>9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага 9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй: 9.1.7.тахарын алба оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, шүүх, шүүгч, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх.</p> <p>9.2.Гүйцэтгэх ажилд хууль тогтоомжийг чанд сахиулах, нууцыг хангуулах зорилгоор Тагнуулын байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.2.5.нууцлалыг задруулахгүй байх бүх талын арга хэмжээ авсны үндсэн дээр гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжийн биелэлтийг цэрэг, цагдаа, тахарын болон хорих ял эдлүүлэх байгууллага дээр хянан шалгах, тэдгээрт байгаа гүйцэтгэх ажлын хэрэгтэй танилцах, шаардлагатай мэдээ баримтыг гаргуулж авах.</p> <p>11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл 11.8.Тахарын алба оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, баривчлах, шүүх, шүүгч, гэрч хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдалд халдлага, хор аюул учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй.</p>	<p>6 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо 6.2.“Эрэн сурвалжлах ажил” гэж Тагнуулын байгууллага цагдаа, тахарын, хорих ял эдлүүлэх байгууллагад Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжоор харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх нууц ажиллагааг хэлнэ.</p> <p>9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага 9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй: 9.1.7.тахарын алба оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, шүүх, шүүгч, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх.</p> <p>9.2.Гүйцэтгэх ажилд хууль тогтоомжийг чанд сахиулах, нууцыг хангуулах зорилгоор Тагнуулын байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.2.5.нууцлалыг задруулахгүй байх бүх талын арга хэмжээ авсны үндсэн дээр гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжийн биелэлтийг цэрэг, цагдаа, тахарын болон хорих ял эдлүүлэх байгууллага дээр хянан шалгах, тэдгээрт байгаа гүйцэтгэх ажлын хэрэгтэй танилцах, шаардлагатай мэдээ баримтыг гаргуулж авах.</p> <p>11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл 11.8.Тахарын алба оргосон яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, баривчлах, шүүх, шүүгч, гэрч хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдалд халдлага, хор аюул учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй.</p>
<p>10</p> <p>2016.12.01 Төрийн болон албаны нууцын тухай хууль</p> <p>батлагдсантай холбогдуулан</p>	<p>13 дугаар зүйл. Гүйцэтгэх байгууллага, тэдгээрийн ажилтны бүрэн эрх 13.3.Гүйцэтгэх байгууллага, ажилтан дор дурдсан үүрэгтэй: 13.3.6.гүйцэтгэх ажлын холбогдолтой төрийн нууцыг чанд хамгаалах, нууцлалыг сахих;</p> <p>18 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын үр дүнг ашиглах 18.1.Гүйцэтгэх ажлын явцад авагдсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоог зөвхөн дараах зорилгоор ашиглана: 18.1.3.Төрийн нууцын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан албан тушаалтнуудад танилцуулах.</p>	<p>13 дугаар зүйл. Гүйцэтгэх байгууллага, тэдгээрийн ажилтны бүрэн эрх 13.3.Гүйцэтгэх байгууллага, ажилтан дор дурдсан үүрэгтэй: 13.3.6.гүйцэтгэх ажлын холбогдолтой төрийн болон албаны нууцыг чанд хамгаалах, нууцлалыг сахих;</p> <p>18 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын үр дүнг ашиглах 18.1.Гүйцэтгэх ажлын явцад авагдсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоог зөвхөн дараах зорилгоор ашиглана: 18.1.3.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан албан тушаалтнуудад танилцуулах.</p>

<p>21 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын нууцыг хамгаалах, хадгалах</p> <p>21.1.Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, баримт бичигтэй Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан журмын дагуу танилцана.</p> <p>21.2.Төрийн болон албаны нууц мэдээ, мэдээлэл, баримт бичгийг итгэмжлэн харуусан гүйцэтгэх ажилтан, албан тушаалтан нь уг ажил, албан тушаалд томилогдох буюу халагдахдаа нууц хадгалах баталгааг бичгээр гаргана.</p> <p>21.7.Энэ хуулийн 17, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу авагдсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг, шалгалтын материалыг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан нууцлах хугацаа дуусалт архивт хадгална.</p>	<p>21 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын нууцыг хамгаалах, хадгалах</p> <p>21.1.Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, баримт бичигтэй Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан журмын дагуу танилцана.</p> <p>21.2.Төрийн болон албаны нууц мэдээ, мэдээлэл, баримт бичгийг итгэмжлэн харуусан гүйцэтгэх ажилтан, албан тушаалтан нь уг ажил, албан тушаалд томилогдох буюу халагдахдаа нууц хадгалах баталгааг бичгээр гаргана.</p> <p>21.7.Энэ хуулийн 17, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу авагдсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг, шалгалтын материалыг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан нууцлах хугацаа дуусалт архивт хадгална.</p>	<p>21 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын нууцыг хамгаалах, хадгалах</p> <p>21.1.Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, баримт бичигтэй Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан журмын дагуу танилцана.</p> <p>21.2.Төрийн болон албаны нууц мэдээ, мэдээлэл, баримт бичгийг итгэмжлэн харуусан гүйцэтгэх ажилтан, албан тушаалтан нь уг ажил, албан тушаалд томилогдох буюу халагдахдаа нууц хадгалах баталгааг бичгээр гаргана.</p> <p>21.7.Энэ хуулийн 17, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу авагдсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг, шалгалтын материалыг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан нууцлах хугацаа дуусалт архивт хадгална.</p>
<p>21 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын нууцыг хамгаалах, хадгалах</p> <p>21.1.Төрийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, баримт бичигтэй Төрийн нууцын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан журмын дагуу танилцана.</p> <p>21.2.Төрийн нууц мэдээ, мэдээлэл, баримт бичгийг итгэмжлэн харуусан гүйцэтгэх ажилтан, албан тушаалтан нь уг ажил, албан тушаалд томилогдох буюу халагдахдаа нууц хадгалах баталгааг бичгээр гаргана.</p> <p>21.7.Энэ хуулийн 17, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу авагдсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг, шалгалтын материалыг Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд заасан нууцлах хугацаа дуусалт архивт хадгална.</p>	<p>9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага</p> <p>9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй:</p> <p>9.1.3.цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох, түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох.</p>	<p>9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага</p> <p>9.1.Дараах байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй:</p> <p>9.1.3.цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох, түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох.</p>
<p>2 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил</p> <p>Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх ажил гэнэ. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагаас хуулиар төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөн явагдах танхимд болон хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийх техникийн үзлэг, шалгалт гүйцэтгэх ажилд хамаарахгүй.</p>	<p>2 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил</p> <p>Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх ажил гэнэ.</p>	<p>2 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил</p> <p>Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх ажил гэнэ.</p>

**ШҮҮХИЙН ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ТҮҮНИЙГ ҮНЭЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ:
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Б.Буянзаяа, Г.Билгээ,
П.Уранчимэг, Ц.Ариунаа, Б.Туул*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

ШҮҮХИЙН ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ТҮҮНИЙГ ҮНЭЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ:
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

1.Оросын Холбооны Улс

1.1.Эрх зүйн орчин

1.2.Шүүхийн шинжээч, түүнийг томилох

1.3.Шинжээчийн дүгнэлт, түүнийг нотлох баримтын түвшинд үнэлэх

2.Бүгд Найрамдах Франц Улс

2.1.Эрх зүйн орчин

2.2.Шүүхийн шинжээч, түүнийг томилох

2.3.Шинжээчийн дүгнэлт, түүнийг нотлох баримтын түвшинд үнэлэх

3.Бүгд Найрамдах Эстони Улс

3.1.Эрх зүйн орчин

3.2.Шүүхийн шинжээч, түүнийг томилох

3.3.Шинжээчийн дүгнэлт, түүнийг нотлох баримтын түвшинд үнэлэх

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Шүүхийн шинжээчийн дүгнэлт, түүнийг үнэлэх эрх зүйн зохицуулалт: гадаадын зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Шүүхийн шинжээчийн дүгнэлтийг хэрхэн үнэлдэг талаарх гадаадын зарим орны туршлагыг эрх зүйн зохицуулалтын хүрээнд судлах.

Хамрах хүрээ: Судалгаанд Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Эстони Улсын холбогдох эрх зүйн орчны хүрээнд шүүхийн шинжилгээтэй холбоотой харилцааг хэрхэн зохицуулдаг, шүүхийн шинжээч гэж хэн бэ, түүнийг хэрхэн томилдог, шинжээчийн дүгнэлт болон түүнийг нотлох баримтын түвшинд хэрхэн үнэлдэг талаарх асуудлуудыг судлав.

Судалгааны бүтэц: Судалгааг ОХУ, Франц, Эстони улсуудын туршлагын хүрээнд: 1) шүүхийн шинжилгээний эрх зүйн орчин; 2) шүүхийн шинжээч, түүнийг томилох; 3) шинжээчийн дүгнэлт, түүнийг нотлох баримтын түвшинд үнэлэх гэсэн бүтэцтэйгээр гүйцэтгэв.

Түлхүүр үг: шүүхийн шинжилгээ, шинжээч, шинжээчийн дүгнэлт, шинжээчийг дүгнэлтийг үнэлэх, нотлох баримт.

Key word: forensic examination, expert opinion, expert, officially certified expert, evidence.

Ключевые слова: обоснованность заключения эксперта, категорические выводы, вероятностные выводы, доказательственное значение вывода эксперта, достоверное доказательство.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

2009 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хурлаас Шүүхийн шинжилгээний тухай хууль батлагдсанаар шүүхийн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах процессыг бие даасан хуулиар зохицуулах болсон. Шүүхийн шинжилгээний тухай хууль¹²¹ батлагдсанаас хойш түүнд нийт 6 удаа, давхардсан тоогоор 40 гаруй зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Мөн эрүү иргэн, захиргаа ба зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудаар шинжээчийн дүгнэлтийн нотлох баримтын хувьд хэрхэн авч үзэхийг зохицуулж байна.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050¹²² Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “шүүхийн шинжилгээний эрх зүйн орчныг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, салбарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны өндөр түвшний технологийг нэвтрүүлэх бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, судалгаа, шинжилгээний баазыг бэхжүүлэх, байгууллагын техник, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн чадамжийг дээшлүүлэх” зорилтот арга хэмжээнүүдийг төлөвлөсөн.

Түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн¹²³ 57-д “хүн амын тоо, нягтрал, гэмт хэргийн гаралт, шүүхийн шинжилгээний хэрэгцээ, цар хүрээ, шинэ төрлийн болон тусгай шинжилгээний шаардлага зэргийг харгалзан шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоог өөрчилж, бүтэц, бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэн эрх зүйн статусыг тодорхой болгох, шинэ төрлийн шинжилгээний зохицуулалт,

¹²¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2010 оны №2.

¹²² Улсын Их Хурлын 2020 оны 54 дүгээр тогтоолын хавсралт, Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 оны №25,

¹²³ Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт, Төрийн мэдээлэл эмхэтгэл 2021 оны №11

итгэмжилсэн шинжээчийн эрх зүйн орчин, шүүхийн шинжилгээ хийх үндэслэл, журам, шинжилгээний онцлог, зарим төрлийн хохиролд үнэлгээ тогтоохтой холбоотой зохицуулалтыг бий болгох “зорилтыг дэвшүүлсэн.

Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн ¹²⁴ 4.3.7-д “Шүүхийн шинжилгээний үйл ажиллагаанд судалгаа, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангана” гэж заасан байна.

Эдгээр үндэслэл, шаардлагад тулгуурлан 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Монгол Улсын Засгийн газраас Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Иймд захиалагчаас ирүүлсэн захиалгыг удирдлага болгон шүүхийн шинжээчийн эрх зүйн орчин, шинжээчийн дүгнэлт, түүнийг шүүхэд нотлох баримтын түвшинд хэрхэн үнэлж байгаа талаар эрх зүйн орчны хүрээнд судлан танилцуулж байна.

Эрх зүйн орчны хувьд, судалгаанд авагдсан улсуудаас *Оросын Холбооны Улс (ОХУ)*-д “ОХУ-ын төрийн шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны тухай” (Закон о государственной судебно-экспертной деятельности в Российской Федерации) хуулиар, *Франц Улсад* “Шүүхийн шинжээчдийн тухай” (Loi n° 71-498 du 29 juin 1971 relative aux experts judiciaires) хуулиар, *Эстони Улсад* “Шүүхийн шинжилгээний тухай” (Forensic Examination Act) хуулиар шүүхийн шинжээчийн эрх зүйн орчныг тодорхойлж өгсөн байна.

ОХУ-ын Төрийн шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны тухай хуулиар иргэний, захиргааны болон эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл, зохион байгуулалтын зарчим, үндсэн чиглэлийг тодорхойлдог.

Эстони Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуулиар шүүхийн шинжээч, шүүхийн шинжилгээний байгууллага, албан ёсоор баталгаажсан шинжээчийн эрх зүйн байдал, эрүү, иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хөнгөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинжээчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбоотой асуудлыг зохицуулдаг байна.

Франц Улсын Шүүхийн шинжээчдийн тухай хууль нь шүүхийн шинжээчийг давж заалдах шатны шүүхийн жагсаалтад оруулах болон улсын хэмжээн дэх үндэсний жагсаалтад бүртгэх, бүртгэлийг сунгах, шинжээчийг эгүүлэн татах, огцруулах, сахилгын шийтгэл ногдуулах, шинжээчийн буруутай үйлдлээс гарсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг байна.

Эдгээр улсуудад дээрх хуулиудаас гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай болон бусад холбогдох хуулиудаар шүүхийн шинжээч, түүнтэй холбоотой асуудлуудыг зохицуулдаг байна.

Шүүхийн шинжээч, түүнийг томилох тухайд, ОХУ-ын төрийн шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны тухай хуульд зааснаар “Төрийн шүүхийн шинжээч нь албан үүргийнхээ хүрээнд шүүхийн шинжилгээ хийдэг төрийн шүүхийн шинжилгээний байгууллагын аттестатчилалд хамрагдсан ажилтан байна” гэж тодорхойлсон байна. Мөн процессын хуулиудад тодорхойлсныг нэгтгэвэл шинжээч нь хуульд заасан журмын дагуу томилогдож,

¹²⁴ Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт, Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 оны №38.

тодорхой хэргийн нөхцөл, асуудлыг тодруулах зорилгоор шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үүрэг хүлээсэн тусгай мэдлэгтэй этгээд байна” гэжээ.

Шинжээч томилох асуудлыг тухайн хэргийн нөхцөл байдалд үндэслэн шүүх, мөрдөн байцаагч, байцаагч шийдвэрлэнэ. Тухайлбал, шинжээчийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн шүүх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүх, мөрдөн байцаагч, байцаагч томилно.

Эстони Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуульд “*Шинжээч* гэж шүүхийн шинжилгээний чиглэлээр мэргэшсэн, судалгаа шинжилгээ хийх чадвартай хууль тогтоомжид заасан эрх зүйн болон эрх зүйн бус мэргэжилтэй этгээдийг хэлнэ” гээд шинжээчид дараах хүмүүсийг хамааруулж үзсэн байна. Үүнд, шүүхээс томилогдсон шинжээч, албан ёсны гэрчилгээтэй, баталгаажсан шинжээч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллагаас томилогдсон бусад хүмүүс хамаарна.

Франц Улсын Шүүхийн шинжээчдийн тухай хуульд “*Шүүхийн шинжээч* гэдэг нь шүүгчид хэрэг маргаануудыг шийдвэрлэх, шийдвэр гаргахад шаардлагатай техникийн болон нарийн мэргэжлийн дүгнэлт өгөх үүрэг бүхий тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнийг хэлнэ” гэж тодорхойлжээ. Шинжээчтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг иргэний ба эргүүгийн процессын хуулиудад тусгаж өгсөн байдаг.

Судалгаанд авагдсан 3 улсын хувьд шүүхийн шинжилгээ хийх шинжээчийг шүүх томилдог боловч зарим ялгаатай болон онцлох зохицуулалт байна. Тухайлбал, ОХУ-ын хувьд шүүхийн шинжилгээг шинжээчдийн комисс томилон хийлгэж болно. Комисст 2-оос доошгүй ижил, эсхүл өөр мэргэжлийн шинжээч байна.

Франц Улсын хувьд шүүхээс тухайн асуудалд тохирох шинжээчийг томилох боловч илүү нарийн мэргэжлийн шинжээчийн хэрэгцээ, шаардлага гарвал талууд тохиролцон шинжээчийг солих хүсэлтийг шүүгчид гаргаж болно.

Эстони Улсын хувьд шүүхээс шинжээчийг томилохоос гадна шүүхийн өмнөх шатны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийг цагдаа (мөрдөн байцаах байгууллага), эсхүл прокуророос томилж болдог байна.

Шинжээчийн дүгнэлт, түүнийг нотлох баримтын түвшинд үнэлэх тухайд, судалгаанд авагдсан улсуудын хувьд шинжээчийн дүгнэлт гэх ойлголтыг дараах байдлаар тодорхойлжээ. Тухайлбал,

ОХУ-д шинжээчийн дүгнэлт гэдгийг “шинжээч нь шүүхийн шинжилгээний явц, түүний үндсэн дээр шүүхээс тавьсан асуултын хариулт, дүгнэлтийг агуулсан бичмэл баримт бичиг байна” гэжээ.

Эстони Улсад шинжээчийн дүгнэлт гэдэг нь “үйл, баримтын нотолгоотой холбоотой үндэслэл болон учир шалтгааныг илэрхийлсэн шинжээчийн баримт бичиг бөгөөд энэ нь шинжилгээний тайлан хэлбэртэй байна” гэж тодорхойлсон байна. Франц Улсын хувьд шинжээчийн дүгнэлт нь шүүхийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хууль зүйн үр дагаварт хүргэхүйц чиглүүлэх дүгнэлт, зөвлөмжтэй байж болохгүй.

Шүүхийн шинжилгээ нь тодорхой хэргийн нотлох нөхцөл байдлыг тогтооход туслах үндсэн үүргийнхээ хувьд шинжээчийг томилсон субъектын тавьсан асуултад үндэслэлтэй, бодитой дүгнэлт өгөх явдал юм. Шинжээчийн дүгнэлт нь бусад бүх нотлох баримтуудын нэгэн адил урьдчилан “хөтөлбөргүй үнэн” гэж тогтоохгүй.

Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх нь юуны өмнө шүүхийн шинжээчийг томилох, цаашлаад шүүхийн шинжилгээ хийх, шинжээчийн дүгнэлт гаргах, шүүх хуралдаанаар шинжээчийн дүгнэлтийг сонсох, асуулт асуухдаа хуульд заасан журмыг дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгах цогц үйл явц байна.

Шүүх тухайн хэрэг маргааны хүрээнд шинжээчийн дүгнэлтийг хүлээн авч танилцан, олон талаас нь харж зөвлөлдөх боловч шийдвэрийг гаргахдаа зөвхөн шинжээчийн дүгнэлтээр хязгаарлагдахгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад цугларсан бүх нотлох баримтуудыг судлан үнэлж *өөрийн дотоод итгэл үнэмшилээрээ* шийдвэр гаргахыг процессын хуулиудад тодорхойлсон байна.

ОХУ-д захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийн дүгнэлтийг үнэлэхийн тулд тухайн шинжилгээ хийсэн шинжлэх ухаан, урлаг, гар урлал, технологийн чиглэлээр мэдлэгтэй мэргэжилтнийг татан оролцуулж болно. Тэрээр шинжээчийн дүгнэлтийг шинжлэх ухааны арга зүй, хуулиар зохицуулсан журамд нийцсэн эсэхийг судлах буюу өөрийн дүгнэлтийг гаргана.

Харин *Эстони Улсад* нотлох баримтыг үнэлэхийн тулд нэмэлт нотлох баримт цуглуулах шаардлагатай бол шүүх хуралдаанд оролцогчдод мэдэгдэж шүүхийн шийдвэрээр зохион байгуулдаг.

Шүүх шинжээчийн дүгнэлтийг үнэлж дуусаад дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргана. Үүнд:

- шинжээчийн дүгнэлт нь бүрэн, үндэслэлтэй бол түүнийг шүүхийн шийдвэрийн үндэслэлд оруулах;
- шинжээчийн дүгнэлт нь тодорхой бус, бүрэн бус гэж үзвэл нэмэлт шинжилгээ хийлгэх;
- шинжээчийн дүгнэлтийн үнэн, зөв эсэхэд эргэлзвэл дахин шинжээч томилох.

Мөн шүүх шинжээчийн дүгнэлттэй санал нийлээгүй, дахин шинжилгээ хийлгэхгүйгээр бусад нотлох баримтад үндэслэн хэргийг хянан шийдвэрлэж болно.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ТҮҮНИЙГ ҮНЭЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Нэг. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

1.1. Эрх зүйн орчин

Оросын Холбооны Улс (ОХУ)-д шүүхийн шинжилгээтэй холбоотой эрх зүйн үндсэн харилцааг 2001 онд батлагдсан **ОХУ-ын төрийн шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны тухай хуулиар** (Закон о государственной судебно-экспертной деятельности в Российской Федерации) зохицуулж байна. Энэ хууль нь тус улсад иргэний, захиргааны болон эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төрийн шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл, зохион байгуулалтын зарчим, үндсэн чиглэлийг тодорхойлдог.

Шүүхийн шинжилгээний талаар ОХУ-ын төрийн шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны тухай хуулиас гадна дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

- Арбитрын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “Арбитрын ХШХШтХ”) (Арбитражный процессуальный кодекс);
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “Захиргааны ХШХШтХ”) (Кодекс административного судопроизводства¹²⁵);
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “Иргэний ХШХШтХ”) (Гражданский процессуальный кодекс¹²⁶);
- Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “Эрүүгийн ХШХШтХ”) (Уголовно-процессуальный кодекс¹²⁷);
- бусад хууль, ОХУ-ын Ерөнхийлөгч, ОХУ-ын Засгийн газар болон шүүхийн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий холбооны гүйцэтгэх байгууллагуудаас гаргасан эрх зүйн хэм хэмжээний актууд хамаарна.

Энэхүү судалгаанд дээрх процессын хуулиудаас Арбитрын ХШХШтХ-иас бусад захиргаа, иргэн болон эрүүгийн процессын хуулиуд, ОХУ-ын төрийн шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны тухай хуулийн (цаашид “ТШШҮАтХ”) хүрээнд авч үзсэн болно.

ТШШҮАтХ-д зааснаар *шүүхийн шинжилгээ* (судебная экспертиза) гэж тус улсын хууль тогтоомжийн дагуу шинжлэх ухаан, технологи, урлаг, соёлын чиглэлээр тусгай мэдлэг шаардагдах асуудлаар судалгаа хийх, шинжээчийн дүгнэлт гаргах зэрэг үйл ажиллагааг ойлгоно. (ТШШҮАтХ-ийн §5)

Шүүхийн шинжилгээ хийх үндэслэл нь шүүх, хэрэг бүртгэх байгууллага, хэрэг бүртгэлт явуулж байгаа этгээд, мөрдөн байцаагч, байцаагч, прокурорын гаргасан шийдвэр байна.

Төрийн шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны үүрэг нь шинжлэх ухаан, технологи, урлаг, соёлын чиглэлээр тусгай мэдлэг шаардсан асуудлыг шийдвэрлэх замаар шүүх, хэрэг бүртгэх байгууллага, хэрэг бүртгэлт явуулж байгаа этгээд, мөрдөн байцаагч, байцаагч тодорхой хэргийн нотлох нөхцөл байдлыг тогтооход туслах явдал юм. (ТШШҮАтХ-ийн §2)

Шүүхийн шинжилгээг зохион байгуулах, хийх зорилгоор байгуулагдсан холбооны улсын эрх бүхий байгууллагууд, ОХУ-ын бүрэлдэхүүн улсуудын гүйцэтгэх засаглалын тусгай байгууллагууд нь *төрийн шүүхийн шинжилгээний байгууллагууд* (государственное судебно-экспертное учреждение) байна. (ТШШҮАтХ-ийн §11)

1.2. Шүүхийн шинжээч, түүнийг томилох

Төрийн шүүхийн шинжээч (государственный судебный эксперт) нь албан ажлын хүрээнд шүүхийн шинжилгээ хийдэг төрийн шүүхийн шинжилгээний байгууллагын аттестатчилалд хамрагдсан ажилтан байдаг. (ТШШҮАтХ-ийн §12) Энэ нь ОХУ-ын төрийн шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны тухай хуульд тодорхойлсон тодорхойлолт юм.

Энэ хуулиас гадна иргэний процессын хуулиас бусад процессын хуулиудад “шинжээч” хэмээх нэр томъёог мөн тодорхойлж өгсөн байна. Эдгээр тодорхойлолтуудыг нэгтгэвэл, шинжээч нь хуульд заасан журмын дагуу томилогдож, тодорхой хэргийн нөхцөл, асуудлыг

¹²⁵ “Кодекс административного судопроизводства Российской Федерации” от 08.03.2015 N 21-ФЗ (ред. от 30.12.2021, с изм. от 13.01.2022) (с изм. и доп., вступ. в силу с 10.01.2022).

¹²⁶ “Гражданский процессуальный кодекс Российской Федерации” от 14.11.2002 N 138-ФЗ (ред. от 30.12.2021, с изм. от 10.03.2022) (с изм. и доп., вступ. в силу с 01.02.2022).

¹²⁷ “Уголовно-процессуальный кодекс Российской Федерации” от 18.12.2001 N 174-ФЗ (ред. от 25.03.2022).

тодруулах зорилгоор шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үүрэг хүлээсэн тусгай мэдлэгтэй этгээд байна. (Захиргааны ХШХШТХ-ийн §49.1; Эрүүгийн ХШХШТХ-ийн §200)

Мөн шүүхийн шинжилгээг шинжээчдийн комисс томилж хийлгэж болно. Комисст 2-оос доошгүй ижил, эсхүл өөр мэргэжлийн шинжээч байна. Комиссын шинжээчид судалгаагаа бие даан хийж, өөрийн биеэр болон бусад шинжээчдийн гаргасан үр дүнг үнэлж, шүүхээс тавьсан асуултад дүгнэлт гаргана. (ТШШҮАТХ-ийн §21; Захиргааны ХШХШТХ-ийн §80; Иргэний ХШХШТХ-ийн §83; Эрүүгийн ХШХШТХ-ийн §200)

Шинжээч томилох асуудлыг тухайн хэргийн нөхцөл байдалд үндэслэн шүүх, мөрдөн байцаагч, байцаагч шийдвэрлэнэ. Тухайлбал, шинжээчийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн шүүх (Иргэний ХШХШТХ-ийн §79.1, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүх, мөрдөн байцаагч, байцаагч томилно (Эрүүгийн ХШХШТХ-ийн §195).

Эрүүгийн ХШХШТХ-ийн 196 дугаар зүйлд зааснаар дор дурдсан асуудлыг тогтоохын тулд шүүхийн шинжилгээ заавал хийлгэнэ. Үүнд:

- 1) үхлийн шалтгааныг;
- 2) эрүүл мэндэд учирсан хохирлын шинж чанар, зэргийг;
- 3) яллагдагч, сэжигтний эрүүл ухаан, эрх, хууль ёсны ашиг сонирхлоо бие даан хамгаалах чадварт эргэлзэж байгаа тохиолдолд түүний сэтгэцийн, эсхүл биеийн байдлыг;
- 4) хохирогчийн эрүүгийн хэрэгт хамааралтай нөхцөл байдлыг зөв ойлгож, мэдүүлэг өгөх чадварт эргэлзэх үед эрүүгийн хэрэгт чухал ач холбогдолтой нөхцөл байдлыг зөв ойлгож, мэдүүлэг өгөх чадварт эргэлзэж байгаа тохиолдолд сэтгэцийн, эсхүл биеийн байдлыг;
- 5) сэжигтэн, яллагдагч, хохирогчийн нас нь эрүүгийн хэрэгт чухал ач холбогдолтой, түүний насыг баталгаажуулсан баримт бичиг байхгүй, эсхүл эргэлзээтэй байгаа тохиолдолд тэдний насыг.

Шинжээч (шинжээчдийн комисс)-ийн үүргүүдийн нэг бол түүнийг томилсон субъектүүдээс тавьсан асуултад үндэслэлтэй, бодитой дүгнэлт өгөх явдал юм. (ТШШҮАТХ-ийн §16) Шинжээч хараат бус байж бусад этгээдээс хамааралгүйгээр тусгай мэдлэгээ ашиглаж гүйцэтгэсэн судалгааны үр дүнд үндэслэн дүгнэлт гаргана. Шинжээчид нөлөөлсөн гэм буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэнэ. (ТШШҮАТХ-ийн §7)

Шинжээч нь шүүхийн шинжилгээг бодитой, шинжлэх ухаан, практикийн үндсэн дээр, холбогдох мэргэжлийн хүрээнд, цогц, бүрэн хэмжээгээр явуулах **зарчмыг** баримтална. (ТШШҮАТХ-ийн §8)

1.3. Шинжээчийн дүгнэлт, түүнийг нотлох баримтын түвшинд үнэлэх

ТШШҮАТХ-д зааснаар шинжээч (шинжээчдийн комисс) нь шүүхийн шинжилгээний явц, түүний үндсэн дээр шүүхээс тавьсан асуултын хариулт, дүгнэлтийг агуулсан бичмэл баримт бичиг болох **шинжээчийн дүгнэлтэд** (заклучение эксперта) тусгаж, гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг дарж баталгаажуулдаг. (ТШШҮАТХ-ийн §9; 25)

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримтуудын нэг болох шинжээчийн дүгнэлт (Захиргааны ХШХШТХ-ийн §59.2; Иргэний ХШХШТХ-ийн §55.1; Эрүүгийн ХШХШТХ-ийн §74.2) нь шинжлэх ухаан, практик мэдээлэлд үндэслэн гаргасан бөгөөд түүний үндэслэлтэй, найдвартай байдлыг шалгах боломжтой байх ёстой. (ТШШҮАТХ-ийн §8) Иймд шинжээчийн дүгнэлтийг харуулсан баримт бичиг, материалыг түүнд хавсаргах ба

материалууд нь түүний салшгүй хэсэг байна. (ТШШҮАтХ-ийн §25; Захиргааны ХШХШтХ-ийн §82.3; Эрүүгийн ХШХШтХ-ийн §204.3)

Шинжээчийн дүгнэлтэд дараах зүйлүүдийг тусгана. (ТШШҮАтХ-ийн §25; Захиргааны ХШХШтХ-ийн §82.2; Эрүүгийн ХШХШтХ-ийн §204.1) Үүнд:

- шүүхийн шинжилгээ хийсэн газар, цаг;
- шүүхийн шинжилгээний хийх үндэслэл;
- шүүхийн шинжилгээний хийлгэхээр томилсон байгууллага, албан тушаалтны тухай мэдээлэл;
- дүгнэлт гаргах шүүхийн шинжилгээний байгууллага болон шинжээчийн тухай мэдээлэл;
- санаатайгаар худал дүгнэлт гаргасан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээх талаар анхааруулга;
- шинжээч (шинжээчдийн комисс)-д тавьсан асуулт;
- шүүхийн шинжилгээ хийлгэхээр шинжээчид ирүүлсэн шинжилгээний объект, хэргийн материал;
- шүүхийн шинжилгээнд оролцогчдын талаарх мэдээлэл;
- шүүхийн шинжилгээнд ашигласан арга, шинжилгээний агуулга, үр дүн;
- тавьсан асуултын талаар шинжилгээний үр дүн, түүний үндэслэл, гарсан дүгнэлт.

Шинжээч нь шүүхийн шинжилгээний явцад шүүхээс тавьсан асуултаас өөр тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой нөхцөл байдлыг шинээр олж тогтоосон бол тэрхүү шинэ нөхцөл байдлын талаарх дүгнэлтийг өөрийн дүгнэлтэд оруулах эрхтэй. (Захиргааны ХШХШтХ-ийн §82.4; Иргэний ХШХШтХ-ийн §86.2; Эрүүгийн ХШХШтХ-ийн §204.2)

Шинжээчийн дүгнэлт хангалтгүй, бүрэн гүйцэд бус гэж үзвэл *нэмэлт шинжилгээ* хийлгүүлэхээр тухайн шинжээчид, эсхүл өөр шинжээчид даалгаж болно. Харин шинжээчийн дүгнэлтийн үнэн зөв, үндэслэлтэй эсэхэд эргэлзэж байгаа бол *давтан шинжилгээ* хийлгүүлэхээр өөр шинжээчид (шинжээчдийн комисс)-т даалгаж болно. (ТШШҮАтХ-ийн §20)

Шинжээчийн дүгнэлт нь бусад бүх нотлох баримтуудын нэгэн адил урьдаас “хөтөлбөргүй үнэн” гэж тогтоох хүчин чадалгүй. (Захиргааны ХШХШтХ-ийн §84.2; Иргэний ХШХШтХ-ийн §67.2; Эрүүгийн ХШХШтХ-ийн §17.2)

Шүүх зөвхөн хэргийг хянан шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой нотлох баримтыг хүлээн авна. (Захиргааны ХШХШтХ-ийн §60; Иргэний ХШХШтХ-ийн §59) ОХУ-ын хуулийг зөрчиж олж авсан нотлох баримт нь хууль зүйн хүчингүй бөгөөд шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болохгүй. (Захиргааны ХШХШтХ-ийн §59.3; Иргэний ХШХШтХ-ийн §55.2)

Шүүх хэрэгт оролцогчийн бичгээр гаргасан хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй. Эрүүгийн хэргийн хувьд шүүх, прокурор, мөрдөн байцаагч, байцаагч Эрүүгийн ХШХШтХ-ийн 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсэгт заасны дагуу нотлох баримтыг хүлээн зөвшөөрөхгүй. (Захиргааны ХШХШтХ-ийн §61.2; Эрүүгийн ХШХШтХ-ийн §88)

Шинжээчийн дүгнэлтийг процессын хуулиудад заасан журмын дагуу үнэлнэ. (Захиргааны ХШХШтХ-ийн §82.8; Иргэний ХШХШтХ-ийн §86.3) Өөрөөр хэлбэл, шинжээчийн дүгнэлтийг үнэлэх нь юуны өмнө шүүхийн шинжээчийг томилох, цаашлаад шүүхийн шинжилгээ хийх, шинжээчийн дүгнэлт гаргах, шүүх хуралдаанаар шинжээчийн дүгнэлтийг сонсох, асуулт асуухдаа хуульд заасан журмыг дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгах цогц үйл явц байна.

Нийтлэг журмын дагуу шинжээчийн дүгнэлтийг бусад нотлох баримтуудын хамт шүүх өөрийн дотоод итгэлээр үнэлдэг. Ингэхдээ аливаа нотлох баримтыг иж бүрэн, бодитой, шууд шинжлэн судалсны үндсэн дээр түүний хамааралтай, хүлээн зөвшөөрөгдөх, найдвартай байдлыг үнэлэхийг процессын хуулиудаар шүүхэд үүрэг болгодог. (Захиргааны ХШХШТХ-ийн §84.1; Иргэний ХШХШТХ-ийн §67.1; Эрүүгийн ХШХШТХ-ийн §17.1; 88.1)

Захиргааны ХШХШТХ-ийн 84 дүгээр зүйл, Иргэний ХШХШТХ-ийн 67 дугаар зүйлд зааснаар шүүх нотлох баримтыг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

- шүүх нотлох баримт тус бүрийн хамаарал, хүлээн зөвшөөрөгдөх байдал, найдвартай байдлыг, түүнчлэн нотлох баримт хоорондын уялдааг үнэлнэ;
- шүүх нотлох баримтыг шалгасны дүнд түүнд агуулагдаж байгаа мэдээлэл үнэн гэж дүгнэх нь нотлох баримтыг найдвартай гэж хүлээн зөвшөөрсөнд тооцно;
- шүүх баримт бичиг болон бусад бичмэл нотлох баримтыг үнэлэхдээ ийм нотлох баримтыг гаргаж өгөх эрх бүхий байгууллагаас ирүүлсэн буюу тэдгээрт эрх бүхий этгээд гарын үсэг зурсан эсэхийг бусад нотлох баримтыг харгалзан тогтооно;
- шүүх баримт бичгийн болон бусад бичмэл нотлох баримтын хуулбарыг үнэлэхдээ тэдгээрийг хуулбарлах явцад тухайн баримт бичгийн хуулбарын агуулга эх хувьтай нь харьцуулахад өөрчлөгдсөн эсэх, хуулбарлахад ямар техник ашигласан, хуулбар нь эх хувийг баталгаажуулах эсэх, хуулбарыг хадгалсан нөхцөл зэргийг тогтооно;
- хэрэв баримт бичгийн эх хувийг үрэгдүүлсэн, эсхүл шүүхэд ирүүлээгүй баримт бичгийн буюу бусад бичмэл нотлох баримтын зөвхөн хуулбар байгаа тохиолдолд тухайн хуулбарт эх баримтын агуулгыг үнэн зөв хуулбарласан эсэхийг бусад нотлох баримтын тусламжтайгаар тогтоох боломжгүй бол шүүх авч үзэх боломжгүй.

Эрүүгийн хэргийн хувьд Эрүүгийн ХШХШТХ-ийн 17 дугаар зүйлд “Шүүгч, тангарагтны шүүгчид, прокурор, мөрдөн байцаагч, байцаагч нар эрүүгийн хэрэгт байгаа нотлох баримтын нийлбэрт үндэслэн хууль, өөрийн ухамсрыг удирдлага болгон дотоод итгэл үнэмшлээрээ нотлох баримтыг үнэлнэ.” гэж заасан нь нотлох баримтыг үнэлэх эрх чөлөөний зарчмыг баримталж байна.

ОХУ-ын Дээд шүүх 2010 оны 12 дугаар сарын 21-ний өдөр “Эрүүгийн хэргийн шүүхийн шинжилгээний тухай” 28 дугаар тогтоолыг¹²⁸ баталсан. Дээд шүүх нь энэхүү тогтоолыг эрүүгийн хэрэгт шүүхийн шинжилгээтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа Эрүүгийн ХШХШТХ-ийн хэм хэмжээг хэрэглэх үед гарч байдаг асуудлуудыг зохицуулах болон шүүхийн практикийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор гаргажээ.

Энэ тогтоолын 19 дүгээр зүйлд зааснаар шүүх эрүүгийн хэргийн шинжээчийн дүгнэлтийг дараах журмаар үнэлнэ. Үүнд:

- шинжээчийн дүгнэлт нь урьдаас тогтоосон хүчин чадалгүй, бусад нотлох баримтаас давуу байхгүй, бусад бүх нотлох баримтын нэгэн адил нийтлэг журмын дагуу үнэлэх;
- шинжээчийн ур чадварыг харгалзан үзэх, түүнд хангалттай материал, судалгааны зохих объектоор хангагдсан эсэхийг тогтоох;
- шинжээчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэрт эш татахдаа зөвхөн түүний дүгнэлтээр хязгаарлаж болохгүй;

¹²⁸ Постановление Пленума Верховного Суда РФ от 21.12.2010 N 28 (ред. от 29.06.2021) "О судебной экспертизе по уголовным делам". http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_108437/

- шинжээчийн дүгнэлтийг хуульд заасан журмын дагуу давж заалдсаны үндсэн дээр зөвхөн шийтгэх тогтоол, шүүхийн бусад эцсийн шийдвэрийн хамт эсэргүүцэж болно;
- Эрүүгийн ХШХШтХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.2.3 дахь хэсэгт заасны дагуу эрүүгийн хэргийн нотлох баримт нь шинжээчийн дүгнэлт болон мэдүүлэг байх ба бүх нотлох баримтын нэгэн адил шүүхэд шууд шалгагдана (Эрүүгийн ХШХШтХ-ийн Х хэсэгт заасан тохиолдлоос бусад) (Эрүүгийн ХШХШтХ-ийн §240).

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийн дүгнэлтийг үнэлэхийн тулд тухайн шинжилгээ хийсэн шинжлэх ухаан, урлаг, гар урлал, технологийн чиглэлээр мэдлэгтэй мэргэжилтэн (мэргэжилтнүүдийн комисс)-ийг оролцуулж болно. Мэргэжилтнүүд нь шинжээчийн дүгнэлтийг шинжлэх ухааны арга зүй, хуулиар зохицуулсан журамд нийцсэн эсэхийг судална (хянаана). Шинжээчдийн дүгнэлтийг судалсан (хянасан)-ы үр дүнд үндэслэн мэргэжилтэн (мэргэжилтнүүдийн комисс) нь өөрийн дүгнэлтийг гаргана.

Шүүх шинжээчийн дүгнэлтийг үнэлж дуусаад дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргана. Үүнд:

- 1) шинжээчийн дүгнэлт нь бүрэн, үндэслэлтэй бол түүнийг шүүхийн шийдвэрийн үндэслэлд оруулах;
- 2) шинжээчийн дүгнэлт нь хангалттай тодорхой бус, бүрэн бус, нэмэлт шинжилгээ хийлгэх;
- 3) шинжээчийн дүгнэлтийн үнэн зөв эсэхэд эргэлзэж, дахин шүүхийн шинжээч (шинжээчдийн комисс) томилох.

Мөн шүүх шинжээчийн дүгнэлттэй санал нийлээгүй бөгөөд дахин шинжилгээ хийхгүйгээр бусад нотлох баримтад үндэслэн хэргийг хянан шийдвэрлэж болно.

Харин шүүх шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа нь үндэслэлтэй байхыг хуулиар шаарддаг. (Захиргааны ХШХШтХ-ийн §82.8; Иргэний ХШХШтХ-ийн §86.3)

Шүүхийн шинжилгээний байгууллага, түүний шинжээч (шинжээчдийн комисс) нь хүний ба иргэний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарлахад хүргэсэн гэж үзэж байгаа бол энэ тухай хууль тогтоомжийн дагуу гомдол гаргах эрхтэй. (ТШШҮАтХ-ийн §6)

Хоёр. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС

2.1. Эрх зүйн орчин

Франц Улсын хувьд шинжээч гэх нэр томьёо анх 1606 онд Генри IV хааны үеэс эхтэй бөгөөд өөрийн эмч, мэс засалчдыг хаант улсын хот, тосгон, газруудад шүүхийн шийдвэрээр болон шинжээчийн чадвар шаардсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд очиж ажиллах, илтгэл тавих зэргээр томилон ажиллуулдаг байжээ. Харин 19 дүгээр зууны төгсгөлд буюу 1892 оны 11 сарын 30-ны өдрийн хуулиар мэргэшсэн шинжээч, эмч нарын анхны жагсаалтыг бий болгож, хуулиар эрх зүйн орчныг зохицуулж эхэлсэн байна.

1971 онд батлагдсан Шүүхийн шинжээчдийн тухай хууль (Loi n° 71-498 du 29 juin 1971 relative aux experts judiciaires) нь 8 бүлэг, 36 зүйлтэй. Энэхүү хууль нь шүүхийн шинжээчийг давж заалдах шатны шүүхийн жагсаалтад болон улсын буюу үндэсний жагсаалтад бүртгэх, бүртгэлийг сунгах, шинжээчийг эгүүлэн татах, огцруулах, сахилгын шийтгэл ногдуулах, шинжээчийн буруутай үйлдлээс гарсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг байна.

Шүүхийн шинжээч нь мэргэжлийн үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг харьяаллын дагуу давж заалдах шатны шүүх, улсын (үндэсний) шинжээчийн жагсаалтад бүртгүүлсэн байх шаардлага тавьдаг.

Шинжээчтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (Code de procédure civile¹²⁹) 263-284¹ дүгээр зүйл, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (Code de procédure pénale¹³⁰) 156-169 дүгээр зүйлд тус тус тусгасан байдаг. *Тухайлбал*, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 232 дугаар зүйлд зааснаар шүүгч нь тусгай мэдлэг шаардсан асуудлаар дүгнэлт гаргах, зөвлөлдөх, мэдээлэл өгөх шинжээчийг томилж болно, мөн хуулийн 234 дүгээр зүйлд зааснаар хэрэв шүүхээс томилогдох шинжээч нь хуулийн этгээд бол түүнийг шүүхэд хууль ёсоор төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, шинжээч, комиссын гишүүдийн нэрийг шүүгчид мэдэгдэнэ.

Мөн хуулийн 244 дүгээр зүйлд зааснаар шүүхийн шинжээч нь шалгагдаж буй асуултуудыг тодруулсан бүх мэдээллийг шинжээчийн хувиар илэрхийлнэ.

2.2. Шүүхийн шинжээч, түүнийг томилох

Шүүхийн шинжээч гэдэг нь шүүгчид хэрэг маргаануудыг шийдвэрлэх, шийдвэр гаргахад шаардлагатай техникийн болон нарийн мэргэжлийн дүгнэлт өгөх үүрэг бүхий тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнийг хэлдэг байна.

Шүүхээс томилогдсон шинжээч нь гэрчтэй ижил түвшний статустай байж бусад гэрчийн нэгэн адил шүүхэд мэдүүлэг өгөхдөө үнэнийг мэдүүлэх үүрэгтэй бөгөөд үнэн, шударга мэдүүлэг өгөх энэхүү үүрэг нь шинжээчийн хүлээсэн үүрэг хариуцлагуудаас дээгүүрт тавигдана.

“Шүүхийн шинжээчийг жагсаалт”-д бүртгэх:

Давж заалдах шатны шүүхээс шүүхийн шинжээчидэд нэр дэвшигчдийг сайтар нягтлан үзсэний дараа өөрийн гаргасан “Шүүхийн шинжээчдийн жагсаалт”¹³¹-д бүртгэдэг. Тэднийг Давж заалдах шатны шүүх болон маргаан гарсан тохиолдолд түүний харьяаллын дагуу томилдог. Шинжээчийн үүрэг бол тодорхой асуудлаар техникийн зөвлөгөө өгөх явдал юм. Шүүх эмнэлгийн шинжилгээ нь нэхэмжлэл гаргаж буй хүнд түүний өргөдлийг хэр анхааралтай авч үзэх баталгааг өгдөг.¹³²

Давж заалдах шатны шүүхийн Ажлын алба (le bureau de la Cour de cassation)-аас гаргадаг шинжээчдийн жагсаалтад бүртгүүлэх хүсэлтэй шинжээчийг 3 жилийн туршилтын хугацаатай ажиллуулна. Туршилтын хугацаа дууссаны дараа шинжээч нь дахин хүсэлт гаргана. Шүүхийн төлөөлөгч, шинжээчдийн нэгтгэсэн комиссоос тухайн шинжээчийн ажлын туршлага, үндэслэл бүхий дүгнэлтийг харгалзан түүний жагсаалтад байх хугацааг 5 жилээр сунгана.

Харин улсын буюу үндэсний жагсаалтад 7 жилийн хугацаатайгаар бүртгэдэг бөгөөд хугацаа дууссаны дараа ажлын үр дүнгээр нь дахин 7 жилээр үргэлжлүүлэн ажиллах, эсхүл шинжээчийн эрхийг хасах эсэх асуудлаар Шүүхийн төлөөлөгч, шинжээчдийн нэгтгэсэн комисс дүгнэлт гаргадаг.

¹²⁹ Code de procédure civile. https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006070716/

¹³⁰ Code de procédure pénale. https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006071154/2022-04-19/

¹³¹ Liste des experts judiciaires. Cour d'appel de Paris. <https://www.cours-appel.justice.fr/paris/experts-judiciaires>

¹³² Cour d'appel de Paris. <https://www.cours-appel.justice.fr/paris/experts-judiciaires>

Шүүхийн шинжээч давж заалдах шатны шүүхэд, эсхүл улсын буюу үндэсний жагсаалтад бүртгэгдсэн бол анхны томилолтынхоо өмнө нэг удаа тангараг өргөдөг. Хэрэв шинжээчийг давж заалдах шатны шүүхэд, эсхүл улсын буюу үндэсний жагсаалтаас сонгоогүй бол тухайн шинжээч шүүхээс түүнийг томилогдсон даруйд тангараг өргөх ёстой бөгөөд тангараг өргөсөн тухай тайланг хавтаст хэрэгт хавсаргадаг байна.

Шинжээчийг солих, шинжээчээс татгалзах: Шинжээчийн үйл ажиллагааг нөгөө тал буюу тэдний өмгөөлөгчийн зүгээс сайтар хянаж, ажиглаж байх ёстой байдаг.

Шүүхээс томилсон шинжээчийн үйл ажиллагаанд нөгөө талын зүгээс сэтгэл хангалуун бус байгаа тохиолдолд түүнийг солих хүсэлтийг шүүгчид гаргах боломжтой. Шинжээчид сэтгэл хангалуун бус байх шалтгаан нь зан чанар, үзэл бодлын зөрчилдөөн, шинжээчийн ур чадвар зэргээс үүдэлтэй байж болно.

Шинжээчийг хэд хэдэн үндэслэл шалтгааны улмаас сольж болно. *Жишээлбэл*, шинжээчийн дүгнэлт хийх явцад гарсан ноцтой хүндрэлүүд, тухайлбал, шинжээчийн идэвхгүй байдал, илэрхий өрөөсгөл хандлага гаргаж байгаа байдал, ашиг сонирхлын зөрчил үүсэх, эсхүл шинжээч өөрийн мэргэшил чадвар хангалтгүй байгааг хүлээн зөвшөөрсөн зэрэг байж болно.

Шүүхээс тухайн чиглэлээр тохирох шинжээчийг томилдог боловч бодит байдал дээр илүү нарийн мэргэжлийн шинжээчийн хэрэгцээ шаардлага гарч болох бөгөөд энэ тохиолдолд өмгөөлөгчтэйгөө хэлэлцэж шаардлагатай гэж үзвэл шинжээчийг солих хүсэлт гаргахын тулд шинжээчийн хяналтын шүүгчид хандаж болно. Гэхдээ энэхүү хүсэлтийг шинжээчийн дүгнэлт гарахаас өмнө гаргах ёстой байдаг.

2.3. Шинжээчийн дүгнэлт, түүнийг нотлох баримтын түвшинд үнэлэх

Шүүх нь шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ:

1. шинжээчийн туршлага, ур чадвар;
2. шинжээчийн дүгнэлт өрөөсгөл, улмаар аль нэг талыг дэмжих хандлагатай эсэх;
3. шинжээчийн дүгнэлт нь тухайн салбарын бусад мэргэжилтнүүдийн хүлээн зөвшөөрсөн аргаар хийсэн эсэх;
4. шинжээч нь хэрэг маргаантай хамааралгүй, эсхүл үндэслэлгүй дүгнэлтэд хүрсэн эсэх;
5. шинжээчийн эсрэг талын өмгөөлөгч, эсхүл шүүхээс түүнд тавьсан асуултад өгсөн хариулт нь түүний дүгнэлтийн үнэ цэнийг бууруулж байгаа эсэх;
6. дүгнэлт өгөх үеийн шинжээчийн итгэл үнэмшил;
7. шүүхэд хамааралтай гэж үзсэн бусад хүчин зүйлүүд гэх мэт.

Шинжээчийн дүгнэлт нь шүүхийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хууль зүйн үр дагаварт хүргэхүйц чиглүүлэх дүгнэлт, зөвлөмжтэй байж болохгүй бөгөөд, шүүх нь шинжээчийн дүгнэлтэд захирагдахгүй. Гэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 238 дугаар зүйлд заасны дагуу шинжээчийн дүгнэлт шүүгчийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлийн нэг юм.

Шүүх тухайн хэрэг маргааны хүрээнд шинжээчийн дүгнэлтийг хүлээн авч танилцан олон талаас нь харж зөвлөлдөх боловч шийдвэрийг гаргахдаа зөвхөн шинжээчийн дүгнэлтээр хязгаарлагдахгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад цугларсан бүх нотлох баримтуудыг судлан үнэлж, өөрийн дотоод итгэл үнэмшлээрээ шийдвэр гаргадаг байна.

Гурав. БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛС

3.1. Эрх зүйн орчин

Эстони Улс Шүүхийн шинжилгээний тухай (Forensic Examination Act) хуулийг 2001 онд баталж, 2002 онд мөрдөж эхэлсэн байна. Хууль нь 6 бүлэг, 31 зүйлтэй.

Хуулийн *хамрах* хүрээ нь шүүхийн шинжээч, шүүхийн шинжилгээний байгууллага, албан ёсоор баталгаажсан шинжээчийн эрх зүйн байдал, эрүү, иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хөнгөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино. (§1)

Шүүхийн шинжилгээ гэж шүүхэд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчээр томилогдсон этгээдийн танилцуулсан материалыг судалж, шүүхийн даалгаврын дагуу дүгнэлт гаргах мэргэжлийн үйл ажиллагааг хэлнэ. (§2)

Эстони Улсын *Шүүхийн шинжлэх ухааны хүрээлэн*¹³³ (EFSI-Estonian Forensic Science Institute) Шүүхийн шинжилгээний товчоо болон Шүүх эмнэлгийн үйлчилгээний төвийг нэгтгэн 2008 онд Хууль зүйн яамны харьяанд байгуулсан байна.

Хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн *зорилго* нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ур чадвар бүхий шүүхийн шинжээчээр хангах, шүүхийн шинжилгээг хөгжүүлэх, цагдаагийн байгууллагын шүүхийн шинжилгээний сургалтыг зохион байгуулах, хүрээлэнгийн чиг үүрэгтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх, үндэсний мэдээллийн сан, бүртгэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Шүүхийн шинжлэх ухааны хүрээлэн нь дараах хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.¹³⁴ Үүнд:

- Шүүхийн шинжилгээний тухай хууль (Forensic Examination Act);
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (Code of Administrative Court Procedure);
- Зөрчлийн тухай хууль (Code of Misdemeanour Procedure);
- Зэвсгийн тухай хууль (Weapons Act);
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (Code of Civil Procedure);
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, бэлдмэлүүдийн тухай хууль (Act on Narcotic Drugs and Psychotropic Substances and Precursors thereof);
- Тэсрэх бодисын тухай хууль (Explosives Act);
- Үхлийн шалтгааныг тогтоох тухай хууль (Establishment of Cause of Death Act);
- Хууль сахиулах тухай хууль (Law Enforcement Act);
- Эрүүгийн хууль (Penal Code);
- Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (Code of Criminal Procedure);
- бусад хууль.

Эдгээр хуулиас гадна Эстонийн Шүүхийн шинжлэх ухааны хүрээлэнгийн дүрэм (Regulation of Estonian Forensic Science Institute)-ийг үйл ажиллагаандаа мөрддөг.

¹³³ Estonian Forensic Science Institute, <https://www.ekei.ee/en>

¹³⁴ Estonian Forensic Science Institute <https://www.ekei.ee/en/efsi-organisation/legal-framework>

3.2. Шүүхийн шинжээч, түүнийг томилох

Шинжээч гэж шүүхийн шинжилгээний чиглэлээр мэргэшсэн, судалгаа шинжилгээ хийх чадвартай, хууль тогтоомжид заасан эрх зүйн болон эрх зүйн бус мэргэжилтэй этгээдийг хэлнэ. (§4) Шинжээчид дараах хүмүүсийг хамааруулж болно. Үүнд:

1. шүүхээс томилогдсон шинжээч;
2. албан ёсны гэрчилгээтэй, баталгаажсан шинжээч;
3. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллагаас томилогдсон бусад хүмүүс.

Албан ёсны гэрчилгээтэй, *баталгаажсан шинжээч* гэж албан ёсны гэрчилгээтэй, шинжээчдийн жагсаалтад орсон хүнийг хэлнэ. (§10) Баталгаажсан шинжээчдийн жагсаалтыг салбар тус бүрээр нь Шүүхийн шинжилгээний байгууллага хөтлөн гаргах бөгөөд жагсаалтыг өдөр тутмын үндэсний сонинд нийтэлдэг. Шүүхийн шинжилгээний байгууллагад шүүхийн шинжээчээр ажиллаж байгаа хүмүүсийг жагсаалтад оруулдаггүй. (§12.2.2)

Шүүхийн шинжээч тангараг өргөж, албан ёсны гэрчилгээ авсны дараа шинжээчийн жагсаалтанд орно. Албан ёсны гэрчилгээг сунгах тохиолдолд дахин тангараг өргөхгүй, харин тухайн шинжээч жагсаалтаас хасагдсан бол өмнөх тангараг хүчингүй болох зохицуулалттай байна. (§17) Гэрчилгээний хугацаа 3 жил байх бөгөөд хүсэлт гаргавал дахин сунгаж болно.

Шүүхийн шинжээчийг томилох (§294): Шинжээчийг шүүх, зарим тохиолдолд талууд томилж болно. Урьдчилсан болон шүүхийн өмнөх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч томилж болно. Шүүхийн өмнөх шатны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийг цагдаа (мөрдөн байцаах байгууллага), эсхүл прокуророос томилж болно. Харин талууд шинжээч томилоогүй, томилох талаар тохиролцоогүй, эсхүл шүүх хуралдаан болохоос өмнө шинжээчийн дүгнэлт гарсан тохиолдолд шүүх шинжээч томилно.

Шинжээчийн дүгнэлтийг шүүхийн шинжээч, улсын шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаг мэргэшсэн хүн, албан ёсны гэрчилгээтэй, баталгаажсан шинжээч, эсхүл шүүхээс томилогдсон тусгай мэргэшсэн бусад хүн хийдэг. Шүүх шинжээч томилохдоо талуудын саналыг харгалзан үзнэ.

Шүүхийн шинжилгээг шүүхийн шинжээч, улсын шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаг бусад мэргэшсэн мэргэжилтэн, албан ёсны гэрчилгээтэй шинжээч, эсхүл шүүхээс томилогдсон тусгай мэргэшсэн хүн хийдэг. Албан ёсны гэрчилгээтэй, баталгаажсан шинжээч байгаа тохиолдолд давуу тал болдог байна.

Шүүх шинжээчээр ажиллах боломжтой хүмүүсийг санал болгож, талууд шинжээчийн талаар тохиролцсон бол тухайн этгээд нь шүүхийн шинжээчээр томилогдно. Мөн шүүх нэмэлт шинжээч томилох, эсхүл томилогдсон шинжээчийг үргэлжлүүлэн томилж болно.

Шинжээчид хүлээлгэх хариуцлага: Шүүхийн шинжээч нь санаатайгаар дүгнэлтээ худал гаргасан бол Эрүүгийн хуулийн 321 дүгээр зүйлд¹³⁵ зааснаар эрүүгийн гэмт хэрэгт тооцогдоно. Тухайлбал:

- бусдыг эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн талаар санаатайгаар худал дүгнэлт гаргаж гүтгэсэн бол мөнгөн торгууль болон нэг жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэх;
- нотлох баримтыг хуурамчаар үйлдсэн бол мөнгөн торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

¹³⁵ Penal Code., <https://www.rigiteataja.ee/en/eli/522012015002/consolidate>

Мөн дараах тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаангүй бол шинжээчид хариуцлага тооцно (§304):

- шүүхээс дуудахад шүүх хуралдаан, сонсголд ирээгүй бол;
- хариуцлагыг сануулсан анхааруулах бичвэрт гарын үсэг зурахаас татгалзсан бол;
- дүгнэлт өгөхөөс татгалзсан бол;
- шүүхээс тогтоосон хугацаанд дүгнэлтээ ирүүлээгүй бол;
- өөрт тавьсан асуултад хариулахаас татгалзсан бол;
- шинжээчийн дүгнэлттэй холбоотой материал ирүүлэхээс татгалзсан бол.

3.3. Шинжээчийн дүгнэлт, түүнийг нотлох баримтын түвшинд үнэлэх

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар *шинжээчийн дүгнэлт* гэдэг нь үйл, баримтын нотолгоотой холбоотой үндэслэл болон учир шалтгааныг илэрхийлсэн шинжээчийн баримт бичиг бөгөөд энэ нь шүүхийн шинжилгээний тайлан хэлбэртэй байна.

Шүүхийн шинжээчийн дүгнэлтийн талаар тус улсын Шүүхийн шинжилгээний тухай хуульд зохицуулалт байхгүй, харин Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад зохицуулсан байна.

Шинжээчийн дүгнэлт (§301): Тусгай мэргэжлийн ур чадвар шаардсан асуудалтай холбоотой нөхцөл байдлыг тодруулахын тулд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн хүсэлтээр, эсхүл шүүхийн санаачилгаар шинжээчийн дүгнэлтийг авч болно.

Шүүхийн шинжээч нь дүгнэлтээ дараах журмын дагуу гаргана. Үүнд:

- шүүхээс амаар, эсхүл шинжээчийн зөвшөөрснөөр өөр хэлбэрээр шинжээчээс дүгнэлт гаргаж өгөхийг даалгаснаас бусад тохиолдолд шинжээч нь дүгнэлтээ шүүхэд бичгээр гаргаж өгнө;
- шинжээчийн нарийвчилсан шалгалтын үр дүнд гарсан дүгнэлт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн асуулт, хэрэгцээ шаардлагад нийцсэн үндэслэл бүхий хариулт агуулсан дэлгэрэнгүй үр дүнг илэрхийлсэн тайлан байна;
- шүүхээс тогтоосон асуудлаар шүүхийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана;
- шинжээчийн дүгнэлт гаргахын тулд хэрэгт шаардлагатай аливаа материалыг судална;
- шүүхээс нэмэлт мэдээлэл шаардаж болно;
- өөрт тавьсан асуултын талаар зөв, үндэслэл бүхий дүгнэлт гаргах;
- дүгнэлт хийх явцад батлагдсан баримтын нууцыг хадгалах үүрэг хүлээж, зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр ил болно;
- шүүхийн шинжилгээ хийх явцад судлах асуултын хүрээнд биш боловч тухайн асуудалтай хамааралтай баримтуудыг олж тогтоовол уг баримтын талаар дүгнэлт гаргаж болно.

Шүүхээс хэд хэдэн шинжээч томилж болох бөгөөд шинжээчид нэгдсэн дүгнэлтэд хүрсэн тохиолдолд хамтарсан дүгнэлт гаргаж болно. Хэрэв шинжээчид нэгдсэн дүгнэлтэд хүрч чадахгүй бол шинжээч бүр тусдаа дүгнэлт гаргана.

Шүүх шинжээчээс нэмэлт мэдээлэл авахаар асуулт тавьж, шүүх хуралдаанд оролцуулж болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 107.2-т зааснаар хэрэв шинжээчийн дүгнэлтийг тангараг өргөөгүй хүн гаргасан бол шинжээчийн дүгнэлтийн танилцуулгад эрүүгийн хариуцлагын талаар анхааруулсан тухай тэмдэглэгээнд гарын үсэг зурна.

Шүүхийн шийдвэрээр гаргасан шинжээчийн дүгнэлт, эсхүл эрүүгийн болон хөнгөн гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллагын захиалгаар гаргасан шинжээчийн дүгнэлтээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулах зорилгоор шүүх ашиглаж болно.

Шинжээчийн дүгнэлт гаргах. Шинжээч дүгнэлт гаргахдаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудыг байлцуулах шаардлагатай бөгөөд шүүх үүнийг шинжээчийн дүгнэлтийн тухай шийдвэр зааж өгч болно. Хэрэв хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудыг байлцуулахгүйгээр шинжээч дүгнэлт гаргах боломжтой гэж шүүх үзвэл хурлын оролцогчид байхгүй байх нь шинжээчийн дүгнэлт гаргахад саад болохгүй.

Хэрэв тухайн асуудал маргаантай бол шинжээчийн дүгнэлт гаргахдаа үндэслэсэн нөхцөл байдлыг шүүх тогтооно. Тухайлбал, хэрэв шаардлагатай бол шүүх нотлох баримттай холбоотой асуудлыг шинжээч ямар хэмжээнд шалгах эрхтэй, шинжээч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудтай холбогдох боломжтой эсэх зэргийг тогтоож өгнө. Шинжээчид өгсөн даалгаврын талаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудад мэдэгдэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 95.4-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллага нь гадаад улсын шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээчийн дүгнэлт гаргуулах хүсэлт гаргаж болно.

Шинжээчээр томилогдсон этгээд хуульд заасан бусад тохиолдол буюу хүндэтгэн үзэх шалтгаанаар шинжээчийн дүгнэлт гаргахаас татгалзаж болно. Мөн шүүх шинжээчийг бусад шалтгаанаар шинжээчийн дүгнэлт гаргах үүргээс чөлөөлж болно гэж Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 296-т заасан.

Шинжээчийг сонсох, анхааруулга өгөх (ИХХШТХ§303): Шинжээчийн дүгнэлтийг шүүх хуралдаан, сонсголын үеэр ил болгох бөгөөд талуудын хүсэлтээр дүгнэлт гаргасан шинжээчийг дуудаж, асуулт тавьж болно. Шүүх хуралдаанд оролцогчид шинжээчийн дүгнэлтийг тодруулахын тулд асуулт тавьж болохоос гадна асуултыг шүүхэд урьдчилан гаргаж болох бөгөөд шүүх шинжээчид шилжүүлдэг. Шинжээч тавьсан асуултад үнэн зөв, үндэслэл бүхий тайлбар гаргана.

Шүүхийн шинжээч болон албан ёсны гэрчилгээгүй шинжээчийг (байгууллагаас томилогдсон) санаатайгаар буруу дүгнэлт гаргахгүй байхыг анхааруулж, шүүхийн протокол, анхааруулах бичвэрт гарын үсэг зуруулж баталгаажуулах журамтай. Гарын үсэг зурсан анхааруулгыг шинжээчийн дүгнэлтийн хамт шүүхэд илгээнэ.

Дахин шинжилгээ хийх (§304): Шинжээчийн дүгнэлт хоёрдмол утгатай, зөрчилтэй, хангалтгүй нэмэлт асуултаар засч залруулах боломжгүй бол шүүх дахин шинжилгээ хийлгэх эрхтэй. Дахин шинжилгээг хийлгэхдээ тухайн шинжээчийг, эсхүл өөр шинжээчдийг томилж болно. Шинжээч нь шүүхээс тогтоосон шинжилгээ хийлгэж байгаа асуудалтай хамааралтай асуултад хариулт өгөөгүй, шүүх хуралдаан, сонсголд тухайн асуултад хариулж чадаагүй бол шүүх нэмэлт шинжилгээ хийлгэх эрхтэй.

Нотлох баримт: Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 229, 272 дугаар зүйл, *Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай* хуулийн 56 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар бүлэгт нотлох баримттай холбоотой, нотлох баримтад ямар зүйл хамаардаг талаар тусгаж өгсөн байна.

Нотлох баримт гэж сэжигтэн, яллагдагч, хохирогчийн мэдүүлэг, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлтийн талаар тайлбар гаргасны дагуу шинжээчийн өгсөн мэдүүлэг, эд мөрийн баримт, мөрдөн байцаалтын ажиллагааны тайлан, шүүх хуралдааны протокол, тандалтын үйл ажиллагааны тайлан, бусад баримт бичиг болох гэрэл зураг, бичлэг зэргийг хэлнэ.

Нотлох баримтын үнэлгээ: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 238 дугаар зүйлд зааснаар эрүүгийн гэмт хэрэг, үндсэн эрхийг хууль бусаар зөрчиж нотлох баримтыг олж авсан бол шүүх нотлох баримтыг хүлээн авахаас татгалзаж буцааж болно. Шинжээчид мэргэжлийн түвшинд, бүрэн гүйцэд, үнэн бодитой гаргасан дүгнэлт нь шинжлэх ухааны үндэслэлтэй байх ерөнхий шаардлага тавигддаг. Энэ нь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагаанд хамаарна.

Талууд шинжээчийн дүгнэлтийг мэдэгдэл, эсхүл сөрөг дүгнэлт гаргах замаар эсэргүүцэж болно. Шүүх хуралдааны явцад талуудын аль нэг нь дүгнэлтийг эсэргүүцсэн ч шүүх шинжээчийн дүгнэлтийг нотлох баримтаар авч үзэж болно. Гэхдээ шүүх шинжээчийн дүгнэлтийг бусад нотлох баримттай холбогдуулан шийдвэрлэнэ. Шүүх хурлын өмнө шинжээчидтэй уулзах, хөндлөнгийн байцаалт авдаг журам байдаггүй ба харин шүүх хуралдааны явцад нэмэлт мэдээлэл шаардлагатай бол шинжээч талуудтай ярилцахыг зөвшөөрдөг.

Шүүх шинжээчийн гаргасан нотлох баримтыг хуулийн дагуу тал бүрээс нь сайтар, бодитой үнэлж, дүгнэж шүүх өөрийн итгэл үнэмшлийн дагуу шүүх хуралдаанд оролцогчийн маргааныг бусад хүчин зүйлсийг харгалзан нотолсон эсэхийг хянан шийдвэрлэнэ.

Нотлох баримтыг үнэлэхийн тулд нэмэлт нотлох баримт цуглуулах шаардлагатай бол шүүх хуралдаанд оролцогчдод мэдэгдэж шүүхийн шийдвэрээр зохион байгуулна. Хэрэв хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй шүүхийн харьяаллаас гадуур нотлох баримт авах шаардлагатай бол тухайн хэргийг хянан хэлэлцэж буй шүүх тухайн нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны актыг гүйцэтгэх тухай тогтоол гаргахын тулд хүсэлтийг бичгээр илгээж нотлох баримтыг авч болно.

Шийдвэр гаргасны дараа нотлох баримтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27-32 дугаар бүлэгт заасан нотлох баримтын төрлөөс хамааруулан нотлох баримт цуглуулах журамд нийцүүлэн авна.



АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**Монгол Улс:**

- Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. <http://forum.parliament.mn/projects/11237>
- Төрийн мэдээлэл эмхэтгэл 2010 оны №2.
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 54 дүгээр тогтоолын хавсралт, Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 оны №25,
- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт, Төрийн мэдээлэл эмхэтгэл 2021 оны №11
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт, Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 оны №38.

Оросын Холбооны Улс:

- "Кодекс административного судопроизводства Российской Федерации" от 08.03.2015 N 21-ФЗ (ред. от 30.12.2021, с изм. от 13.01.2022) (с изм. и доп., вступ. в силу с 10.01.2022). <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102380990>
- "Гражданский процессуальный кодекс Российской Федерации" от 14.11.2002 N 138-ФЗ (ред. от 30.12.2021, с изм. от 10.03.2022) (с изм. и доп., вступ. в силу с 01.02.2022). <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102078828>
- "Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ (ред. от 25.03.2022). <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&nd=102073942>
- Постановление Пленума Верховного Суда РФ от 21.12.2010 N 28 (ред. от 29.06.2021) "О судебной экспертизе по уголовным делам". http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_108437/

Бүгд Найрамдах Франц Улс:

- Loi n° 71-498 du 29 juin 1971 relative aux experts judiciaires. <https://www.legifrance.gouv.fr/loda/id/JORFTEXT000000874942/>
- Code de procédure civile. https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006070716/
- Code de procédure pénale. https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006071154/2022-04-19/
- Cour d'appel de Paris. <https://www.cours-appel.justice.fr/paris/experts-judiciaires>

Бүгд Найрамдах Эстони Улс:

- Forensic Examination Act. <https://www.riigiteataja.ee/en/eli/ee/501042019023/consolide/current>
- Estonian Forensic Science Institute, <https://www.ekei.ee/en>
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (Code of Civil Procedure). <https://www.riigiteataja.ee/en/eli/ee/510012017004/consolide/current>
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Code of Criminal Procedure). <https://www.riigiteataja.ee/en/eli/ee/522012015002/consolide>
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (Code of Administrative Court Procedure)

**ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООХ
БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ**

(Тойм судалгаа)

О.Нарантуяа

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ

1. ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ

- 1.1.1992 оны Үндсэн хууль хэлэлцсэн байдал
- 1.2.Засгийн газрын Ажлын хэсгийн асуулга (2016 он)
- 1.3.Зөвлөлдөх санал асуулга (2017 он)

2.ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

- 2.1.Дэлхийн улс орнуудын парламентын танхимын тоо
- 2.2.Парламентын нэг танхимын талаар
- 2.3.Парламентын хоёр танхимын талаар
- 2.4.Хоёр шатлал бүхий парламентын талаар

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Монгол Улсын Үндсэн хуулиудад парламентын танхимын талаар зохицуулсан байдал
- Хүснэгт 2. Монгол Улсын Их Цаазын өөрчлөлтийн харьцуулалт
- Хүснэгт 3. Монгол Улсын хоёр шатлал бүхий парламентын бүрэн эрхийн ялгаа
- Хүснэгт 4. Саналын томьёолол: УИХ нэг танхимтай байна
- Хүснэгт 5. Саналын томьёолол: УИХ хоёр танхимтай байна
- Хүснэгт 6. Засгийн газрын Ажлын хэсгээс явуулсан асуулга, хариулт (УИХ-ын бүтэц, зохион байгуулалттай холбоотой)
- Хүснэгт 7. Зөвлөлдөх санал асуулга, хариулт (УИХ хоёр танхимтай байх хувилбар, хувиар)
- Хүснэгт 8. Дэлхийн улс орнуудын парламентын танхимын тоог засаглалын хэлбэрээр авч үзвэл
- Хүснэгт 9. Нэг танхимтай парламентын эерэг, сөрөг тал
- Хүснэгт 10. Хоёр танхимтай парламентын эерэг, сөрөг тал
- Хүснэгт 11. Хоёр шатлал бүхий парламентын эерэг, сөрөг тал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АИХ	Ардын Их Хурал
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТИХ	Ардын Төлөөлөгчдийн Их Хурал
БНАСАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНУ	Бүгд Найрамдах Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ӨАБНУ	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс
УБХ	Улсын Бага Хурал
УИХ	Улсын Их Хурал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Монгол Улсын хувьд, хоёр шатлал бүхий нэг танхимтай парламентын уламжлал бий бөгөөд энэ нь 1924 оны Үндсэн хуулиас эх сурвалжтай. Улмаар 1940, 1960 оны Үндсэн хууль болон 1990 оны Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулиудад хууль тогтоох байгууллагын өөрийн бүтцийг хоёр шатлалт нэг танхимтай байхаар зохион байгуулж ирсэн байна. Харин 1990 оны Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд Төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурал, хууль тогтоох байгууллага нь Улсын Бага Хурал байна гэж заасан. Харин 1992 оны ардчилсан шинэ Үндсэн хуулийн төсөл хэлэлцэх үед Улсын Их Хурлыг өөрчлөх хоёр хувилбарыг дэвшүүлж байжээ. Тухайлбал, Ардын Их Хурал хэмээх дээд танхим, Улсын Бага хурал хэмээх доод танхим буюу хоёр танхимтай болох, нөгөөх нь БНМАУ-ын Ардын Их Хурлыг шууд байнгын ажиллагаатай парламент болгох байв. Засгийн дээд эрх барих газар нь Ардын Төлөөлөгчдийн Их Хурал байх бөгөөд түүний чөлөөт цагт засгийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага нь БНМАУ-ын Бага Хурал байх хувилбар байв.

Гэвч 1992 оны Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх үед Монгол Улсын хууль тогтоох байгууллагыг хоёр шатлалтай байх асуудлаар санал хураалт явуулсан боловч олонхын дэмжлэг аваагүйн улмаас хууль тогтоох байгууллага зохион байгуулалтын хэлбэрийн хувьд нэг танхимтай, байнгын ажиллагаатай парламенттай байх хувилбарыг сонгожээ. Монгол Улсын Үндсэн хуулийг анх батлахад болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах бүрд парламентын танхимын асуудал хөндөгдөж байжээ. Тухайлбал, 1992 оны ардчилсан шинэ Үндсэн хуулийг батлахад парламентын танхимын талаар олон өдөр мэтгэлцэж, маргалдсан бөгөөд парламентын нэг танхимыг сонгох талаар 21 депутат, хоёр танхимыг сонгох талаар 120 депутат¹³⁶ саналаа хэлж байжээ. Гэвч олон хоногийн хэлэлцүүлэг, санал хураалтын дүнд парламентын нэг танхимыг сонгожээ.

Үүний дараа 2016 онд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын захирамжаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг судлах ажлын хэсгийг байгуулж, судалгаа хийсэн бөгөөд судалгаагаар Монгол Улсад хоёр танхимтай парламент зохимжтой гэж судалгаанд оролцогчдын 1019 хүн буюу 48.3 хувь, парламентын бүгд найрамдах улс гэж 967 хүн буюу 45.9 хувь нь хариулсан байна. Харин парламентын ямар бүтэц, зохион байгуулалтыг хэрхэн өөрчлөх талаарх асуултад гишүүдийн тоог цөөлөх, чанартай цөөн гишүүнтэй байх гэж 214 хүн буюу 45.7 хувь, парламентын хоёр танхимтай болох гэж 145 хүн буюу 31 хувь нь хариулжээ.

Энэхүү судалгааны дараа Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаарх анхдугаар зөвлөлдөх санал асуулгаар (2017 оны 04 дүгээр сар) хоёр дахь удаагийн санал асуулгад хамрагдсан 669 хүнээс Төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурал, хууль тогтоох байгууллага нь Улсын Бага Хурал гэсэн хоёр танхимтай байх гэсэн асуултад 579 хүн үнэлгээ өгснөөс нэг дэх санал асуулгад оролцогчдын 58.3 хувь нь дэмжиж байсан бол, хоёр дахь санал асуулгад 60.6 хувь нь үүний эсрэг саналтай байжээ.

Мөн хоёр танхимтай байснаар шийдвэр гаргахад төвөгтэй болж, төр засгийн үйл ажиллагаа бүтээмж багатай болно гэж үзжээ. Түүнчлэн Парламент хоёр танхимтай байснаар “Хоёр танхим хоёулаа нэг улс төрийн намын гишүүдээс бүрдэж хяналт тавих боломжгүй болно” гэж эхний болон хоёр дахь санал асуулгад оролцогчдын 43-аас дээш хувь нь үзсэнээр дэмжлэг авч чадаагүй юм.

¹³⁶ Улсын Их Хурлын Тамгын газар. АИХ-ын 1991.11.30-ний өдрийн хуралдааны тэмдэглэл. Дугаар 19, кассет 16. 32 дахь тал.

Дэлхийн улс орнуудын хувьд, Олон улсын парламентын холбоо (IPU)-ны гишүүн дэлхийн 191 улсаас¹³⁷ парламентын засаглалтай 74 улс, ерөнхийлөгчийн засаглалтай 46 улс, холимог засаглалтай (Presidential-parliamentary) 45 улс, хаант засаглалтай 12 улс, коммунист систем (Communist system)-тэй 5 улс байна. Эдгээрээс:

- 1) Парламентын засаглалтай 74 улсын хувьд:
 - нэг танхим бүхий парламенттай – 43 улс;
 - хоёр танхим бүхий парламенттай – 31 улс;
- 2) Ерөнхийлөгчийн засаглалтай 46 улсын хувьд:
 - нэг танхим бүхий парламенттай – 26 улс;
 - хоёр танхим бүхий парламенттай – 20 улс;
- 3) Холимог засаглал бүхий 45 улсын хувьд:
 - нэг танхим бүхий парламенттай – 23 улс;
 - хоёр танхим бүхий парламенттай – 22 улс;
- 4) Хаант засаглал бүхий 12 улсын хувьд:
 - нэг танхим бүхий парламенттай – 6 улс;
 - хоёр танхим бүхий парламенттай – 6 улс;
- 5) Коммунист системтэй 5 улсын хувьд:
 - бүгд хоёр шатлал бүхий нэг танхимтай парламенттай байна.

Дээрх статистик мэдээллээс үзэхэд, судалгаанд хамрагдсан дэлхийн 191 улсын 103 улс нь нэг танхимтай парламенттай, 79 улс нь хоёр танхимтай парламенттай байна. Парламентын засаглалтай 74 улсыг төрийн байгууламжийн хэлбэрээр авч үзвэл, нэгдмэл улс 61 байгаагаас,

- нэг танхимтай парламент – 43 улс;
- хоёр танхимтай парламент – 18 улс байна.

Холбооны улс (13)-ын хувьд бүгд хоёр танхим бүхий парламенттай байна. Өөрөөр хэлбэл, нэгдмэл улсуудын 70.5 хувь нь нэг танхимтай, 29.5 хувь нь хоёр танхимтай байна. Холбооны улсуудын хувьд бүгд хоёр танхимтай парламенттай байгаа бол коммунист системтэй 5 улс бүгд хоёр шатлал бүхий нэг танхимтай парламенттай байна.

Үндсэн хуулийн эрх зүйд парламент хэдэн танхимтай (chambers) байх вэ гэдэг нь маргаантай асуудал юм. Хууль тогтоох хоёр танхимтай (two legislative chambers) байх нь анх Их Британи ба Европын орнуудын хаант засаглалын системд аристократууд болон жирийн иргэдийн төлөөллийг, АНУ-д штатуудын төлөөллийг тус тус хууль тогтоох үйл ажиллагаанд оролцуулах шаардлагаас үүссэн байдаг.

Парламентын нэг танхимын хувьд, нэгдмэл улсууд ихэвчлэн нэг танхимтай парламенттай байх боловч хоёр танхимтай парламенттай орнууд цөөнгүй байна. Тэдгээрийн хувьд Дээд танхимдаа нийгмийн янз бүрийн бүлэглэлүүдийн төлөөллийг оролцуулах, Доод танхимынхаа хууль тогтоох үйл ажиллагааг хянах, зөвлөх эрхтэй байдаг байна. Нэг танхимтай парламент нь гол төлөв төвлөрсөн буюу нэгдмэл тогтолцоотой, үндэстний цөөнх багатай, хүн ам цөөнтэй, шашны ялгарал багатай орнуудад байдаг. Сүүлийн хориод жилд цөөнгүй орон ардчилсан тогтолцоонд шилжсэн, Үндсэн хуулийн бүтэц нь өөрчлөгдсөн зэрэг зарим өөрчлөлт гарсан ч хүн ам цөөнтэй орнууд ихэвчлэн нэг танхимтай парламентын систем сонгодог чиг хандлага хадгалагдсаар байна.

¹³⁷ Энэхүү судалгаанд шилжилтийн улс (Буркина Фасо, Чад, Гвиней, Ливи, Мали, Өмнөд Судан, Сири, Йемен) болон дайны нөхцөл байдалд байгаа Украин Улсыг оруулаагүй болно.

Парламентын хоёр танхимын хувьд, хоёр танхимтай парламентын тогтолцоог сонгон авахад тухайн орны төрийн эрх мэдлийг зохицуулж ирсэн уламжлал, холбооны болон нэгдмэл улсын тогтолцооны онцлог, эдийн засгийн хөгжлийн түвшин, хүн амын тоо, бүс нутгийн болон орон нутгийн удирдлагын тогтолцоо, үндэстэн ястан, шашин омгууд, бүс нутаг, нийгмийн анги давхаргуудын төлөөлөл, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал хоорондын эрх мэдлийн хуваарилалт, хяналтын тогтолцоо зэрэг олон хүчин зүйлүүдийг харгалзан үздэг. Парламентын хоёр танхимыг бүрдүүлэх хэлбэрийн хувьд дээд танхимыг томилгооны, сонгуулийн зарчмаар болон томилгоо болон сонгуулийн хосолмол хэлбэрээр бүрдүүлдэг. Доод танхимын хувьд ард түмний төлөөлөл болж, бүх нийтийн, чөлөөтэй, шууд сонгуулиар бүрддэг.

Хоёр шатлал бүхий парламентын хувьд, хууль тогтоох байгууллага буюу парламент нь хоёр шатлал бүхий нэг танхимтай байхаар Үндсэн хуульдаа хуульчилж, энэ загвараар парламентынхаа үйл ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд парламентын доод танхим нь дээд танхимаасаа томилогдсон гишүүдээс бүрддэгээрээ онцлогтой.

Парламентын танхим бүр өөр өөрийн гэсэн эерэг, сөрөг талтай байдгийг дараах хүснэгтээс үзнэ үү.

Парламентын танхимуудын эерэг, сөрөг талууд

ЭЕРЭГ ТАЛ	СӨРӨГ ТАЛ
Нэг танхимтай парламентын хувьд	
<ul style="list-style-type: none"> • Шаардлага тулгарсан үед хууль тогтоомжийг шуурхай батлан гаргах боломжтой. Хоёр танхимаар дамжин хугацаа алдахгүй гэсэн үг. • Зөвхөн нэг танхим гарсан хуулийн төлөө хүлээх хариуцлага тодорхой. • Нэг танхимтай, цөөн гишүүнтэй байхад зардал бага байна.¹³⁸ 	<ul style="list-style-type: none"> • Хуулийн төслийг дахин хянан хэлэлцэх боломжгүй байдаг. • Аль нэг нам давамгайлж байгаа тохиолдолд хуулиудыг хүчээр батлах боломжийг бий болгож, улмаар түүнийг дагаж мөрдөх нь олон нийтэд дарамт учруулдаг. • Хүн ам олонтой томоохон улс орнуудад төлөөллийг зөв, ил тод байлгах боломжгүй байдаг. (Энэтхэг, Хятад, АНУ гэх мэт)
Хоёр танхимтай парламентын хувьд	
<ul style="list-style-type: none"> • Бүс нутаг, нийгмийн анги давхарга, овог аймаг зэргээр нийгмийн олон янзын төлөөллийг парламентад оруулна. • Дутагдал, өө сөвтэй хууль батлагдан гарахаас сэргийлнэ. (нэг танхим нь нөгөөгийнхөө баталсан хуулийг дахин хэлэлцдэг) • Хоёр танхимтай байснаар гүйцэтгэх засаглалд тавих хяналт сайжирна. • Хууль тогтоох танхим улс төрийн томилгоо хийхгүй байх боломжтой болно. 	<ul style="list-style-type: none"> • Хууль тогтоомжийг шуурхай батлан гаргах процесс удаашралтай, олон шат дамжлагатай, хэлэлцүүлгийн хугацаа сунжрах, нэгдсэн шийдэлд хүрэхэд төвөгтэй. • Хууль тогтоох үйл ажиллагааны эцсийн хариуцлага хүлээх асуудал маргаантай юм. • Парламент болон Ажлын аппаратын зардал өндөр болно.

¹³⁸ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Гадаадын зарим орны хоёр танхимтай парламентын талаарх харьцуулсан судалгаа. СТ-11/212. 2011 он.

Хоёр шатлал бүхий парламентын хувьд¹³⁹

- Тодорхой орон нутаг, хүн ам, нийгмийн цөөнхийн ашиг сонирхлыг зөрчихөөс сэргийлэх.
- Улс төрийн намын нөлөөллийг багасгах, аливаа ашиг сонирхлоос ангид байх, монополь байдлыг тэнцвэржүүлэх.
- Шат тус бүрээр хэлэлцэн батлагдаж буй хууль тогтоомжийн чанар сайжрах.
- Парламентын хяналтын тогтолцоо сайжрах, доод танхимын үйл ажиллагааг хянах, мэргэшүүлэх.
- Хоёр шатлал бүхий парламент нь социалист дэглэмтэй улсад байдаг.
- Парламентын төсөв хэт ихсэх. Тухайлбал, сонгуулийн зардал, гишүүдийн зардал, албан хаагчдын зардал болон Парламентын ажлын албаны бүтэц хэт томрох.
- Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн үйл явц хэт удаашрах, цаг алдах.

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ**1. ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ****1.1.1992 оны Үндсэн хууль хэлэлцсэн байдал**

Монгол Улсын хувьд хоёр шатлал бүхий нэг танхимтай парламентын уламжлал бий бөгөөд энэ нь 1924 оны Үндсэн хуулиас эх сурвалжтай. Улмаар 1940, 1960 оны Үндсэн хууль болон 1990 оны Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулиудад хууль тогтоох байгууллагын өөрийн бүтцийг хоёр шатлалт нэг танхимтай байхаар зохион байгуулж ирсэн байна.

Хүснэгт 1. Монгол Улсын Үндсэн хуулиудад парламентын танхимын талаар зохицуулсан байдал

Үндсэн хууль	Эрх зүйн зохицуулалт
1924 оны Үндсэн хууль¹⁴⁰ (Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийг 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Улсын анхдугаар Их Хурлаар баталсан, 6 бүлэг, 50 зүйлтэй)	Үндсэн хуулийн Дөрөвдүгээр зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах бөгөөд мөн хурлын чөлөө цагт Бага Хурлын тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино.” гэж заасан. УИХ нь жилд нэг удаа, УБХ нь жилд хоёроос цөөнгүй хуралдах бөгөөд УБХ нь хурлын Тэргүүлэгчидтэй байна. УБХ нь шийтгэсэн хэрэг ба явуулсан засгийн ерөнхий бодлого зэргийг Улсын Их Хуралд илтгэнэ.
1940 оны Үндсэн хууль¹⁴¹ (1940 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Улсын VIII Их Хурлаар баталсан, 12 бүлэг, 95 зүйлтэй)	Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын засгийн дээд эрхийг барих газар нь Улсын Их Хурал болно. Улсын Их Хурлын чөлөө завсар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын засгийн дээд эрхийг Улсын Бага Хурал барина. Улсын Их Хурлыг Улсын Бага Хурлаас гурван жилд нэгэн удаа, Бага Хурлын тогтмол хурлыг жилд нэг удаа зарлан хуралдуулна. Бага Хурлын чөлөө цагт Бага Хурлын Тэргүүлэгчид засгийн дээд байгууллага мөн бөгөөд өөрийн бүх ажил явуулгын тухай тайлан илтгэлийг Бага Хуралд гаргана.
1960 оны Үндсэн хууль¹⁴² (1960 оны 7 дугаар сарын 06-ны өдөр баталсан, 10 бүлэг, 94 зүйлтэй)	Үндсэн хуулийн Гуравдугаар бүлэгт төрийн эрх барих дээд байгууллагын талаар зохицуулсан. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн эрх барих дээд

¹³⁹ Улсын Их Хурал. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал

асуулга явуулах сэдвийн танилцуулга. УБ., 2017 он. 54 дэх тал.

¹⁴⁰ <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1924.html>

¹⁴¹ <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1940.html>

¹⁴² <https://legalinfo.mn/api/front/index.html>

зүйлтэй)	байгууллага нь Ардын Их Хурал мөн бөгөөд хууль тогтоох эрхийг гагцхүү Ардын Их Хурал эдэлнэ. Ардын Их Хурлын ээлжит чуулганыг жилд нэг удаа хийх бөгөөд Ардын Их Хурлын чуулганы чөлөө цагт төрийн эрхийг Ардын Их Хурлын Тэргүүлэгчид хэрэгжүүлж, үйл ажиллагааныхаа талаар АИХ-ын өмнө хариуцан тайлагнана.
1990 оны Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль ¹⁴³ (БНМАУ-ын АИХ-ын 11 дэх удаагийн сонгуулийн IX чуулганаар баталсан.)	БНМАУ-ын Ардын Их Хурал бол монголын ард түмний бүрэн эрхийг илэрхийлсэн төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага мөн. БНМАУ-ын Бага Хурал нь хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрх бүхий төрийн эрх барих байнгын дээд байгууллага мөн.
1992 оны Үндсэн хууль ¹⁴⁴ (1992 оны 01-р сарын 13-нд БНМАУ-ын АИХ-аар баталсан, 6 бүлэг, 70 зүйлтэй)	Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.

1990 оноос Монгол Улс ардчилсан тогтолцоо бүхий зах зээлийн эдийн засгийн нийгэмд шилжихэд эрх зүйн үндэс болсон шинэ Үндсэн хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, ард нийтээр хэлэлцүүлсний дараа Ардын Их Хурал (АИХ)-аар нэлээдгүй хэлэлцэж баталсан билээ.

АИХ-аас 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр БНМАУ-ын төрийн дээд байгууллагын бүтцийн талаар тогтоол баталжээ.¹⁴⁵ Энэхүү тогтоолд ард нийтээр хэлэлцүүлэх Үндсэн хуулийн төсөлд БНМАУ-ын төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага нь АИХ, хууль тогтоох байнгын дээд байгууллага нь Улсын Бага Хурал (УБХ) байх зохицуулалтыг тусгах чиглэлийг өгчээ. Үүний дагуу 1990 оны Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд дээрх зохицуулалтыг тусгажээ.

Харин ардчилсан шинэ Үндсэн хуулийг (1992) хэлэлцэн батлах явцад төслийг нийт 5 удаа өөрчлөн өргөн барьж байсан бөгөөд парламентын нэг, эсхүл хоёр танхимтай байх эсэх талаарх зохицуулалтыг тэдгээр төслүүдэд дараах байдлаар томъёолж байжээ.

Хүснэгт 2. Монгол Улсын Их Цаазын өөрчлөлтийн харьцуулалт

1-р төсөл	2-р төсөл	3-р төсөл	4-р төсөл	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ	МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ	МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ
УБХ-д өргөн барьсан хувь	Ард түмнээр хэлэлцүүлсэн хувь	УБХ-д өргөн барьсан хувь	УБХ-аас АИХ-д өргөн барьсан хувь	Батлагдсан хувь
1991.04.19	1991.06.05	1991.10.05	1991.11.07	1992.01.13
21 дүгээр зүйл	Хорин гуравдугаар зүйл	Хорин нэгдүгээр зүйл	Хорин нэгдүгээр зүйл	Хорин нэгдүгээр зүйл
Монгол Улсын Их Хурал нь нэг танхимтай байнгын ажиллагаатай байх бөгөөд 75 гишүүнээс бүрдэнэ.	1.Мөнгөл-Улсын Их Хурал нь нэг танхимтай байнгын ажиллагаатай байх бөгөөд 75 гишүүнээс бүрдэнэ.	Улсын Их Хурал 75 гишүүнээс бүрдэнэ.	1.Улсын Их Хурал 76 гишүүнээс бүрдэнэ.	1.Улсын Их Хурал нэг танхимтай , далан зургаан гишүүнтэй байна.

¹⁴³ Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2016 он. 443 дахь тал.

¹⁴⁴ <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1992.html>

¹⁴⁵ Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2016. он 442 дахь тал.

Тайлбар: -үг, өгүүлбэр шинээр нэмэгдсэнийг тод хараар (“**bold**”),
-үг, өгүүлбэрийг өөрчлөн найруулсныг доогуур зураасаар (“underline”),
-үг, өгүүлбэр хасагдсаныг дундуур зураасаар (“~~strike through~~”),
-зарчмын зөрүүтэй санал орхигдсон, өөрчлөлт орсон зэргийг тодруулав (“**highlighting**”) тус тус тэмдэглэв.

1992 оны ардчилсан шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулах үеийн үзэл баримтлал болон Үндсэн хуулийг хэлэлцэх үеийн УБХ болон АИХ-ын хуралдааны тэмдэглэлээс үзэхэд тухайн үеийн **Улсын Их Хурлыг өөрчлөх хоёр хувилбар**¹⁴⁶ -ыг дэвшүүлэн тавьж байжээ. Тодруулбал:

- А

- Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (дээд танхим)
 - Улсын Бага Хурал (доод танхим)

Б

- БНМАУ-ын Ардын Их Хурлыг шууд байнгын ажиллагаатай парламент болгох

Нэгдүгээр хувилбарын хувьд, Монголын ард түмний засгийн дээд эрх барих газар нь Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (АТИХ) байхаар заасан бөгөөд засаг захиргаа-нутаг дэвсгэрийн үндсэн нэгж болох сум, хороо, орон нутгийн хот бүрээс 1 төлөөлөгч байхаар бодож сонгогчид бүх нийтийн, шууд, тэгш эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж 5 жилийн хугацаагаар сонгохоор төлөвлөж байжээ.¹⁴⁷

АТИХ ээлжит хуралдаанаа хагас жилд нэг удаа хийх бөгөөд өөрийн үзэмжээр төрийн дотоод болон гадаад аливаа асуудлыг хэлэлцэх бүрэн эрхтэй боловч Хүснэгт 3-т дурдсан асуудлыг өөрийн онц эрхэд авч, хэлэлцэн шийдвэрлэх хувилбар байв.

АТИХ-ын чөлөөт цагт засгийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага нь БНМАУ-ын Бага Хурал байна. УБХ-ыг АТИХ-аас 50 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр өөрийн бүрэн эрхийн хугацаагаар сонгож байгуулна. УБХ-ыг дэд ерөнхийлөгч толгойлох ба хагас жил тутам нэг удаа тус бүр 3 сар хүртэлх хугацаагаар ээлжит чуулган хийх¹⁴⁸ -ээр төсөлд тусгажээ.

УБХ нь хуулиар АТИХ-д олгосон бүрэн (онц) эрхээс бусад Хүснэгт 3-т дурдсан төрийн дотоод, гадаад бодлогын ямар ч асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр, мөн УБХ нь хууль батлахаас гадна эрх хэмжээнийхээ асуудлаар Үндсэн хуульд нийцсэн тогтоол гаргах бөгөөд бүрэн эрхийн хувьд дараах байдлаар ялгамжтай төлөвлөж байжээ. Үүнд:

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁴⁶ Чимид Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2017 он. 28 дахь тал.

¹⁴⁷ Мөн тэнд.

¹⁴⁸ Мөн тэнд.

Хүснэгт 3. Монгол Улсын хоёр шатлал бүхий парламентын бүрэн эрхийн ялгаа¹⁴⁹

АТИХ-ын онц эрх	УБХ-ын бүрэн эрх
<ul style="list-style-type: none"> - Үндсэн хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах; - Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг сонгох; - Бага Хурлыг өөрийн бүрэлдэхүүнээс сонгох, түүний ажлын тайланг хэлэлцэн батлах; - Үндсэн хуулийн хяналтын Хороо сонгох; - Ерөнхийлөгчийн санал болгосноор Сайд нарын зөвлөлийн дарга (ерөнхий сайд), Улсын Прокурорыг томилж, Улсын Дээд шүүхийн даргыг сонгох, өөрчлөх; - Эдийн засаг, нийгмийн хөгжлийн 5 жилийн болон хэтийн төлөвлөгөөний үндсэн чиглэл (концепц)-ийг батлах. 	<ul style="list-style-type: none"> - Үндсэн хуулиас бусад батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах; - Бага Хурлын байнгын хороо, хороодын тоог тогтоож, бүрэлдэхүүнийг сонгох, өөрчлөх; - Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Засгийн газрын гишүүдийг нэг бүрчлэн хэлэлцэж томилох, өөрчлөх; - Үндсэн хуулийн хяналтын хороо (Үндсэн хуулийн цэц)-ны санал болгосноор Үндсэн хуулийн биелэлтийг шалгах; - Ардын хянан шалгах хорооны бүрэлдэхүүний тоог тогтоож, батлах (байгуулах), өөрчлөх; - Нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийн бие даасан байдал, бүрэн эрхийг хамгаалах; - Эдийн засаг, нийгмийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, тэдгээрийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж батлах; - Үндсэн хуулийн хяналтын хорооны дүгнэлтийг үндэслэн Үндсэн хуульд нийцээгүй Улсын Дээд шүүхийн дарга, тэргүүлэгчид, Ардын хянан шалгах хороо, Улсын прокурор, яам, агентлаг, аймаг, хотын Ардын Хурлын тогтоол, шийдвэрийг хүчингүй болгох; - УБХ-д ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагуудын ажлын тайланг хэлэлцэн, гүйцэтгэлийг Засгийн газар хангаж байх чигээр бүрэн эрхийг өргөтгөн тогтоох; - Олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах; - Ардын Төлөөлөгчдийн Их Хурал шаардлагатай гэж үзвэл Бага Хуралд бусад эрх олгож болно.

Гэвч 1992 оны Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх үед Монгол Улсын хууль тогтоох байгууллагыг хоёр шатлалтай байх асуудлаар хэд хэдэн удаагийн санал хураалт явуулсан боловч олонхын дэмжлэг аваагүйн улмаас хууль тогтоох байгууллага зохион байгуулалтын хэлбэрийн хувьд нэг танхимтай, байнгын ажиллагаатай парламенттай байх хувилбарыг сонгожээ.

1992 оны Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх үеийн хуралдааны тэмдэглэлээс:

Улсын Бага Хурлын 1991 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар ард нийтээр хэлэлцүүлсний дараах Их цаазын төслийг хэлэлцсэн бөгөөд төслийн 20, 21 дүгээр зүйлд УИХ нь нэг танхимтай, байнгын ажиллагаатай, 75 гишүүнээс бүрдэнэ гэж тусгажээ. Төслийн хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурал (УИХ)-ыг хоёр танхимтай байх талаарх саналуудыг дэвшүүлж байжээ. Тухайлбал, АИХ нь жилд нэг удаа хуралддаг их танхим, байнгын ажиллагаатай, цөөхөн гишүүнтэй бага танхимаас бүрдэх, нэг танхимтай, 75 гишүүнтэй байх нь ард түмнийг төлөөлөх чадварын хувьд бэрхшээлтэй тулгарч болзошгүй бөгөөд 7-8 сумын дундаас нэг гишүүн буюу 30 мянган хүнийг нэг төлөөлөгч төлөөлөх нь ард түмэнтэй харилцах харилцааны хувьд бэрхшээлтэй зэрэг саналуудыг гаргаж байжээ. Харин Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимид “Парламентад байх ёстой хэд хэдэн шинж байдаг. Тухайлбал, нэгд, Парламент бол ард түмнээсээ шууд үүсмэл байх ёстой, хоёрт, бүрэн төгс эрхтэй байх ёстой. Хууль тогтоох байгууллагын тогтоосныг ямар нэг газар нялаад хаячихдаггүй, түүгээрээ ч хариуцлага хүлээдэг байх ёстой, гуравт, парламент бол бүрэлдэхүүний ирцийн хувьд хүчин төгөлдөр байх ёстой. Түүнээс 120-150 хүн сонгочихоод 40 нь сууж байна гэдэг бол 370 депутат сонгочихоод 6-7 тэргүүлэгч гишүүн хууль тогтоож байсантай яг адилхан. Хоёр танхим

¹⁴⁹ Мөн тэнд. 29 дэх тал.

нь эрх тэгш байх ёстой. Нэг нь нөгөөгөө хүчингүй болгодоггүй, харин нэг нь нөгөөгөө барьж, хянадаггүй. Доод танхимаар орсон хууль дээд танхимаар ордог, эсхүл зэрэг хэлэлцдэг, энэ хоёрын санал нийлсэн цагт хууль гардаг, санал нийлэхгүй бол дундаасаа комисс гаргаж зөвшилцөж шийддэг, тэгээд шийдэхгүй бол хууль гаргадаггүй нэлээн хүнд сурталтай хэлбэр юм. Нэг хууль гаргах гэж гурав, дөрвөн сар болох талтай гэсэн тайлбарыг хийж байжээ.

Ийнхүү УБХ-ын 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар парламентын нэг, эсхүл хоёр танхимыг сонгох асуудлыг хэлэлцэж хэлэлцүүлгийн дараа “хоёр танхимтай байна” гэсэн саналыг дэмжжэ гэсэн томьёоллоор санал хураалт явуулахад олонхын дэмжлэг (зөвшөөрсөн 16, татгалзсан 24, түдгэлзсэн 0, бүгд 40) аваагүй тул УИХ нь нэг танхимтай байх хувилбарыг төсөлд тусгаж АИХ-д өргөн мэдүүлжээ.

Ардын Их Хурлын 1991 оны II дугаар хуралдааны 20, 21 дэх өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Цаазын төслийн УИХ-ын танхимын талаар хэлэлцсэн бөгөөд төсөлд хууль тогтоох байгууллагын талаар УИХ нь 76 гишүүнээс бүрдэнэ гэж тусгасан хэдий ч парламентын танхимын талаар тусгаагүй байжээ. Төслийн хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын танхимын талаар нэлээдгүй маргаан өрнөж, парламентын нэг танхимыг сонгох талаар 21 депутат, хоёр танхимыг сонгох талаар 120 депутат¹⁵⁰ саналаа хэлжээ. Тухайлбал,

Нэг танхимтай, байнгын ажиллагаатай парламенттай байх талаар, Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс байхаар тогтсон тул орон нутгийн төлөөллийг хангасан нэг танхимтай байх нь зөв, улс төрийн нам, эсхүл сонгогчдын тоонд хуваарилсан хоёр танхимтай байх бүтэц нь энэ зарчмаа алдагдуулахад хүргэх гол үндэслэл болно. Хоёр танхим бол ихэвчлэн улс төрийн намууд нь нэлээд тогтворжсон, холбооны зарчимтай улсуудад байхад зохимжтой, парламентын нэлээд уламжлалтай улсуудад байдаг зарчим. Манай улс жижиг улс, нөгөө талаар огт хууль тогтоох байнгын ажиллагаагүй байгууллагатай байж байгаад гэнэт үсэрч 200 жил, 400 жилийн туршлагатай орнуудыг дулдуйдаад хоёр танхим хийчих юм бол бид нар хууль гаргаж чадахгүйд хүрнэ.

Хууль тогтоох дээд байгууллага маань илүү шат дамжлагагүй, удирдлагын шийдвэр гаргах тийм цогц байлгах, парламентаа жигдрүүлэх эхний шатанд ямар нэгэн хэмжээгээр ажиллах чадвартай, цомхон, гар нийлсэн мэргэжлийн парламент бий болгох үүднээс жижиг улсад нэг танхимтай байх нь зүйтэй. Парламентын хоёр танхимтай байж болохгүйн үндэслэлийг дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

- сонгууль явуулж байгаа, сонгуульд нэр дэвшүүлэх газар нь нам байгаа. Хоёр танхимтай газруудад нэг талд нь нам, нөгөө талд нь холбооны улсууд, эсхүл язгуурын төлөөлөл байдаг.
- аймаг аймгаас төлөөлөгч орно гэх юм бол 18 аймгаа 18 холбооны улс болгох аюултай бөгөөд үндэс угсаа зэрэг олон шалтгааны улмаас задрах аюултай.
- Монгол Улс нэгдмэл улсаас холбооны улс болох нөхцөлийг бүрдүүлж өгнө. Тиймээс Монгол Улс бол нэг төр, нэг хуультай, нэгдмэл улс гэдэг зарчмыг хатуу баримтлах ёстой гэсэн үндэслэл, тайлбарыг хийж байжээ.

Хоёр танхимтай парламенттай байх талаар, Парламентын хоёр танхимын хувьд хоёр хувилбар хөндөгдөж байжээ. Тухайлбал, нэг нь нөгөөгөөс үүсэн бий болдог хоёр танхим, тус тусдаа бие дааж бүрддэг хоёр танхим. Энэ дээд, доод танхим нь хоёулаа хууль тогтоох эрхтэй байх бол, нөгөөх нь доод танхимын хэлэлцсэн хуулийн төслийг дээд танхим хэлэлцэнэ. Энэ нь хоёр танхим бие биендээ хуулийн төслөө дамжуулаад баталж чадахгүй байх боломжтой.

¹⁵⁰ Улсын Их Хурлын Тамгын газар. АИХ-ын 1991.11.30-ний өдрийн хуралдааны тэмдэглэл. Дугаар 19, кассет 16, 32 дахь тал.

Парламент нь хоёр танхимтай байх асуудал нь зөвхөн холбооны бүгд найрамдах улсад л байдаг практик биш бөгөөд Бүгд найрамдах улсад ч хууль тогтоох байгууллага нь хоёр танхимтай улс орнууд байдаг. Доод танхимын үйл ажиллагаанд дээд танхим хяналт тавьдаг, түүний гаргасан алдааг засах баталгаатай байдгаараа хоёр танхим нь нэг нь нөгөөгөөсөө илүү сайн талтай. Дээд танхим нь хуулиа тогтооно, доод танхим нь гол нь концепцын асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэдэг, асуудлаа боловсруулаад Дээд танхимдаа оруулдаг, Их Хурлаасаа дээд, доод танхимаа бүрдүүлдэг байх, эсхүл Ерөнхийлөгчгүйгээр хоёр танхимтай парламенттай болох саналыг хүртэл гаргаж байжээ. Гэвч хууль тогтоох үндсэн үүргээ гүйцэтгэдэггүй, байнгын биш ажилтай парламент гэж байдаггүй. Хоёр танхим хоёулаа зэрэгцэн ажиллана. Нэг танхим нь хуулийг баталж өгөхгүй бол нөгөө танхим нь баталж чадахгүй. Нэг нь нөгөөгөөсөө урган гарсан танхим байж болохгүй, нэг нь нөгөөгөө төрүүлчихээд хоёр танхим гэж ерөөсөө ярьж болохгүй.

Жинхэнэ сонгомол парламент байгуулъя гэвэл зэрэгцэн ажиллах хоёр танхимтай байгаад нэг нь их танхим, нэг нь бага танхим байг. Энэ хоёр нийлээд УИХ болдог хувилбар манай улсын нөхцөлд илүү тохиромжтой гэсэн саналуудыг гаргасан байна.

Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимидийн парламентын танхимын талаар хийсэн тодруулгаас:

- Манай улс заавал хоёр танхимтай байх хэрэгцээ шаардлага багатай юм. Язгуур угсаа баримталсан юм уу, эсхүл төрийн байгууламжийн онцлог буюу холбоог илэрхийлсэн, муж улсуудыг илэрхийлсэн дээд хэлбэр байх онцын шаардлага байхгүй юм гэж үзээд нэг танхимтай байх энэ хэлбэрийг сонгож авсан.
- Манайх бол нэгдмэл нэг л улс. Заавал нэг нь нөгөөгөө давхар хянаж байдаг дээд танхим, төлөөлөгчийн танхим гэж шийдвэрээ дээд танхимдаа үзүүлж давхар батлуулж байх шаардлага бол манай Монгол Улсын нөхцөлд, нэгдмэл нэг улсад хэрэггүй юм.
- Хоёр танхим байж болох хувилбарыг боловсруулж үзсэн. Тэгэхээр Дээд танхим бол манайд 14-15 онд байсан зүйл. Бусад орны Дээд танхим бол нэг бол үндэстэн төрийн нэгжийг төлөөлсөн, нэг бол язгууртныг төлөөлсөн, нэг бол төрийн дээд албан тушаалтнууд түүнээсээ гарахаар шилжиж ордог ийм уламжлал голдуу байгаа. Ийм гурван янзын уламжлал байна.
- Манайд байвал хоёр жижигхэн 30, 30 хүнтэй юм байх, хоёулаа ямар нэг хэмжээгээр байнга ажиллах болно, хэлбэрийн талаас, хууль зүйн талаасаа гэж үзээд нэг талаар улсынхаа хүн ам, хүчин чадалтай холбоотойгоор, нөгөө талаар дэлхийн улс орнуудын жишиг байна. Одоо бидний зүйрлүүлсэн орнуудын доод талынх нь парламентын нэг гишүүнд ногдож байгаа хүн ам бол 20 мянга, манайх бол 5 мянга. Энэ бүгдийг харгалзаж үзэж нэг танхимтай, байнгын ажиллагаатай парламенттай болох хувилбарыг сонгосон.

АИХ-ын 1991 оны 12 дугаар сарын 01-ний болон 03-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс үзэхэд, парламентын танхимын хувьд нэг, эсхүл хоёр танхимтай байх талаар хэлэлцэж, хэд хэдэн удаа санал хураалт явуулсны эцэст УИХ нэг танхимтай байх хувилбар хоёр удаагийн санал хураалтаар дийлэнх олонхын санал авч дэмжигджээ.

Хүснэгт 4. Саналын томьёолол: УИХ нэг танхимтай байна

	1991.12.01		1991.12.03		1991.12.03 15.10 цагт		1991.12.03		1991.12.03 18.01 цагт	
Зөвшөөрсөн	131	47%	175	51%	178	53%	198	58%	219	67%
Татгалзсан	110	40%	140	41%	131	39%	129	38%	81	25%
Түдгэлзсэн	36	13%	26	8%	30	8%	17	4%	28	8%
Бүгд	278	65%	341	80%	339	80%	344	81%	328	77%
	Энгийн олонх		Энгийн олонх		Энгийн олонх		Дийлэнх олонх		Дийлэнх олонх	

Хүснэгт 5. Саналын томьёолол: УИХ хоёр танхимтай байна

	1991.12.01		1991.12.03	
Зөвшөөрсөн	206	59%	175	51%
Татгалзсан	114	33%	145	42%
Түдгэлзсэн	28	8%	23	7%
Бүгд	348	82%	343	81%
	Энгийн олонх		Энгийн олонх	

1.2.Засгийн газрын Ажлын хэсгийн асуулга (2016 он)

2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын захирамжаар “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг судлах, санал, дүгнэлт боловсруулах эрдэмтэн судлаачдын ажлын хэсэг” байгуулагдсан. Ажлын хэсгийг доктор, профессор Ч.Энхбаатар ахалсан бөгөөд ажлын хэсэг судалгааны түүврийн хэмжээг тогтоохдоо Монгол Улсын сонгуулийн насанд хүрсэн нийт хүн амыг эх олонлог гэж үзэж эх олонлогоос түүвэр олонлогийн хэмжээг тооцохдоо хүн амын нас, хүйсийн харьцааг түүвэр олонлогт пропорционал байхаар тооцож улсын хэмжээнд нийт 3692 хүнийг судалгаанд түүвэрлэн хамруулсан байна.

Судалгаагаар Монгол Улсад төрийн удирдлагын хэлбэрийн хувьд ерөнхийлөгчийн БНУ, хоёр танхимтай парламент зохимжтой гэж судалгаанд оролцогчдын 1019 хүн буюу 48,3 хувь, парламентын бүгд найрамдах улс гэж 967 хүн буюу 45.9 хувь нь хариулсан байна. Харин УИХ-ын өнөөгийн бүтэц, зохион байгуулалт тохиромжтой эсэх талаарх асуултад судалгаанд оролцогчдын 1519 хүн буюу 43,7 хувь нь тохирохгүй байна, 1019 хүн буюу 29,3 хувь нь хариулж мэдэхгүй байна гэж хариулжээ. Хэрэв тохирохгүй байгаа бол парламентын ямар бүтэц, зохион байгуулалтыг хэрхэн өөрчлөх талаарх асуултад гишүүдийн тоог цөөлөх, чанартай цөөн гишүүнтэй байх гэж 214 хүн буюу 45,7 хувь, парламентын хоёр танхимтай болох гэж 145 хүн буюу 31 хувь нь хариулжээ.

УИХ-ЫН
СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 6. Засгийн газрын Ажлын хэсгээс явуулсан асуулга, хариулт
(УИХ-ын бүтэц, зохион байгуулалттай холбоотой)*

<i>Асуулгын хариулт</i>	<i>Хүний тоо</i>	<i>Хувь</i>
1.Таны бодлоор Монгол Улсад төрийн удирдлагын аль хэлбэр илүү зохимжтой вэ?		
Парламентын бүгд найрамдах улс	967	45,9
Ерөнхийлөгчийн БНУ, хоёр танхимтай парламент	1019	48,3
Хагас ерөнхийлөгчийн бүгд найрамдах улс	60	2,8
Хаант засаглал	6	0,3
Бусад	56	2,7
Нийт	2108	100,0
2.Улсын Их Хурлын бүтэц, зохион байгуулалт өнөөгийн нөхцөлд хэр зэрэг тохирч байна гэж Та үзэж байна вэ?		
Тохирч байна	936	26,9
Тохирохгүй байна	1519	43,7
Хариулж мэдэхгүй	1019	29,3
Нийт	3474	100,0
3.Хэрэв тохирохгүй байна гэж үзэж байгаа бол парламентын ямар бүтэц, зохион байгуулалтыг хэрхэн өөрчлөх талаар Та өөрийн саналыг бичнэ үү?		
Гишүүдийн тоог цөөлөх, чанартай цөөн гишүүнтэй байх	214	45,7
Парламентын дээд, доод хоёр танхимтай болох	145	31,0
Ерөнхийлөгчийн засаглалтай болох	12	2,6
Гишүүдийн тоог нэмж, эрх мэдлийг багасгах	10	2,1
Хариуцлагын тогтолцоотой болох (хариуцлага тооцох, эргүүлэн татах)	59	12,6
УИХ-ын гишүүн өөр бусад албан тушаал давхар хашихгүй байх (давхар дээлгүй байх)	28	6,0
Нийт	468	100,0

1.3.Зөвлөлдөх санал асуулга (2017 он)

2017 оны 4 дүгээр сард “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаарх анхдугаар зөвлөлдөх санал асуулгыг хоёр үе шаттай зохион байгуулсан бөгөөд санал асуулгад улсын хэмжээнд 1568 өрхийг газар зүйн байршлаар, санамсаргүй түүврийн аргаар сонгож 1515 өрх эхний санал асуулгад оролцсон. Хоёр дахь шатны санал асуулгад эхний санал асуулгад оролцсон өрхөөс мөн санамсаргүй түүврийн аргаар сонгож 699 хүн оролцсон бөгөөд дараах асуултуудад хариулсан.

УИХ-ЫН
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 7. Зөвлөлдөх санал асуулга, хариулт
(УИХ хоёр танхимтай байх хувилбар, хувиар)

Нэг дэх санал асуулга		Хоёр дахь санал асуулга
1.Төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурал, хууль тогтоох байгууллага нь Улсын Бага Хурал гэсэн хоёр танхимтай байх?		
Дэмжсэн	58.3	31.5
Эсэргүүцсэн	30.1	60.6
2.Хоёр танхимтай болвол хоёр дахь танхим нь бага хуралд хяналт тавьж ажиллана.		
Дэмжсэн	69.6	38.2
Эсэргүүцсэн	22.4	50.8
3.Хоёр дахь танхим буюу АИХ нь хэтэрхий олон улс төрчдийг бий болгоно.		
Дэмжсэн	48.4	56.8
Эсэргүүцсэн	34.3	28.7

Дээрх хариултаас харахад, санал асуулгад оролцогчид **Парламент хоёр танхимтай байхыг дэмжээгүй** байна. Энэ нь хэтэрхий олон улс төрчдийг бий болж, шийдвэр гаргахад төвөгтэй, төр засгийн үйл ажиллагаа бүтээмж багатай болно гэж үзжээ. Түүнчлэн Парламент хоёр танхимтай байснаар “Хоёр танхим хоёулаа нэг улс төрийн намын гишүүдээс бүрдэж хяналт тавих боломжгүй болно” гэж хоёр шатны санал асуулгад оролцогчдын 43-аас дээш хувь нь үзжээ.

ТӨРИЙН ЭРХ БАРИХ ДЭЭД БАЙГУУЛЛАГА НЬ АРДЫН ИХ ХУРАЛ, ХУУЛЬ ТОГТООХ
БАЙГУУЛЛАГА-УЛСЫН БАГА ХУРАЛ ГЭСЭН ХОЁР ТАНХИМТАЙ БАЙХЫГ ДЭМЖСЭНГҮЙ



Зөвлөлдөх уулзалтын санал асуулгын үр дүнг үндэслэсэн **Зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмжид** парламент хоёр танхимтай байхыг нэг дэх шатны судалгаагаар дэмжиж байсан боловч мэдээлэл авч харилцан зөвлөлдсөний дараа дэмжсэн байр суурь огцом багассан нь хоёр дахь шатны хэлэлцүүлгийн үед Үндсэн хуулийн суурь бүтэц, үзэл баримтлалыг өөрчлөхөд хүрнэ гэсэн асуудал хүчтэй хөндөгдсөнтэй холбоотой байж болох учраас зөвлөлдөх санал асуулгын 2 дахь шатны чанарын болон бусад холбогдох судалгааны мэдээллээр тодруулсны үндсэн дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах эсэх асуудлыг авч үзвэл зохистой гэсэн зөвлөмжийг өгчээ.

2.ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

2.1.Дэлхийн улс орнуудын парламентын танхимын тоо

Үндсэн хуулийн эрх зүйд парламент хэдэн танхимтай (chambers) байх вэ гэдэг нь маргаантай асуудал юм. Хууль тогтоох хоёр танхимтай (two legislative chambers) байх нь анх Их Британи ба Европын орнуудын хаант засаглалын системд аристократууд болон жирийн иргэдийн төлөөллийг, АНУ-д штатуудын төлөөллийг тус тус хууль тогтоох үйл ажиллагаанд оролцуулах шаардлагаас үүссэн байдаг. Нэгдмэл танхимын систем (unicameral system) буюу хууль тогтоох нэг танхимтай (one legislative chamber) байх нь авторитар орнуудад голлон байдаг гэсэн үзэл байсаар ирсэн. Орчин үед ингэж үзэх нь буруу боловч шинэ ардчилсан улсууд, ялангуяа том улсуудын хувьд ерөнхийдөө хоёр танхимын системд шилжих хандлагатай болж байна. Гэхдээ түүх, соёл, улс төрийн нөхцөл байдлаасаа шалтгаалан тухайн улс хэдэн танхимтай парламенттай байхаа шийдэх нь зүйн хэрэг.¹⁵¹

Олон улсын парламентын холбоо (IPU)-ны гишүүн дэлхийн 191 улсаас парламентын засаглалтай 74 улс, ерөнхийлөгчийн засаглалтай 46 улс, холимог засаглалтай (Presidential-parliamentary) 45 улс, хаант засаглалтай 12 улс, коммунист систем (Communist system)-тэй 5 улс байна.¹⁵² Эдгээрээс:

- 1) Парламентын засаглалтай 74 улсын хувьд:
 - нэг танхим бүхий парламенттай – 43 улс;
 - хоёр танхим бүхий парламенттай – 31 улс;
- 2) Ерөнхийлөгчийн засаглалтай 46 улсын хувьд:
 - нэг танхим бүхий парламенттай – 26 улс;
 - хоёр танхим бүхий парламенттай – 20 улс;
- 3) Холимог засаглал бүхий 45 улсын хувьд:
 - нэг танхим бүхий парламенттай – 23 улс;
 - хоёр танхим бүхий парламенттай – 22 улс;
- 4) Хаант засаглал бүхий 12 улсын хувьд:
 - нэг танхим бүхий парламенттай – 6 улс;
 - хоёр танхим бүхий парламенттай – 6 улс;
- 5) Коммунист системтэй 5 улсын хувьд:
 - бүгд хоёр шатлал бүхий нэг танхимтай парламенттай байна.

Дээрх статистик мэдээллээс үзэхэд, судалгаанд хамрагдсан дэлхийн 191 улсын 103 улс нь нэг танхимтай парламенттай, 79 улс нь хоёр танхимтай парламенттай байна. Парламентын засаглалтай 74 улсыг төрийн байгууламжийн хэлбэрээр авч үзвэл, нэгдмэл улс 61 байгаагаас,

- нэг танхимтай парламент – 43 улс;
- хоёр танхимтай парламент – 18 улс байна.

Нэгдмэл улсуудын 70.5 хувь нь нэг танхимтай, 29.5 хувь нь хоёр танхимтай байна. Холбооны улс (13)-ын хувьд бүгд хоёр танхим бүхий парламенттай байгаа бол коммунист системтэй 5 улс бүгд хоёр шатлал бүхий нэг танхимтай парламенттай байна.

¹⁵¹ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Гадаадын зарим орны хоёр танхимтай парламентын талаарх харьцуулсан судалгаа. СТ-11/212.

¹⁵² Энэхүү судалгаанд шилжилтийн улс (Буркина Фасо, Чад, Гвиней, Ливи, Мали, Өмнөд Судан, Сири, Йемен) болон дайны нөхцөл байдалд буй Украин улсыг оруулаагүй болно.

Хүснэгт 8. Дэлхийн улс орнуудын парламентын танхимын тоог засаглалын хэлбэрээр авч үзвэл

Парламентын засаглалтай улс (Parliamentary system)		
1	Нэг танхимтай парламент - 43 улс	Албани, Андорра, Армэн, Бангладеш, Ботсван, Болгар, Кабо-Верде, Хорват, Дани, Доминик, Эстони, Фижи, Финланд, Гүрж, Грек, Унгар, Исланд, Ирак, Израил, Кирибати, Латви, Лихтенштайн, Люксембург, Мальт, Маврики, Монако, Монгол, Шинэ Зеланд, Умард Македон, Норвег, Папуа Шинэ Гвиней, Португал, Молдова, Сент-Китс ба Невис, Сент-Винсент ба Гренадин, Самоа, Сан-Марино, Серб, Словак, Соломоны арлууд, Швед, Зүүн Тимор, Тувалу, Вануату
2	Хоёр танхимтай парламент - 31 улс	Антигуа ба Барбуда, Австрали, Бахама, Барбадос, Бельги, Белиз, Босни-Херцеговин, Камбож, Канад, Чех, Этиоп, Герман, Гренада, Энэтхэг, Ирланд, Итали, Ямайка, Япон, Лесото, Малайз, Балба, Нидерланд, Пакистан, Сент Люсиа, Словени, Өмнөд Африк, Испани, Швейцар, Тайланд, Тринидад ба Тобаго, ИБУИНХУ (Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс)
Ерөнхийлөгчийн засаглалтай улс (Presidential system)		
1	Нэг танхимтай парламент - 26 улс	Бенин, Коста Рико, Кипр, Эквадор, Эль Сальвадор, Эритрей, Гамби, Гана, Гватемал, Гвиней-Бисау, Хондурас, Индонез, Киргиз, Малави, Мальдив, Маршаллын Арлууд, Микронез, Никарагуа, Панам, Перу, Солонгос, Сьерра Леон, Суринам, Уганда, Танзани, Венесуэл
2	Хоёр танхимтай парламент - 20 улс	Афганистан, Аргентин, Болив, Бразил, Брунди, Чили, Колумби, Доминикан, Хаити, Кени, Ливи, Мексик, Нигери, Палау, Парагвай, Филиппин, Тажикистан, Туркменистан, АНУ, Уругвай
Холимог засаглалтай улс (Presidential-parliamentary)		
1	Нэг танхимтай парламент - 23 улс	Ангол, Азербайжан, Төв Африк, Коморос, Жибути, Гайана, Иран, Ливан, Литви, Мавритани, Монтенегро, Мозамбик, Наура, Нижер, Сан-Томе ба Принсипи, Сенегал, Сейшелийн арлууд, Сингапур, Шри-Ланк, Того, Тунис, Турк, Замби
2	Хоёр танхимтай парламент - 22 улс	Алжир, Австри, Беларусь, Камерун, Конго, Кот д'Ивуар, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Египет, Эквадорын Гвиней, Франц, Габон, Казахстан, Мадагаскар, Мьянмар, Намиби, Польш, Румын, ОХУ, Руанда, Сомали, Узбекистан, Зимбабве
Хаант засаглалтай улс (Monarchy)		
1	Нэг танхимтай парламент - 6 улс	Бруней, Кувейт, Катар, Саудын Араб, Тонга, Арабын нэгдсэн Эмират
2	Хоёр танхимтай парламент - 6 улс	Бахрайн, Бутан, Эсватини, Йордан, Марокко, Оман
Коммунист системтэй улс (Communist system)		
1	2 шатлал бүхий нэг танхимтай парламент - 5 улс	БНХАУ, Вьетнам, БНАСАУ, Куба, Лаос

Эх сурвалж: Олон улсын парламентын холбооны цахим хуудас, 2022 он

Хоёр танхимтай парламентын тогтолцоог сонгон авахад тухайн орны төрийн эрх мэдлийг зохицуулж ирсэн уламжлал, холбооны болон нэгдмэл улсын тогтолцооны онцлог, эдийн засгийн хөгжлийн түвшин, хүн амын тоо, бүс нутгийн болон орон нутгийн удирдлагын тогтолцоо, үндэстэн ястан, шашин омгууд, бүс нутаг, нийгмийн анги давхаргуудын төлөөлөл, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал хоорондын эрх мэдлийн хуваарилалт, хяналтын тогтолцоо зэрэг олон хүчин зүйлүүдийг харгалзан үзэх шаардлагатай.

Парламентын хоёр танхимыг бүрдүүлэх хэлбэр:

- Дээд танхимын хувьд:
 - томилгооны зарчмаар;
 - сонгуулийн зарчмаар;
 - томилгоо болон сонгуулийн хосолмол хэлбэрээр бүрдүүлдэг байна.
- Доод танхимын хувьд:
 - ард түмний төлөөлөл болж, бүх нийтийн, чөлөөтэй, шууд сонгуулиар бүрддэг.

Дээд танхимыг бүрдүүлсэн хэлбэрээс үзэхэд, Хаант засаглалтай болон язгууртны “уламжлалт” хэв шинжийг хадгалж бүрдүүлсэн, улс төрийн намуудаас бүрдүүлсэн, ардчиллын зарчмаар нийгмийн бүлэг, давхаргуудын төлөөллийг оролцуулж бүрдүүлсэн, хууль тогтоох байгууллагын дархлааг бий болгох үүднээс сонгон шалгаруулалтын зарчмаар туршлагатай улс төрчид, эрдэмтдээс бүрдүүлсэн гэх мэтийн дүр зураг харагдаж байна.

Дээд танхимын бүрэн эрхийн тухайд, зарим орнуудад Дээд танхим нь хууль тогтоох ажиллагаанд Доод танхимтай зэрэгцээ байдлаар оролцдог, зарим оронд зөвхөн тодорхой асуудлуудыг хянан хэлэлцдэг заагтай, зарим оронд доод танхимдаа зөвлөх үүрэгтэй гэх мэтийн хэлбэрүүд байна.

Судалгаанаас үзэхэд, Холбооны улсууд ихэвчлэн 2 танхимтай парламенттай байх ба хууль тогтоох, засаглалын үйл ажиллагаанд оролцох оролцоо, эрх мэдэл нь хүчтэй, сулавтар, сул байдаг байна. Хоёр танхимын эрх мэдэл, үүргийн хуваарилалт нь улс орон бүрд харилцан адилгүй.

Нэгдмэл улсуудын хувьд ихэвчлэн 1 танхимтай парламенттай байх боловч 2 танхимтай парламенттай орнууд цөөнгүй байна. Тэдгээрийн хувьд Дээд танхимдаа нийгмийн янз бүрийн бүлэглэлүүдийн төлөөллийг оролцуулах, Доод танхимынхаа хууль тогтоох үйл ажиллагааг хянах, зөвлөх эрхтэй байдаг байна. Дээд танхимдаа Мужийн сонгогдсон зөвлөл, эмэгтэйчүүд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг сонгох болон томилох хэлбэрээр оруулдаг улсууд ч байна. Нэг танхимтай парламент нь гол төлөв төвлөрсөн буюу нэгдмэл тогтолцоотой, үндэстний цөөнх багатай, хүн ам цөөтэй, шашны асуудлыг зохицуулах онцгой шаардлагагүй орнуудад байдаг.

2.2. Парламентын нэг танхимын талаар

Нэг танхимтай парламент нь (One-chamber or unicameral legislatures) гол төлөв төвлөрсөн юмуу нэгдмэл тогтолцоотой, хүн амын бүрэлдэхүүн нэгэн төрөл, цөөн хүн амтай орнуудад байдаг. Ийм улсуудын тоонд Коста-Рика, Португал, Унгар, Исланд, Швед, Словени, Уганда, Шинэ Зеланд зэрэг улсууд бий. Сүүлийн хориод жилд цөөнгүй улс орон ардчилсан тогтолцоонд шилжсэн, үндсэн хуулийн бүтэц нь өөрчлөгдсөн зэрэг зарим өөрчлөлт гарч байгаа боловч хүн ам цөөнтэй орнууд ихэвчлэн нэг танхимтай парламентын систем сонгодог чиг хандлага (тенденци) хадгалагдсаар байна. Тухайлбал, Зүүн Европын бүх орнууд нэг танхимтай парламентын системийг сонгосон байна. Зарим тохиолдолд сонгуулийн системийн онцлогоор нэг танхимтай парламентад ч нийгмийн олон янзын сонирхлын төлөөллийг оруулж болдог. Жишээлбэл, Словенийн үндсэн хуулиар нэг танхимтай

парламент-Үндэсний хуралдаа үндэсний цөөнхүүдийн нэг нэг төлөөллийг оруулдаг. Угандын нэг танхимтай парламентад улсын 39 район бүрээс орох эмэгтэйчүүдэд зориулсан суудлууд байх ба нийгмийн бэрхшээлтэй иргэд, хөлсний ажилчдад оногдох суудал ч бий.

Мөн зарим улс орнууд хоёр танхимтай парламентаас нэг парламенттай танхим руу шилжих тохиолдол байдаг. Тухайлбал, 1867 онд Швед улс дөрвөн танхимтай хууль тогтоох байгууллагаас АНУ, Норвегийн загварт суурилсан хоёр танхимтай хууль тогтоох байгууллага болж өөрчлөгдсөн. Хоёр танхим нь гишүүдийнхээ ажиллаж байсан тойрог, төлөөлөгчдийг сонгох арга барил, бүрэн эрхийн хугацаа зэргээрээ харилцан адилгүй байв. Гэсэн хэдий ч танхимууд нь АНУ-ын Төлөөлөгчдийн танхим, Сенаттай адил хууль тогтоох эрх мэдлийг ижилхэн хэрэгжүүлж байсан хэдий ч хоёр танхимын хооронд зөрөлдөөн гарч дээд танхим нь консерватив олонх, доод танхим нь либерал олонх давамгайлж байсан хоёр өөр үзэл суртлын байгууллага болон хувирч, үзэл суртлын хуваагдал нь хууль тогтоох мухардалд хүргэж, улмаар улс төрийн зогсонги байдалд хүргэжээ. Үүний улмаас хууль тогтоох байгууллагыг шинэчлэх оролдлого 1945 оноос эхэлсэн ч энэ үйл явц 20 гаруй жил үргэлжилжээ. Зуу гаруй жил хоёр танхимтай байсны эцэст 1967 он хүртэл нэг танхимтай хууль тогтоох байгууллагын төлөө саналаа өгөөгүй байна. Одоогийн байдлаар Швед улс нь үндсэн хуульт хаант засаглалтай парламентын засаглалтай бөгөөд нэг танхимтай парламенттай болсон байна.

Хүснэгт 9. Нэг танхимтай парламентын эерэг, сөрөг тал

ЭЕРЭГ ТАЛ	СӨРӨГ ТАЛ
Нэг танхимтай парламентын хувьд	
<ul style="list-style-type: none"> • Шаардлага тулгарсан үед хууль тогтоомжийг шуурхай батлан гаргах боломжтой. Хоёр танхимаар дамжин хугацаа алдахгүй гэсэн үг. • Зөвхөн нэг танхим гарсан хуулийн төлөө хүлээх хариуцлага тодорхой. • Нэг танхимтай, цөөн гишүүнтэй байхад зардал бага байна.¹⁵³ 	<ul style="list-style-type: none"> • Хуулийн төслийг дахин хянан хэлэлцэх боломжгүй байдаг. • Аль нэг нам давамгайлж байгаа тохиолдолд хуулиудыг хүчээр батлах боломжийг бий болгож, улмаар түүнийг дагаж мөрдөх нь олон нийтэд дарамт учруулдаг. • Хүн ам олонтой томоохон улс орнуудад төлөөллийг зөв, ил тод байлгах боломжгүй байдаг. (Энэтхэг, Хятад, АНУ гэх мэт)

2.3. Парламентын хоёр танхимын талаар

Хоёр танхимтай хууль тогтоох байгууллага (а bicameral legislature) нь гол төлөв дээд ба доод танхим гэж нэрлэгдэх хоёр танхимаас бүрдэнэ. Доод танхим нь ихэвчлэн бүс нутаг бүрийн хүн амын тоонд пропорционалаар тогтоогдсон тооны гишүүдээс бүрдэнэ. Дээд танхимыг бүрдүүлэхдээ үе залгамжлах, янз бүрийн байгууллага, эрх мэдэл бүхий хүмүүсийн зүгээс томилох, шууд ба шууд бус сонгуулиар сонгох гэх мэт бүрдүүлэх олон арга хэлбэр ашиглана. Дээд танхим нь улс төрийн намуудын төлөөлөл хэлбэрээр бас байгуулагдаж болно, тухайлбал, АНУ-ын Сенат, ХБНГУ-ын Бундесрат, Энэтхэгийн Раджа Сабхаг ийм зарчмаар байгуулдаг. Засаглалын хоёр түвшний байгууллагаас шалтгаалан холбооны улсуудад хоёр танхимын (Bicameral system) систем тохиромжтой байдаг. Мөн дээд танхимд нийгмийн чухал нэгжүүдийн төлөөлөл, тухайлбал Энэтхэг, Этиоп зэрэг улсуудтай адил үндэстэн ястан, шашин, омгийн бүлэглэлүүдийн төлөөллийг оруулдаг жишиг бий.

Холбооны улс буюу федерализм нь харьцангуй ховор улс төрийн систем бөгөөд нэг газар нутаг ба иргэдэд засаглалын хоёр түвшин үйлчилж байдаг. Хууль батлах, төсөв хуваарилах

¹⁵³ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Гадаадын зарим орны хоёр танхимтай парламентын талаарх харьцуулсан судалгаа. СТ-11/212.

зэрэг нь төрийн төв байгууллага ба штат, провинц, нутаг дэвсгэрийн төрийн байгууллага хооронд хуваагдана. Дэлхийн ихэнх улс нэгдмэл байх бөгөөд орон нутгийн төрийн байгууллагын эрх мэдэл нь төвөөсөө тодорхойлогдоно. Хүчтэй федерал системд штат, орон нутгийн засаг өөртөө орлого төвлөрүүлэх эрхтэй байдаг.

- Холбооны систем голдуу хоёр танхимтай парламенттай байх бөгөөд үндэсний хууль тогтоох байгууллагад штат, бүс нутаг/мужийн эрх ашгийг төлөөлсөн дээд танхим байна.
- Холбооны системд тодорхой хэмжээнд хууль тогтоох эрх бүхий хоёр дахь шатны хууль тогтоох байгууллага (subnational legislature) байдаг. Зарим эрх мэдэл хууль тогтоох хоёр шатны байгууллага хооронд хуваагдана.
- Хүчтэй холбооны системд үндэсний хэмжээний хууль тогтоох ба гүйцэтгэх эрх мэдлийг сулруулсан байна.

Засаглалын хоёр түвшинд эрх мэдлийн тэнцвэр улс бүрд адилгүй. АНУ, ХБНГУ, Канад хүчтэй холбооны системтэй, Нигерид сул, Мексикт дунд зэргийн хүчтэй холбооны систем байна. Энэтхэгийн холбооны улсын үндсэн хуулиар төрийн төв байгууллага нь батлан хамгаалах, гадаад харилцаа, төмөр зам, тээвэр, холбоо, валют, банк, гааль, онцгой албан татварын асуудлаар хүчтэй холбоо байдаг. Энэтхэгийн парламент хууль тогтоох зарим тодорхой эрх мэдлийг 14 штат, 5 бүс нутгийн хоёрдахь шатны хууль тогтоох байгууллагатай хуваалцдаг. Үүнд, эдийн засаг ба нийгмийн төлөвлөлт, нийгмийн халамж, хөдөлмөрийн асуудал зэрэг орно. Хоёр шатны эрх мэдэл зөрчилдсөн тохиолдолд үндэсний парламент ба холбооны засгийн газрын хууль шийдвэрүүд давуу эрхтэй.

Хоёр танхимын системд парламентын хоёр танхимын эрх мэдэл улс бүрд өөр өөр байдаг. Сул хоёр танхимын системтэй зарим оронд дээд танхим нь зөвхөн зөвлөх эрхтэй байдаг. Жишээлбэл, Их Британид бүх ард түмнээс сонгогдсон Нийтийн танхим нь хууль тогтоох давуу эрх мэдэлтэй бөгөөд шийдвэрүүд нь дээд танхим–Лордуудын танхимаас давуу байна. АНУ-д бол хоёр танхим нь адил болон харилцан нөхөх эрх мэдэлтэй бөгөөд гарч буй хууль тогтоомж хоёр танхимаар хоёулангаар нь дэмжигдсэн байх шаардлагатай. Канадад Нийтийн танхим нь илүү эрх мэдэлтэй боловч Сенат нь доод танхимын баталсан хуульд нь нэмэлт оруулах болон бодлогын асуудлаар хяналт хийх эрхтэй. Германд муж улсуудын сонирхол парламентын дээд танхим Бундесратад тусгагдах бөгөөд гишүүд нь муж улсуудын засгийн газруудаас томилогдоно. Бундесратын хууль тогтоох эрх мэдэл нь хүчтэй биш боловч муж улсууд болон холбооны засгийн газрын хоорондын маргааныг эцэслэн шийдвэрлэх эрхтэй.

Хоёр танхимтай парламент бүхий нэгдмэл улсуудад дээд танхимыг нийгмийн янз бүрийн бүлэглэлүүдийн төлөөллийг оруулах болон доод танхимын хууль тогтоох эрх мэдлийг хянах зорилгоор байгуулдаг. Жишээ нь, Ботсванийн Удирдагчдын танхим нь сонгогдсон болон уламжлалт овог аймгуудаас томилогдсон гишүүдээс бүрдэнэ. Удирдагчдын танхим нь хязгаарлагдмал үүрэг гүйцэтгэх боловч Үндсэн хуульд өөрчлөлт оруулах болон овог аймгуудын асуудлаар нөгөө танхимтай заавал зөвлөлдөх ёстой. Буркино Фасод дээд танхим нь цэвэр зөвлөлдөх байгууллага бөгөөд янз бүрийн регион, нийгмийн бүлгүүдийн дуу хоолойг хүргэх зорилготой байгуулагдана. Энэ танхим мужийн сонгогдсон зөвлөлүүдийн төлөөлөл, эмэгтэйчүүдийн байгууллага, уламжлалт удирдагчид, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл зэргийг оролцуулсан томилогдсон болон шууд бус сонгуулиар сонгогдсон нийт 178 гишүүнтэй.

Дээд танхим нь ерөнхийдөө дараах аргуудын нэгээр байгуулагдана:

- шууд сонгууль—сонгогчид саналаа шууд тодорхой нэр дэвшигчид юмуу намд өгнө (АНУ);
- шууд бус сонгууль—сонгогчид орон нутгийн эрх барих байгууллагыг сонгоод, дараа нь уг байгууллагаас дээд танхимын гишүүдийг сонгоно. (Аргентин, Австри, Герман, Энэтхэг);
- доод танхимаас дээд танхимын гишүүдийг сонгох шууд бус сонгууль (Канад, Йордан, Тайланд);
- үе залгамжлах (Их Британид Лордуудын танхимын гишүүдийн ихэнх нь үе залгамжилсан пэрүүд байдаг);
- Үндсэн хуулиар эрх олгогдсон байгууллага, хүмүүсийн зүгээс томилох.

Хоёр танхимын үүрэг, эрх мэдлийг зохицуулах аргууд

Хууль тогтоох үйл явцад хоёр танхим оролцож байгаа үед танхим хооронд ялгаатай саналаар зөвшилцөх болон зөвшилцөл явуулах процессын талаарх аргуудыг тодорхойлсон байх ёстой. Танхим тус бүр нь ялгаатай учир дээрх аргуудыг тодорхойлох хууль тогтоомжууд нь ялгаатай байна. Ихэнх хоёр танхимтай парламентад хуулийн төслийг авч үзэх, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр танхимууд эцсийн зөвшилцөлд хүртэл нэг танхимаас нөгөө рүү төслийг дамжуулан хэлэлцдэг систем (a shuttle system) үйлчилдэг. Энэ системээр нэг танхим нь хуулийн төслийн өөрийн хувилбарыг нөгөө танхимдаа танилцуулах бөгөөд тэр танхим нь төслийг батлах, буцаах болон нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр хэлэлцэнэ. Энэ процесс хоёр танхим хуулийн нэг төсөл дээр бүрэн зөвшилцөх хүртэл үргэлжилнэ. Зөвшилцөлд хүрэхгүй тохиолдолд аль нэг танхимын төслөөр батлах, хуулийн төслийг бүрмөсөн буцаах, эсхүл парламент тарах гэх мэт олон янзын шийдэл байдаг.

Олон тохиолдолд хуулийн төслийг эцэслэн батлахад аль нэг танхим (голдуу доод танхим) нь шийдвэрлэх эрхтэй байна.

- Словенид дээд танхим-Үндэсний зөвлөл нь доод танхим-Үндэсний хурлаас баталсан хуульд долоо хоногийн дотор хориг тавих эрхтэй. Гэхдээ Үндэсний хурал ердийн олонхын саналаар хоригийг хүлээн авахгүй байх эрхтэй.
- ОХУ-д дээд танхим Холбооны зөвлөл нь доод танхим Төрийн думын баталсан хуулийг буцаах эрхтэй боловч доод танхим нь дийлэнх олонхын саналаар хоригийг хүлээн авахгүй байж болно.

Зарим оронд хоёр танхимын эрх мэдэл нь хэлэлцэж буй хуулиас шалтгаалан өөрчлөгдөх тохиолдол бий.

- ӨАБНУ-д хуулийн төсөл провинцуудад шууд хамаарахааргүй (үндэсний хэмжээний батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүйн гэх мэт асуудлууд) бол доод танхим Үндэсний Ассамблей ердийн олонхын саналаар батлах ба дээд танхим Провинцуудын үндэсний зөвлөл батлах буюу буцааж болно, эсхүл өөрчлөлт оруулж болно. Харин провинцуудад нөлөөлөхөөр хуулийн төсөл дээр хоёр танхим санал зөрөлдвөл уг төслийг хоёр танхимын гишүүдээс бүрдсэн дундын хороонд шилжүүлнэ. Хэрэв уг хороо санал зөрөлдөөнийг зохицуулж чадахгүй бол хуулийн төслөөр доод танхим Үндэсний Ассамблейд дахин санал хураалт явуулах бөгөөд энэ удаад хууль гишүүдийн гуравны хоёроос дээш олонхын саналаар батлагдах ёстой.

Зарим тохиолдолд хоёр танхим зөвшилцөлд хүрч чадахгүй бол хуулийн төслийг бүрмөсөн буцаана. Маш цөөн тохиолдолд парламент тарах болдог.

- Казахстанд доод танхим Мажилис баталсан хуулиа дээд танхим Сенатаар дэмжүүлэхээр өргөн барина. Сенат хуулийг дэмжилгүй Мажилист буцааж болдог. Энэ тохиолдолд Мажилис хуулийг дахин хэлэлцэж, гуравны хоёроос доошгүйн саналаар баталж, Сенатад дахиад хүргүүлж болно. Хэрэв Сенат төслийг дахин дэмжихгүй бол уг төслийг бүрмөсөн буцаах бөгөөд парламентын энэ чуулганы хугацаанд дахин хэлэлцэхгүй.
- Австралид доод танхим - Төлөөлөгчдийн танхим баталсан хуулийн төслөө дээд танхим Сенатад өргөн барина. Хэрэв Сенат уг төслийг батлахаас татгалзах, эсхүл нэмэлт, өөрчлөлттэйгээр баталсан бөгөөд үүнтэй нь доод танхим санал нийлэхгүй байвал доод танхим уг хуулийн төслийг дахин гурван сарын дараа авч хэлэлцэн баталж болно. Хэрэв Сенат төслийг дахин батлахаас татгалзах, эсхүл доод танхимаас ялгаатайгаар баталвал Генерал-губернатор хоёр танхимыг хоёуланг нь зэрэг тарааж болно.¹⁵⁴

Хүснэгт 10. Хоёр танхимтай парламентын эерэг, сөрөг тал

ЭЕРЭГ ТАЛ	СӨРӨГ ТАЛ
Хоёр танхимтай парламентын хувьд	
<ul style="list-style-type: none"> • Бүс нутаг, нийгмийн анги давхарга, овог аймаг зэргээр нийгмийн олон янзын төлөөллийг парламентад оруулна. • Дутагдал, өө сэвтэй хууль батлагдан гарахаас сэргийлнэ. (нэг танхим нь нөгөөгийнхөө баталсан хуулийг дахин хэлэлцдэг) • Хоёр танхимтай байснаар гүйцэтгэх засаглалд тавих хяналт сайжирна. • Хууль тогтоох танхим улс төрийн томилгоо хийхгүй байх боломжтой болно. 	<ul style="list-style-type: none"> • Хууль тогтоомжийг шуурхай батлан гаргах процесс удаашралтай, олон шат дамжлагатай, хэлэлцүүлгийн хугацаа сунжрах, нэгдсэн шийдэлд хүрэхэд төвөгтэй. • Хууль тогтоох үйл ажиллагааны эцсийн хариуцлага хүлээх асуудал маргаантай юм. • Парламент болон Ажлын аппаратын зардал өндөр болно.

2.4. Хоёр шатлал бүхий парламентын талаар

Улс төрийн дэглэмийн хувьд социалист улсууд нь хоёр шатлал бүхий парламентын загвартай байна. Эдгээр социалист улсуудаас БНХАУ, Вьетнам, БНАСАУ, Куба зэрэг нь нийгмийн байгууллын¹⁵⁵ хувьд социалист чиг баримжааг баримталдаг, эрх зүйн бүлийн хувьд социалист эрх зүйн бүл¹⁵⁶-д хамаардаг гэж үздэг. Гэвч Вьетнамын Үндсэн хуулиас үзэхэд эрх зүйт төр¹⁵⁷-ийн үндсэн шинжүүдийг агуулж, нийгмийн харилцаанд ардчилсан чиг баримжааг баримталж буй байдал харагдаж байна.

¹⁵⁴ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Гадаадын зарим орны хоёр танхимтай парламентын талаарх харьцуулсан судалгаа. СТ-11/212.

¹⁵⁵ Нийгмийн байгуулал гэж үндсэн хуулийн эрх зүйн онолд нийгмийн харилцааны түүхэн тодорхой тогтолцоо, өөрөөр хэлбэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хуваарилалт ба солилцооны хүрсэн тодорхой түвшин, нийгмийн ухамсрын онцлог шинж, амьдралын янз бүрийн хүрэн дэх хүмүүсийн харилцан ажиллагааны уламжлалаар нөхцөлдсөн нийгмийн зохион байгуулалт. Төр ба эрх зүйгээр хамгаалагдана. Нарангэрэл.С. Эрх зүйн эх толь бичиг. Анхны хэвлэл. УБ., 2007 он. 301 дэх тал.

¹⁵⁶ Социалист эрх зүйн бүл–байцаан шийтгэх ажиллагааны ойролцоо зарчим болон эрх зүйн арга зүйгээрээ Ром-Германы эрх зүйн бүлийн олон хэв шинжийг өөртөө агуулсан ч улсын өмч дангаар ноёрхсон байдал, улс төрийн намын тогтолцоо зэргээрээ өөр гэж үздэг.

¹⁵⁷ Эрх зүйт төр – Үндсэн хуулийн эрх зүйд ард түмний бүрэн эрхт байдал, үндсэн хуулийн байгуулал бүхий төртэй, төрийн зүгээс хүний эрх ба эрх чөлөөг зөрчихгүй, үндсэн хууль болон бусад хуулийг дээдлэх, эрх мэдлийг хуваарилах, эрх мэдлийн хариуцлагын институт нь нь эрх зүйт төрийн зохион байгуулалтын үндэс болох, шүүх хараат бус байх шинжийг агуулсан байна. Нарангэрэл.С. Монголын эрх зүйн эх толь бичиг. Дөрөв дэх хэвлэл. УБ., 2015 он. 416 дахь тал.

Хоёр шатлал бүхий парламенттай улсын хувьд парламентын доод танхим нь дээд танхимаасаа томилогдсон гишүүдээс бүрддэгээрээ онцлог. Энэ нь төлөөллийн ардчиллын үндсэн зарчимтай зөрчилдөнө.

Хууль тогтоох байгууллага буюу парламент нь хоёр шатлал бүхий нэг танхимтай байхаар Үндсэн хуульдаа хуульчилж, энэ загвараар парламентынхаа үйл ажиллагааг зохион байгуулж буй дараах улсууд байна. Үүнд:

- Бүгд Найрамдах Хятад Ард Улс;¹⁵⁸
- Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс;¹⁵⁹
- Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улс;¹⁶⁰
- Бүгд Найрамдах Куба Улс;¹⁶¹
- Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс.¹⁶²

Эдгээр улсуудаас БНХАУ, Вьетнам, БНАСАУ, Куба зэрэг нь нийгмийн байгууллын¹⁶³ хувьд социалист чиг баримжааг баримталдаг, эрх зүйн бүлийн хувьд социалист эрх зүйн бүл¹⁶⁴-д хамаардаг гэж үздэг. Гэвч Вьетнамын Үндсэн хуулийн байгууллагаас үзэхэд эрх зүйт төр¹⁶⁵-ийн үндсэн шинжүүдийг агуулж, нийгмийн харилцаанд ардчилсан чиг баримжааг баримталж буй байдал харагдаж байна. Тухайлбал, Вьетнамын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд “Социалист Вьетнам Улсын ард түмэн нь шууд ардчиллын хэлбэрээр болон Үндэсний Ассамблей, Ардын зөвлөл,¹⁶⁶ бусад төрийн байгууллагаар дамжуулан шууд бус ардчиллын хэлбэрээр төрийн үйл хэрэгт оролцоно”¹⁶⁷ гэж тунхагласан байна. Мөн хувь хүний улс төрийн, иргэний, эдийн засгийн, нийгэм соёлын болон иргэний эрхийг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрч, хамгаалж, Үндсэн хуульд заасан баталгаагаар хангах тухайгаа Үндсэн хуулиндаа тунхаглан зарласан байна.¹⁶⁸

Мөн оршин суух газраа чөлөөтэй сонгох, гадаад дотоодод чөлөөтэй аялах, шашин шүтэх, эс шүтэх, өөрийн итгэл үнэмшилтэй байх, үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэлийн эрх чөлөө, мэдээлэл авах эрх чөлөө, шүүхээс гэм бурууг нь тогтоогоогүй бол хэнийг ч гэм буруутай тооцож үл болох, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хувийн болон нийтийн өмчийг зайлшгүй шаардлагаар дайчлан авсан бол төрөөс нөхөн олговор олгохтой холбоотой зохицуулалт зэрэг ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний үндсэн эрхийг бүхэлд нь Үндсэн хуулиараа тогтоож, хамгаалсан байна. Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг ч мөн Ш.Монтескьегийн засаглал хуваарилах онолын дагуу хийсэн байна.

¹⁵⁸ https://www.constituteproject.org/constitution/China_2004?lang=en

¹⁵⁹ https://www.constituteproject.org/constitution/Socialist_Republic_of_Vietnam_2013?lang=en

¹⁶⁰ https://www.constituteproject.org/constitution/Laos_2003?lang=en

¹⁶¹ https://www.constituteproject.org/constitution/Cuba_2002?lang=en

¹⁶² https://www.constituteproject.org/constitution/Cuba_2002?lang=en

¹⁶³ Нийгмийн байгуулал гэж үндсэн хуулийн эрх зүйн онолд нийгмийн харилцааны түүхэн тодорхой тогтолцоо, өөрөөр хэлбэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хуваарилалт ба солилцооны хүрсэн тодорхой түвшин, нийгмийн ухамсрын онцлог шинж, амьдралын янз бүрийн хүрэн дэх хүмүүсийн харилцан ажиллагааны уламжлалаар нөхцөлдсөн нийгмийн зохион байгуулалт. Төр ба эрх зүйгээр хамгаалагдана. Нарангэрэл.С. Эрх зүйн эх толь бичиг. Анхны хэвлэл. УБ., 2007 он. 301 дэх тал.

¹⁶⁴ Социалист эрх зүйн бүл–байцаан шийтгэх ажиллагааны ойролцоо зарчим болон эрх зүйн арга зүйгээрээ Ром-ерманы эрх зүйн бүлийн олон хэв шинжийг өөртөө агуулсан ч улсын өмч дангаар ноёрхсон байдал, улс төрийн намын тогтолцоо зэргээрээ өөр гэж үздэг.

¹⁶⁵ Эрх зүй төр – Үндсэн хуулийн эрх зүйд ард түмний бүрэн эрхт байдал, үндсэн хуулийн байгуулал бүхий төртэй, төрийн зүгээс хүний эрх ба эрх чөлөөг зөрчихгүй, үндсэн хууль болон бусад хуулийг дээдлэх, эрх мэдлийг хуваарилах, эрх мэдлийн хариуцлагын институт нь нь эрх зүйт төрийн зохион байгуулалтын үндэс болох, шүүх хараат бус байх шинжийг агуулсан байна. Нарангэрэл.С. Монголын эрх зүйн эх толь бичиг. Дөрөв дэх хэвлэл. УБ., 2015 он. 416 дахь тал.

¹⁶⁶ Ардын Зөвлөл нь орон нутгийн иргэдийн хурал.

¹⁶⁷ https://www.constituteproject.org/constitution/Socialist_Republic_of_Vietnam_2013?lang=en

¹⁶⁸ Вьетнамын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйл.

Харин Лаос нь Үндсэн хуулиараа ардчилсан улс болохоо тунхагласан байна.¹⁶⁹ Мөн үндсэн хуульт хаант засаглалтай орнуудын хувьд ч парламентын танхимуудын хуралдааны чөлөөт цагт үйл ажиллагаа явуулдаг байнгын ажиллагаатай (permanent body) парламентын өөрийн бүтэц ажилладаг нь парламентын дотоод зохион байгуулалтын энэхүү загвар нь аливаа улсын засаглал, нийгмийн байгууллаас хамаарах гэхээс илүү парламентын зохион байгуулалтын нэг хэлбэр гэж үзэж болохоор байна.

Тухайлбал, Испанийн Үндсэн хуулийн холбогдох зүйлүүдэд зааснаар “**Байнгын Төлөөлөл**” буюу “**Permanent Deputation**” нь парламентын хоёр Танхим тус бүрд нь байх бөгөөд парламентын бүлэг бүрээс сонгосон хамгийн багадаа 21 гишүүний бүрэлдэхүүнтэй байнгын ажиллагаатай бүтэц байна. Испанийн Үндсэн хуулийн:

78.1-т “Танхим тус бүрийн Байнгын төлөөлөл нь хамгийн багадаа 21 гишүүнээс бүрдэх ба парламентын бүлгүүдийн тоонд хувь тэнцүүлэн бүрдүүлнэ”,

78.2-т “Байнгын төлөөллийг танхим тус бүрийн дарга нар тэргүүлэх ба тэдний үүрэг нь парламентын чөлөөт цагт Танхимуудын бүрэн эрхийг хамгаалахад оршино. Үндсэн хуулийн 73 дугаар зүйлийг журамлан Үндсэн хуулийн 86, 116 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын дараа Танхимууд тарсан, эсхүл Танхимуудын бүрэн эрхийн хугацаа дууссан бол парламентын бүрэн эрхийг Байнгын төлөөлөл өөртөө авна” гэж заасан байдаг.

Камбожийн Вант Улсын парламент нь парламентын хоёр танхимтай бөгөөд мөн Үндсэн хуульд зааснаар, парламентын танхимуудын чөлөөт цагт байнгын ажиллагаатай “*Standing Committee*” буюу Байнгын хороо ажиллана. Энэ нь манай улсын байнгын хорооноос өөр нэгж юм. Камбожийн Вант Улсын Үндсэн хуулийн 84 дүгээр зүйлд доод танхимын, 108 дугаар зүйлд¹⁷⁰ дээд танхимын байнгын ажиллагаатай бүтцийг заасан бөгөөд чиг үүрэг нь чуулганы чөлөөт цагт парламентын танхимуудын ажлыг эрхлэн явуулахад оршино.

Эдгээр хоёр танхимтай парламентын танхимуудын чөлөөт цагт парламентын ажлыг эрхлэн явуулах байнгын нэгж нь хоёр шатлалт нэг танхимтай парламентын зохион байгуулалтаас ялгаатай. Тухайлбал, хоёр танхимтай парламентын аль ч танхим нь байнгын ажиллагаатай байдаг. Мөн тэдгээрийн чөлөөт цагт ажиллах байнгын төлөөлөл нь дангаар хууль тогтоох эрх эдлэхгүй.

Харин БНХАУ, Вьетнам, Лаос, БНАСАУ-ын хууль тогтоох байгууллагын өөрийн бүрэлдэхүүн дотроос сонгож байгуулдаг байнгын ажиллагаатай бүтэц нь Үндсэн хуулиар Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (АТИХ)-ын бүрэн эрхэд хамаарахаас бусад хууль тогтоомжийг бие даан батлах бүрэн эрхтэй. Мөн бусад хууль тогтоох байгууллагын эдэлдэг бүрэн эрхийг эдлэх боловч Үндсэн хууль болон төсөв, санхүү, татвар, мөнгөний бодлого болон улс орны хувьд нэн чухал гэж үзсэн асуудлаар АТИХ холбогдох хууль баталж, шийдвэр гаргах эрхтэй байдаг байна. Мөн БНХАУ-ын АТИХ-ын хувьд эрүү, иргэн, захиргааны болон төрийн захиргааны төв байгууллагуудын суурь хуулийг батлах бөгөөд эдгээрээс бусад хууль тогтоомжийг Байнгын хороо (УБХ) нь баталдаг.

АТИХ-ыг байнгын ажиллагаатай гэж үздэггүй бөгөөд БНХАУ-ын АТИХ нь жилд нэг удаа хуралддаг бол Вьетнам Улсынх жилд 2 удаа чуулах бөгөөд нэг удаадаа 30 хоног чуулна. Вьетнам Улсын Үндсэн хуулийн 82 дугаар зүйлийн 82.3 дахь хэсэгт “Үндэсний Ассамблейн төлөөлөгчийн ажил үүргийн зардлыг төрөөс гаргана” гэж заасан. Харин төлөөлөгчид сар бүр тогтмол цалин олгох хуулийн заалт байхгүй.

¹⁶⁹ Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улсын Үндсэн хуулийн 2 дугаар зүйл.

¹⁷⁰ https://www.constituteproject.org/constitution/Cambodia_2008?lang=en

Байнгын бус үйл ажиллагаатай АТИХ-ын үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг төр хариуцах бөгөөд Вьетнам Улсын хувьд нийт 500 төлөөлөгч нь “part time” буюу зөвхөн хуралдааны үед урамшуулал авах бөгөөд түүний 33 хувь болох Байнгын хорооны 165 гишүүн л тогтмол цалинжин ажиллаж байгаа нь бага зардлаар төрийн эрх барих дээд байгууллагын ажлыг чанаржуулж, хариуцлагажуулах сайн талтай гэж үзэж болохоор байна.¹⁷¹

Хүснэгт 11. Хоёр шатлал бүхий парламентын эерэг, сөрөг тал

ЭЭРЭГ ТАЛ	СӨРӨГ ТАЛ
Хоёр шатлал бүхий парламентын хувьд¹⁷²	
<ul style="list-style-type: none"> Тодорхой орон нутаг, хүн ам, нийгмийн цөөнхийн ашиг сонирхлыг зөрчихөөс сэргийлэх. Улс төрийн намын нөлөөллийг багасгах, аливаа ашиг сонирхлоос ангид байх, монополь байдлыг тэнцвэржүүлэх. Шат тус бүрээр хэлэлцэн батлагдаж буй хууль тогтоомжийн чанар сайжрах. Парламентын хяналтын тогтолцоо сайжрах, доод танхимын үйл ажиллагааг хянах, мэргэшүүлэх. 	<ul style="list-style-type: none"> Хоёр шатлал бүхий парламент нь социалист дэглэмтэй улсад байдаг. Парламентын төсөв хэт ихсэх. Тухайлбал, сонгуулийн зардал, гишүүдийн зардал, албан хаагчдын зардал болон Парламентын ажлын албаны бүтэц хэт томрох. Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн үйл явц хэт удаашрах, цаг алдах.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁷¹ http://www.nyulawglobal.org/globalex/Vietnam1.html#_National_Assembly

¹⁷² Улсын Их Хурал. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах сэдвийн танилцуулга. УБ., 2017 он. 54 дахь тал.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- БНМАУ-ын АИХ-ын 1991 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны тэмдэглэл (№20).
- БНМАУ-ын АИХ-ын 1991 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны тэмдэглэл (№21).
- БНМАУ-ын АИХ-ын 1991 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны тэмдэглэл (№22).
- БНМАУ-ын Бага хурлын 1991 оны намрын чуулганы 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэл.
- Олон Улсын Парламентын Холбооны цахим хуудас <https://www.ipu.org/national-parliaments>
- Улсын Их Хурал. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах сэдвийн танилцуулга. УБ., 2017 он.
- Улсын Их Хурал. Үндэсний Статистикийн хороо. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулгын дүн. УБ., 2017 он.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Гадаадын зарим орны хоёр танхимтай парламентын талаарх харьцуулсан судалгаа. СТ-11/212. УБ., 2012 он.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба Монгол Улсын Их Цаазын төслүүдийн (1991.VI.05, X.05, XI.07) харьцуулалт. СТ-15/206. УБ., 2015 он.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Парламентын засаглалтай улс орнуудын төрийн эрх мэдлийн хуваарилалт-харьцуулсан судалгаа, СТ-17/206. УБ., 2017 он.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Хоёр шатлал бүхий нэг танхимтай парламент: БНХАУ, Вьетнам улсын туршлага-харьцуулсан судалгаа, СТ-17/211. УБ., 2017 он.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Холбооны улсуудын парламентын танхимын тоо харьцуулсан судалгаа. СТ-15/212. УБ., 2015 он.
- Чимид Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2017 он. 28 дахь тал.



ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭЛДЭХҮҮН

(Тойм судалгаа)

Р.Оргилмаа

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН БҮРЭЛДЭХҮҮН

1. ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ТООГ ХЭРХЭН ТОГТООДОГ ЗАРЧМЫН ТУХАЙ

1.1. Орчин үеийн парламент дахь төлөөллийн болон хүн амын тоо

2. ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ

2.1. 1992 оны Үндсэн хуулийг хэлэлцсэн байдал

2.1.1. Ард нийтээр хэлэлцүүлсэн Монгол Улсын Их Цааз (Үндсэн хууль)-ын төслийн 23 дугаар зүйлийн саналын тойм

2.1.2. Монгол Улсын Их Цааз (Үндсэн хууль)-ын Ард нийтээр хэлэлцүүлсэн дүн болон шинэчилсэн төслийн 21.1-ийн саналын тойм

2.1.3. УБХ-аас АИХ-д өргөн барьсан Монгол Улсын Их Цааз (Үндсэн хууль)-ын төслийн 21.1-ийн саналын тойм

2.2. 2019 онд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх үеэр УИХ-ын бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх тухай гарсан санал

3. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

3.1. Дэлхийн улс орнуудын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулсан байдал

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын Их Цааз (Үндсэн хууль)-ын өөрчлөлтийн харьцуулалт

Хүснэгт 2. УИХ-ын гишүүдийн тоог өөрчлөх саналын томъёолол

Хүснэгт 3. Хоёроос таван сая хүн амтай, парламентын засаглалтай улс орнуудын парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоо

Хүснэгт 4. Парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоо

Хүснэгт 5. Дэлхийн улсуудын парламентын танхим, гишүүд, хүн амын тоонд харьцуулсан байдал

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Парламентын гишүүний тоог тогтоох зарчим болох Куб язгуурын томьёо (Cube root formula)-г Эстонийн улс төр судлаач Рейн Таагепера анх томьёолсон байна. Парламентын гишүүдийн тоо нь хүн амын тооноос куб язгуур гаргасан тоотой ойролцоо байвал зохимжтой гэсэн үзэл санаа юм. Гэвч практикт энэ нь хэрэгждэггүй бөгөөд улс орнууд янз бүрийн нийгмийн бүлгүүдийн эрх ашиг, сонирхлыг бүрэн дүүрэн илэрхийлэх, төлөөлөх боломжтой, оновчтой тоог тодорхойлохын тулд гол төлөв хүн амын тоо, нягтаршил, газар нутгийн байдал, уламжлал, парламент хэрхэн ажилладаг, өөрөөр хэлбэл, байнгын, эсхүл байнгын бус ажиллагаатай парламенттай зэрэг олон зүйлийг харгалздаг байна. Парламентын гишүүдийн тоог тогтооход хамгийн гол хүчин зүйл нь тухайн орны хүн амын тоо байдаг байна.¹⁷³ Ингэхдээ нийт хүн амын тоог бус тухайн улсын идэвхтэй хүн ам (хүн амын бичиг үсэгт тайлагдсан хувь болон хүн амын хөдөлмөрийн насны хувь)-ын тоог тооцон гаргах нь зүйтэй гэж аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад үздэг байна.

Түүхээс үзвэл төрийн эрх барих, хууль тогтоох “Их Хурал”-ын гишүүдийн тоог тогтоохдоо хүн амыг бүхэлд нь, бүрэн дүүрэн төлөөлөх учиртайг үндэс болгодог байжээ. 1924 оны Монгол Улсын Үндсэн хуульд “Улсын Их Хурал бол олон аймаг ба хот, жич ардын цэргийн төлөөлөгчид хуралдах бөгөөд тоог төлөөлөгчид сонгох газрын хүн амын олон цөөнийг үзэж нэгэн жилийн хугацаагаар сонговол зохино” гэж хуульчилсан байна. 1940 оны Үндсэн хуульд “хүн амын 1500 хүн тутамд нэг төлөөлөгч сонгон...”, 1957 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөр “3500 хүн ам тутмаас нижгээд депутатаар бодож...”, 1960 оны Үндсэн хуульд “4000 хүн ам тутамд 1 депутат байхаар...” тус тус тооцон төлөөллийн тоог тогтоож байсан байна.

1992 оны ардчилсан шинэ Үндсэн хуульд төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллагын бүрэлдэхүүний тоог, Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын гишүүд эрдэмтэн, судлаачидтай хамтран судалгаа шинжилгээнд үндэслэн, сонгон авсан шинэ төрийн болон эдийн засгийн тогтолцоо, хүн амын тоо, тархац, хэтийн төлөв, тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал, улс орны хөгжлийн чиг хандлага зэргийг харгалзан тогтоосон байна. Ингэхдээ хүн амын тоог чухалчлан үзэж, дэлхийн улс орнуудын жишигт нийцүүлэн, хэтдээ манай улсын хүн ам дунджаар 7 сая орчим болоход 76 гишүүн нь нийт хүн амаа бүрэн төлөөлөх боломжтой гэсэн тооцооллын үндсэн дээр энэхүү тоог тогтоожээ.¹⁷⁴

Шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэн батлах явцад төслийг нийт 5 удаа өөрчилж, байнгын ажиллагаатай парламентын бүтэц, бүрэлдэхүүний талаар Ард нийтийн хэлэлцүүлэг, Улсын Бага Хурал болон Ардын Их Хурлын хуралдаанууд дээр:

- 50-78, эсхүл 100-120 гишүүнтэй нэг танхимтай парламенттай байх;
- 30-50 гишүүнтэй байнгын ажиллагаатай доод танхим болон 100-120 гишүүнтэй тодорхой давтамжтай хуралддаг дээд танхим бүхий 2 танхимтай парламенттай байх зэрэг саналууд гарч байв.

2019 оны 06 дугаар сард Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын нэр бүхий 62 гишүүнээс Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг өргөн мэдүүлэхэд Улсын Их Хурлын гишүүдийн тоотой холбоотой зохицуулалт төсөлд тусгагдаагүй байв. Харин 2019 оны 07 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн төсөл, саналд УИХ-ын гишүүний тоог “108” байхаар санал оруулж ирснийг Зөвшилцлийн ажлын хэсгээс “99” гэж өөрчилж, саналаа Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд

¹⁷³ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Унитар улсуудын парламентын болон орон нутгийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаа, парламентын гишүүдийн тоог тогтоох жишиг. СТ-11/225. Судалгааны эмхэтгэл, Боть 12. УБ., 2011 он.

¹⁷⁴ Улсын Их Хурлын Тамгын газар. УБХ-ын 1991.10.17-ны өдрийн хуралдааны тэмдэглэл. (Их цааз төслийн асуулт хариулт)

оруулсан. Энэхүү саналыг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар 66.7 хувийн саналаар дэмжсэн боловч, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар нийт гишүүний дөрөвний гурвын олонхын саналаар дэмжигдээгүй байна.

Судалгаанд олон улсын туршлагыг дэлхийн 191 улсыг хамруулан судалж, парламентын гишүүдийн тоо болон нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоог Монгол Улстай харьцуулан гаргав. Ингэхэд арлын улсууд болон хүн ам цөөнтэй улс орнуудын хувьд парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоо 1000 хүрэхгүй байхад хүн ам олонтой улс орнуудын хувьд нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоо хэдэн зуун мянгаас хоёр сая гаран (Энэтхэг улс 2.5 сая) хүртэл байна. Тодруулбал, судалгаанд хамрагдсан 191 улсаас 66 (34.7%) улсын парламентын нэг гишүүн нь 100.001-ээс дээш хүн амыг төлөөлж байна. Монгол Улстай хүн амын тоогоороо ойролцоо (2-5 сая хүн амтай), парламентын засаглалтай 14 улсаас парламентын нэг гишүүн нь дунджаар 40.5 мянган иргэнийг төлөөлж буй 7 улс байна.

Монгол Улсын Их Хурлын нэг гишүүн нь 44.178 иргэнийг төлөөлөн ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын парламент нь бүтэц, бүрэлдэхүүний хувьд өөрчлөгдсөн хийгээд өөрчлөхөөр шийдвэрлэсэн тохиолдлууд цөөнгүй байгаа бөгөөд тухайлбал, 2019 онд Итали улсын парламентын доод танхим нь парламентын 2 танхимын гишүүдийн тоог цөөлөх хуулийг баталж, Үндсэн хуульдаа мөн өөрчлөлт оруулсан байна.¹⁷⁵ Ингэснээр ирэх 10 жилийн хугацаанд гишүүдийн цалин болон бусад зардалд зарцуулагдах ойролцоогоор 1 тэрбум Евро-г улсын төсвөөс хэмнэнэ гэсэн тооцоо гарчээ. Тус шийдвэрийг 2023 оноос хэрэгжүүлж эхлэхээр шийдвэрлэсэн байна.¹⁷⁶

Эерэг ба сөрөг тал

ЭЕРЭГ ТАЛ	СӨРӨГ ТАЛ
Парламентын олон гишүүнтэй тохиолдолд	
<ul style="list-style-type: none"> Парламентаас батлагдаж буй хуулийн чанар, үр нөлөө сайжирна. Парламентын гишүүд зүй бус нөлөөнд автах эрсдэлийг илэрхий бууруулах. Засгийн газарт тавих парламентын хяналтыг үр нөлөөтэй болгох. 	<ul style="list-style-type: none"> Хууль тогтоомжийг шуурхай батлан гаргах процесс удаашралтай, нэгдсэн шийдэлд хүрэхэд төвөгтэй. Парламентын болон Ажлын албаны зардал нэмэгдэнэ.
Парламентын цөөн гишүүнтэй тохиолдолд	
<ul style="list-style-type: none"> Аливаа асуудлыг шуурхай шийдэх боломжтой. Зардал, төсөв хэмнэнэ. Парламент нь ард түмнийг төлөөлөх мэргэшсэн, чадварлаг гишүүдээс бүрдэх боломжтой. 	<ul style="list-style-type: none"> Парламентын гишүүдийн тоо нийт иргэдийн тоондоо цөөдөж, төлөөлөх зарчмаа хэрэгжүүлэх боломж багасдаг. Батлагдаж буй хууль, парламентаас гарч буй шийдвэр чанаргүй, үр нөлөө багатай болох магадлалтай.

¹⁷⁵ https://www.constituteproject.org/constitution/Italy_2020?lang=en

¹⁷⁶ <https://www.bbc.com/news/world-europe-49979103>

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН БҮРЭЛДЭХҮҮН

1. ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ТООГ ХЭРХЭН ТОГТООДОГ ЗАРЧМЫН ТУХАЙ¹⁷⁷

Аливаа улсын парламент нь хууль тогтоох, ард түмнийг төлөөлөх, гүйцэтгэх эрх мэдэлд хяналт тавих чиг үүргээ чанартай хэрэгжүүлэхийн тулд хэдэн гишүүнтэй байвал зохистойг “Куб язгуурын томьёо”¹⁷⁸-оор тооцоолон гаргадаг байна. Парламентын гишүүдийн зохистой хэмжээг тогтоох куб язгуурын томьёо (Cube root formula)¹⁷⁹-г анх 1972 онд Эстонийн улс төр судлаач Рейн Таагепера томьёолсон байна. Энэ нь парламентын гишүүдийн тоо нь хүн амын тооноос куб язгуур гаргасан тоотой ойролцоо байвал зохимжтой гэсэн үзэл санаа бөгөөд (Taagepera, 1972; Taagepera and Shugart, 1989; Taagepera and Recchia, 2002; Taagepera, 2007) төлөөллийн пропорционал хэмжээ алдагдахаас сэргийлэхэд чиглэгдсэн байна (Lijphart 2012).¹⁸⁰

Практикт парламентын гишүүдийн тоог тогтоох ерөнхий /нийтлэг/ томьёолол байхгүй юм. Парламентын хэмжээ буюу гишүүдийн тоо нь тухайн улс орны нөхцөл байдал, хөгжлийн түвшингээс хамааран янз бүр байх ба парламентын гишүүдийн зохистой тоо хэмжээг тогтооход тухайн улсын парламентын түүхэн уламжлал, улс орны нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо (сонгуулийн эрх бүхий иргэний тоо болон бичиг үсэг мэддэг хүний тоо), газар зүй, нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжүүдийн тоо зэрэг нь нөлөөлөх хүчин зүйлүүд байж болох юм.¹⁸¹

1.1.Орчин үеийн парламент дахь төлөөллийн болон хүн амын тоо

Аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад ардчилсан төлөөллийг судлахад тухайн улсын хүн амын болон парламентын төлөөллийн тоо хоорондын куб язгуурын үндсийг дараах байдлаар тооцно:

$$S = P^{1/3}$$

Энд “**S**” нь парламент (эсхүл парламентын доод танхим)-ын суудал, харин “**P**” нь улсын нийт хүн ам болно. Хөгжиж буй орнуудын хувьд энэхүү энгийн тооцоогоор парламент дахь төлөөллийн тоог гаргасан байна. Үнэн хэрэгтээ энд нийт хүн амын тоо бус, харин “**Pa**” буюу “идэвхтэй” хүн амын тоо чухал юм. Идэвхтэй хүн ам нь зах зээлийн эргэлтэд оролцох хийгээд улс төрийн төлөөллийг илэрхийлж болох хэсэг гэж тооцож болно:

$$Pa = PLW$$

Энд “**L**” нь хүн амын бичиг үсэгт тайлагдсан хувь, “**W**” нь хүн амын хөдөлмөрийн насны хувь болно. Иймд хэрэв 10 сая хүн амтай, тэдгээрийн 90 хувь нь бичиг үсэгт тайлагдсан, 55 хувь нь хөдөлмөрийн насных бол “**Pa**” буюу “идэвхтэй” хүн амын тоо 4,950,000 болно.

¹⁷⁷ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Төлөөллийн эрх мэдлийн байгууллагын төлөөллийн тоог тогтоох, тооцох зарчмын талаарх лавлагаа (куб язгуурын томьёо). СТ-19/418. Судалгааны боть 29. УБ., 2019 он.

¹⁷⁸ Парламентын гишүүдийн зохистой хэмжээг тогтоох куб язгуурын томьёо (cube root formula)-г анх 1972 онд Эстонийн улс төр судлаач Рейн Таагепера томьёолсон байдаг. Энэ нь парламентын гишүүдийн тоо нь хүн амын тооноос куб язгуур гаргасан тоотой ойролцоо байвал зохимжтой гэсэн үзэл санаа.

¹⁷⁹ Parliaments Shapes and Sizes, Raphael Godefroy and Nicolas Klein*, January 6, 2017. <https://nicolasklein.com/data/documents/parliaments010617.pdf>

¹⁸⁰ Explaining reforms of assembly sizes, Reassessing the cube root law relationship between population and assembly size, Kristof Jacobs, Institute of Management Research, Radboud University (NL) Simon Otjes, Documentation Centre Dutch Political Parties, University of Groningen (NL) <https://ecpr.eu/Filestore/PaperProposal/3bc100be-56fe-4efc-8d8c-a1f0b85e7f24.pdf>

¹⁸¹ <http://aceproject.org/electoral-advice/archive/questions/replies/760379812>
<http://aceproject.org/main/english/es/esc03.htm>

$$Pa = 10,000,000 \times .90 \times .55 = 4,950,000$$

Харин 10 сая хүн амтай, тэдгээрийн 55 хувь нь хөдөлмөрийн насны хүн, харин бичиг үсэгт тайлагдсан байдал нь 75 хувь бол идэвхтэй хүн амын тоо нь 4,125,000 болно.

$$Pa = 10,000,000 \times .75 \times .55 = 4,125,000$$

Хөгжингүй орнуудад идэвхтэй болон нийт хүн амын хооронд ялгаа бага байдаг бол хөгжиж буй орнуудад том ялгаа гарч болно.

Улс орнуудыг парламентын хамт судлахад идэвхтэй хүн амын тоо болон парламентын суудлын тооны хооронд дараах харьцаа илэрсэн байна:

$$S = (2Pa)^{1/3}$$

Дээрх хоёр жишээг авч үзвэл, 4.950.000 идэвхтэй хүн амтай улсын парламент нь 215 гишүүнтэй байхаар тооцох бол 4.125.000 идэвхтэй хүн амтай улсын парламент нь 202 гишүүнтэй байхаар тооцож байна.

2. ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ¹⁸²

Анхдугаар Үндсэн хууль батлагдахын өмнөх нөхцөл байдалд зөвлөх эрх бүхий “Улсын түр цагийн хурлын дүрэм хэмжээ”-г 1921 оны 09 дүгээр сарын 20-нд Ардын засгийн газраас баталж, 10 дугаар сарын 25-нд Улсын түр цагийн хурлыг нээсэн байна. Энэ нь яамдын тэргүүн ба дэд сайдууд, эрхэлсэн түшмэд, аймаг, шавь, цэрэг ба залуучуудын байгууллын төлөөллийг багтаасан, нийгмийн янз бүрийн асуудлаар засгийн газарт зөвлөх эрхтэй байгууллага байжээ.

Түр цагийн хурлыг Дөрвөн аймаг, шавь тус бүрээс бичиг эрдэмд сайн 5 ард, Дөрвөн аймаг, шавийн ноёдоос тус бүр 1, яамдын түшмэдүүд, дэд сайдууд, тэргүүн сайдууд, Намын төв хорооны түшмэл 1, залуучуудын эвлэлээс 3, сурган боловсруулах хэлтсээс 1, цэргийн хороо тус бүрээс 1 хүнийг сонгон байгуулна гэж заасан байна. Улсын түр цагийн хурал нь хууль тогтоох бус зөвлөх эрхтэй боловч хууль санаачлах эрх эдэлж, Монголын нийгмийн янз бүрийн анги давхрааны бодол санаа, хүсэл зоригийг илэрхийлсэн ардчилал, үндэсний нэгдлийн шинжтэй байгууллага байсан байна. Уг хурал Улсын Их Хурлыг хуралдуулах бэлтгэл хангах түр зуурын түүхэн үүргээ гүйцэтгээд 1923 онд таржээ.¹⁸³

Улсын Анхдугаар Их Хурал 1924 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Нийслэл хүрээнд эхэлж, Халхын дөрвөн аймаг, Дөрвөдийн хоёр аймаг, Алтай ба Хөвсгөлийн Урианхай хошууд, Дарьганга, Ховдын тариачин хошуу болон ардын цэргийн ангиудаас нийт 90 хүн төлөөлөгчөөр сонгогдсоноос 77 төлөөлөгч нь оролцжээ. 1924 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Улсын Анхдугаар Их Хурлаар Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаар Үндсэн хуульт байгууллын хууль зүйн үндэс тавигджээ. Анхдугаар Үндсэн хуульд: “БНМАУ-ын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах, хурлын чөлөө цагт Улсын Бага хуралд хадгалуулах бөгөөд Бага хурлын чөлөө цагт Бага хурлын тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино” хэмээжээ.

1924 оны Үндсэн хуулийн 7 дугаар зүйлд: “Улсын Их Хурал бол олон аймаг ба хот, жич ардын цэргийн төлөөлөгчид хуралдах бөгөөд тоог төлөөлөгчид сонгох газрын хүн амын олон цөөнийг үзэж нэгэн жилийн хугацаагаар сонговол зохино” гэж хуульчилсан байна.¹⁸⁴

¹⁸² Лүндээжанцан Д. Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2014 он.

¹⁸³ <https://history-hvrd.blogmn.net/95254/lyekts-%E2%84%9612--sedev:-1921-1930-onii-mongoliin-uls-turiin-gadaad-do...html?>

¹⁸⁴ <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1924.html>

Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд: “Улсын Бага Хурлыг гучин гишүүнтэй сонгож байна” гэсэн заалтыг 1925 онд хуралдсан Улсын II Их хурлын тогтоолоор өөрчилж гучаас олон гишүүдийг сонгох болжээ.

1940 оны Үндсэн хуулийн 13 дугаар зүйлд: “БНМАУ-ын засгийн дээд эрхийг барих газар нь Улсын Их Хурал” гэж хуульчлан тогтоосон байна. Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд: “Улсын Их Хурал бол хот ба аймгийн хурлуудаар хүн амын 1500 хүн тутмаас нэг төлөөлөгчөөр сонгогдсон хот, аймгийн хөдөлмөрчин ард олон ба ардын хувьсгалт цэргийн албан хаагчдын төлөөлөгчдөөс байгуулагдана” гэж хуульчилжээ.¹⁸⁵

1949 онд Улсын IX Их Хурал хуралдаж, Улсын Их Хурлын сонгуулийг шууд, тэгш, саналаа нууцаар хураах үндсэн дээр явуулж, Улсын Их Хурлын депутатыг тойргоор сонгох болсон. Үүний дагуу Үндсэн хуульд өөрчлөлт оруулж Улсын Бага Хурлыг татан буулгаж, Улсын Их Хурал бол төрийн дээд эрхийг барих, хууль тогтоох эрх бүхий байгууллага гэж тунхаглан бэхжүүлжээ.

1951 оны 07 дугаар сард Улсын Их Хурлын анхдугаар сонгуулийг шинэ тогтолцоонд тулгуурлан явуулж сонгогдсон 295 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй шинэ Улсын Их Хурал байгуулагдсан байна.

1957 онд “Улсын Их Хурлыг 3500 хүн ам тутмаас нижгээд депутатаар бодож, сонгуулийн тойргуудаар ард иргэд сонгоно” хэмээн Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан байна.

1960 оны Үндсэн хуульд “БНМАУ-ын Ардын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага, хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Ардын Их Хуралд хадгална. БНМАУ-ын иргэд нь дөрвөн мянган хүн тутмаас нэг депутат байхаар бодож сонгуулийн тойргууд байгуулж Ардын Их Хурлыг сонгоно” гэж заажээ.¹⁸⁶

1990 оны 05 дугаар сард батлагдсан “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль”-аар төрийн эрх барих уламжлалт дээд байгууллага – Ардын Их Хурал (АИХ), парламентат ёсны шинэ байгууллага – Улсын Бага Хурал (УБХ), төрийн тэргүүн – Ерөнхийлөгчийн институтыг бий болгосон байна.¹⁸⁷

2.1.1992 оны Үндсэн хуулийг хэлэлцсэн байдал

Ардчилсан шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх явцад парламентын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоохдоо Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссоос боловсруулсан төслийг тухайн үеийн УБХ болон АИХ-аар нухацтай хэлэлцэж, судалгаа шинжилгээ, эдийн засгийн тооцоонд үндэслэн, хүн ам, улс орны хөгжлийн хэтийн төлөв зэргийг харгалзан нэг танхимтай, 76 гишүүнтэй байхаар тогтсон байна.

“Их цааз” (Үндсэн хууль)-ын төслийг хэлэлцэн батлах явцад төсөлд нийт 5 удаа өөрчлөлт оруулж, УБХ, АИХ болон Ард нийтээр хэлэлцүүлэхэд Улсын Их Хурал (УИХ)-ын гишүүний тоо, сонгуулийн зарчмын талаар дараах байдлаар томьёолсон байна.¹⁸⁸

¹⁸⁵ <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1940.html>

¹⁸⁶ <https://legalinfo.mn/api/front/index.html>

¹⁸⁷ Лүндээжанцан Д. Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2014 он.

¹⁸⁸ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба Монгол Улсын Их Цаазын төслүүдийн (1991.VI.05, X.05, XI.07) харьцуулалт” СТ-15/206, Судалгааны боть 20.

* ТАЙЛБАР: -үг, өгүүлбэр шинээр нэмэгдсэнийг тод хараар (“**bold**”),

-үг, өгүүлбэрийг өөрчлөн найруулсныг доогуур зураасаар (“underline”),

-үг, өгүүлбэр хасагдсаныг дундуур зураасаар (“~~strikethrough~~”),

-зарчмын зөрүүтэй санал орхигдсон, өөрчлөлт орсон зэргийг тодруулав (“**highlighting**”) тус тус тэмдэглэв.

Хүснэгт 1. Монгол Улсын Их Цааз (Үндсэн хууль)-ын өөрчлөлтийн харьцуулалт

1-р төсөл	2-р төсөл	3-р төсөл	4-р төсөл	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ	МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ	МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ
УБХ-д өргөн барьсан хувь	Ард түмнээр хэлэлцүүлсэн хувь	УБХ-д өргөн барьсан хувь	УБХ-аас АИХ-д өргөн барьсан хувь	Батлагдсан хувь
1991.04.19	1991.06.05	1991.10.05	1991.11.07	1992.01.13
I. Хууль тогтоох эрх мэдэл. Монгол Улсын Их хурал	НЭГ. Монгол Улсын Их хурал	НЭГ. Монгол Улсын Их Хурал	НЭГ. Монгол Улсын Их Хурал	НЭГ. Монгол Улсын Их Хурал
21 дүгээр зүйл	Хорин гуравдугаар зүйл	Хорин нэгдүгээр зүйл	Хорин нэгдүгээр зүйл	Хорин нэгдүгээр зүйл
Монгол Улсын Их Хурал нь нэг танхимтай байнгын ажиллагаатай байх бөгөөд 75 гишүүнээс бүрдэнэ.	1. Мөнгөл-Улсын Их Хурал нь нэг танхимтай байнгын ажиллагаатай байх бөгөөд 75 гишүүнээс бүрдэнэ.	Улсын Их Хурал 75 гишүүнээс бүрдэнэ.	1. Улсын Их Хурал 76 гишүүнээс бүрдэнэ.	1. Улсын Их Хурал нэг танхимтай , далан зургаан гишүүнтэй байна.
		<i>А хувилбар:</i> 2. Улсын Их Хурлын гишүүнийг Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд <u>бүх нийтийн</u> чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж 4 жилийн хугацаагаар сонгоно.		2. Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд <u>нийтээрээ</u> , чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.
Монгол Улсын Их Хурлын гишүүнийг Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд саналаа нууцаар гаргаж 6 жилийн хугацаагаар сонгоно.	2. Монгол Улсын Их Хурлын гишүүнийг Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд <u>нийтээрээ тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр</u> саналаа нууцаар гаргаж 6 жилийн хугацаагаар сонгоно.	<i>Б хувилбар:</i> 2. Мөнгөл Улсын Их Хурлын гишүүнийг Мөнгөл-улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ тэгш, шууд сонгох <u>эрхийн үндсэн дээр</u> саналаа нууцаар гаргаж 6 жилийн хугацаагаар сонгоно.	2. Улсын Их Хурлын гишүүнийг сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, шууд сонгох <u>эрхтэй оролцож</u> саналаа нууцаар гаргаж, 6 жилийн хугацаагаар сонгоно.	
Монгол Улсын Их Хурлын Тэргүүн даргаас бусад гишүүний хоёрны нэгийг гурван жил тутам шинэчлэн сонгож сэлбэнэ.	3. Монгол Улсын Их Хурлын даргаас бусад гишүүний хоёрны нэгийг гурван жил тутам шинэчлэн сонгож сэлбэнэ.	Мөнгөл Улсын Их Хурлын даргаас бусад гишүүний хоёрны нэгийг гурван жил тутам шинэчлэн сонгож сэлбэнэ.	Улсын Их Хурлын нийт гишүүний хоёрны нэгийг 3 жил тутам шинэчлэн сонгож сэлбэнэ.	

Үндсэн хуулийн төслийн Ард нийтийн хэлэлцүүлэг, УБХ болон АИХ-ын хуралдааны хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүдийн тоог тогтоох тухайд нэлээдгүй саналууд гарч байжээ.

Монгол Улсын Их Цааз (Үндсэн хууль)-ын төсөл боловсруулах комиссоос боловсруулсан анхны төслийг 1991 оны 04 дүгээр сарын 19-нд БНМАУ-ын Бага Хуралд хэлэлцүүлэхээр өргөн барьжээ. УБХ III чуулганаараа 1991 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 09-ний өдрийг хүртэл 2 удаа (1, 2 дугаар хэлэлцүүлэг) хэлэлцэн зарим тодруулга, өөрчлөлт хийж улмаар ард нийтийн хэлэлцүүлэгт оруулахаар шийдэж тогтоол гаргасан байна.¹⁸⁹

Тус төсөлд Их Хурлын бүрэлдэхүүнийг 75 гишүүнтэй байхаар тогтоосон бөгөөд БНМАУ-ын ерөнхийлөгч, Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын дарга П.Очирбат УБХ-д төслийг хэлэлцүүлэхээр өргөн барихдаа дараах үндэслэлийг илтгэлдээ дурджээ.

“...Төслийн 20, 21 дүгээр зүйлд тодорхойлсноор төрийн эрх барих дээд байгууллагын шилжилтийн чанартай одоогийн тогтолцоог өөрчилж, 75 гишүүн бүхий нэг танхимт байнга ажилладаг УИХ байхаар тусгалаа. Гишүүний тоо 75 байх нь бага тоо биш гэж үзэж байна. Нэг гишүүн цаашдаа 25000-30000 хүний буюу 14000-15000 орчим сонгогчийг төлөөлж байх нь дэлхийн улсуудын жишигтэй харьцуулахад бүрэн боломжтой бөгөөд нийцтэй юм. ... УИХ-ын бүрэлдэхүүнийг тогтмол “нөхөн сэлбэх” зарчимд шилжихээр төсөлд орж байна. Энэ нь алсдаа парламент мэргэшсэн байх нөхцөл бүрдүүлэх болно” гэсэн байна.¹⁹⁰

УБХ “Монгол Улсын Их Цааз” (Үндсэн хууль)-ын төслийг зүйлчлэн нухацтай авч хэлэлцээд комиссын боловсруулсан төслийг ард нийтээр хэлэлцүүлэхийг зөвшөөрсөн байна.

2.1.1. Ард нийтээр хэлэлцүүлсэн Монгол Улсын Их Цааз (Үндсэн хууль)-ын төслийн 23 дугаар зүйлийн саналын тойм¹⁹¹

Монгол Улсын Их Цааз (Үндсэн хууль)-ыг ард нийтээр хэлэлцүүлсэн төсөлд “Улсын Их Хурал нэг танхимтай, байнгын ажиллагаатай, 75 гишүүнээс бүрдэх юм. Урьдчилсан баримжаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрийг 75 тойрогт хуваах үед сонгуулийн тэгш эрхийн зарчмын тухай асуудал гарч ирнэ. Сонгуулийн тэгш эрхийн зарчмын мөн чанар нь нэг тойрогт хамаарах хүний тоогоороо биш, харин тэнд нэг сонгогч, нэг л удаа нэг хүний төлөө саналаа өгч нэг хүн нэг тойрогт бүртгэгдэх зэргээр сонгогч сонгогчтойгоо эрх тэгшээр сонгуульд оролцдогт оршино.

УИХ-ын нэг гишүүний сонгуулийн тойрог нь одоогийн хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг хамрах юм. Энэ нь урьдынхтай харьцуулбал УИХ-ын гишүүнээс сонгогч олон түмэнтэйгээ харилцах бололцоог хязгаарлагдмал болгож болзошгүй мэт ойлголт төрүүлж болох юм. Комисс асуудлыг ийнхүү тавихдаа дараах учир баримтад тулгуурласан юм.

Нэгдүгээрт, УИХ-ын гишүүн гэдэг бол ард түмнээс сонгогдсон төрийн эрх барих байгууллагын байнгын төлөөлөгч, төрийн шадар зүтгэлтэн байх юм.

Хоёрдугаарт, шинэ төсөл ёсоор орон нутгийн засаг захиргаа нь зөвхөн төвөөс өгсөн үүрэг даалгавар, гүйцэтгэгч бус “хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий байгуулалт” байх болно. Ийм нөхцөлд УИХ-ын гишүүн сонгогчид болон төвийн байгууллагын хооронд аж ахуй, эрэлтийн зууч байх үүргээс чөлөөлөгдөх болно.

¹⁸⁹ Чулуун Г. Улсын Бага Хурлын товчоон (1990-1992). УБ., 2015 он.

¹⁹⁰ Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2016 он. 561 дэх тал.

¹⁹¹ Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2016 он. 535 дахь тал.

Гуравдугаарт, хэрэв шаардлагатай гэж үзвэл УИХ-ын гишүүн сонгогдсон тойргийнхоо хэмжээнд хэд хэдэн хэсэгт өөрийн бүрэн эрхт төлөөлөгчдийг ажиллуулж сонгогчдын эрэлт хүсэлтийг хүлээн авч тэдэнтэйгээ байнга холбоотой байх боломжоор хангагдаж болох юм.

УИХ-ын гишүүдийн мэргэшсэн чадварыг дээшлүүлэх, шинэлэг үзэл баримтлалаар тогтмол сэлбэж байх зорилгоор түүний бүрэлдэхүүнийг 3 жил тутамд өөрчлөн сэлбэж байх зарчмыг сонгон авав. Энэ зарчмыг сонгон авснаар цаашдаа УИХ-ынх бус харин түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил байх бөгөөд УИХ нь байнга тасралтгүй ажиллах журамд шилжих болно” гэсэн үндэслэлийг дэвшүүлжээ.

Товчоор хэлбэл, УИХ нь нэг танхимтай, 75 гишүүнтэй байх, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил, тэдгээрийн тал нь сэлгээгээр гурван жил тутам сонгогдож байхаар заажээ.

2.1.2. Монгол Улсын Их Цааз (Үндсэн хууль)-ын Ард нийтээр хэлэлцүүлсэн дүн болон шинэчилсэн төслийн 21.1-ийн саналын тойм ¹⁹²

Монгол Улсын Их Цааз (Үндсэн хууль)-ыг 1991 оны 06 дугаар сарын 10-аас 1991 оны 09 дүгээр сарын 01-ний хооронд ард нийтээр хэлэлцүүлэх явцад гарсан дүгнэлтийг харгалзан шинэчлэн боловсруулж, 1991 оны 10 дугаар сарын 10-ны өдөр УБХ-д өргөн мэдүүлсэн байна. Ард нийтийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудын 40.8 хувь нь 3 дугаар бүлгийн талаар байжээ.

Шинэчилсэн төслийг УБХ-аар хэлэлцүүлэн “75 гишүүнээс бүрдэнэ” гэсэн үндсэн саналыг зөвшөөрч байгаа дээр санал хураахад олонх нь дэмжсэн байна. Ингээд цөөнхийн саналыг сонсоход дараах саналууд гарч байжээ.

“75” гэдэг тоог цөөн гэж үзэн “100” - “120” гишүүнтэй байхыг дэмжин,

- Намуудын бодлогыг хэрэгжүүлэх боломжгүйн дээр Засгийн газраа парламент дотроо тодорхой хэмжээгээр оруулахын тулд парламентын гишүүдийн тоогоо нэмэх шаардлагатай.
- Эдийн засаг хүнд нөхцөлд 75 гишүүнтэй, байнгын ажиллагаатай парламентыг ажиллуулахад хэцүү тул гишүүдийн тоог Үндсэн хуулиар хуульчлан баталгаажуулах шаардлагагүй, сонгуулийн хуулиар өөрчилж болохоор тусгах. Тухайлбал, “УИХ нь нэг танхимтай байнгын ажиллагаатай байх бөгөөд гишүүний тоо, сонгуулийг зохион байгуулах журмыг хуулиар тогтооно” гэсэн заалт оруулбал цаашид тоон дээр уян хатан байх боломжтой.
- Парламент нь дотроо 14-20 гишүүдээс бүрдсэн байнгын хороодуудтай байна. Үүнээс бага гишүүнтэйгээр байнгын хороо ажиллах боломжгүй. Парламентыг жинхэнэ утгаар нь ажиллуулъя гэвэл 110-120 гишүүнтэй байх шаардлагатай. Хувь тэнцүүлэн хуваарилах зарчмын хувьд мөн 100-аас дээш гишүүнтэй байх шаардлагатай.
- Парламентын гишүүний тоог хүн амын тооноос хамааруулна гэдэг нь хэтэрхий механик ойлголт гэж үзэж байна. Парламентат ёсыг хэрэгжүүлээд төрийн хууль тогтоох дээд байгууллагын хэмжээнд, хөгжингүй орнуудын хэмжээнд ажиллуулъя гэвэл ажлын цар хүрээ, чиг үүрэг, ажил үүргийн хуваарилалт энэ бүгдээс хамааруулж тоогоо тогтоох ёстой зэрэг саналуудыг гаргажээ.

УБХ ийнхүү 1991 оны намрын төслийг албан ёсоор хэлэлцэж, 75 гишүүнтэй байхыг дэмжсэн байна.

¹⁹² Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2016 он.

2.1.3.УБХ-аас АИХ-д өргөн барьсан Монгол Улсын Их Цааз (Үндсэн хууль)-ын төслийн 21.1-ийн саналын тойм

БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат 1991 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр “Их цааз”-ын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, төслийн үзэл баримтлалтай холбогдсон зарчмын гол асуудлын талаар УБХ, Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын дүгнэлтийг АИХ-ын хуралдаан дээр танилцуулсан байна.¹⁹³

Ерөнхийлөгч илтгэлдээ “Их цаазын төсөлд зааснаар УИХ 76 гишүүнээс бүрдэх юм. Энэ тооны хувьд олон янзын санал гарсан бөгөөд дунджаар энэ тоонд бусад саналын агуулга нийцэж байгаа юм. УИХ-ын нэг гишүүн нь 28 мянгаас 30 мянган хүний буюу сонгуулийн нас хүрсэн 14 мянгаас 15 мянга орчим сонгогчийг төлөөлөхөөр байгаа нь дэлхийн улсуудын жишигт дүйж байгаа юм. Та бүхэнд тараасан төсөлд ийнхүү 76 гэсэн тэгш тоо сонгож авсны учир нь нэгдүгээрт, УИХ-ын нийт гишүүний хоёрны нэгийг гурван жил тутам сэлбэн шинэчилж байх, хоёрдугаарт, УИХ-ын дарга, дэд даргын бүрэн эрхийн хугацаа 3 жил байхаар тогтоож байгаатай холбоотой юм...

УИХ-ын гишүүдийн мэргэшсэн чадвар хийгээд хууль тогтоох ажлын залгамжлагдах, шинэчлэгдэх хос чанарыг хангах зорилгоор түүний бүрэлдэхүүнийг 3 жил тутамд өөрчлөн сэлбэж байх зарчмыг сонгон авч төсөлд оруулав. Энэ бол манай парламентын хувьд үнэхээр шинэлэг зүйл бөгөөд уул зарчмыг сонгон авснаар цаашдаа УИХ-ынх бус харин түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил байж, ингэснээр УИХ нь байнга тасралтгүй ажиллах нөхцөл боломжоор хангагдах юм”¹⁹⁴ гэжээ.

УИХ 76 гишүүнээс бүрдэнэ гэдгийг 3 зүйлийг үндэс болгон тогтоосон гэж УБХ-аас тайлбар өгсөн байна. Үүнд:¹⁹⁵

1. Монгол Улсын парламентын шинж чанар, ирээдүйн парламентын байнга ажиллах шинж чанарыг харгалзан төлөөллийн түвшинг дэлхийн жишигтэй харьцуулан, хүн ам цөөнтэй улс орнуудын жишгийг баримталсан. Судалсан орнуудад нэг депутатад ногдож байгаа хүн амын тоо доод талынх нь 20.000, харин дунджаар 90-100 мянгад хүрч байна. Доод захыг нь барьсны учир нь Монгол Улсын өргөн уудам нутаг дэвсгэр, зам харилцааны хөгжил гэсэн хоёр хүчин зүйлийг харгалзаад дэлхийн доод түвшингээр тодорхойлох бодлого барьсан.
2. Түүхэн уламжлалаа барьсан. Монгол Улс эдүгээ хүртэл байнгын парламенттай байгаагүй боловч 1924-1949 он хүртэл Их Хурал (Их Хурал нь депутатуудын хурал байгаагүй)-ын хооронд буюу 1-9 жилийн хугацаанд ганц удаа болдог, ард түмнээ төлөөлөх намын их хурал шиг байжээ. Энэ үед харьцангуй тогтвортой ажиллаж байсан хууль тогтоох дээд байгууллага болох УБХ-ын гишүүдийн 25 жилийн дунджийг авч үзсэн. Эхлээд 30, ганц удаа 100, голдуу 50, 75, 30-аар байсан байна. 76 нь эдгээр тоог дундажлаад гарган авсан тоо.
3. Нэгэнт парламентын хэлбэрийг сонгож авч байгаа учраас парламент ямар ч танхимтай байсан, хэдэн ч танхимтай байсан эдийн засаг талаасаа ерөөсөө энэ хэмжээнээс хэтрэхгүй байх нь зүйтэй гэж үзсэн. Бас авсаархан бүтэцтэй байх нь хүний тооноос гадна асуудлыг шуурхай шийдэх боломжийг нь харгалзсан. Асуудал шийдвэрлэхэд удах тусам зардал их гарна зэрэг 3 үндэслэлээр 76 гэсэн тоон дээр тогтсон.

¹⁹³ Чулуун Г. Улсын Бага Хурлын товчоон (1990-1992). УБ., 2015 он. 173 дахь тал.

¹⁹⁴ Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2016 он. 202 дахь тал.

¹⁹⁵ Улсын Их Хурлын Тамгын газар. Ардын Их Хурлын 1991.12.01-ний өдрийн хуралдааны тэмдэглэл. 66 дахь тал.

Төслийг АИХ-аар хэлэлцүүлэх хэлэлцүүлгийн явцад томоохон өөрчлөлтүүд хийгдсэн бөгөөд үүнд, УИХ-ын бүрэн эрхийн хугацааг 6 жилээс 4 жил болгон өөрчилж, гишүүдийн тоо ба хоёр танхимтай байх эсэх асуудлуудыг авч хэлэлцсэний эцэст нэг танхимтай байхаар тогтжээ.¹⁹⁶

Цөөнхөөс 2 шаттай нэг танхимтай байх (4 санал), эсхүл 2 танхимтай байх (5 санал) саналуудыг гаргаж байжээ. Энэхүү 2 бүтэцтэй парламентын гишүүдийн тооны талаар дараах саналуудыг гаргасан байна:

- 30-55 гишүүнтэй байнгын ажиллагаатай танхим;
- 50-80, 110-150 депутаттай дээд танхимтай байх зэрэг болно.

1991 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар УИХ-ыг 102 гишүүнтэй, нэг танхимтай байгуулах төслийг оруулан, санал хураахад дийлэнх олонхын саналаар ажлын хэсэгт шилжүүлжээ.¹⁹⁷ Энэ нь:

1. Их Хуралд орон нутгийн төлөөллийг баталгаатай байлгах;
2. Ард түмнээ төлөөлөх утгаараа холбоо, хэлхээ нь баталгаатай хэрэгжих чадвартай байх гэсэн 2 зүйл дээр үндэслэжээ. Дэлгэрүүлэн үзвэл,

190 мянгаас доош хүн амтай аймгийн нэг тойрогт 4 Их Хурлын гишүүнтэй, 190 мянгаас дээших нь 6 Их Хурлын гишүүнтэй, Улаанбаатар хотод 20 гишүүн гэж тооцоод нийт 102 гишүүнтэй байх тоог гаргасан байна.

1991 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн АИХ-ын хуралдаан дээр Улс төрийн нам, депутатын бүлгүүдийн ахлагч, депутатын хорооны дарга нарын зөвшилцөөний (Их засаг (Үндсэн хууль)-ийн хоёрдугаар хэлэлцүүлэгт бэлтгэж өөрчлөлт оруулсан зүйл, заалтуудын талаар) протоколыг уншиж танилцуулсан байна.¹⁹⁸ Үүнд:

“Гуравдугаар бүлэг. 21 дүгээр зүйлийн нэгдүгээр заалтыг Улсын Их Хурал нэг танхимтай, 76 гишүүнтэй байна гэж өөрчлөн найруулах” гэжээ.

Гишүүд энэхүү заалтыг хэлэлцэн 1992 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн АИХ-ын хуралдаан дээр Их засаг хууль (Үндсэн хууль)-ийн 21-р зүйлийн 1-ийг зөвшилцөөний протоколд зааснаар буюу “Улсын Их Хурал 76 гишүүнтэй байх”-аар батлахыг хуралд оролцсон нийт гишүүдийн 76 хувь нь зөвшөөрсөн байна.

Ингээд нэг танхимтай, 76 гишүүнтэй, байнгын ажиллагаатай парламенттай байхаар тогтож, үүнээс хойш УИХ-ыг найман удаа бүх нийтийн, шууд, чөлөөт, ардчилсан сонгуулиар байгуулаад байна.

Манай улсын нийт хүн ам 1992 онд 2.1 сая байсан бол 2020 онд 3.2 сая болж **52 хувиар** өссөн байна. Энэ нь:

- 1992 онд УИХ-ын нэг гишүүн **29145 иргэнийг** төлөөлж байсан;
- 2020 онд УИХ-ын нэг гишүүн **44178 иргэнийг** төлөөлөх болсон байна.

Харин сонгуулийн эрх бүхий иргэд 1992 онд УИХ-ын анхны сонгуулийг явуулснаас хойш 2020 он гэхэд **85 хувиар** өссөн байна. Энэ нь:

- 1992 онд УИХ-ын нэг гишүүн **сонгуулийн эрх бүхий 14368 иргэнийг** төлөөлж байсан бол;
- 2020 онд УИХ-ын нэг гишүүн **сонгуулийн эрх бүхий 26368 иргэнийг** төлөөлж байна.

¹⁹⁶ Чулуун Г. Улсын Бага Хурлын товчоон (1990-1992). УБ., 2015 он.

¹⁹⁷ Улсын Их Хурлын Тамгын газар. Ардын Их Хурлын 1991.12.03-ны өдрийн хуралдааны тэмдэглэл. 60, 160 дахь талууд.

¹⁹⁸ Улсын Их Хурлын Тамгын газар. Ардын Их Хурлын 1991.12.27-ны өдрийн хуралдааны тэмдэглэл. 32 дахь талууд.

2.2.2019 онд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх үеэр УИХ-ын бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх тухай гарсан санал¹⁹⁹

2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хурлын нэр бүхий 62 гишүүнээс Үндсэн хуулийн 20 зүйл, 44 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн мэдүүлэхэд Улсын Их Хурлын гишүүдийн тоотой холбоотой зохицуулалт төсөлд тусгагдаагүй байв.

Төслийн анхны хэлэлцүүлгийн дараа Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн 20 зүйл, 49 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, саналыг өргөн мэдүүлсэн бөгөөд уг төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11.3.4-т заасны дагуу саналын түвшинд харгалзан Улсын Их Хурлын 62 гишүүний өргөн мэдүүлсэн төсөлд гаргасан зарчмын зөрүүтэй санал гэж үзэн, хамтатган хэлэлцэж, санал хурааж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 2. УИХ-ын гишүүдийн тоог өөрчлөх саналын томьёолол

УИХ-ын гишүүдийн өргөн мэдүүлсэн төсөл 2019.06.06	Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөл, санал 2019.07.16	Зөвшилцлийн ажлын хэсгээс гарсан саналын томьёолол	Хэлэлцэгдсэн байдал
Хорин нэгдүгээр зүйл			
1.Улсын Их Хурал ... далан зургаан гишүүнтэй байна.			
хөндөөгүй	“Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун найман гишүүнээс бүрдэх бөгөөд тавин дөрвөн гишүүнийг нэг мандат бүхий сонгуулийн тойргоос мажоритар тогтолцоогоор, тавин дөрвөн гишүүнийг сонгуулийн нэгдсэн нэг тойргоос пропорциональ тогтолцоогоор тус тус сонгоно.”	Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “далан зургаан” гэснийг “ерөн есөн” гэж, гэж өөрчлөх	ТБХ- 66.7 хувийн саналаар дэмжигдсэн. Нэгдсэн хуралдаан - Улсын Их хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг аваагүй.

Ингэхдээ УИХ-аас 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдөр 72 дугаар тогтоол баталж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн төсөл, саналыг 62 гишүүний өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй уялдуулах, асуудлыг зөвшилцөх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан, Зөвшилцлийн ажлын хэсгийн даргаар Монгол Улсын Ерөнхийлөгч, бүрэлдэхүүнд нь МАН, АН, бусад намын төлөөллийг тэнцвэртэй оруулсан байна.

Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11.3.4-т зааснаар урьдчилан тогтсон нэг төсөл буюу Улсын Их Хурлын гишүүдийн өргөн мэдүүлсэн төслийг нэгэнт хэлэлцэж эхэлсэн тул Ерөнхийлөгчийн төслийг мөн заалтын **“саналын түвшинд харгалзана”** гэсний дагуу, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 2.4-т заасан агуулга, хязгаарыг баримтлан хэлэлцжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн төсөл, саналд Улсын Их Хурлын гишүүний тоог 108 байхаар санал оруулж ирсэн боловч ажлын хэсгээс уг тоог 99 гэж өөрчлөхөөр Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд санал оруулж, 66.7 хувийн саналаар дэмжсэн боловч, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар нийт гишүүний дөрөвний гурвын олонхын саналаар дэмжигдээгүй байна.

¹⁹⁹ Улсын Их Хурлын Тамгын газар, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтэс, 2022 он.

3. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

3.1. Дэлхийн улс орнуудын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулсан байдал

Судалгаанд дэлхийн 191 улсыг хамруулсан бөгөөд тухайн улсын хүн амын тоог парламентын гишүүний тоонд (үүнд нэг танхимтай парламентын гишүүдийн тоо, хоёр танхимтай парламентын хувьд доод танхимын гишүүдийн тоог баримтлан) харьцуулан гаргав. Эдгээр улс орнуудаас парламент нь нэг танхимтай 109 улс, 2 танхимтай 82 улс байна. Судалгаанд хамрагдсан Судан улсын хувьд 2019 оны 4-р сард төрийн эргэлт гарч Суданы парламентыг тараасны улмаас гишүүдийн тоог гаргах боломжгүй байв.²⁰⁰

Хүн ам цөөнтэй арлын улс орнуудын парламентын гишүүд нь 1000 хүрэхгүй иргэд төлөөлөх тохиолдлууд байхад, хүн ам ихтэй Энэтхэг (2.532.118), АНУ (760.925), Пакистан (645.884), Нигери (572.609) зэрэг орны парламентын гишүүн нь хамгийн олон иргэнийг төлөөлөн ажилладаг байна.

Парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоог авч үзвэл нийт улс орнуудын 66 нь буюу 34.7 хувь нь 100.001-ээс дээш иргэнийг төлөөлөн ажиллаж байна. Парламентын нэг гишүүн нь 40.001-60.000 иргэнийг төлөөлж буй 19 улс байна. **Монгол Улсын Их Хурлын нэг гишүүн нь 44.178 иргэнийг төлөөлж дээрх хэсэгт багтаж байна.**

Монгол Улстай хүн амын тоогоороо ойролцоо (2-5 сая хүн амтай), парламентын засаглалтай 14 улсыг авч үзэхэд 3-5 сая хүн амтай, дунджаар 40.5 мянган иргэнийг төлөөлж буй 7 улс, 2-3 сая хүн амтай, дунджаар 27.0 мянган иргэнийг төлөөлж буй 7 улс байна.

Хүснэгт 3. Хоёроос таван сая хүн амтай, парламентын засаглалтай улс орнуудын парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоо

Парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоо /дунджаар/	Улсын тоо	Хүн амын тоо	Улсын нэр
40.5 мян	7	3-5 сая хүртэл	Босни-Херцеговин, Гүрж, Ирланд, Молдова, Шинэ Зеланд, Хорват
27.0 мян	7	2-3 сая хүртэл	Албани, Армени, Ботсван, Лесото, Словени, Умард Македон, Ямайка

2019 онд Итали улсын парламентын доод танхим нь парламентын 2 танхимын гишүүдийн тоог цөөлөх (Төлөөлөгчдийн танхимын гишүүдийг 630-аас 400 хүртэл, Сенаторуудыг 315-200 хүртэл) хуулийг баталж, Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулсан байна.²⁰¹ Гишүүдийн тоог цөөлснөөр ирэх 10 жилийн хугацаанд гишүүдийн цалин болон бусад зардалд зарцуулагдах ойролцоогоор 1 тэрбум Евро-г улсын төсвөөс хэмнэнэ гэсэн тооцоо гарчээ. Тус шийдвэрийг 2023 оноос хэрэгжүүлж эхлэхээр шийдвэрлэсэн байна.

²⁰⁰ https://data.ipu.org/content/sudan?chamber_id=13530

²⁰¹ https://www.constituteproject.org/constitution/Italy_2020?lang=en

Хүснэгт 4. Парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоо

Парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоо	Улсын тоо	Нийт орноос эзлэх хувь	Улсын нэр
10.000 хүртэл	26	13.6	Андорра, Антигуа ба Барбуда, Барбадос, Бруней Даруссалам, Вануату, Гренада, Доминик, Исланд, Кабо-Верде, Кирибати, Лихтенштайн, Мальдив, Мальта, Маршаллын арлууд, Монако, Монтенегро, Науру, Палау, Самоа, Сан-Марино, Сан-Томе ба Принсипи, Сейшелийн арлууд, Сент-Винсент ба Гренадин, Сент-Китс ба Невис, Тонга, Тувалу
10.001-20.000	22	11.5	Багамын арлууд, Белиз, Бутан, Габон, Гайана, Гвиней-Биссау, Жибути, Кипр, Куба, Латви, Лесото, Литва, Люксембург, Маврики, Сент-Люсия, Соломоны арлууд, Суринам, Фижи, Умард Македон, Экваторын Гвиней, Эсватини, Эстони
20.001-40.000	29	15.2	Албани, Армени, Болгар, Бостван, Грек, Гүрж, Дани, Зүүн Тимор, Ирланд, Коморын арлууд, Конго (БНКУ), Ливи, Мавритани, Микронез, Молдова, Намиби, Норвег, Өмнөд Судан, Серб, Словак, Словени, Солонгос (БНАСУ), Төв Африкийн БНУ, Тринидад ба Тобаго, Уругвай, Финланд, Хорват, Швед, Эритрей
40.001-60.000	19	10	Австри, Бахрейн, Гамби, Доминиканы БНУ, Зимбабве, Лаос, Ливан, Оман, Португал, Румын, Сингапур, Сомали, Сьерра-Леон, Тунис, Туркменистан, Унгар, Швейцар, Шинэ Зеланд, Ямайка
60.001-100.000	29	15.2	Азербайжан, Беларусь, Бельги, Боливи, Босни Херцеговин, Бурунди, Йемен, Израил, Йордан, Итали, Катар, Киргиз, Коста Рика, Кувейт, Либери, Малави, Марокко, Никарагуа, Панам, Папуа-Шинэ Гвиней, Парагвай, Польш, Сири, Того, Уганда, Хаити, Хондурас, Шри-Ланка, Эль Сальвадор
100.001-ээс дээш	66	34.7	Австрали, Алжир, Ангол, АНУ, Арабын НЭУ, Аргентин, Афганистан, Балба, Бангладеш, Бенин, БНХАУ, Бразил, Буркино Фасо, Венесуэл, Вьетнам, Гана, Гватемал, Гвиней, Герман, Египет, Замби, Индонез, Ирак, Иран, Испани, Их Британи, Казахстан, Камбож, Камерун, Канад, Кени, Колумби, Конго (БНАКУ), Кот д'Ивуар, Мадагаскар, Малайз, Мали, Мексик, Мозамбик, Мьянмар, Нижер, Нигери, Нидерланд, ОХУ, Өмнөд Африк, Пакистан, Перу, Руанда, Саудын Араб, Сенегал, Солонгос (БНСУ), Тажикистан, Тайланд, Танзани, Турк, Узбекистан, Филиппин, Франц, Чад, Чех, Чили, Эквадор, Энэтхэг, Этиоп, Япон

Хүснэгт 5. Дэлхийн улсуудын парламентын танхим, гишүүд, хүн амын тоонд харьцуулсан байдал

№	Улсын нэр	Засаглалын хэлбэр	Танхимын тоо	Танхимын нэр, гишүүдийн тоо ²⁰²	Хүн амын тоо ²⁰³	Парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоо
1.	Австрали	Парламентын	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	76 151	25.499.884
2.	Австри	Холимог	2	Холбооны Зөвлөл Үндэсний Зөвлөл	61 183	9.006.398
3.	Азербайжан	Холимог	1	Үндэсний Ассамблей	125	10.139.177
4.	Албани	Парламентын	1	Парламент	140	2.877.797
5.	Алжир	Холимог	2	Үндэсний Зөвлөл Үндэсний Ардын Ассамблей	174 407	43.851.044
6.	Ангол	Холимог	1	Үндэсний Ассамблей	220	32.866.272
7.	Андорра	Парламентын	1	Ерөнхий Зөвлөл	28	77.265
8.	Антигуа ба Барбуда	Парламентын	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	17 18	97.929
9.	АНУ	Ерөнхийлөгчийн	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	100 435	331.002.651
10.	Арабын НЭУ	Хаант	1	Холбооны Үндэсний Зөвлөл	40	9.890.402
11.	Аргентин	Ерөнхийлөгчийн	2	Сенат Депутатуудын танхим	72 257	45.195.774
12.	Армени	Парламентын	1	Үндэсний Ассамблей	107	2.963.243
13.	Афганистан	Ерөнхийлөгчийн	2	Дээд танхим (House of Elders) Доод танхим (House of the People)	102 250	38.928.346
14.	Багамын арлууд	Парламентын	2	Сенат Ассамблейн танхим	16 39	393.244
15.	Балба	Парламентын	2	Үндэсний Ассамблей Төлөөлөгчдийн танхим	59 275	29.136.808
16.	Бангладеш	Парламентын	1	Парламент	350	164.689.383
17.	Барбадос	Парламентын	2	Сенат Ассамблейн танхим	21 30	287.375
18.	Бахрейн	Хаант	2	Зөвлөх Зөвлөл Төлөөлөгчдийн танхим	40 40	1.701.575
19.	Беларусь	Холимог	2	Төрийн зөвлөл Төлөөлөгчдийн танхим	64 110	9.449.323
20.	Белиз	Парламентын	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	13 32	397.628
21.	Бельги	Парламентын	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	60 150	11.589.623
22.	Бенин	Ерөнхийлөгчийн	1	Үндэсний Ассамблей	83	12.123.200
23.	БНХАУ	Коммунист	1	Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурал	3000	1.439.323.776
24.	Болгар	Парламентын	1	Үндэсний Ассамблей	240	6.948.445
25.	Боливи	Ерөнхийлөгчийн	2	Сенат Депутатуудын танхим	36 130	11.673.021
26.	Босни-Херцеговин	Парламентын	2	Ардын танхим Төлөөлөгчдийн танхим	15 42	3.280.819

²⁰² https://data.ipu.org/compare?field=chamber%3A%3Afield_statutory_members_number&structure=any_lower_chamber#map

²⁰³ <https://www.worldometers.info/world-population/population-by-country/>

27.	Ботсван	Парламентын	1	Үндэсний Ассамблей	65	2.351.627	36.178
28.	Бразил	Ерөнхийлөгчийн	2	Холбооны Сенат Депутатуудын танхим	81 513	212.559.417	414.345
29.	Буркина Фасо	Шилжилтийн (Transitional system)	1	Хууль тогтоох Ассамблей	71	20.903.273	294.412
30.	Бруней Даруссалам	Хаант	1	Хууль тогтоох зөвлөл	45	437.479	9721
31.	Бурунди	Ерөнхийлөгчийн	2	Сенат Үндэсний Ассамблей	39 123	11.890.784	96.673
32.	Бутан	Хаант	2	Үндэсний Зөвлөл Үндэсний Ассамблей	25 47	771.608	16.417
33.	Вануату	Парламентын	1	Парламент	52	307.145	5906
34.	Венесуэл	Ерөнхийлөгчийн	1	Үндэсний Ассамблей	167	28.435.940	170.275
35.	Вьетнам	Коммунист	1	Үндэсний Ассамблей	500	97.338.579	194.677
36.	Габон	Холимог	2	Сенат Үндэсний Ассамблей	67 143	2.225.734	15.564
37.	Гайана	Холимог	1	Үндэсний Ассамблей	72	786.552	10.924
38.	Гамби	Ерөнхийлөгчийн	1	Үндэсний Ассамблей	58	2.416.668	41.666
39.	Гана	Ерөнхийлөгчийн	1	Парламент	275	31.072.940	112.992
40.	Гватемал	Ерөнхийлөгчийн	1	Конгресс	160	17.915.568	111.972
41.	Гвиней	Шилжилтийн (Transitional system)	1	Үндэсний Зөвлөл	81	13.132.795	162.133
42.	Гвиней-Бисау	Ерөнхийлөгчийн	1	Үндэсний Ардын Ассамблей	102	1.968.001	19.294
43.	Герман	Парламентын	2	Бундесрат-Холбооны зөвлөл Бундестаг-Холбооны хурал	69 598	83.783.942	140.106
44.	Грек	Парламентын	1	Парламент	300	10.423.054	34.743
45.	Гренада	Парламентын	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	13 15	112.523	7501
46.	Гүрж	Парламентын	1	Парламент	150	3.989.167	26.594
47.	Дани	Парламентын	1	Парламент	179	5.792.202	32.358
48.	Доминик	Парламентын	1	Ассамблейн танхим	32	71.986	2250
49.	Доминиканы БНУ	Ерөнхийлөгчийн	2	Сенат Депутатуудын танхим	32 190	10.847.910	57.094
50.	Египет	Холимог	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	300 596	102.334.404	179.849
51.	Жибути	Холимог	1	Үндэсний Ассамблей	65	988.000	15200
52.	Замби	Холимог	1	Үндэсний Ассамблей	167	18.383.955	110.083
53.	Зимбабве	Холимог	2	Сенат Үндэсний Ассамблей	80 270	14.862.924	55.047
54.	Зүүн Тимор	Парламентын	1	Үндэсний Парламент	65	1.318.445	20.283
55.	Йемен	Шилжилтийн (Transitional system)	2	Зөвлөх Зөвлөл Төлөөлөгчдийн танхим	111 301	29.825.964	99.089
56.	Израил	Парламентын	1	Кнессет	120	8.655.535	72.129
57.	Индонез	Ерөнхийлөгчийн	1	Төлөөлөгчдийн танхим	575	273.523.615	475.693
58.	Йордан	Хаант	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	65 130	10.203.134	78.485
59.	Ирак	Парламентын	1	Төлөөлөгчдийн зөвлөл	329	40.222.493	122.256
60.	Иран	Холимог	1	Исламын Зөвлөх Хурал	290	83.992.949	289.630
61.	Ирланд	Парламентын	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	60 160	4.937.786	30.861
62.	Исланд	Парламентын	1	Парламент	63	341.243	5416
63.	Испани	Парламентын	2	Сенат Депутатуудын Конгресс	265 350	46.754.778	133.585
64.	Итали	Парламентын	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	321 630	60.461.826	95.971
65.	ИБУИНХУ	Парламентын	2	Лордуудын танхим	800		104.440

			Нийтийн танхим	650	67.886.011	
66.	Кабо-Верде	Парламентын	1 Үндэсний Ассамблей	72	555.987	7722
67.	Казахстан	Холимог	2 Сенат	49		
			Төлөөлөгчдийн танхим	107	18.776.707	175.483
68.	Камбож	Парламентын	2 Сенат	62		
			Үндэсний Ассамблей	125	16.718.965	133.751
69.	Камерун	Холимог	2 Сенат	100		
			Үндэсний Ассамблей	180	26.545.863	147.477
70.	Канад	Парламентын	2 Сенат	105		
			Нийтийн танхим	338	37.742.154	111.663
71.	Катар	Хаант	1 Зөвлөх зөвлөл	45	2.881.053	64.023
72.	Кени	Ерөнхийлөгчийн	2 Сенат	68		
			Үндэсний Ассамблей	350	53.771.296	153.632
73.	Кипр	Ерөнхийлөгчийн	1 Төлөөлөгчдийн танхим	80	1.207.359	15.091
74.	Киргиз	Ерөнхийлөгчийн	1 Дээд Зөвлөл	90	6.524.195	72.491
75.	Кирибати	Парламентын	1 Ассамблей	45	119.449	2654
76.	Колумби	Ерөнхийлөгчийн	2 Сенат	108		
			Төлөөлөгчдийн танхим	187	50.882.891	272.101
77.	Коморын арлууд	Холимог	1 Холбооны Ассамблей	24	869.601	36.233
78.	Конго (БНАКУ)	Ерөнхийлөгчийн	2 Сенат	109		
			Үндэсний Ассамблей	500	89.561.403	179.122
79.	Конго (БНКУ)	Холимог	2 Сенат	72		
			Үндэсний Ассамблей	151	5.518.087	36.543
80.	Коста-Рика	Ерөнхийлөгчийн	1 Хууль тогтоох Ассамблей	57	5.094.118	89.370
81.	Кот д'Ивуар	Холимог	2 Сенат	99		
			Үндэсний Ассамблей	255	26.378.274	103.444
82.	Куба	Коммунист	1 Ардын эрхэт Үндэсний Ассамблей	605	11.326.616	18.721
83.	Кувейт	Хаант	1 Үндэсний Ассамблей	65	4.270.571	65.701
84.	Лаос	Коммунист	1 Үндэсний Ассамблей	164	7.275.560	44.363
85.	Латви	Парламентын	1 Парламент	100	1.886.198	18.861
86.	Лесото	Парламентын	2 Сенат	33		
			Үндэсний Ассамблей	122	2.142.249	17.559
87.	Либерии	Ерөнхийлөгчийн	2 Сенат	30		
			Төлөөлөгчдийн танхим	73	5.057.681	69.283
88.	Ливан	Холимог	1 Үндэсний Ассамблей	128	6.825.445	53.323
89.	Ливи	Шилжилтийн (Transitional system)	1 Төлөөлөгчдийн танхим	200	6.871.292	34.356
90.	Литва	Холимог	1 Парламент	141	2.722.289	19.307
91.	Лихтенштайн	Парламентын	1 Диет	25	38.128	1525
92.	Люксембург	Парламентын	1 Депутатуудын танхим	60	625.978	10.432
93.	Маврики	Парламентын	1 Үндэсний Ассамблей	70	1.271.768	18.168
94.	Мавритани	Холимог	1 Үндэсний Ассамблей	157	4.649.658	29.615
95.	Мадагаскар	Холимог	2 Сенат	18		
			Үндэсний Ассамблей	151	27.691.018	183.384
96.	Малави	Ерөнхийлөгчийн	1 Үндэсний Ассамблей	193	19.129.952	99.118
97.	Малайз	Парламентын	2 Сенат	70		
			Төлөөлөгчдийн танхим	221	32.365.999	146.452
98.	Мали	Шилжилтийн (Transitional system)	1 Үндэсний Зөвлөл	121	20.250.833	167.362
99.	Мальдив	Ерөнхийлөгчийн	1 Ардын Хурал	87	540.544	6213
100.	Мальта	Парламентын	1 Төлөөлөгчдийн танхим	65	441.543	6792
101.	Марокко	Хаант	2 Зөвлөхүүдийн танхим	120		
			Төлөөлөгчдийн танхим	395	36.910.560	93.444
102.	Маршаллын арлууд	Ерөнхийлөгчийн	1 Парламент	33	59.190	1793
103.	Мексик	Ерөнхийлөгчийн	2 Сенаторын танхим	128		
			Депутатуудын танхим	500	128.932.753	257.865

104.	Микронез	Ерөнхийлөгчийн	1	Конгресс	14	548.914	39.208
105.	Мозамбик	Холимог	1	Ассамблей	250	31.255.435	125.021
106.	Молдова	Парламентын	1	Парламент	101	4.033.963	39.940
107.	Монако	Парламентын	1	Үндэсний Зөвлөл	24	39.242	1635
108.	Монтенегро	Холимог	1	Парламент	81	628.066	7753
109.	Мьянмар	Холимог	2	Дээд танхим Доод танхим	224 440	54.409.800	123.658
110.	Намиби	Холимог	2	Үндэсний Зөвлөл Үндэсний Ассамблей	42 104	2.540.905	24.431
111.	Науру	Холимог	1	Парламент	19	10.824	569
112.	Нижер	Холимог	1	Үндэсний Ассамблей	171	24.206.644	141.559
113.	Нигери	Ерөнхийлөгчийн	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	109 360	206.139.589	572.609
114.	Нидерланд	Парламентын	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	75 150	17.134.872	114.232
115.	Никарагуа	Ерөнхийлөгчийн	1	Үндэсний Ассамблей	91	6.624.554	72.797
116.	Норвег	Парламентын	1	Парламент	169	5.421.241	32.078
117.	Оман	Хаант	2	Төрийн зөвлөл Зөвлөх зөвлөл	86 86	5.106.626	59.379
118.	ОХУ	Холимог	2	Холбооны Зөвлөл Төрийн Дум	170 450	145.934.462	324.298
119.	Өмнөд Африк	Парламентын	2	Үндэсний зөвлөл Үндэсний Ассамблей	90 400	59.308.690	148.271
120.	Өмнөд Судан	Шилжилтийн (Transitional system)	2	Төрийн зөвлөл Үндэсний хууль тогтоох Ассамблей	100 550	11.193.725	20.352
121.	Пакистан	Парламентын	2	Сенат Үндэсний Ассамблей	100 342	220.892.340	645.884
122.	Палау	Ерөнхийлөгчийн	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	13 16	18.094	1130
123.	Панам	Ерөнхийлөгчийн	1	Үндэсний Ассамблей	71	4.314.767	60.771
124.	Папуа-Шинэ Гвиней	Парламентын	1	Үндэсний Парламент	111	8.947.024	82.153
125.	Парагвай	Ерөнхийлөгчийн	2	Сенат Депутатуудын танхим	45 80	7.132.538	80.603
126.	Перу	Ерөнхийлөгчийн	1	Конгресс	130	32.971.854	253.629
127.	Польш	Холимог	2	Сенат Сейм	100 460	37.846.611	82.275
128.	Португал	Парламентын	1	Бүгд Найрамдах Улсын Ассамблей	230	10.196.709	44.333
129.	Руанда	Холимог	2	Сенат Депутатуудын танхим	26 80	12.952.218	161.902
130.	Румын	Холимог	2	Сенат Депутатуудын танхим	136 330	19.237.691	58.296
131.	Самоа	Парламентын	1	Хууль тогтоох Ассамблей	51	198.414	3890
132.	Сан-Марино	Парламентын	1	Ерөнхий Зөвлөл	60	33.931	565
133.	Сан-Томе ба Принсипи	Холимог	1	Үндэсний Ассамблей	55	219.159	3984
134.	Саудын Араб	Хаант	1	Зөвлөх зөвлөл	151	34.813.871	230.555
135.	Сейшелийн арлууд	Холимог	1	Үндэсний Ассамблей	35	98.347	2809
136.	Сенегал	Холимог	1	Үндэсний Ассамблей	165	16.743.927	101.478
137.	Сент-Винсент ба Гренадин	Парламентын	1	Ассамблейн танхим	22	110.940	5042
138.	Сент-Китс ба Невис	Парламентын	1	Үндэсний Ассамблей	16	53.199	3324
139.	Сент-Люсия	Парламентын	2	Сенат Ассамблей	11 18	183.627	10.201
140.	Серби	Парламентын	1	Үндэсний Ассамблей	250	8.737.371	34.949

141.	Сингапур	Холимог	1	Парламент	104	5.850.342	56.253
142.	Сири	Шилжилтийн (Transitional system)	1	Ардын Хурал	250	17.500.658	70.002
143.	Словак	Парламентын	1	Үндэсний Зөвлөл	150	5.459.642	36.397
144.	Словени	Парламентын	2	Үндэсний Зөвлөл Үндэсний Ассамблей	40 90	2.078.938	23.099
145.	Соломоны арлууд	Парламентын	1	Үндэсний Парламент	50	686.884	13.737
146.	Солонгос (БНАСУ)	Коммунист	1	Ардын Их Хурал	687	25.778.816	37.523
147.	Солонгос (БНСУ)	Ерөнхийлөгчийн	1	Үндэсний Ассамблей	300	51.269.185	170.897
148.	Сомали	Холимог	2	Дээд танхим Ард түмний танхим	54 275	15.893.222	57.793
149.	Судан		2	Төрийн зөвлөл Үндэсний Ассамблей (2019 оны 4-р сард төрийн эргэлт хийж Суданы парламентыг тараасан байна.)	- -	43.849.260	- -
150.	Суринам	Ерөнхийлөгчийн	1	Үндэсний Ассамблей	51	586.632	11.502
151.	Сьерра Леон	Холимог	1	Парламент	146	7.976.983	54.636
152.	Тажикистан	Ерөнхийлөгчийн	2	Үндэсний Ассамблей Төлөөлөгчдийн танхим	33 63	9.537.645	151.391
153.	Тайланд	Парламентын	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	250 500	69.799.978	139.599
154.	Танзани	Ерөнхийлөгчийн	1	Үндэсний Ассамблей	393	59.734.218	151.995
155.	Того	Холимог	1	Үндэсний Ассамблей	91	8,278,724	90.974
156.	Тонга	Хаант	1	Хууль тогтоох Ассамблей	30	105,695	3523
157.	Төв Африкийн БНУ	Холимог	1	Үндэсний Ассамблей	140	4.829.767	34.498
158.	Тринидад ба Тобаго	Парламентын	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	32 42	1.399.488	33.321
159.	Тувалу	Парламентын	1	Парламент	16	11.792	737
160.	Тунис	Холимог	1	Ард түмний Төлөөлөгчдийн танхим	217	11.818.619	54.463
161.	Турк	Холимог	1	Үндэсний Их Хурал	600	84.339.067	140.565
162.	Туркменистан	Ерөнхийлөгчийн	2	Ард түмний Зөвлөл Ассамблей	56 125	6.031.200	48.249
163.	Уганда	Ерөнхийлөгчийн	1	Парламент	529	45.741.007	86.466
164.	Узбекистан	Холимог	2	Сенат Хууль тогтоох танхим	100 150	33.469.203	223.128
165.	Унгар	Парламентын	1	Үндэсний Ассамблей	199	9.660.351	48.544
166.	Уругвай	Ерөнхийлөгчийн	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	31 99	3.473.730	35.088
167.	Фижи	Парламентын	1	Парламент	51	896.445	17.577
168.	Филиппин	Ерөнхийлөгчийн	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	24 304	109.581.078	360.464
169.	Финланд	Парламентын	1	Парламент	200	5.540.720	27.703
170.	Франц	Холимог	2	Сенат Үндэсний Ассамблей	348 577	65.273.511	113.125
171.	Хаити	Ерөнхийлөгчийн	2	Сенат Депутатуудын танхим	30 119	11.402.528	95.819
172.	Умард Македон	Парламентын	1	Ассамблей	123	2.083.374	16.938
173.	Хондурас	Ерөнхийлөгчийн	1	Үндэсний Конгресс	128	9.904.607	77.379
174.	Хорват	Парламентын	1	Парламент	151	4.105.267	27.187
175.	Чад	Шилжилтийн (Transitional system)	1	Үндэсний Зөвлөл	93	16.425.864	176.622
176.	Чех	Парламентын	2	Сенат Депутатуудын танхим	81 200	10.708.981	132.209

177.	Чили	Ерөнхийлөгчийн	2	Сенат Депутатуудын танхим	50 155	19.116.201	123.330
178.	Швед	Парламентын	1	Парламент	349	10.099.265	28.937
179.	Швейцар	Парламентын	2	Төрийн зөвлөл Үндэсний зөвлөл	46 200	8.654.622	43.273
180.	Шинэ Зеланд	Парламентын	1	Төлөөлөгчдийн танхим	120	4.822.233	40.185
181.	Шри Ланка	Холимог	1	Парламент	225	21.413.249	95.169
182.	Эквадор	Ерөнхийлөгчийн	1	Үндэсний Ассамблей	137	17.643.054	128.781
183.	Экваторын Гвиней	Холимог	2	Сенат Депутатуудын танхим	70 100	1.402.985	14.029
184.	Эль Сальвадор	Ерөнхийлөгчийн	1	Хууль тогтоох Ассамблей	84	6.486.205	77.216
185.	Энэтхэг	Парламентын	2	Муж улсуудын зөвлөл Ардын танхим	245 545	1.380.004.385	2.532.118
186.	Эритрей	Ерөнхийлөгчийн	1	Үндэсний Ассамблей	150	3.546.421	23.642
187.	Эсватини	Хаант	2	Сенат Ассамблейн танхим	30 70	1.160.164	16.573
188.	Эстони	Парламентын	1	Парламент	101	1.326.535	13.134
189.	Этиоп	Парламентын	2	Холбооны танхим Ардын Төлөөлөгчдийн танхим	153 547	114.963.588	210.171
190.	Ямайка	Парламентын	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	21 63	2.961.167	47.002
191.	Япон	Парламентын	2	Зөвлөхүүдийн танхим Төлөөлөгчдийн танхим	248 465	126.476.461	271.992

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Лүндээжанцан Д. Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2014 он.
- Чулуун Г. Улсын Бага Хурлын товчоон (1990-1992). УБ., 2015 он.
- Олон Улсын парламентын холбооны цахим хуудас. Data on parliaments:
https://data.ipu.org/compare?field=chamber%3A%3Afield_statutory_members_number&structure=any__lower_chamber#map
- Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2016 он.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Унитар улсуудын парламентын болон орон нутгийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаа, парламентын гишүүдийн тоог тогтоох жишиг. СТ-11/225. Судалгааны эмхэтгэл, Боть 12. УБ., 2011 он.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Дэлхийн улс орнуудын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулсан байдал болон холбооны улсуудын парламентын танхимын тоо. СТ-15/210. Судалгааны эмхэтгэл, Боть 20. УБ., 2015 он.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Төлөөллийн эрх мэдлийн байгууллагын төлөөллийн тоог тогтоох, тооцох зарчмын талаарх лавлагаа (куб язгуурын томьёо). СТ-19/418. Судалгааны эмхэтгэл, Боть 29. УБ., 2019 он.
- Улсын Их Хурлын Тамгын газар, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтэс, 2022 он.
- Итали Улсын Үндсэн хууль.
https://www.constituteproject.org/constitution/Italy_2020?lang=en

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН
СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО**

(Тойм судалгаа)

Д.Халиун

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

**ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН СОНГУУЛИЙН
ТОГТОЛЦОО**

1.ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ

- 1.1.БНМАУ-ын Ардын Их Хурлын сонгуулийн тойм
- 1.2.Үндсэн хуулийг шинэчлэх болсон хүчин зүйлүүд (1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэх үеийн санал)
- 1.3.Өнөөгийн нөхцөл байдал буюу 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- 1.4.Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны талаар Үндсэн хуулийн цэц дээр үүссэн маргаан
 - 1.4.1.Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргаан /Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлт/
 - 1.4.2.Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргаан /Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар шийдвэр/
- 1.5.1992 оны Үндсэн хууль батлагдсаны дараах улс төрийн үйл явц

2.ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

- 2.1.Ардчилсан сонгуулийн үндсэн зарчмууд
 - 2.1.1.Дэлхийн зарим улс орнуудын парламентын сонгуулийн шууд зарчим
- 2.2.Сонгуулийн тогтолцоо, ангилал
 - 2.2.1.Сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо
 - 2.2.2.Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо бүхий зарим улс орны эрх зүйн зохицуулалт
 - 2.2.3.Зарим улс орнууд дахь сонгуулийн холимог тогтолцооны эрх зүйн зохицуулалт
- 2.3.Дэлхийн улс орнуудын сонгуулийн тогтолцоо
 - 2.3.1.Сонгуулийн тогтолцоог Үндсэн хуульдаа тусгасан орнууд
- 2.4.Ротацын журмаар парламентын гишүүдийг сэлгэдэг зарим орны туршлага

ХАВСРАЛТУУД

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. БНМАУ-ын Ардын Их Хурлын ээлжит сонгууль явагдсан он дараалал
- Хүснэгт 2. БНМАУ-ын сум, хороо, район, орон нутгийн хотын АДХ-ын сонгууль явагдсан он, дараалал
- Хүснэгт 3. УИХ-ын сонгуулиудын тогтолцоо, тэдгээрийн давуу болон сул тал
- Хүснэгт 4. Үндсэн хуулиар парламентын гишүүдийг шууд сонгох болон сонгуулийн тогтолцоог тогтоосон байдал
- Хүснэгт 5. Парламентын гишүүдийн сонгуулийн шууд зарчим, засаглалын хэлбэрээр
- Хүснэгт 6. Парламентын гишүүдийн сонгуулийн зарчимтай холбоотой гадаадын зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт
- Хүснэгт 7. Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоо (парламентын нэг танхимт болон доод танхимуудын хувьд)
- Хүснэгт 8. Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоо, засаглалын хэлбэрээр
- Хүснэгт 9. Үндсэн хуульдаа парламентын сонгуулийн тогтолцоог тогтоосон орнуудын жагсаалт
- Хүснэгт 10. Сонгуулийн хүчин зүйлийн нөлөөлөл
- Хүснэгт 11. Ротацын журмаар парламентын гишүүдийг сэлгэдэг улсын тоо, эзлэх хувь, засаглалын хэлбэрээр
- Хүснэгт 12. Ротацын журмаар парламентын гишүүдийг сэлгэдэг туршлага

СУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. БНМАУ-ын сонгуулийн шинэ систем (1949-1990 он)
- Зураг 2. Сонгуулийн тогтолцооны төрөл, хэлбэрүүд
- Зураг 3. Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоо

ХАВСРАЛТУУД

- Хавсралт 1. Монгол Улсын Үндсэн хууль (1992 он) ба Монгол Улсын их цаазын төслүүдийн (1991.VI.05, X.05, XI.07) харьцуулалт
- Хавсралт 2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүнгийн статистик мэдээлэл /1992-2020 он/
- Хавсралт 3. УИХ-ын сонгуулийн тогтолцооны эрх зүйн зохицуулалт
- Хавсралт 4. Сонгуулийн холимог болон хувь тэнцүүлэх тогтолцоо бүхий орнуудын судалгаа
- Хавсралт 5. Дэлхийн улс орнуудын нэг танхимт болон парламентын доод танхимуудын сонгуулийн тогтолцоо

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Өмнөх ба одоогийн Үндсэн хуулийн зохицуулалт: Монгол Улсын түүхэнд 1924, 1940, 1960 онуудад Үндсэн хууль батлагдаж байсан бөгөөд дөрөв дэх нь 1992 оны ардчилсан шинэ Үндсэн хууль юм. 1990 оны 3 дугаар сард БНМАУ-ын Ардын Их Хурлаас “БНМАУ-ын төрийн дээд байгууллагын бүтцийн тухай” тогтоол гаргаж улмаар 1960 оны Үндсэн хуульд 1990 оны 5 дугаар сард нэмэлт оруулсан нь парламентыг байгуулах, олон намын оролцоотой сонгууль явуулах, шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулах асуудлыг багтаажээ.

Шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэн батлах явцад нийт 5 удаа төсөл өөрчлөгдөж байсан. 1991 оны 05 ба 06 дугаар сард боловсруулсан төслүүдийг Чингис хааны хуулийн нэрээр “Их цааз” гэж нэрлэжээ. Уг төсөлд Улсын Их Хурал нь нэг танхимтай байх, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил, тэдгээрийн тал нь сэлгээ маягаар гурван жил тутам сонгогдож байхаар заажээ.

Ардын Их Хурлын хэлэлцүүлгийн явцад улс төрийн тогтолцоонд томоохон үр дагавартай зарим өөрчлөлтийг хийжээ. Үүнд: Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацааг 6 жилээс 4 жил болгон өөрчилж, гишүүдийн тоо ба мөн хоёр танхимтай байх эсэх асуудлыг авч хэлэлцсэний эцэст нэг танхимтай байхаар тогтжээ. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дөрөв, эсхүл зургаан жил байхаас үл хамааран бүрэн эрхийн хугацаанд гишүүдэд сэлгээ хийх сонгуулийн системээс татгалзсан.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиар Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтоохоор заасан. Үүнээс хойш 1992, 2005, 2011, 2015, 2019 онуудад Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг шинэчлэн баталсан, харин сонгуулийн тогтолцоог 1992, 1996, 2008, 2012, 2015, 2016, 2019 онуудад тус тус өөрчилж байсан буюу сонгууль бүрийн өмнө өөрчилж иржээ. Ердөө 2000, 2004 оны УИХ-ын сонгуулийн өмнө сонгуулийн тогтолцоог өөрчлөөгүй байна. 1992 оноос хойш явагдсан Улсын Их Хурлын 8 удаагийн сонгуулийн тогтолцооны өөрчлөлтүүдээс харахад мажоритар тогтолцооны хувилбаруудыг голлон хэрэглэж, нэг мандаттай, эсхүл олон мандаттай хувилбарууд болон 48/28 гэсэн мажоритар давамгайлсан зэрэгцээ тогтолцоог туршиж байсан.

Иймд сонгууль явуулах эрх зүйн орчныг тогтвортой байх нөхцөлийг хангахын тулд ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хориглосон.

Олон улсын туршлага:

Сонгуулийн тогтолцоо, ангилал: Сонгуулийн тогтолцоо (буюу санал хураах тогтолцоо) гэдэг нь сонгогч тодорхой хувилбаруудаас өөрийн сонголтыг хийхтэй холбогдсон харилцаа юм. Сонгуулийн тогтолцоо нь санал хураах, санал тоолох, эцсийн дүнг нэгтгэн тооцох дүрэм журмыг өөртөө агуулж байдаг. Сонгуулийн тогтолцоог судалдаг онолыг *сонгуулийн эрх зүй* гэж хэлбэр талаас нь тодорхойлж болох бөгөөд түүний цаана улс төр судлал, эдийн засаг, математикийн агуулга оршиж байдаг.

Сонгуулийн саналын агуулга, тойргийн хэмжээ, санал хураалтын дүнг мандатад шилжүүлэн тооцох журам, саналаа тухайлсан нэр дэвшигчийн төлөө, эсхүл түүнийг хамруулж байгаа нам, эвсэл (нэрсийн жагсаалт)-ийн төлөө өгөх зэрэг хувьсах чанартай үзүүлэлтүүдийг харгалзан сонгуулийн тогтолцоог дор дурдсанаар ангилна.

Дэлхийн улс орнуудад сонгуулийн тогтолцооны гол гурван ангилал үйлчилж байгаа бөгөөд тэдгээр нь дотроо олон хувилбартай байгаа юм. Үүнийг хялбарчлан сонгуулийн *олонхыг төлөөлөх тогтолцоо*, сонгуулийн *хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо*, сонгуулийн

болохооргүй үл шилжих нэг саналын, хязгаарлагдмал саналын, саналыг дугаарлаж өгөх Бордогийн тооцооны арга гэсэн сонгуулийн тогтолцооны ангилал бас байдаг.

Олонхыг төлөөлөх буюу мажоритар тогтолцоо: Тодорхой нэр дэвшигчээр дамжуулан сонгуулиар эрх барих байгууллагыг бүрдүүлдэг тогтолцоог олонхыг төлөөлөх тогтолцоо гэнэ.

Энэ тогтолцоо нь харьцангуй олонхын, багц саналын, намын багц саналын, дараалал тогтоож саналаа өгөх альтернатив саналын, хоёр шатлалтай саналын гэх мэт хувилбаруудтай. Сонгогчдын олонхын санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцогдох бөгөөд туйлын олонх (50+1), харьцангуй олонх (хамгийн олон санал авсан), дийлэнх (2/3) болон үнэмлэхүй олонх (3/4)-ийн саналаар сонгогдох гэж ангилдаг.

Хувь тэнцүүлэн хуваарилах буюу пропорционал тогтолцоо: Нам эвслийн төлөөллөөр дамжуулан сонгуулиар эрх барих байгууллагыг бүрдүүлдэг тогтолцоог хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо гэнэ. Нам эвслийн авсан саналын хувьтай мандатын тоо нь уялдаж байх ёстой. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо нь жагсаалт (нээлттэй ба хаалттай)-ын, шилжих бололцоотой нэг саналын гэх мэт олон хувилбартай. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоонд:

- нам эвслүүдэд суудал хуваарилах тооцоо нь давуу тал олонтой ч зарим талаар хүндрэлтэй;
- ихэнх тохиолдолд сонгуулийн босго тогтоох замаар суудлыг хуваарилдаг;
- сонгуулийн босгыг ихэнхдээ тухайн тойрог/улсын хэмжээнд/-ийн сонгуулийн хүчинтэй саналын тоог мандатын тоонд харьцуулж тодорхойлдог;
- намын нэрийн жагсаалтаас хэдэн хүнд мандат хуваарилагдах вэ гэдэг нь босго саналын тоо тухайн намын авсан саналын тоонд хэд дахин багтаж байгаагаар илэрхийлэгдэнэ;
- үлдэгдэл саналыг хэрхэн хуваарилах нь маш чухал асуудал.

Холимог тогтолцоо: Олонхыг төлөөлөх, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны аль алиных нь шинжийг агуулдаг. Энэхүү тогтолцоог *холимог хувь тэнцүүлсэн, зэрэгцээ* (параллел) гэж ангилж болно.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд сонгогчдын өгсөн нэг саналаар хоёр өөр тогтолцооны суудал хуваарилах аргыг хэрэглэдгээрээ онцлог юм. Зэрэгцээ (параллел) саналын арга нь сонгогч олонхыг төлөөлөх хэсэгт 1 санал, хувь тэнцүүлэн хуваарилах хэсэгт нэг санал өгдгөөрөө ялгаатай.

Сонгуулийн янз бүрийн тогтолцооны эцсийн үр дүн нь олон янз байж болох бөгөөд ялангуяа илэрхий олонх байхгүй тохиолдолд бүр ч илүү мэдрэгддэг. Иймээс сонгуулийн тогтолцоог сонгохдоо хэлбэр талаас нь биш агуулгаар нь авч үзэхийг онолын талаас нь шаардах болжээ.

ЭЕРЭГ ТАЛ	СӨРӨГ ТАЛ
Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны хувьд	
<ul style="list-style-type: none"> • Парламент олон нам суудал авах нөхцөл бүрдүүлнэ. • Аливаа үзэл бодол, үнэт зүйл нэг танхимд хэлэлцэгдэх боломж бүрдүүлнэ. • Зөвхөн бус нутгийн бус улс орны нийтлэг эрх ашгийг илэрхийлэх үзэл санааны мэтгэлцээн парламентад өрнөх. • Төсөв, хөрөнгө оновчтой хуваарилагдах боломжтой. 	<ul style="list-style-type: none"> • Хэт олон нам цөөн суудал авч Засгийн газар байгуулах олонхыг бүрдүүлэхэд бэрхшээл тулгарч, хугацаа алдах. • Хариуцлага хүлээх чадамж нам, эвслийн дунд тарамдах. • Зах хязгаар нутгийн хөгжилд тавих анхаарал сулрах.

Холимог тогтолцооны хувьд

- | | |
|--|---|
| <ul style="list-style-type: none"> Олонхыг төлөөлөх, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны давуу талуудыг товчлох, дутагдалтай талуудыг хязгаарлах бололцоо бүрдүүлнэ. Том улсуудад болон үндэсний асуудал тавигддаг улсуудад тохиромжтой. | <ul style="list-style-type: none"> Бүс нутгийн болон үндэсний хэмжээний асуудлын зааг ялгарч, Парламентад өөр өөр ашиг сонирхол зөрчилдөх магадлалтай. |
|--|---|

Парламентын сонгуулийн үндсэн зарчмыг тогтоосон гол эх сурвалж нь тухайн улсын Үндсэн хууль байдаг. Тэр дундаа сонгуулийн тогтолцооны талаар гадаад орнуудын Үндсэн хуулиар зохицуулсан хэм хэмжээ нь харилцан адилгүй байдаг. Гэхдээ сонгуулийн талаарх илүү нарийвчилсан зохицуулалтыг хууль тогтоох байгууллагаас баталсан сонгуулийн тухай хууль, эсхүл хууль тогтоох байгууллагын танхимаас баталсан регламентуудаар тогтоодог.

Судалгаанаас үзэхэд дэлхийн 83 улсын Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог тодорхой заасан байна. Үүнд, олонхыг төлөөлөх тогтолцоотой 34 улс, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой 34 улс, холимог тогтолцоотой 15 улс тус тус орсон байна.

Сонгуулийн тогтолцоог Үндсэн хуульд тусгах нь сонгуулийн тогтолцоо тогтвортой байх боломж хангагдаж, энэ нь ард түмний төлөөлөх чадамжийг хангасан тогтолцоог бий болгох, парламентын төлөвшил, намуудын төлөвшилд эерэг нөлөөлж, ардчилсан засаглалыг бэхжүүлэх, сонгогчдод сонгуулийн журам тогтвортой ойлгомжтой байх зэрэг ач холбогдолтой юм.

Дэлхийн улс орнуудын сонгуулийн тогтолцоо: Дэлхийн 192 улсын парламентуудын хувьд (нэг танхимт парламент болон доод танхимууд) дараах сонгуулийн тогтолцоог хэрэглэж байна:²⁰⁴

- Сонгуулийн холимог тогтолцоотой – 32 улс (16.7%);
- Олонхыг төлөөлөх тогтолцоотой – 65 улс (34.8%);
- Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой – 77 улс (41.1%);
- Бусад – 6 улс (3.2%);
- Шууд сонгууль явуулдаггүй – 7 улс (3.7%)
- Мэдээлэл байхгүй – 5 улс байна.

Парламентын сонгуулийн шууд зарчмын хувьд: Парламентын сонгуулийн шууд зарчимтай холбоотой зохицуулалтыг 55 улсын Үндсэн хуулийн хүрээнд судалж үзэхэд 8 улс (Исланд, Замби, Лаос, Мьянмар, Непал, Турк, Эритрей, Япон)-аас бусад 47 улс Парламентын гишүүдийг шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгоно гэж Үндсэн хуульдаа тусгасан байна. Мөн 10 улс сонгуулийн зарчмаа шууд гэж заагаад сонгуулийн тогтолцоогоо тодорхой зааж өгсөн байна. Үүнд:

- *Пропорционал тогтолцоотой гэж:* Армени, Австри, Финланд, Латви, Люксембург, Намиби, Польш, Руанда, Уругвай;
- *Мажоритар тогтолцоотой гэж:* Азербайжан Улс заасан байна.

Ер нь аль ч улс оронд сонгуулийн зарчим нь бүх нийтийн, чөлөөтэй, тэгш, шууд, саналаа нууцаар гаргана гэсэн байх бөгөөд зарим улсад эдгээр зарчмын аль нэг нь байхгүй, эсхүл заавал санал өгөх зарчмыг нэмж тусгадаг байна. Сонгуулийн талаарх онолын үүднээс авч үзвэл, шууд сонгох эрх нь *сонгогч ямар нэг төлөөллөөр дамжуулахгүйгээр өөрөө саналаа өгөх* гэж ойлгодог байна.

²⁰⁴ Олон улсын парламентын холбоо (IPU)-ын мэдээллийн сан, <https://data.ipu.org/content/list-comparative-fields>

Ротацын журмаар парламентын гишүүдийг сэлгэх талаар: Судалгаанд авагдсан 60 улсаас нийт 14 улс парламентын гишүүдийг Ротацын журмаар шинэчилдэг ба эдгээрээс парламентын засаглалтай - 4 улс, ерөнхийлөгчийн засаглалтай - 5 улс, холимог засаглалтай - 5 улс байна. Судалгаанд авагдсан улсуудын хувьд 2 танхимтай улсуудын дээд танхимуудад Ротацын журам түгээмэл хэрэглэгдэж байна. Судалгаанд нэг танхимт парламент бүхий – 33 улс, парламентын 2 танхимтай – 27 улс хамрагдсанаас 14 улсын парламентын дээд танхим буюу хоёр танхим парламентуудын 52% нь Ротацын журмаар шинэчлэгддэг бол зөвхөн Аргентин Улсад парламентын дээд болон доод танхимын гишүүд нь Ротацын журмаар шинэчлэгддэг байна.

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

1.ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ

Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоотой холбоотойгоор Үндсэн хуулийг зөрчсөн талаарх маргаан, шүүмжлэл удаа дараа гарч, ээлжит сонгууль бүрийн өмнө сонгуулийн хуулийг өөрчлөх замаар тодорхойгүй, тогтворгүй байдал бий болгосоор ирсэн.

Ер нь сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнийг шинэчлэн найруулах болгонд сонгуулийн тогтолцооны хувилбаруудыг хөндөж, өөрчилж байсан. 1992 оноос хойш явагдсан Улсын Их Хурлын 8 удаагийн сонгуулийн тогтолцооны өөрчлөлтүүдээс харахад мажоритар тогтолцооны хувилбаруудыг голлон хэрэглэж, нэг мандаттай, эсхүл олон мандаттай хувилбарууд болон 48/28 гэсэн мажоритар давамгайлсан зэрэгцээ тогтолцоог туршиж байсан.

1.1.БНМАУ-ын Ардын Их Хурлын сонгуулийн тойм²⁰⁵

1949 онд хуралдсан Улсын IX Их Хурал Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1940 оны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар төрийн байгууллагуудын сонгуулийн системийг бүх нийтийн тэгш, шууд, саналаа нууцаар гаргаж сонгох шинэ систем болгон тогтоожээ.

Энэхүү системийн дагуу 1951 оны 06 дугаар сарын 10-ны өдөр БНМАУ-ын Улсын Их Хурлыг (1960 оны Үндсэн хууль үйлчлэх хүртэл Улсын Их Хурал гэж нэрлэж байсан) сонгох анхдугаар удаагийн сонгууль явагдсан.


Үүнээс өмнө баг²⁰⁶, хорины хөдөлмөрчдийн хурлаас сум, хорооны Хурлын төлөөлөгчдийг, түүнээс аймаг, хотынхныг сонгосны дараа Улсын Их Хурлыг аймаг, хотын бага хурлаас төлөөлөгчдийг сонгох журмаар шатлан байгуулж байсан бол 1951 оноос хойш шинэ системээр бүх шатны Хурлыг нийт иргэд, сонгогчдоос шууд сонгох тогтолцоонд шилжжээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

²⁰⁵ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2015 он). *БНМАУ-ын Ардын Их Хурлын сонгуультай холбоотой лавлагаа*. УБ: Судалгааны эмхэтгэл XXI боть, СТ-15/415.

²⁰⁶ 1959 оны 8 дугаар сард багийг татан буулгаснаар сум, хороо нь орон нутгийн анхан шатны нэгж болов.

Зураг 1. БНМАУ-ын сонгуулийн шинэ систем (1949-1990 он)



1960 оны Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийн 18 дугаар зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн эрхийг барих дээд газар нь Ардын Их Хурал (цаашид “АИХ” гэх) мөн. БНМАУ-ын АИХ, түүний байгууллагуудын журмыг БНМАУ-ын Үндсэн хуульд нийцүүлж гаргасан БНМАУ-ын АИХ-ын регламент болон бусад хуулиар тодорхойлно.” хэмээн хуульчилсан байна.

АИХ-ын анхдугаар сонгууль 1951 онд явагдсанаас хойш 1990 оныг дуустал АИХ-ын нийт 12 удаагийн сонгууль зохион байгуулагдсан байна.

1960 оны Үндсэн хуульд АИХ-ыг бүх нийтийн, тэгш, шууд сонгуулийн эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах замаар тус улсын 18 нас хүрсэн бүх иргэн сонгох ба 5 жилийн хугацаагаар сонгоно гэж заасан байдаг ч сонгууль ихэвчлэн 3-5 жилийн давтамжтай явагдсан байна.

1960 оны Үндсэн хуулийн 3 дугаар бүлэгт БНМАУ-ын АИХ-д тус аймгийн харьяалалтай хороо, аймгийн төвөөс бусад орон нутгийн хот бүрээс нэг, аймгийн төвийн болон улсын харьяалалтай хотын 10.000 хүн ам тутмаас 1 депутат тус тус сонгох ба АИХ-ын бүрэн эрхийн хугацаа 5 жил байхаар хуульчилсан байна. Мөн АИХ-ын ээлжит чуулганыг жилд нэг удаа хийх бөгөөд АИХ-ын Тэргүүлэгчдийн санаачилгаар, эсхүл депутатуудын гуравны нэгээс доошгүй нь шаардвал АИХ-ын ээлжит бус чуулганыг хийдэг байжээ.

Хүснэгт 1. БНМАУ-ын Ардын Их Хурлын ээлжит сонгууль явагдсан он дараалал

АИХ-ын ээлжит сонгууль	Сонгууль явагдсан он	Бүрэн эрхийн хугацаа
1 дэх удаагийн	1951	3 жил
2 дахь удаагийн	1954	3 жил
3 дахь удаагийн	1957	3 жил
4 дэх удаагийн	1960	3 жил
5 дахь удаагийн	1963	3 жил
6 дахь удаагийн	1966	3 жил
7 дахь удаагийн	1969	4 жил
8 дахь удаагийн	1973	4 жил
9 дэх удаагийн	1977	4 жил
10 дахь удаагийн	1981	5 жил
11 дэх удаагийн	1986	5 жил
12 дахь удаагийн	1990	2 жил болоод 1992 оны Үндсэн хуулийн дагуу үйл ажиллагаа нь зогссон.

БНМАУ-ын Ардын Депутатуудын Хурал (цаашид “АДХ” гэх)-ууд эрх хэмжээ, үйлчлэх нутаг дэвсгэр үйл ажиллагааныхаа шинжээр бие биенээсээ ялгаатай. Үүний үндсэн дээр АДХ-ууд 2 хэсэгт хуваагдана. Нэгдүгээр хэсэгт дээр дурдсан төрийн эрх барих ардын төлөөлөгчдийн дээд байгууллага болох БНМАУ-ын АИХ, хоёрдугаар хэсэгт төрийн эрх барих ардын төлөөлөгчдийн орон нутгийн байгууллагууд болох аймаг, хот, район, сум, хороодын ардын депутатуудын хурлууд хамаарна.

Орон нутгийн АДХ-ын сонгууль анх 1952 оны 10 дугаар сарын 19-нд шинэ сонгуулийн үндсэн дээр анх удаа БНМАУ-ын аймаг, хот, сум, хороо, баг, хорины Ардын хурлын депутатуудыг сонгох сонгууль явагдсан. Орон нутгийн ардын хурлын депутатуудыг сонгох 16 удаагийн сонгууль болсон байна.

Хүснэгт 2. БНМАУ-ын сум, хороо, район, орон нутгийн хотын АДХ-ын сонгууль явагдсан он, дараалал

Орон нутгийн АДХ-ын ээлжит сонгууль	Сонгууль явагдсан он	Бүрэн эрхийн хугацаа
1 дэх удаагийн	1952	2 жил
2 дахь удаагийн	1954	2 жил
3 дахь удаагийн	1956	3 жил
4 дэх удаагийн	1959	2 жил
5 дахь удаагийн	1961	2 жил
6 дахь удаагийн	1963	2 жил
7 дахь удаагийн	1965	2 жил
8 дахь удаагийн	1967	2 жил
9 дэх удаагийн	1969	3 жил
10 дахь удаагийн	1972	3 жил
11 дэх удаагийн	1975	3 жил
12 дахь удаагийн	1978	3 жил
13 дахь удаагийн	1981	3 жил
14 дахь удаагийн	1984	3 жил
15 дахь удаагийн	1987	3 жил
16 дахь удаагийн	1990	АИХ-ын сонгуультай хамт явагдсан.

БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн дагуу АИХ-ыг 5 жилийн хугацаагаар, орон нутгийн АДХ-ыг 3 жилийн хугацаагаар сонгохоор хуульчилсан боловч сонгууль энэ хугацаанд явагдаагүй зарим тохиолдол байна. Тухайлбал, 1952-1967 онуудад 2 жилийн давтамжтай явагджээ.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1969 оны 144 дүгээр зарлигаар АИХ-ыг 4 жилийн хугацаагаар орон нутгийн АДХ-ыг 3 жилийн хугацаагаар сонгож байхаар тогтоожээ.

1990 оны 3 дугаар сард АИХ БНМАУ-ын Үндсэн хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулж 05 дугаар сарын 10-ны өдрийн АИХ-ын чуулганаар сонгуулийн хууль баталсан нь Монголд парламентын чөлөөт сонгууль явуулах анхны алхам болсон. Анх удаагаа олон нам оролцсон сонгууль болсон нь ардчиллын үндсийг тавьсан юм.

1990 оны 7 дугаар сард орон даяар бүх шатны АДХ-ын сонгууль болж, түүнд нийт сонгогчдын 97.8% нь оролцсон байв. БНМАУ-ын АИХ-ын депутатын сонгуулийн (бүх) 430 тойрогт сонгууль хуулийн дагуу явагдаж дуусав. Зарим нэр дэвшигчид сонгогчдын олонхын саналыг авч чадаагүй зэрэг шалтгаанаар санал хураалтыг хуулийн хүчинтэйд тооцох боломжгүй байсан 28 тойрогт хуульд зааснаар нэг сарын дотор дахин сонгууль явуулах шаардлагатай болов. Хууль журмын дагуу сонгууль бүрэн төгс болсон бусад тойрогт нийтдээ нэр бүхий 402 сонгогдогч БНМАУ-ын АИХ-ын депутат болов. Тэдгээрийг улс төрийн намын харьяаллаар нь авч үзвэл:

- МОАН-аас 23;
- МСДН-аас 4;
- МҮДН-аас 7;
- МЧХН-аас 1;
- МАХН-аас 343;
- МХЗЭ-ээс 4;
- нам бус – 20 хүн тус тус байв.

Сонгуульд оролцсон нийт сонгогчийн 60% нь МАХН-ыг, 24% нь МОАН-ыг, 6% нь МҮДН-ыг, 5% нь МСДН-ыг тус тус дэмжжээ. Анхны чөлөөт, ардчилсан сонгуулийг ажиглахаар АНУ, Англи, Зөвлөлт Холбоот Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Унгар Улс, Энэтхэг зэрэг орноос 30 гаруй хүн хүрэлцэн ирсний дээр дэлхийн 10 гаруй орны хэвлэл – мэдээллийн байгууллагын 80 шахам сурвалжлагч ажиллажээ. Сонгуулийн явц байдалтай танилцсан тэдгээр ажиглагчид энэхүү сонгуулийг хууль зүйн дагуу шударга үнэн явагдсан, ардчиллын ёс зарчимд нийцсэн гэж дүгнэсэн байдаг.

АДХ-ын энэ удаагийн сонгуулиар, түүнд оролцсон улс төрийн намуудын нэрээр санал хураалт явуулж, (явагдсан) саналын дүнг нь үндэслэн Улсын бага Хурлын 50 гишүүний суудлаас тухайн намд ногдох суудлын тоог хувь тэнцүүлэн хуваарилсан нь Монголд анх удаа сонгуулийн пропорционал тогтолцоог хэрэглэсэн явдал болов.²⁰⁷

1.2.Үндсэн хуулийг шинэчлэх болсон хүчин зүйлүүд (1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэх үеийн санал)

Монгол Улсын түүхэнд 1924, 1940, 1960 онуудад Үндсэн хууль батлагдаж байсан бөгөөд дөрөв дэх нь 1992 оны ардчилсан шинэ Үндсэн хууль юм. Тус шинэ Үндсэн хуулийг боловсруулах үйл явц 1980-1990-ээд оны зааг дээр социалист тогтолцоо задарч, түүнд багтаж байсан улс орнууд ардчилсан ёс, зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн, Монголын ард түмэн бусад улс орнуудын нэгэн адил ардчилал, өөрчлөлт шинэчлэлийн замыг сонгож, 1989 оны 12 дугаар сард олон намын систем тогтоох, хүний эрхийг дээдлэх, бүх нийтийн сонгуулийг хугацаанаас нь өмнө явуулах зэрэг 13 зүйлийн шаардлага бүхий олныг хамарсан эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлсний дараа эхэлсэн байна. Улмаар 1960 оны Үндсэн хуульд 1990 оны 5 дугаар сард нэмэлт оруулсан нь парламентыг байгуулах, олон намын оролцоотой сонгууль явуулах, шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулах асуудлыг багтаажээ. АИХ-ыг тойргоос сонгогдох депутатуудын бүрэлдэхүүнтэй байгуулж, түүний бүрэн эрхэд улсын Ерөнхийлөгчийг сонгох, шинэ Үндсэн хуулийг батлах, түүнчлэн хууль тогтоох байгууллага болох Улсын Бага Хурлын гишүүдийг сонгохоор тусгажээ.

Сонгууль 1990 оны 07 дугаар сард явагдаж, түүний үр дүнгээр шинэ парламент, шинэ Засгийн газар байгуулагдсан. Ерөнхийлөгч П.Очирбатаар ахлуулсан 20 гишүүн бүхий Үндсэн хуулийн төслийг боловсруулах комиссыг мөн оны 10 дугаар сард байгуулжээ. Үйл явц нь Үндсэн хуулийн төслийг боловсруулах, Улсын Бага Хурлаар хэлэлцүүлж батлуулах, АИХ-аар батлах зэрэг үе шатуудтай байхаар төлөвлөжээ.

Улсын Бага Хурлаар хэлэлцэгдсэн Үндсэн хуулийн төсөл 1991 оны 05 дугаар сард бэлэн болж, засварлаж боловсруулсан эхийг 06 дугаар сард хэвлэн нийтэлж, 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл олон нийтээр хэлэлцүүлэхээр болжээ. Төслийг өргөн хүрээнд тарааж иргэдэд орон нутгийн Хурлаар дамжуулан саналаа өгөх боломж олгов. 1991 оны 05 ба 06 дугаар сард боловсруулсан төслүүдийг Чингис хааны хуулийн нэрээр “Их цааз” гэж нэрлэжээ. Уг төсөлд Улсын Их Хурал нь нэг танхимтай байх, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил, тэдгээрийн тал нь сэлгээ маягаар гурван жил тутам сонгогдож байхаар заажээ. Үүнийг Улсын

²⁰⁷ Чулуун, Г. (2015). *Улсын Бага Хурлын товчоон: Үйл ажиллагааны хроно-тойм (1990-1992)*. УБ.

Их Хурлын гишүүдийн мэргэшсэн чадвар хийгээд хууль тогтоох ажлын залгамжлагдах, шинэчлэгдэх хос чанарыг хангах, мөн Улсын Их Хурлын байнга тасралгүй ажиллах нөхцөл боломжоор хангах зорилгоор түүний бүрэлдэхүүнийг сэлбэж байх зарчмыг сонгон авч төсөлд оруулсан байна.

Шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэн батлах явцад нийт 5 удаа төсөл өөрчлөгдөж байсан. Парламентын гишүүдийг сонгох журмыг тэдгээр төслүүдэд хэрхэн томьёолж байсныг Хавсралт 1-ээс үзнэ үү.

Харин Улсын Их Хурлын гишүүдийг сэлгэн ажиллуулахтай холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хуулийн төслийн талаар БНМАУ-ын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын дарга П.Очирбатын 1991 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Улсын Бага Хурлын чуулганы хуралдаанд хэлсэн үгэнд:

“...Улсын Их Хурлын гишүүдийг ээлжээр “жижүүрлэх” маягаар ажиллуулах нь тохиромжтой юм гэсэн ч санал бий. Гэтэл энэ үзэл баримтлалыг дагавал эцэстээ Улсын Их Хурлын хэлэлцэх асуудлыг аппарат нь бэлтгэж шийдвэрлэдэг байсан АИХ-ын Тэргүүлэгчдийн хуучин хэлбэр, загварт эргэж ороход хүргэх юм гэсэн бодитой болгоомжлол байгааг ташрамд тэмдэглэе...” гэжээ.

Төслийг АИХ-д 1991 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр илгээсэн бөгөөд АИХ-ын хэлэлцүүлгийн явцад улс төрийн тогтолцоонд томоохон үр дагавартай зарим өөрчлөлтийг хийжээ. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацааг 6 жилээс 4 жил болгон өөрчилж, гишүүдийн тоо ба хоёр танхимтай байх эсэх асуудлыг авч хэлэлцсэний эцэст нэг танхимтай байхаар тогтжээ. Ерөнхийлөгчийн тогтолцоотой байх асуудлыг хэлэлцэж түр хугацаанд хүлээн зөвшөөрсөн боловч шууд бус сонгогддог ерөнхийлөгчтэй, парламентын тогтолцоотой байх санал дахин гарч иржээ. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дөрөв, эсхүл зургаан жил байхаас үл хамааран бүрэн эрхийн хугацаанд гишүүдэд сэлгээ хийх сонгуулийн системээс татгалзаж, Улсын Их Хурал дөрвөн жил тутамд бүрэн бүрэлдэхүүнээр солигдож байхаар тусгасан.²⁰⁸

1.3.Өнөөгийн нөхцөл байдал буюу 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт

1992 оны Үндсэн хуулийн заалт	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгаас 2019.07.16-ны өдөр өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн заалт	2019 оны нэмэлт, өөрчлөлтийн заалт
§21.1. Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.	§21.1. Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун найман гишүүнээс бүрдэх бөгөөд тавин дөрвөн гишүүнийг нэг мандат бүхий сонгуулийн тойргоос мажоритар тогтолцоогоор, тавин дөрвөн гишүүнийг сонгуулийн нэгдсэн нэг тойргоос пропорциональ тогтолцоогоор тус тус сонгоно.	-
§21.4. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.	-	§21.4. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

²⁰⁸ НҮБХХ. (2015). Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: дүн шинжилгээ. УБ.

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг 1992 оны 01 дүгээр сарын 13-нд баталсан. Цаг үе, нийгмийн шаардлагаар өнгөрсөн хугацаанд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хэд хэдэн санал гарч, 2019, 2000 онуудад өөрчлөлт оруулсан байдаг. Үүний дараа Үндсэн хуульд нэмэлт оруулах төслийг боловсруулах ажлын баг 2008-2019 онд долоон удаа байгуулагдаж, 2011, 2012, 2015 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Улсын Их Хуралд өргөн барьж байсан ч хэлэлцээгүй. Харин хамгийн сүүлд буюу 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Уг төсөлд Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоотой холбоотой зохицуулалт төсөлд тусгагдаагүй байсан.

2019 оны 07 дугаар сарын 16-ны өдөр тухайн үеийн Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга хуульд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд уг төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11.3.4-т заасны дагуу саналын түвшинд харгалзан Улсын Их Хурлын 62 гишүүний өргөн мэдүүлсэн төсөлд гаргасан зарчмын зөрүүтэй санал гэж үзэн санал хурааж шийдвэрлэж байсан. Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүний өргөн мэдүүлсэн төслийг улс төрийн намуудаар хэлэлцүүлэх үед болон хожим Улс төрийн намын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг улс төрийн намуудаар хэлэлцүүлэх үед мөн л Улсын Их Хурлын сонгуулийг холимог, эсхүл сонгуулийн хувь тэнцүүлсэн /пропорционал/ тогтолцоогоор явуулах асуудлыг Үндсэн хуулиар зохицуулах нь зүйтэй гэсэн санал удаа дараа ирж байсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгаас 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалд Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог Үндсэн хуульд тодорхой тусгахтай холбоотой дараах үндэслэл, шаардлагыг дурдсан байна.²⁰⁹ Үүнд:

- “2012 оны сонгуульд холимог тогтолцоог ашигласнаар парламентад олон намын төлөөлөл орсноос гадна иргэдийн саналыг гээх нь багассанаараа чухал ач холбогдолтой байсан. Олон намын төлөөлөл бүхий парламент нь аливаа асуудлыг зөвшилцлийн замаар шийдвэрлэх, шийдвэр гаргах явц дахь нэг намын хэт давамгайллыг бууруулах давуу талтай.
- Монгол Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн 33 намаас хувь тэнцүүлэх, эсхүл сонгуулийн холимог тогтолцоог хуульчлан тогтоох нь зүйтэй гэсэн байр суурийг чамгүй олон илэрхийлж байгаа.
- Дэлхийн улс орнуудаас Япон, ХБНГУ, БНСУ, Шинэ Зеланд, Унгар, Словени, Польш, Румын, Литва, Франц зэрэг улс холимог тогтолцоог ашиглан парламентын сонгуулиа явуулж байгаа бөгөөд олон намын тогтолцоотой улс орнууд сонгуулийн хосолсон болон пропорционал тогтолцоог өргөнөөр сонгох хандлага ажиглагдаж байна.
- Манай улсын хувьд Үндсэн хууль, өөрийн орны онцлог, хүн ам цөөн, өргөн уудам нутаг дэвсгэрт тархан суудаг, улс төрийн намуудын төлөвшил сул зэргээ харгалзан, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангах, тогтвортой байдлыг бэхжүүлэх зүй ёсны шаардлагын хүрээнд сонгуулийн тогтолцоогоо оновчтой, тодорхой болгож, тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ингэвээс төрийн эрх барьж буй нам сонгуулийн өмнө өөрсдийн эрх ашигт нийцүүлэн сонгуулийн хуулийг өөрчилдөг гэж жишгийг халах онцгой ач холбогдолтой.

²⁰⁹ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн цахим хуудас, <https://president.mn/10139/>

- Эдгээр асуудлын хүрээнд Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог Үндсэн хуульд тодорхой тусган, зааж өгөх нь зөв гэж үзэж байна. Ингэснээр төрийн эрх барьж буй нам өөрийн эрх ашигт нийцүүлэх байдлаар сонгууль бүрийн өмнө сонгуулийн хууль болон тогтолцоо, журмыг өөрчилдөг зохисгүй байдал дахин гарахгүй байх нөхцөл бүрдэнэ.” гэжээ.

Улсын Их Хурлаас 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдөр 72 дугаар тогтоол баталж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, саналыг Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын нэр бүхий 62 гишүүний өргөн мэдүүлсэн төсөлтэй уялдуулах, асуудлыг зөвшилцөх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Улсын Их Хурлын 72 дугаар тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсгээс Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар 2019 оны 07 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд Төрийн ордонд таван удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2019 оны 08 дугаар сарын 28, 29, 09 дүгээр сарын 04, 05, 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, төслийг ард нийтийн санал асуулгад оруулах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь тогтсон тул Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу ард нийтийн санал асуулгад оруулах төслийн нэг, хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолыг баталсан.

Тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсныг Улсын Их Хурал 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэн хүлээн авах нь зүйтэй гэж үзэж “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг хүчингүй болгосон.

Ингэснээр Улсын Их Хурал төслийг гурав дахь хэлэлцүүлэгт шилжүүлэн, Гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоосон Улсын Их Хурлын тогтоолыг баталсны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийсэн.

Төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх хүрээнд Улсын Их Хурлын даргын 199 дүгээр захирамжаар байгуулагдсан Зөвшилцлийн ажлын хэсэг 2019 оны 09 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 07, 08, 09, 11 дүгээр сарын 05, 12-ны өдрүүдэд нийт 7 удаа хуралдаж, тодорхой асуудлуудаар зөвшилцөлд хүрч санал нэгджээ. Ингээд Зөвшилцлийн ажлын хэсгээс Ерөнхий сайд танхимаа өөрөө бүрдүүлэх, Улсын Их Хурлын сонгуулийг олонхын /мажоритар/ болон хувь тэнцүүлэх /пропорционал/ зарчмыг хослуулан явуулж сонгогч нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх гэсэн зарчмын шинжтэй хоёр санал гаргасныг тус Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээд хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар санал хурааж, хуралдаанд оролцсон нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн.

Харин Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө.” гэсэн агуулгатай 1, 2 дахь өгүүлбэрийг нэмэх саналыг чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон 69 гишүүний 41 нь буюу 59.4 хувь нь дэмжиж, энэ санал хуралдаанд оролцсон гишүүдийн дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авч чадаагүй байна.

1.4.Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны талаар Үндсэн хуулийн цэц дээр үүссэн маргаан

Үндсэн хуулийн цэцэд хянан шийдвэрлэгдсэн Сонгуулийн тухай хуультай холбоотой маргаан нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, ард түмэн төрийн үйл хэрэгт шууд болон шууд бус оролцох эрх, иргэдийн сонгох эрхээ хэрэгжүүлэх зарчим болон холбогдох бусад агуулга бүхий Үндсэн хуулийн зүйл заалтыг хамарсан байна. Тухайлбал,

1.4.1.Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргаан (Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлт)

Нэр бүхий иргэдээс Үндсэн хуулийн цэцэд хандаж шинэчилсэн найруулгаар батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуультай холбоотой мэдээлэл гаргаж, түүндээ 2011 онд батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсгийн “... энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан...”, 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалтын “энэ хуулийн 48.2-т заасан “А” жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид “В” жагсаалт”гэх/-ыг гаргах.”; 49.1.5.а заалтын “санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;”, 49.1.5.б заалтын “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигч;”, 49.1.5.в заалтын “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд таваас доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч;”, “49.1.6 дахь заалтын “тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан “В” жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, “В” жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа...” гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”; Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”; Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...” Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж...сонгоно.” гэсэн заалтыг зөрчсөн эсэхийг тодорхойлоход ханджээ.²¹⁰

Дээрх мэдээллийн дагуу маргаан үүсэж, 2012 оны 03 дугаар сарын 28-ны өдөн Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар уг асуудлыг авч хэлэлцсэн байна. Уг асуудал нь нэлээд ээдрээтэй байж, хуралдааны явцад маш олон асуулт гарсан байна.

Хуралдаанаас гарсан дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

“1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь Улсын Их Хурлын сонгуулийн 26 тойрогт 48 мандатын төлөө нэр

²¹⁰ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ Үндсэн хуулийн цэцийн шийдвэр дугаар 02, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1045>

дэвшигчдээс тус тусын тойрогтоо ялагдал хүлээсэн боловч тэдгээрээс 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох боломжийг бий болгон хуульчилснаараа зарим нэр дэвшигч нарт давуу байдал бий болгон Үндсэн хуульд заасан хуулийн өмнө эрх тэгш байх зарчмын агуулгыг алдагдуулсан байна.

2.Түүнчлэн сонгуулийн эрх бүхий иргэд нэгэнт сонголтоо хийсэн байтал дээрх зохицуулалт нь Улсын Их Хурлын 26 тойрогт нэр дэвшээд тус тусын тойрогт ялагдал хүлээсэн боловч 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч улс төрийн нам, эвслийн жагсаалтад шилжин орсноор Улсын Их Хурлын гишүүний мандат буюу суудлыг нам, эвсэлд тэдгээрийн авсан саналын хувь хэмжээгээр хуваарилах агуулгатай сонгуулийн хувь тэнцүүлэх хэлбэр хэрэгжих боломжгүйд хүрч, улмаар иргэдийн шууд сонгох эрхийг алдагдуулсан байна.

3.Мөн Улсын Их Хуралд нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчид өгсөн санал хоёр удаа буюу сонгуулийн олонхийн болон хувь тэнцүүлэх хэлбэрт тус тус үнэлэгдсэнээр, намын нэрээр өгсөн сонгогчдын санал эзэнгүйдэн, улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн жагсаалтад орсон 28 нэр дэвшигчид өгсөн саналыг бодитойгоор үнэлэх боломжгүй байдалд хүргэн, тэдгээрийн сонгогдох эрхийг хязгаарласан байна.” гэжээ. Мөн түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь дээр дурдсан зөрчлийн шинжийг агуулснаараа ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн суурь зарчимд харшилсан болохыг тэмдэглэсэн байна.

Дээрх маргааныг хянан хэлэлцээд гаргасан **Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар дүгнэлт** Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дурдагдсан зүйл, заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...", Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж...сонгоно." гэснийг тус тус зөрчсөн гэж гарчээ.²¹¹

Үүний дараагаар Улсын Их Хурлын 2012 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн байна.²¹²

Иймээс тус асуудлыг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар магадлан хэлэлцэхээр болсон. Их суудлын хуралдаанд бэлтгэх явцад мэдээлэл гаргагч иргэдээс зарим нэг нь өөрийн мэдээллийн шаардлагаас бүхэлд нь татгалзаж байсан байна.²¹³

²¹¹ Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 02 шийдвэр /Дүгнэлт/ "Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн Хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1045>

²¹² Улсын Их Хурлын 2012 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоол <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10329>

²¹³ Солонго Д. (2017). Үндсэн хуулийн цэц иргэдийн сонгох, сонгогдох эрхийн баталгаа болох нь. Жанцан Ж., Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: Онол арга зүйн хэрэгжилт. УБ: Монгол Улсын Үндсэн хуулийн цэц.

Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн их суудлын хуралдаанаар дээрх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэж 03 дугаар тогтоол гаргасан. Ингэхдээ тухайн асуудлаар өмнө гаргасан Цэцийн 02 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна гэж үзэж Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дээр дурдагдсан заалтуудыг хүчингүй болгохоор шийдвэрлэсэн байна.²¹⁴

1.4.2. Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргаан (Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар шийдвэр)

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан 2016 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр хуралдаж Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад “хувь тэнцүүлсэн /пропорционал/”, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын 48-аас илүүгүй гишүүнийг олонхийн сонгуулиар, 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар тус тус сонгоно.” гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1, Хорин нэгдүгээр зүйлийн 2, 3, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн.

Хуралдаанаас гарсан дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн үзэл баримтлалыг тодорхой болгох үүднээс Үндсэн хуулийн төслийг хэлэлцсэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын болон АИХ-ын хуралдааны тэмдэглэлийг судлан үзэхэд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын хуралдаанаар Улсын Их Хурлыг бүрдүүлэхэд хэрэглэх сонгуулийн хэлбэрийн талаар хэлэлцэж санал хураалт явуулж байжээ.

Тодруулбал, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын Үндсэн хуулийн төслийг хэлэлцсэн 1991 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанд зарим гишүүний гаргасан саналын дагуу “... Их Хурлын гишүүдийн заримыг нь намын талаар авсан саналын үндсэн дээр хувь тэнцүүлэн суулгах, заримыг нь тухайлбал, гуравны хоёрыг нь шууд сонгож бүрдүүлэх гэсэн ийм холимог бүрэлдэхүүнтэй байх. Нэг танхимтай холимог бүрэлдэхүүнтэй парламент байх хэрэгтэй гэсэн. Ийм саналыг дэмжиж байгаа дээр санал хураалт явуулъя...” гэж хувь тэнцүүлэх элемент бүхий сонгуулийн холимог хэлбэрийг Улсын Их Хурлын сонгуульд хэрэглэх талаар санал хураахад уг санал гишүүдийн олонхийн дэмжлэг авч чадаагүй байна.

Үүнээс үзэхэд Улсын Их Хурлын сонгуулийг хувь тэнцүүлсэн хэлбэрээр явуулах боломжийг Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөөгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Энэхүү үзэл баримтлалын дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг ... сонгоно”; мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнээр ... иргэнийг сонгоно.” гэсэн зохицуулалтыг тусгаж, аль нэг намд бус нэр дэвшигч иргэнд өөрт нь саналаа өгөх замаар Улсын Их Хурлын гишүүнийг сонгох агуулгаар хуульчилсан байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт нь бүхэлдээ, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсгийн “... 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар ... сонгоно.” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан заалтыг зөрчсөн гэж үзэхээр байна.

²¹⁴ Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн дугаар 03 тогтоол “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” <https://old.legalinfo.mn/law/details/1044?lawid=1044>

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүнийг шууд сонгох зарчим нь Улсын Их Хурлын гишүүнийг ямар нэг байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр дамжуулан дам сонгохгүйгээр, сонгогч саналаа аливаа этгээдээр төлөөлүүлэхгүйгээр өөрөө биечлэн, шууд гарган сонгохыг ойлгоно. Иймээс Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдээс Улсын Их Хурлын гишүүнийг шууд сонгох эрхэд хязгаарлалт хийх боломжгүй байна.

3. Иргэдийн мэдээлэлд дурдсан үндэслэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Дээрх маргааныг хянан хэлэлцээд гаргасан **Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 05 дугаар дүгнэлт** Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад “хувь тэнцүүлсэн /пропорционал/;”, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын 48-аас илүүгүй гишүүнийг олонхийн сонгуулиар, 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар тус тус сонгоно.” гэж заасны “... 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд ... шууд ... сонгоно.” Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.” гэснийг тус тус зөрчсөн байна.

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад “хувь тэнцүүлсэн /пропорционал/;”, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын 48-аас илүүгүй гишүүнийг олонхийн сонгуулиар, 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар тус тус сонгоно.” гэж заасан нь Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн хэмээн Үндсэн хуулийн цэц шийдвэрлэж, сонгуулийн хувь тэнцүүлэх тогтолцооны суурь зохицуулалт өөрчлөгдсөнтэй уялдуулан дагалдаж өөрчлөгдөх зарим заалт тус хуульд байгаа болохыг дурдсугай.

Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад “хувь тэнцүүлсэн /пропорционал/;”, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт “... 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар ...” гэсэн заалтын үйлчлэлийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.” гэж гарчээ.²¹⁵

²¹⁵ Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” дугаар 05 дүгнэлт <https://old.legalinfo.mn/law/details/11847>

Үүний дараагаар Улсын Их Хурлын 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 38 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийн хүлээн зөвшөөрсөн байна.²¹⁶

Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай Улсын Их Хурлын 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон.²¹⁷

1.5.1992 оны Үндсэн хууль батлагдсаны дараах улс төрийн үйл явц

Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлд зааснаар “Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”, мөн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.” гэж заажээ.²¹⁸

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан 1992 оноос хойш Монгол Улсад УИХ-ын сонгууль 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, 2020 онд нийт 8 удаа явагдсан.

- **1992 оны** УИХ-ын сонгууль нь Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан, УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуулийн дагуу явагдсан анхны сонгууль байлаа. 1992 оны сонгууль олон мандаттай мажоритар системээр, тойрог бүрд 2-4 гишүүн сонгогдохоор явагдсан. 1992 оны сонгуульд МАХН УИХ-д үнэмлэхүй олонх болсноор Засгийн газрыг дангаараа бүрдүүлсэн.
- **1996 оны** УИХ-ын сонгууль нь цэвэр мажоритар системээр явагдсан ба түүний үр дүнд Ардчилсан Холбоо эвсэл парламентын олонх болж Засгийн газрыг “Ардчилсан Холбоо” Эвсэлд багтсан МҮАН, МСДН-ын гишүүд бүрдүүлсэн билээ.
- **2000 оны** УИХ-ын сонгууль мөн цэвэр мажоритар системээр явагдсан бөгөөд энэ сонгуульд МАХН үнэмлэхүй олонх болж Засгийн газраа дангаараа бүрдүүлсэн. УИХ-ын 1996 оны сонгуультай харьцуулахад сонгуульд оролцсон нам, эвслээс нэр дэвшигчийн тоо 2 дахин илүү байсан.
- **2004 оны** УИХ-ын сонгууль өмнөх хоёр сонгуулийн нэгэн адил мажоритар системээр явагдсан ба тус парламентын сонгуульд аль ч нам олонх болоогүй учраас хамтарсан Засгийн газрыг МАХН болон Эвсэлд багтсан намын төлөөллөөс бүрдүүлсэн билээ.
- **2008 оны** УИХ-ын сонгуулийн тогтолцоог 2005 онд баталсан УИХ-ын сонгуулийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-аар, 1992 оны сонгуулийн тогтолцооны загвараар (мажоритар системээр олон мандаттай тойрогт) явуулсан. Гэхдээ сонгогч мандатын тоогоор бус өөрийн хүсэлтээр хэд хэдэн нэр дэвшигчид санал өгөх эрхтэй болсон байна. Энэхүү сонгуульд МАХН олонх болсон хэдий ч тухайн үеийн нийгэм-улс төрийн нөхцөл байдлын улмаас хамтарсан Засгийн газар байгуулагдсан.
- **2012 оны** УИХ-ын сонгууль нь 2011 онд шинээр батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн дагуу явагдсан. Шинээр батлагдсан сонгуулийн тухай хуулийн дагуу сонгуулийг холимог тогтолцоогоор буюу 26 тойргоос 48 гишүүнийг олонхыг төлөөлөх (мажоритар)

²¹⁶ Улсын Их Хурлын 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлтийн тухай” 38 дугаар тогтоол <https://legalinfo.mn/mn/detail?lawld=11895>

²¹⁷ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай Улсын Их Хурлын 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоол <https://legalinfo.mn/mn/detail?lawld=11630>

²¹⁸ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2012 он). Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойм. УБ: Судалгааны эмхэтгэл XIII боть, СТ-12/408.

тогтолцоогоор, 28 гишүүнийг намын жагсаалтаар пропорционал тогтолцоогоор сонгосон. Үүний үр дүнд гадаад дахь Монгол Улсын иргэд анх удаагаа сонгуульд саналаа өгөх боломжтой болсон. Тус сонгууль нь шинэ тогтолцоо, автоматжуулсан хэлбэрээр явагдсанаараа онцлог болсон.

- **2016 оны** УИХ-ын сонгууль 2015 онд батлагдсан шинэ Сонгуулийн тухай хуулийн дагуу нэг мандаттай тойрог бүхий олонхыг төлөөлөх (мажоритар) тогтолцоогоор явагдсан. Үр дүнд нь гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэд аль нэг тойрогт харьяалагдахгүй болсны улмаас санал өгөх боломжгүй болсон.
- **2020 оны** УИХ-ын сонгууль 2019 онд батлагдсан шинэ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу томсгосон тойрог бүхий олонхыг төлөөлөх (мажоритар) тогтолцоогоор явагдсан. Сонгогч мандатын тооноос хамаарч 2-3 санал өгч, хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгосон.

Судалгаанаас үзэхэд, 1992, 2005, 2011, 2015, 2019 онуудад УИХ-ын сонгуулийн тухай хуулийг шинэчлэн баталсан. Харин сонгуулийн тогтолцоог 1992, 1996, 2008, 2012, 2015, 2016, 2019 онуудад тус тус өөрчилж байсан буюу сонгууль бүрийн өмнө өөрчилж иржээ. Ердөө 2000, 2004 оны УИХ-ын сонгуулийн өмнө сонгуулийн тогтолцоог өөрчлөөгүй байна. (Хавсралт 2)

Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн хамтран хэрэгжүүлсэн “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд 2015 онд гаргасан судалгааны тайланд:²¹⁹

“Монгол Улс 1990 оноос хойш үндсэндээ сонгуулийн олонхын тогтолцоог ашиглаж ирсэн. Гэвч энэ нь заримдаа ихээхэн гажуудал үүсгэж байв. Үүний хамгийн тод жишээ нь, 2000 оны Улсын Их Хурлын сонгуульд 76 тойрог тус бүрээс хамгийн олон санал авсан нэг хүн сонгогдсон. Уг сонгуулиар МАХН нийт саналын 53.32 хувийг авсан ч 76 суудлаас 72-ыг, харин Ардчилсан нам нийт саналын 13.35 ба 1 суудал; Эх орон-Бүгд найрамдах нам 10,95 хувь ба 1 суудал; Иргэний зориг нам нийт саналын 3.45 хувь ба 1 суудал; бие даагчид 2.92 хувь ба 1 суудал авчээ. Бусад намууд нийт саналын 15.97 хувийг авсан ч суудалгүй үлдсэн. Уг сонгуульд нийт саналын 16 хувь буюу 190 мянган сонгогчийн санал хаягдсан нь 10 тойргийн сонгогчийн тоотой тэнцэх юм. Мөн бусад оронтой харьцуулахад суудал-саналын харьцааны алдагдал маш өндөр байгаа бөгөөд Улсын Их Хурал дахь намуудын харьцаа гажуудахад хүргэж болно.

Суудал-саналын харьцааны алдагдал буюу сонгогчдын санал гээгдэх явдал үргэлжлэн гарсаар байна. 2008 оны Улсын Их Хурлын сонгууль олон мандаттай 26 тойрогт явагдсан бөгөөд МАХН 1,514,855 саналаар 45 суудал, АН 1,396,625 саналаар 28 суудал авчээ. Хоёр намын авсан саналын тоо маш ойролцоо боловч суудлын тоо ихээхэн зөрүүтэй байв. Сонгогчдын боловсрол төв Конрад Аденауэрын сангийн дэмжлэгтэйгээр 2008 онд Монгол Улсын сонгуулийг санал тоолох янз бүрийн хувилбараар шинжилж үзээд сонгуулийн тогтолцоонд суудал саналын харьцааны алдагдал маш их байгааг тогтоожээ. Аль ч хувилбараар тооцоход суудал-саналын харьцаа 2000 оны сонгуулийн бодит дүнгээс зөрүүтэй байжээ. Чухам ийм байдлыг засах зорилгоор сонгуулийн тогтолцоог өөрчилж 2012 оны сонгуульд пропорционал элемент оруулсан. Гэвч нийслэлийн мандатын тоо хүн амын өсөлттэй харьцуулахад цөөн байгаа нь нийслэлийн иргэдийн санал гээгдэхэд хүргэж, сонгуулийн тогтолцоо орон нутагт давуу байдал олгосон хэвээр байна.” гэжээ.

²¹⁹ НҮБХХ. (2015). Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: дүн шинжилгээ. УБ.

1992 оноос хойш явагдсан сонгуулийн тогтолцооны өөрчлөлтийг дүгнэхэд мажоритар тогтолцооны хувилбаруудыг голлон хэрэглэж ирсэн байна. Үүнд, 1996, 2000, 2004, 2016 онуудад сонгуулийн нэг мандаттай нэг тойрог, 1992, 2008, 2020 онуудад олон мандаттай том тойрог, 2012 онд 48/28 гэсэн мажоритар давамгайлсан зэрэгцээ тогтолцоог хэрэглэсэн байна. Өнгөрсөн жилүүдэд ашигласан холбогдох тогтолцоо нь дараах давуу болон сул талтай байна. Үүнд:

Хүснэгт 3. УИХ-ын сонгуулиудын тогтолцоо, тэдгээрийн давуу болон сул тал

Сонгуулийн тогтолцоо	Он	Онцлог	Давуу тал	Сул тал
Мажоритар – Олон мандаттай том тойрог бүхий мажоритар тогтолцоо	1992 2008 2020	Олон мандаттай тойргуудад явагдсан	- Хүчирхэг намд илүү ашигтай - Олонх тойрогт зөвхөн нэг намаас ялалт байгуулах	- Намууд хоорондын бус харин нэг нам доторх өрсөлдөөнийг гааруулдаг - Нэр дэвшигчдийн бүтэц алдагддаг - Сонгуулийн нүсэр санхүүжилт шаарддаг - Парламент дахь намын бүлгийн бүтцэд сөргөөр нөлөөлдөг - Санал тоолоход хүндрэлтэй
Мажоритар – нэг мандаттай тойрог бүхий мажоритар тогтолцоо	1996 2000 2004 2016	Нэг мандат – нэг тойрог зарчмаар явагдсан	- Аль нэг нам давуу ялалт байгуулах боломжтой. Гэвч эрсдэл ихтэй.	- Аль нэг намын хэт давуу ялалтыг бий болгодог - Жижиг намуудын санал авах боломжийг хаадаг - Парламент дахь сөрөг хүчний харьцааг алдагдуулдаг
Холимог тогтолцоо	2012	48/28 гэсэн мажоритар давамгайлсан холимог тогтолцоогоор явагдсан	- Олон талт байдал, цөөнхийн оролцоог хангадаг - Цэвэр пропорционал тогтолцоотой харьцуулахад олон тооны жижиг намын тоо цөөн - Санал бага гээгдэнэ.	- Сонгогчдын санал ямар үр дүнд хүрэх нь тодорхой бус - Хоёр өөр статустай “төлөөлөгч” бий болох

Хавсралтаар 1992 оноос 2020 оны хооронд явагдсан нийт 8 удаагийн сонгуулийн дүнг нэгтгэн тоймлож Хавсралт 2-оор үзүүлээ. Мөн тухайн сонгуульд оролцсон намууд хэдэн хувийн санал авч байсныг харах боломжтой юм. Нийт 8 удаагийн сонгуулийн тогтолцооны эрх зүйн холбогдох зохицуулалтыг Хавсралт 3-аас үзнэ үү.

2. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

2.1. Ардчилсан сонгуулийн үндсэн зарчмууд²²⁰

Жинхэнэ ардчилсан сонгууль гэдэг нь ард түмэн тусгаар тогтнол, халдашгүй эрх дархаа хамтарсан байдлаар илэрхийлж байгаа хэрэг мөн бөгөөд иргэний заяагдмал эрхийн нэг билээ.

Сонгуулийн эрхийн зарчмыг үндсэн ба туслах гэж хоёр ангилж үздэг. Үндсэн зарчимд бүх нийтийн, шууд, чөлөөтэй, тэгш, саналаа нууцаар гаргах, туслах зарчимд сонгуулийг иргэд өөрсдөө зохион байгуулах, заавал нэр дэвшүүлэн сонгох, сонгуулийн нутаг дэвсгэрийн сонгуулийн санал хураахаас бусад ажил ил тод байх, сонгогдсонд тооцох зарчмууд орно.²²¹

²²⁰ <http://www.globeinter.org.mn/e-edu/election-media/index.php?cmd=Content&menuid=6&id=15>

²²¹ Бямбадорж Ж. (1999 он). Сонгууль сонгуулийн тогтолцоо. *Шинэ толь* №28.

Энэ талаар дэлхийн олон улс орны Үндсэн хууль төдийгүй Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) болон бусад холбогдох байгууллагуудын хүний эрхийн баримт бичгүүдэд тусгажээ.

а) Бүх нийтийн байх зарчим (*Universal Suffrage*)

Бүх нийтийн байх гэдэг нь сонгуулийн насанд хүрсэн бүх иргэн сонгууль өгөх эрхтэй байх юм. Иргэн яс үндэс, гарал, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал байдал, өмч, эрхэлж буй ажил, албан тушаал, шашин шүтлэг, боловсролын түвшингээс үл хамааран сонгох эрхтэй. Хуульд заасны дагуу зарим нэг хязгаарлалт байж болдог нь бүх нийтийн байх зарчмыг алдагдуулж буй хэрэг биш юм. Жишээ нь: Эмнэлгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн сонгуульд оролцох эрхгүй.

б) Сонгууль чөлөөтэй байх зарчим (*Free Suffrage*)

Энэ нь сонгогч сонгуульд заавал оролцож саналаа өгөх үүрэг хариуцлага хүлээхгүй гэсэн үг буюу сонгуульд оролцох, эс оролцохоо өөрөө шийдэх эрхтэй юм. Мөн саналаа хэнд өгөхөө зөвхөн өөрийн бодол, шийдвэрээр чөлөөтэй шийдэх бөгөөд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.

в) Саналаа нууцаар гаргах зарчим (*Secret Voting*)

Сонгогч саналаа хэрхэн өгч буй нь таны хувийн нууц юм. Сонгогч ямар нэгэн гадны хүч, нөлөөлөлгүйгээр, зөвхөн өөрийн оюун бодлоор сонголт хийх, саналаа чөлөөтэй илэрхийлэх бололцоо нөхцөлийг хангахад энэхүү зарчмын агуулга оршино. Санал бэлтгэх тасалгаанд сонгогчоос өөр хэн ч байж болохгүй бөгөөд саналаа чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахыг хориглон хуульчилсан. Саналын нууцыг хамгаалах үүргийг сонгуулийг эрхлэн явуулж буй байгууллагууд хүлээнэ.

Сонгууль тэгш байх зарчим (*Equal Suffrage*)

Дараах гурван нөхцөлийг биелүүлсэн тохиолдолд сонгуулийн тэгш байдал хангагддаг. Үүнд: сонгогч бүр адил тооны (голдуу нэг санал) санал өгөх эрхтэй байх; бүх сонгогчид адил тэгш үндсэн дээр сонгох; төлөөлөгч (депутат) бүр ижил тооны иргэдийг төлөөлөх ёстой.

Шууд байх зарчим (*Direct Suffrage*)

Саналаа ямар нэгэн төлөөлөлгүйгээр зөвхөн өөрөө биечлэн өгнө. Ихэнх тохиолдолд парламентын доод танхим, нэг танхимт парламентын гишүүдийг шууд сонгуулиар сонгодог. Энэ нь сонгууль явуулахын тулд тусгайлан байгуулагдсан сонгуулийн коллеги, эсхүл доод шатны төлөөллийн байгууллагыг иргэдээс сонгон үүний дараа тэдгээр байгууллага өөрсдийн дээд шатны төлөөллийн байгууллагыг сонгодог шууд бус сонгуулиас ялгаатай юм.

Европын Холбооноос сонгуультай холбоотой олон улсын болон бүс нутгийн баримт бичгийг (*Compendium of International Standards for Elections*)²²² тайлбарын хамт эмхэтгэн гаргадаг. Уг баримт бичгүүдэд шууд сонгох эрхийн талаар дараах байдлаар тодорхойлсон байна.

Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйлд.²²³

“1.Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй. ...

... 3.Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа

²²² European Commission, Directorate-General for External Relations. (2019). Compendium of international standards for elections: fourth edition. Publications Office. <https://data.europa.eu/doi/10.2770/923866>

²²³ Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946 он, НҮБ <https://legalinfo.mn/mn/detail/1271>

чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно” гэжээ.

2002 оны Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн орнуудын Ардчилсан сонгууль, сонгуулийн эрх, эрх чөлөөний стандартын тухай конвенц (*Convention on the Standards of Democratic Elections, Electoral Rights and Freedoms in the Member States of the Commonwealth of Independent States (2002)*)-ийн 4 дүгээр зүйлд:

“1. Шууд байх зарчмыг баримтлах гэдэг нь сонгогчид сонгуульд нэр дэвшигч, ба/эсхүл нэр дэвшигчдийн жагсаалтын төлөө, эсхүл нэр дэвшигч ба/эсхүл нэр дэвшигчдийн жагсаалтын эсрэг, эсхүл бүх нэр дэвшигч ба/эсхүл нэр дэвшигчдийн жагсаалтын эсрэг шууд саналаа өгөхийг ойлгоно.

2. Хууль тогтоох байгууллагын аль нэг танхимын бүх гишүүдийн мандат нь ерөнхий сонгуулиар нэр дэвшигч ба/эсхүл нэр дэвшигчдийн жагсаалтын хооронд явагдах чөлөөт өрсөлдөөний объект байна.

3. Үндэсний хууль тогтоох байгууллага нь хоёр танхимтай бөгөөд зарим, эсхүл бүх мандат нь ерөнхий сонгуулиар нэр дэвшигч ба/эсхүл нэр дэвшигчдийн жагсаалтын хооронд явагдах чөлөөт өрсөлдөөний объект биш байх тохиолдолд Конвенцын энэхүү заалттай зөрчилдөхгүй.” гэжээ.

2.1.1. Дэлхийн зарим улс орнуудын парламентын сонгуулийн шууд зарчим²²⁴

Парламентын сонгуультай холбоотой зохицуулалтыг санамсаргүй байдлаар сонгосон 55 улсын Үндсэн хуулийн хүрээнд судалж үзэхэд:

Судалгаанд хамрагдсан 55 улсаас 8 улс (Исланд, Замби, Лаос, Мьянмар, Непал, Турк, Эритрей, Япон)-аас бусад 47 улс Парламентын гишүүдийг шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгоно гэж Үндсэн хуульдаа тусгасан байна. Мөн 10 улс сонгуулийн зарчмаа шууд гэж заагаад сонгуулийн тогтолцоогоо зааж өгсөн байна. (Хүснэгт 5.) Үүнд:

- *Пропорционал тогтолцоотой гэж:* Армени, Австри, Финланд, Латви, Люксембург, Намиби, Польш, Руанда, Уругвай;
- *Мажоритар тогтолцоотой гэж:* Азербайжан Улс заасан байна.

Ер нь аль ч улс оронд сонгуулийн зарчим нь бүх нийтийн, чөлөөтэй, тэгш, шууд, нууц гэсэн байх бөгөөд зарим улсад эдгээр зарчмын аль нэг нь байхгүй, эсхүл заавал санал өгөх зарчмыг нэмж тусгадаг байна. Сонгуулийн талаарх онолын үүднээс авч үзвэл, шууд сонгох эрх нь **сонгогч ямар нэг төлөөллөөр дамжуулахгүйгээр өөрөө саналаа өгөх** гэж ойлгодог байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

²²⁴ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2011). Дэлхийн зарим улс орнуудын парламентын сонгуулийн шууд зарчим. Судалгааны эмхэтгэл Х боть, СТ-11/410.

Хүснэгт 4. Үндсэн хуулиар парламентын гишүүдийг шууд сонгох болон сонгуулийн тогтолцоог тогтоосон байдал

Шууд сонгох эрхийг тусгасан эсэх	Сонгуулийн тогтолцоог тогтоогоогүй	Сонгуулийн хэлбэрийг тогтоосон:		
		Пропорционал	Мажоритар	Холимог
Тусгасан 47 улс	37 улс Беларусь, БНКонго Улс, БНСУ, Болгар, Гаити, Грек, Гренада, Дани, Израил, Иран, Итали, Казахстан, Камбож, Камерун, Катар, Коста Рика, Кувейт, Литва, Мавритани, Мадагаскар, Молдова, Монтенегро, Румын, Сент Люсия, Серби, Словак, Словени, Тунис, Туркменистан, Умард Македон, Унгар, ХБНГУ, Хорват, Чех, Чили, Швед, Эстони	9 улс Австри, Армени, Латви, Люксембург, Намиби, Польш, Руанда, Уругвай, Финланд	1 улс Азербайжан	-
Тусгаагүй 8 улс	5 улс Лаос, Мьянмар, Турк, Эритрей, Япон	1 улс Исланд	1 улс Замби	1 улс Непал

Судалгаанд авагдсан 55 улсын хувьд:²²⁵

Танхимын тооны хувьд:

- 1 танхим бүхий - 31 улс;
- 2 танхим бүхий - 24 улс;

Засаглалын хэлбэрийн хувьд:

- Парламентын засаглалтай – 26 улс;
- Ерөнхийлөгчийн засаглалтай – 7 улс;
- Холимог засаглалтай – 19 улс;
- Хаант засаглалтай – 2 улс;
- Нэг намын тогтолцоотой – 1 улс тус тус хамрагдсан болно.

Хүснэгт 5. Парламентын гишүүдийн сонгуулийн шууд зарчим, засаглалын хэлбэрээр

Засаглалын хэлбэр	Шууд зарчмыг тусгаагүй			Шууд зарчмыг тусгасан	
	Улсын тоо	Улсын нэр	Улсын тоо	Улсын нэр	
Парламентын засаглалтай	3 улс	Исланд, Непал, Япон	23 улс	Армени, Болгар, Грек, Гренада, Дани, Израил, Итали, Камбож, Латви, Люксембург, Молдова, Сент Люсия, Серби, Словак, Словени, Умард Македон, Унгар, Финланд, ХБНГУ, Хорват, Чех, Швед, Эстони	
Ерөнхийлөгчийн засаглалтай	1 улс	Эритрей	6 улс	БНСУ, Гаити, Коста Рика, Туркменистан, Уругвай, Чили	
Холимог засаглалтай	3 улс	Замби, Мьянмар, Турк	15 улс	Австри, Азербайжан, Беларусь, БНКонго Улс, Иран, Казахстан, Камерун, Литва, Мавритани, Мадагаскар, Монтенегро, Намиби, Польш, Руанда, Румын, Тунис	
Бусад	1 улс	Лаос	2 улс	Катар, Кувейт	

²²⁵ ОУПХ-ны мэдээллийн баазыг ашиглан танхимын тоо, засаглалын хэлбэрийг тодорхойлсон болно.
<https://data.ipu.org/>

Хүснэгт 6. Парламентын гишүүдийн сонгуулийн зарчимтай холбоотой
гадаадын зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт²²⁶

Улсын нэр		Зохицуулалт
1.	Армени	7.Сонгуулийн зарчмууд Үндэсний Ассамблей болон орон нутгийн зөвлөлийн сонгууль ард нийтийн санал асуулга нь бүх нийтийн, тэгш, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах замаар явагдана. 89.Үндэсний Ассамблей 101-ээс доошгүй гишүүнээс бүрдэнэ... Үндэсний Ассамблейг пропорционал төлөөллийн зарчмаар сонгоно...
2.	Австри	26.Үндэсний Зөвлөлийг Холбооны ард түмэн (сонгууль явагдах өдөр 16 нас хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс) пропорционал төлөөллийн зарчмын үндсэн дээр тэгш, шууд , биечлэн болон саналаа нууцаар гаргах замаар сонгоно.
3.	Азербайжан	83.Парламентын гишүүдийг бүх нийтийн, тэгш, шууд сонгуулиар чөлөөт, биечлэн, саналаа нууцаар гаргах үндсэн дээр олонхыг төлөөлөх (мажоритар) тогтолцоогоор сонгоно.
4.	Беларусь ²²⁷	67.Депутатуудын сонгууль шууд байна . Депутатуудыг иргэд шууд сонгоно .
5.	БНСУ	41.Үндэсний Ассамблей бүх нийтийн, тэгш, шууд , нууц санал хураалтаар иргэдийн санал авсан гишүүдээс бүрдэнэ.
6.	Болгар	10.Сонгууль, үндэсний болон орон нутгийн бүх нийтийн санал асуулга нь бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах замаар явагдана.
7.	Гаити	89.Төлөөлөгчдийн Танхимын гишүүд нь санал өгөх эрх бүхий иргэдээс шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгогдох бөгөөд тэд иргэдийн нэрийн өмнөөс Сенаттай хамтран, хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ.
8.	ХБНГУ	38.Герман Улсын Бундестагийн гишүүнийг бүх нийтийн, шууд , чөлөөт, тэгш болон нууц сонгуулиар сонгоно. Бундестагийн гишүүд нийт ард түмний төлөөлөгч бөгөөд аливаа чиглэл, даалгаврыг биелүүлэх үүрэггүй, гагцхүү өөрийн итгэл үнэмшилд захирагдана.
9.	Грек	51.Парламентын гишүүдийг шууд , бүх нийтийн, нууц санал хураалтаар хуульд заасан санал өгөх эрх бүхий иргэд сонгоно.
10.	Гренада	32.Үндсэн хуулийн 56-р зүйлд заасны дагуу Гренада нь сонгуулийн тойргуудад хуваагдах бөгөөд нэг тойргоос нэг Төлөөлөгчдийн танхимын гишүүнийг тухайн тойргийн иргэд Үндсэн хууль болон бусад хуульд заасны дагуу шууд сонгоно .
11.	Дани	31.1.Парламентын гишүүдийг бүх нийтийн, шууд санал хураалтаар сонгоно.
12.	Замби ²²⁸	45.Үндсэн хуулийн 47 дугаар зүйлд заасан Ерөнхийлөгч, Парламентын гишүүн, зөвлөхийн сонгуулийн тогтолцоо нь: а) иргэд улс төрийн эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэх; б) санал тэгш байх зарчим дээр суурилсан насанд хүрэгчдийн бүх нийтийн санал хураалт; в) нийгмийн янз бүрийн бүлгүүдийн сонирхлын шударга төлөөлөл; г) Парламент, эсхүл Зөвлөл дэх жендерийн тэгш байдлыг тус тус хангана. 47.2.Парламентын сонгуулийг Үндсэн хуулийн 68 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүн ялах дүрэмтэй харьцангуй олонхыг (FPTP) төлөөлөх тогтолцоогоор явуулна.

²²⁶ <https://constituteproject.org/?lang=en>

²²⁷ 2022 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард нийтийн санал асуулга явуулж, холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулсан. <https://president.gov.by/ru/gosudarstvo/constitution>

²²⁸ 2016 оны 01 дүгээр сарын 5-ны өдөр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

[https://www.parliament.gov.zm/sites/default/files/documents/amendment_act/Constitution%20of%20Замби%20%20\(Amendment\),%202016-Act%20No.%202_0.pdf](https://www.parliament.gov.zm/sites/default/files/documents/amendment_act/Constitution%20of%20Замби%20%20(Amendment),%202016-Act%20No.%202_0.pdf)

13.	Израил	4.Кнессетийг үндэсний, бүх нийтийн, шууд , тэгш, нууц, хувь тэнцүүлэх (пропорционал төлөөллийн) сонгуулиар Кнессетийн сонгуулийн тухай хуулийн дагуу сонгоно. Энэ хэсгийг Кнессетийн олонхын саналаас бусад байдлаар өөрчлөхгүй.
14.	Иран	62.Исламын Зөвлөх Ассамблей ард түмнээс шууд , нууц санал хурааж сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ.
15.	Исланд	31 Парламент нь бүх ард түмнээс нууц санал хураалтаар, пропорционал төлөөллийн үндсэн дээр , 4 жилийн хугацаагаар сонгогддог 63 гишүүнтэй байна. ...Сонгуулийн тойргийн хил, хязгаарыг тогтоох, Парламентад суудал хуваарилах арга хэлбэртэй холбоотой зохицуулалтыг зөвхөн Парламентын гуравны хоёрын саналаар өөрчилнө.
16.	Итали	56.Төлөөлөгчдийн танхим бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно.
17.	Казахстан	50.1.Парламент нь Сенат ба Мажилис (Төлөөлөгчдийн танхим) гэж нэрлэх хоёр танхимаас бүрдэнэ. 3.Мажилис зуун долоон (107) төлөөлөгчөөс бүрдэх бөгөөд тэдгээр нь Үндсэн хуульд нийцүүлэн гаргасан дүрмийн дагуу сонгогдоно. 51.Мажилисийн 98 төлөөлөгчийг бүх нийтийн, тэгш, шууд болон нууц санал хураалтын үндсэн дээр сонгоно. Мажилисийн 9 төлөөлөгчийг Казахстаны Ардын Чуулган (Ассамблей)-аас сонгоно.
18.	Камбож	76.Депутатуудыг чөлөөт, бүх нийтийн, тэгш, шууд , нууц санал хураалтаар сонгоно.
19.	Камерун	15.Үндэсний Ассамблей 180 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийг шууд , бүх нийтээр сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар 5 жилийн хугацаагаар сонгоно.
20.	Катар	77.Аль-Шура зөвлөл 45 гишүүнээс бүрдэх бөгөөд 30 нь бүх нийтийн, шууд , нууц санал хураалтаар сонгогдох ба 15-ыг нь Эмир сайдууд болон бусад хүмүүсээс томилно.
21.	БНКонго Улс	128.Үндэсний Ассамблейн гишүүдийг шууд , бүх нийтээр сонгох эрхийн үндсэн дээр сонгоно.
22.	Коста-Рика	93.Санал өгөх нь иргэн бүрийн үндсэн чухал, заавал биелүүлэх үүрэг бөгөөд Иргэний бүртгэлд бүртгэгдсэн иргэд нь шууд , нууцаар саналаа өгөх эрхтэй.
23.	Кувейт	80.Үндэсний Ассамблей нь сонгуулийн хуульд заасны дагуу бүх нийтийн шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар сонгогдсон 50 гишүүнтэй байна.
24.	Лаос	54.Үндэсний Ассамблейн бүрэн эрхийн хугацаа таван жил байна. Үндэсний Ассамблейн гишүүд хуульд заасны дагуу Лаосын иргэдээс сонгогдоно.
25.	Латви	6.Сейм бүх нийтийн, чөлөөтэй, тэгш, шууд , нууц, пропорционал төлөөллийн үндсэн дээр сонгогдоно.
26.	Литва	55.Сейм бүх нийтийн, чөлөөт, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгосон ард түмний 141 төлөөлөгчөөс бүрдэнэ.
27.	Люксембург	51.4.сонгууль шууд байна. 5.Депутатуудыг бүх нийтийн санал хураалтаар, намын нэрсийн жагсаалтаар, пропорционал төлөөллийн дагуу ... сонгоно
28.	Мавритани	47.Үндэсний Ассамблейн депутатуудыг 5 жилийн хугацаагаар шууд сонгоно.
29.	Мадагаскар	69.Үндэсний Ассамблейн гишүүдийг бүх нийтийн шууд сонгох эрхийн үндсэн дээр 5 жилийн хугацаагаар сонгоно.

30.	Умард Македон	62.БНМакедон Улсын Хурал 120-140 депутатаас бүрдэнэ. Депутатуудыг бүх нийтийн, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах замаар сонгоно.
31.	Молдова	61.Парламентын гишүүдийг бүх нийтийн, тэгш, шууд , саналаа нууцаар гаргаж сонгоно. Сонгуулийг зохион байгуулах, явуулах журмыг органик хуулиар тогтооно.
32.	Монтенегро	83.Парламент нь бүх нийтийн, тэгш сонгуулиар саналаа нууцаар гаргах үндсэн дээр шууд сонгогдсон Парламентын гишүүдээс бүрдэнэ. Парламент 81 гишүүнтэй байна.
33.	Мьянмар	109.Төлөөлөгчдийн танхим нь (The Pyithu Hluttaw) хамгийн ихдээ 440 гишүүнээс бүрдэх бөгөөд дараах байдлаар бүрдүүлнэ: 330-аас илүүгүй төлөөлөгчийг хот суурины тухай хуульд заасан ...тойргуудаас; 110-аас илүүгүй төлөөлөгчийг хуульд заасны дагуу Батлан хамгаалах албаны Ерөнхий командлагчийн нэр дэвшүүлсэн Батлан хамгаалах албаны албан хаагч бүхий төлөөлөгчид байна.
34.	Намиби	18.1. Үндэсний Ассамблей дараах бүрэлдэхүүнтэй байна: А.96 гишүүнийг сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчид бүх нийтийн, шууд , нууц санал хураалтаар сонгоно. 49. 46.1.а-д заасан гишүүдийн сонгуулийг намын нэрсийн жагсаалтаар Хавсралт 4-т заасны дагуу пропорционал төлөөллийн үндсэн дээр явуулна.
35.	Непал	84.Төлөөлөгчдийн танхим нь нийт 275 гишүүнээс бүрдэх бөгөөд дараах байдлаар бүрдүүлнэ: 165 гишүүнийг хүн ам, газар зүй болон онцлог байдлыг харгалзан хуваасан 165 тойргоос хамгийн олон санал авсан хүн ялах дүрэмтэй харьцангуй олонхыг (FTRP) төлөөлөх тогтолцоогоор ; 110 гишүүнийг сонгогчид намын төлөө санал өгөх хувь тэнцүүлэх (пропорционал төлөөллийн) тогтолцоогоор улсыг бүхэлдээ нэг тойрог гэж үзэж сонгуулийг явуулна.
36.	Польш	96.2.Сеймийн сонгууль бүх нийтийн, тэгш, шууд, пропорционал байх ба нууцаар саналаа өгөх замаар явагдана.
37.	Руанда	75.Төлөөлөгчдийн танхимын бүрэлдэхүүн, гишүүдийг сонгох: Төлөөлөгчдийн танхим 80 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийг дараах төлөөллүүдээс сонгоно. Үүнд: 53 гишүүнийг улс төрийн байгууллагаас нэр дэвшүүлсэн нэрсийн тогтмол жагсаалтаас, эсхүл бие даагч нэр дэвшигчдийг пропорционал тогтолцоогоор шууд бүх нийтийн сонгуулийн үндсэн дээр; 24 эмэгтэй гишүүнийг үндэсний засаг захиргааны нэгжээс сонгуулийн тусгай коллегииор дамжуулан; 2 гишүүнийг Үндэсний залуучуудын зөвлөлөөс; 1 гишүүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Үндэсний зөвлөлөөс тус тус сонгоно. ...Гишүүдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэй байна.
38.	Румын	62.Төлөөлөгчдийн танхим, Сенатыг сонгуулийн хуульд заасны дагуу бүх нийтийн, тэгш, шууд , чөлөөт сонгуулийн эрхийн үндсэн дээр сонгоно.
39.	Сент Люсиа	33.1.Үндсэн хуулийн 58-р зүйлд заасны дагуу сонгуулийн тойргууд байгуулагдах бөгөөд нэг тойргоос нэг Төлөөлөгчдийн танхимын гишүүнийг тухайн тойргийн иргэд шууд сонгоно .
40.	Словак	74.Парламентын гишүүдийг бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр, нууц санал хураалтаар сонгоно.
41.	Словени	80.Парламентын гишүүдийг бүх нийтийн, тэгш, шууд , нууц санал хураалтаар сонгоно.

42.	Серби	100.Үндэсний Ассамблей нь хуульд заасны дагуу шууд сонгуулиар, саналаа нууцаар гаргах үндсэн дээр сонгогдсон 250 гишүүнээс бүрдэнэ...
43.	Тунис ²²⁹	55.Ардын Төлөөлөгчдийн Хурлын гишүүдийг сонгуулийн хуульд заасны дагуу бүх нийтийн, чөлөөт, шууд , саналаа нууцаар гаргах үндсэн дээр, шударга, ил тод санал хураалтаар сонгоно.
44.	Турк	75.Туркийн Үндэсний Их Хурал бүх нийтийн сонгуулийн эрхийн үндсэн дээр сонгогддог 600 депутатаас бүрдэнэ.
45.	Туркменистан	78.Парламент нь 125 төлөөлөгчөөс бүрдэх бөгөөд, тэдгээрийг тэгш тоо бүхий (сонгуулийн тэгш зарчим) сонгогчдын тойргоос таван жилийн хугацаатай сонгоно. 119.Туркменистан Улсын Ерөнхийлөгч, Парламентын (дээд, доод) гишүүдийг бүх нийтийн, тэгш сонгуулиар сонгоно. 121.Сонгууль нь шууд байх бөгөөд сонгогдсон хүмүүс нь иргэдээс шууд сонгогдоно.
46.	Унгар	2.Үндэсний Ассамблейн гишүүнийг органик хуульд заасны дагуу шууд болон саналаа нууцаар гаргах санал хураалтаар, сонгогчдын хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэхийг баталгаажуулсан бүх нийтийн, тэгш сонгуулиар сонгоно.
47.	Уругвай	88.Төлөөлөгчдийн тахим нь улс орны лема (нам) бүрд өгсөн саналыг харгалзан үздэг пропорционал төлөөллийн үндсэн дээр иргэдээс шууд сонгогдсон 99 гишүүнээс бүрдэнэ.
48.	Финланд	25.Парламентын гишүүдийг шууд, пропорционал , нууц санал хураалтаар сонгоно. Санал өгөх эрх бүхий иргэн бүр сонгуульд тэгш эрхтэй оролцоно.
49.	Хорват	71.Хорватын Парламент нь бүх нийтийн шууд , тэгш сонгуулиар, саналаа нууцаар гаргах үндсэн дээр сонгогдсон 100-аас доошгүй, 160-аас дээшгүй тооны гишүүнтэй байна.
50.	Чех	18.Төлөөлөгчдийн танхимын сонгуулийг бүх нийтийн, тэгш, саналаа шууд гаргах эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар пропорционал төлөөллийн үндсэн дээр явуулна.
51.	Чили	47.Төлөөлөгчдийн Танхим нь сонгуулийн тойргоос (дүүргээс) шууд , нууц санал хурааж сонгогдсон гишүүдээс бүрдэнэ. Үндсэн хуулийн органик хуулиар Төлөөлөгчийн танхимын гишүүдийн тоо, сонгуулийн тойрог болон сонгуулийн хэлбэрийг тогтооно.
52.	Швед	Удирдлагын хэлбэрийн тухай 3 дугаар бүлэг 1.Риксдаг (Парламент)-ыг чөлөөт, нууц, шууд сонгуулиар томилно. Ийм сонгуульд саналыг намд өгөх бөгөөд сонгогч өөрийн үзэмжээр саналаа илэрхийлэх боломжтой юм.
53.	Эритрей	31.2.Үндэсний Ассамблей ард түмнээс сонгогдсон гишүүдээс бүрдэнэ. 3. Үндэсний Ассамблейн гишүүдийг сонгуулийн эрх бүхий бүх иргэд нууц санал хураалтаар сонгоно.
54.	Эстони	60.Рийгикогу (Парламент) нь 101 гишүүнээс бүрдэнэ. Рийгикогугийн гишүүдийг чөлөөт сонгуулиар хувь тэнцүүлэн хуваарилах (пропорционал төлөөллийн) зарчмын үндсэн дээр сонгоно. Сонгууль нь бүх нийтийн, жигд нэг хэлбэрээр, шууд явагдана . Саналаа нууцаар гаргана.
55.	Япон	47.Сонгуулийн тойрог, санал хураах аргачлал, хоёр танхимын гишүүдийн сонгуульд холбогдох бусад асуудлыг хуулиар тогтооно.

²²⁹ Тунис Улс нь 2014 онд шинэ Үндсэн хуулиа баталсан.
https://constituteproject.org/constitution/Тунис_2014?lang=en

2.2. Сонгуулийн тогтолцоо, ангилал²³⁰

Сонгуулийн тогтолцоо (буюу санал хураах тогтолцоо) гэдэг нь сонгогч тодорхой хувилбаруудаас өөрийн сонголтыг хийхтэй холбогдсон харилцаа юм. Сонгуулийн тогтолцоо нь санал хураах, санал тоолох, эцсийн дүнг нэгтгэн тооцох дүрэм журмыг өөртөө агуулж байдаг. Сонгуулийн тогтолцоог судалдаг онолыг *сонгуулийн эрх зүй* гэж хэлбэр талаас нь тодорхойлж болох бөгөөд түүний цаана улс төр судлал, эдийн засаг, математикийн агуулга оршиж байдаг.

Сонгуулийн тогтолцоог өргөн хүрээнд, хязгаарлагдмал хүрээнд гэсэн хоёр түвшинд авч үзэж агуулгыг нь тодорхойлдог.

- Иргэнд сонгуулийн эрхийг нээж өгөх, сонгуулийн эрхийн зарчмыг тодорхойлох, төрийн төв болон орон нутгийн сонгуулийг зохион байгуулж явуулах, сонгуулийн санал хураалтын дүнг нэгтгэж, үр дүнг тодорхойлох зэрэг харилцааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээг бүхэлд нь сонгуулийн тогтолцооны өргөн хүрээний тодорхойлолт гэж үздэг. Ийм эрх зүйн системийг бүхэлд нь сонгуулийн эрх зүй гэдэг.
- Санал хураалтын дүнг нэгтгэн тодорхойлох журмыг сонгуулийн тогтолцооны хязгаарлагдмал хүрээний тодорхойлолт гэж үздэг.

1936 оны ЗХУ-ын Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог өргөн утгаар нь тодорхойлох хүртэл гадаадын улс орнуудын судлаачид сонгуулийн тогтолцоог хязгаарлагдмал хүрээнд тодорхойлж иржээ.

Сонгуулийн саналын агуулга, тойргийн хэмжээ, санал хураалтын дүнг мандатад шилжүүлэн тооцох журам, саналаа тухайлсан нэр дэвшигчийн төлөө, эсхүл түүнийг хамруулж байгаа нам, эвсэл /нэрсийн жагсаалт/-ийн төлөө өгөх зэрэг хувьсах чанартай үзүүлэлтүүдийг харгалзан сонгуулийн тогтолцоог дор дурдсанаар ангилдаг.

Сонгуулийн тогтолцооны ангилал

Дэлхийн улс орнуудад сонгуулийн тогтолцооны маш олон хувилбар үйлчилж байгаа бөгөөд тэдгээр нь дотроо олон хувилбартай байгаа юм. Үүнийг хялбарчлан сонгуулийн *олонхыг төлөөлөх тогтолцоо*, сонгуулийн *хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо*, сонгуулийн *холимог тогтолцоо* гэсэн гурван ангилалд авч үздэг. Эдгээрийн алинд ч хамааруулж болохооргүй *үл шилжих нэг саналын, хязгаарлагдмал саналын, саналыг дугаарлаж өгөх Бордагийн тооцооны* арга гэсэн сонгуулийн тогтолцооны ангилал бас байдаг. (Зураг 2)

А.Олонхыг төлөөлөх (мажоритар) тогтолцоо: Тодорхой нэр дэвшигчээр дамжуулан сонгуулиар байгуулагддаг эрх барих байгууллагыг бүрдүүлдэг тогтолцоог олонхыг төлөөлөх тогтолцоо гэнэ. Энэ нь бусад намтай (намын нэрсийн жагсаалттай) харьцуулахад тойрогтоо олонх сонгогчдын санал авсан нэг (нэг мандаттай тойргийн үед), эсхүл нэг намын жагсаалтад харьяалалтай хэд хэдэн нэр дэвшигч (олон мандаттай тойрогт) сонгогдсонд тооцогдох олонхын зарчимд үндэслэгдэнэ.

Мажоритар тогтолцооны үед олонхыг:²³¹

- тодорхой,
- үнэмлэхүй,
- харьцангуй гэсэн төрлүүдэд ялган авч үздэг.²³²

²³⁰ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2010). Сонгуулийн эрх зүйн тогтолцооны онол арга зүйн үндэслэл, зохистой хувилбарыг сонгох зарчим. Судалгааны эмхэтгэл V боть, СТ-10/217.

²³¹ Сонгогчдын олонхын санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцогдох бөгөөд туйлын олонх (50+1), харьцангуй олонх (хамгийн олон санал авсан), дийлэнх (2/3) болон үнэмлэхүй олонх (3/4)-ийн саналаар сонгогдох гэж ангилдаг.

Тодорхой олонхын мажоритар тогтолцооны хэлбэрийн үед нэр дэвшигчийн (нэр дэвшигчдийн жагсаалт) сонгогдсон тооцоход шаардлагатай тодорхой саналын хувийг хуулиар тогтоож өгдөг байна. Энэ хувь нь голдуу 50+1 санал байж болох боловч үүнээс өөр ч байж болох юм. Хэрвээ тодорхой олонхын мажоритар тогтолцооны үед нэг ч ялагч тодроогүй бол хоёр дахь шатны санал хураалт болно. Хоёр дахь шатанд тухайн тогтолцоогоор шинэ санал хураалтад бусдаа бодвол хамгийн их санал авсан хоёр нэр дэвшигчийг өрсөлдүүлэх, эсхүл өөр байдлаар зохион явуулах боломжтой.

Үнэмлэхүй (ердийн) олонхын мажоритар тогтолцооны хэлбэрийн үед нийт санал өгсөн сонгогчдын (хүчингүй саналын хуудсыг тооллогоос хасдаг) 50-аас доошгүй (хамгийн багадаа) хувийн санал авах шаардлагатай. Энэ тохиолдолд мөн нэг ч ялагч тодроогүй бол хоёр дахь шатны санал хураалт болно.

Харьцангуй олонхын мажоритар тогтолцооны хэлбэрийн үед нэр дэвшигч (нэр дэвшигчийн жагсаалт) сонгогдохын тулд өөр дурын нэр дэвшигчээс (жагсаалт) илүү санал авах ёстой. Энэ тогтолцоо нь дээрх хоёртой харьцуулахад өртөг өндөр хоёр дахь шатны сонгууль явуулах шаардлага үүсгэдэггүй гэдгээр давуу талтай боловч сонгуульд олон нэр дэвшигч оролцож байгаа тохиолдолд сонгогчдын санал хуваагдах магадлал өндөр.

Олонхыг төлөөлөх тогтолцоо нь харьцангуй олонхын, багц саналын, намын багц саналын, дараалал тогтоож саналаа өгөх альтернатив саналын, хоёр шатлалтай саналын гэх мэт хувилбаруудтай. (Зураг 2)

Б.Хувь тэнцүүлэн хуваарилах (пропорционал) тогтолцоо: Нам эвслийн төлөөллөөр дамжуулан сонгуулиар байгуулагддаг эрх барих байгууллагыг бүрдүүлдэг тогтолцоог хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо гэнэ. Нам эвслийн авсан саналын хувьтай мандатын тоо нь уялдаж байх ёстой. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо нь жагсаалт (нээлттэй ба хаалттай)-ын, шилжих бололцоотой нэг саналын гэх мэт олон хувилбартай. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоонд:


- нам эвслүүдэд суудал хуваарилах тооцоо нь давуу тал олонтой ч зарим талаар хүндрэлтэй;
- ихэнх тохиолдолд сонгуулийн босго тогтоох замаар суудлыг хуваарилдаг.
- сонгуулийн босгыг ихэнхдээ тухайн тойрог/улсын хэмжээнд/-ийн сонгуулийн хүчинтэй саналын тоог мандатын тоонд харьцуулж тодорхойлдог;
- намын нэрийн жагсаалтаас хэдэн хүнд мандат хуваарилагдах вэ гэдэг нь босго саналын тоо тухайн намын авсан саналын тоонд хэд дахин багтаж байгаагаар илэрхийлэгдэнэ;
- үлдэгдэл саналыг хэрхэн хуваарилах нь хамгийн том асуудал.

В.Холимог тогтолцоо: Олонхыг төлөөлөх, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны аль алиных нь шинжийг агуулдаг. Энэхүү тогтолцоог *холимог хувь тэнцүүлсэн, зэрэгцээ* (параллел) гэж ангилж болно.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд сонгогчдын өгсөн нэг саналаар хоёр өөр тогтолцооны суудал хуваарилах аргыг хэрэглэдгээрээ онцлог юм. Зэрэгцээ (параллел) саналын арга нь сонгогч олонхыг төлөөлөх хэсэгт 1 санал, хувь тэнцүүлэн хуваарилах хэсэгт 1 санал өдгөөрөө ялгаатай.

²³² Цогтоо, Ш. (2018 он). Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй. УБ.

Зураг 2. Сонгуулийн тогтолцооны төрөл, хэлбэрүүд²³³



Эх сурвалж: Elections, Electoral Systems and Party Systems, A Resource Guide, IDEA, 2017

Сонгуулийн тогтолцооны хэлбэрүүд		
Олонхын төлөөлөх тогтолцоо / Plurality/Majority Systems		
	Нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүн ялах дүрэмтэй харьцангуй олонх (First Past The Post)	FPTP
	Хоёр шатлалтай санал (The Two-Round system)	TRS
	Альтернатив санал (The Alternative Vote)	AV
	Багц санал (Block Vote)	BV
	Намын багц санал (Party Block Vote)	PBV
Холимог тогтолцоо / Mixed Systems		
	Зэрэгцээ (Parallel Systems)	Parallel
	Холимог хувь тэнцүүлсэн (Mixed Member Proportional)	MMP
Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо / Proportional Representation		
	Жарсаалт (List PR)	List PR
	Шилжих бололцоотой нэг санал (The Single Transferable Vote)	STV
Бусад		
	Үл шилжих нэг санал (The Single Non-Transferable Vote)	SNTV
	Хязгаарлагдмал санал (The Limited Vote)	LV
	Бордагийн тооцооны арга (Borda Count)	BC

Сонгуулийн янз бүрийн тогтолцооны эцсийн үр дүн нь олон янз байж болох бөгөөд ялангуяа илэрхий олонх байхгүй тохиолдолд бүр ч илүү мэдрэгддэг. Иймээс сонгуулийн тогтолцоог сонгохдоо хэлбэр талаас нь биш агуулгаар нь авч үзэхийг онолын талаас нь шаардах болжээ.

Сонгуулийн тогтолцооны агуулгад дор дурдсан хүчин зүйлүүдийг зайлшгүй тооцох хэрэгтэй байдаг. Үүнд:

Сонгуулийн тогтолцооны агуулгад:

- саналаа илэрхийлэх хэлбэр;
- нэр дэвшигчийн асуудал;
- санал адил жинтэй байх шаардлага;
- саналын босго тогтоох арга;
- сонгуулийн тойрог, сонгогчид хамаарах үндэсний болон хүйсийн онцлогийг тооцож үзэх шаардлага.

²³³ (IDEA, 2017)

Олон ялагчдыг тодруулах арга:

- хувь тэнцүүлэн хуваарилах арга;
- хагас хувь тэнцүүлэх арга;
- холимог тогтолцооны арга.

Ганц ялагчийг тодруулах арга:

- нэг болон дараалалд оруулсан саналын арга;
- шилдгийг тодруулах олон шатлалтай саналын арга;
- зэрэглэх саналын арга (саналаа дугаарлаж өгөх, хэлэлцүүлэгтэй санал өгөх);
- нэг ялагчийг шалгаруулах үнэлгээний шалгуур зэргийг харгалзан үзэх хэрэгтэй.

2.2.1. Сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо

Төрийн эрх барих, хууль тогтоох дээд эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагын хувьд сонгогчдын саналыг бодитоор үнэлж, нийгэмд оршиж байгаа олон ургалч үзэл, янз бүрийн ашиг сонирхол, үнэт зүйлсийг бүрэн тооцох боломжийг нэг танхимд төвлөрүүлдэг нь хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны хамгийн том давуу тал юм.

Сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоог агуулга талаас нь авч үзвэл:

- Сонгогч саналаа шууд, нууц гаргах эрхийн үндсийг бүрэн хангах боломжтой.
- Сонгуульд нэр дэвшигчийн талаас нь авч үзвэл нам, эвсэл, нам, эвслээс гаргасан нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт, тухайлсан нэр дэвшигчийн аль нь ч байж болохоор байна.
- Нэг сонгогч-нэг санал гэсэн саналын хувийн жин тэнцүү байх боломжийг бүрдүүлж чадна.
- Саналын босгыг оновчтой тогтооход онцгой анхаарах нь чухал. Босгыг хэт өндөр тогтоох нь парламент дахь үзэл бодлын төлөөллийн тоог хязгаарлаж, олонхыг төлөөлөх тогтолцооныхоос нэг их ялгаагүй болгодог бол хэт доогуур тогтоовол олонхын төлөөлөл тогтохгүй, хамтарч Засгийн газраа байгуулахад хүргэдэг сул талуудтай учир энэ босгыг онож тогтоохоос парламентын ардчиллын хувь заяа шийдэгдэх учиртай. Судалгаанд хамрагдсан 71 улс (Хавсралт 4)-ын сонгуулийн тогтолцооноос харахад 12 улс 5 хувиар, 19 улс 5-аас доош хувиар, 5 улс²³⁴ 5 хувиас дээш босго тогтоосон байхад 29 улсад босго тогтоохгүйгээр сонгуулийн үр дүнгээр хүчинтэй саналын тоонд үндэслэн дор дурдсан томьёоны аль нэгээр нуугдмал босгыг тогтоогоод суудлыг хуваарилдаг байна. Нэлээд улс орнуудад саналын босгыг 5% буюу түүнээс доош тогтоосон байна.

Харе (Hare)-гийн томьёо: $K = \frac{V}{S}$	Друп (Droop)-ийн томьёо: $K = \frac{V}{S+1} + 1$
Империали квот (Imperiali quota)-ын томьёо: $K = \frac{V}{S+2}$	Сент Лагю (Sainte-Laguë)-гийн томьёо: $K = \frac{V}{2S+1}$
Д'Хонт (D'Hondt)-ын томьёо: $K = \frac{V}{S+1}$	Харенбах Бишхофф (Hagenbach-Bischoff quota)-ын томьёо: $K = \frac{V}{S+1}$

K- босго саналын тоо

V- хүчинтэй саналын тоо

S- мандат (суудал)-ын тоо

Харе, Сент Лагюгийн арга нь суудал хуваарилахад жижиг намуудад илүү тааламжтай байдаг бол Друпийн арга нь том намуудад арай илүү, Д'Хонтын арга нь том намуудад бүр илүү,

²³⁴ Лихтенштайн 8%, ОХУ 7%, Шри Ланк (1/8)12.5%, Швед тойрогтоо 12%, Турк мужийн түвшинд 10%.

империали арга нь хамгийн том намд илүү тааламжтай байдаг байна. Сонгуулийн санал хураасны дараа эдгээр томьёоны аль нэгийг хэрэглэж хүчин төгөлдөр саналаас тооцоо хийхэд тойрогт ч, муж, бүс нутгийн хэмжээнд ч, үндэсний 1 тойргийн хэмжээнд ч босгыг тогтоох боломжтой.

Империали квотын томьёог маш цөөхөн оронд тухайлбал, Эквадор, Италийн Депутатуудын танхимын сонгууль (1946-1993 онуудад)-д хэрэглэж байсан.

Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоонд олонх орнуудад саналын босгыг тогтоохдоо Харе, Друпийн босго тогтоох аргыг хэрэглэдэг байна. Харин суудал хуваарилахдаа Д'Хонт, Сент Лагюгийн аргыг түлхүү хэрэглэдэг байна. Судалгаанд хамрагдсан 71 улсын дотор намуудад суудал хуваарилахдаа Д'Хонт-ын аргыг 35 улсад Сент Лагюгийн аргыг - 6 улсад ашигладаг байхад Хагенбах-Бишхоффын зэрэг зарим аргуудыг цөөхөн зарим орнуудад ашиглаж байна. Эдгээрээс дунджийг нь сонгоё гэвэл Д'Хонтын аргыг сонгож болохоор байна.

Сонгуулийн тойрог, сонгогчид хамаарах онцлогийг сонгуулийн хуульд зөв тусгах хэрэгтэй. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоог сонгосон тохиолдолд тойргийг хэд хэдэн хувилбараар байгуулж болох талтай. Тойрогт оногдох суудлын тоо олон байх тутам суудлын хуваарилалт улам илүү хувь тэнцүүлсэн шинжтэй болдог байна. Үүнд:

а) Улсын хэмжээнд нэг тойрог байгуулах хувилбарыг сонгоход намаас нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт олонх тохиолдолд хаалттай байдгийг анхаарлын гадна үлдээж болохгүй. Энэ тохиолдолд нэрсийн жагсаалтыг нам дотроо эрэмбэлж тогтоогоод сонгуулийн компаний үед хуульд заасан тодорхой тохиолдлоос бусад нөхцөлд өөрчлөлт оруулахгүй байх механизмыг тогтоох шаардлагатай.

б) Улсын хэмжээнд олон мандат бүхий хэд хэдэн тойрог байгуулж, тэдгээрт нэр дэвшигчдийг сонгохдоо намын нээлттэй нэрийн жагсаалтаас сонгодог практик хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн тогтолцоотой олонх оронд ашиглаж байна. Намуудын нээлттэй нэрийн жагсаалтаас сонголт хийхэд 2 үндсэн аргыг хэрэглэж байна.

- Намаас нэр дэвшигчдийн нээлттэй жагсаалтыг гаргаж тодорхой нэр дэвшигчийн төлөө саналаа өгч, тэр нь намын саналд тооцогддог. Намын нэр дэвшигчдийн нээлттэй жагсаалтаас сонголт хийх хувилбар нь намынхаа нэр хүндийг дагаж, цөөхөн санал авсан том намын нэр дэвшигчид суудал оногдож байхад олон санал авсан жижиг намын нэр дэвшигчид суудал оногдохгүй байх тохиолдол цөөнгүй гардаг нь энэ хувилбарын дутагдалтай тал гэж үзэж байна. Нидерландад тойрогтоо босго саналын 25%-аас дээш санал авсан нэр дэвшигчид дараалал хамаарахгүй суудал олгогддог байна.
- Намаас нэр дэвшигчдийн жагсаалтад бүхэлд нь дүгнэлт өгч, жагсаалтад нь санал өгөх хувилбар байдаг.

в) Хувь тэнцүүлэн хуваарилах болон олонхыг төлөөлөх тогтолцоо хосолсон холимог хувилбарыг дэлхийн 30 шахам орнуудад ашигладаг. Ер нь холимог тогтолцоог ихэнх тохиолдолд газар нутгийн хэмжээ томтой, олон хүн амтай, олон үндэстэн ястан оршин суудаг, бүс нутгийн болон үндэстний эрх ашгийг төлөөлөх зайлшгүй шаардлагатай улс орнуудад сонгосон байдаг.

2.2.2. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо бүхий зарим улс орны эрх зүйн зохицуулалт

Судалгаанд хамрагдсан дэлхийн 71 улс (Хавсралт 4)-д сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах, түүнтэй ойролцоо тогтолцоогоор хууль тогтоох дээд байгууллагаа буюу аль нэг танхимыг нь бүрдүүлж байгаагийн дотор Боливи, Ардчилсан Конго, Герман, Унгар, Литва, Итали, Өмнөд Солонгос зэрэг 19 улсад сонгуулийн холимог тогтолцоог сонгосон байгаа бол 52 улсад сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах буюу түүнтэй ойролцоо тогтолцоотой байна.

Сонгуулийн тогтолцоог өөрчлөхөд хүргэдэг үндсэн 2 шалтгаан байдаг гэж үзэх болсон байна. Үүнд:

- улс төрчдийн суурь мэдлэг, мэдээлэл дутмаг байснаас сонгуулийн тогтолцооны хувилбаруудын үр дагаврыг таньж мэдээгүй байх;
- улс төрчид сонгуулийн тогтолцооны талаарх мэдлэгээ ашиглаж, өөрсдийн намдаа ашигтай хувилбарыг илүүд үзэх;

Сонгуулийн тогтолцоог сонгоход алсаа бодож харахгүй, улс төрийн явцуу эрх ашгийг урьтал болгох нь түүний яваандаа үзүүлэх үр дагаврын улмаас өргөн хүрээний ашиг сонирхлыг хохирооход хүргэдэг.

Сонгуулийн тогтолцооны шинэчлэлийг Италид 1993 онд холимог хувь тэнцүүлэх тогтолцоонд шилжсэнээр эхэлсэн гэж үзэж байна. 1993-2022 оны хооронд дэлхийн 217 улсаас 47 улс сонгуулийн тогтолцоондоо өөрчлөлт оруулахдаа 7 улс (Азербайжан, Ирак, Египет, Кувейт, Либер, Монгол, Сьерра Леон)-аас бусад нь олонхыг төлөөлөх тогтолцоог хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны элементээр баяжуулах, эсхүл бүхэлд нь хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор халсан байна. (Хавсралт 5)

Монгол Улсын нийгэм, эдийн засаг, газар нутгийн хэмжээ, хүн амын тоо, парламентын гишүүдийн тоо зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо бүхий зарим улс орнуудын сонгуулийн эрх зүйн зохицуулалтыг тив, тивийг төлөөлүүлэн түүвэрлэн авч үзье.

Ази тивээс Израил, Шри Ланка улсыг сонгов.

Израил Улсын парламент *Кнессет* нь нэг танхимтай, 120 гишүүнтэй. Кнессетийн сонгуулийг үндэсний хэмжээний 1 тойрогт намуудын хаалттай нэрсийн жагсаалтаар санал хурааж, Д'Хонтын аргаар суудлыг хуваарилдаг байна. Намуудын авсан байвал зохих доод саналын босгыг 3,25%-аар тогтоожээ.²³⁵

Шри Ланка Улсын парламент нэг танхимтай, 225 гишүүнтэй. Шри Ланка Улсын парламентын сонгуулийг хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулдаг. Парламентын гишүүдийн 196-г 4-20 мандат бүхий 22 тойргоос, 29-ийг үндэсний хэмжээний 1 тойргоос намын нээлттэй жагсаалтаар санал хурааж намуудын авсан саналд хувь тэнцүүлэн хуваарилдаг байна. Намуудын авсан байвал зохих саналын доод босго 22 тойрогт тойргийн нийт хүчинтэй саналын 1/20, үндэсний хэмжээний 1 тойрогт Д'Хонтын томьёогоор тодорхойлохоор заажээ. Сонгогч 1 саналыг дэмжиж байгаа намдаа, 3-аас дээшгүй саналыг дэмжиж байгаа нэр дэвшигчийн төлөө өгөх журамтай. Нэр дэвшигчийн төлөө өгсөн санал нь суудал хуваарилахад тэдгээрийн эрэмбийг тогтоох хүчин зүйл болдог байна.²³⁶

Африк тивээс Ангол, Намиби улсыг хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, нэгдмэл улс гэсэн шалгуураар сонгов.

Намиби Улсын Үндэсний Ассамблей 104 гишүүнтэй, 8 гишүүнийг Ерөнхийлөгч ажлын туршлага, мэргэжил чадварыг нь харгалзан томилдог, таслах эрхгүй. 96 гишүүнийг бүх ард түмнээс шууд нууцаар сонгохдоо улсын хэмжээнд 1 тойрогт хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны намын хаалттай жагсаалтаар сонгууль явуулдаг бөгөөд суудлыг Д'Хонтын аргаар хуваарилдаг байна.²³⁷

Ангол Улсын Үндэсний Ассамблей нэг танхимтай, 220 гишүүнтэй, 90 гишүүнийг улсын 18 мужийн 18 тойргоос, 130 гишүүнийг улсын хэмжээний 1 тойргоос сонгохдоо хувь тэнцүүлэн

²³⁵ <https://main.knesset.gov.il/EN/About/Lexicon/Pages/electoralsystem.aspx>

²³⁶ http://constitutionalreforms.org/wp-content/uploads/2016/06/CPA_WP_CR_No_16_Final-2.pdf

²³⁷ <https://www.parliament.na/national-assembly/>

хуваарилах тогтолцооны намын хаалттай жагсаалтын аргыг хэрэглэдэг. Суудлыг Д'Хонтын аргаар хуваарилдаг байна.²³⁸

Европ тивээс Латви, парламентын олон жилийн уламжлал бүхий Дани, Финланд улсыг сонгов.

Латви Улсын нэг танхимт парламент *Сейм* нь 100 гишүүнтэй. Сеймийн сонгуулийг 14-29 мандат бүхий 5 тойрогт намаас нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг сонгох хэлбэрээр явуулдаг. Тойргийн хэмжээнд сонгуульд намуудын нэрсийн жагсаалтад өгсөн саналыг хувь тэнцүүлэн хуваарилахдаа Сент Лагюгийн аргаар хуваарилдаг. Энэ аргын үндэс нь намуудын тойрогтоо авсан саналын нийлбэрийг 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14... гэх мэтээр мандатын тоо хүртэл тоонд хувааж, гарсан нодворт багтсан нэр дэвшигчдийг сонгогдсонд тооцох бөгөөд дутсан суудалд их үлдэгдлийг харгалзан суудал хуваарилдаг арга юм.²³⁹

Дани Улсын парламент нэг танхимтай, 179 гишүүнтэй, *Фолькетинг* гэж нэрлэдэг. Парламентын сонгуулийг олон мандат бүхий 10 тойрогт намаас нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг эсхүл аль нэг нэр дэвшигчийг сонгох (намыг сонгосонд тооцогдох) журамтай. Тойргийн хэмжээнд намуудаар саналын дүнг нэгтгэж, Сент Лагюгийн арга, Харегийн босго тогтоох аргын боловсронгуй болгосон хувилбарыг ашигласнаар жижиг намуудыг илүү дэмждэг хувилбарт тооцогддог байна. Энэхүү аргын дээр дурдсанаас ялгагдах онцлог нь 1-ээс эхлэн мандатын тоо хүртэл сондгой тоонд хувааж, парламентын 135 суудлыг хуварилсны дараа үлдэгдэл суудлыг улсын хэмжээнд 2%-аас дээш санал авсан намд суудал хуваарилах, тойргуудын суудал хуваарилалтыг тэнцвэржүүлэх зорилгоор нөхөн хуваарилдаг байна.²⁴⁰

Финланд Улсын парламент нэг танхимтай, 200 гишүүнтэй, *Эдускунта* гэж нэрлэдэг. Парламентын сонгуулийг Аланд арал 1 мандаттай 1 тойрогт олонхыг төлөөлөх зарчмаар, эх газарт 7-36 мандат бүхий 13 тойрогт хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны намын нээлттэй нэрийн жагсаалтаас зөвхөн нэг нэр дэвшигчийг сонгогч сонгох хувилбарыг хэрэглэдэг. Нэр дэвшигчид өгсөн санал нь намын саналд тооцогдох бөгөөд Д'Хонтын аргаар суудлыг хуваарилдаг.²⁴¹

Америк тивээс Парламентын гишүүдийн тооны хувьд Монгол Улстай ойролцоо Перу, Парагвай, Гайана улсыг сонгож авлаа.

Перу Улсын парламент нэг танхимтай *Конгресс* 130 гишүүнтэй. Парламентын сонгуулийг олон мандат бүхий 25 тойрогт нам, эвслийн нэрийн хаалттай жагсаалтаар санал хураах хувилбарыг хэрэглэдэг. Суудлыг их үлдэгдлийн аргаар хуваарилдаг байна.²⁴²

Парагвай Улсын Депутатуудын, Сенатын гэсэн 2 танхим бүхий парламентыг *Конгресс* гэж нэрлэдэг. Депутатуудын танхим 80 гишүүнтэй, Сенатын танхим 45 гишүүнтэй. Депутатуудын сонгуулийг олон мандаттай 18 тойрогт намын нэрийн хаалттай жагсаалтаар, Сенатын сонгуулийг 45 мандат бүхий 1 тойрогт намын нэрийн хаалттай жагсаалтаар санал хурааж, хувь тэнцүүлэн хуваарилдаг байна.²⁴³

Гайана Улсын парламент-Үндэсний Ассамблей нь нэг танхимтай, 65 гишүүнтэй. Үндэсний ассамблейн гишүүдийг 40 мандат бүхий 1 тойрог болон хэд хэдэн мандат (бүгд 25) бүхий 10 тойрогт намын нэрийн жагсаалтаар санал хурааж, Харегийн саналын босго тогтоох аргаар

²³⁸ http://archive.ipu.org/parline-e/reports/2007_B.htm

²³⁹ <https://www.saeima.lv/en/about-saeima/the-parliament-of-latvia/elections-of-the-saeima/>

²⁴⁰ https://www.thedanishparliament.dk/-/media/pdf/publikationer/english/the-parliamentary-system-of-denmark_2011.ashx

²⁴¹ <https://vaalit.fi/en/parliamentary-elections>

²⁴² https://data.ipu.org/node/133/elections?chamber_id=13492

²⁴³ http://archive.ipu.org/parline-e/reports/2249_B.htm

<http://archive.ipu.org/parline-e/reports/2250.htm>

хамгийн их үлдэгдлийн аргаар суудлыг нам, эвслийн авсан саналтай хувь тэнцүүлэн хуваарилдаг байна. 5 гишүүн нь томилогддог.²⁴⁴

2.2.3.Зарим улс орнууд дахь сонгуулийн холимог тогтолцооны эрх зүйн зохицуулалт

Шинэ Зеланд

Шинэ Зеланд Улс нэг танхимт парламент 120 гишүүнтэй, Төлөөлөгчдийн танхим гэж нэрлэдэг. Төлөөлөгчдийн танхимын 70 нь олонхыг төлөөлөх тогтолцоогоор 1 мандат бүхий тойргоос сонгогдох ба үүний дотор 7 нь уугуул Маори үндэстний тойрог байдаг. 50 нь үндэсний хэмжээний 1 тойргоос намын хаалттай нэрийн жагсаалтаар сонгогдоно. Сонгогч нэр дэвшигчид 1, намын нэрийн жагсаалтад 1 бүгд 2 санал өгнө, 5 хувийн босготой.

Сонгуулийн тогтолцоо: Шинэ Зеланд Улс Парламентын сонгуулийг 2 шатлал бүхий сонгуулийн холимог (*mixed member proportional*) тогтолцоог 1993 онд явагдсан ард нийтийн санал асуулгын үр дүнд 1996 оноос нэвтрүүлж, мажоритар тогтолцоог халсан байна. Доод шатаар орон нутгийн төлөөлөгчийг тогтоодог бол дээд шатаар Танхимын пропорционалт байдлыг (*аль нам нь хэчнээн хувийг бүрдүүлж байгааг*) тогтоодог байна. Сонгуулийн холимог систем нь Парламентын 120 суудлын 70-ыг нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугуйг бөглөх, үлдсэн 50-ийг нь намын жагсаалтаас сонгон өмнөх дугуйг бөглөнө.

Сонгогч санал гаргах: Шинэ Зеландад сонгогч хоёр саналын эрхтэй. Өөрөөр хэлбэл, сонгогчид 2 санал гаргана. “намын төлөөх санал” болон “нэр дэвшигчийн төлөөх санал”.

Гол санал (*main vote*) нь “намын төлөөх санал” (*party vote*) юм. Энэ саналаар танхимын пропорционалт байдлыг (*аль нам нь хэчнээн хувийг бүрдүүлж байгааг*) тодруулах буюу, энэ нь сонгуулийн системийн дээд шатлал байна. Төлөөлөгчдийн танхимын 50 гишүүдийг үндэсний хэмжээний намын жагсаалтаас сонгох ба намын төлөө өгсөн бүх саналыг нам бүрээр хуваарилж гаргана. Нам нь намын төлөөх бүх саналаас хамгийн багадаа 5 хувийн санал авах ёстой, эсхүл Төлөөлөгчдийн танхимын суудлын жагсаалтыг хуваарилахад “electorate seat” авснаар ялна.

Нөгөө санал нь “нэр дэвшигчийн төлөөх санал” (*electorate vote*) бөгөөд энэ нь доод шат юм. Энэ саналаар танхим доторх орон нутгийн төлөөлөгчийг тодруулах бөгөөд энэ нь пропорционалт байдлыг (*аль нам нь хэчнээн хувийг бүрдүүлж байгааг*) өөрчлөхгүй. Нэр дэвшигчийн төлөөх санал нь энгийн олонхын системээр ажиллах ба, тойрогтоо хамгийн өндөр санал авсан нэр дэвшигч сонгогдоно.

Энгийн мажоритар саналаар 63 гишүүнийг Ерөнхий сонгуулийн тойргоос* сонгох бол, 7 гишүүнийг Маоригийн сонгуулийн тойргоос сонгоно.

Шинэ Зеланд Улсын Сонгуулийн тухай хуульд²⁴⁵ сонгогч санал өгөх аргачлалыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

*168-р зүйл. Санал өгөх аргачлал*²⁴⁶

168.1. Сонгогч саналын хуудсыг хүлээн авч:

- а) зориулалтын тасалгаа руу орж,
- б) ганцаарчлан, нууцаар санал өгнө:
 - намын төлөөх саналыг тэмдэглэхдээ, сонгохыг хүсч буй намынхаа нэрний өмнөх дугуй дээр зөв гэсэн тэмдэглэгээ тавьж сонгох намаа тэмдэглэнэ;

²⁴⁴ <https://www.parliament.gov.gy/about-parliament/history-of-parliament>

²⁴⁵ Electoral Act, 1993. <https://www.legislation.govt.nz/act/public/1993/0087/latest/DLM307519.html>

²⁴⁶ Сонгуулийн хууль. 1993 он. №87, 6 дугаар бүлэг, 168 дугаар зүйл.

* Сонгуулийн ерөнхий тойрог гэдэг нь Маоригийн сонгуулийн тойргоос бусад тойргийг ойлгоно.

- нэр дэвшигчийн төлөөх саналыг тэмдэглэхдээ, тухайн тойрогт нэр дэвшигчдийн хэнд нь өгөхийг хүсч буй тухайн нэр дэвшигчийн нэрний өмнөх дугуй дээр зөв гэсэн тэмдэглэгээ хийнэ.

168.2.Саналын хуудсанд зөвхөн намын төлөөх санал, эсхүл зөвхөн нэр дэвшигчийн төлөөх санал байх ба энэ зүйлийн 3.1 дэх хэсгийн оронд дагаж мөрдөнө.

168.5.Сонгогч бүр зориулалтын тасалгааг орхин гарахаас өмнө, доторх агуулгыг нь үзэх боломжгүйгээр саналын хуудсыг нугалан, нугалаастай нь саналын хайрцагт хийнэ.

Санал тоолох, суудал хуваарилах: Шинэ Зеландын Сонгуулийн хуулийн 6 дугаар бүлгийн “Саналын урьдчилсан тооллого”, “Албан ёсны саналын тооллого болон үр дүнг зарлах”, “Дахин тоолох” гэсэн дэд бүлгүүдээр санал тоолох процесс, тооллогын комисс түүнийг батлах журам, санал хуудсыг зөв тоолж буй эсэхэд хяналт тавих ажиллагааг нэг бүрчлэн зохицуулсан байна.

Хуулийн “Саналын урьдчилсан тооллого”, “Албан ёсны саналын тооллого болон үр дүнг зарлах”, “Дахин тоолох” гэсэн дэд бүлгүүдээр санал тоолох процесс, тооллогын комисс түүнийг батлах журам, саналын хуудсыг зөв тоолж буй эсэхэд хяналт тавих ажиглагчийн үйл ажиллагааг нэг бүрчлэн зохицуулсан байна. Түүнчлэн санал дахин тоолох үндэслэл, журам, тооллогын комиссын талаар нэг бүрчлэн зохицуулсан байна. Тухайлбал, дахин тооллогыг зөв явуулж буй эсэхийг хянах болон суудлын жагсаалтын хуваарилах талаар дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

183-р зүйл: Дахин тооллогыг нягтлах болон суудлын жагсаалтыг хуваарилах

1. Аливаа сонгуулийн тойрогт нэр дэвшигч энэ хуулийн 180 дугаар зүйлийн 1-т заасны дагуу сонгуулийн тойрог дахь саналын хуудсыг дахин тоолох хүсэлт гаргасан бол нэг болон түүнээс дээш хөндлөнгийн ажиглагч байлцуулахаар томилно.

2. Аливаа улс төрийн нам:

- а) Энэ хуулийн 180 дугаар зүйлийн 2-т зааснаар сонгуулийн тойргийн намын төлөөх саналыг дахин тоолуулахаар хүсэлт гаргасан бол,
- б) Энэ хуулийн 181 дүгээр зүйлийн 1-т зааснаар сонгуулийн бүх тойргийн намын төлөөх саналыг дахин тоолуулахаар хүсэлт гаргасан бол дахин тооллого хийлгүүлэхээр 1 болон түүнээс дээш хөндлөнгийн ажиглагч томилно.

3. Намын төлөөх саналтай холбоотойгоор саналын хуудасны хэсэгт бүртгэгдсэн улс төрийн аль ч нам 1 ба түүнээс дээш хөндлөнгийн ажиглагч томилж болох ба энэ тухайгаа энэ хуулийн 191-193 дугаар зүйлд заасны дагуу Сонгуулийн хорооноос суудал хуваарилах үед танилцуулна.

4. Хөндлөнгийн ажиглагч бүр энэ хуулийн холбогдох заалтад заасан ёсоор батлагдаж, хуулиар зөвшөөрөгдөхөөс өмнө Сонгуулийн комиссар, Сонгуулийн хорооны ажилтан, эвийн шүүгч, эсхүл солисторын өмнө тунхаглал гаргана.

5. Суудлын жагсаалтыг хуваарилах үед улс төрийн нам нь хөндлөнгийн ажиглагчаар нэгээс дээш гишүүнийг томилсон тухай танилцуулах бол улс төрийн намын зөвхөн нэг хөндлөнгийн ажиглагч байх, эсхүл Сонгуулийн хорооны зөвшөөрлийг авсан бол нэгээс дээш ажиглагчийг хэдийд ч томилж болно.

6. Хөндлөнгийн ажиглагчийн талаарх энэхүү заалтыг нэр дэвшигч хэрэгжүүлэхгүй.

7. Тооллогын комиссын гишүүнийг энэхүү заалтын дагуу факсаар томилж болно.

Суудал хэрхэн хуваарилах талаарх хуулийн зохицуулалтыг багцлан үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Хэрэв намаас сонгогдсон гишүүдийн тоо нь тухайн намын авсан саналын дагуу тухайн намд олгогдсон тооны эрхэнд хүрэхгүй бол гишүүний тоог гишүүдийн жагсаалт дахь дараагийн гишүүнээр нөхөж гүйцээх буюу үүнийг “tops up” гэж нэрлэнэ. Өөрөөр хэлбэл, пропорционал системээр санал хураах “намын төлөөх санал” хураалтын үед энэхүү зарчим ашиглагдана.
- Шинэ Зеландын сонгуулийн системийн дагуу суудал нь эхлээд тойрогт ялсан нэр дэвшигчдийн дунд хуваарилагддаг.
- Түүний дараа намууд нь “намын төлөөх санал”-ын хувьтай ойролцоо хувиар парламентад суудал эзэлдэг. Хэрэв нам нь сонгуулийн тойрогт “намын төлөөх санал”-ын дагуу авсан суудлаас илүү суудал авсан бол тухайн илүү суудлаа хадгалж болох бөгөөд үүнийг нь “overhang seats”²⁴⁷ гэж нэрлэнэ.

ХБНГУ

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд “Герман Улсын Бундестагийн гишүүнийг бүх нийтийн, шууд, чөлөөт, тэгш болон нууц сонгуулиар сонгоно. Бундестагийн гишүүд нийт ард түмний төлөөлөгч бөгөөд аливаа чиглэл, даалгаврыг биелүүлэх үүрэггүй, гагцхүү өөрийн итгэл үнэмшилд захирагдана...” хэмээн холбооны сонгуулийн эрхийн үндсэн зарчмыг хуульчилжээ.

Сонгуулийн тухай Холбооны хуульд²⁴⁸ Германы Бундестагийн сонгуулийг холимог системээр явуулахыг хуульчилжээ. Германы Бундестаг нийт 598 депутаттай ба эдгээрээс 299 депутатыг нэг мандаттай сонгуулийн тойргоос, үлдсэн 299 депутатыг улс төрийн намуудын нэрсийн жагсаалтаар сонгодог байна.

Санал гаргах: Сонгуулийн энэхүү системийн дагуу сонгогч тус тусдаа, бие даасан, бие биенээсээ харилцан үл хамаарах хоёр саналыг гаргана. Нэгдүгээр санал нь сонгуулийн тойргоос сонгогдож байгаа нэр дэвшигчийн төлөө өгөх бол хоёрдугаар саналыг намын нэрсийн жагсаалтад байгаа аль нэг намын төлөө өгнө.

Сонгуулийн тойрогт буюу мажоритар хувилбараар сонгогдож байгаа тойрогт аль олон нэгдүгээр санал авсан нэр дэвшигч сонгогдоно.

Хоёрдугаар саналыг сонгогч 16 Холбооны муж улс тус бүрийн улс төрийн намуудаас гаргасан намын жагсаалтаас аль нэг намыг сонгоно. Энэхүү улс төрийн намаас гаргасан жагсаалтад бичигдсэн нэр дэвшигчдийн нэрс, хатуу тогтоосон дэс дарааллыг сонгогч өөрчлөх эрхгүй.

Саналын дүнг нэгтгэх: Сонгуулийн дараа сонгогчдын өгсөн хоёрдугаар саналын дүнг үндэслэн Холбооны сонгуулийн комисс нь сонгуульд орсон улс төрийн намуудад Германы Бундестагийн суудлыг хуваарилах ба энэ нь сонгуулийн дүнд тодорхойлох үүрэг гүйцэтгэдэг.

Саналын хуудас нь дараах агуулгатай байдаг. Үүнд:

- Сонгуулийн тойргийн хувьд – тухайн тойрогт нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн нэр, хэрэв намаас нэрийг нь дэвшүүлж байгаа бол тухайн намынх нь нэр, хэрэв тусгай тэмдэгтэй бол энэхүү тэмдэг, үгүй бол зохих томьёолсон тэмдэг;

²⁴⁷ <http://www.ipu.org/parline-e/reports/2233.htm>

²⁴⁸ Federal Elections Act, 1993. §1(1)

https://www.bundeswahlleiter.de/en/dam/jcr/4ff317c1-041f-4ba7-bbbf-1e5dc45097b3/bundeswahlgesetz_engl.pdf

- Намын нэрсийн жагсаалтын хувьд - намын нэр, хэрэв тусгай тэмдэгтэй бол энэхүү тэмдэг, мөн тухайн намын нэрсийн жагсаалтын эхний 5 нэр дэвшигчийн нэр бичигдсэн байна.²⁴⁹

2.3.Дэлхийн улс орнуудын сонгуулийн тогтолцоо

Дэлхийн 192 улсын парламентуудын хувьд (нэг танхимт парламент болон доод танхимуудын хувьд) дараах сонгуулийн тогтолцоог хэрэглэж байна.²⁵⁰

- Сонгуулийн холимог тогтолцоотой – 32 улс (16.7%);
- Олонхыг төлөөлөх тогтолцоотой – 65 улс (34.8%);
- Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой – 77 улс (41.1%);
- Бусад – 6 улс (3.2%);
- Шууд сонгууль явуулдаггүй – 7 улс (3.7%)
- Мэдээлэл байхгүй – 5 улс байна.

Хүснэгт 7. Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоо (парламентын нэг танхимт болон доод танхимуудын хувьд)

Сонгуулийн тогтолцоо	Улсын тоо, эзлэх хувь	Сонгуулийн тогтолцооны хувилбар	Улсын тоо, сонгуулийн хувилбарт эзлэх хувь	Улсын нэр
Сонгуулийн холимог тогтолцоотой	32 улс (16.7%)	Холимог хувь тэнцүүлсэн	8 улс	Жибути, ХБНГУ, Унгар, Мексик, Шинэ Зеланд, БНСУ, Тажикистан, Тайланд
		Зэрэгцээ	18 улс	Андорра, БНКонго Улс, Египет, Гүрж, Итали, Япон, Йордан, Литва, Мавритани, Нижер, Умард Македон, Панам, Филиппин, ОХУ, Сенегал, Сейшелийн арлууд, Украин, Венесуэл
		Мэдээлэл байхгүй	6 улс	Боливи, Гайана, Лесото, Ливи, Мадагаскар, Непал
Олонхыг төлөөлөх тогтолцоотой	65 улс (34.8%)	Альтернатив саналын	2 улс	Австрали, Папуа Шинэ Гвиней
		Багц саналын	2 улс	Этиоп, Монгол
		Харьцангуй олонхын	47 улс	Антигуа ба Барбуда, Азербайжан, Бахам, Бангладеш, Барбадос, Белиз, Бутан, Ботсвана, Канад, Габон, Гамби, Гана, Гренада, Энэтхэг, Ямайка, Кени, Кирибати, Лаос, Либер, Малайз, Мальдив, Маршаллын арлууд, Маврики, Мьянмар, Науру, Нигери, Пакистан, Палау, Катар, Сент Китс ба Невис, Сент Люсиа, Сент Винсент ба Гренадин, Самоа, Сьерра Леон, Сингапур, Соломоны арлууд, Тонга, Тринидад ба Тобаго, Туркменистан, Тувалу, Уганда, ИБУИНХУ, Танзани, АНУ, Йемен, Замби, Зимбабве
		Хоёр шатлалтай саналын	12 улс	Бахрейн, Беларусь, БНАСАУ, Вьетнам, Гаити, Иран, Төв Африкийн БНУ, Коморос, Конго, Эсватини, Франц, Узбекистан
		Мэдээлэл байхгүй	2 улс	Кот д'Ивуар, Микронез

²⁴⁹ § 30 Избирательные бюллетени, 2

²⁵⁰ (IPU, 2022)

https://data.ipu.org/compare?field=chamber%3A%3Afield_electoral_system&structure=any_lower_chamber#map

Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой	77 улс (41.1%)	Жагсаалтын	74 улс	Албани, Алжир, Ангол, Аргентин, Армени, Австри, Бельги, Бенин, Босни-Херцеговин, Бразил, Болгар, Бурунди, Кабо Верде, Камбож, Камерун, Чили, Колумби, Коста Рика, Хорват, Кипр, Чех, Дани, Доминик, Доминиканы БНУ, Эквадор, Эль Сальвадор, Экваторын Гвиней, Эстони, Фижи, Финланд, Грек, Гватемала, Гвиней-Бисау, Хондурас, Исланд, Индонез, Израил, Казахстан, Киргиз, Латви, Ливан, Лихтенштайн, Люксембург, Монако, Монтенегро, Марокко, Мозамбик, Намиби, Нидерланд, Никарагуа, Норвег, Парагвай, Перу, Польш, Португал, Румын, Руанда, Сан Марино, Сан Томе ба Принсип, Серб, Словак, Словени, Өмнөд Африк, Испани, Шри Ланка, Суринам, Швед, Швейцар, Зүүн Тимор, Того, Тунис, Турк, Уругвай, Вануату
		Шилжих бололцоотой нэг саналын	2 улс	Ирланд, Мальта
		Мэдээлэл байхгүй	1 улс	Молдова
Бусад	6 улс (3.2%)	Харьцангуй олонхын болон Багц саналын	1 улс	Малави
		Үл шилжих нэг санал	5 улс	Афганистан, Куба, Ирак, Кувейт, Оман
Шууд сонгууль явуулдаггүй	7 улс (3.7%)	-	-	Бруней, БНХАУ, Эритрей, Саудын Араб, Сомали, Өмнөд Судан, АНЭУ
Мэдээлэл байхгүй	5 улс	-	-	Буркина Фасо, Чад, Гвиней, Мали, Сири

Зураг 3. Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоо



Эх сурвалж: IPU

Парламентын засаглалтай улс орнуудын хувьд судалгаанд авагдсан нийт 76 улсаас:

- Сонгуулийн холимог тогтолцоотой – 12 улс (15.8%);
- Олонхыг төлөөлөх тогтолцоотой – 26 улс (34.2%);
- Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой – 37 улс (48.7%);
- Бусад – 6 улс (1.3%) байна.

Хүснэгт 8. Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоо, засаглалын хэлбэрээр

Сонгуулийн холимог тогтолцоотой	Олонхыг төлөөлөх тогтолцоотой	Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой	Бусад	Шууд сонгууль явуулдаггүй
Парламентын засаглалтай - 76 улс				
12 улс	26 улс	37 улс	1 улс	-
Андорра, Гүрж, ХБНГУ, Унгар, Итали, Япон, Лесото, Непал, Шинэ Зеланд, Умард Македон, Тайланд, Украин	Антигуа ба Барбуда, Австрали, Бахам, Бангладеш, Барбадос, Белиз, Ботсвана, Канад, Этиоп, Гренада, Энэтхэг, Ямайка, Кирибати, Малайз, Маврики, Монгол, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Сент Китс ба Невис, Сент Люсиа, Сент Винсент ба Гренадин, Самоа, Соломоны арлууд, Тринидад ба Тобаго, Тувалу, ИБУИНХУ	Албани, Армени, Бельги, Босни-Херцеговин, Болгар, Кабо Верде, Камбож, Хорват, Чех, Дани, Доминик, Эстони, Фижи, Финланд, Грек, Исланд, Ирланд, Израил, Латви, Лихтенштайн, Люксембург, Мальта, Монако, Нидерланд, Норвег, Португал, Молдова, Сан Марино, Серби, Словак, Словени, Өмнөд Африк, Испани, Швед, Швейцар, Зүүн Тимор, Вануату	Ирак	
Ерөнхийлөгчийн засаглалтай – 46 улс				
7 улс	15 улс	21 улс	2 улс	1 улс
Боливи, Мексик, Панам, Филиппин, БНСУ, Тажикистан, Венесуэл	Гамби, Гана, Гаити, Кени, Либер, Мальдив, Маршаллын арлууд, Микронез, Нигери, Палау, Сьерра Леон, Туркменистан, Уганда, Танзани, АНУ	Аргентин, Бенин, Бразил, Бурунди, Чили, Колумби, Коста Рика, Кипр, Доминиканы БНУ, Эквадор, Эль Сальвадор, Гватемала, Гвиней-Бисау, Хондурас, Индонез, Киргиз, Никарагуа, Парагвай, Перу, Суринам, Уругвай	Афганистан, Малави	Эритрей
Холимог засаглалтай – 45 улс				
11 улс	15 улс	18 улс	-	1 улс
БНКонго Улс, Жибути, Египет, Гайана, Литва, Мадагаскар, Мавритани, Нижер, ОХУ, Сенегал, Сейшелийн арлууд	Азербайжан, Беларусь, Төв Африкийн БНУ, Коморос, Конго, Скот д'Ивуар, Франц, Габон, Иран, Мьянмар, Науру, Сингапур, Узбекистан, Замби, Зимбабве	Алжир, Ангол, Австри, Камерун, Экваторын Гвиней, Казахстан, Ливан, Монтенегро, Мозамбик, Намиби, Польш, Румын, Руанда, Сан Томе ба Принсип, Шри Ланка, Того, Тунис, Турк		Сомали
Хаант засаглалтай – 12 улс				
1 улс	5 улс	1 улс	2 улс	3 улс
Йордан	Бахрейн, Бутан, Эсватини, Катар,	Марокко	Кувейт, Оман	Бруней, Саудын Араб,

	Тонга			АНЭУ
Нэг намын засаглалтай – 5 улс				
-	3 улс	-	1 улс	1 улс
	БНАСАУ, Лаос, Вьетнам		Куба	БНХАУ

2.3.1. Сонгуулийн тогтолцоог Үндсэн хуульдаа тусгасан орнууд

Парламентын сонгуулийн үндсэн зарчмыг тогтоосон гол эх сурвалж нь тухайн улсын Үндсэн хууль байдаг. Тэр дундаа сонгуулийн тогтолцооны талаар гадаад орнуудын Үндсэн хуулиар зохицуулсан хэм хэмжээ нь харилцан адилгүй байдаг.

Гэхдээ сонгуулийн талаарх илүү нарийвчилсан зохицуулалтыг хууль тогтоох байгууллагаас баталсан сонгуулийн тухай хууль, эсхүл хууль тогтоох байгууллагын танхимаас баталсан регламентууд байдаг.

Дэлхийн 83 улсын Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог тогтоосон байна. Үүнд, олонхыг төлөөлөх тогтолцоотой 34 улс, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой 34 улс, холимог тогтолцоотой 15 улс тус тус орсон байна.²⁵¹

Хүснэгт 9. Үндсэн хуульдаа парламентын сонгуулийн тогтолцоог тогтоосон орнуудын жагсаалт

	Нэг танхимтай	Хоёр танхимтай
Олонхыг төлөөлөх тогтолцоо <i>Нэг танхимтай – 16 улс</i> <i>Хоёр танхимтай – 18 улс</i>	Азербайжан, Вануату, Вьетнам, Куба, Мальдив, Маршаллын Арлууд, Науру, Невис, Папуа Шинэ Гвиней, Самоа, Сент-Винсент ба Гренадин, Соломоны Арлууд, Тувалу, Туркменистан, Хойд Солонгос, Хятад	Австрали, Антигуа ба Барбуда, АНУ, Барбадос, Белиз, Бутан, Гаити, Гренада, Канад, Малайз, Палау, Сент Люсиа, Тринидад ба Тобаго, Фижи, Филиппин, Чех, Энэтхэг, Ямайка
Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо <i>Нэг танхимтай – 20 улс</i> <i>Хоёр танхимтай – 14 улс</i>	Албани, Зүүн Тимор, Исланд, Киргиз, Коста-Рика, Лаос, Латви, Лихтенштайн, Люксембург, Никарагуа, Норвег, Панама, Перу, Португал, Сальвадор, Суринам, Финланд, Швед, Шри Ланка, Эстони	Австри, Аргентин, Бельги, Боливи, Бразил, Доминиканы БНУ, Испани, Колумби, Нидерланд, Парагвай, Польш, Тайланд, Уругвай, Швейцар
Холимог тогтолцоо <i>Нэг танхимтай – 8 улс</i> <i>Хоёр танхимтай – 7 улс</i>	Венесуэл, Гватемал, Хондурас, Гүрж, Микронез, Шинэ Зеланд, Өмнөд Солонгос, Эквадор	Камбож, Мексик, Мьянмар, Пакистан, Тайланд, Чили, Япон

Тайлбар: Судалгаанд парламентын хоёр танхимтай орнуудын хувьд доод танхимыг сонгосон болно.

²⁵¹ И.Б.Борисов, А.Г.Головин, & А.В.Игнатов. (2015). *Выборы в мире: Избирательные системы*. Санкт-Петербург: Российский общественный институт избирательного права, Избирательная комиссия ленинградской области.

Хүснэгт 10. Сонгуулийн хүчин зүйлийн нөлөөлөл

Сонгуулийн тогтолцооны нөлөөлөл				Сонгогч саналаа гаргах чиглэлийн нөлөөлөл			
Олонхыг төлөөлөх	Хувь тэнцүүлэн хуваарилах	Холимог	Намын нэрийн жагсаалтад	Нэр дэвшигчийн нэрийн жагсаалтад	Тухайлсан нэр дэвшигчид		
					Олонхыг төлөөлөх тогтолцооны	Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны	
ДАВУУ ТАЛУУД							
Том намуудад давуу тал үүсгэдэг. Төрийн эрхийг том намууд тогтвортой барих нөхцөл бүрдүүлнэ.	Парламент олон нам суудал авах нөхцөл бүрдүүлнэ. Аливаа үзэл бодол, үнэт зүйл нэг танхимд хэлэлцэгдэх боломж бүрдүүлнэ.	Олонхыг төлөөлөх, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны давуу талуудыг товойлгох, дутагдалтай талуудыг хязгаарлах бололцоо бүрдүүлнэ. Том улсуудад болон үндэсний асуудал тавигддаг улсуудад тохиромжтой.	Жижиг намуудад суудал ногдох боломжийг илүү бүрдүүлнэ. Хувь тэнцүүлсэн шинж улам тодрох, санал адилжинтэй байх, санал өгөх, тооцоход хялбар, хүйсийн тэгш байдал, үндэстний асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдүүлнэ.	Намын нээлттэй нэрийн жагсаалт байдгаараа сонгогчид илүү ойлгомжтой. Жижиг намуудад суудал ногдох боломж давуутай.	Цөөн намын нөлөөг нэмэгдүүлж, олонхын Засгийн газар бүрдэж, Намын доторх нэр дэвшигчдийн сонгогдох дараалалд сонгогч нөлөөлөх боломж бүрдүүлнэ.	Парламентад хэд хэдэн нам орж, ялангуяа жижиг нам суудал авах магадлал өснө. Намын доторх нэр дэвшигчдийн сонгогдох дараалалд сонгогч нөлөөлөх боломж бүрдүүлнэ.	
ДУТАГДАЛТАЙ ТАЛУУД							
Сонгогчдын саналын багагүй хэсэг парламентад тусгалаа олохгүй байх сул талтай.	Засгийн газраа намууд нэгдэж байгуулах, хариуцлага хүлээх эзэн тодорхойгүй болох, Засгийн газар огцрох магадлал өснө.	Бүс нутгийн болон үндэсний хэмжээний асуудлын зааг ялгарч, Парламентад өөр өөр ашиг сонирхол зөрчилдөх магадлалтай.	Орон нутаг, парламентын гишүүдийн амьд холбоо сулрах, намын лидерүүдийн давамгайл байдал тогтох, эсхүл нөлөө багатай, үгнээс гардаггүй хүмүүсийг жагсаалтаа оруулах, намын доторх эрүүл санал бодлыг үл хүндэтгэх талтай.	Парламент олон намын оролцоотой болж, Засгийн газрыг намууд хамтарч бүрдүүлэх тохиолдол элбэг байдаг.	Сонгогчийн өгсөн саналын нэлээд хэсэг нь парламентад тусгалаа олохгүй гадна талд нь үлддэг.	Намын нээлттэй нэрсийн жагсаалтаас сонголт хийх нь Сонгуульд оролцож байгаа нам бүрээр нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт гаргаж сонгогч бүр түүнээс сонголт хийхэд төвөгтэй.	

Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны босго тогтоох аргуудын нөлөөлөл				Босгыг урьдчилан тогтоохын нөлөөлөл			Тойргийн хэмжээ, тооны нөлөөлөл		
Харегийн арга	Сент Лазюгийн арга	Друлийн арга	Империял арга	Өндөр босго	Бага босго	Улс 1 тойрог /том/	Олон мандаттай цөөн тойрог	Цөөн мандаттай олон тойрог	
ДАВУУ ТАЛУУД									
Жижиг нам парламентад суудал авах магадлалыг өсгөнө.	Жижиг намууд парламентад суудал авах магадлалыг өсгөнө.	Томоохон намуудын суудлын тоог нэмэгдүүлэх магадлал илүү.	Томоохон намуудын суудлын тоог нэмэгдүүлэх магадлал бүр илүү.	Томоохон намууд үүнийг сайшаан дэмжинэ.	Жижиг намуудын парламентад суудал авах магадлалыг өсгөнө.	Намуудад суудал хувь тэнцүүлэн хуваарилах шинж чанарыг өсгөнө.	Намуудад суудал хувь тэнцүүлэн хуваарилах шинж чанарыг өсгөнө.	Нэр дэвшигчдийг сонгогчтой илүү ойр дотно байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.	
ДУТАГДАЛТАЙ ТАЛУУД									
Томоохон намууд энэ аргаас аль болох зайлсхийнэ.	Томоохон намууд энэ аргаас аль болох зайлсхийнэ.	Жижиг намуудад төдийлөн таатай биш.	Жижиг намууд энэ аргаас аль болох зайлсхийнэ.	Жижиг намууд, бие даасан нэр дэвшигчид суудал авах магадлалыг бууруулна.	Томоохон намуудын жижиг намууд хуваалцана.	Парламентын гишүүд орон нутгийн хоорондын харилцаа суларна.	Сонгуулийн газар зүйн зургийг тусгайлан гаргаж, засаг захиргааны олон нэгж 1 тойрогт хамрагдана.	Намуудын суудал хуваарилалт олонхыг төлөөлөх зарчимд илүү ойртож сонгогчийн санал парламентад тусгалаа олохгүй байх магадлалыг өсгөнө.	



2.4.Ротацын журмаар парламентын гишүүдийг сэлгэдэг зарим орны туршлага

Судалгаанд авагдсан 60 орноос нийт 14 улс парламентын гишүүдийг Ротацын журмаар шинэчилдэг ба эдгээрээс 4 улс нь парламентын засаглалтай, 5 улс нь ерөнхийлөгчийн засаглалтай, 5 улс нь холимог засаглалтай байна.²⁵²

Хүснэгт 11. Ротацын журмаар парламентын гишүүдийг сэлгэдэг улсын тоо, эзлэх хувь, засаглалын хэлбэрээр

Засаглалын хэлбэр	Судалгаанд авагдсан улсын тоо	Ротацын зарчим хэрэглэдэг улсын тоо, эзлэх хувь
Парламентын засаглалтай	31 улс	4 улс (13%)
Ерөнхийлөгчийн засаглалтай	9 улс	5 улс (56%)
Холимог засаглалтай	17 улс	5 улс (29%)
Бусад	3 улс	-
Нийт	60 улс	14 улс (23%)

Судалгаанд авагдсан улсуудын хувьд 2 танхимтай улсуудын дээд танхимуудад Ротацын журам түгээмэл хэрэглэгдэж байна. Судалгаанд 1 танхимтай – 33 улс, 2 танхимтай – 27 улс хамрагдсанаас 2 танхимтай 27 улсын 14 улсын дээд танхим буюу 52% нь Ротацын журмаар шинэчлэгддэг бол зөвхөн 1 улс (Аргентин)-д парламентын дээд болон доод танхимын гишүүд нь Ротацын журмаар шинэчлэгддэг байна.

Хүснэгт 12. Ротацын журмаар парламентын гишүүдийг сэлгэдэг туршлага

№	Улсын нэр	Сонгуулийн тогтолцоо	Танхимын тоо	Парламентын гишүүдийн тоо	Ротацын
ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ					
1.	Австрали	Доод танхим – мажоритар, Дээд танхим - пропорционал	2	Дээд танхим - 76 Доод танхим - 151	Сенатын 36 гишүүнийг 3 жилийн хугацаагаар, 49 гишүүнийг 6 жилийн хугацаагаар сонгодог.
2.	Албани	пропорционал	1	140	үгүй
3.	Бангладеш	мажоритар	1	350	үгүй
4.	Грек	пропорционал	1	300	үгүй
5.	Исланд	пропорционал	1	63	үгүй
6.	Итали	холимог	2	Дээд танхим - 321 Доод танхим - 630	үгүй
7.	Их Британи	Доод танхим - мажоритар	2	Дээд танхим - 763 Доод танхим - 650	үгүй
8.	Камбож	Доод танхим - пропорционал	2	Дээд танхим – 61 Доод танхим - 125	үгүй
9.	Канад	Доод танхим - мажоритар	2	Дээд танхим - 105 Доод танхим - 338	үгүй
10.	Латви	пропорционал	1	100	үгүй
11.	Маврики	мажоритар	1	70	үгүй

²⁵² Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2015). *Парламентын засаглалтай орнуудын сонгуулийн тогтолцоо ба Ротацын журмаар парламентын гишүүдийг сэлгэдэг зарим орны туршлага*. УБ: Судалгааны эмхэтгэл XX боть, СТ-15/211.

12.	Малайз	Доод танхим - мажоритар	2	Дээд танхим - 70 Доод танхим - 223	үгүй
13.	Молдова	пропорционал	1	101	үгүй
14.	Монтенегро	пропорционал	1	81	үгүй
15.	Өмнөд Африк	Доод танхим - пропорционал	2	Дээд танхим - 90 Доод танхим - 400	үгүй
16.	Португал	пропорционал	1	230	үгүй
17.	Серби	пропорционал	1	250	үгүй
18.	Словак	пропорционал	1	150	үгүй
19.	Словени	Доод танхим - пропорционал	2	Дээд танхим - 40 Доод танхим - 90	үгүй
20.	Украин	холимог	1	450	үгүй
21.	Умард Македон	холимог	1	123	үгүй
22.	Унгар	холимог	1	199	үгүй
23.	Финланд	пропорционал	1	200	үгүй
24.	ХБНГУ	Доод танхим - холимог	2	Дээд танхим - 69 Доод танхим - 736	үгүй
25.	Чех	Дээд танхим - мажоритар, Доод танхим - пропорционал	2	Дээд танхим - 81 Доод танхим - 200	Дээд танхимын гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байх ба 2 жил тутамд гишүүдийн 1/3 нь сэлгээний журмаар шинэчлэгдэн сонгогддог.
26.	Швейцар	пропорционал	2	Дээд танхим - 46 Доод танхим - 200	үгүй
27.	Шинэ Зеланд	холимог	1	120	үгүй
28.	Энэтхэг	Доод танхим - мажоритар	2	Дээд танхим - 245 Доод танхим - 545	Дээд танхимын гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил, 2 жил тутамд 1/3 нь шинэчлэгдэн сонгогддог.
29.	Эстони	пропорционал	1	101	үгүй
30.	Этиоп	Доод танхим - мажоритар	2	Дээд танхим - 112 Доод танхим - 547	үгүй
31.	Япон	Дээд, доод танхим - холимог	2	Дээд танхим - 245 Доод танхим - 465	Дээд танхимын гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил, 3 жил тутамд 1/2 нь шинэчлэгдэн сонгогддог.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛТАЙ

1.	АНУ	Дээд, доод танхим - мажоритар	2	Дээд танхим - 100 Доод танхим - 435-аас ихгүй	Дээд танхимын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил байх ба гишүүдийн 1/3 нь 2 жил тутамд шинээр сонгогддог.
2.	Аргентин	Дээд танхим - мажоритар, Доод танхим - пропорционал	2	Дээд танхим - 72 Доод танхим - 257	Дээд танхимын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил байх ба гишүүдийн 1/3 нь 2 жил тутамд, доод танхимын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил бөгөөд гишүүдийн 1/2 нь 2 жил тутамд шинээр сонгогддог.
3.	Гаити	Дээд, доод танхим - мажоритар	2	Дээд танхим - 30 Доод танхим - 119	Дээд танхимын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил байх ба гишүүдийн 1/3 нь 2 жил тутамд шинээр сонгогддог.
4.	БНСУ	холимог	1	300	үгүй
5.	Чили	Дээд, доод танхим - пропорционал	2	Дээд танхим - 50 Доод танхим - 155	Дээд танхимын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 8 жил байх ба гишүүд ээлжлэн 4 жил тутамд шинээр сонгогддог.
6.	Индонез	пропорционал	1	575	үгүй

7.	Тажикистан	Доод танхим - холимог	2	Дээд танхим - 33 Доод танхим - 63	үгүй
8.	Филиппин	Доод танхим - холимог	2	Дээд танхим - 24 Доод танхим - 304	үгүй
9.	Бразил	Дээд танхим - мажоритар, Доод танхим - пропорционал	2	Дээд танхим - 81 Доод танхим - 594	Дээд танхимын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 8 жил байх ба гишүүдийн 3/1 болон 3/2 нь 4 жил тутамд шинээр сонгогддог.
ХОЛИМОГ ЗАСАГЛАЛТАЙ					
1.	Австри	Доод танхим - пропорционал	2	Дээд танхим - 64 Доод танхим - 183	үгүй
2.	Алжир	Доод танхим - пропорционал	2	Дээд танхим - 144 Доод танхим - 407	Дээд танхимын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил, 3 жил тутамд 50% нь шинэчлэн сонгогддог.
3.	Ангол	пропорционал	1	220	үгүй
4.	Армени	пропорционал	1	107	үгүй
5.	Босни-Херцеговин	Доод танхим - пропорционал	2	Дээд танхим - 15 Доод танхим - 42	үгүй
6.	Египет	Дээд доод танхим - холимог	2	Дээд танхим - 300 Доод танхим – 450-аас багагүй	Дээд танхимын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил, 3 жил тутамд 50% нь шинэчлэн сонгогддог.
7.	Казахстан	пропорционал	2	Дээд танхим – 49 Доод танхим - 107	Сенатын депутатын бүрэн эрхийн хугацаа 6 жил бөгөөд 3 жил тутам депутатуудын тал хувийг шинээр сонгож, томилдог.
8.	Литва	холимог	1	141	үгүй
9.	Мавритани	Доод танхим - холимог	2	Дээд танхим - 56 Доод танхим - 157	Дээд танхимын гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил, 2 жил тутамд 1/3 нь шинэчлэгдэн сонгогддог.
10.	Мадагаскар	Доод танхим - холимог	2	Дээд танхим - 33 Доод танхим - 151	үгүй
11.	ОХУ	Доод танхим - холимог	2	Дээд танхим – 170 Доод танхим - 450	үгүй
12.	Польш	пропорционал	2	Дээд танхим - 100 Доод танхим - 460	үгүй
13.	Румын	пропорционал	2	Дээд танхим - 136 Доод танхим - 330	үгүй
14.	Сингапур	мажоритар	1	104	үгүй
15.	Тунис	пропорционал	1	217	үгүй
16.	Турк	пропорционал	1	600	үгүй
17.	Франц	Дээд танхим - холимог, Доод танхим - холимог мажоритар	2	Дээд танхим – 348 Доод танхим - 577	Дээд танхимын гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байх ба 3 жил тутам гишүүдийн 1/2 нь сэлгээний журмаар шинэчлэгдэн сонгогддог.
БУСАД					
1.	Вьетнам	мажоритар	1	500	үгүй
2.	Марокко	пропорционал	2	Дээд танхим - 120 Доод танхим - 395	үгүй
3.	Хятад	-	1	3000	үгүй

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Монгол Улсын Үндсэн хууль (1992 он) ба Монгол Улсын их цаазын төслүүдийн (1991.VI.05, X.05, XI.07) харьцуулалт²⁵³

Тайлбар: -үг, өгүүлбэр шинээр нэмэгдсэнийг тод хараар (“bold”),
-үг, өгүүлбэрийг өөрчлөн найруулсныг доогуур зураасаар (“underline”),
-үг, өгүүлбэр хасагдсаныг дундуур зураасаар (“strikethrough”),
-зарчмын зөрүүтэй санал орхигдсон, өөрчлөлт орсон зэргийг тодруулав (“highlighting”) тус тус тэмдэглэв.

1-р төсөл	2-р төсөл	3-р төсөл	4-р төсөл	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ²⁵⁴
МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ ²⁵⁵ (Үндсэн хууль)	МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ ²⁵⁶ (Үндсэн хууль)	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ²⁵⁷ (Их цааз)	МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ ²⁵⁸	
УБХ-д өргөн барьсан хувь 1991.04.19	Ард түмнээр хэлэлцүүлсэн хувь 1991.06.05	УБХ-д өргөн барьсан хувь 1991.10.05	УБХ-аас АИХ-д өргөн барьсан хувь 1991.11.07	(Батлагдсан хувь) 1992.01.13
МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ. ТӨРИЙН ЭРХ МЭДЛИЙГ ХУВААРИЛАХ НЬ	МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛЫГ БАТАЛГАН БЭЭЖҮҮЛЭХ НЬ	МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ	МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ	МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ
I. Хууль тогтоох эрх мэдэл. Монгол Улсын Их хурал	НЭГ. Монгол Улсын Их хурал	НЭГ. Монгол Улсын Их Хурал	НЭГ. Монгол Улсын Их Хурал	НЭГ. Монгол Улсын Их Хурал
20 дугаар зүйл	ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ	Хорьдугаар зүйл	Хорьдугаар зүйл	Хорьдугаар зүйл
Монгол улсын төрийн дээд эрх мэдлийг Улсын Их Хуралд хадгална.	1. Монгол улсын төрийн дээд эрх мэдлийг Улсын Их Хуралд хадгална.	Хуулийн 3-р төслийн 20-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна: Монгол Улсад хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хэрэгжүүлнэ.	1. Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.	Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.
Монгол Улсын Их Хурал бол монголын ард түмний бүрэн эрхийг илэрхийлсэн, хууль тогтоох, хянан шалгах төлөөлөгчдийн дээд байгууллага мөн.	2. Монгол Улсын Их Хурал бол монголын ард түмний бүрэн эрхийг илэрхийлсэн, хууль тогтоох, хянан шалгах төлөөлөгчдийн дээд байгууллага мөн.	1. Монгол Улсын Их Хурал бол төрийн засаг /эрх/-ийг барих төлөөлөгчдийн дээд байгууллага мөн.		

²⁵³ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2015). *Монгол Улсын Үндсэн хууль (1992) болон Монгол Улсын Их цаазын төслүүдэд хэлэлцүүлгийн явцад орсон өөрчлөлтүүд*. УБ: Судалгааны эмхэтгэл XX боть, СТ-15/403.

²⁵⁴ “Ардын эрх” сонин, 1992.01.14, №9 /313/.

²⁵⁵ Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын архив, данс №1-91, 167-190 дэх тэл.

²⁵⁶ “Ардын эрх” сонин, 1991.06.05, №86 /158/.

²⁵⁷ Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын архив, данс №1-92, 165-199 дэх тал.

²⁵⁸ Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын архив, данс №1-92, 200-234 дэх тал.

Хуулийн төслийн 20-р зүйлд тусгагдсан байна.	Хуулийн төслийн 20-р зүйлд тусгагдсан байна.	Хуулийн төслийн 20-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна.	2. Монгол улсад хууль тогтоох эрх мэдлийг гэгцхүү Улсын Их Хурал хэрэгжүүлнэ.	Хуулийн төслийн 20-р зүйлд тусгагдсан байна.	Хуулийн төслийн 20-р зүйлд тусгагдсан байна.
21 дүгээр зүйл	Монгол Улсын Их Хурал нь нэг танхимтай байнгын ажиллагаатай байх бөгөөд 75 гишүүнээс бүрдэнэ.	ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ	1. Мөнгөн-Улсын Их Хурал нь нэг танхимтай байнгын ажиллагаатай байх бөгөөд 75 гишүүнээс бүрдэнэ.	Хорин нэгдүгээр зүйл	Хорин нэгдүгээр зүйл
Монгол Улсын Их Хурлын гишүүнийг иргэд саналаа нууцаар гаргаж 6 жилийн хугацаагаар сонгоно.	Монгол Улсын Их Хурлын гишүүнийг иргэд саналаа нууцаар гаргаж 6 жилийн хугацаагаар сонгоно.	2. Монгол Улсын Их Хурлын гишүүнийг Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ тэнэг, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж 6 жилийн хугацаагаар сонгоно.	2. Мөнгөн-Улсын Их Хурал нь нэг танхимтай байнгын ажиллагаатай байх бөгөөд 75 гишүүнээс бүрдэнэ.	Улсын Их Хурал 75 гишүүнээс бүрдэнэ.	1. Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна. 2. Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.
Монгол Улсын Их Хурлын Төргүүн даргаас бусад гишүүнийг хоёрны нэгийг гурван жил тутам шинэчлэн сонгож сэлбэнэ.	Монгол Улсын Их Хурлын гишүүнээр 25 нас хүрсэн Монгол улсын иргэнийг сонгоно.	3. Монгол Улсын Их Хурлын даргаас бусад гишүүнийг хоёрны нэгийг гурван жил тутам шинэчлэн сонгож сэлбэнэ.	3. Монгол Улсын Их Хурлын гишүүнээр 30 нас хүрсэн иргэнийг сонгож сэлбэнэ.	Улсын Их Хурлын нийт гишүүний хоёрны нэгийг 3 жил тутам шинэчлэн сонгож сэлбэнэ.	3. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын 25 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.
Монгол Улсын Их Хурлын гишүүнийг сонгуулийн зарчим, журмыг хуулиар тогтооно.	Монгол Улсын Их Хурлын гишүүнийг сонгуулийн зарчим, журмыг хуулиар тогтооно.	4. Монгол Улсын Их Хурлын гишүүнийг сонгуулийн зарчим, журмыг хуулиар тогтооно.	4. Монгол Улсын Их Хурлын гишүүнийг сонгуулийн зарчим, журмыг хуулиар тогтооно.	Улсын Их Хурлын гишүүнээр 30 нас хүрсэн иргэнийг сонгож сэлбэнэ.	4. Улсын Их Хурлын гишүүнээр 30 нас хүрсэн иргэнийг сонгож сэлбэнэ.

Хавсралт 2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүнгийн статистик мэдээлэл /1992-2020 он/²⁵⁹

№	Үзүүлэлт	1992 оны сонууль	1996 оны сонууль	2000 оны сонууль	2004 оны сонууль	2008 оны сонууль	2012 оны сонууль	2016 оны сонууль	2020 оны сонууль ²⁶⁰
1	Эрх зүйн зохицуулалт	УИХ-ын сонуулийн тухай хууль 1992.04.04	УИХ-ын сонуулийн тухай хууль 1992.04.04 /1996 онд өөрчлөлт орсон/	УИХ-ын сонуулийн тухай хууль 1992.04.04	УИХ-ын сонуулийн тухай хууль 1992.04.04	УИХ-ын сонуулийн тухай хууль 2005.12.29	УИХ-ын сонуулийн тухай хууль 2011.12.15	Сонуулийн тухай хууль 2015.12.25	УИХ-ын сонуулийн тухай хууль 2019.12.20
2	Сонуулийн тогтолцоо	Мажоритар (BV) ²⁶¹	Мажоритар ²⁶²	Мажоритар	Мажоритар	Мажоритар (BV)	Холбоог тогтолцоо	Мажоритар (FPTP)	Мажоритар (BV)
3	Хүн амын тоо	2 154 646	2 231 363	2 382 525	2 407 568	2 564 285	2 801 136	3 057 778	-
4	Сонуулийн насны хүний тоо	1 202 704	1 218 549	1 364 862	1 472 372	1 607 825	1 882 035	1 998 823	-
5	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогч	1 085 129	1 147 260	1 247 033	1 279 516	1 542 617	1 840 824	1 911 047	2 003 969
6	Санал өгсөн сонгогчийн	1 037 392	1 057 182	1 027 985	1 051 812	1 179 448	1 238 537	1 406 123	1 475 895
7	Хүчинтэй саналын тоо	95,6	92,1	82,4	82,2	76,46	67,28	73,58	73,64
8	Тойргийн болон аймаг, нийслэлийн сонуулийн хороо	97,5	1 010 157	1 002 554	1 036 578	1 160 326	1 238 537	1 406 123	-
9	Салбар, сум, дүүргийн сонуулийн хороо	94,0	95,6	97,5	98,5	98,38	100,00	100,00	-
10	Хэсгийн тоо	26	76	76	76	26	26	22	22
11	Мандатын тоо	357	332	330	338	332	333	339	337
12	Нийслэл	1 569	1 586	1 601	1 645	1 704	1 905	1 998	2070
13	Орон нутаг	24	20	20	20	20	28 нэрсийн жагсаалт 48 тойрог	28	24
14	Сонуульд оролцсон нам, эвсэл	52	56	56	56	56		48	52
15	Нийт нэр дэвшигч	8 нам, 2 эвсэл	5 нам, 3 эвсэл	13 нам, 3 эвсэл	7 нам, 1 эвсэл	12 нам, 1 эвсэл	11 нам, 2 эвсэл	12 нам, 3 эвсэл	13 нам, 4 эвсэл
16	Нам, эвслээс	293	302	602	244	356	544	498	606
17	Бие даан нэр дэвшигч	275	267	575	229	311	518	429	485*
18		18	35	27	15	45	26	69	121*
№	Үзүүлэлт	1992 оны сонууль	1996 оны сонууль	2000 оны сонууль	2004 оны сонууль	2008 оны сонууль	2012 оны сонууль	2016 оны сонууль	2020 оны сонууль

259 СЕХ. (2017). Монгол Улсын Их Хурлын сонгуулиудын дүн. <https://ges.gov.mn/uploads/IHsonguuli2012.pdf>

260 <https://www.gec.gov.mn/#gallery-1> <https://www.gec.gov.mn/blog/2862>
<https://qooo.mn/D0%83%D0%98%D0%A5-D1%81%D0%BE%D0%BD%D0%B3%D1%83%D0%BB%D1%8C-2020/>

37-52.

261 BV-олон мандагтай тойрог бүхий олонхыг төлөөлөх тогтол
262 Нэг мандагтай тойрог бүхий олонхыг төлөөлөх тогтолцоо

15	УИХ-д суудал авсан нам, эвсэл, бие даагчдын дэмжлэг авсан хувь ²⁶³	58.23%	53.80%	52.23%	54.90%	49.56%	41.10%	46.30%	45.99%
16	УИХ-д суудал авсан нам, эвсэл, бие даагчийн авсан саналын хувь ²⁶⁴	МАХН-56.9% Ардчилсан холбоо эвсэл- 17.5% МСДН-10.1% Бие даагч-3%	Ардчилсан холбоо эвсэл- 47% МАХН-40.5% МУНН-1.8%	МАХН-51.6% Ардчилсан холбоо эвсэл- 13.4% Эх Орон- МАШСН-11% ИЗН, МНН-ын эвсэл-3.6% Бие даагч- 2.9%	МАХН- 48.2% АН-44.3% БНН-1.4% Бие даагч- 3.4%	МАХН-43.1% АН-39.2% ИЗНН-3.5% Бие даагч-5.3%	АН-35.3% АН-31.3% Шударга ёс эвсэл-22.3% ИЗНН-5.51% Бие даагч- 5.6%	МАН-45.9% АН-33.7% МАХН-8.1% Бие даагч- 12.3%	МАН-44.9% АН-24.5% ТБЗ-8.1% ЗХЗ-5.3% Бие даагч- 8.7%
17	УИХ-ын суудлын хуваарилалт	МАХН-70 Ардчилсан холбоо эвсэл- 4 МСДН-1 Бие даагч-1	Ардчилсан холбоо эвсэл- 50 МАХН-25 МУНН-1	МАХН-72 Ардчилсан холбоо эвсэл- 1 Эх Орон- МАШСН-1 ИЗН, МНН-ын эвсэл-1 Бие даагч-1	МАХН-36 АН-36 БНН-1 Бие даагч-3	МАХН-45 АН-28 ИЗНН-1 Иргэний эвсэл-1 Бие даагч-1	АН-34 МАН-26 Шударга ёс эвсэл-11 ИЗНН-2 Бие даагч-3	МАН-65 АН-9 МАХН-1 Бие даагч-1	МАН-62 АН-11 ТБЗ-1 ЗХЗ-1 Бие даагч-1
18	УИХ дахь эмэгтэй гишүүдийн тоо ²⁶⁵	3	8	9	5	3	11	13	13
19	Сонгуулийн зардал	21.0 сая	270.0 сая	460.0 сая	696.6 сая	7.2 тэрбум	16.8 тэрбум	16.5 тэрбум	20.5 тэрбум
20	Сонгууль товлон зарласан болон явагдсан огноо	1992.4.13 1992.6.28	1996.4.16 1996.6.30	2000.4.17 2000.7.02	2004.4.12 2004.6.27	2008.5.14 2008.6.29	2012.4.28 2012.6.28	2016.4.08 2016.6.29	2020.01.30 2020.06.24

²⁶³ Гэрэлт-Од, Э. (2020). Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтоцоо: сонголт, туршлага. *Шинэ толь* №81.

²⁶⁴ Werner, P., & Luvсандemdev, S. (2008). Voters' Voices People's Perception of Mongolia's Political and Economic Transition as Reflected in Opinion Polls from 1995 to 2007. Ulaanbaatar.

Nohlen, D., Grotz, F., & Hartmann, C. (2002). *Elections in Asia and the Pacific A Data Handbook VOLUME II South East Asia, East Asia and the South Pacific*. Oxford University Press, IPU < http://archive.ipu.org/parline-e/reports/arc/2219_04.htm > ; <<https://www.electionguide.org/elections/id/1389/>> ; (Werner & Luvсандemdev, 2008)

²⁶⁵ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2012). *Монголын эмэгтэй улс төрчид*. УБ: Судалгааны эмхэтгэл XIII боть, СТ-12/403.

Хавсралт 3.УИХ-ын сонгуулийн тогтолцооны эрх зүйн зохицуулалт

Хуулийн нэр, батлагдсан огноо		Холбогдох зохицуулалт
№		
1	1992 онд батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай хууль ²⁶⁶ (1996 онд өөрчлөлт орсон)	8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг "Сонгуулийг нэг мандат бүхий тойргоор зохион байгуулж явуулна." 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг "Тухайн тойрогт хамгийн олон гэхдээ сонгогчдын 25, түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнд сонгогдсонд тооцно."
2	2005 онд батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай хууль ²⁶⁷ /Шинэчилсэн найруулга/	4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг "Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно." 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэг "Тойргийн хороо нэр дэвшигчдийг авсан саналын нь тоогоор дараалалд оруулах бөгөөд хамгийн олон, гэхдээ сонгогчдын 25, түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно."
3	2011 онд батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай хууль ²⁶⁸ /Шинэчилсэн найруулга/	4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэг "Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид "нам, эвсэл" гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно." 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэг "Тойргийн хороо тухайн тойрогт нэр дэвшигчдийг авсан саналын тоогоор нь дараалалд оруулан жагсаалт /цаашид "А" жагсаалт" гэх/-ыг гаргах бөгөөд хамгийн олон, гэхдээ санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан, мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр шууд сонгогдсонд тооцно."
4	2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хууль ²⁶⁹	7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг "7.1.Сонгууль нь олонхийн /мажоритар/ тогтолцоотой байна." 133 дугаар зүйлийн 133.2 дэх хэсэг "Сонгуулийн төв байгууллага тухайн тойрогт нэр дэвшигчдийг авсан саналын тоогоор нь дараалалд оруулан жагсаалт гаргах бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр шууд сонгогдсонд тооцно."
5	2019 онд батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай хууль ²⁷⁰	4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг "Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно." 74 дүгээр зүйлийн 74.1-2 дахь хэсэг "Сонгуулийн ерөнхий хороо нь санал хураалтын дүнг үндэслэн тухайн тойрогт нийт нэр дэвшигчийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана. Хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно."

²⁶⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawid=7117>
²⁶⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawid=7112>
²⁶⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawid=351>
²⁶⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawid=12178>
²⁷⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawid=14869>

Хавсралт 4. Сонгуулийн холимог болон хувь тэнцүүлэх тогтолцоо бүхий орнуудын судалгаа

Улсын нэр	Сонгогч саналаа өгөх субъект	Жагсаалтын хэлбэр	Босгын хувь	Суудал хуваарилах арга	Тойргийн хэлбэр	Бүх суудал (Хувь тэнцүүлэн хуваарилахад ногдоо суудал)
СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦООТОЙ УЛСУУД						
БНКонго Улс	Нэр дэвшигчид	нээлтэй	Нуугдмал	Харегийн их үлдэгдлийн	109 олон мандаттай тойрог	500/440
-доод танхим	Нэр дэвшигчийн нэрийн жагсаалтад	нээлтэй	нуугдмал	Их үлдэгдлийн арга	Муж бүр 1 тойрог	108/108
-дээд танхим	Намд	нээлтэй	3%			300/54
Боливи	Нэр дэвшигчид	хаалттай	Нуугдмал	Д'Хонт	4 мандаттай 9 тойрог	130/60
-дээд танхим	Нэр дэвшигчид	нээлтэй	нуугдмал	Их үлдэгдлийн арга	Олон мандаттай 9 тойрог	36/36
Венесуэл	намд	хаалттай	нуугдмал	Д'Хонт	Үндэсний 1 тойрог	164/1мандаттай
Итали	Намд	хаалттай	2-4%	Олон суудлыг урамшуулах	Олон мандаттай 26 тойрог	тойргийг хассан 630
-доод танхим	намд	хаалттай	нуугдмал	Д'Хонт	40 мандаттай	120/40
-дээд танхим	намд	хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Үндэсний 1 тойрог	141/70
Литва	Намд	нээлтэй	нуугдмал	3-аас дээш мандаттай тойрогт	1 буюу түүнээс дээш	95/14-өөс дээш
Мавритани	Намд-1 санал, нэр дэвшигчид-1 санал	хаалттай	нуугдмал	хаалттай жагсаалтаар санал хурааж, намуудад их үлдэгдлийн аргаар суудал хуваарилна.	мандаттай 45 тойрог, 14 мандаттай үндэсний 1 тойрог	тодорхойгүй.
-доод танхим	намд	хаалттай	Нуугдмал	Их үлдэгдлийн	200 мандаттай үндэсний 1 тойрог	500/200
Мексик	намд	хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	32 мандаттай үндэсний 1 тойрог	128/32
-доод танхим	намд	хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Үндэсний 1 тойрог	450
ОХУ	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	нээлтэй	7%	Харегийн	1 мандаттай 25 тойрог	34/9
Доод танхим	Нэр дэвшигчид	хаалттай	Махоритар системээр 10%-аас системээр дээш санал авсан намд 9 10%-ийн суудлыг хувь тэнцүүлэн суудал авсан нам	Махоритар системээр 10%-аас дээш санал авсан намд 9 суудлыг хувь тэнцүүлэн хуваарилна.		
Сейшелийн арлууд	Нэр дэвшигчид	нээлтэй	нуугдмал	Их үлдэгдлийн	5 хүртэл мандаттай 35 тойрог, 60 мандаттай үндэсний 1 тойрог	165/60
Сенегал	Нэр дэвшигчид-1 санал, намын нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад	нээлтэй	нуугдмал	Их үлдэгдлийн	10 мандат бүхий 8 тойрог	500/125
Доод танхим	Нэр дэвшигчид-1 санал, намд-1 санал	хаалттай	нуугдмал	Их суудалтай намд үлдэгдэл хуваарилагдана.		
Тайланд	намд	хаалттай	3%	Сент Лаго		450/225
Украин	намд	хаалттай				

г. Унгар	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	хаалттай	5%	Д'Хонт	106 мандаттай 1 тойрог, олон мандаттай 20 тойрог	199/93
д. Филиппин	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад-1 санал, нэр дэвшигчид-1 санал	нээлттэй	2%	Суудал авсан намд 3 хүртэл суудлын нэмэлт олгож, 53-т хүргэдэг.	1 мандат бүхий 219 тойрог, 21 мандат бүхий үндэсний 1 тойрог	304/61
е. ХБНГУ	Нэр дэвшигчид, намд	хаалттай	5%	Сент Лаго	Олон мандаттай 16 тойрог	598/299
ж. Бундестаг	Намд, нэр дэвшигчид	хаалттай	5%	Их үлдэгдлийн	Үндэсний 1 тойрог	120/50
з. Шинэ Зеланд	Намын нэр дэвшигч-дийн жагсаалтад	нээлттэй	Нуугдмал	Д'Хонт	Олон /6-29/ мандаттай 11 тойрог	465/176
д. Япон	Нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад	нээлттэй	нуугдмал	Д'Хонт	Үндэсний 1 тойрог 96 мандаттай, (2-10) бүгд 146) мандаттай 47 тойрог	245/98

№	Улсын нэр	Сонгогч саналаа өгөх субъект	Жагсаалтын хэлбэр	Босгын хувь	Суудал хуваарилах арга	Тойргийн хэлбэр	Суудлын тоо
---	-----------	------------------------------	-------------------	-------------	------------------------	-----------------	-------------

СОНГУУЛИЙН ХУВЬ ТЭНЦҮҮЛЭН ХУВААРИЛАХ ТОГТОЛЦООТОЙ УЛСУУД							
20.	Австрали	Нэр дэвшигчдийг зэрэглэж	нээлттэй	нуугдмал	Д'Хонт	12 мандаттай 6 тойрог, 2 мандаттай 2 тойрог	76
21.	Австри	Намд	хаалттай	4%	Харе	3-12 мандаттай 9 тойрог	183
	-доод танхим	намд	нээлттэй	нуугдмал	Д'Хонт Харе	7-36 мандаттай 9 тойрог	61
22.	Алжир	Нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад	хаалттай	нуугдмал	Сент Лаго	Олон мандат бүхий 48 тойрог	407
23.	Ангол	намд	хаалттай	нуугдмал	Харе	130 нь үндэсний 1 тойрог, 5 мандат бүхий 18	220
24.	Аргентин	Намд	хаалттай	3%	Д'Хонт	Олон мандаттай 24 тойрог	257
	-Доод танхим	намд	хаалттай	-	Тойрогтоо хамгийн их санал авсан намд 2 суудал, дараагийнхад нь 1 суудал хуваарилдаг.	3 мандаттай 24 тойрог	72
25.	Бельги	Намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад	нээлттэй	5% (тойргийн хувьд, үндэсний хэмжээнд байхгүй)	Д'Хонт	Олон мандаттай 11 тойрог	150
	-доод танхим	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	нээлттэй	нуугдмал	Д'Хонт	Олон мандаттай 3 тойрог	40

271 https://www.bmi.gv.at/412_english/

26.	Болгар	Намд, Нэр дэвшигчид	хаалттай	4%	Харе	31 нь олонхыг төлөөлөх тогтолцоогоор 209 нь олон мандаттай 31 тойроос 8-70 мандаттай 27 тойрог	240
27.	Бразил -доод танхим	Намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад	нээлттэй	нуугдмал	Д'Хонт	Олон мандаттай 31 тойрог	513
28.	Бурнди -доод танхим	намд	хаалттай	2%	Д'Хонт	Олон мандаттай 17 тойрог	123
29.	Гвиней-Бисау	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Олон мандаттай 27 тойрог	102
30.	Грек	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	нээлттэй	3%	Хагенбах Бишофф	олон мандаттай 56 тойрог, 12 мандаттай үндэсний 1 тойрог	300
31.	Дани	Нэр дэвшигчид	нээлттэй	2%	Д'Хонт	Олон мандаттай 10 тойрог	179
32.	Доминикан -доод танхим	намд	хаалттай	нуугдмал	Д'Хонт	Олон мандаттай 29 тойрог, үндэсний 1 тойрог	183
33.	Израил	намд	хаалттай	3,25%	Д'Хонт	120 мандаттай үндэсний 1 тойрог	120
34.	Индонез -доод танх.	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	4%	Заяцын хүчин зүйл	Олон мандаттай 33 тойрог	575
35.	Исланд	намд	хаалттай	5%	Д'Хонт	10-11 мандаттай тойргууд	63
36.	Испани -доод танхим	Намд	хаалттай	3% Байхгүй	Д'Хонт	Олон мандаттай 50 тойрог Олон мандаттай 52 тойрог	350
37.	Кабо-Верде	намд	хаалттай	нуугдмал	Шууд бус	2-15 мандаттай 16 тойрог	208
38.	Камбож	намд	хаалттай	нуугдмал	Д'Хонт	Олон мандаттай 21 тойрог	72
39.	Кипр	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	3,6% (тойрог)+ 1,8% (үндэсний хэмжээнд)	Харе	Олон мандаттай 6 тойрог	125 80
40.	Колумби -доод танхим -дээд танхим	Намд	нээлттэй	нуугдмал	Д'Хонт	Олон мандаттай 33 тойрог 100 мандаттай үндэсний тойрог, 2 мандаттай тусгай тойрог	187 102
41.	Коста-Рика	намд	нээлттэй	нуугдмал	Д'Хонт	4-21 мандаттай 7 тойрог	57
42.	Латви	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	5%	Сент Лаго	14-29 мандаттай 5 тойрог	100
43.	Лихтенштайн	Нам, нэр дэвшигчийн аль нэгд	нээлттэй	8%	Хамгийн их үлдэгдлийн арга	10, 15 мандаттай 2 тойрог	25
44.	Люксембург	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	нуугдмал	Хагенбах Бишофф	7-23 мандаттай 4 тойрог	60
45.	Мальта	Нэр дэвшигчийг зэрэглэж	нээлттэй	нуугдмал	үлдэгдлийг дахин хуваарилах	5 мандаттай 13 тойрог	65
46.	Намиби	намд	хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Үндэсний 1 тойрог	104
47.	Нидерланд -доод танхим -дээд танхим	Намд намд	хаалттай хаалттай	0,67%	Д'Хонт	Олон мандаттай 18 тойрог 12 мужийн зөвлөл	150 75

48.	Никарагуа	намд		хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	20 мандаттай Үндэсний 1 тойрог, 2-19 мандаттай 17 тойрог	91
49.	Норвег	Нэр дэвшигчид		нээлтэй	4%	Сент Лапо	19 тойроос тус бүр 1 нь шууд сонгогдсон тооцогдож, 150 нь хувь тэнцүүлэн хуваарилагдана.	169
50.	Парагвай -доод танхим -дээд танхим	Намд		хаалттай	Нуугдмал	Д'Хонт	Олон мандаттай 18 тойрог. Үндэсний нэг тойрог	80
51.	Перу	намд		хаалттай	Нуугдмал	Д'Хонт		45
52.	Польш -Сейм	Намд Намын нэр дэвшигчдийн жагсаалтад.		хаалттай нээлтэй	5% Нам-5% Эвсэл-8% Цөөнх-0%	Их үлдэгдлийн Д'Хонт	Олон мандаттай 25 тойрог 7-19 мандаттай 41 тойрог	130 460
53.	Португал	Намд, нэр дэвшигчид		хаалттай		Д'Хонт	Олон мандаттай 22 тойрог	230
54.	Руанда Доод танхим	намд		хаалттай	5%	Их үлдэгдлийн арга, 27 суудалд шууд бус сонгуулиар бүрдэнэ.	53 мандат бүхий үндэсний 1 тойрог, 27 суудалд шууд бусаар сонгогддог.	80
55.	Румын дээд, доод танхим	Нэр дэвшигчид		хаалттай	5%	Д'Хонт	1 мандаттай тойрогт эхний шатанд тооцогдоогүй саналыг үндэсний хэмжээнд нэгтгэж, намуудад хувь тэнцүүлэн хуваарилдаг.	1 мандаттай 315 тойроос 50%+1 санал авсан нь шууд сонгогдсон тооцож, үлдсэнийг нь үндэсний хэмжээнд нэгтгэж 10%-ийн босго давсан намд хувь тэнцүүлэн хуваарилна.
56.	Сан-Томе ба Принсип	намд		хаалттай	нуугдмал	Д'Хонт	Олон мандаттай 7 тойрог	55
57.	Словак	Намын нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад		нээлтэй	5%	Хагенбах Бышхофф	Үндэсний 1 тойрог	150
58.	Словени -доод танхим -дээд танхим	Намд, нэр дэвшигчид		нээлтэй	4%	Д'Хонт	11 мандаттай 88 тойрог, италичуудад зориулсан 2 мандаттай 1 тойрог	90
59.	Суринам	намд		нээлтэй	-	Д'Хонт	Олон мандаттай 10 тойрог	51
60.	Турк	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад		хаалттай	10%	Д'Хонт	Олон мандаттай 79 тойрог	600
61.	Уругвай -доод танхим	Намд		хаалттай	-	Их үлдэгдлийн	Олон мандаттай 19 тойрог. 30 мандаттай үндэсний 1 тойрог	99 31/30
62.	Финланд	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад		хаалттай нээлтэй	нуугдмал	Д'Хонт	7-36 мандаттай 13 тойрог	200

63.	Хорват	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	нээлттэй	5%	Д'Хонт	14 мандаттай 10 тойрог, 8 мандаттай үндэсний тойрог, гадаад оршин суугчдад зориулсан тойрог /мандатын тоо заагаагүй/	151
64.	Чех Доод танхим	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	Нам-5% Эвсэл(2 нам)-10% Эвсэл(3 нам)-15% Эвсэл(4 нам)-20%	Д'Хонт	Олон мандаттай 14 тойрог	200
65.	Чили -дээд танхим Доод танхим	намд	нээлттэй	0%	Д'Хонт	13 олон мандаттай тойрог, 60 олон мандаттай тойрог	50
66.	Швед -Риксдаг	Нэр дэвшигчид	нээлттэй	4% -үндэсний хэмжээнд, 12% тойрог	Сент Лаго	2-34 мандаттай 29 тойрог, 39 мандаттай үндэсний 1 тойрог	155 349
67.	Швейцар -доод танхим	Нэр дэвшигчид	нээлттэй	-	Д'Хонт/Хагенбах Бишхофф	Олон мандаттай 26 тойрог	200
68.	Шри Ланка	Намд, нэр дэвшигчид	нээлттэй 225/196 хаалттай 225/29	12,5% нуугдмал	Д'Хонт	4-20 мандаттай 22 тойрог, 29 мандаттай үндэсний 1 тойрог	225
69.	Экваторын Гвиней	намд	хаалттай	нуугдмал	Д'Хонт	Мужийн тоогоор олон мандаттай тойрог	100
70.	Энэтхэг -дээд танхим	Нэр дэвшигчид	нээлттэй	нуугдмал	Шилжих нэг саналын	Шууд бус сонгууль	245/233
71.	Эстони	намд	нээлттэй	5%	Харе/Д'Хонт	6-13 мандаттай 13 тойрог	101



Хавсралт 5. Дэлхийн улс орнуудын нэг танхимт болон парламентын доод танхимуудын сонгуулийн тогтолцоо²⁷²

Улсын нэр	Сонгууль явагдсан огноо	Сонгуулийн тогтолцоо	Парламентын сонгуулийн тогтолцооны хэлбэр (Нэг танхим, Доод танхим)	Шатлал	Парламентын гишүүдийн тоо (шууд сонгогддог)	Парламентын нийт гишүүдийн тоо (Нэг танхим, Доод танхим)
Сонгуулийн тогтолцоонд өөрчлөлт ороогүй орнууд						
Австрали	2022	Мажоритар	AV	1		
Австри	2019	Пропорционал	List PR	3	183	183
Ангол	2017	Пропорционал	List PR	2	220	220
Андорра	2019	Холимог	Parallel	2	28	28
Антигуа ба Барбуда	2014	Мажоритар	FPTP	1	17	17
АНУ	2020	Мажоритар	FPTP	1	435	435
Аргентин	2021	Пропорционал	List PR	1	257	257
Аруба	2021	Пропорционал	List PR	1	21	21
Афганистан	2018	Бусад	SNTV	1	250	250
Бангладеш	2018	Мажоритар	FPTP	1	300	350
Бахам	2021	Мажоритар	FPTP	1	39	39
Бахрейн	2018	Мажоритар	TRS	1	40	40
Белиз	2020	Мажоритар	FPTP	1	31	31
Бельги	2019	Пропорционал	List PR	1	150	150
Бенин	2019	Пропорционал	List PR	1	83	83
Бермуд	2020	Мажоритар	FPTP	1	36	36
БНАСАУ	2005	Мажоритар	TRS	1	687	687
БНКонго Улс	2017	Мажоритар	TRS	1	151	151
Босни-Херцеговин	2018	Пропорционал	List PR	1	42	42
Ботсвана	2019	Мажоритар	FPTP	1	57	63
Бразил	2018	Пропорционал	List PR	1	513	513
Буркина Фасо	2020	Пропорционал	List PR	2	127	127
Бурунди	2020	Пропорционал	List PR	1	100	124
Бутан	2018	Мажоритар	FPTP	1	47	47
Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс	2018	Мажоритар ба Пропорционал	#FPTP #List PR	H	500	500
Вануату	2020	Бусад	SNTV	H	52	52
Виргинийн Арлууд	2019	Мажоритар	FPTP	2	13	13
Вьетнам	2021	Мажоритар	TRS	1	500	500
Габон	2018	Мажоритар	TRS	1	143	143
Гаити	2021	Мажоритар	TRS	1		
Гайана	2020	Пропорционал	List PR	2	65	65
Гамби	2022	Мажоритар	FPTP	1	53	58
Гана	2020	Мажоритар	FPTP	1	275	275
Гватемал	2019	Пропорционал	List PR	2	160	160
Гвиней	2020	Холимог	Parallel	2	114	114
Гвиней-Бисау	2019	Пропорционал	List PR	1	102	102
Гернси	2020	Мажоритар	BV	1	38	40
Гибралтар	2019	Бусад	LV	1	17	17
Грек	2019	Пропорционал	List PR	2	300	300
Гренада	2018	Мажоритар	FPTP	1	15	15
Гренланд	2021	Пропорционал	List PR	1	31	31
Гүрж	2020	Холимог	Parallel	2	150	150
Дани	2019	Пропорционал	List PR	2	179	179
Доминик	2019	Мажоритар	FPTP	1	21	32
Доминиканы БНУ	2020	Пропорционал	List PR	3	190	190
Жерси	2014	Мажоритар	#FPTP #BV	H	49	49
Замби	2021	Мажоритар	FPTP	1	156	167
ИБУИНХУ	2019	Мажоритар	FPTP	1	650	650
Израил	2021	Пропорционал	List PR	1	120	120
Индонез	2019	Пропорционал	List PR	1	575	575
Иран	2020	Мажоритар	TRS	1	290	290
Ирланд	2020	Пропорционал	STV	1	159	160
Исланд	2021	Пропорционал	List PR	2	63	63
Испани	2019	Пропорционал	List PR	1	350	350
Йемен	2003	Мажоритар	FPTP	1	301	301
Кабо Верде	2021	Пропорционал	List PR	1	72	72
Камбож	2018	Пропорционал	List PR	1	125	125
Канад	2021	Мажоритар	FPTP	1	338	338

²⁷² <https://www.idea.int/advanced-search?th=Electoral%20System%20Design%20Database®ion=world&question=130355>

Катар	2021	Мажоритар	FPTP	1	30	45
Кени	2017	Мажоритар	FPTP	2	337	350
Кипр	2021	Пропорционал	List PR	1	56	56
Кирибати	2020	Мажоритар	TRS	1	44	46
Колумби	2022	Пропорционал	List PR	1	166	166
Коморос	2020	Мажоритар	TRS	1	24	33
Косово	2021	Пропорционал	List PR	1	120	120
Коста Рика	2022	Пропорционал	List PR	1	57	57
Кот д'Ивуар	2021	Мажоритар	#FPTP #PBV	H	255	255
Куба	2018	Мажоритар	TRS	1	612	612
Күүийн арлууд	2018	Мажоритар	FPTP	1	24	24
Лаос	2021	Мажоритар	BV	1	164	164
Латви	2018	Пропорционал	List PR	1	100	100
Ливи	2014	Холимог	Parallel	3	200	200
Литва	2020	Холимог	Parallel	2	141	141
Лихтенштайн	2021	Пропорционал	List PR	1	25	25
Люксембург	2018	Пропорционал	List PR	1	60	60
Маврики	2019	Мажоритар	BV	1	62	70
Малави	2019	Мажоритар	FPTP	1	193	193
Малайз	2018	Мажоритар	FPTP	1	222	222
Мали	2020	Мажоритар	TRS	1	147	147
Мальта	2022	Пропорционал	STV	1	67	67
Маршаллын арлууд	2019	Мажоритар	#FPTP #BV	H	33	33
Микронез	2021	Мажоритар	FPTP	2	14	14
Мозамбик	2019	Пропорционал	List PR	1	250	250
Монтенегро	2020	Пропорционал	List PR	1	81	81
Моңцerrat	2019	Мажоритар	TRS	1	9	11
Мэн арал	2021	Мажоритар	BV	1	24	24
Мьянмар	2020	Мажоритар	FPTP	1	330	440
Намиби	2019	Пропорционал	List PR	1	96	96
Науру	2019	Бусад	Modified BC	1	19	19
Нигери	2019	Мажоритар	FPTP	1	360	360
Нидерланд	2021	Пропорционал	List PR	1	150	150
Нидерландын Антилын Арлууд	2010	Пропорционал	List PR	1	22	22
Нижер	2020	Пропорционал	List PR	H	171	171
Никарагуа	2021	Пропорционал	List PR	2	90	90
Норвег	2021	Пропорционал	List PR	2	169	169
Ниуэ	2020	Мажоритар	#FPTP #BV	2	20	20
Оман	2019	Мажоритар	#FPTP #BV	H	86	86
Палау	2020	Мажоритар	FPTP	1	16	16
Панам	2019	Пропорционал	#FPTP #List PR	H	71	71
Парагвай	2018	Пропорционал	List PR	1	80	80
Перу	2021	Пропорционал	List PR	1	130	130
Питкэрний Арлууд	2005	Бусад	SNVT	1	6	8
Польш	2019	Пропорционал	List PR	1	460	460
Португал	2022	Пропорционал	List PR	1	230	230
Руанда	2018	Пропорционал	List PR	1	53	80
Сан Марино	2019	Пропорционал	List PR	1	60	60
Сан Томе ба Принсип	2018	Пропорционал	List PR	1	55	55
Сейшелийн Арлууд	2020	Холимог	Parallel	2	35	35
Сенегал	2017	Холимог	Parallel	3	165	165
Сент Винсент ба Гренадин	2020	Мажоритар	FPTP	1	15	23
Сент Китс ба Невис	2020	Мажоритар	FPTP	1	11	15
Сент Люсия	2021	Мажоритар	FPTP	1	17	17
Серби	2022	Пропорционал	List PR	1	250	250
Сири	2020	Мажоритар	BV	1	250	250
Словак	2020	Пропорционал	List PR	1	150	150
Словени	2022	Пропорционал	List PR	2	90	90
Соломоны Арлууд	2019	Мажоритар	FPTP	1	50	50
Суринам	2020	Пропорционал	List PR	1	51	51
Тайвань	2020	Холимог	Parallel	3	113	113
Танзани	2020	Мажоритар	FPTP	1		
Токелау	2020	Мажоритар	FPTP	1	22	22
Төв Африкийн Бүгд Найрамдах Улс	2020	Мажоритар	TRS	1	140	140
Тринидад ба Тобаго	2020	Мажоритар	FPTP	1	41	41
Тувалу	2019	Мажоритар	BV	1	16	16

Турк	2018	Пропорционал	List PR	1	600	600
Туркменистан	2018	Мажоритар	TRS	1	125	125
Уганда	2021	Мажоритар	FPTP	1	499	529
Узбекистан	2019	Мажоритар	TRS	1	150	150
Умард Кипр	2022	Пропорционал	List PR	1	50	50
Унгар	2022	Холимог	MMP	2	199	199
Уругвай	2019	Пропорционал	List PR	1	99	99
Финланд	2019	Пропорционал	List PR	1	200	200
Фолкландын арлууд (Малвинас)	2021	Мажоритар	BV	1	8	8
Франц	2017	Мажоритар	TRS	1	577	577
ХБНГУ	2021	Холимог	MMP	2	736	736
Хондурас	2021	Пропорционал	List PR	1	128	128
Чад	2011	Мажоритар	#FPTP #PBV #List PR	H	188	188
Чех	2021	Пропорционал	List PR	1	200	200
Чили	2021	Пропорционал	List PR	1	155	155
Швед	2018	Пропорционал	List PR	2	349	349
Швейцар	2019	Пропорционал	List PR	1	200	200
Шри Ланка	2020	Пропорционал	List PR	2	225	225
Эквадор	2021	Пропорционал	List PR	3	137	137
Экваторын Гвиней	2017	Пропорционал	List PR	1	100	100
Эль Сальвадор	2021	Пропорционал	List PR	1	84	84
Энэтхэг	2019	Мажоритар	FPTP	1	543	545
Эсватини	2018	Мажоритар	FPTP	1	59	70
Эстони	2019	Пропорционал	List PR	2	101	101
Этиоп	2021	Мажоритар	FPTP	1	547	547
Ямайка	2020	Мажоритар	FPTP	1	63	63
Сонгуулийн тогтолцооны хэлбэрт өөрчлөлт орсон орнууд						
Ангилья	2020	Мажоритар	#FPTP #BV	2	11	13
	2015	Мажоритар	FPTP	1	7	11
	2010	Мажоритар	FPTP	1	7	11
	2005	Мажоритар	FPTP	1	7	11
Беларусь	2019	Мажоритар	FPTP	1	110	110
	2016	Мажоритар	FPTP	1	110	110
	2012	Мажоритар	TRS	1	110	110
	2008	Мажоритар	TRS	1	110	110
	2004	Мажоритар	TRS	1	110	110
	2000	Мажоритар	TRS	1	110	110
	1995	Мажоритар	TRS	1	260	260
БНСУ	2020	Холимог	MMP	2	300	300
	2016	Холимог	Parallel	2	300	300
	2012	Холимог	Parallel	2	300	300
	2008	Холимог	Parallel	2	299	299
	2004	Холимог	Parallel	2	299	299
	2000	Холимог	Parallel	2	273	273
	1996	Холимог	Parallel	2	299	299
	1992	Холимог	Parallel	2	299	299
Венесуэл	2020	Холимог	Parallel	2	277	280
	2015	Холимог	Parallel	2	167	167
	2010	Холимог	Parallel	2	165	165
	2005	Холимог	MMP	3	167	167
	2000	Холимог	MMP	3	165	165
	1998	Холимог	MMP	3	207	207
	1993	Холимог	MMP	3	207	207
Гэгээн Елена Арал	2021	Мажоритар	BV	1	12	15
	2005	Мажоритар	#FPTP #BV	H	12	14
Камерун	2020	Мажоритар	List PR	H	180	180
	2013	Мажоритар	#FPTP #PBV #List PR	H	180	180
	2007	Мажоритар	#FPTP #PBV #List PR	H	180	180
	2002	Мажоритар	#FPTP #PBV #List PR	H	180	180
	1997	Мажоритар	#FPTP #PBV #List PR	H	180	180
	1992	Мажоритар	#FPTP #PBV	H	180	180

			#List PR			
Кайманы арлууд	2021	Мажоритар	FPTP	1	19	19
	2017	Мажоритар	FPTP	1	18	18
	2013	Мажоритар	BV	1	18	18
	2009	Мажоритар	BV	1	15	15
	2005	Мажоритар	BV	1	15	15
Мальдив	2019	Мажоритар	FPTP	1	87	87
	2014	Мажоритар	FPTP	1	85	85
	2009	Мажоритар	FPTP	1	77	77
	2005	Мажоритар	BV	1	42	50
	1999	Мажоритар	BV	1	42	50
Папуа Шинэ Гвиней	2017	Мажоритар	AV	2	111	111
	2012	Мажоритар	AV	2	111	111
	2007	Мажоритар	AV	2	109	111
	2002	Мажоритар	FPTP	2	109	109
	1997	Мажоритар	FPTP	2	109	109
Самоа	1992	Мажоритар	FPTP	2	109	109
	2021	Мажоритар	FPTP	1	51	51
	2016	Мажоритар	#FPTP #BV	H	49	50
	2011	Мажоритар	#FPTP #BV	H	49	49
	2006	Мажоритар	#FPTP #BV	H	49	49
	2001	Мажоритар	#FPTP #BV	H	49	49
	1996	Мажоритар	#FPTP #BV	H	49	49
Сингапур	2020	Мажоритар	#FPTP #PBV	H	93	104
	2015	Мажоритар	#FPTP #PBV	H	89	101
	2011	Мажоритар	#FPTP #PBV	H	87	110
	2006	Мажоритар	#FPTP #PBV	H	84	104
	2001	Мажоритар	#FPTP #PBV	H	84	103
	1997	Мажоритар	#FPTP #PBV	H	83	99
	1991	Мажоритар	#FPTP #PBV	H	81	91
	1988	Мажоритар	#FPTP #PBV	H	81	84
	1984	Мажоритар	FPTP	1	79	79
Тонга	2021	Мажоритар	FPTP	1	17	26
	2017	Мажоритар	FPTP	1	17	26
	2014	Мажоритар	FPTP	1	17	26
	2010	Мажоритар	FPTP	1	17	26
	2008	Мажоритар	BV	1	9	30
	2005	Мажоритар	BV	1	9	30
	1999	Мажоритар	BV	1	9	30
	1996	Мажоритар	BV	1	9	30
	1993	Мажоритар	BV	1	9	30
Туркс ба Кайкосын Арлууд	2021	Мажоритар	#FPTP #BV	2	15	19
	2012	Мажоритар	#FPTP #BV	2	15	19
	2007	Мажоритар	FPTP	1	15	18
	2003	Мажоритар	FPTP	1	13	18
	1999	Мажоритар	FPTP	1	13	
	1995	Мажоритар	FPTP	1	13	
	1991	Мажоритар	FPTP	1	13	
Пропорционал, эсхүл холимог тогтолцоонд шилжсэн орнууд						
Албани	2021	Пропорционал	List PR	1	140	140
	2017	Пропорционал	List PR	1	140	140
	2013	Пропорционал	List PR	1	140	140
	2009	Пропорционал	List PR	1	140	140
	2005	Холимог	MMP	2	140	140
	2001	Холимог	MMP	2	140	140
	1997	Холимог	Parallel	2	155	155
	1996	Холимог	Parallel	2	140	140
	1992	Холимог	MMP	2	140	140
	1991	Мажоритар	TRS	1	250	250
Алжир	2021	Пропорционал	List PR	1	407	407

	2017	Пропорционал	List PR	1	462	462
	2012	Пропорционал	List PR	1	462	462
	2007	Пропорционал	List PR	1	389	389
	2002	Пропорционал	List PR	1	389	389
	1997	Пропорционал	List PR	1	380	380
	1991	Мажоритар	TRS	1	430	430
Армени	2021	Пропорционал	List PR	1	107	107
	2018	Пропорционал	List PR	1	132	132
	2017	Пропорционал	List PR	1	105	105
	2012	Холимог	Parallel	2	131	131
	2007	Холимог	Parallel	2	131	131
	2003	Холимог	Parallel	2	131	131
Боливи	1999	Холимог	Parallel	2	131	131
	1995	Холимог	Parallel	2	190	190
	2020	Холимог	MMP	3	130	130
	2019	Холимог	MMP	3	130	130
	2014	Холимог	MMP	3	130	130
	2009	Холимог	MMP	3	130	130
Болгар	2005	Холимог	MMP	2	130	130
	2002	Холимог	MMP	2	130	130
	1997	Холимог	MMP	2	130	130
	1993	Пропорционал	List PR	1	130	130
	2021	Пропорционал	List PR	1	240	240
	2017	Пропорционал	List PR	1	240	240
Жибути	2014	Пропорционал	List PR	1	240	240
	2013	Пропорционал	List PR	1	240	240
	2009	Холимог	Parallel	2	240	240
	2005	Пропорционал	List PR	1	240	240
	2001	Пропорционал	List PR	1	240	240
	1997	Пропорционал	List PR	1	240	240
Зимбабве	1994	Пропорционал	List PR	1	240	240
	1991	Пропорционал	List PR	1	240	240
	2018	Холимог	MMP	1	65	65
	2013	Холимог	MMP	1	65	65
	2008	Мажоритар	BV	1	65	65
	2003	Мажоритар	BV	1	65	65
Зүүн Тимор	1997	Мажоритар	BV	1	65	65
	1992	Мажоритар	BV	1	65	65
	2018	Холимог	Parallel	2	270	270
	2013	Холимог	Parallel	2	270	270
	2008	Мажоритар	FPTP	1	210	210
	2005	Мажоритар	FPTP	1	120	150
Итали	2000	Мажоритар	FPTP	1	120	150
	1995	Мажоритар	FPTP	1	120	150
	2018	Пропорционал	List PR	1	65	65
	2017	Пропорционал	List PR	1	65	65
	2012	Пропорционал	List PR	1	65	65
	2007	Пропорционал	List PR	1	65	65
Йордан	2001	Холимог	Parallel	2	88	88
	2018	Холимог	Parallel	2	630	630
	2013	Пропорционал	List PR	1	630	630
	2008	Пропорционал	List PR	1	630	630
	2006	Пропорционал	List PR	1	630	630
	2001	Холимог	MMP	2	630	630
Казахстан	1996	Холимог	MMP	2	630	630
	1994	Холимог	MMP	2	630	630
	1992	Пропорционал	List PR	1	630	630
	2020	Пропорционал	List PR	1	130	130
	2016	Пропорционал	List PR	1	130	130
	2013	Холимог	Parallel	2	150	150
Кувейт	2010	Бусад	SNTV	1	108	120
	2007	Бусад	SNTV	1	104	110
	2003	Бусад	SNTV	1	104	110
	1997	Бусад	SNTV	1	80	80
	1993	Бусад	SNTV	1	80	80
	2021	Пропорционал	List PR	1	98	107
	2016	Пропорционал	List PR	1	98	107
	2012	Пропорционал	List PR	1	98	107
	2007	Холимог	Parallel	2	98	107
	2004	Холимог	Parallel	2	67	77
	1999	Холимог	Parallel	2	67	77
	1995	Холимог	Parallel	2	67	77
	1994	Мажоритар	FPTP	1	135	177
	2020	Бусад	SNTV	1	50	65

	2016	Бусад	SNTV	1	50	65
	2013	Бусад	SNTV	1	50	65
	2012	Бусад	SNTV	1	50	
	2009	Мажоритар	BV	1	50	
	2008	Мажоритар	BV	1	50	
	2006	Мажоритар	BV	1	50	
	2003	Мажоритар	BV	1	50	
	1999	Мажоритар	BV	1	50	
	1996	Мажоритар	BV	1	50	
	1992	Мажоритар	BV	1	50	
Киргиз	2021	Холимог	Parallel	2	90	90
	2020	Пропорционал	List PR	1	120	120
	2015	Пропорционал	List PR	1	120	120
	2010	Пропорционал	List PR	1	120	120
	2007	Пропорционал	List PR	1	90	90
	2005	Мажоритар	TRS	1	75	75
	2000	Холимог	Parallel	2	60	60
Ливан	1995	Мажоритар	TRS	1	35	35
	2022	Пропорционал	List PR	1	128	128
	2018	Пропорционал	List PR	1	128	128
	2009	Мажоритар	BV	1	128	128
	2005	Мажоритар	BV	1	128	128
	2000	Мажоритар	BV	1	128	128
	1996	Мажоритар	BV	1	128	128
Лесото	1992	Мажоритар	BV	1	128	128
	2017	Холимог	MMP	2	120	120
	2015	Холимог	MMP	2	120	120
	2012	Холимог	MMP	2	120	120
	2007	Холимог	MMP	2	120	120
	2002	Холимог	MMP	2	120	120
	1998	Мажоритар	FPTP	1	80	80
Мавритани	1993	Мажоритар	FPTP	1	80	80
	2018	Холимог	Parallel	3	157	157
	2013	Холимог	Parallel	3	146	146
	2006	Мажоритар	TRS	1	95	95
	2001	Мажоритар	TRS	1	81	81
	1996	Мажоритар	TRS	1	79	79
	1992	Мажоритар	TRS	1	79	79
Мексик	2021	Холимог	MMP	2	500	500
	2018	Холимог	MMP	2	500	500
	2015	Холимог	MMP	2	500	500
	2012	Холимог	MMP	2	500	500
	2009	Холимог	MMP	2	500	500
	2006	Холимог	MMP	2	500	500
	2003	Холимог	MMP	2	500	500
	2000	Холимог	MMP	2	500	500
	1997	Холимог	MMP	2	500	500
	1994	Холимог	Parallel	2	500	500
	1991	Холимог	MMP	2	500	500
	2021	Пропорционал	List PR	1	101	101
Молдова	2019	Холимог	Parallel	2	101	101
	2014	Пропорционал	List PR	1	101	101
	2010	Пропорционал	List PR	1	101	101
	2009	Пропорционал	List PR	1	101	101
	2005	Пропорционал	List PR	1	101	101
	2001	Пропорционал	List PR	1	101	101
	1998	Пропорционал	List PR	1	101	101
Монако	1994	Мажоритар	TRS	1	104	104
	2018	Холимог	Parallel	2	24	24
	2013	Холимог	Parallel	2	24	24
	2008	Холимог	Parallel	2	24	24
	2003	Холимог	Parallel	2	24	24
	1998	Мажоритар	TRS	1	18	18
	1993	Мажоритар	TRS	1	18	18
Марокко	2021	Пропорционал	List PR	2	395	395
	2016	Пропорционал	List PR	2	395	395
	2011	Пропорционал	List PR	2	395	395
	2007	Пропорционал	List PR	2	325	325
	2002	Пропорционал	List PR	2	325	325
	1997	Пропорционал	List PR	2	325	325
	1993	Мажоритар	FPTP	1	222	333
Непал	2017	Холимог	Parallel	2	275	275
	2013	Холимог	Parallel	2	575	601
	2008	Холимог	Parallel	2	575	601

ОХУ	1999	Мажоритар	FPTP	1	205	205
	1994	Мажоритар	FPTP	1	205	205
	1991	Мажоритар	FPTP	1	205	205
	2021	Холимог	Parallel	2	450	450
	2016	Холимог	Parallel	2	450	450
	2011	Пропорционал	List PR	1	450	450
	2007	Пропорционал	List PR	1	450	450
	2003	Холимог	Parallel	2	450	450
	1999	Холимог	Parallel	2	450	450
Өмнөд Африк	1995	Холимог	Parallel	2	450	450
	2019	Пропорционал	List PR	2	400	400
Өмнөд Судан	2016	Шилжилтийн тогтолцоотой	Шилжилтийн тогтолцоотой			
	2010	Холимог	Parallel	3	170	170
Пакистан	2018	Холимог	Parallel	2	342	342
	2013	Холимог	Parallel	2	342	342
	2008	Холимог	Parallel	2	342	342
	2002	Холимог	Parallel	2	342	342
	1997	Мажоритар	FPTP	1	217	217
	1993	Мажоритар	FPTP	1	217	217
	1993	Холимог	Parallel	2	450	450
	2006	Холимог	Parallel	2	132	132
Палестин	1996	Мажоритар	BV	1	88	88
	2020	Пропорционал	List PR	1	312	329
Румын	2016	Пропорционал	List PR	1	312	329
	2012	Холимог	MMP	2	332	332
	2008	Холимог	MMP	2	334	334
	2004	Пропорционал	List PR	1	332	332
	2000	Пропорционал	List PR	1	345	345
	1996	Пропорционал	List PR	1	343	343
	2015	Холимог	Parallel	3	450	450
	2010	Холимог	Parallel	3	450	450
Судан	2000	Мажоритар	FPTP	1	270	360
	1996	Мажоритар	FPTP	1	275	400
	2020	Холимог	Parallel	2	63	63
	2015	Холимог	Parallel	2	63	63
Тажикистан	2010	Холимог	Parallel	2	63	63
	2005	Холимог	Parallel	2	63	63
	2000	Холимог	Parallel	2	63	63
	1995	Мажоритар	TRS	1	181	181
Тайланд	2019	Холимог	MMP	2	500	500
	2014	Холимог	Parallel	2	500	500
	2011	Холимог	Parallel	2	500	500
	2007	Холимог	Parallel	2	480	480
	2006	Холимог	Parallel	2	500	500
	2005	Холимог	Parallel	2	500	500
	2001	Холимог	Parallel	2	500	500
	1996	Мажоритар	BV	1	393	393
	1995	Мажоритар	BV	1	391	391
	1992	Мажоритар	BV	1	360	360
	2018	Пропорционал	List PR	1	91	91
	2013	Пропорционал	List PR	1	91	91
	2007	Пропорционал	List PR	1	81	81
Того	2002	Мажоритар	TRS	1	81	81
	1999	Мажоритар	TRS	1	81	81
	1994	Мажоритар	TRS	1	78	78
	2019	Пропорционал	List PR	1	217	217
	2014	Пропорционал	List PR	1	217	217
	2011	Пропорционал	List PR	1	217	217
	2009	Холимог	Parallel	2	214	214
	2004	Холимог	Parallel	2	189	189
	1999	Холимог	Parallel	2	183	183
Тунис	1994	Холимог	Parallel	2	163	163
	2020	Пропорционал	List PR	1	120	120
	2016	Пропорционал	List PR	1	120	120
	2014	Пропорционал	List PR	1	123	123
	2011	Пропорционал	List PR	1	123	123
	2008	Пропорционал	List PR	1	120	120
	2006	Пропорционал	List PR	1	120	120
	2002	Пропорционал	List PR	1	120	120
	1998	Холимог	Parallel	2	120	120
Умард Македон	1994	Мажоритар	TRS	1	120	120
	2019	Холимог	Parallel	2	424	424
Украин	2019	Холимог	Parallel	2	424	424

	2014	Холимог	Parallel	2	450	450
	2012	Холимог	Parallel	2	450	450
	2007	Пропорционал	List PR	1	450	450
	2006	Пропорционал	List PR	1	450	450
	2002	Холимог	Parallel	2	450	450
	1998	Холимог	Parallel	2	450	450
	1994	Мажоритар	TRS	1	450	450
Фижки	2018	Пропорционал	List PR	1	51	51
	2014	Пропорционал	List PR	1	50	50
	2006	Мажоритар	AV	2	71	71
	2001	Мажоритар	AV	2	71	71
	1999	Мажоритар	AV	2	71	71
	1994	Мажоритар	#FPTP #BV	1	70	70
	1992	Мажоритар	#FPTP #BV	1	70	70
Филиппин	2022	Холимог	Parallel	2	316	316
	2019	Холимог	Parallel	2	306	306
	2016	Холимог	Parallel	2	297	297
	2013	Холимог	Parallel	2	292	292
	2010	Холимог	Parallel	2	286	286
	2007	Холимог	Parallel	2	270	270
	2004	Холимог	Parallel	2	239	239
	2001	Холимог	Parallel	2	221	221
	1998	Холимог	Parallel	2	220	220
	1995	Мажоритар	FPTP	1	204	204
	1992	Мажоритар	FPTP	1	199	199
Хорват	2020	Пропорционал	List PR	1	151	151
	2016	Пропорционал	List PR	1	151	151
	2015	Пропорционал	List PR	1	151	151
	2011	Пропорционал	List PR	1	151	151
	2007	Пропорционал	List PR	1	153	153
	2003	Пропорционал	List PR	1	152	152
	2000	Пропорционал	List PR	1	151	151
	1995	Холимог	Parallel	2	124	127
	1992	Холимог	Parallel	2	124	127
Шинэ Зеланд	2020	Холимог	MMP	3	120	120
	2017	Холимог	MMP	3	120	120
	2014	Холимог	MMP	3	121	121
	2011	Холимог	MMP	3	121	121
	2008	Холимог	MMP	3	122	122
	2005	Холимог	MMP	3	121	121
	2002	Холимог	MMP	3	120	120
	1999	Холимог	MMP	3	120	120
	1996	Холимог	MMP	3	120	120
	1993	Мажоритар	FPTP	1	99	99
Япон	2021	Холимог	Parallel	2	465	465
	2017	Холимог	Parallel	2	465	465
	2014	Холимог	Parallel	2	475	475
	2012	Холимог	Parallel	2	480	480
	2009	Холимог	Parallel	2	480	480
	2005	Холимог	Parallel	2	480	480
	2003	Холимог	Parallel	2	480	480
	2000	Холимог	Parallel	2	480	480
	1996	Холимог	Parallel	2	500	500
	1993	Бусад	SNTV	1	511	511
Мажоритар тогтолцоонд шилжсэн орнууд						
Азербайжан	2020	Мажоритар	FPTP	1	125	125
	2015	Мажоритар	FPTP	1	125	125
	2010	Мажоритар	FPTP	1	125	125
	2006	Мажоритар	FPTP	1	125	125
	2005	Мажоритар	FPTP	1	125	125
	2000	Холимог	Parallel	2	125	125
	1995	Холимог	Parallel	2	125	125
Египет	2020	Мажоритар	#TRS #PBV	2	568	596
	2015	Мажоритар	#TRS #PBV	2	568	596
	2012	Холимог	Parallel	2	498	508
	2010	Мажоритар	TRS	1	508	518
	2005	Мажоритар	TRS	1	444	454
	2000	Мажоритар	TRS	1	444	454
	1995	Мажоритар	TRS	1	444	454
Ирак	2021	Мажоритар	SNTV	1	329	329

	2018	Пропорционал	List PR	1	329	329
	2014	Пропорционал	List PR	1	328	328
	2010	Пропорционал	List PR	1	325	325
	2005	Пропорционал	List PR	2	275	275
	2016	Мажоритар	BV	1	24	24
	2011	Мажоритар	#FPTP #BV	H	24	24
	2006	Мажоритар	#FPTP #BV	H	24	24
	2001	Мажоритар	#FPTP #BV	H	24	24
Либерия	2017	Мажоритар	FPTP	1	73	73
	2011	Мажоритар	FPTP	1	73	73
	2005	Мажоритар	FPTP	1	64	64
	1997	Пропорционал	List PR	1	64	64
Мадагаскар	2019	Мажоритар ба Пропорционал	#FPTP #List PR	1	151	151
	2013	Мажоритар ба Пропорционал	#FPTP #List PR	H	151	151
	2007	Мажоритар	#FPTP #PBV	1	127	127
	2002	Мажоритар ба Пропорционал	#FPTP #List PR	1	160	160
	1998	Мажоритар ба Пропорционал	#FPTP #List PR	1	150	150
	1993	Пропорционал	List PR	1	138	138
	2020	Мажоритар	BV	1	76	76
Монгол	2016	Мажоритар	FPTP	1	76	76
	2012	Холимог	Parallel	2	76	76
	2008	Мажоритар	BV	1	76	76
	2004	Мажоритар	TRS	1	76	76
	2000	Мажоритар	TRS	1	76	76
	1996	Мажоритар	TRS	1	76	76
	1992	Мажоритар	BV	1	76	76
	2018	Мажоритар	FPTP	1	132	146
Сьерра Леон	2012	Мажоритар	FPTP	1	112	124
	2007	Мажоритар	FPTP	1	112	124
	2002	Пропорционал	List PR	1	112	124
	1996	Пропорционал	List PR	1	68	80

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- IPU. (2022). IPU Parline: Global data on national parliaments. https://data.ipu.org/compare?field=chamber%3A%3Afield_electoral_system&structure=any_lower_chamber#map
- Werner, P., & Luvsandemdev, S. (2008). *Voters' Voices People's Perception of Mongolia's Political and Economic Transition as Reflected in Opinion Polls from 1995 to 2007*. Ulaanbaatar.
- Nohlen, D., Grotz, F., & Hartmann, C. (2002). *Elections in Asia and the Pacific A Data Handbook VOLUME II South East Asia, East Asia and the South Pacific*. Oxford University Press.
- European Commission, Directorate-General for External Relations. (2019). *Compendium of international standards for elections: fourth edition*. Publications Office.
- Гэрэлт-Од, Э. (2020). Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо: сонголт, туршлага. *Шинэ толь №81*.
- Цогтоо, Ш. (2018 он). Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй. УБ.
- Солонго Д. (2017). Үндсэн хуулийн цэц иргэдийн сонгох, сонгогдох эрхийн баталгаа болох нь. Жанцан Ж., *Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: Онол арга зүйн хэрэгжилт*. УБ: Монгол Улсын Үндсэн хуулийн цэц.
- СЕХ. (2017). *Монгол Улсын Их Хурлын сонгуулиудын дүн*. <https://gec.gov.mn/uploads/IHsonguuli2012.pdf>
- НҮБХХ. (2015). *Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: дүн шинжилгээ*. УБ.
- Чулуун, Г. (2015). *Улсын Бага Хурлын товчоон: Үйл ажиллагааны хроно-тойм (1990-1992)*. УБ.
- Бямбадорж Ж. (1999 он). Сонгууль сонгуулийн тогтолцоо. *Шинэ толь №28*.
- Остапенко Г. И. (2020. № 4). «Динамика» и «статика» парламентских выборов в Монголии сквозь призму электорального анализа. *Известия Восточного института*, 37–52.
- И.Б.Борисов, А.Г.Головин, & А.В.Игнатов. (2015). *Выборы в мире: Избирательные системы*. Санкт-Петербург: Российский общественный институт избирательного права, Избирательная комиссия ленинградской области.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2015 он). *БНМАУ-ын Ардын Их Хурлын сонгуультай холбоотой лавлагаа*. УБ: Судалгааны эмхэтгэл XXI боть, СТ-15/415.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2015). *Монгол Улсын Үндсэн хууль (1992) болон Монгол Улсын Их цаазын төслүүдэд хэлэлцүүлгийн явцад орсон өөрчлөлтүүд*. УБ: Судалгааны эмхэтгэл XX боть, СТ-15/403.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2015). *Парламентын засаглалтай орнуудын сонгуулийн тогтолцоо ба Ротацын журмаар парламентын гишүүдийг сэлгэдэг зарим орны туршлага*. УБ: Судалгааны эмхэтгэл XX боть, СТ-15/211.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2012). *Монголын эмэгтэй улс төрчид*. УБ: Судалгааны эмхэтгэл XIII боть, СТ-12/403.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2012 он). *Монгол Улсын Их хурлын сонгуулийн тойм*. УБ: Судалгааны эмхэтгэл XIII боть, СТ-12/408.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2011). *Дэлхийн зарим улс орнуудын парламентын сонгуулийн шүүд зарчим*. Судалгааны эмхэтгэл X боть, СТ-11/410.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2010). *Сонгуулийн эрх зүйн тогтолцооны онол арга зүйн үндэслэл, зохистой хувилбарыг сонгох зарчим*. Судалгааны эмхэтгэл V боть, СТ-10/217.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. (2009 он). *Сонгуулийн системийн харьцуулалт: давуу ба сул тал*. УБ: Судалгааны эмхэтгэл IV боть, СТ-09/219.

ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙ ҮҮРЭГТ ҮЛ ХАМААРАХ АЖИЛ, АЛБАН ТУШААЛ ХАВСРАН АЖИЛЛАХ ТУХАЙ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Тойм судалгаа)

Д.Жигваагүнсэл

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙ ҮҮРЭГТ ҮЛ ХАМААРАХ АЖИЛ, АЛБАН ТУШААЛ ХАВСРАН АЖИЛЛАХ ТУХАЙ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

1. ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ

1.1.1992 оны Үндсэн хуулийг хэлэлцэн батлах үеэр “Парламентын гишүүний үүрэгт үл хамаарах ажил, албан тушаал хавсран ажиллах” талаар хэлэлцсэн байдал

1.2.Парламентын гишүүний үүрэгт үл хамаарах ажил, албан тушаал хавсран ажиллах талаар Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тойм

2. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

2.1.Парламентын гишүүний үүрэгт үл хамаарах ажил, үүргийн тухай ойлголт

2.2.Парламентын гишүүний үүрэгт үл хамаарах өөр бусад албан тушаал хавсрах эсэх

2.3.Парламентын гишүүн засгийн газрын гишүүний үүргийг хавсран ажилладаг эсэх

2.4.Парламентын засаглалтай улс орнуудад парламентын гишүүн засгийн газрын гишүүний үүргийг хавсран ажилладаг эсэх

ХАВСРАЛТ.

Парламентын засаглалтай орнуудад парламентын гишүүн засгийн газрын гишүүний үүргийг хавсран ажилладаг эсэх тухай Үндсэн хуулийн зохицуулалт

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын Их Цаазын өөрчлөлтийн харьцуулалт

Хүснэгт 2. УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран гүйцэтгэсэн байдал (1992-2018 он)

Хүснэгт 3. Зөвлөлдөх санал асуулгаар гарсан санал (хувиар)

Хүснэгт 4. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллах эсэхтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтүүд

Хүснэгт 5. Дэлхийн улс орнуудад парламентын гишүүн засгийн газрын гишүүний үүргийг хавсран ажилладаг эсэх

Хүснэгт 6. Парламентын засаглалтай улс орнуудад парламентын гишүүн засгийн газрын гишүүний үүргийг хавсран ажилладаг эсэх (75 улс)

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Парламентын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт үл хамаарах ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхийг хориглох зарчим нь төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмаас үүдэлтэй. Үүнийг баримтлахын ач холбогдол нь нэгдүгээрт, засгийн газраас хараат хүмүүс парламентад орох боломжийг хаах, хоёрдугаарт, парламентын гишүүд аливаа бизнесийн ашиг сонирхол, эдийн засгийн бүлэглэлийн нөлөөллөөс хамгаалагдсан байх нөхцөлийг бүрдүүлэх, гуравдугаарт, парламентын гишүүдийг аливаа ашиг хөөх, бусдын эрх ашигт үйлчлэх, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашиглах зэрэг зохисгүй үйлдэл хийхээс сэргийлэхэд оршдог байна.

Түүхэн эх сурвалж

Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлд, *“БНМАУ-ын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах бөгөөд мөн Хурлын чөлөө цагт Улсын Бага Хуралд хадгалуулах, ба бас мөн Хурлын чөлөө цагт Бага Хурлын Тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино”* гэж тус тус зохицуулжээ. Улсын Их ба Бага Хуралд сонгогдсон депутатууд нь орон тооны бус, үндсэн ажлын хажуугаар төлөөллийн үүргээ хэрэгжүүлдэг байсан учраас тэдний хувьд албан тушаал үл нийцэх зарчим үйлчилдэггүй байсан.²⁷³

Дээрх зарчмыг 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулиар анх зохицуулсан байдаг.

Шинэ Үндсэн хуулийг хэлэлцэн батлах явцад төслийг нийт 5 удаа (Хүснэгт 1) өөрчлөн өргөн барьсан бөгөөд парламентын гишүүний үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсран ажиллах эсэх зохицуулалтыг хэд хэдэн янзын томъёоллоор хэлэлцсэн байна. Үндсэндээ *“парламентын гишүүн засгийн газрын гишүүн байж болно, болохгүй, эсхүл зөвхөн ерөнхий сайд парламентын гишүүн байх”* гэсэн саналууд илүү хүчтэй яригдсан. Улмаар депутатуудын дийлэнх олонх нь *“Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй”* гэсэн томъёоллыг дэмжсэн байна. (§29.1)

Түүнээс хойш энэ заалтад 2000, 2019 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг.

1992 онд Үндсэн хуулийг батлахдаа судлаачид, иргэдийн оролцоог маш сайн хангаж, депутатууд олон талаас нь удаан хугацаанд нухацтай хэлэлцэж Үндсэн хуулийн төслийг боловсруулж, АИХ-д өргөн барьж байсан. Энэ жишгийг 2000 оны нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ баримтлаагүйгээс “дордуулсан долоон өөрчлөлт” гэх асуудлыг үүсгэжээ.

Парламентын гишүүн Засгийн газарт орж ажиллахыг бусад хуулиар зохицуулах оролдлогыг 1992, 1993, 1998 онд хийсэн боловч үүнийг Үндсэн хуулийн цэц хүчингүй болгож байжээ. Тодруулбал, Улсын Их Хурал (УИХ)-ын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран гүйцэтгэж болох агуулгатай заалтууд Улсын Их Хурлын тухай хууль²⁷⁴, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд²⁷⁵ оруулсныг Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр тус тус хүчингүй болгосон.

²⁷³ Доктор, профессор Ч.Энхбаатар, “Парламентын гишүүний үүрэг бусад ажил, үүрэгтэй үл нийцэх зарчмын ойлголт, үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт”, Төрийн удирдлага 2018 (III) дугаар 04.

²⁷⁴ Улсын Их Хурлын тухайн хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 1995.01.04, Дугаар 01. Улсын Их Хурлын хуулийн 22 дугаар зүйлийн 1 дүгээр заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтыг зөрчсөн эсэх тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 1996.07.17, Дугаар 06.

²⁷⁵ Улсын Их Хурлын хуулийн 22 дугаар зүйлийн 1 дүгээр заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтыг зөрчсөн эсэх тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 1998.10.23, Дугаар 09.

1999, 2000 Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүн давхар байж болохоор дахин баталсан байдаг. Энэ нь парламентаас хууль тогтоомжийг хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулж, улс төрчид эрх мэдлийн төлөө тэмүүлэх санаархлыг хөөрөгдөх болсон гэж зарим судлаачид тайлбарлажээ.

Улмаар 2019 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт дахин оруулсан ба ингэхдээ 2000 онд гаргасан алдааг давтахгүйн тулд 1992 оны Үндсэн хуулийг батлах үйл явцын жишигт ойртуулсан байдлаар хийсэн. Нэмэлт, өөрчлөлтөөр шинэ Үндсэн хуулийн төрийн эрх мэдлийг хуваарилах, хяналт тэнцлийг хангах агуулгыг сэргээж, УИХ-ын гишүүн нь Засгийн газрын гишүүн байх боломжийг хязгаарласан. Үүнийг судалгаа шинжилгээнд суурилан, иргэд, олон нийтийн санаа бодлыг сонсож, урт хугацаанд олон талаас нь хэлэлцэж шийдвэрлэсэн. Тухайлбал, 2017 оны Зөвлөлдөх санал асуулгаар оролцогчдын дийлэнх нь УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллахыг дэмжээгүй бол, Ард нийтийн хэлэлцүүлгээр 60 гаруй хувь нь Ерөнхий сайд болон Засгийн газрын нийт гишүүний гуравны нэг нь УИХ-ын гишүүн байж болохоор хязгаарлахыг дэмжсэн байна.

Монгол Улсын хувьд олон улсын жишгээр парламентын цөөн гишүүнтэй орны тоонд орох бөгөөд УИХ-ын гишүүний албыг давхар хашиж байгаа Засгийн газрын гишүүний тоо олон байх нь ихэнхдээ сөрөг үр дагавартай гэж үзэх явдал түгээмэл байв. Ихэнх шүүмжлэл нь УИХ, Засгийн газрын ажил үүрэг давхардах, ажил цалгардах явдал гарч, хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын харилцан хяналт-тэнцэл алдагдаж, хариуцлага сулрах нөхцөл үүсгэдгийг онцолсон байна.

Олон улсын туршлага

Олон Улсын Парламентын Холбоо (IPU)-ны гишүүн дэлхийн 185 улсаас 92 улсад парламентын гишүүн засгийн газрын гишүүний үүргийг хавсарч болдоггүй бол 83 улсад парламентын гишүүд засгийн газрын гишүүн байх ёстой, эсхүл байж болохоор тогтоосон байна. Үүнээс:

- Засгийн газрын гишүүн заавал Парламентын гишүүн байх – **24 улс**,
- Засгийн газрын гишүүн Парламентын гишүүн байж болох – **59 улс** байна.

Эдгээрээс парламентын засаглалтай 75 улсыг дэлгэрүүлэн авч үзэхэд 51 нь парламентын гишүүн засгийн газрын гишүүн байхыг шаарддаг болон зөвшөөрдөг бол, 24 улс хориглодог байна:

- Засгийн газрын гишүүнийг заавал парламентын гишүүн байхыг шаарддаг – **20 улс**,
- Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байхыг зөвшөөрдөг – **31 улс**,
- Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байхыг хориглодог – **24 улс** байна.

А.Парламентын гишүүн засгийн газрын гишүүнээр хавсран ажилладаг эсэх

Бусад орны туршлагаас харахад **парламентын гишүүн засгийн газрын гишүүнээр хавсран ажилладаг эсэх** тухай сонголт нь ихэвчлэн тухайн орны парламентын нийт гишүүдийн тоо болон парламентын танхимын тоо, засаглалын хэлбэр зэргээс шууд хамаардаг. Ерөнхийлөгчийн болон холимог засаглалтай улсад засгийн газрын гишүүн нэгэн зэрэг парламентын гишүүн байхыг ихэвчлэн хориглодог. Парламентын сонгодог тогтолцоонд засгийн газрыг ихэвчлэн парламентын гишүүдээс бүрдүүлэх журам үйлчлэх нь элбэг байдаг. Энэ хоёр албан тушаалыг хослох сонголт хийсэн орнуудад парламентын гишүүдийн тоо нь ихэвчлэн 200-аас дээш тоотой, нөгөө талаас парламент нь 2 танхимтай бөгөөд засгийн газрын гишүүд нь зөвхөн доод танхимд харьяалагддаг байна.

Нэг танхимтай орнуудад Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байхыг ихэвчлэн хориглодог (Умард Македон, Серби, Болгар гэх мэт) бол зөвшөөрдөг орнуудын хувьд ихэнхдээ Үндсэн хуулиараа ямар нэгэн хязгаарлалт тавьдаг. Тухайлбал, Финланд улсад сайд нарыг парламентын байнгын хороодод оруулдаггүй бол Доминикт сенаторуудын дундаас гурваас илүүгүй сайдыг томилдог (Бангладеш, Финланд, Доминик гэх мэт).

Б.Парламентын гишүүний хавсарч үл болох ажил, албан тушаал

Парламентын гишүүний хавсарч үл болох ажил, албан тушаалтай холбоотой зохицуулалтыг парламентын засаглалтай 75 улсын Үндсэн хуульд дараах байдлаар заасан байна:

- *нэрлэн заасан* (Люксембург, Унгар, Турк гэх мэт);
- *тоймлон заасан* (Франц, Серби, Сингапур гэх мэт);
- *тодорхойлон заагаад түүнээс бусдыг хориглосон* (Доминикан, ОХУ, Молдова гэх мэт);
- *бусад хуулиар* (Словени, БНСУ гэх мэт).

Улсуудын зохицуулалтаас харахад төрийн эрх мэдлийг хуваарилах үзэл баримтлалын дагуу төрийн захиргааны болон бусад албан тушаал хавсрахыг парламентын гишүүдэд шууд хориглох нь зонхилж байна. Тухайлбал, депутат засгийн газраас цалинжихыг (Пакистан, Филиппин гэх мэт), хараат бус агентлагийн захирлын тушаал хашихыг (Косово), төрийн захиргааны өндөр албан тушаалд ажиллахыг (Албани гэх мэт), төрийн албан хаагч байхыг (Польш, Серби), Төрийн Зөвлөлийн гишүүний алба хашихыг (Нидерланд), Радио, телевизийн Үндэсний хорооны гишүүнээр сонгогдохыг (Польш) тус тус хоригложээ.

Мөн Парламентын гишүүдийг засгийн газраас явуулж буй ажиллагаатай хутгалдахыг сонирхлын зөрчлийн илрэл гэж үзэн хязгаарлах нь түгээмэл байдаг. Тухайлбал, Грек улсын Үндсэн хуулиар (57 дугаар зүйл) төрийн дэмжлэгтэй, эсхүл төрийн байгууллагаас хөрөнгө оруулалт хийгдэж байгаа байгууллагын удирдлагад парламентын гишүүн ажиллахыг хориглосон байдаг.

Өөрчлөлтийн зэрэг ба сөрөг тал

ЭЭРЭГ ТАЛ	СӨРӨГ ТАЛ
Парламентын гишүүн засгийн газрын гишүүнээр хавсран ажиллахыг зөвшөөрдөг тохиолдолд (тодорхой хязгаартай)	
<ul style="list-style-type: none"> Засгийн газар парламент хоёрын хоорондын хямрал үүсэхээс сэргийлнэ. Парламентын гишүүнээр сонгогдсон буюу ард түмэнд хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь Засгийн газрын гишүүний үүргийг гүйцэтгэхэд туршлага, мэдлэгээ зориулах боломж илүү бүрдэнэ. Хамаарал бүхий этгээдийг Засгийн газарт орохыг хязгаарлаж, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх боломж нэмэгдэнэ. 	<ul style="list-style-type: none"> Парламентын гишүүн засгийн газрын гишүүнээр давхар ажиллаж байгаа хүний тоо олон байх нь парламентад байгаа фракц нь засгийн газарт нөлөөлнө. Парламент, засгийн газрын чиг үүргийн давхцал нэмэгдэж, энэ хоёр институцын чиг үүргийн ялгаа илүү бүдгэрнэ. Парламент, засгийн газрын харилцан хяналт, тэнцэл суларна. Хууль тогтооход Засгийн газрын гишүүний оролцоо багасч, хуулийн хүлээн зөвшөөрөгдөх чанарыг сулруулна.
Парламентын гишүүн засгийн газрын гишүүнээр хавсран ажиллахыг хориглодог тохиолдолд	
<ul style="list-style-type: none"> Парламентын засгийн газарт тавих хяналт сайжирна. Засгийн газраас хараат хүмүүс парламентад орох боломжийг хаана. Парламентын гишүүд аливаа ашиг сонирхол, эдийн засгийн нөлөөлөлд орохоос сэргийлнэ. Засгийн газрын гишүүн эрхэлсэн салбартаа дагнах, мэргэжлийн сайд томилогдох магадлал өснө. 	<ul style="list-style-type: none"> Парламентаас засгийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхгүй байх магадлалтай. Засгийн газрын гишүүнийг зөв сонгоход зарим бэрхшээл гарч болзошгүй.

ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙ ҮҮРЭГТ ҮЛ ХАМААРАХ АЖИЛ, АЛБАН ТУШААЛ ХАВСРАН АЖИЛЛАХ ТУХАЙ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

1. ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ

Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийн 4-р зүйлд, “БНМАУ-ын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах бөгөөд мөн Хурлын чөлөө цагт Улсын Бага Хуралд хадгалуулах, ба бас мөн Хурлын чөлөө цагт Бага Хурлын Тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино” гэж тус тус зохицуулжээ. Улсын Их ба Бага Хуралд сонгогдсон депутатууд нь орон тооны бус, үндсэн ажлын хажуугаар төлөөллийн үүргээ хэрэгжүүлдэг байсан учраас тэдний хувьд албан тушаал үл нийцэх зарчим үйлчилдэггүй байсан.²⁷⁶

1992 оны Үндсэн хуулиар энэхүү асуудлыг зохицуулснаас хойш мөн хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт (2000, 2019 онуудад) орсон байдаг.

1.1.1992 оны Үндсэн хуулийг хэлэлцэн батлах үеэр “Парламентын гишүүний үүрэгт үл хамаарах ажил, албан тушаал хавсран ажиллах” талаар хэлэлцсэн байдал

Үндсэн хуулийг (1992) хэлэлцэн батлах явцад төслийг нийт 5 удаа өөрчлөн өргөн барьсан бөгөөд парламентын гишүүний үүрэгт үл хамаарах ажил, албан тушаал хавсран ажиллах эсэх зохицуулалтыг тэдгээр төслүүдэд дараах байдлаар томъёолж байжээ.

Хүснэгт 1. Монгол Улсын Их Цаазын өөрчлөлтийн харьцуулалт²⁷⁷

1-р төсөл	2-р төсөл	3-р төсөл	4-р төсөл	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ	МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ	МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ	
УБХ-д өргөн барьсан хувь	Ард түмнээр хэлэлцүүлсэн хувь	УБХ-д өргөн барьсан хувь	УБХ-аас АИХ-д өргөн барьсан хувь	Батлагдсан хувь
1991.04.19	1991.06.05	1991.10.05	1991.11.07	1992.01.13
29 дүгээр зүйл	Гучин нэгдүгээр зүйл	Хорин есдүгээр зүйл	Хорин есдүгээр зүйл	Хорин есдүгээр зүйл
Хуулийн төслийн 30-р зүйлд тусгагдсан байна:	Хуулийн төслийн 32-р зүйлд тусгагдсан байна:	1. Улсын Их Хурлын гишүүн нь бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин харамж хүртэх бөгөөд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд , Засгийн газрын гишүүний болон хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй.	1. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин хангамж хүртэх бөгөөд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бөгөөд хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.	1. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна . Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй.
Монгол Улсын Их хурлын гишүүн нь Ерөнхийлөгч, Засгийн Газрын гишүүний болон хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад албан тушаал хавсран эрхэлж болохгүй.	Монгол Улсын Их хурлын гишүүн нь Ерөнхийлөгч, Засгийн Газрын гишүүний болон хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад албан тушаал хавсран эрхэлж болохгүй.			

Тайлбар: -үг, өгүүлбэр шинээр нэмэгдсэнийг тод хараар (“**bold**”),
 -үг, өгүүлбэрийг өөрчлөн найруулсныг доогуур зураасаар (“underline”),
 -үг, өгүүлбэр хасагдсаныг дундуур зураасаар (“~~strikethrough~~”),
 -зарчмын зөрүүтэй санал орхигдсон, өөрчлөлт орсон зэргийг тодруулав (“**highlighting**”) тус тус тэмдэглэв.

²⁷⁶ Доктор, профессор Ч.Энхбаатар, Парламентын гишүүний үүрэг бусад ажил, үүрэгтэй үл нийцэх зарчмын ойлголт, Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт, 2018 он.

²⁷⁷ СТ-15/206 Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба Монгол Улсын Их цаазын төслүүдийн (1991.VI.05, X.05, XI.07) харьцуулалт

Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах комиссоос анх 1991 оны 04 сарын 19-нд “Монгол Улсын Их Цааз”-ын төслийг Улсын Бага Хуралд өргөн барьсан бөгөөд Парламентын гишүүний үүрэгт үл хамаарах ажил, албан тушаал хавсран ажиллах эсэх тухай асуудал нь уг төслийн Гуравдугаар бүлгийн 30-р зүйлд *“Монгол Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхийлөгч, Засгийн Газрын гишүүний болон хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад албан тушаал хавсран эрхэлж болохгүй.”* гэсэн томъёоллоор орсон байна. Улмаар төслийг Улсын Бага Хурлаар 1991 оны 5-р сарын 17-ноос 6-р сарын 09-нийг хүртэл 2 удаа хэлэлцэн (1, 2-р хэлэлцүүлэг) зарим тодруулгыг хийж²⁷⁸ үндсэнд нь дэмжээд ард нийтээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын Их цаазын төслийг 1991 оны 6-р сарын 10-наас 1991 оны 9-р сарын 1-ний хооронд ард нийтээр хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлгийн явцад төсөлд 220000 санал гаргасны 40,8 хувь нь 3-р бүлгийн талаар ирсэн бөгөөд төсөлд ирүүлсэн бүх саналын 44,3 хувийг ямар нэгэн байдлаар төсөлд тусгасан гэж БНМАУ-ын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын дарга П.Очирбатын илтгэлд дурджээ.²⁷⁹

Ард нийтээр хэлэлцүүлсний дараа Их цаазын төсөлд нэлээд өөрчлөлт орсон бөгөөд энэ үед *“Улсын Их Хурлын гишүүний цалин хангамж, Ерөнхий сайд мөн парламентын гишүүн байхыг хориглох”* асуудлуудыг нэмж тусган, Улсын Бага Хурлын 4-р чуулганаар (1991.10.15) хэлэлцүүлэхэд депутатуудын дийлэнх олонх нь төслийн эх томъёоллыг дэмжсэнээр Ардын Их Хуралд өргөн барьсан байна. Харин цөөнхөөс *“Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байж болно, эсвэл Засгийн газрын гишүүдийн 1/3 нь парламентын гишүүн байж болно, зөвхөн Ерөнхий сайд засгийн газрын гишүүн байж болох”* гэсэн саналууд гаргаж байжээ.

Улмаар Ардын Их Хурал нь Үндсэн хуулийг (Их цааз) хэлэлцэх явцад (1991.12.04-12.05) эхний хэлэлцүүлгээр Улсын Бага Хурлаас өргөн барьсан эх төслийн томъёоллыг дийлэнх депутатууд дэмжиж байсан ч цөөнхөөс *“Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн гэснийг хасах”* санал оруулж нэлээд удаан хугацаанд мэтгэлцэн хэлэлцсэний эцэст уг санал дэмжигдэж хассан хувилбар болох *“Парламентын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй”* гэсэн томъёолол дээр депутатуудын дийлэнх олонх нь санал нэгдсэн байна.

1992 оны Үндсэн хуулийг (Их цааз) Улсын Бага Хурал болон Ардын Их Хурлаар хэлэлцэх үеэр парламентын гишүүн засгийн газрын гишүүн байхыг хориглох, засгийн газар, их хурал хоёр нь тусдаа байх нь парламентын хяналт тэнцлийг хадгална гэсэн үзэл санааг ихэнх депутатууд дэмжиж үг хэлж байсан байна. Хэдийгээр цөөнхөөс засгийн газрын гишүүн парламентын гишүүний үүргийг хавсрахыг дэмжсэн саналууд гаргасаар байсан ч хэлэлцүүлгийн явцад манай улсын нөхцөл байдалд тохирох эсэх дээр нухацтай ярилцсан байдаг. *Тухайлбал, Парламентын гишүүн Засгийн газрын гишүүн байж болохгүй гэдэг дээр* “Энэ нь сайн харвал 300-400 хүнтэй парламентуудад л элбэг байдаг. Парламент руу Засгийн газар нь ингээд ороод ирэх юм бол сүүдэр нь гарцаагүй дахиад ороод ирнэ. Өнөөдөр сүүдрийн Засгийн газар, жинхэнэ Засгийн газар хоёулаа тэнд байна. Манайх шиг цөөн гишүүнтэй дээр нь боловсон хүчин сул газарт бүтэхгүй санал юм”, *Парламентын гишүүн Засгийн газрын гишүүн байж болно гэсэн санал дээр* “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, УИХ-ын гишүүн байх тийм үүд хаалгыг нь нээж өгөх хэрэгтэй. Яагаад вэ гэхээр, Дэлхийн парламент хөгжсөн орнуудад тухайлбал ХБНГУ-д Засгийн газрын гишүүдийнх нь бараг 80-аад хувь нь, парламентынх нь гишүүд байгаа юм. Энэ нь гүйцэтгэх засаглалынхаа өөрөөр хэлбэл хууль биелүүлэх тэр процессыг дэмжиж өгч байгаа юм. Сөрөг тал нь энд

²⁷⁸ Улсын Бага Хурлын товчоон. Г.Чулуун. 2015 он

²⁷⁹ БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль (1990-1992) баримт бичгийн эмхэтгэл, 185-р хуудас.

парламентаас Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтын тухайд яригдана. Үүнийг УИХ-ынхаа хуулиар хэрэгжүүлж болно. Манай нөхцөлд бол бүх засгийн газрын гишүүдийн 80 хувь нь байх албагүй. Гол нь Их Хурлын гишүүн байх ийм нээлттэй эрхийг нь энд нээж өгөх хэрэгтэй байна.” гэх зэргээр санал үндэслэлээ хэлж байсан бол энэ асуудлаар Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга Б.Чимид “Депутатын тоог олшруулбал Засгийн газрынхныг нэлээн оруулах шаардлагатай болно. Ийм парламент жаахан сулрах талтай. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын өмнөө эсэргүүцэл багасч байна. Сайн тал нь Засгийн газартайгаа ажиллах, бодлогоо ойлгоход нэлээд тустай. Тиймээс дундын вариант байж болох юм. Хоёрдугаарт, үл хамаарах ажил албан тушаал хавсарч болохгүй гэж байна, Үүнд олон нийтийн байгууллага ямар нэгэн сонгуульт ажил орох уу гэж байна. Би орно гэж хэлнэ. Зөвхөн Парламентын доторх намын сонгуулийн асуудал энд хамаарахгүй.” хэмээн тайлбарлаж байжээ.

1.2. Парламентын гишүүний үүрэгт үл хамаарах ажил, албан тушаал хавсран ажиллах талаар Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тойм

1992 онд Үндсэн хуулиар “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэж заажээ. Энэхүү заалтын Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүнд хамаарах эсэх нь 1996 онд Ардчилсан эвсэл засгийн эрх мэдлийг авсны дараахан УИХ-ын гишүүний албыг хавсрах нь Үндсэн хууль зөрчиж байгаа тухай нэхэмжлэлийг иргэн Д.Ламжав Үндсэн хуулийн цэцэд гаргаснаар нийтийн анхаарлын төвд орж ирсэн байна.

УИХ-ын гишүүн нэгэн зэрэг Засгийн газрын гишүүний үүргийг хавсрах эсэх. Засгийн газарт хэн орж ажиллах, ийнхүү ажиллахын тулд парламентын гишүүнээс чөлөөлөгдөх шаардлагатай эсэх нь олон жил маргаантай асуудал байсан юм.

Парламентын гишүүн Засгийн газарт орж ажиллахыг бусад хуулиар зохицуулах оролдлогыг 1992, 1993, 1998 онд хийсэн боловч үүнийг Цэц хүчингүй болгож байжээ.²⁸⁰

2000 оны нэмэлт, өөрчлөлтийн тухай. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарч парламентын гишүүн засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран ажиллахыг хориглосон. Ийнхүү хатуу хориглосон тохиолдолд парламентад олонх болсон намын лидерүүд Засгийн газартаа орох боломж хязгаарлагдаж, парламентын олонх Засгийн газраа ойр ойрхон өөрчилж, бодлогын уялдаа, нэгдмэл байдал алдагдаж ирсэн нь 2000 онд Үндсэн хуульд өөрчлөлт оруулахад хүргэсэн нэг шалтгаан болсон гэж үздэг.

2000 онд Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэж өөрчлөлт оруулснаар Засгийн газрын гишүүн ямар нэг хязгаарлалтгүйгээр УИХ-ын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэх боломжтой болсон.

Иргэд 1999, 2000 оны энэхүү нэмэлт, өөрчлөлтийн талаар Үндсэн хуулийн Цэцэд хандан маргаан үүсгэсэн, ба Цэц дунд суудлын хуралдаанаараа Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэжээ. УИХ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг

²⁸⁰ 1992 онд Улсын Их Хурлын тухай хуулийг, 1993 онд Засгийн газрын тухай хуулийг батлахдаа Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран гүйцэтгэж болох агуулгатай заалтууд оруулсныг Үндсэн хуулийн Цэц 1996 онд, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд энэ асуудлыг тусгасныг 1998 онд Үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр тус тус хүчингүй болгож байжээ. (Дүгнэлт: 01/1995 01.04. Дүгнэлт: 06/1996 07.17. Дүгнэлт: 09/1998.10.23)

хүлээж аваагүй, өөрчлөлтийг тэр чигээр нь дахин баталсан.²⁸¹

Үндсэн хуульд дээрх нэмэлт, өөрчлөлт орсноос хойших хугацаанд Засгийн газар хэд хэдэн удаа солигджээ. Эдгээр Засгийн газрын бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүд олноор орж, Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран гүйцэтгэсээр ирсэн юм. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран гүйцэтгэсэн байдал (1992-2018 он)²⁸²

Засгийн газар, Ерөнхий сайд/ажилласан хугацаа	ЗГ-ын гишүүдийн нийт тоо	УИХ-ын гишүүн сайдын тоо
П.Жасрай (1992.07.21-1996.07.19)	19	5
М.Энхсайхан (1996.07.19-1998.04.23)	10	0
Ц.Элбэгдорж (1998.04.23-1998.12.09)	10	0
Ж.Наранцацралт (1998.12.09-1999.07.22)	10	0
Р.Амаржаргал (1999.07.30-2000.07.26)	10	0
Н.Энхбаяр (2000.07.26-2004.08.20)	13	4
Ц.Элбэгдорж (2004.08.20-2006.01.13)	18	13
М.Энхболд (2006.01.25-2007.11.22)	17	15
С.Баяр (2007.11.22-2008.09.11)	16	8
С.Баяр (2008.09.11-2009.10.28)	15	11
Сү.Батболд (2009.10.29-2012.01.20-27)	15	12
Сү.Батболд (2012.01.20-2012.08.09)	14	9
Н.Алтанхуяг (2012.08.09-2014.11.05)	19	17
Ч.Сайханбилэг (2014.11.05-2015.09.08)	19	10
Ч.Сайханбилэг (2015.09.08-2016.07.21)	19	14
Ж.Эрдэнэбат (2016.07.21-2017.09.07)	16	8
У.Хүрэлсүх (2017.09.08-2021.01.27)	16	15

Монголын олон улс төрч, судлаачид энэхүү зохицуулалт нэлээд сөрөг үр дагавар авчирсан, тухайлбал, төрийн эрх мэдлийг хуваарилах зарчимд харшилсан, парламентын хууль батлах эрх болон парламентын хяналтыг сулруулсан гэж үздэг. Хэдийгээр манайтай адил төрийн удирдлагын хэлбэртэй улсад парламентын гишүүн нь засгийн газрын гишүүний үүргийг хавсрах нь ердийн үзэгдэл боловч ийм улс орнуудад парламент нь ихэвчлэн хоёр танхимтай, олон гишүүнтэй байдаг бөгөөд зөвхөн доод танхимын гишүүд нь Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэдэг жишигтэй. Энэ нөхцөлд засгийн газрын гишүүний ажил давхар хашдаг парламентын гишүүд парламентын шийдвэрт нөлөөлөх жин бага байдаг учраас хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын харилцан хяналт-тэнцлийн сөрөг нөлөө нь цөөн парламентын гишүүнтэй манай улсыг бодвол харьцангуй бага байдаг байна.

2000 оны нэмэлт, өөрчлөлт нь эрдэмтэн судлаачид болон олон нийтийн зүгээс ихээхэн шүүмжлэл дагуулж байсан учраас 2019 онд дахин нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ иргэд, олон нийт, судлаачдын оролцоог сайн хангаж, Зөвлөлдөх санал

²⁸¹ Энэ нь тухайн үед Үндсэн хуулийн хямрал үүсгэж байсан юм. Харин 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар МАХН (одоогийн МАН-аас нэр дэвшсэн Ерөнхийлөгч Багабанди дахин ялалт байгуулж улиран сонгогдсоны дараа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн, түүнчлэн энэхүү нэмэлт, өөрчлөлтийн талаар иргэд Үндсэн хуулийн цэцэд хандсан боловч Цэц маргаан үүсгэхээс татгалзсанаар эдгээр нь хүчин төгөлдөр болсон юм.

²⁸² “Төрийн удирдлага” онол, арга зүйн сэтгүүл. 2018.III. Дугаар 4

асуулга, нээлттэй хэлэлцүүлэг, цахим санал асуулга зэргийг явуулж, бусад орны туршлагыг судлах зэргээр удаан хугацаанд ихээхэн нухацтай ажилласан.

2017 оны ажлын хэсгийн асуулга. 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын захирамжаар “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг судлах, санал, дүгнэлт боловсруулах эрдэмтэн судлаачдын ажлын хэсэг” байгуулагдсан. Ажлын хэсгийг доктор, профессор Ч.Энхбаатар ахалсан бөгөөд ажлын хэсэг нь нийт 3692 иргэнийг түүвэрлэн авч судалгаанд хамруулсан ба тэдгээрийг түүвэрлэхдээ Монгол Улсын сонгуулийн насанд хүрсэн нийт хүн амыг эх олонлог гэж үзэн, эх олонлогоос түүвэр олонлогийн хэмжээг тооцохдоо хүн амын нас, хүйсийн харьцааг түүвэр олонлогт пропорционал байхаар тооцсон байна.

Судалгаагаар УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүн байхыг хэсэгчлэн буюу бүрэн хязгаарлах санал маш их гарсан. Мөн тус ажлын хэсгээс явуулсан судалгаанд хамрагдсан иргэд “Засгийн газрын гишүүн нэгэн зэрэг УИХ-ын гишүүн байх нь зөв үү” гэсэн асуултад дараах байдлаар хариулсан байна:

- 1817 хүн буюу 51.7 хувь нь “үндсээрээ буруу”;
- 686 хүн 20.0 хувь нь “ерөнхий чиг үүргийн яамдын сайдууд л УИХ-ын гишүүн байх нь зөв”;
- 589 хүн буюу 16.8 хувь нь “зөвхөн Ерөнхий сайд л УИХ-ын гишүүн байх нь зөв” гэж хариулсан байна.

Асуулгад хамрагдсан иргэдийн зөвхөн 3.9 хувь нь одоогийн зохицуулалтыг зөв гэж үзсэн байна.

2017 оны зөвлөлдөх санал асуулга.²⁸³ Дээрх ажлын хэсгийн судалгааны үр дүн болон бусад судалгаа, шинжилгээ, хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн 2017 оны 4 дүгээр сард “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар зөвлөлдөх санал асуулгыг хоёр үе шаттай зохион байгуулсан. Санал асуулгад улсын хэмжээнд 1568 өрхийг газар зүйн байршлаар, санамсаргүйгээр сонгож, эхний санал асуулгад 1515 өрх оролцсон. Хоёр дахь шатны санал асуулгад 699 хүн оролцсон байна.

Зөвлөлдөх санал асуулгын 1 дүгээр сэдвийн 1.2 дахь дэд сэдэв нь “Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээс дээшгүй хувь нь УИХ-ын гишүүн байж болохоор хязгаарлах” асуудал байв.

Дээрх хоёр шатны зөвлөлдөх санал асуулгын үр дүнг нэгтгэн дүгнэсэн **Зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмжид** Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээс дээшгүй хувь нь УИХ-ын гишүүнээр давхар ажиллаж болохоор хязгаарлах шаардлагагүй гэж үзжээ.

Хүснэгт 3. Зөвлөлдөх санал асуулгаар гарсан санал (хувиар)

	Нэг дэх санал асуулга	Хоёр дахь санал асуулга
Засгийн газрын гишүүдийн гуравны нэг хүртэл хувь нь УИХ-ын гишүүнээр давхар ажиллаж болохоор хязгаарлах		
Дэмжсэн	37.4	34.2
Эсэргүүцсэн	52.5	53.4

²⁸³ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар явуулсан анхдугаар зөвлөлдөх санал асуулгын дүнгийн тайлан, МУУСХ, 2017 он

Өөрөөр хэлбэл, Засгийн газрын гишүүн УИХ-ын гишүүнээр давхар ажиллахыг дэмжээгүй байна. Эхний судалгаагаар оролцогчдын 52.5 хувь нь, хоёр дахь судалгаагаар 53.4 хувь нь 0-4 оноог сонгосон байна. Энэ нь дундаж утгад ойрхон байгаа учраас зөвлөлдөх санал асуулгын 2 дахь шатны чанарын судалгаа болон бусад холбогдох судалгааны мэдээллээр тодруулсны үндсэн дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд оновчтой болгож тусгах эсэхийг авч үзвэл зохилтой гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах тухай” УИХ-ын 2017 оны 39 дүгээр тогтоол.²⁸⁴

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр УИХ-ын даргад өргөн барьсан. Энэхүү төслийг ард нийтээр хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзэж УИХ-ын 39 дүгээр тогтоолыг баталсан. Төслийг олон нийтээр хэлэлцүүлэхдээ 21 аймаг, 9 дүүрэгт 14 хоногийн хугацаанд 65 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулжээ.

Хэлэлцүүлгээр Ерөнхий сайд болон Засгийн газрын нийт гишүүний гуравны нэг нь УИХ-ын гишүүн байж болохоор хязгаарлах гэсэн асуултад нийт 270672 хүн санал өгснөөс:

- дэмжсэн - 163953 буюу 60.5 хувь;
- дэмжээгүй - 102311 буюу 37.8 хувь;
- өөр саналтай - 4408 буюу 1.7 хувь байсан байна.

2019 оны нэмэлт, өөрчлөлтийн тухай. Уг нэмэлт, өөрчлөлтөөр 1992 оны Үндсэн хуулийн төрийн эрх мэдлийг хуваарилах, хяналт тэнцлийг хангах агуулгыг сэргээж, УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүн байх боломжийг хязгаарлах шаардлагатай байгааг эш үндэс болгон, Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт өөрчлөлт оруулжээ.

2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Д.Лүндээжанцан УИХ-д өргөн барьсан.

1992 оны Үндсэн хуулийн заалт	2019 оны нэмэлт, өөрчлөлтийн заалт
§39.1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.	§39.1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.

Манай улсын хувьд УИХ-ын гишүүн нь Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран ажиллахад аливаа хязгаар тогтоогоогүй нь онолын хувьд ч, туулж ирсэн туршлагаасаа үзсэн ч сөрөг үр дагавар нь давамгайлж, олон нийтийн шүүмжлэлийг дагуулсаар байсан тул уг хоёр албан тушаалыг хавсарч болох тодорхой хязгаарыг Үндсэн хуулиар тогтоож өгчээ.

УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүнээс өөр ажил, албан тушаал эрхлэх боломжийн тухай. Манай улсын хувьд УИХ-ын гишүүний хавсран гүйцэтгэж болох ажил, албан тушаалыг хуулиар зөвшөөрөх байдлаар тогтоож, хуулиар зөвшөөрсөн эдгээр ажил, албан тушаалаас бусад ажил, албан тушаалыг хориглосон байдаг. Харин сонгуульд нэр дэвшихийг хориглосон хатуу зохицуулалт байхгүй юм.²⁸⁵

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт УИХ-ын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд:

- Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн;
- улс төрийн намын сонгуульт албан тушаал;

²⁸⁴ Монгол Улсын Их Хурлын түүхэн товчоон, УИХТГ, 2020 он, 89 дэх тал

²⁸⁵ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар, УБ., 2017 он.

- төрийн бус байгууллагын сонгуульт албан тушаал;
- багшлах болон эрдэм шинжилгээний ажил, албан тушаал хавсран гүйцэтгэх эрхтэй гэж заажээ. Үүнд зааснаас бусад ажил, албан тушаалыг хориглоно.

Үндсэн хуулийн цэцийн холбогдох дүгнэлтүүд. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 66.2.1 дэх заалтын дагуу УИХ-ын гишүүн Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн үндэслэлээр, мөн зүйлийн 66.2.4 дэх заалтын дагуу УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх талаар УИХ-д дүгнэлт гаргаж болно.

- *УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүнээс өөр ажил, албан тушаал эрхлэх асуудлаар*

УИХ-ын гишүүн өөрийн үүрэгт үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэснээр Үндсэн хуулийн 29 дүгээр зүйл зөрчсөн эсэх маргааныг 3 удаа үүсгэжээ.

УИХ-ын гишүүн Ц.Төрмандах, С.Зориг (хоёр удаа), Д.Ганболд, Ц.Элбэгдорж нар Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг шийдвэрлэж²⁸⁶, Ц.Төрмандах нь 1993 онд телевизийн нэвтрүүлэг бэлтгэх, солилцох, баримтат кино хийх, худалдах үйл ажиллагаа бүхий бүрэн бус хариуцлагатай "Монголын чөлөөт телевиз-1" компани байгуулан ажиллаж ирсэн, С.Зориг нь Стратеги судалгааны төвийг үүсгэн байгуулж, удирдахдаа аж ахуйн үйл ажиллагаа зэрэгцүүлэн явуулж байсан нь УИХ-ын гишүүний үүрэгт ажилтай ямар нэг хамааралгүй атал эдгээр УИХ-ын гишүүд Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргаж байв.²⁸⁷

- *УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллах эсэх асуудлаар*

Үндсэн хуулийн цэц нь УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллах эсэх асуудлаар гарсан маргаантай холбоотой хэд хэдэн удаа (1996, 1998, 2000 онуудад) дүгнэлт гаргасан.

УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний албыг хавсрах нь Үндсэн хууль зөрчиж байгаа тухай нэхэмжлэлийг анх иргэн Д.Ламжав Үндсэн хуулийн цэцэд гаргасан байдаг. Цэц 1996 оны 07 дугаар сарын 17-нд Д.Ламжавын өргөдлийг хүлээн авч дүгнэлт гаргасныг УИХ 07 дугаар сарын 30-нд хүлээн зөвшөөрөхөөс татгалзав. Мөн оны 09 дүгээр сарын 07-нд Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаас УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний үүргийг давхар хашиж болохгүй гэсэн өмнөх дүгнэлтээ тогтоолоор баталгаажуулжээ.

Парламентын гишүүн Засгийн газарт орж ажиллахыг бусад хуулиар зохицуулах оролдлогыг 1992, 1993, 1998 онд хийсэн боловч үүнийг Цэц хүчингүй болгож байжээ. *Тухайлбал*, 1992 онд Улсын Их Хурлын тухай хуулийг, 1993 онд Засгийн газрын тухай хуулийг батлахдаа УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран гүйцэтгэж болох агуулгатай заалтууд оруулсныг Үндсэн хуулийн Цэц **1996** онд, мөн Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд энэ асуудлыг тусгасныг **1998** онд Үндсэн хууль зөрчсөн үндэслэлээр тус тус хүчингүй болгосон байна.²⁸⁸ (Дэлгэрэнгүйг хүснэгтээс үзнэ үү)

²⁸⁶ Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Төрмандах Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчсөн эсэх тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 1994.01.12, 03, Дугаар 03.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Элбэгдорж, Д.Ганболд, С.Зориг нар Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 1994.02.23, Дугаар 04.

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Зориг Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 1994.06.15, Дугаар 06.

²⁸⁷ Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Төрмандах Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчсөн эсэх тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 1994.01.12, Дугаар 03.

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Зориг Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 1994.06.15, Дугаар 06.

²⁸⁸ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 1995.01.04, Дугаар 01.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дүгээр заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 1996.07.17, Дугаар 06. УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалт, түүнийг үндэслэн гарсан УИХ-ын тогтоолууд

Улмаар Иргэн С.Нарангэрэлээс 1999 оны 12 дугаар сарын 31-нд Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдлийн дагуу УИХ-аас 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүхэлд нь хүчингүй болгосон дүгнэлт гаргасан ч 2000 онд УИХ-аас түүнийг дахин хэвээр нь баталжээ. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн талаар иргэд Үндсэн хуулийн цэцэд хандсан боловч Цэц маргаан үүсгэхээс татгалзсан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 4. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллах эсэхтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтүүд

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт	
Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт	
1996.07.17, Дугаар 06 Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дүгээр заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэх тухай маргааны талаар ²⁸⁹	ҮНДЭСЛЭЛ: Улсын Их Хурал, түүний гишүүний үүргийг Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийн 20, 23, 25, 29 дүгээр зүйлүүдэд тодорхой заажээ. Засгийн газрын гишүүний албан тушаал нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д байгаа "... хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал" гэсэн ойлголтод хамаарахгүй болох нь хуралдааны явцад цугларсан нотлох баримтуудаар батлагдаж байна. Эдгээрээс үзэхэд Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчиж байна гэсэн иргэн Д.Ламжавын гомдлыг хангах үндэслэлтэй байна. ДүГНЭЛТ: Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн: 1/ Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгална. Засгийн газрын бүрэлдэхүүнд байх Улсын Их Хурлын гишүүдийн тоо Засгийн газрын нийт гишүүний гуравны нэгээс хэтрч болохгүй. 2/ Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын байнгын болон бусад хорооны даргаар сонгогдож болохгүй бөгөөд Засгийн газарт итгэл хүлээлгэх, түүнийг огцруулах, өөрийг нь Засгийн газрын гишүүнээр томилох зэрэг өөртэй нь шууд холбогдсон асуудлаар санал хураахад таслах эрх эдлэхгүй. 3/ Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнд орвол энэ хоёр албан тушаалын цалин, хангамжийн аль нэгийг нь сонгох эрхтэй. Түүний ажлын цагийг зохицуулах журмыг Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдтай зөвшилцөн захирамжаараа тогтооно" гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй" гэсэн заалтыг зөрчиж байна.
1998.10.23, Дугаар 09 УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалт, түүнийг үндэслэн гарсан УИХ-ын тогтоолууд Ундсэн хуулийн 29 дүгээр зүйлийн нэг дэх заалтыг зөрчсөн	ҮНДЭСЛЭЛ: Иргэн Д.Ламжаваас гаргасан Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн нэг дэх хэсэг, 8 дугаар зүйлийн холбогдох хэсэг, заалтууд болон УИХ-ын бусад холбогдох тогтоолууд Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн гэж үзсэн нь хууль зүйн үндэслэлгүй юм" гэжээ. ДүГНЭЛТ: 1. Монгол Улсын Засгийн газрын гишүүний албан тушаал, түүний үүргийг Улсын Их Хурлын гишүүний үүрэгт хамааруулан үзэх хууль зүйн үндэслэл Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоогдохгүй байна. 2. УИХ-ын гишүүний үүрэгт Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч болохоор хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн утга агуулгатай зөрчилдсөн байна.

²⁸⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1114>

эсэх тухай малаар ²⁹⁰	3.УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1, 8 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх талаар гаргасан УИХ-ын тогтоолууд нь уг хуулийн заалт хүчинтэй эсэхээс шууд хамаарах тул тухайн тогтоолуудын талаар тусгайлан дүгнэлт гаргах шаардлагагүй гэж үзэв. Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх "Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах", мөн зүйлийн 3 дахь хэсгийн "УИХ-ын гишүүн Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж болно" гэсэн заалтууд ба 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт байгаа "Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдох" гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "хуулиар тогтоосон үүрэгт нь ул хамаарах бусад ажил албан тушаал хавсарч болохгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.
1998.11.24, Дугаар 02 УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн тухай /тогтоол/	ҮНДЭСЛЭЛ: 1.УИХ гишүүнийхээ үүргийг хуульчлан тогтоох эрхтэй боловч энэхүү эрх нь Үндсэн хуулийн зарчим, зүйл, агуулгаар хязгаарлагдах ёстойг үл харгалзан Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. 2.УИХ-ын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран ажиллаж болох тухай УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн ялгаа зааг, харилцан бие биедээ хяналт тавих Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын агуулгатай зөрчилдөж байна. 3.Иргэн Д.Ламжавын өргөдөл дурдсан Улсын Их Хурлын тогтоолууд нь УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтууд хүчинтэй эсэхээс шууд хамаарах тул хамтатган эцэслэн шийдвэрлэх шаардлагагүй байна. ДҮГНЭЛТ: 1.Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалт "Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах", мөн зүйлийн 3 дахь хэсгийн "УИХ-ын гишүүн Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж болно", 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдох" гэсэн заалтуудыг тус тус хүчингүй болгосугай.
2000.03.15, Дугаар 03 Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааны талаар ²⁹¹	ҮНДЭСЛЭЛ: 1.Монгол Улсын Их Хурал 1999 оны 12 дугаар сарын 24-нд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн нь Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2; далдугаар зүйлийн 1 дэх заалтад нийцээгүй байна. 2.Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулийн жаран наймдугаар зүйлийн 1 дэх заалтыг хэрэгжүүлэх боломжийг Үндсэн хуулийн Цэцэд олгоогүй байна. 3.Эдгээрээс үзэхэд Улсын Их Хурлаас баталсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2; 68 дугаар зүйлийн 1; 70 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчиж байна гэсэн иргэн С.Нарангэрэл, Н.Хайдав, Н.Баасанжав, Д.Чулуунжав, Н.Отгон, О.Жамбалдорж нарын гомдлыг хангах үндэслэлтэй байна.

²⁹⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawid=1086>

²⁹¹ <https://legalinfo.mn/mn/detail?>

ДҮГНЭЛТ:

1.Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт” нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т заасан “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, жаран наймдугаар зүйлийн 1-д заасан “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно”, далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2, жаран наймдугаар зүйлийн 1, далдугаар зүйлийн 1 дэх хэсгээс бусад зүйл, заалтын талаар иргэдээс гаргасан гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай.



2. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

2.1. Парламентын гишүүний үүрэгт үл хамаарах ажил, үүргийн тухай ойлголт

Хууль тогтоох үүрэг нь парламентын гишүүний үндсэн үүрэг мөн тул уг үүрэгт үл хамаарах аливаа цалинтай, цалингүй ажил, үүргийг хавсран гүйцэтгэхийг хориглох нь парламентад ёсны нэг үндсэн зарчим байдаг. Үүнийг олон улсад "албан тушаал үл нийцэх зарчим" гэж томъёолдог (оросоор "несовместимость Должностей": англиар "incompatibility of positions/posts"). Парламентын гишүүний ажил үүрэгтэй холбоотой ийм хязгаарлалтыг дэлхийн ихэнх улс үндсэн хуулиараа тогтоосон байдаг.²⁹²

Парламентын гишүүн Үндсэн хуулиар өөрт олгогдсон бүрэн эрхээс гадуур ажил, албан тушаал хавсрах эсэх тухай асуудал нь төрийн эрх мэдлийн хуваарилалт, түүний мөн чанартай холбоотой асуудал юм. Зарчмын хувьд:

- төрийн эрх мэдлийн хуваарилалтын тэнцвэртэй байдлыг хангах;
- төрийн засаглалын хууль ёсны зөвшөөрөгдсөн байдлыг баталгаажуулах,
- парламентын гишүүний эрх зүйн байдлыг тодорхойлох,
- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах;
- парламентын үр нөлөөг хангахтай холбоотой юм.

Онолын хувьд төрийн эрх мэдлийн хуваарилалтыг төрийн байгуулалт, чиг үүрэг, хүний нөөцийн гэсэн үндсэн гурван түвшинд авч үздэг. Тиймээс парламентын гишүүний төлөөлөх, хууль тогтоох, хянан шалгах чиг үүрэгт харшлах, сөргөөр нөлөөлөх ажил, албан тушаалыг хавсарч үл болох албан тушаал гэж тогтоон хориглосон байдаг. Өөрөөр хэлбэл, хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь аливаа байдлаар саад учруулахуйц, цаашлаад төрийн эрх мэдлийн хуваарилалтын зарчим, эрх мэдлийн салаа мөчир хоорондын чиг үүрэг, үйл ажиллагааны тэнцлийг алдагдуулахуйц ажил, албан тушаалыг хуулиар хориглодог учиртай.²⁹³

Парламентын гишүүнд Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхээс гадуур, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаалыг:

- парламентын гишүүний сонгогдож болохгүй албан тушаал;
- парламентын гишүүний хавсарч үл болох ажил, албан тушаал гэж зааглан тодорхойлсон байдаг.

"Сонгогдож болохгүй" гэсэн ойлголт нь хууль зүйн хувьд парламентын гишүүн байж болохгүй гэсэн утгатай гэжээ. Тухайлбал, Вестминстерийн загварын орнуудад төрийн албан хаагчид болон улсын төсвөөс цалин хөлс авч ажиллаж буй хүмүүс парламентад сонгогдож болохгүй байхаар тогтоосон байдаг.

Харин "хавсарч үл болох" албан тушаал гэсэн ойлголт парламентад сонгогдсон гишүүн өмнөх ба шинэ албан тушаал хоёрын аль нэгийг нь сонгох утгыг илэрхийлдэг гэж үздэг.

Хуулиар тогтоосон үүрэгт үл хамаарах ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхийг хориглох зарчим нь төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмаас үүдэлтэй бөгөөд энэхүү журмыг хэрэглэсний ач холбогдол нь нэгдүгээрт, засгийн газраас хараат хүмүүс парламентад орох боломжийг хаах, хоёрдугаарт, парламентын гишүүд аливаа бизнесийн ашиг сонирхол, эдийн

²⁹² Доктор, профессор Ч.Энхбаатар, "Парламентын гишүүний үүрэг бусад ажил, үүрэгтэй үл нийцэх зарчмын ойлголт, Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт", Төрийн удирдлага 2018 (III) дугаар 04.

²⁹³ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар, 2017 он

засгийн бүлэглэлийн нөлөөллөөс хамгаалагдсан байх нөхцөлийг бүрдүүлэх, гуравдугаарт, парламентын гишүүдийг аливаа ашиг хөөх, бусдын эрх ашигт үйлчлэх, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашиглах зэрэг зохисгүй үйлдэл хийхээс сэргийлэхэд оршино.

2.2.Парламентын гишүүний үүрэгт үл хамаарах өөр бусад албан тушаал хавсрах эсэх

Улс орон бүр парламентын гишүүний үүрэгтэй үл нийцэх ажил үүргийг өөр өөрөөр тогтоосон байдаг. Зарим тохиолдолд төрийн алба хааж буй хэн боловч парламентын гишүүн байхыг хориглодог бол хязгаарлалтад хамрагдах албан тушаалтны жагсаалтыг хуулиар тодорхойлдог. Иймд тодорхой албан тушаал эрхэлж буй хүн бүх нийтийн сонгуульд өрсөлдөхөөр зориг шулуудсан бол зарим оронд сонгуулиас өмнө, зарим оронд парламентын гишүүнээр сонгогдсоныхоо дараа уг албан тушаалаа орхих, эсхүл парламентын суудлаас татгалзах эсэхээ шийдэх ёстой. Зарим тохиолдолд төрийн албан хаагч парламентад сонгогдсоноор хуучин албан тушаалаа хадгалах боловч гишүүн байх хугацаандаа тухайн албан тушаалын үүрэг гүйцэтгэхээс түдгэлзэнэ.

Харин судалгаа шинжилгээ, багшлах ажил эрхлэх болон төрийн болон хувийн ашиг сонирхлын зөрчилгүй олон нийтийн ажилд оролцохыг нийтлэг зөвшөөрдөг байна.

Улсуудын практикийг тоймлон авч үзвэл төрийн дээд албан тушаалд байх нь аливаа төрийн бусад албан тушаалтай үл нийцнэ гэсэн үзэл баримтлал давамгайлж байна. Тухайлбал, Герман, Латви, Унгар, Итали зэрэг нэлээд улсад ерөнхийлөгч нь парламентын гишүүн байхыг үндсэн хуулиараа хориглосон бол Орос болон Франц улс энэ асуудлыг нээлттэй орхисон байдаг. Гэхдээ Франц улсад үндсэн хуулийг хэрэгжүүлэх явцад тухайн нэр дэвшигч улсын ерөнхийлөгчөөр сонгогдмогц парламентын гишүүний үүргээ зогсоодог практик жишгийг тогтоожээ.²⁹⁴

Төрийн эрх мэдлийг хуваарилах үзэл баримтлалын дагуу төрийн захиргааны болон бусад албан тушаал хавсрахыг парламентын гишүүдэд шууд хориглох нь зонхилж байна. Тухайлбал, депутат засгийн газраас цалинжихыг Науру, Балба, Пакистан, Панам, Филиппин, Сингапур, Тайланд, хараат бус агентлагийн захирлын тушаал хашихыг Косово, төрийн захиргааны өндөр албан тушаалд ажиллахыг Албани, Тайвань төрийн албан хаагч байхыг Польш, Серби, Төрийн Зөвлөлийн гишүүний алба хашихыг Нидерланд, Радио, телевизийн Үндэсний хорооны гишүүнээр сонгогдохыг Польш, Төв банкны захирлаар томилогдохыг Чили улс тус тус хоригложээ.

Мөн Испани, Ангол, Албани, Польш, Словак, Унгар зэрэг улсад парламентын гишүүний албан тушаал үл нийцэх зарчим прокуроруудад, Италид мөрдөн байцаагч нарт, Нидерланд, Словак, Унгар, Испанид омбудсман (иргэний эрхийг хамгаалагч)-д хамаарна. Францын Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүд ч ийм хязгаарлалтад хамрагддаг байна.

Зарим орны хууль тогтоомжоор зэвсэгт хүчинд алба хааж буй хүмүүс парламентын гишүүнээр сонгогдох эрхгүй. Ийм хязгаарлалт аюулаас хамгаалах байгууллагын ажилтнууд (Испани, Грек, Албани, Косово, Того зэрэг улс), цагдаа нар (Албани, Грек, Испани, Польш, Итали, Сьерра Леон, Унгар), сонгуулийн хорооны гишүүд (Испани, Ангол), дипломатч (Албани Норвег), Ерөнхий аудитор, Тооцооны хорооны гишүүдэд (Барбадос, Гайана, Нидерланд, Польш, Унгар) бас хамаарна. Мөн санваартныг парламентын гишүүнээр сонгохгүй байх журам олон оронд үйлчилдэг²⁹⁵ байна.

²⁹⁴ Энэ журмыг анх ерөнхийлөгч М.Помпиду хэрэглэсэн байдаг.

²⁹⁵ Кипр (70-р зүйл), Израил (7 р зүйл), Мьянмар (121а), Сент-Люсия (26, 32-р зүйл), Сент Винсент ба Гренадин 26-р зүйл), Норвег (103-р зүйл).

Бусад улсын Үндсэн хуульд сонгуультны арилжаа наймааны идэвхийг хязгаарласан заалтууд байдаг. Тухайлбал, Киргизийн Үндсэн хуулиар парламентын (Жогорку Кенеш) гишүүдэд хувиараа хөдөлмөр эрхлэх, бизнесийн байгууллагын удирдах алба болон хяналтын зөвлөлийн ажлыг хавсран гүйцэтгэхийг хоригложээ (Т2.2 дугаар зүйл). Гамбийн Үндсэн хуульд зааснаар, радио, телевиз, сонин хэвлэлийг эзэмшдэг хүнийг парламентын гишүүнээр сонгохыг хориглоно (90 дүгээр зүйл).

Сонирхлын зөрчил гэсэн ойлголт сүүлийн үед батлагдаж байгаа Үндсэн хуулиудад нэлээд өргөн тусгагдсан байдаг. (Серби, Унгарын Үндсэн хууль зэрэг). Тухайлбал, Серби улсын Үндсэн хуульд зааснаар хуульд заасны дагуу ашиг сонирхлын зөрчил бүхий бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно" (102 дугаар зүйл) гэжээ.

Парламентын гишүүдийг засгийн газраас явуулж буй ажиллагаатай хутгалдахыг сонирхлын зөрчлийн илрэл гэж үзэж хязгаарлах нь түгээмэл байдаг. Тухайлбал, Грек улсын Үндсэн хуулиар (57 дугаар зүйл) төрийн дэмжлэг хүлээсэн, эсхүл төрийн байгууллагаас хөрөнгө оруулалт хийгдэж байгаа байгууллагын удирдлагад парламентын гишүүн ажиллахыг хориглосон байдаг. Франц улсад сонгуулийн тухай хуулийн дагуу парламентын гишүүний мандат нь төрийн дэмжлэг хүлээсэн буюу нийтийн үйлдвэрүүд, хадгаламж зээлийн хоршоод, барилгын зориулалтаар газар худалддаг байгууллагын удирдлагад ажиллахтай үл нийцнэ. Түүнчлэн парламентын гишүүд тендерт оролцохыг үл зөвшөөрөх, төрийн өмчийг худалдан авах, түрээслэхийг хориглох зэрэг олон хязгаарлалтыг тогтоосон байдаг.

Албан тушаал үл нийцэх журмыг шинжлэхдээ парламентын гишүүний албан тушаал засгийн газрын гишүүнийхтэй нийцэх эсэх асуудлыг тусад нь авч үзэх нь зүйтэй. Учир нь парламентч нэгэн зэрэг сайд байж болох асуудлыг улс орнууд харилцан адилгүй зохицуулдаг.

2.3. Парламентын гишүүн засгийн газрын гишүүний үүргийг хавсран ажилладаг эсэх

Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байж болох эсэх нь гол төлөв тухайн улсын тогтолцооны хэлбэрээс хамаардаг.

Ерөнхийлөгчийн болон холимог засаглалтай улсад засгийн газрын гишүүн нэгэн зэрэг парламентын гишүүн байхыг хориглодог. Парламентын сонгодог тогтолцоонд засгийн газрыг ихэвчлэн парламентын гишүүдээс бүрдүүлэх журам үйлчилдэг. Гэхдээ хэдийгээр парламентын засаглал бүхий улсад парламентын гишүүн нь засгийн газрын гишүүнээр давхар ажиллах нь хэвийн үзэгдэл байдаг боловч энэ нь тухайн тогтолцооны үндсэн шинж биш юм.²⁹⁶

Олон Улсын Парламентын Холбоонд ирүүлсэн 185 орны мэдээллийг авч үзэхэд: (Хүснэгт 4)

- Засгийн газрын гишүүнийг заавал парламентын гишүүн байхыг шаарддаг – 24 улс
- Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байхыг зөвшөөрдөг – 59 улс
- Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байхыг хориглодог – 92 улс байна.

²⁹⁶ Парламентат ёс. Лүндээжанцан.Д, Өлзийсайхан.Л, 2005, 129 дэх тал

Хүснэгт 5. Дэлхийн улс орнуудад парламентын гишүүн засгийн газрын гишүүний үүргийг хавсран ажилладаг эсэх²⁹⁷

Нөхцөл	Улсын тоо	Улсын нэр
Засгийн газрын гишүүн заавал Парламентын гишүүн байхыг шаарддаг	24	Австрали, Барбадос, Бостван, Бруней, Куба, Сватини, Фижи, Энэтхэг, Ирланд, Лесото, Мальта, Маврики, Намиб, Шинэ Зеланд, Пакистан, Папуа шинэ Гвиней, Сент Люсия, Сент-Винсент ба Гренадин, Сингапур, Соломоны арлууд, Шри ланк, ИБУИНХУ, Танзаны БНУ, Зимбабве
Засгийн газрын гишүүн Парламентын гишүүн байхыг зөвшөөрдөг	59	Албани, Антигуа Барбуда, Бахамын арлууд, Бангладеш, Бутан, Бразил, Канад, Хятад, Хорват, Чех, БНКонгу, Дани, Эльсальвадор, Эритрей, Этиоп, Финланд, Габон, Гамби (The), Гана, Грек, Гайана, Унгар, Исланд, Израил, Итали, Япон, Иордан, Кувейт, Лаос, Латви, Ливан, Литва, Малави, Малайз, Маршаллын арлууд, Монгол, Мозамбик, Науру, Непал, Оман, Панам, Перу, Польш, Румын, Сент Китс ба Невис, Самоа, Сомали, Өмнөд Африк, Испани, Суринам, Тайланд, Тонга, Тринадад тобаго, Турк, Тувалу, Уганда, Вануату, Вьетнам, Замби
Засгийн газрын гишүүн Парламентын гишүүн байхыг хориглодог	92	Афганистан, Алжир, Андорра, Ангол, Аргентин, Армен, Азербайжан, Бахрайн, Бельги, Белиз, Бенин, Боливи (Plurinational State of), Босни-Херцеговин, Болгар, Буркина Фасо, Бурунди, Кабо-верде, Камбож, Камерун, Төв Африк, Чад, Чили, Колумб, Конго, Косто Рика, Кипр, Жибути, Доминик, Доминиканы БНУ, Эквадор, Египет, Экваторын Гвиней, Эстони, Гүрж, Гватимал, Гвиней, Гвиней-Бисау, Гаити, Гондурас, Индонез, Иран (Islamic Republic of), Ирак, Казахстан, Кени, Киргиз, Либер, Лихтенштайн, Люксембург, Мадагаскар, Малдив, Мали, Мавритан, Мексик, Микронез, Монако, Монтенегро, Марокко, Нидерланд, Нигер, Нигери, Умард Македон, Норвег, Палау, Парагвай, Филиппин, Португал, Катар, Молдова, ОХУ, Руанда, Сан Марино, Сан Томе ба Принсипи, Саудын Араб, Сенегал, Серби, Сейшель, Сьерра-Леон, Словак, Словени, Өмнөд Судан, Швед, Швейцар, Тажикистан, Зүүн Тимор, Того, Туркменистан, Арабын нэгдсэн Эмират, АНУ, Уругвай, Узбекистан, Коморын арлууд

Судалгаанаас үзэхэд Австрали, Энэтхэг, Канад, Шинэ Зеланд, Шри ланк зэрэг гол төлөв Их Британийн колони байсан орнуудад **сайд нар заавал парламентын гишүүн байх шаардлагыг** үндсэн хуулиндаа тусгажээ. Тухайлбал, Австралийн 1900 оны Үндсэн хуульд "Парламентын гишүүн бус сайд энэхүү албан тушаалд гурван сараас илүүгүй ажиллана" (64 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг) гэж заасан байдаг (Constitutions of the Countries of the World, 1987). Энэтхэг ба Балбад (Энэтхэгийн Үндсэн хуулийн 75 дугаар зүйл, Балбын (Непал) Үндсэн хуулийн 38 дугаар зүйл) энэ хугацаа нь зургаан сар байдаг. Энэхүү зохицуулалтаар, парламентын гишүүн бус хүн сайдаар томилогдвол хуульд заасан хугацаанд парламентын гишүүн болох шаардлага тавигдаж байгаа юм. Папуа-Шинэ Гвинейн 1975 оны Үндсэн хуулийн дагуу Засгийн газрын гишүүд заавал парламентын гишүүн байх ёстой бөгөөд парламентын суудлыг алдсан сайд нь аяндаа огцроход хүрдэг (14а дугаар зүйл) байна.

Харин Дани, Йордан, Испани, Исланд, Финланд, Унгар зэрэг улсад **парламентын гишүүн нь засгийн газрын гишүүн байх практикийг хориглодоггүй** боловч сайд нарыг парламентын байнгын хороодод оруулдаггүй (тухайлбал, Финланд улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйл). Японы Үндсэн хуулийн дагуу сайд нарын ихэнх нь парламентын гишүүн байх шалгуурыг тогтоосон бол Израилд зөвхөн Ерөнхий сайдын хувьд ийм шаардлага үйлчилдэг. Бусад улс ч парламентч нь сайдын албыг давхар хашихыг зөвшөөрчээ.²⁹⁸ Мөн парламентын гишүүн

²⁹⁷ <https://data.ipu.org/content/list-comparative-fields>

²⁹⁸ Албани (69-р зүйл), Бангладеш (56-р зүйл), Бутан (17-р зүйл), Сомали (59-р зүйл), Өмнөд Африк (47-р зүйл),

парламентын гишүүнээс түдгэлзэхийг шаарддаг улс ч байдаг (Бельги, Болгар).²⁹⁹

Нөгөөтэйгүүр Нидерланд, Норвег, Серби, Тайланд, Швед, Швейцар зэрэг парламентын засаглалтай нэлээд оронд засгийн газрын гишүүдийг парламентын гишүүн байхыг үндсэн хуулиараа шууд хоригложээ. Энэ нь засаглал хуваах зарчмыг илүү тууштай хэрэгжүүлэх, кабинетыг хэт улс төржихөөс сэргийлэх, хууль тогтоох эрх мэдлийг гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус байлгах зэрэг шаардлагаас үүдэлтэй гэж судлаачид үздэг.³⁰⁰

2.4. Парламентын засаглалтай улс орнуудад парламентын гишүүн засгийн газрын гишүүний үүргийг хавсран ажилладаг эсэх

Парламентын засаглалтай улсад сонгуулийн үр дүнд бүрдсэн парламентын олонх Засгийн газраа эмхлэн байгуулах эрх авч Ерөнхий сайдаа томилдог. Парламентын улс орнуудад засгийн газрын бүрэлдэхүүнд парламентын гишүүн багтах жишиг дэлхийн нэлээд улс орнуудад түгээмэл байдаг ч нэг танхимтай цөөн хүн амтай улс орнуудын хувьд хориглох зохицуулалт нийтлэг (Финланд, Эстони, Умард Македон, Португал, Серби) байна (Хүснэгт 5).

Парламентын засаглалтай улсууд энэ асуудлыг Үндсэн хуульдаа хэрхэн зохицуулдгийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 6. Парламентын засаглалтай улс орнуудад парламентын гишүүн засгийн газрын гишүүний үүргийг хавсран ажилладаг эсэх (75 улс)³⁰¹

Нэг танхимтай парламент - 44 улс		Нийт тоо
Засгийн газрын гишүүн заавал парламентын гишүүн байхыг шаарддаг	Ботсван, Фижи, Кирибати, Мальт, Маврики, Шинэ Зеланд, Папуа Шинэ Гвиней, Сент-Винсент ба Гренадин, Соломоны арлууд, Тувалу	10
Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байхыг зөвшөөрдөг	Албани, Бангладеш, Доминик, Хорват, Дани, Финланд, Грек, Унгар, Исланд, Израил, Латви, Монгол, Сент-Китс ба Невис, Самоа, Вануату, Лихтенштайн	16
Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байхыг хориглодог	Андорра, Армен, Болгар, Кабо-верде, Эстони, Гүрж, Ирак, Люксембург, Монако, Умард Македон, Норвег, Португал, Молдова, Сан-Марино, Серби, Словак, Швед, Зүүн Тимор	18
Хоёр танхимтай парламент - 31 улс		Нийт тоо
Засгийн газрын гишүүн заавал парламентын гишүүн байхыг шаарддаг	Австрали, Барбадос, Гренада, Энэтхэг, Ирланд, Ямайка, Лесото, Пакистан, Малайз, ИБУИНХУ	10
Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байхыг зөвшөөрдөг	Антигуа ба Барбуда, Бахамын арлууд, Канад, Чех, Этиоп, Итали, Япон, Непал, Өмнөд Африк, Испани, Сент Люсия, Тайланд, Тринидад ба Тобаго, Герман, Белиз	15
Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байхыг хориглодог	Бельги, Босни-Херцеговин, Камбож, Нидерланд, Словени, Швейцар	6

²⁹⁹ Бельги (50-р зүйл), Болгар (68-р зүйл) Кот д'Ивуар (84-р зүйл), Мадагаскар (71-р зүйл), Панам (156-р зүйл), Эстони (64-р зүйл)

³⁰⁰ Тухайлбал, Р.Андревский тэмдэглэснээр, кабинетыг улс төрөөс ангид байлгах, улс орныг удирдахдаа амин хувийн явцуу эрх ашгийг бус харин үндэсний нийтлэг эрх ашгийг удирдлага болгох учиртайг харуулах зорилгоор Нидерландын үндсэн хуульд ийм заалт оруулжээ. Ande.R., 1983.P.131

³⁰¹ <https://data.ipu.org/content/list-comparative-fields>

Дээрх хүснэгтээс үзэхэд Парламентын засаглалтай улс орнуудад:

- Засгийн газрын гишүүнийг заавал парламентын гишүүн байхыг шаарддаг – 20 улс
- Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байхыг зөвшөөрдөг – 31 улс
- Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байхыг хориглодог – 24 улс байна.

Парламентын засаглалтай улс орнуудын дийлэнх нь буюу (75 орны 44 нь нэг танхимтай, 31 нь хоёр танхимтай) 58 хувь нь нэг танхимтай улс байгаагаас парламентын гишүүн засгийн газрын гишүүн байхыг шаарддаг (10) болон зөвшөөрдөг (16) улс орнууд 25 буюу 56 хувийг эзэлж байна. Харин парламентын гишүүн засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэхийг үндсэн хуулиараа хориглосон улс 18 буюу 40 хувийг эзэлж байна. Парламентын засаглалтай хоёр танхим бүхий улс орнуудын хувьд ихэвчлэн засгийн газрын гишүүн парламентын гишүүн байхыг шаарддаг болон зөвшөөрдөг (нийт 31 улсын 25 нь буюу 80 хувь) бол, 6 улсад хориглодог ажээ. Зөвшөөрдөг буюу хориглодоггүй улс орнуудын хувьд ихэнх нь Үндсэн хуулиараа ямар нэгэн хязгаар тогтоодог. (Бангладеш, Доминик, Финланд.)

Олон улсын практикаас үзвэл зөвхөн доод танхимын гишүүд засгийн газрын гишүүнээр сонгогдох эрхтэй байдаг. Парламентын гишүүд олон байх тусмаа цөөн гишүүн сайдын албан тушаал хавсрах нь парламентын хяналтад, бүр цаашилбал төрийн эрх мэдлийн хуваарилалтад тэр бүр сөргөөр нөлөөлөхгүй сайн талтай гэж үздэг байна.

ХАВСРАЛТ

Парламентын засаглалтай орнуудад парламентын гишүүн засгийн газрын гишүүний үүргийг хавсран ажилладаг эсэх тухай Үндсэн хуулийн зохицуулалт³⁰²

№	Улс орнууд	Эрх зүйн зохицуулалт
1.	Австрали	64.Анхны бүх нийтийн сонгуулийн дараа аль ч төрийн сайд Төлөөлөгчдийн танхимын гишүүн, эсхүл сенатор биш, эсхүл болоогүй бол гурван сараас дээш хугацаагаар уг албан тушаалыг хашихгүй.
2.	Андора	78.2.Засгийн газрын гишүүн нь Ерөнхий зөвлөл (Парламент)-ийн гишүүн, эсхүл Засгийн газрын гишүүнчлэлээс үл хамаарах төрийн албан тушаал эрхлэхтэй нийцэхгүй.
3.	Албани	69.1.Дараах хүмүүс албан тушаалаасаа чөлөөлөгдөхгүйгээр нэр дэвших, депутатаар сонгогдохгүй: <ul style="list-style-type: none"> • Шүүгч, прокурор; • Цэргийн жинхэнэ алба; • Цагдаа болон Үндэсний аюулгүй байдлын ажилтан; • Дипломат төлөөлөгч; • Албан үүргээ гүйцэтгэж байгаа газар нутаг, дүүргийнхээ мэр ба дарга; • Сонгуулийн хороодын дарга, гишүүн; • Улсын ерөнхийлөгч, хуулиар Төрийн захиргааны өндөр дээд албан тушаал гэж заасан албан тушаалууд. 69.2.Энэхүү зүйлийн 1 дүгээр догол мөрд заасныг зөрчиж авсан мандат хүчингүй. 103.1.Депутат болох чадвартай хэн ч сайдаар томилогдож болно. 103.2.Сайд нь өөр бусад төрийн чиг үүрэг гүйцэтгэхгүй, мөн ашгийн төлөө компанийн захирал, эсхүл удирдах зөвлөлийн гишүүн байж болохгүй. 103.3.Сайд нарын зөвлөлийн гишүүд депутатын нэгэн адил халдашгүй бүрэн эрхийг эдэлнэ.
4.	Антигуа ба Барбадос	39.1 Дараах тохиолдолд Танхимын гишүүнээр сонгогдохгүй. ж) Төрийн аливаа албан тушаал, Дээд шүүхийн шүүгч, Омбудсмэний албан тушаал хашиж байгаа эсвэл үүрэг гүйцэтгэж байгаа, эсхүл Сонгуулийн тойргийн комисс, шүүх, хууль зүйн үйлчилгээний комисс, Төрийн албаны комисс, Цагдаагийн албаны комиссын гишүүн бол 69.4.Ерөнхий сайдаас бусад сайд нарыг Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхий захирагч танхим, сенатын гишүүдийн дундаас томилно.
5.	Армени	95.Парламентын гишүүн нь шинжлэх ухаан, боловсрол, уран бүтээлийн ажлаас бусад гишүүний ажил үүрэгтэй хамааралгүй төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын, эсхүл худалдааны байгууллагын ажил үүрэг хаших, эсхүл аж ахуйн үйл ажиллагаанд оролцох, бусад цалинтай ажил эрхлэхийг хориглоно.
6.	Бангладеш	56.2.Ерөнхий сайд болон бусад сайд, Төрийн сайд, дэд сайд нарын томилгоог дараах байдлаар Ерөнхийлөгч хийнэ. Сайд нарын нийт бүрэлдэхүүний 9/10-аас багагүй хувийг Парламентын гишүүд дундаас, 1/10-ээс илүүгүй хүнийг парламентын гишүүнээр сонгогдох болзол хангасан хүмүүсээс сонгоно.
7.	Барбадос	65.2.Бусад сайд нарыг Ерөнхий сайдын санал болгосны дагуу хоёр танхимын гишүүдийн дотроос Ерөнхий захирагч томилно.
8.	Бахамын арлууд	48.2.Зэвсэгт хүчин болон цагдаагийн албанд ажилладаг, үүрэг гүйцэтгэдэг албан тушаалтан, ажилтнууд Парламентын гишүүнээр сонгогдох боломжгүй. 73.2.Ерөнхий сайдаас бусад сайд нарыг Ерөнхий сайдын санал болгосны дагуу танхимын гишүүдийн дундаас Ерөнхий захирагч томилно.
9.	Белиз	40.Сайдын албан тушаалд томилохдоо Ерөнхий сайдын санал болгосны дагуу Ерөнхий захирагч Төлөөлөгчдийн танхим болон Сенатын танхимын гишүүдийн дундаас томилно. Төлөөлөгчдийн танхимын дарга, Сенатын танхимын ерөнхийлөгчийг сайдын албан тушаалд томилохгүй.
10.	Бельги	50.Хаан парламентын хоёр танхимын депутатаас сайдаар томилсон тохиолдолд уг сайд Парламентын хуралдаанд (гишүүний хувиар) оролцохгүй. Хаан тухайн

³⁰² <https://constituteproject.org/constitutions?lang=en&key=housenum>

		сайдуг албан тушаалаас нь огцруулсан үед гишүүний мандат нь эргэж сэргэнэ.
11.	Болгар	68.1.Үндэсний Ассамблейн гишүүд төрийн өөр албан тушаал хавсрах, өөрийн ажил үүрэгт нь нийцэхгүй бусад үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглоно. 68.2.Сайдаар сонгогдсон Үндэсний Ассамблейн гишүүн нь томилогдон ажиллах хугацаандаа гишүүний бүрэн эрхээ түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд Үндэсний Ассамблейд түүнийг орлох журмыг хуулиар зохицуулна.
12.	Бостван	42.3.Ерөнхийлөгч Үндэсний Ассамблейн гишүүдээс сайд болон дэд сайдыг томилно. Ингэхдээ дараах нөхцөлийг харгалзана: Ассамблейн гишүүн бус боловч түүнд сонгогдох шаардлагыг хангасан дөрвөөс илүүгүй хүнийг сайд болон дэд сайдын албан тушаалд томилж болно. Парламентын бүрэн эрх дуусгавар болох үед сайд эсхүл дэд сайдыг томилох шаардлага гарвал тийнхүү бүрэн эрх нь дуусгавар болохоос өмнө Ассамблейн гишүүн байсан хүнийг томилж болно. 62.1.Үндэсний Ассамблейн гишүүнээр сонгогдох болзол хангаагүй хүн: <ul style="list-style-type: none"> • Нтло я Дикгоси-гийн гишүүн;³⁰³ • Парламентаас тогтоосон онцгой тохиолдлыг харгалзан төрийн аливаа албан тушаалыг хашиж байгаа, эсхүл зургаан сараас дээш хугацаагаар төрийн ажил үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа албан тушаалтан;
13.	Вануату	42.1.Ерөнхий сайд болон бусад сайдыг парламентын гишүүдээс томилно ... 46.Сайдаар томилогдсон гишүүдийн Парламентын гишүүний бүрэн эрх хадгалагдана.
14.	Грек	57.Парламентын гишүүн нь төрийн байгууллагын дэмжлэгтэй, эсхүл төрийн байгууллагаас хөрөнгө оруулалт хийгдэж байгаа байгууллагын удирдах албан тушаалд ажиллахыг хориглоно. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> • Төрийн ажил эсхүл судалгаа, худалдаа ханган нийлүүлэлт эрхэлдэг, төрийн эсхүл улсын бүтээн байгуулалт, эсхүл хөрөнгө оруулалтын чанартай ажил үйлчилгээний нөхцөлтэй; • Тусгай давуу эрх эдэлдэг; • Грект радио, телевиз эзэмшдэг эсхүл ажиллуулдаг, улс орон даяар түгээдэг сонин хэвлэж нийтлүүлдэг; • Төрийн алба, төрийн эзэмшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн үйлчилгээний аж ахуйн нэгжтэй концессын гэрээтэй; • Төрийн мэдлийн үл хөдлөх хөрөнгийг арилжааны зорилгоор түрээсэлдэг.
15.	Гренада	31.2.Парламентын чиг үүрэгт хамаарах, эсхүл үүнтэй холбоотой аливаа албан тушаалыг хашиж байгаа, эсхүл үүрэг гүйцэтгэж байгаа хүн Парламентын төлөөлөгчдийн танхимын гишүүнээр сонгогдох эрхгүй. 58.4. Ерөнхий сайдаас бусад сайдын албан тушаалд томилох асуудлыг Ерөнхий сайдын санал болгосны дагуу Төлөөлөгчдийн танхим болон Сенатын танхимын гишүүдийн дундаас Ерөнхий захирагч томилно.
16.	Гүрж	39.4.Парламентын гишүүн нь төрийн албаны аливаа албан тушаал хаших, эсхүл аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно. Парламентын гишүүн олон нийтийн үйл ажиллагаанд оролцож болно. Парламентын гишүүн нь академик, сурган хүмүүжүүлэх, болон урлаг, уран сайхны үйл ажиллагаанд захиргааны үүрэг, үйл ажиллагаа гүйцэтгэх зорилгоор биш бол оролцож болно. Ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг Парламентын дэгийн тухай хуулиар тодорхойлно.
17.	Доминик	59.4.Ерөнхий сайдаас бусад сайдыг Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч танхимын гишүүдээс томилно: Ингэхдээ сенаторуудын дундаас гурваас илүүгүй сайдыг томилно.
18.	Зүүн Тимор	68.1.Улсын Ерөнхийлөгч, Үндэсний Парламентын дарга, Дээд шүүхийн ерөнхийлөгч, Захиргааны хэрэг, татвар, аудитын дээд шүүхийн дарга, Ерөнхий прокурор болон Засгийн газрын гишүүний албан үүргүүд нэг нь нөгөөтэйгөө нийцэхгүй. Бусад нийцэхгүй байдлыг хуулиар тодорхойлно.
19.	ИБУИНХУ	Засгийн газрын гишүүд нь Нийтийн танхимын гишүүн байх бөгөөд Нийтийн танхимын өмнө ажлаа хариуцдаг байна. Ерөнхий сайд нь заавал парламентын гишүүн байна. ³⁰⁴
20.	Израил	Засгийн газар 11-р бүлэг. 5-р зүйл

³⁰³ Ботсвана улсын Үндсэн хуульд заасан үндэсний ашиг сонирхлын асуудлаар Үндэсний Ассамблейн зөвлөх байгууллага юм. Бус нутгуудын сонгуулийн коллегийг сонгогдсон 22 гишүүн, Ерөнхийлөгчөөс томилогдсон 5 гишүүнээс бүрддэг.

³⁰⁴ Гадаад орнуудын үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2009 он, 184 дэх тал. www.parliament.uk

		б) Ерөнхий сайд Кнессетийн гишүүн байна. Сайд нар Кнессетийн гишүүн байх албагүй.
21.	Ирак	49-р зүйл. Зургадугаар хэсэг. Төлөөлөгчдийн зөвлөлийн гишүүний ажил үүргийг бусад албан тушаалтай хавсран гүйцэтгэж болохгүй.
22.	Ирланд	28-р зүйл 7-р хэсэг 1.Ерөнхий сайд (Taoiseach), Ерөнхий сайдын орлогч (Tánaiste) ба Сангийн сайд нь Төлөөлөгчдийн танхимын гишүүн байна. Засгийн газрын бусад гишүүд нь Төлөөлөгчдийн танхимын (Dáil Éireann) эсхүл Сенатын танхимын (Seanad Éireann) гишүүд байна. Гэхдээ Сенатын танхимын гишүүд нь хоёроос ихгүй байна.
23.	Исланд	51.Сайдууд зохих журмыг баримталж, ажил үүргийн шугамаар Алтинги (Парламент)-ийн хуралдаанд оролцон мэтгэлцэх эрхтэй. Хэрэв сайд давхар Алтингийн гишүүн бол санал өгөх эрхтэй байна.
24.	Испани	98.3.Засгийн газрын гишүүд нь Парламентын гишүүний бүрэн эрхийг давхар гүйцэтгэхээс бусдаар төлөөлөх үүрэг гүйцэтгэхгүй ба албан үүргээсээ өөр төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэхгүй. Мэргэжлийн болон арилжааны үйл ажиллагаанд хамтран оролцохгүй.
25.	Итали	64.Парламентын гишүүн бус Засгийн газрын гишүүн нь мөн парламентын хуралдаанд оролцох эрхтэй ба шаардлагатай тохиолдолд заавал оролцох үүрэгтэй. Тэднийг санал гаргасан тохиолдол бүрд хуралдаанд оролцуулна.
26.	Кабо-верде	176.1.Депутатын ажил, үүрэг нь дараах ажил, үүрэгтэй нийцэхгүй: <ul style="list-style-type: none"> • Засгийн газрын гишүүн • Магистратор • Үндэсний Ассамблейн даргын үүргийг гүйцэтгэхээс бусад тохиолдолд Бүгд Найрамдах Улсын Зөвлөлийн гишүүн; • Дипломатч • Цэргийн жинхэнэ албан хаагчид. Бусад нийцэхгүй байдлыг хуулиар тодорхойлно.
27.	Камбож	79-р зүйл. Үндэсний Ассамблейн гишүүн нь Хааны Засгийн газрын Сайд нарын Зөвлөлд ажиллах ёстойгоос бусад тохиолдолд төрийн идэвхтэй үйл ажиллагаа эрхлэх болон Үндсэн хуульд заасан бусад байгууллагын гишүүн байх ёсгүй. Энэ тохиолдолд Үндэсний Ассамблейн гишүүн нь Үндэсний Ассамблейн гишүүн хэвээр үлдэх боловч Байнгын хороо эсхүл Үндэсний Ассамблейн бусад комиссын ямар нэгэн албыг хашихгүй.
28.	Канад	Ерөнхий сайд Парламентын гишүүдээр Засгийн газрын сайд нарын ажлыг хавсарч гүйцэтгүүлнэ. ³⁰⁵
29.	Кирибати	41.1.Кирибати Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүн (Beretitenti) нь албан үүргээ авсан даруйдаа, Парламентын танхимын (Maneaba ni Maungatabu) гишүүдээс сайд нараа томилно.
30.	Латви	38.Ерөнхийлөгчийн албыг ямар нэг албан тушаалтай хавсран гүйцэтгэж болохгүй. Хэрэв Сеймийн гишүүн Ерөнхийлөгчөөр сонгогдсон бол тэрээр Сеймийн гишүүнээс татгалзах ёстой. 63.Сайд нар нь Сеймийн гишүүн биш байсан ч Сейм болон түүний хороодын хуралдаанд оролцох, хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй.
31.	Лесото	87.4.Эзэн хаан бусад сайд нарыг Үндэсний Ассамблейн гишүүдээс, эсхүл энэхүү Үндсэн хуулийн 55-р хэсэгт заасанчлан Хаан өөрөө нэр дэвшүүлсэн сенаторуудын дундаас Ерөнхий сайдын санал болгосноор томилно. Ерөнхий сайдаас бусад сайд нарыг томилох үеэр парламентын бүрэн эрх дуусгавар болсон тохиолдолд ийнхүү дуусгавар болохын өмнөх парламентын гишүүн эсхүл Сенаторыг сайдаар томилж болно.
32.	Лихтенштайн	79.4.Засгийн газрын гишүүн нь Лихтенштайны иргэн бөгөөд парламентын гишүүн байна. 79.5.Засгийн газрыг томилох үед хоёр бүс нутгаас хамгийн багадаа тус бүр хоёр гишүүнийг багтаана. Тэднийг солих тохиолдолд оронд нь томилох хүмүүсийг тухайн бүс нутгаас нь сонгоно.
33.	Люксембург	54.Депутатын мандаттай бол доорх албан тушаал хашиж болохгүй:

³⁰⁵ Канадын парламент цахим хуудас. www.parl.gc.ca

		<p>1.Засгийн газрын гишүүн, 2.Төрийн Зөвлөлийн гишүүн, 3.Шүүхийн шийдвэр бүхий магистрат, 4.Төсвийн танхимын гишүүн, 5.Дүүргийн комиссар, 6.Цэргийн албан хаагч.</p> <p>Энэхүү үл зохицох нөхцөлд байгаа төрийн албан хаагч нь депутатын мандат болон төрийн албаны аль нэгийг сонгох эрхтэй.</p>
34.	Маврики	<p>59.3.Ерөнхийлөгч Ассамблейн гишүүдийн олонхын санал, дэмжлэгийг авч чадна гэж үзсэн Ассамблейн гишүүнийг Ерөнхий сайдаар томилох ба мөн Шадар сайд, Ерөнхий шүүгч болон бусад сайд нарыг Ассамблейн гишүүд дундаас Ерөнхий сайдын санал болгосноор томилно.</p>
35.	Малайз	<p>43.2b. Хаан нь засгийн газрын бусад сайд нарыг Парламентын хоёр танхимын гишүүд дундаас Ерөнхий сайдын санал болгосноор томилно. Гэхдээ хэрвээ Парламентын бүрэн эрх дуусгавар болох үед томилох шаардлага гарвал өмнөх Төлөөлөгчдийн танхимын гишүүнийг томилж болох ба тэрээр Ерөнхий сайдаар томилогдох, шинээр бүрдсэн Төлөөлөгчдийн танхимын гишүүн эсхүл сенатын танхимын гишүүн болоогүй бол парламентын шинэ хуралдаан эхэлсний дараа тэрхүү албыг хүлээлгэн өгнө.</p>
36.	Малыт	<p>54.1.Төрийн аливаа албан тушаал хашиж байгаа, эсхүл үүрэг гүйцэтгэж байгаа, эсхүл Мальта Улсын Засгийн газрын зэвсэгт хүчинд алба хааж байгаа бол (парламентаас өөрөөр заагаагүй бол) Төлөөлөгчдийн танхимын гишүүнээр сонгогдох эрхгүй.</p> <p>80.Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдаар, Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн олонхын санал, дэмжлэгийг авч чадна гэж үзсэн тухайн танхимын гишүүнийг томилж, улмаар Ерөнхий сайдын санал болгосноор Төлөөлөгчдийн танхимын гишүүдээс бусад сайдуудыг томилно.</p>
37.	Молдова	<p>70.1.Парламентын гишүүн нь багшлах болон эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхлэхээс бусад хөдөлмөрийн хөлс авдаг ажил эрхлэхгүй.</p>
38.	Монгол	<p>1.Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.</p>
39.	Непал	<p>78.1.76 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасанчлан, Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын санал болгосноор Холбооны парламентын гишүүн бус хүнээр Шадар сайд, сайд, төрийн сайд, дэд сайдыг тус тус томилж болно.</p> <p>78.2.(1) хэсэгт заасанчлан томилогдсон сайд нь тангараг өргөснөөс хойш зургаан сарын хугацаанд багтаж Холбооны парламентын гишүүн болно.</p> <p>78.3.Хэрвээ тухайн сайд (2) хэсэгт заасанчлан Холбооны парламентын гишүүн болж чадахгүй бол тэрээр тухайн Төлөөлөгчдийн танхимын бүрэн эрхийн хугацаанд дахин сайдаар томилогдох боломжгүй.</p>
40.	Нидерланд	<p>57.2.Парламентын гишүүн нь сайд, төрийн нарийн бичгийн дарга, Төрийн зөвлөлийн гишүүн, Аудитын Ерөнхий газрын гишүүн, Үндэсний Омбудсман, Дэд Омбудсман, Дээд шүүхийн гишүүн, Дээд шүүхийн дэргэдэх Ерөнхий прокурор, Ерөнхий өмгөөлөгчийн ажлыг хавсран гүйцэтгэж үл болно.</p>
41.	Норвег	<p>62.Засгийн газрын яамдад ажиллаж байгаа (Төрийн нарийн бичгийн дарга, улс төрийн зөвлөхөөс бусад) албан хаагчид төлөөлөгчөөр сонгогдож болохгүй. Тус зохицуулалт нь Дээд шүүхийн гишүүн болон дипломат, эсхүл консулын албанд ажиллаж буй албан хаагчдад мөн адил хамаарна.</p> <p>Төрийн зөвлөл (Засгийн газар)-ийн гишүүн нь уг албан тушаалыг хашиж байх хугацаандаа төлөөлөгчийн хувиар Стортинг (Парламент)-ийн хуралдаанд оролцох эрхгүй байна. Үүний адилаар Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын яамдын улс төрийн зөвлөхүүд уг албан тушаалыг хашиж байх хугацаандаа төлөөлөгчийн хувиар Стортинг (Парламент)-ийн хуралдаанд оролцох эрхгүй байна.</p>
42.	Өмнөд Африк	<p>47.1.Дор дурдсанаас бусад тохиолдолд Үндэсний Ассамблейн сонгуульд санал өгөх эрхтэй иргэн бүр Үндэсний Ассамблейн гишүүн болох эрхтэй байна:</p> <p>а/ Томилогддог албан тушаал эрхэлж буй, эсхүл төрийн албанд ажиллаж буй, мөн тухайн ажил, албан тушаал эрхэлснийхээ төлөө төрөөс цалин авдаг аливаа этгээд. Үүнд дор дурдсан хамаарахгүй:</p> <ul style="list-style-type: none"> • Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Сайд болон дэд сайд нар; • Үндэсний Ассамблейн гишүүний чиг үүргийг хавсарч болох бусад албан тушаалтнууд, улсын хууль тогтоомжоор хавсарч болно гэж заасан бусад

		албан тушаалтнууд.
43.	Пакистан	<p>63.1.Дараах тохиолдолд Парламентын гишүүнээр сонгогдох, гишүүн байх эрхгүй гэж үзнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Хуулиар гишүүнийн албан үүргийг хавсарч болохгүй гэж тогтоогүй, төрөөс цалин хөлс авдаг бусад албан тушаал; Төрийн мэдлийн, эсхүл төрөөс хяналт тавьдаг, эсхүл төр хувьцааны хяналтын багцыг нь эзэмшдэг аливаа байгууллагад алба хашдаг бол. <p>92.1.91 дүгээр зүйлийн (9) болон (10) дахь заалтыг баримтлан Ерөнхийлөгч Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентын гишүүд дундаас Холбооны сайд, төрийн сайд нарыг томилно. Ингэхдээ:</p> <ul style="list-style-type: none"> Сенатын гишүүн бүхий Холбооны сайд, төрийн сайд нарын тоо ямар ч үед Холбооны сайд нарын дөрөвний нэгээс хэтрэхгүй байна; <p>Цаашлаад Засгийн газрын гишүүд, түүний дотор Төрийн сайд нарын тоо Парламентын нийт гишүүдийн арван нэг хувиас хэтрэхгүй байна.</p>
44.	Папуа шинэ Гвиней	<p>141.Яам нь парламентын гүйцэтгэх засаглал байх учир:</p> <p>А. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Парламентын гишүүн бус этгээд сайдаар томилогдохгүй бөгөөд парламентын гишүүн байхаа больсон тохиолдолд сайдын албан тушаалаасаа бууна.</p>
45.	Португал	<p>154.Парламентын гишүүний бусад албан тушаал хавсран гүйцэтгэхийг хязгаарлах нь</p> <ol style="list-style-type: none"> 1) Засгийн газрын гишүүнээр томилогдсон гишүүд Засгийн газраас гарах хүртэл гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлэхгүй бөгөөд өмнөх зүйлд заасанчлан түүний албан үүргийг түр орлон гүйцэтгэнэ. 2) Бусад үл нийцэх нөхцөлүүдийг хуулиар тогтооно. 3) Гишүүд шүүгч, арбитрч, шинжээч эсхүл гэрч болохын тулд Бүгд Найрамдах Улсын Ассамблейгаас зөвшөөрөл авах шаардлагатай тохиолдол, нөхцөлүүдийг хуулиар зохицуулна.
46.	Самоа	<p>32.2.Төрийн тэргүүн Ерөнхий сайдын санал болгосноор наймаас цөөнгүй, арван хоёроос илүүгүй тооны парламентын гишүүдийг сайдаар томилно.</p>
47.	Сент Винсент ба Гренадин	<p>26.1.Дараах тохиолдолд Төлөөлөгч, эсхүл Сенатор (цаашид “гишүүн” гэх)-оор сонгогдох, томилогдох эрхгүй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Аль нэгэн гадаад улс, эсхүл хүчинтэй холбогдсон, даалгавар тушаалыг нь биелүүлдгээ ямар нэг байдлаар өөрөө хүлээн зөвшөөрсөн; Шашны номлогч бол; Дээд шүүхийн шүүгч, үүрэг гүйцэтгэгч бол; Парламентаас тогтоосон хязгаарлалт, нөхцөлд хамаарах аливаа нийтийн албан тушаал хашдаг, эсхүл Сент Винсентийн батлан хамгаалах хүчний аль нэг салбараас цалин хөлс авдаг гишүүн бол. <p>51.4.Ерөнхий сайдаас бусад сайд нарыг Амбан Захирагч Танхимын гишүүдийн дундаас Ерөнхий сайдын санал болгосноор томилно:</p> <p>Ингэхдээ Сенаторуудын дундаас хоёроос илүү сайдыг томилохгүй.</p>
48.	Сент Люсия	<p>32.1.Дараах тохиолдолд Танхимын гишүүнээр сонгогдох эрхгүй байна:</p> <p>b. Шашны номлогч бол;</p> <p>f. Парламентаас тогтоосон аливаа хязгаарлалтад хамаарах зүйлүүд болон Засгийн газрын гэрээнд ашиг сонирхлын зөрчилтэй этгээд.</p> <p>32.4.Сенатороор сонгогдсон бол танхимын гишүүнээр сонгогдох эрхгүй байна.</p> <p>32.5.Парламентаас тогтоосон хязгаарлах нөхцөлүүд болон тухайн хүн цэрэг, цагдаагийн хүчинд алба хаадаг, эсхүл ажилладаг бол гишүүнээр сонгогдох боломжгүй.</p>
49.	Сент-Китс ба Невис	<p>52.4.Ерөнхий сайдын албан тушаалаас бусад сайдын албан тушаалд томилох асуудлыг Ерөнхий сайдын санал болгосны дагуу Үндэсний Ассамблейн гишүүдийн дундаас Амбан Захирагч томилно.</p>
50.	Серби	<p>102.Үндэсний Ассамблейн гишүүн нь автономит мужийн Ассамблейн гишүүн, Засгийн газар, шүүхийн байгууллагад албан тушаал хавсрах эрхгүй бөгөөд хуульд заасны дагуу ашиг сонирхлын зөрчил бүхий бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.</p>
51.	Словак	<p>77.1.Депутатын чиг үүргийг шүүгч, прокурор, олон нийтийн эрхийг хамгаалагч, цэргийн алба, Европарламентын гишүүнийн албан үүрэгтэй хавсарч болохгүй.</p> <p>77.2.Парламентын гишүүн нь Засгийн газрын гишүүнээр томилогдвол ажиллах хугацаанд нь бүрэн эрх нь хүчинтэй байх боловч хэрэгжүүлж болохгүй.</p>
52.	Словени	<p>82.Депутатаар сонгогдохгүй нөхцөл болон депутатын ажил үүргийг хавсарч болохгүй бусад ажил, үүрэг үйл ажиллагааг хуулиар тогтооно.</p>

53.	Соломоны арлууд	33.3.Ерөнхий сайдаас бусад сайд нарыг Ерөнхий сайдын санал болгосны дагуу Парламентын гишүүдийн дундаас Амбан Захирагч томилно. 49.6.Төрийн албаны аливаа албан тушаал хашиж байгаа болон үүрэг гүйцэтгэж байгаа хүн Парламентын гишүүнээр сонгогдох эрхгүй байна.
54.	Тайланд	98.Дараах этгээд Төлөөлөгчдийн танхимын гишүүнд нэр дэвших эрхгүй байна: 3.Аливаа сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгч, хувьцаа эзэмшигч; 12. улс төрийн албан тушаалтнаас бусад байнгын албан тушаал эрхэлж байгаа буюу тогтмол цалин авдаг төрийн албан хаагч; 13.нутгийн хурлын гишүүн, нутгийн захиргааны төлөөлөгч; 14.Сенатор болон гишүүнчлэл нь дуусгавар болж хоёроос доош жил өнгөрсөн Сенатор; 15.Төрийн байгууллага, улсын үйлдвэрийн газар, засгийн газрын агентлагийн албан тушаалтан, төрийн бусад байгууллагын ажилтан; 16.Үндсэн хуулийн шүүхийн шүүгч, эсхүл хараат бус байгууллагад ажилладаг албан тушаалтан.
55.	Тринадад Тобаго	48.2.Дараах албан тушаалтан, алба хаагч парламентын гишүүнд нэр дэвшихгүй: А. Аль нэгэн зэвсэгт хүчин, түүний анги нэгтгэлд харьяалагддаг; Б. Аль нэгэн цагдаагийн хүчинд харьяалагддаг эсхүл алба хашдаг. 76.3.Ерөнхий сайдаас бусад сайд нарыг Ерөнхий сайдын санал болгосны дагуу Ерөнхийлөгч Төлөөлөгчдийн танхим болон Сенаторуудын дундаас томилно.
56.	Тувалу	62.5.71-р хэсэг (Түр засгийн газар) болон (6) дэд хэсэгт зааснаар бүх сайд (Ерөнхий сайдын оролцуулан) Парламентын гишүүн байна.
57.	Умард Македон	89.Засгийн газрын тэргүүн буюу Ерөнхий сайд болон бусад сайд нар Ассамблейн гишүүн байж болохгүй.
58.	Унгар	20.Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн шүүхийн гишүүн, Үндэсний Ассамблейн иргэний эрхийн комиссар, Төрийн аудитын танхимын дарга, орлогч дарга, гишүүд, шүүгч, прокурор, төрийн захиргааны байгууллагын ажилтан, цэргийн албан хаагч, цагдаагийн ажилтан Үндэсний Ассамблейн гишүүн байж болохгүй. Энэ заалт Засгийн газрын гишүүн болон улс төрийн асуудал хариуцсан төрийн нарийн бичгийн албан тушаалд хамаарахгүй. 4.2.Үндэсний Ассамблейн гишүүдийн давхар эрхлэхийг хориглосон төрийн албан тушаал ба ашиг сонирхлын бусад зөрчлийг хуулиар тогтооно.
59.	Фижи	95.1.Хуульд зааснаар сайд нь Парламентын гишүүн байна.
60.	Финланд	27.Хууль зүйн сайд, Ерөнхий Омбудсмен, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий Прокурор Парламентын гишүүнээр сонгогдож, хавсран ажиллаж болохгүй, хэрэв Ерөнхийлөгч буюу дээр дурдсан албан тушаалд томилогдсон бол Парламентын гишүүнээс чөлөөлөгдөх үүрэгтэй. 48.Засгийн газрын гишүүн Парламентын хэлэлцүүлэгт оролцох эрхтэй. Сайд нь Парламентын байнгын хорооны гишүүн байж болохгүй. Сайд нь Ерөнхийлөгчийн үүргийг орлож байх хугацаанд Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу Парламентын үйл ажиллагаанд оролцохгүй. 63.Засгийн газрын гишүүн бусад төрийн алба хавсрах болон сайдын албан үүрэгт нь харшлах аливаа ажил үйлчилгээ эрхлэхийг хориглоно.
61.	Хорват	108.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд нь Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр аливаа мэргэжлийн болон бусад төрийн үүрэг гүйцэтгэхийг хориглоно.
62.	Чех	22.1.Депутатын, эсхүл Сенаторын чиг үүргийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, шүүгч болон хуулиар тогтоогдсон бусад чиг үүрэгтэй хавсарч болохгүй. 22.2.Депутат, эсхүл Сенатор нь Ерөнхийлөгч, шүүгч, эсхүл чиг үүргийг хавсарч болохгүй бусад албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн өдрөөс эхлэн мандат нь хүчингүй болно. 32.Засгийн газрын гишүүн депутат, эсхүл Сенатор нь Депутатуудын танхим болон Сенатын дарга, даргын орлогч байж болохгүй. Мөн Парламентын хороод, мөрдөн шалгах болон бусад комиссын гишүүн болж болохгүй.
63.	Швед	6.1.2.Засгийн газрын сайдуудыг бусад ажил үүрэг хавсран ажиллахыг хориглохоор заасан. Харин Парламентын гишүүдийг хориглосон заалт тусгагдаагүй байна.
64.	Швейцар	144.1.Үндэсний зөвлөл, Төрийн зөвлөл, Холбооны зөвлөлийн аль ч гишүүн, эсхүл Холбооны Дээд шүүхийн аль ч шүүгч нь нэгэн зэрэг эдгээр байгууллагын гишүүн, эсхүл шүүгч байж болохгүй.
65.	Шинэ Зеланд	2 дугаар хэсэг.

		6.Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн буюу Засгийн газрын сайдаар зөвхөн Парламентын гишүүн хүнийг томилно.
66.	Энэтхэг	75.5.Парламентын гишүүн бус хүн сайдаар томилогдсон болон 6 сарын хугацаанд Парламентын аль нэг танхимын гишүүн болж чадахгүй бол сайдын үүрэгт ажлаасаа огцорно.
67.	Эстони	63.Рийгикогу (Парламент)-ийн гишүүн нь бүрэн эрхийн хугацаандаа өөр ямар нэг ажил, албан тушаал хавсарч болохгүй. Рийгикогугийн гишүүн байх хугацаандаа тус улсын Зэвсэгт хүчний албанаас чөлөөлөгдөнө. 64.Парламентын гишүүн Засгийн газрын гишүүнээр сонгогдвол Парламентын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх ба хэрэв Засгийн газрын гишүүнээс чөлөөлөгдсөн бол Парламентын гишүүний эрхээ сэргээлгэж болно.
68.	Этиоп	74.2.Ерөнхий сайд хоёр танхимын гишүүдийн дундаас, эсхүл аль нэг танхимын гишүүн биш боловч шаардлагыг хангасан хүнийг сайдад нэр дэвшүүлэн Ардын төлөөлөгчдийн танхимд батлуулахаар өргөн мэдүүлнэ.
69.	Ямайка	70.1.Амбан захирагч Ерөнхий сайдыг томилох шаардлагатай үед өөрийн үзэмжээр Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн олонхын итгэлийг хамгийн их хүлээж чадна гэж үзсэн тухайн танхимын гишүүнийг томилно, Ерөнхий сайдын зөвлөсөн тооны бусад сайд нарыг Ерөнхий сайдын зөвлөсний дагуу Парламентын хоёр танхимын гишүүдийн дундаас томилно.
70.	Япон	68.Ерөнхий сайд нь Төрийн сайд нарыг томилох ба сайд нарын дийлэнхийг нь Төлөөлөгчдийн танхимын гишүүдээс сонгоно.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Парламентын судалгааны хүрээлэнгээс хийгдсэн судалгааны жагсаалт:

- 2000 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 7 нэмэлт, өөрчлөлт, түүнтэй ижил төстэй бусад орнуудын Үндсэн хуулийн зохицуулалт (СТ-15/213).
- Дэлхийн зарим орнуудын Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох хэлбэр (СТ-15/216). Судалгааны эмхэтгэл-21 боть. Улсын Их Хурлын Тамгын газар. Улаанбаатар. 2015 он.
- ХБНГУ-ын Үндсэн хуулийн Ерөнхийлөгч, Канцлер, Үндсэн хуулийн шүүхийн тухай зарим заалтууд (СТ-15/410).
- Израил Улсын Үндсэн хууль дахь Засгийн газрыг байгуулахтай холбогдсон заалтууд (СТ-15/421). Судалгааны эмхэтгэл-21 боть. Улсын Их Хурлын Тамгын газар. Улаанбаатар. 2015 он.
- Дэлхийн улс орнуудын төрийн удирдлагын хэлбэр, парламентын засагтай орнуудын сонгуулийн зарчим (СТ-15/427). Судалгааны эмхэтгэл-21 боть. Улсын Их Хурлын Тамгын газар. Улаанбаатар. 2015 он.
- Парламентын засаглалтай улс орнуудын төрийн эрх мэдлийн хуваарилалт (СТ-17/205)

Бусад:

- Удирдлагын академийн судалгааны тайлан. “Монгол Улсын Парламент, Засгийн газрын үйл ажиллагааны уялдаа холбоо, харилцан хамаарлыг Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд шинжлэх нь” 2020 он.
- Удирдлагын академийн судалгааны тайлан 008. “Парламентын засаглалын үндсэн шинж, нийтлэг жишиг, монголын онцлог” 2018 он.
- “Төрийн удирдлага” онол арга зүйн сэтгүүл. Дугаар 04, 2018 он III сар.
- Парламентат ёс. Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан.
- Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар, 2017 он.
- Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа, 2017 он.
- Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт (Товч танилцуулга), 2021 он.
- Улсын Бага Хурлын товчоон, Г.Чулуун. УБ, 2015 он.
- Монгол Улсын Их Хурлын түүхэн товчоон, УИХТГ, 2020 он, 89 дэх тал
- БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль (1990-1992) баримт бичгийн эмхэтгэл
- <https://constituteproject.org/constitutions?lang=en>
- <https://data.ipu.org/content/list-comparative-fields>
- <https://www.idea.int/advanced-search>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТАЛААРХ ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Тойм судалгаа)

Г.Билгээ

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТАЛААРХ ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ

1.1.Парламентаас сонгогдсон БНМАУ-ын анхны Ерөнхийлөгчийг сонгосон үйл явц

1.2.1992 оны Үндсэн хууль батлах явцад Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал ба түүнийг сонгох журмын талаар үзэл баримтлал

1.2.1.Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлын талаар

1.2.2.Ерөнхийлөгчийг сонгох журмын талаар

1.3.Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойших нөхцөл байдал

1.3.1.2017 оны Зөвлөлдөх санал асуулгаар хэлэлцсэн байдал

1.3.2.2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар

2.ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

2.1.“Төрийн тэргүүн”-ий талаар нэршил

2.2.Төрийн тэргүүний институт

2.3.Парламентын засаглалтай орнуудад төрийн тэргүүнийг сонгох, томилох хэлбэр

2.3.Ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоо

2.3.1.Ард түмний шууд сонгууль

а) Энгийн олонхын буюу мажоритар тогтолцоо

б) Хоёр шатлал бүхий тогтолцоо

в) Давуу эрхтэй саналын буюу санал хураалтын түргэвчилсэн тогтолцоо

2.3.2.Шууд бус сонгууль

а) Дийлэнх олонхын тогтолцоо

б) Парламентын шийдвэрээр томилох

2.4.Парламентын засаглалтай орнуудад Ерөнхийлөгчийг сонгох хэлбэр

2.4.1.Ерөнхийлөгчийг парламентаас сонгох

2.4.2.Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар сонгох

2.4.3.Ерөнхийлөгчийг сонгогчдын коллегийос сонгох

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба Монгол Улсын Их цаазын төслүүдийн (1991.VI.05, X.05, XI.07) харьцуулалт

Хавсралт 2. Парламентын засаглалтай орнуудын Ерөнхийлөгчийн сонгуулийн хэлбэр

Хавсралт 3. Парламентын засаглалтай орнуудын Ерөнхийлөгчийн сонгуулийн талаарх Үндсэн хуулийн зохицуулалт

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэн баталсан цаглабар
- Хүснэгт 2. Парламентын засаглалтай орнууд дахь “төрийн тэргүүн”-ий нэршил
- Хүснэгт 3. Парламентын засаглалтай улсуудыг Ерөнхийлөгчийн сонгуулийн хэлбэрээр ангилсан байдал
- Хүснэгт 4. Парламентын санал хураалт (эхний шат)-аар Ерөнхийлөгчийг сонгоход шаардлагатай саналын босго
- Хүснэгт 5. Бүх нийтийн сонгуулиар Ерөнхийлөгчийг сонгоход шаардлагатай саналын босго
- Хүснэгт 6. Сонгуулийн коллегийг Ерөнхийлөгчийг сонгоход шаардлагатай саналын босго

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АИХ	Ардын Их Хурал
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Улс
БНМУ	Бүгд Найрамдах Молдова Улс
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
ОХУ	Оросын Холбооны Улс
УБХ	Улсын Бага Хурал
УИХ	Улсын Их Хурал

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Өмнөх ба одоогийн Үндсэн хуулийн зохицуулалт

1990 онд Ардын Их Хурлаар баталж, 1992 оны Үндсэн хууль батлагдтал дагаж мөрдсөн “Үндсэн хуулийн нэмэлтийн тухай” хуулиар Монгол Улсын Ерөнхийлөгчийг парламентаас сонгохоор зохицуулж, 1990 онд анхны Ерөнхийлөгч Ардын Их Хурлаас сонгогдож байв.

Үндсэн хууль тогтоогчид Ерөнхийлөгчийн төрийн тогтолцоонд эзлэх байр суурь болон бүрэн эрхэд түүнийг сонгох журам ихээхэн нөлөөтэй гэдгийг сайн ойлгож байжээ. Ерөнхийлөгч парламентаас сонгогдвол түүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл бололцоо харьцангуй хязгаарлагдмал байх бол бүх нийтээр сонгогдсон Ерөнхийлөгчийн эрх мэдэл, асуудалд хандах хандлага, бусад институттэй харилцах байдал огт өөр байна. Ардын Их Хурал Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх явцад бүх нийтээр сонгох хувилбар дэмжигдэж байсан.

Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлд Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа, эсхүл хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлэхээр, мөн Ерөнхийлөгчийн сонгууль “хоёр шаттай байна” гэж хуульчилсан. 2017 онд хийсэн Үндсэн хуулийн үзэл баримтлалын хэсэгт хийсэн дүн шинжилгээгээр эхний хэсэгт Ерөнхийлөгч улс төрөөс хараат бус байх үзэл санаатай зарим талаар зөрчилдөж байгааг, дараагийн хэсгийн “хоёр шат” гэдгийг тодруулах шаардлагатай гэсэн дүгнэлт, зөвлөмжийг гаргасан байна.

Ерөнхийлөгчөөр 45 нас хүрсэн, сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгох ба ингэхдээ нэг удаа улируулан сонгож байсныг Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 50 нас хүрсэн хүнийг 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгохоор өөрчилсөн билээ.

Олон улсын туршлага

Тухайн улсын төрийн удирдлагын хэлбэр, төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмаас наад зах нь төрийн тэргүүний нэршил, цаашлаад төрийн тэргүүнийг сонгох, томилох асуудал хамаарч, эцэст нь төрийн тэргүүний бүрэн эрх хамаардаг.

Нэршлийн хувьд гадаад орнуудад “Ерөнхийлөгч”-ийг “Head of state, President, Chef d’Etat, Governor-general” зэрэг олон янзын нэршлээр томьёолдог ба өнөө цагт Ерөнхийлөгч нь бүгд найрамдах засаглалтай улсын төрийн тэргүүн гэсэн утга санааг илэрхийлдэг. Парламентын бүгд найрамдах улсад төрийн тэргүүн, ерөнхийлөгчийн бүгд найрамдах улсад төр, засгийн тэргүүн байна.

Олон Улсын Парламентын Холбоо (IPU)-ны гишүүн парламентын засаглалтай 75 орны Үндсэн хуулиас үзэхэд, 57 хувь нь ерөнхийлөгчтэй (Герман, Израил, Монгол гэх мэт), 39 хувь нь эзэн хаан (Бельги, Нидерланд, Япон гэх мэт), хатан хаан (ИБУИНХУ), амбан захирагчтай (Австрали, Ямайка гэх мэт) байна.

Судалгаанд хамрагдсан парламентын засаглалтай орнуудад төрийн тэргүүнийг янз бүрийн аргаар сонгох, эсхүл томилж байна. Тухайлбал, 13 улсад Эзэн хаан угсаа залгамжилдаг бол Лесото, Малайз, Камбож зэрэг улсуудад Эзэн хааныг Сонгуулийн коллегийг сонгож, эсхүл томилж байна. Харин Хамтын нөхөрлөлийн 13 улсад Амбан захирагчийг Хатан хаан Элизабет II томилж байна.

Ерөнхийлөгчтэй нийт 43 улсын төрийн тэргүүнийг сонгодог гурван хэлбэр байна. Ихэнх улсад буюу 63 хувьд нь Ерөнхийлөгчийг Парламентаас (Израил, Унгар, Швейцар гэх мэт), эсхүл Сонгуулийн коллегийг (Герман, Итали, Энэтхэг гэх мэт), үлдсэн 37 хувь нь бүх нийтийн сонгуулиар (Ирланд, Португал, Финланд) тус тус сонгож байна.

Зарим дотоод, гадаадын судлаачид Ерөнхийлөгчийг хаанаас сонгох нь тийм чухал биш, харин ямар бүрэн эрхийг эдлүүлэх вэ гэдэг л маш чухал гэж үздэг юм байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоо нь хууль тогтоох байгууллагын сонгуулиас ялгаатай бөгөөд ерөнхийдөө ард түмний шууд болон шууд бус сонгууль гэж хоёр ангилдаг.

Ард түмний шууд сонгуулийн тогтолцоог дараах байдлаар гурав ангилна:

1) энгийн олонхын буюу мажоритар тогтолцоонд хамгийн олон санал авсан нэр дэвшигч ялалт байгуулдаг;

2) хоёр шатлал бүхий тогтолцоо нь эхний шатны санал хураалтад сонгогчдын үнэмлэхүй олонхын санал авах шаардлагатай ба хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч ийм санал аваагүй бол эхний шатанд тэргүүлсэн хоёр нэр дэвшигчийн хооронд хоёр дахь шатны санал хураалт явагдаж, санал хураалтад оролцсон сонгогчдын олонхын санал авсан нь сонгогдоно;

3) давуу эрхтэй саналын тогтолцоо буюу санал хураах түргэвчилсэн тогтолцоонд сонгогчид нь нэр дэвшигчдийг давуу эрхээр эрэмбэлэх боломжийг олгодог, хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч сонгогчдын үнэмлэхүй олонхын саналыг аваагүй бол хамгийн бага санал авсан нэр дэвшигчийг хасаж, түүний саналыг дараагийн сонголтод шилжүүлэх ба энэхүү хасагдах, дахин хуваарилах үйл явц нь нэг нэр дэвшигч олонхын санал авах хүртэл үргэлжилдэг.

Шууд бус сонгуулийн тогтолцоог дараах байдлаар хоёр ангилна:

1) дийлэнх олонхын тогтолцоо нь засгийн газар болон сөрөг хүчний намуудад хараат бус, улс төрийн хувьд төвийг сахисан ерөнхийлөгчийг сонгохын тулд олонхын дүрмийг ашигладаг;

2) парламентын шийдвэрээр томилох нь ерөнхийлөгчийг өрсөлдөөнтэй сонгуулиар сонгохын оронд явуулдаг хувилбар юм.

ЭЭРЭГ ТАЛ	СӨРӨГ ТАЛ
Ард түмний шууд сонгуулийн хувьд	
<ul style="list-style-type: none"> • Ингэж сонгогдсон Ерөнхийлөгч улс төрийн аливаа хямралын үед итгэлтэй, зоримог ажиллах, шийдэмгий арга хэмжээ авах боломж илүү байдаг. • Энгийн олонхын буюу мажоритар тогтолцоо нь шударга, энгийн, хямд, үр дүнтэй тул Ерөнхийлөгчийг сонгох хамгийн хялбар арга юм. • Давуу эрхтэй саналын тогтолцоо буюу санал хураах түргэвчилсэн тогтолцооны үед санал хураалтыг нэг удаа явуулах боломжтой. 	<ul style="list-style-type: none"> • Энгийн олонхын буюу мажоритар тогтолцоонд сонгогчдын талаас бага хувь нь дэмжигдсэн нэр дэвшигч сонгогдох боломжтой; нэр дэвшигчдийн тоог хоёр болгох буюу улс төрийн дуу хоолойг бууруулдаг. • Хоёр шатлал бүхий тогтолцооны эцсийн үр дүнд цөөнх Засгийн газрыг удирдаж, засаглах чадвар буурах магадлалтай. Үүнээс үүдэн гарах магадлалтай засаглалын асуудлууд нь харилцан уялдаатай институцын бүтцийг нэгэн зэрэг авч үзэх нь чухал байдаг. • Ерөнхийлөгчийн сонгуульд дэвшүүлж байгаа мөрийн хөтөлбөр нь Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй давхцах, эсвэл сөргөлдөх эрсдэлтэй.

Шууд бус сонгуулийн хувьд

- Орон даяар явуулдаг сонгуулийн тоо цөөрснөөр улс төржилт тодорхой хэмжээгээр багасахын зэрэгцээ ерөнхийлөгчийн сонгуулийн зардал үлэмж хэмнэгдэнэ.
- Улс төрийн зөрчил, тэмцэл багасч, төрийн тэргүүн - ерөнхийлөгч үндэсний эв нэгдлийн билэгдэл байх боломж нөхцөл илүү хангагдана.
- Ерөнхийлөгчийг улс төрийн хувьд төвийг сахисан, нам бус хүн гэдгийг батлах нэмэлт боломжуудыг нээж өгдөг.
- Парламент, эсхүл сонгуулийн коллегийс сонгогдох тохиолдолд эдгээр институцэд олонхын намаас нэр дэвшигч сонгогдох магадлал өндөр байна. Ингэснээр улс төрийн бүх эрх мэдэл нэг улс төрийн хүчний гарт төвлөрөх, хариуцлага, хяналт сулрах, иргэдийн нийтлэг эрх ашгаас илүүтэйгээр улс төрийн нам, бүлэг фракцын ашиг сонирхлыг илүү харгалзсан сонголт хийх магадлалтай.
- Парламентын шийдвэрээр томилох нь засгийн газар нь дангаараа ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх ардчилсан бус нөхцөлийг бүрдүүлдэг.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТАЛААРХ ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ

Ерөнхийлөгчийн институц нь парламент, засгийн газар зэрэг төрийн бусад институцүүдийг бодвол харьцангуй хожуу үүссэн. Ерөнхийлөгчийн институц анх 1787 оны АНУ-ын Үндсэн хуулиар тогтоогдож байсан. Энэхүү институц нь дэлхийд хурдан тархаж, эдүгээ НҮБ-ын гишүүн 200 гаруй орноос 150 орчим нь ерөнхийлөгчийн институцыг тогтоосон байна. Чухамхүү ерөнхийлөгчид олдсон бүрэн эрхээр нь бид тухайн улсыг ерөнхийлөгчийн, парламентын, эсхүл холимог бүгд найрамдах улс гэж төрийн удирдлагын хэлбэрээр ангилах боломжтой байдаг. Энэ нь уг институц төрийн тогтолцоонд эзлэх байр суурийг илэрхийлэх юм.³⁰⁶

Монголчуудын өвөг Хүннүгийн 24 аймгийн зонхилгогчдоос шилэгдэн сонгогддог байсан шаньюйгаас эхлээд 1992 оны шинэ Үндсэн хуулийн дагуу бүх нийтийн сонгуулиар сонгогддог Монгол Улсын Ерөнхийлөгч хүртэлх үе үеийн төрийн тэргүүн, түүхэн уламжлалын талаар манай улсын эрдэмтэн судлаачдын судалгааны бүтээлүүдэд тодорхойлсныг Удирдлагын академиас нэгтгэн танилцуулсан байна.³⁰⁷

Үүнээс 1992 оноос хойших Монгол Улсын төрийн тэргүүн болох Ерөнхийлөгч, түүний сонгуулийн талаар судалгааны энэ хэсэгт авч үзье.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

³⁰⁶ Энхбаатар Ч., Монгол Улсын Ерөнхийлөгчийн институцын онцлог, үүсэл, хөгжил. Удирдахуйн онол, практикийн асуудлууд (Эрдэм шинжилгээний асуудлууд). 2020, №1 (23). 14 дэх тал.

³⁰⁷ Удирдлагын академи. Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн байх суурь: Бүрэн эрхийн шинжилгээ. УБ., 2019 он. 21-29 дэх талууд.

1.1. Парламентаас сонгогдсон БНМАУ-ын анхны Ерөнхийлөгчийг сонгосон үйл явц

Ерөнхийлөгч бол Монгол Улсын төрийн тогтолцоонд цоо шинээр бий болсон албан тушаал юм.³⁰⁸ 1960 онд батлагдсан Үндсэн хуульд 1990 онд оруулсан нэмэлтээр³⁰⁹ төрийн шинэ байгууллыг тогтоож, тэр дундаа Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын Ерөнхийлөгчийн албан тушаалыг бий болгосон юм.³¹⁰

1988 оноос 1990 оны эхэн хүртэлх хугацаанд Монгол Улсын тэргүүн нь хамтын биш, намын удирдагч хавсарсан биш, төрийн дээд албан тушаалтан байх нь зүйтэй гэдэг дүгнэлтэд хүрч, эцэстээ Ерөнхийлөгчийн хоёр хувилбарыг боловсруулан түүнээс сонголт хийсэн юм. Тухайлбал, 1988 оны 12 дугаар сард болсон Монгол ардын хувьсгалт нам (МАХН)-ын төв хорооны V бүгд хурал “төрийн байгуулалтыг ардчилах зорилт”-ын дотор тэр үеийн БНМАУ-ын Ардын Их Хурал (АИХ)-ын дарга (орон тооны бус)-ыг АИХ-ын Тэргүүлэгчдийг удирдах үүрэгтэй, төрийн дээд албан тушаалтан байхаар бүрэн эрхийг нь тодорхойлохоор тогтсон. Энэ санааг цаашид гүнзгийрүүлэн боловсруулах явцад АИХ-ын Тэргүүлэгчдийн Төрийн байгуулалтын хэлтэс “БНМАУ-ын төрийн дээд байгууллагын тогтолцоо ямар байх тухай” саналыг боловсруулж, МАХН-ын Улс төрийн товчоо, АИХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулжээ.

Энэ саналд ирээдүйн төрийн байгууллагын тогтолцоог тодорхойлохдоо: “засаг хуваах” (тэр үеийн хэллэг) букуу “эрх мэдэл хуваарилах” (одоогийн хэллэг) онолыг хүлээн авах нь зүйтэй гэж дурдаад шинэ тогтолцоог тодорхойлохдоо: Ерөнхийлөгч–Парламент–Засгийн газар, эсхүл Парламент–Ерөнхийлөгч–Засгийн газар гэсэн хоёр хувилбарын аль нэгийг сонгох шаардлагатай гэсэн саналыг толилуулжээ. Энэ саналд Монгол Улсын Ерөнхийлөгчийн институц бий болгох санааг анх ийнхүү гаргаж, парламентын засагт улсын ерөнхийлөгчийн хувилбар илүү зохистой хэмээн үзжээ.³¹¹

Ийнхүү АИХ-ын Тэргүүлэгчдээс боловсруулсан үзэл баримтлалын дагуу АИХ-аас “БНМАУ-ын төрийн дээд байгууллагын бүтцийн тухай” тогтоол гарч, түүнд БНМАУ-ын төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч байхаар тогтоосон.

Хуулийн төслийг АИХ-ын IX чуулганаараа хэлэлцэж, 1990 оны 05 дугаар сарын 12-ны өдөр “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай” хуулийг³¹² баталсан. Нэмэлтийн тухай хуулийн 11-17 дугаар зүйлд төрийн дээд байгууллагын шинэ тогтолцоонд Ерөнхийлөгчийн эзлэх байр, сонгогдох, ажил хариуцах ёс, түүнд тавих шаардлага, үндсэн бүрэн эрх, түүний эхлэх, дуусгавар болох, хариуцлага хүлээх үндэслэлийг, мөн хуулийн 13 дугаар зүйлд БНМАУ-ын Ерөнхийлөгч бол Ардын төрийн тэргүүн, БНМАУ-ын тусгаар тогтнол, Монголын ард түмний эв нэгдлийн баталгаа гэж тодорхойлоод Ерөнхийлөгчийн албан тушаалд хоёр ба түүнээс дээш хүний нэрийг дэвшүүлэн, АИХ-ын нийт депутатын олонхын саналаар сонгож, тангараг өргөснөөр бүрэн эрх нь эхэлж байхаар тогтоосон байв. Монгол Улсад Ерөнхийлөгч гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн шинэ байгуулалт (институц) ийнхүү бий болсон.

³⁰⁸ Амарсанаа Ж. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн баталгаа. “Ерөнхийлөгчийн институтыг боловсронгуй болгох нь” онол практикийн бага хурлын эмхэтгэл. УБ., 2003.

³⁰⁹ “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай” хууль. БНМАУ-ын Ардын Их Хурлын 2 дахь удаагийн сонгуулийн 9 дүгээр чуулганы 1990.05.12-ны өдрийн хуралдаанаар батлагдсан. **Эх сурвалж:** Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2016. 443-451 дэх тал.

³¹⁰ Чимид Б. Ардчилсан Үндсэн хууль бол Монголын ард түмний бүтээл. “Ардчилсан Үндсэн хууль-20” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2012. 11 дэх тал.

³¹¹ Чимид Б. Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал. “Ерөнхийлөгчийн институтыг боловсронгуй болгох нь” онол практикийн бага хурлын эмхэтгэл. УБ., 2003. 14-19 дэх талууд.

³¹² “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай” хууль. БНМАУ-ын Ардын Их Хурлын 2 дахь удаагийн сонгуулийн 9 дүгээр чуулганы 1990.05.12-ны өдрийн хуралдаанаар батлагдсан. **Эх сурвалж:** Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2016. 443-451 дэх тал.

Өөрөөр хэлбэл, парламентаас сонгогддог, түүний өмнө хариуцлага хүлээдэг гол зарчмын хувьд парламентын бүгд найрамдах улсын ерөнхийлөгчийн статустайгаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн албан тушаалыг анхлан бий болжээ. Ийнхүү төр тэргүүлдэг байгууллага нь бие даан, шийдвэрээ өөрөө шууд батлан гаргадаг болов.³¹³

Ийнхүү 1990 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр “Үндсэн хуулийн нэмэлтийн тухай” хууль, АИХ-ын анхдугаар хуралдааны дэгд заасан журмын дагуу Ерөнхийлөгчид АИХ-ын депутатуудын дотроосоо нэр дэвшүүлэн хэлэлцэн нууцаар санал хурааж, Санал хураах комиссын³¹⁴ тогтоолыг³¹⁵ үндэслэн БНМАУ-ын анхны Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат АИХ-аас сонгогдсон³¹⁶ байна.

БНМАУ-ын Ерөнхийлөгч 1993 оны 06 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл Парламентаас сонгогдсон Ерөнхийлөгч шинэ Үндсэн хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байсан.³¹⁷

1.2.1992 оны Үндсэн хууль батлах явцад Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал ба түүнийг сонгох журмын талаар үзэл баримтлал

1.2.1.Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлын талаар

Үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссын дарга, БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбатын хэлсэн үг, тавьсан илтгэлүүдэд Үндсэн хуулийн төсөл боловсруулах комисс Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлын талаар ямар байр суурь баримталж байсан нь тодорхой харагддаг.

Эдгээрийг тоймловол: АИХ-ын IX чуулганы хуралдаанд тавьсан “БНМАУ-ын төрийн эрх барих дээд байгууллагын бүтцийг өөрчлөн шинэчлэх тухай БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн төсөл” илтгэлд: *“улс оронд эдийн засаг, улс төрийн дорвитой шинэчлэл хийх, төрийн үйл хэргийг жолоодох арга хэлбэрийг боловсронгуй болгох, түүнд ардчилсан ёс, төвлөрсөн ёс хоёрыг зөв хослуулах зорилт нь Парламентын буюу төлөөлөгчдийн засаглалыг Ерөнхийлөгчийн эрх мэдэлтэй хослуулах замаар хууль тогтоох, хянах, гүйцэтгэх механизмын харилцан уялдааг сайжруулахыг зүй ёсоор шаардаж байна”* гээд *“төсөлд зааснаар Ерөнхийлөгчийн албан тушаал бий болгохдоо төрийн эрх барих дээд байгууллага нь АИХ хэвээр байж, хууль тогтоох байнгын байгууллага нь Улсын Бага Хурал, гүйцэтгэн захирамжлах дээд байгууллага нь Засгийн газар байх тийм нөхцөлийг харгалзан үзсэн юм. Ийм нөхцөл байдалд хууль тогтоох, гүйцэтгэн захирамжлах үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад Ерөнхийлөгч чухал үүрэг гүйцэтгэх учиртай. Чухам ийм л зохион байгуулалттай байвал төрийн хууль, төлөөлөгчдийн байгууллагын бусад шийдвэр хэрэгжих нэмэлт баталгаа бүрдэж хэрэгжих болно.”*; Улсын Бага Хурал (УБХ)-ын III чуулганы хуралдаанд тавьсан “Монгол Улсын Их цааз” (Үндсэн хууль)-ын төслийн талаар” илтгэлд: *“...харьцангуй бие даасан эрх бүхий ерөнхийлөгчтэй байх саналыг сонгож авсан”* тухай дурдаад, *“...шинэ төсөл ёсоор Ерөнхийлөгч төрийн гурван оргилын үйл ажиллагааг холбож, тэдний хоорондын харилцаанд үүсч болох зарим ээдрээтэй асуудлыг*

³¹³ Чимид, Б. Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал. “Ерөнхийлөгчийн институтыг боловсронгуй болгох нь” онол практикийн бага хурлын эмхэтгэл. УБ., 2003. 20-21 дэх талууд.

³¹⁴ БНМАУ-ын АИХ-ын “Комисс байгуулах тухай” 1990.09.03-ны өдрийн №06 тогтоол. **Эх сурвалж:** Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ. 2016.

³¹⁵ БНМАУ-ын АИХ-ын Санал тоолох комиссын “Санал тоолсон дүнгийн тухай” 1990.09.03-ны өдрийн №01 тогтоол. **Эх сурвалж:** Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ. 2016. 82 дахь тал.

³¹⁶ “БНМАУ-ын Ерөнхийлөгчийг сонгох тухай” хууль. 1990.09.03-ны өдөр батлагдсан. **Эх сурвалж:** Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ. 2016. 81 дэх тал.

³¹⁷ Долгоржав Я. Нээлтийн үг. “Ерөнхийлөгчийн институтыг боловсронгуй болгох нь” онол практикийн бага хурлын эмхэтгэл. 2003. 13 дахь тал.

зохицуулах, тэнцвэржүүлэх, тэнцвэржилтийг барьж байх ийм үүрэгтэй байвал яасан юм гэж үзсэн юм”; АИХ-ын чуулганы II хуралдаанд тавьсан “Монгол улсын Их Цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай” илтгэлд: “...Монгол Улсын хөгжлийн түүхэн сургаамж, шилжилтийн үеийн онцлог зэргийг харгалзан **зохих бүрэн эрхтэй ерөнхийлөгчтэй** төрийн удирдлагын парламентын хэлбэрийг сонгон авч байна.”; “Ерөнхийлөгч нь **төрийн тэргүүн**, Монголын ард түмний **эв нэгдлийн бэлгэдэл байх** хууль зүйн үндэслэлийг тогтоох үзлийг баримталсан юм.”; “Их Цаазын төслийн ёсоор Ерөнхийлөгч нь **зонхилж төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд ажиллах чиглэлтэй** байгаа бөгөөд төрийн тэргүүний хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүхийн байгууллагыг удирдах ажиллагаанд **зохицуулах зарчим, чиг үүрэгтэй** байна.”; “Парламентын удирдлагын хэлбэр зонхилж байгаа зарим орны ерөнхийлөгчийн **эрх хэмжээтэй харьцуулахад** манай Ерөнхийлөгчид нэлээд эрх эдлүүлэхээр төсөлд оруулсан боловч Ерөнхийлөгч төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх буюу Засгийн газрын үйл ажиллагааг чиглүүлэхтэй холбогдсон эрх хэмжээ одоогийн төсөлд арай дутмаг байгаа юм.” гэж тус тус хэлжээ.

Эдгээрээс үзвэл, Ерөнхийлөгчийн чиг үүргийг төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын хоорондын уялдаа холбоог хангах үүрэгтэй холбон авч үзэж байсан байна. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч нь бусад парламентын бүгд найрамдах улсын төрийн тэргүүнтэй харьцуулбал, илүү бүрэн эрхтэй гэдгийг хоёрдмол утгагүйгээр хэлж байв.

1.2.2.Ерөнхийлөгчийг сонгох журмын талаар

АИХ дээр мэтгэлцээн өрнөсөн гол асуудал нь Ерөнхийлөгчийг хаанаас сонгох тухай асуудал байсан.³¹⁸

Үндсэн хууль тогтоогчид ерөнхийлөгчийн төрийн тогтолцоонд эзлэх байр суурь болон бүрэн эрхэд түүнийг сонгох журам ихээхэн нөлөөтэй гэдгийг сайн ойлгож байжээ. Хэрэв ерөнхийлөгч парламентаас сонгогдвол түүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл бололцоо харьцангуй хязгаарлагдмал байх бол бүх нийтээр сонгогдсон ерөнхийлөгчийн зангарга, асуудалд хандах хандлага, бусад институцтэй харилцах байдал огт өөр байна.

Тухайлбал, Ерөнхийлөгчийг сонгох журмын талаар дараах байр суурийг илэрхийлж байсныг тоймловол: АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга П.Очирбат АИХ-ын IX чуулганы хуралдаанд тавьсан илтгэлдээ “БНМАУ-ын төрийн эрх барих дээд байгууллагын бүтцийг өөрчлөн шинэчлэх тухай БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн төсөл” илтгэлдээ: **“Ерөнхийлөгчийг БНМАУ-ын АИХ-аас сонгох хувилбарыг сонгон авч байна. Ерөнхийлөгчийг ард түмнээс шууд сонгох гэсэн санал цөөнгүй байгааг бид тал талаас нь авч үзлээ. Хэрэв ийнхүү шууд сонговол, Ерөнхийлөгч нь АИХ-тайгаа адил түвшинд байхад хүрнэ. Тэгээд төрийн хяналтаас гадуур, бүхнийг шийддэг, өөрийн үзэл бодлоо УБХ-даа тулган хүлээлгэх онцгой эрх мэдэлтэй албан тушаалтан болчих вий дээ гэж үзэх талтай. Ингэхгүй гэх баталгаа ч хараахан олдохгүй байна.”** гэж байжээ.

БНМАУ-ын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын дарга П.Очирбат УБХ-ын 1991 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанд тавьсан илтгэлд “...Шинэ төслийн ёсоор **Ерөнхийлөгч ард түмнээс нэр дэвшин, Их Хурлаас сонгогдсон төрийн тэргүүнийхээ** хувьд өөрөө ард түмэн, түүний төлөөлөгчдийн байгууллагын хяналтад байхын зэрэгцээ төрийн дээд эрх мэдлээ хэрэгжүүлдэг байгууллагуудын аль нэг нь бүрэн эрхээ хэтрүүлж эхлэхэд хянаж хориг тавих

³¹⁸ “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн үүрэг” Дүн шинжилгээ. УБ., 2015. 37-40 дэх тал.

бололцоо бүхий харилцан уялдсан эрх хэмжээтэй байх нь зүйтэй гэж үзсэн.” гэсэн байна.³¹⁹

Шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулах үед дээрх санал өөрчлөгдсөнийг БНМАУ-ын Ерөнхийлөгч, Комиссын дарга П.Очирбатын АИХ-ын чуулганы 1991 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанд тавьсан “Монгол Улсын Их цааз (Үндсэн хууль)-ын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай” илтгэлээс харж болох юм. Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлэх³²⁰ явцад энэ талаар гаргасан саналыг харгалзан ийнхүү Ерөнхийлөгчийн сонгуулийн хувилбарыг ийнхүү шинэчилжээ. (Шигтгээ 1.)

Шигтгээ 1. БНМАУ-ын АИХ-ын чуулганы 1991.11.13-ны өдрийн хуралдаанд БНМАУ-ын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын дарга П.Очирбатын тавьсан “Монгол Улсын Их цааз /Үндсэн хууль/-ын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай” илтгэлээс

...Их цаазын төсөлд Ерөнхийлөгчийг сонгох сонгууль хоёр шаттай байхаар тогтоосон юм. Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлэх явцад энэ талаар гаргасан саналыг харгалзан үзэж Комисс Ерөнхийлөгчийн сонгуулийн хувилбарыг доорх байдлаар шинэчиллээ.

Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргахаар төсөлд тусгав. Энэ тохиолдолд хоёр дахь шатны сонгууль хийхгүй. Харин Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн хэн нь ч сонгогчдын олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүнийг хоёр дахь шатны сонгууль буюу Улсын Их Хуралд оруулан хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний олонхын саналаар Ерөнхийлөгчийг сонгохоор тусгаж байна.

Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлэх явцад Ерөнхийлөгчийг ард түмнээс шууд сонгох, мөн Улсын Их Хурлаас сонгох, эсвэл энэ хоёр хэлбэрийг хослуулсан хувилбар байх тухай гурван янзын санал гарсан юм. Бид сүүлчийн хувилбарыг нь сонгож авсан. Ерөнхийлөгчийг шууд парламентаас сонгох зарчим нэлээд түгээмэл байгаа бөгөөд тухайн нөхцөлд парламентат ёс төлөвшин хөгжих үйл явц эхэлж байгаа орнуудад төрийн засаг нь ард түмнээс сонгогдсон парламентад төвлөрдөг байна. Үүний хамтаар Ерөнхийлөгчийг эрх мэдлээ хэрэгжүүлэхэд ард түмний төлөөлөгчдөөс төрийн дээд хяналт тавих, ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд гарч болох дутагдал, доголдлыг сэргийлэх, тухайн үед нь залруулах, улмаар эрх мэдлээ хэтрүүлэх явдлыг хязгаарлаж байх боломжийг бүрдүүлдэг. Гэвч энэ тохиолдолд Ерөнхийлөгчийн сонгууль зөвхөн парламентын хүрээнд түүнд суудал авсан намуудын хэмжээнд болдог бөгөөд нийт ард түмний хүсэл эрмэлзэл үүнд төдийлөн нөлөөлж чаддаггүй байсан.

Тиймээс ч бид эдгээр хэлбэрийг хослуулсан уян хатан, дундаж гэж болох хувилбарыг сонгож авсан. Парламентын удирдлагын хэлбэр зонхилж байгаа зарим орны Ерөнхийлөгчийн эрх хэмжээтэй харьцуулахад манай Ерөнхийлөгчид нэлээд өргөн эрх эдлүүлэхээр төсөлд оруулсан боловч Ерөнхийлөгч төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх буюу Засгийн газрын үйл ажиллагааг чиглүүлэхтэй холбогдсон эрх хэмжээ одоогийн төсөлд арай дутмаг байгаа юм. Ерөнхийлөгчөөр сонгогдох хүний насны талаар ярилцах нь зүйтэй гэж бодож байна.

УБХ-аас АИХ-д өргөн мэдүүлсэн төсөлд ерөнхийлөгчийн сонгуулийг хоёр шаттай байхаар, ингэхдээ эхний шатанд сонгогчдын санал хурааж хамгийн олон санал авсан хоёр хүнийг дараагийн шатанд парламентад санал хурааж сонгох хослуулсан системийг өвөрмөц байдлаар тусгасан байжээ.

³¹⁹ Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын УБХ-ын 1991.10.17-ны өдрийн хуралдааны тэмдэглэл.

³²⁰ Монгол Улсын их цааз (Үндсэн хууль)-ын төслийг 1991.06.10-ны өдрөөс 09.01-ний өдрийн хооронд ард нийтээр хэлэлцүүлсэн байна. Уг хэлэлцүүлгийн явцад гарсан саналыг төслийн бүлэг тус бүрээр авч үзвэл, хамгийн олон буюу 40.8 хувь нь “Монгол Улсын төрийн байгуулал” гэсэн 3 дугаар бүлэгтэй холбогдсон санал байжээ. БНМАУ-ын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын дарга П.Очирбат. “Монгол Улсын Их цааз (Үндсэн хууль)-ын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай”. БНМАУ-ын АИХ-ын чуулганы 1991.11.13-ны өдрийн хуралдаанд тавьсан илтгэлээс. **Эх сурвалж:** Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ. 2016. 185-218 дахь тал.

Энэ хувилбарыг “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн үүрэг” судалгаанд³²¹ дараах байдлаар дүгнэсэн байна: “Дэлхийн хаана ч байхгүй, ойлгомж муутай тогтолцоо гэсэн байна. Энэ нь харилцан буулт хийсэн хувилбар мэт боловч сонгуульд олон нийтийн өрсөлдөөн бий болгосон, зардал ихтэй хэрнээ эцсийн шийдвэрийг дээд зиндааныхан гаргахаар хоёр тогтолцооны хамгийн муу талуудыг хослуулсан хувилбар болсон байв. Энэ тогтолцооны дагуу хэрэв парламент сонгуульд аман хүзүүдсэн нэр дэвшигчийг сонгосон тохиолдолд олон нийтийн сонголтыг үгүйсгэснээрээ нийгэмд үл ойлголцол бий болгох үр дагавартай байв. Өөрөөр хэлбэл, авсан саналын тоогоор нэгд орсон нэр дэвшигчийг дэмжигчдэд зүй ёсны бухимдал үүсч, эсэргүүцэл илэрхийлж болно. Нөгөөтэйгүүр, хэрэв парламент нийтийн санал хураалтын дүнг баталгаажуулсан бол дахин нэг шаттай байх хэрэггүй юм.” гэжээ

Энэхүү журам АИХ-аар бүтэн 4 өдрийн турш (1991 оны 12 дугаар сарын 5-8-ны өдрүүдэд) маш нухацтай хэлэлцэгдэж ихээхэн цаг зарцуулсан байдаг. Ерөнхийлөгчийг бүх ард түмнээс, эсхүл парламентаас, өөр хувилбар нь аль алиныг оролцуулан хоёр шаттай явуулах саналууд өрсөлдөж, эцсийн дүнд УБХ-аас оруулсан хувилбар олонхын дэмжлэг авсныг АИХ-ын хуралдааны тэмдэглэлүүд гэрчилдэг. Тухайлбал, Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байх нь хэвээр үлдэж, хоёр дахь шатанд хамгийн олон санал авсан хоёр хүнийг хооронд нь өрсөлдүүлэх биш харин “анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчдын олонхын санал авсан нэр дэвшигчийг УИХ Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрнө” гэж уг заалтыг өөрчилсөн юм.

Шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэн батлах явцад төсөл нийт 5 удаа өөрчлөгдөж, ерөнхийлөгчийг сонгох журам (Үндсэн хуулийн Гучдугаар зүйл)-ыг тэдгээр төслүүдэд хэрхэн томьёолж байсныг Хавсралт 1-ээс үзнэ үү.

Хүснэгт 1. Шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэн баталсан цаглабар

1-р төсөл МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ	2-р төсөл МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ	3-р төсөл МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ	4-р төсөл МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ
УБХ-д өргөн барьсан хувь	Ард түмнээр хэлэлцүүлсэн хувь	УБХ-д өргөн барьсан хувь	УБХ-аас АИХ-д өргөн барьсан хувь	Батлагдсан хувь
1991.04.19	1991.06.05	1991.10.05	1991.11.07	1992.01.13

Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2 дугаар хуралдаанаар 430 депутат 76 хоногийн турш хэлэлцэж, эцэст нь Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгодог байхыг депутатуудын олонх нь санал гаргасан тул энэ томьёоллоор санал хураахад хуралдаанд ирсэн 334 депутатаас 236 нь дэмжжээ.

1.3.Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойших нөхцөл байдал

1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан шинэ Үндсэн хуулийн дагуу 1993 оны 06 дугаар сарын 18-ны өдөр бүх нийтийн сонгуулиар Монгол Улсын анхны Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат сонгогдсоноос хойш Ерөнхийлөгчийн сонгууль 8 удаа явагджээ. 1997, 2001 онд Н.Багабанди, 2005 онд Н.Энхбаяр, 2009, 2013 онд Ц.Элбэгдорж, 2017 онд Х.Баттулга нар Монгол Улсын Ерөнхийлөгчөөр тус тус сонгогдож, 2021 оноос Монгол Улсын зургаа дахь Ерөнхийлөгч У.Хүрэлсүх уг албыг хашиж байна.

³²¹ “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн үүрэг” Дүн шинжилгээ. УБ., 2015. 37-40 дэх тал.

Үндсэн хууль ёсоор Монгол Улсын Ерөнхийлөгч нь Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч бөгөөд улс орноо гадаад, дотоодод төлөөлөх бүрэн эрхтэй. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль болон бусад хуулиар бүрэн эрхийг нь баталгаажуулж өгсөн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу зохион байгуулж ирэв. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль нь 1993, 2012, 2015 онд батлагдаж байсан ба одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа шинэчилсэн найруулга нь 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан.

Ерөнхийлөгчийн сонгуулийн эрх зүйн үндсийг Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлээр тогтоосон. УИХ-д суудал бүхий нам дангаараа, эсхүл хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлэхээр хуульчилсан. Энэ заалтыг Ерөнхийлөгчийн улс төрөөс хараат бус байх үзэл санаатай зарим талаар зөрчилдөж байна хэмээн “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн үүрэг” дүн шинжилгээнд³²² дүгнэсэн байна.

Мөн Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхийлөгчийн сонгууль “хоёр шаттай байна” гэж заасныг дараах шалтгаанаар “ойлгомж муутай хувилбар” гэж үзэж байна.³²³ Үүнд:

- Хоёр шаттай сонгууль гэдэг нь эхлээд бүх нийтийн сонгуулиар Ерөнхийлөгчийг сонгоод, дараа нь тэрхүү сонголтыг УИХ-аас баталгаажуулахыг хэлж байна уу, аль эсхүл бүх нийтийн сонгууль нь заавал хоёр шатаар явахыг хэлж байна уу гэдэг нь анхнаасаа бүрхэг байсан;
- Нэр дэвшигч анхан шатны сонгуульд олонхын санал авах боломжтой бөгөөд энэ тохиолдолд хоёр дахь шатны сонгуулийг явуулах шаардлагагүй. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд (2012) “Хоёр дахь шатны сонгууль гэж анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж түүний бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргахыг хэлнэ” гэж заасан.³²⁴ Эрдэмтэд энэ заалтыг зүй ёсоор шүүмжилж, энд дурдсан хоёр дахь шатныг сонгуулийн бие даасан шат гэж үзэхгүй, учир нь энэ нь ард түмний сонголтыг дээд байгууллагаас хүлээн зөвшөөрч байгаа ердийн үйл явц бөгөөд нэр дэвшигчийг сонгох “сонгууль” явагддаггүй. Энэ нь шийдвэрийг хоёрдмол байдлаар хүчин төгөлдөр болгож байгаа хэрэг биш, харин ард түмний илэрхийлсэн шийдвэрийг хууль зүйн хэлбэрт оруулж байгаа явдал юм. Иймд УИХ ард түмний сонголтыг нэгэнт өөрчилж чадахгүй тул сонгуулийн бие даасан шат бий болгох замаар энэ сонголтыг авч хэлэлцэх шаардлагагүй гэсэн байна.

Иймд “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн үүрэг” дүн шинжилгээнээс “Хоёр шат гэдэгт чухам юуг ойлгохыг тодруулах зорилгоор Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөх шаардлагатай.” хэмээх зөвлөмжийг гаргасан байна.

Түүнчлэн “Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна” гэснийг 3 янзаар тайлбарласан тухай, түүний дотор Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга Б.Чимид асан Их цаазын төсөлд Ерөнхийлөгчийн сонгууль хоёр

³²² “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн үүрэг” Дүн шинжилгээ. УБ., 2015. 37-40 дэх тал.

³²³ “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн үүрэг” Дүн шинжилгээ. УБ., 2015. 37-40 дэх тал.

³²⁴ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, 4 дүгээр зүйлийн 8 дахь заалт, 2012.

шаттай байхаар АИХ-д өргөн баригдаад сүүлийн шат нь үгүйсгэгдсэн ч уг зүйлийн толгойд байсан “хоёр шаттай байна” гэсэн нь ...сэмхнээр нуугдан үлджээ. Энэ нь “алтны үртэс шороотой байдаг, амьтны үр зунгагтай төрдөг”-өөс ялгаа юун гэж хошигносон тухай УБХ-ын болон УИХ-ын гишүүн асан, Үндсэн хууль судлаач Ц.Товуусүрэн “Үндсэн хуулиа ойлгохуй” номондоо бичжээ.³²⁵ Иймээс үүнийг цаашид анхааралдаа авах хэрэгтэй.

1.3.1.2017 оны Зөвлөлдөх санал асуулгаар хэлэлцсэн байдал

УИХ-аас 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.3.3-т заасан асуудлыг УИХ хэлэлцэн шийдвэрлэх үндэслэл, шаардлагыг тодорхойлоход Зөвлөлдөх санал асуулгыг заавал явуулна” гэж заасны дагуу “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар Зөвлөлдөх санал асуулга явуулах, Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай” УИХ-ын 2017 оны 24 дүгээр тогтоол батлагдсан юм.

Энэ тогтоолын хавсралтаар Зөвлөлдөх санал асуулгын 6 сэдэв баталсны нэг нь **“Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, энэ чиглэлд ажил, үүргийн давхардлыг арилгах үүднээс Ерөнхийлөгчийн эрх, үүргийг тодорхой болгох”** гэсэн 2 дахь сэдэв байв.

Ерөнхийлөгчийн засаглалтай оронд төрийн тэргүүн нь засгийн тэргүүний үүргийг давхар гүйцэтгэж, засгийн газраа өөрөө байгуулж, удирддаг. Харин парламентын бүгд найрамдах улсад төрийн тэргүүн гагцхүү улс үндэстнийхээ бүрэн эрхт байдал, эв нэгдлийг илэрхийлэгч байдаг бөгөөд Засгийн газрын өдөр тутмын үйл ажиллагаанд тэр бүр оролцдоггүй.

Үүний дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн” хэмээн заажээ. Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалын дагуу Монгол Улс парламентын засаглалтай учир Ерөнхийлөгч Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд заасан билэгдлийн шинжтэй, цөөн бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрхтэй гэж үздэг.

Гэсэн ч Монгол Улсад Ерөнхийлөгч бүх ард түмнээс сонгогддог, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлдэг, хууль санаачлах, Засгийн газарт чиглэл өгөх эрх эдэлдэг, Үндсэн хуулиас гадна бусад хуулиар Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нэмэгдүүлэх боломж олгосон учраас Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээ өргөжсөн зэрэг нь Монгол Улсын Ерөнхийлөгчид бусад парламентын засаглалтай орны төрийн тэргүүнүүдээс илүү улс төрийн идэвхтэй байх, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох бодит боломжийг олгож байна гэж судлаачид асуудал дэвшүүлжээ.

Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг илүү тодорхой болгох, үндэсний эв нэгдлийг бататгах үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг сонгодог парламентын тогтолцоотой орнуудын жишигт ойртуулах, төрийн тогтолцоонд эзлэх байр суурийг нь төгөлдөржүүлэх зарим шаардлага байгааг Зөвлөлдөх санал асуулгад зориулж гаргасан танилцуулгад³²⁶ дурдсан байна.

³²⁵ Товуусүрэн Ц. “Үндсэн хуулиа ойлгохуй”. Хоёр дахь хэвлэл. УБ., 2020. 118 дахь тал.

³²⁶ Улсын Их Хурал. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах сэдвийн танилцуулга. УБ., 2017 он. 22-29 дэх талууд.

Иймд Зөвлөлдөх санал асуулгаар³²⁷ хэлэлцүүлэхээр “Ерөнхийлөгчийг нэг удаа 6 жилийн хугацаагаар сонгохдоо УИХ-ын гишүүд, аймаг, нийслэл, хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт гишүүдээс бүрдсэн УИХ-ын өргөтгөсөн хуралдаанаар сонгодог болох” өөрчлөлтийг санал болгож байсан.

Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасны дагуу Үндэсний статистикийн хорооноос 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдөр ирүүлсэн “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар явуулсан анхдугаар зөвлөлдөх санал асуулгын дүнгийн тайлан”-д дурдснаар Зөвлөлдөх II санал асуулгаар **Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгохыг хэвээр үлдээх санал** гарсан байна.³²⁸

Уг тайланг Зөвлөлдөх зөвлөл 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хурлаараа эцэслэн хэлэлцээд дараах зөвлөмжийг гаргасан байна.

Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн дагуу санал асуулгыг удирдан зохион байгуулах, зөвлөлдөх санал асуулгын асуултыг боловсруулах, санал асуулгын дүнг хэлэлцэж зөвлөмж гаргах, энэ талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Зөвлөлдөх зөвлөлийг тухайн асуудлаар мэргэшсэн, хараат бус, мэдлэг, туршлага бүхий хорин нэгэн насанд хүрсэн Монгол Улсын иргэн, эрдэмтэн, судлаач, хувийн хэвшлийн болон тухайн чиглэлийн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан 8 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Зөвлөлдөх зөвлөлөөс Ерөнхийлөгчийг нэг л удаа 6 жилээр сонгохдоо сонгуулийн коллегийос (олон улсын нэршлээр) сонгодог болохыг дэмжээгүйг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулахдаа харгалзаж үзэх зөвлөмжийг УИХ-д өгчээ.

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

³²⁷ **Зөвлөлдөх I санал асуулга** – Үндэсний статистикийн хороо мэргэжил, арга зүйгээр ханган зөвлөлдөх санал асуулгын 1 дэх үе шатны судалгааг 2017.04.12-ны өдрийн 17.00 цагаас эхлэн орон даяар эхлүүлж байсан. Судалгаанд 21 аймаг, 9 дүүргээс санамсаргүй түүврийн аргаар Монгол Улсын нийт 860 гаруй мянган өрхөөс 1570 өрхийг сонгож, тэдгээрт амьдардаг Монгол Улсын насанд хүрсэн, нийт хүн амыг төлөөлөхүйц 2 сая гаруй иргэдээс 1570 иргэнийг сонгосон.

Зөвлөлдөх II санал асуулга – Нэг дэх үе шатанд оролцогчдын 50 хувийг санамсаргүй түүврийн аргаар сонгож 2017.04.29-ний өдөр 2 дахь үе шат буюу Төрийн ордонд болсон зөвлөлдөх уулзалтад 785 иргэнийг сонгон урилга хүргүүлснээс судалгаанд 669 иргэн оролцсон байна.

³²⁸ Монгол Улсын Их Хурал. Үндэсний Статистикийн хороо. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулгын дүн. 2017.

Шигтгээ 2. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар явуулсан анхдугаар зөвлөлдөх санал асуулгын тайланг үндэслэн Зөвлөлдөх зөвлөлөөс Улсын Их Хуралд гаргасан зөвлөмжөөс

2.Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, энэ чиглэлд ажил, үүргийн давхардлыг арилгах үүднээс ерөнхийлөгчийн эрх, үүргийг тодорхой болгох

2.1.Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 6 жил байх, улируулан сонгохгүйгээр УИХ-ын өргөтгөсөн хуралдаанаас сонгодог болох (УИХ-ын өргөтгөсөн хуралдааны бүрэлдэхүүн нь улсын их хурлын 76 гишүүн, аймаг, нийслэл, хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт гишүүдээс бүрдэнэ)

2.1.1.Ерөнхийлөгчийг нэг л удаа 6 жилээр сонгодог болох

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.640, хоёр дахь судалгаагаар 0.471 болж 0.169-өөр өөрчлөгджээ. Эхний судалгаанд хамрагдсан хүний 60.6 хувь нь, хоёр дахь судалгаагаар 40.9 хувь 6-10 оноог сонгожээ. Өөрөөр хэлбэл, мэдээлэл аваагүй эхний шатны судалгаанд оролцогсдын олонх нь дэмжсэн бол хоёр дахь судалгаанд мэдээлэл авч хэлэлцсэний дараа олонх нь дэмжихгүй болж өөрчлөгдсөн байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулахад энэ байдлыг харгалзан үзүүштэй.

2.1.2.Ерөнхийлөгчийг нэг л удаа 6 жилээр сонгохдоо УИХ-ын гишүүд, аймаг, нийслэл, хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт гишүүдээс сонгодог болох

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.390, хоёр дахь судалгаагаар 0.381 болжээ. Эхний судалгаагаар 57.4 хувь нь, хоёр дахь судалгаагаар 56.7 хувь нь 0-4 оноог сонгожээ. Өөрөөр хэлбэл, олонх нь Ерөнхийлөгчийг нэг л удаа 6 жилээр сонгохдоо УИХ-ын гишүүд, аймаг, нийслэл, хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт гишүүдээс сонгодог болохыг дэмжээгүй байна. Үүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулахдаа харгалзаж үзэх шаардлагатай.

1.3.2.2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар³²⁹

Парламентын засаглалтай улсын Ерөнхийлөгч нь хуульд заасан тодорхой нөхцөлд парламент болон Засгийн газар хоорондын харилцааны хяналт-тэнцлийн тэнхлэг нь байж, зохицуулалтын үүрэг гүйцэтгэх учиртай.

Ерөнхийлөгчөөр улиран сонгогдох боломжийг олгож байгаа Үндсэн хуулийн одоогийн зохицуулалт нь харьцангуй нас залуу хүн Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллахдаа дахин сонгогдохын тулд Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч байх зарчмаасаа хазайж, өөрийг нь нэр дэвшүүлсэн улс төрийн намын эрх ашигт нийцүүлэн ажиллахад хүргэх сөрөг үр дагавартай юм.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох насны доод хязгаарыг өндөрсгөж, зөвхөн нэг удаа сонгогдох зохицуулалтыг 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгажээ.

³²⁹ Улсын Их Хурал. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт (Товч танилцуулга). УБ., 2021. 88 дахь тал.

2.ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

2.1.“Төрийн тэргүүн”-ий талаар нэршил

“Ерөнхийлөгч” (англи, герман, францаар president; оросоор президент) гэдэг үг нь латины “prae” буюу “өмнө”, “sedereto sit” буюу “суух” гэсэн үгнүүдээс бүтэх латины “praesidens” буюу “өмнө талд суух, тэргүүнд суух, аливаа юмны толгойд суух” (эрт үед хурал даргалж буй хүнийг ингэж нэрлэж байжээ) гэсэн нэр томьёо болно гэж тайлбарласан байна.³³⁰ Гадаад орнуудад “Ерөнхийлөгч”-ийг “Head of state, President, Chef d’Etat, Governor-general” зэрэг олон янзын нэршилээр томьёолдог.³³¹ Өнөө цагт Ерөнхийлөгч нь бүгд найрамдах засаглалтай улсын төрийн тэргүүн гэсэн утга санааг илэрхийлдэг байна.³³² Парламентын бүгд найрамдах улсад төрийн тэргүүн, ерөнхийлөгчийн бүгд найрамдах улсад төр, засгийн тэргүүн байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн практикт төр, засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх бүхий улс төрийн албан тушаалтныг “ерөнхийлөгч” гэж нэрлэнэ.³³³

Олон Улсын Парламентын Холбоо (IPU)-ны гишүүн парламентын засаглалтай 75 орны³³⁴ Үндсэн хуулиас үзэхэд, 57 хувь нь ерөнхийлөгчтэй, 39 хувь нь эзэн хаан, хатан хаан, амбан захирагчтай, үлдсэн 4 хувь нь бусад өөр нэрээр “төрийн тэргүүн”-ээ томьёолж байна.

Хүснэгт 2. Парламентын засаглалтай орнууд дахь “төрийн тэргүүн”-ий нэршил

Жич: * Холбооны улсуудыг тэмдэглэв.

№	Төрийн тэргүүн	Улсын тоо	Улсын нэр
1.	Хаантай	29 (39%)	
	- Хатан хаан Элизабет II (Амбан захирагч)	14 (19%)	ИБУИНХУ, Австрали*, Антигуа ба Барбуда, Бахам, Белиз, Гренада, Канад*, Сент-Винсент ба Гренадин, Сент-Китс ба Невис*, Сент-Люсия, Соломоны арлууд, Тувалу, Шинэ Зеланд, Ямайка
	- Эзэн хаан (хаан, султан, эмир, хунтайж, их ван, ханхүү)	15 (20%)	Бельги*, Дани, Испани, Камбож, Лесото, Лихтенштайн, Люксембург, Малайз*, Монако, Нидерланд, Норвег, Папуа-Шинэ Гвиней, Тайланд, Швед, Япон
2.	Ерөнхийлөгчтэй	43 (57%)	Албани, Армени, Балба, Бангладеш, Барбадос, Болгар, Ботсван, Вануату, Герман*, Грек, Гүрж, Доминик, Зүүн Тимор, Израил, Ирак*, Ирланд, Исланд, Итали, Кабо-Верде, Кирибати, Латви, Маврики, Мальт, Молдова, Монгол , Өмнөд Африк, Пакистан*, Португал, Самоа, Серб, Словак, Словени, Тринидад ба Тобаго, Унгар, Фижи, Финланд, Умард Македон, Хорват, Чех, Швейцар*, Энэтхэг*, Эстони, Этиоп*
3.	Бусад	3 (4%)	-Андорра (Хос гүн); -Босни-Херцеговин* (Тэргүүлэгчид); -Сан-Марино (Капитан Регент).

³³⁰ Цогтоо Ш. Ерөнхийлөгчийн институт ба Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Эрх зүй. 2014. №2 (28). 65 дахь тал; Лүндээжанцан Д., Өлзийсайхан Л. Парламентат ёс. УБ., 2005. 258 дахь тал.

³³¹ Досжан, Б. Ерөнхийлөгчийн сонгууль: Үндсэн хуулийн эрх зүйн харьцуулсан судалгаа. Монголын төр, эрх зүй. 2017. №2 (88). 24 дэх тал.

³³² Лүндээжанцан Д., Өлзийсайхан Л. Парламентат ёс. УБ., 2005, 258 дахь тал.

³³³ Удирдлагын академи. Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн байх суурь: Бүрэн эрхийн шинжилгээ. УБ., 2019 он. 3 дахь тал.

³³⁴ Parliamentary system. Source: Parline database on national parliaments (<https://data.ipu.org>).

2.2.Төрийн тэргүүний институт³³⁵

Дэлхийн ихэнх оронд төрийн тэргүүний институт байдаг. Төрийн тэргүүн буюу “Head of state” нь улсын тэргүүлэгч хүн юм. Өөрөөр хэлбэл, төрийн тэргүүн бол төрийн байгууллагуудын тогтолцоонд дээд байр суурь эзэлж буй албан тушаалтан буюу байгууллага байна. Мөн дотоод болон гадаадад төрийн дээд төлөөлөл болохын хамт улс үндэстний эв нэгдлийн билэгдэл болдог.³³⁶

Төрийн тэргүүн гэдэг бол олон улсын жишиг маягийн хэллэг бөгөөд парламентын бүгд найрамдах улсууд Үндсэн хуульдаа ерөнхийлөгчөө гол төлөв “төрийн тэргүүн мөн” гэж томъёолсон байдаг.³³⁷

Ардчилал, сонгуульд туслалцаа үзүүлэх олон улсын хүрээлэн (IDEA)-гийн судалгаанд³³⁸ парламентын засаглалтай ардчилсан орнуудын ерөнхийлөгчийг “гүйцэтгэх засаглалын бус ерөнхийлөгч” гэж тодорхойлсон байна. “Гүйцэтгэх засаглалын бус ерөнхийлөгч” нь төлөөллийн болон иргэний үүрэг гүйцэтгэдэг боловч гүйцэтгэх болон шийдвэр гаргах эрх мэдлийг хэрэгжүүлдэггүй, төрийн эв нэгдэл, бүрэн бүтэн байдлыг бэлгэддэг удирдагч гэсэн байна.

Үүнтэй санал нийлдэггүй судлаачид, улс төрчид байдаг. Тэд англи хэлний “head of state” гэсэн үг хэллэгийг “төрийн тэргүүн” гэдгийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг, заримдаа бүр шашны эрхийг ч хүртэл нэг хүн угсаа залгамжлан дангаар хэрэгжүүлж байсан удирдлагын хэлбэр болох “хаан” гэж ойлгодог хуучирсан зан заншлын хэм хэмжээ хэмээн ойлгон ярьж хэрэглэж байна, энэ нь “президент” гэдэг орчин үеийн хууль зүйн шинжлэх ухааны нэр томъёоны утгыг илэрхийлж чаддаггүй, харин ч эрх зүйн байдлыг нь дордуулдаг.³³⁹ гэж үздэг байна.

Төрийн тэргүүний нэршил, түүнийг сонгох, томилох журам, эрх, үүрэг нь тухайн улсын засаглалын хэлбэрээс хамаарч байдаг. Тухайлбал төрийн тэргүүн нь.³⁴⁰

- бүгд найрамдах улсад энэ үүргийг “ерөнхийлөгч” гүйцэтгэдэг бол хаант улсын төрийн тэргүүн нь ихэвчлэн “хаан”, эсхүл “хатан хаан” байдаг;
- ард түмний шууд сонгууль, хууль тогтоох байгууллага, эсхүл сонгуулийн коллегийн шууд бус сонгуулиар сонгогдох, өв залгамжлах зэргээр албан үүргээ хүлээн авдаг;
- Үндсэн хуулийн томоохон эрх мэдэлтэй, эсхүл зөвхөн өөрийн албан тушаал, эсхүл цолтой холбоотой ёслолын эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Жишээлбэл, орчин үед хатан хаан II Елизабета Их Британийн төрийн тогтолцоонд чухал боловч гол төлөв бэлгэдлийн үүрэг гүйцэтгэдэг. Тэрээр Парламентын шинэ чуулган бүрийг нээх, Парламентыг хугацаанаас нь өмнө тараах, улсаа гадаад улсад төлөөлөх зэрэг эрх, үүрэгтэй. Харин Францын Ерөнхийлөгч нь гадаад улсын Засгийн газартай гэрээ байгуулах, зэвсэгт хүчнийг удирдах зэрэг томоохон эрх мэдэлтэй. Энэ хоёр тохиолдолд төрийн тэргүүн (хатан хаан, эсхүл Ерөнхийлөгч) нь Ерөнхий сайд болох Засгийн газрын тэргүүнээс ялгаатай. Харин АНУ, Филиппин зэрэг улсад төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүний эрх, үүргийг хэрэгжүүлж байдаг.

³³⁵ Удирдлагын академи. Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн байх суурь: Бүрэн эрхийн шинжилгээ. УБ., 2019 он. 4-5 дахь тал.

³³⁶ Даш-Ёндон Б., Төрийн тэргүүн, парламентын засаглалтай улсын Ерөнхийлөгчийн институт. Шинэ толь. 1999. №4 (28). 57 дахь тал.

³³⁷ Чимид Б. Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал. “Ерөнхийлөгчийн институтыг боловсронгуй болгох нь” (онол практикийн бага хурал), УБ. 2003.

³³⁸ International IDEA. Non-Executive Presidents in Parliamentary Democracies. 2017. Second edition. P.3.

³³⁹ Цогтоо Ш. Ерөнхийлөгчийн институт ба Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Эрх зүй. 2014. №2 (28). 65 дахь тал.

³⁴⁰ <https://www.britannica.com/topic/head-of-state>

Тухайн улсын төрийн удирдлагын хэлбэр, төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмаас нь төрийн тэргүүний нэршил, цаашлаад төрийн тэргүүнийг сонгох, томилох асуудал, төрийн тэргүүний бүрэн эрх зэрэг хамаарч байдаг байна.

2.3. Парламентын засаглалтай орнуудад төрийн тэргүүнийг сонгох, томилох хэлбэр

Судалгаанд хамрагдсан парламентын засаглалтай орнуудад төрийн тэргүүнийг янз бүрийн аргаар сонгож, эсхүл томилж байна. Тухайлбал, Бельги*, Дани, ИБУИНХУ, Испани, Лихтенштайн, Люксембург, Монако, Нидерланд, Норвег, Папуа-Шинэ Гвиней, Тайланд, Швед, Япон зэрэг 13 улсад Эзэн хаан угсаа залгамжилдаг бол Лесото, Малайз*, Камбож зэрэг улсуудад Эзэн хааныг Сонгуулийн коллегийг сонгодог, эсхүл томилдог байна. Харин Австрали*, Антигуа ба Барбуда, Бахам, Белиз, Гренада, Канад*, Сент-Винсент ба Гренадин, Сент-Китс ба Невис*, Сент-Люсия, Соломоны арлууд, Тувалу, Шинэ Зеланд, Ямайка зэрэг 13 улсад Амбан захирагчийг Хатан хаан Элизабет II томилж байна.

Ерөнхийлөгчтэй нийт 43 улсын төрийн тэргүүнийг сонгодог гурван хэлбэр байна. Ихэнх улсад буюу 63 хувьд нь Ерөнхийлөгчийг Парламентаас, эсхүл Сонгуулийн коллегийг, үлдсэн 37 хувь нь бүх нийтийн сонгуулиар тус тус сонгож байна.

Хүснэгт 3. Парламентын засаглалтай улсуудыг Ерөнхийлөгчийн сонгуулийн хэлбэрээр ангилсан байдал

Жич: * Холбооны улсуудыг тэмдэглэв.

№	Ерөнхийлөгчийн сонгуулийн хэлбэр	Улсын тоо	Улсын нэр
1.	Парламентаас сонгодог	20 (47%)	Албани*, Армени, Бангладеш, Барбадос, Ботсван, Грек, Доминик, Израил, Ирак*, Латви, Маврики, Мальт, Өмнөд Африк, Самоа, Тринидад ба Тобаго, Унгар, Фижи, Швейцар*, Эстони, Этиоп*
2.	Бүх нийтийн сонгуулиар сонгодог	16 (37%)	Болгар, Зүүн Тимор, Ирланд, Исланд, Кабо-Верде, Кирибати, Молдова, Монгол , Португал, Серби, Словак, Словени, Финланд, Умард Македон, Хорват, Чех
3.	Сонгогчдын коллегийг сонгодог	7 (16%)	Балба*, Вануату, Герман*, Гүрж, Итали, Пакистан*, Энэтхэг*

2.3.1. Ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоо³⁴¹

Ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоо нь хууль тогтоох байгууллагын сонгуулиас ялгаатай байдаг. Ардчилал, сонгуульд туслалцаа үзүүлэх олон улсын хүрээлэн (IDEA)-ээс Ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоог ерөнхийд нь ард түмний шууд болон шууд бус сонгууль гэж хоёр ангилсан байна.³⁴² Мөн “ACE” сонгуулийн мэдлэгийн сүлжээ (www.aceproject.org)³⁴³ байгууллагаас Ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоог мажоритар, хоёр шатлал бүхий, давуу эрхтэй саналын (Preferential Voting) гэж гурав ангилсан байна.

Судалгааны энэ хэсэгт Ерөнхийлөгчийн сонгуулийн дээрх хоёр ангиллыг нэгтгэн авч үзлээ.

³⁴¹ ACE Electoral Knowledge Network. <https://aceproject.org/main/english/es/esi01.htm>

³⁴² International IDEA. Non-Executive Presidents in Parliamentary Democracies. 2017. Second edition.

³⁴³ ACE сонгуулийн мэдлэгийн сүлжээ (www.aceproject.org) байгууллага нь сонгуулийн талаар иж бүрэн, эрх мэдэл бүхий мэдээллээр хангадаг, сонгуулийн үйл явцын талаарх мэдээлэл, мэдлэг түгээх, чадавхыг бэхжүүлэх, туслалцаа үзүүлэх интерактив мэдлэгийн систем юм.

2.3.1.Ард түмний шууд сонгууль

Ард түмний шууд сонгуулийн тогтолцоог дараах байдлаар гурван ангилна:

а) Энгийн олонхын буюу мажоритар тогтолцоо

Энгийн олонхын тогтолцоо (simple plurality vote) буюу мажоритар тогтолцоо (First Past the Post - FPTP)-нд хамгийн олон санал авсан нэр дэвшигч ялалт байгуулдаг. Энэхүү тогтолцоо нь шударга, энгийн, хямд, үр дүнтэй байдаг тул ерөнхийлөгчийг сонгох хамгийн хялбар арга гэж үздэг.

Гэвч олон нэр дэвшигчтэй ширүүн өрсөлдөөнтэй үед нэр дэвшигчид цөөн хувийн саналаар Ерөнхийлөгчөөр сонгогдох сул талтай. Тухайлбал, 1993 онд Венесуэлд Рафаэль Кальдера нийт сонгогчдын 30.5 хувийн саналаар Ерөнхийлөгчөөр сонгогдож байсан бол 1992 онд Филиппинд Фидель Рамос бусад 7 нэр дэвшигчээс ердөө 25 хүний санал илүү авч Ерөнхийлөгчөөр сонгогдож байжээ.

Мөн энэхүү тогтолцоо нь хоёр хуваагдсан нийгэмд “ялагч бүхнээ авна” гэсэн улс төрийн асуудлыг хурцатгаж болзошгүй байдаг. Тухайлбал, 1992 онд Анголын Ерөнхийлөгчийн сонгуульд 40 хувийн санал авсан Йонас Савимби нь түүнээс ердөө 9 хувиар илүү санал авсан Хосе дос Сантос-т ялагдсан. Йонас Савимби-д ардчилсан сөрөг хүч байх сонирхол бага байсан учраас иргэний дайныг дахин эхлүүлж байжээ. 2000 онд Тайванийн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшсэн Чен Шуйбян 39 хувийн санал авч, өрсөлдөгчөөсөө 3 хүрэхгүй хувийн илүү саналаар ялалт байгуулсан нь улс төрийн эрс өөрчлөлтийг бий болгосон.

б) Хоёр шатлал бүхий тогтолцоо

Хоёр шатлал бүхий тогтолцоо (Two-Round System - TRS) нь эхний шатны санал хураалтад сонгогчдын үнэмлэхүй олонхын санал авах шаардлагатай байдаг. Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч үнэмлэхүй олонхын санал аваагүй бол уг санал хураалтад тэргүүлсэн хоёр нэр дэвшигчийн хооронд санал хураалтын хоёр дахь шатанд өрсөлдөөн явагдана. Хоёр дахь шатны санал хураалтад оролцсон сонгогчдын олонхын санал авсан нэр дэвшигч сонгогдоно. Энэ тогтолцоог Франц, Австри, Болгар, Португал, Польш, ОХУ, Финланд зэрэг Европын орнууд, Намиби, Мозамбик, Мадагаскар, Конго, Сьерра-Леон, Төв Африкийн БНУ зэрэг Африкийн орнууд хэрэглэдэг.

Энэхүү тогтолцоонд зарим тохируулга байдаг. Тухайлбал, Коста Рикад нэр дэвшигч эхний шатанд ердөө 40 хувийн саналаар ялах боломжтой. Харин Сьерра-Леонд нэг нэр дэвшигч эхний шатанд 55 хувийн санал аваагүй бол хоёр дахь шатны санал хураалт явагдахгүй. Аргентинд нэр дэвшигч ялалт байгуулахын тулд 45 хувь, эсхүл 40 хувийн санал авсан ч хамгийн ойрын өрсөлдөгчөөсөө 10 гаруй хувиар олон санал авахыг шаарддаг.

ОХУ болон хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан ихэнх улсад ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчдын хамгийн бага ирц буюу 50 хувь байдаг. Энэ нь сонгуулийн үр дүнгийн хууль ёсны байдлыг баталгаажуулах нэмэлт механизм боловч эхний шатны санал хураалтад ирц хүрээгүйн улмаас хоёр дахь шатны санал хураалтыг явуулах шаардлагатай болж ихээхэн хэмжээний зардал, техникийн асуудалтай тулгардаг байна.

Хоёр шатлал бүхий тогтолцооны муу туршлага Латин Америкт байдаг. Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний шатанд ялалт байгуулахын тулд намууд эвсэж чадсан орнуудыг эс тооцвол (жишээлбэл, 1994 онд Бразил, 1989, 1994 онд Чилид гэх мэт), энэ тогтолцооны эцсийн үр дүнд цөөнх Засгийн газрыг удирдаж, засаглах чадвар буурах сөрөг тал ажиглагддаг.

Энэхүү тогтолцоо нь олон намын тогтолцооны туйлшралыг улам бүр хурцатгаж, хууль тогтоох байгууллагыг мухардалд оруулах тохиолдол ч гарч байсан. Тухайлбал, 1990 оны Перуд Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатанд Альберто Фухимори сонгогчдын 56 хувийн санал авсан боловч түүний нам Сенатад 60 суудлын 14-ийг нь, Төлөөлөгчдийн танхимд 180 суудлын 33-ыг нь л авч байжээ. 1989 онд Бразилд Фернандо Колор де Мело хоёр дахь шатанд 50-аас бага санал авч сонгогдсон боловч түүний нам тусдаа явагдсан парламентын сонгуульд Сенатад 75 суудлын ердөө 3-ыг нь, Депутатуудын танхимд 503 суудлын дөнгөж 40-ийг нь л авчээ. 1979 онд Эквадорт Ерөнхийлөгчийн сонгуулийг хоёр шатлал бүхий тогтолцоогоор явуулдаг болсноос хойш цөөнхийн Засгийн газрууд байгуулагддаг болсон.

Үүнээс үүдэн гарч буй засаглалын асуудлууд нь харилцан уялдаатай институцын бүтцийг нэгэн зэрэг авч үзэх нь чухал болохыг харуулж байдаг. Хоёр шатлал бүхий тогтолцоо нь санал хураалтын хоёр дахь шатанд ард түмний олонхын саналаар Ерөнхийлөгчийн эрх мэдэлд хүргэдэг ч хууль тогтоох байгууллагын сонгуулийн бусад тогтолцоог ашигласан ч ерөнхийлөгч нь парламентад томоохон дэмжлэг үзүүлэх баталгаа болж чадаагүй байна.

Мөн амжилтад хүрсэн нэр дэвшигчид нь хоёр шатны санал хураалтаар бусад намаас дэмжлэг авсан ч сонгуулийн дараа тэрхүү дэмжлэгийг үргэлжлүүлэн авсаар байх боломж хомс байдаг нь ажиглагддаг.

в) Давуу эрхтэй саналын буюу санал хураалтын түргэвчилсэн тогтолцоо

Давуу эрхтэй саналын (Preferential Voting) буюу санал хураалтын түргэвчилсэн тогтолцоо (an instant run-off system) нь хоёр шатлал бүхий тогтолцооны сул талыг сайжруулсан буюу санал хураалтын хоёр шатыг нэгтгэж нэг сонгууль хийх явдал юм. Үүнийг мөн альтернатив санал хураалт гэж нэрлэдэг.

Энд сонгогчид нь нэр дэвшигчдийг давуу эрхээр эрэмбэлэх боломжийг олгодог. Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч сонгогчдын үнэмлэхүй олонхын саналыг аваагүй бол хамгийн бага санал авсан нэр дэвшигчийг хасаж, түүний саналыг дараагийн сонголтод шилжүүлдэг. Энэхүү хасагдах, дахин хуваарилах үйл явц нь нэг нэр дэвшигч олонхын санал авах хүртэл үргэлжилнэ.

Шри Ланкад Ерөнхийлөгчийн сонгуулийг энэ тогтолцоогоор явуулдаг. Тус улсын сонгогчид зөвхөн хамгийн их дэмжиж байгаа нэр дэвшигчийг төдийгүй (хүсвэл) дэмжиж байгаа дараагийн хоёр, гурав дахь нэр дэвшигчдийг тэмдэглэдэг. Ингэхдээ хамгийн их дэмжиж байгаа нэр дэвшигчийн нэрний хажууд “1”, дэмжиж байгаа дараагийн нэр дэвшигчдийн нэрсийн хажууд “2”, “3” гэсэн тоогоор тэмдэглэгээ хийнэ. “1” дэх сонголтоор үнэмлэхүй олонхын санал авсан нэр дэвшигч нь сонгогдоно. Хэрэв нэр дэвшигчийн хэн нь ч ийм санал аваагүй бол эхний хоёр нэр дэвшигчээс бусад нь хасагдаж, хасагдсан саналыг дарааллын дагуу тэргүүлсэн хоёр нэр дэвшигчийн аль нэгэнд нь шилжүүлнэ. Эцэст нь хамгийн олон санал авсан нэр дэвшигч сонгогдоно. Энэ тогтолцоо нь хоёр сонгуулиар бус нэг сонгуулиар үр дүнд хүрдэг тул зардал ихээхэн хэмнэж, удирдлагын үр ашгийг дээшлүүлдэг гэж үздэг.

Шри Ланкийн тогтолцооны (Sri Lankan system) сул тал нь:

- бичиг үсгийн шаардлага өндөр байдаг;
- сонгогчид саналаа бүрэн ашиглахын тулд эхний хоёр нэр дэвшигч хэн болохыг таах хэрэгтэй байдаг.

Энэ тогтолцоог мөн Ирландын Ерөнхийлөгчийг сонгоход ашигладаг. Альтернатив санал хураалт (Alternative Vote - AV) гэж нэрлэдэг энэхүү тогтолцоо нь Шри Ланкийн тогтолцоотой төстэй ч зарим талаараа ялгаатай. Тухайлбал, саналын хуудсанд тэмдэглэгээ хийхэд Ирландын сонгогчид гурван саналаар хязгаарлагдахгүй, саналаа хүссэнээрээ тэмдэглэж

болдог. Мөн саналыг тоолохдоо тэргүүлсэн хоёр нэр дэвшигчээс бусад бүх нэр дэвшигчийг нэгэн зэрэг хасахгүй, эхлээд альтернатив санал хураалтаар хамгийн доогуур эрэмбэлэгдсэн нэр дэвшигчийг хасаж, тухайн саналыг дараагийн сонголт руу шилжүүлнэ. Энэхүү үйл явц нь аль нэг нэр дэвшигч үнэмлэхүй олонхын санал авах хүртэл, эсхүл бүх давуу эрхийг тоолж дуустал давтагдана.

Мөн Шри Ланкийн тогтолцооноос ялгаатай нь Ирландын альтернатив санал хураалтаар хамгийн доогуур эрэмбэлэгдэж байсан нэр дэвшигч нь тэргүүлж байсан нэр дэвшигчдийг гүйцэж түрүүлж, эцэст нь ялалт байгуулах боломжтой байдаг. Ийм байдлаар давуу эрх шилжүүлэх замаар Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан хамгийн сүүлийн жишээ бол 1990 онд Ирландын Ерөнхийлөгчөөр сонгогдсон Мэри Робинсоны тохиолдол юм.

Эдгээр ялгааг үл харгалзан дээрх хоёр тогтолцооны үндсэн зорилго бол сонгуульд ялсан нэр дэвшигч нь сонгогчдын олонхын дэмжлэгийг авсан байх явдал юм. Энд санал хураах, санал тоолох үйл явц нь хоёр шатлал бүхий тогтолцооноос илүү төвөгтэй ч гэсэн сонгуулийг нэг удаа явуулах боломжтой гэдгээрээ ложистикийн хувьд давуу талтай.

2.3.2. Шууд бус сонгууль

Ерөнхийлөгчийн шууд бус сонгуулийн тогтолцооны үед Ерөнхийлөгчийг улс төрийн хувьд төвийг сахисан, нам бус хүн гэдгийг батлах нэмэлт боломжуудыг нээж өгдөг.

а) Дийлэнх олонхын тогтолцоо

Дийлэнх олонхын тогтолцоо (supermajority rules) – Засгийн газар болон сөрөг хүчний намуудад хараат бус, улс төрийн хувьд төвийг сахисан ерөнхийлөгчийг сонгохын тулд олонхын дүрмийг ашигладаг. Энд хэд хэдэн хувилбар байдаг. Тухайлбал, Грект Парламентын нийт гишүүдийн 2/3-ын саналаар Ерөнхийлөгчөө сонгодог. Хоёр шатны санал хураалтад нэр дэвшигчдийн хэн нь ч 2/3-ын олонхын санал авч чадаагүй бол гурав дахь шатны санал хураалтад 3/5-ын олонхын санал авах шаардлагатай байдаг. Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч 3/5-ын олонхын санал авч чадаагүй бол Парламент тарж, дараагийн шинэ Парламент Ерөнхийлөгчийг 3/5-ын олонхын саналаар сонгоно. Энэ оролдлого бүтэлгүйтсэн бол Парламентын энгийн олонхын саналаар Ерөнхийлөгчийг сонгоно.

б) Парламентын шийдвэрээр томилох

Парламентын шийдвэрээр томилох (appointment by parliamentary resolution) – Ерөнхийлөгчийг өрсөлдөөнтэй сонгуулиар сонгохын оронд Парламентаас томилдог хувилбар байдаг. Тухайлбал, Мальтад Төлөөлөгчдийн танхимын тогтоолоор Ерөнхийлөгчөө томилдог. Энд ихэвчлэн Төлөөлөгчдийн танхимын олонхын дэмжлэгтэй Засгийн газар нь дангаараа Ерөнхийлөгчид нэр дэвшүүлдэг. Ингэснээр Ерөнхийлөгчийг хараат, намын хүн гэсэн ойлголтыг нэмэгдүүлж байдаг. Энэ хувилбарт мөн хоёр нам (жишээлбэл, Ерөнхий сайд болон Парламент дахь хамгийн том сөрөг хүчний намын дарга) нэр дэвшүүлж болдог. Үүнийг 1999 онд Австралид санал болгосон ч сонгогчид үүнийг ардчилсан бус гэж үзжээ.

2.4. Парламентын засаглалтай орнуудад ерөнхийлөгчийг сонгох хэлбэр

Парламентын засаглалтай (бүгд найрамдах) улсуудад ерөнхийлөгчийг ихэвчлэн парламент, сонгуулийн коллеги болон бүх нийтийн сонгуулийн аль нэгээр сонгодог.

Судалгааны энэ хэсэгт парламентын засаглалтай орнуудад ерөнхийлөгчийг дээрх гурван хэлбэрээр хэрхэн сонгодог талаар авч үзнэ.

2.4.1. Ерөнхийлөгчийг парламентаас сонгох

Ардчилал, сонгуульд туслалцаа үзүүлэх олон улсын хүрээлэн (IDEA)-ийн судалгаанд³⁴⁴ дурдсанаар ерөнхийлөгчийг парламентаас сонгох нь түүний хараат бус мандат сулрах хандлагатай байдаг. Гэсэн ч ерөнхийлөгчийн сонгуулийн эрх зүйн зохицуулалтаас хамааран энэ нь ерөнхийлөгчийг парламентад олонх болсон гишүүдээс арай илүү эрх мэдэлтэй болгож, улмаар засгийн газраас хараат байдлыг буруулж байж болзошгүй гэсэн байна.³⁴⁵

Парламентаас улсын ерөнхийлөгчөө сонгодог 20 улсаас Барбадос, Өмнөд Африк, Тринидад ба Тобаго, Швейцар, Этиоп зэрэг 5 улс нь хоёр танхим бүхий Парламенттай байна.

Тринидад ба Тобагод Ерөнхийлөгчийг сонгох “Сонгуулийн коллеги” нь бусад улс шиг Парламент болон Орон нутгийн хурлын төлөөллөөс бүрддэггүй, зөвхөн Парламентын хоёр танхимын нийт гишүүдээс бүрдэж байгаа учраас Ерөнхийлөгчийг Парламентаас сонгодог хэлбэрт хамруулан авч үзлээ.

Парламентаасаа Ерөнхийлөгчийг сонгодог парламентын засаглалтай улсын тоонд 2021 оноос Барбадос Улс нэмэгдсэн байна. 2021 оны 11 дүгээр сарын 30-ний өдөр Барбадосын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орж, тус улс нь засаглалын хэлбэрийн хувьд Үндсэн хуульт хаант засаглалаас парламентын бүгд найрамдах улс болж өөрчлөгджээ. Тус улсын төрийн тэргүүн нь Хатан хааны томилдог Амбан захирагч бус Парламентаас сонгогдсон Ерөнхийлөгч байхаар тогтжээ.

Сонгуулийн тогтолцооны хувьд, Албани, Армени, Ботсван, Грек, Доминик, Израил, Ирак, Унгар, Фижи зэрэг 9 улсын парламент нь ерөнхийлөгчөө **2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоогоор** сонгохоор Үндсэн хуульдаа тусгасан байна.

Судалгаанд авагдсан орнуудын Үндсэн хуулийн онцлог зохицуулалтаас дурдвал, Ботсванд Ерөнхийлөгчийн сонгуулийг Үндэсний Ассамблейн сонгуультай хамт явуулдаг; Грек, Израилд Ерөнхийлөгчийг сонгох зорилгоор Парламентын тусгай чуулганыг зарлан хуралдуулдаг; дийлэнх улсад ерөнхийлөгчийг сонгох парламентын хуралдааныг спикер даргалдаг бол Өмнөд Африкт тус улсын Ерөнхий шүүгч нь энэ үүргийг хүлээх ба тэрээр мөн Ерөнхийлөгчийн сонгуулийг товлон зарладаг байна.

Шигтгээ 3. Ботсваны Үндсэн хуулийн 32 дугаар зүйлээс

Үндэсний Ассамблейд нэр дэвшигч нь нэрээ дэвшүүлэхдээ Ерөнхийлөгчид дэмжиж байгаа нэр дэвшигчээ мэдэгдэнэ. Хэрэв тэрээр ийнхүү мэдэгдэхгүй бол Үндэсний Ассамблейд нэр дэвшихэд нь саад болохгүй. Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтыг хариуцсан Комиссар байх ба тэрээр Үндэсний Ассамблейд сонгогдсон нийт гишүүдийн талаас дээш хувийн дэмжлэг авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж зарлана.

Парламентаас ерөнхийлөгчийг сонгоход шаардлагатай саналын босгыг 15 улсын Үндсэн хуулиар зохицуулжээ. Эдгээрээс 12 улсад ерөнхийлөгчийг сонгох **эхний шатны санал хураалтад** парламентын нийт гишүүдийн үнэмлэхүй буюу дийлэнх олонхын саналаар, 3 улсад хуралдаанд, эсхүл санал хураалтад оролцсон гишүүдийн дийлэнх олонхын буюу энгийн олонхын саналаар тус тус сонгогдож байна.

Бусад 5 улсын Үндсэн хуульд энэ талаар тусгаагүй байна.

³⁴⁴ International IDEA. Non-Executive Presidents in Parliamentary Democracies. 2017. Second edition.

³⁴⁵ International IDEA. Non-Executive Presidents in Parliamentary Democracies. 2017. Second edition. P.14.

Хүснэгт 4. Парламентын санал хураалт (эхний шат)-аар Ерөнхийлөгчийг сонгоход шаардлагатай саналын босго

Сонгоход шаардлагатай саналын босго хувь		Улсын тоо	Улсын нэр
Нийт гишүүдийн олонхын	75.0%	1	Армени
	66.7%	5	Этиоп, Эстони, Ирак, Унгар, Грек
	60.0%	1	Албани
	50.0% + 1	5	Ботсван, Доминик, Израил, Латви, Маврикий
Санал хураалтад оролцсон гишүүдийн олонхын	66.7%	1	Барбадос
Хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын	50.0% + 1	2	Өмнөд Африк, Фижи

Шигтгээ 4. “Олонх” нэр томьёоны тайлбар

Энгийн олонх	(Simple Majority)	тоологдсон нийт саналын (санал хураалтад оролцсон гишүүдийн) 50.0% + 1 санал авсныг
Үнэмлэхүй олонх	(Absolute Majority)	тоологдвол зохих нийт саналын (нийт гишүүдийн) 50.0% + 1 санал авсныг
Харьцангуй олонх	(Effective Majority)	хамгийн олон санал авсныг
Дийлэнх олонх	(Special Majority)	“гуравны хоёр” (66.7%), “дөрөвний гурав” (75.0%) г.м. тодорхой заасан санал авсныг

Парламентаас эхний шатны санал хураалтаар улсын ерөнхийлөгчөө сонгож чадаагүй тохиолдолд 2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоо буюу үр дүнд хүрэх хүртлээ санал хураалтыг дахин явуулдаг. Албанийн Үндсэн хуулиар 5 хүртэл буюу хамгийн олон шаттай явуулахаар тогтоосон байна.

Шигтгээ 5. Албанид Үндсэн хуулийн 87 дугаар зүйлээс

Парламент Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтыг 5 хүртэлх шаттай явуулна. Нэг, хоёр, гурав дахь шатны санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч Парламентын нийт гишүүдийн 3/5-аас доошгүйн санал аваагүй бол дөрөв, тав дахь шатны санал хураалтыг явуулна.

Хоёр, гурав, дөрөв дэх шатны санал хураалтад шинэ хүн нэр дэвшиж болно. Дөрөв, тав дахь шатны санал хураалтаар Парламентын нийт гишүүдийн талаас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцно.

Тав дахь шатны санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч шаардлагатай олонхын саналыг аваагүй, эсхүл дөрөв дэх шатны санал хураалт амжилтгүй болсны дараа шинэ хүнийг нэр дэвшигчийг бол Парламент танин

Дараа дараагийн шатны санал хураалт нь эхний шаттай харьцуулахад дараах онцлогтой. Үүнд:

- нэр дэвшигчдийн тоог бууруулах буюу эхний шатны санал хураалтаар хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигч дараагийн шатны санал хураалтад өрсөлдөхөөр үлддэг;

- ерөнхийлөгчийг сонгох шаардлагатай саналын босго нь санал хураалтын эхний шаттай харьцуулахад буурдаг.

Харин парламент нь ерөнхийлөгчийг сонгож чадаагүй тохиолдолд Эстонид санал хураалтын 3 дахь шатны дараа Ерөнхийлөгчийг сонгохын тулд Сонгуулийн коллегийг зарлан хуралдуулахаар, Албанид санал хураалтын 5 дахь шатны, Грект 3 дахь шатны дараа Парламент тарахаар тус тус Үндсэн хуулиудад хуульчилсан байна.

Ерөнхийлөгчийг хууль тогтоох байгууллагаас сонгох үйл явцад хамаарах өөр нэг асуудал бол **Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй субъект** юм. Парламентаас ерөнхийлөгчийг сонгодог 12 улсын Үндсэн хуульд ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй субъектийг тусгажээ. Эдгээрээс 7 улсад парламент, парламентын гишүүд, 5 улсад ерөнхий сайд, сөрөг хүчин, намууд нэр дэвшүүлэх эрхтэй.

Тухайлбал, Этиопт Парламент нь, Арменид Парламентын гишүүдийн 25.0 хувь нь, Унгар, Эстонид – 20.0 хувь нь, Албанид – 14.3 хувь нь, Израилд – 8.3 хувь нь, Өмнөд Африкт – 0.5 хувь нь тус тус Ерөнхийлөгчид нэр дэвшүүлнэ.

Ботсванийн Үндсэн хуулийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх нь сонгуулийн эрх бүхий 1000-аас багагүй иргэн дэмжсэн тохиолдолд хүчинтэй байх шаардлагыг тавьдаг.

Ерөнхий сайдын хувьд, Маврикид Ерөнхий сайд дангаараа, Доминикт Ерөнхий сайд, сөрөг хүчний удирдагч хамтран, Барбадос, Фиждид Ерөнхий сайд, сөрөг хүчний удирдагч тус тусдаа Ерөнхийлөгчид нэр дэвшүүлнэ.

Харин Самоад намуудын, эсхүл засгийн эрхийг барьж байгаа нам нь Ерөнхийлөгч (Төрийн тэргүүн)-д нэр дэвшүүлнэ.

2.4.2.Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар сонгох

Бүх нийтийн сонгууль нь орон даяар, сонгуулийн эрх бүхий иргэд бүх нийтээрээ оролцох боломжийг хангасны үндсэн дээр явуулдаг сонгуулийн хэлбэр юм.

Ард түмнээс сонгож байгаа энэхүү шууд сонгууль нь нэр дэвшигчдийг сонгуулийн кампанит ажил явуулахад хүргэдэг бөгөөд ерөнхийлөгчийг улс төрийн үйл явцад илүү идэвхтэй оролцоход түлхэц болдог байна.³⁴⁶

Сонгуулийн тогтолцооны хувьд, парламентын засаглалтай бөгөөд ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар сонгодог Болгар, Зүүн Тимор, Кабо-Верде, Молдова, Монгол, Португал, Серби, Словени, Финланд, Умард Македон, Хорват, Чех зэрэг 12 улсын Үндсэн хуульд улсын ерөнхийлөгчөө **2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоогоор** сонгохоор тогтоосон байдаг.

Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгоход шаардлагатай саналын босгыг Үндсэн хуулиар зохицуулснаас үзэхэд 2 улсад нийт сонгогчдын, 4 улсад сонгуульд оролцсон нийт сонгогчдын, 3 улсад хүчинтэй саналын, нэг улсад нийт сонгогчдын 40-өөс дээш хувийн олонхын саналаар Ерөнхийлөгчид сонгогдсонд тооцно. Харин 5 улсын Үндсэн хуульд “олонх” гэдгийг дээрхтэй адил тодорхой тусгаагүй байна.

³⁴⁶ International IDEA. Non-Executive Presidents in Parliamentary Democracies. 2017. Second edition. P.14.

Хүснэгт 5. Бүх нийтийн сонгуулиар Ерөнхийлөгчийг сонгоход шаардлагатай саналын босго

Сонгоход шаардлагатай саналын босго	Улсын нэр	Улсын нэр
Нийт сонгогчдын олонхын	3	Болгар, Исланд, Чех
Сонгуульд оролцсон нийт сонгогчдын олонхын	4	Молдова, Монгол , Финланд, Хорват
Хүчинтэй саналын олонхын	3	Зүүн Тимор, Кабо-Верде, Португал
Олонхын	5	Ирланд, Кирибати, Серби, Словак, Словени
Нийт сонгогчдын 40-өөс дээш хувийн олонхын	1	Умард Македон

Дээрх улсуудаас 8 улсын Үндсэн хуульд **Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх субъектийг** зааж өгсөн нь сонгуулийн эрх бүхий иргэд, Парламентад суудал авсан намууд, Парламент болон түүний гишүүд байна.

Чехэд сонгуулийн эрх бүхий 50000 иргэд, Финландад – 20000 иргэд, Умард Македонд – 10000-аас доошгүй иргэд, Португалд – 7500-15000 иргэд, Исландад – 1500-3000 иргэд, Кабо-Вердед – 1000-4000 иргэд Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй.

Чех, Умард Македон болон Финландад сонгуулийн эрх бүхий иргэдээс гадна Парламентын гишүүд Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй байдаг. Тодруулбал, Чехэд депутатуудын 5.0 хувь нь, сенатуудын 12.3 хувь нь, Умард Македонд БНУ-ын Ассамблейн 30-аас доошгүй төлөөлөгч нь, Финландад Парламентад суудалтай намууд нь ийм эрхтэй.

Кирибатид Парламентын гишүүд нэр дэвшүүлэх эрхтэй. Харин Словакт сонгуулийн эрх бүхий 15000-аас доошгүй иргэдийн болон Үндэсний Зөвлөлийн 15-аас доошгүй гишүүдийн өргөдөлд үндэслэн Үндэсний Зөвлөл нь Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхийг эдэлдэг.

2.4.3.Ерөнхийлөгчийг сонгогчдын коллегиос сонгох

Сонгогчдын коллеги бол парламентын болон муж улсын, эсхүл орон нутгийн төлөөллийн байгууллагын гишүүдийн хамтарсан институт юм.

Сонгогчдын коллегийг холбооны, эсхүл засаг захиргааны олон нэгжид хуваагдсан парламентын (бүгд найрамдах) улсад тохиромжтой байж болохыг Ардчилал, сонгуульд тусалцаа үзүүлэх олон улсын хүрээлэн (IDEA)-ийн судалгаанд дурдсан байна.³⁴⁷ Тухайлбал, сонгогчдын коллегиос улсын ерөнхийлөгчөө сонгодог 7 улсаас Балба*, Герман*, Итали, Пакистан*, Энэтхэг* зэрэг 5 улс нь хоёр танхим бүхий парламенттай, харин эдгээрийн 4 улс нь төрийн байгууламжийн хувьд холбооны улсууд байна.

Тодруулбал, Балба*, Итали, Пакистан*, Энэтхэг* зэрэг улсуудад парламентын хоёр танхимын болон муж улсуудын, эсхүл орон нутгийн төлөөллийн байгууллагын гишүүд хамтран Сонгогчдын коллегийг бүрдүүлдэг.

Харин Германд дээрх улсуудын схемээс өөрөөр буюу Парламентын зөвхөн доод танхим болох Бундестагийн нийт гишүүд болон тэдгээртэй тэнцүү тооны муж улс бүрийн ард түмний төлөөллийн байгууллагуудаас хувь тэнцүүлэх зарчмаар сонгогдсон гишүүд Сонгогчдын коллегийг бүрдүүлж байна.

³⁴⁷ International IDEA. Non-Executive Presidents in Parliamentary Democracies. 2017. Second edition. P.14.

Вануатуд нэг танхим бүхий Парламентын гишүүдтэй хамт орон нутгийн захиргааны зөвлөлийн дарга нар, Гүржид Абхаз, Аджарын автономит БНУ-удын төлөөллийн дээд байгууллагуудын гишүүд нэгдэж Сонгуулийн коллегийг бүрдүүлдэг.

Сонгуулийн тогтолцооны хувьд, Итали, Балба*, Гүрж зэрэг улсуудад Сонгогчдын коллеги нь Ерөнхийлөгчийг **2 шатлал бүхий сонгуулийн тогтолцоогоор** сонгохоор Үндсэн хуульдаа тусгасан байна.

Сонгуулийн коллегиос ерөнхийлөгчийг сонгоход шаардлагатай саналын босгыг 5 улсын Үндсэн хуульд зохицуулжээ. Герман, Вануату, Итали зэрэг 3 улсад **эхний шатны санал хураалтаар** Сонгогчдын коллегийн нийт гишүүдийн үнэмлэхүй олонхын саналаар, Гүржид – харьцангуй олонхын саналаар, Балбад – хуралдаанд оролцсон гишүүдийн энгийн олонхын саналаар тус тус Ерөнхийлөгчийг сонгож байна.

Пакистан, Энэтхэгийн Үндсэн хуульд энэ талаар тусгаагүй байна.

Хүснэгт 6. Сонгуулийн коллегиос Ерөнхийлөгчийг сонгоход шаардлагатай саналын босго

Сонгогдоход шаардлагатай саналын босго хувь		Улсын тоо	Улсын нэр
нийт гишүүдийн	66.7%	2	Вануату, Итали
	50.0% + 1	1	Герман*
хамгийн олон санал авсан		1	Гүрж
хуралдаанд оролцсон гишүүдийн	50.0% + 1	1	Балба*

Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй субъектийн хувьд, зөвхөн Гүржийн Үндсэн хуулиа Сонгуулийн коллегийн 30-аас доошгүй гишүүн Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй байна.

Хавсралтууд

Хавсралт 1. Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба Монгол Улсын Их цаазын төслүүдийн (1991.VI.05, X.05, XI.07) харьцуулалт³⁴⁸

Тайлбар: -үг, өгүүлбэр шинээр нэмэгдсэнийг тод хараар (“**bold**”),
-үг, өгүүлбэрийг өөрчлөн найруулсныг доогуур зураасаар (“underline”),
-үг, өгүүлбэр хасагдсаныг дундуур зураасаар (“~~strikethrough~~”),
-зарчмын зөрүүтэй санал орхигдсон, өөрчлөлт орсон зэргийг тодруулав (“highlighting”) тус тус тэмдэглэв.

1-р төсөл	2-р төсөл	3-р төсөл	4-р төсөл	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ³⁴⁹
МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ ³⁵⁰ (Үндсэн хууль)	МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ ³⁵¹ (Үндсэн хууль)	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ³⁵² (Их цааз)	МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ ³⁵³	
УБХ-д өргөн барьсан хувь 1991.04.19	Ард түмнээр хэлэлцүүлсэн хувь 1991.06.05	УБХ-д өргөн барьсан хувь 1991.10.05	УБХ-аас АИХ-д өргөн барьсан хувь 1991.11.07	(Батлагдсан хувь) 1992.01.13
31 дүгээр зүйл	Гучин гуравдугаар зүйл	Гучдугаар зүйл	Гучдугаар зүйл	Гучдугаар зүйл
Монгол улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл мөн.	1.Монгол улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл мөн.	1.Монгол улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл мөн.	1.Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл мөн.	1.Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.
Ерөнхийлөгчөөр 40 нас хүрсэн, сүүлийн таваас хүрсэн, сүүлийн доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол	2.Ерөнхийлөгчөөр 40 нас хүрсэн, сүүлийн таваас хүрсэн, сүүлийн доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, дурван	2.Ерөнхийлөгчөөр 40 нас хүрсэн, сүүлийн таваас хүрсэн, сүүлийн доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол	2.Ерөнхийлөгчөөр 50 нас хүрсэн, сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин уугуул	2.Ерөнхийлөгчөөр 45 нас хүрсэн, сүүлийн таваас хүрсэн, сүүлийн доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол

³⁴⁸ Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба Монгол Улсын Их цаазын төслүүдийн (1991.VI.05, X.05, XI.07) харьцуулалт.

Харьцуулсан судалгаа (СТ-15/206) УБ. 2015.

³⁴⁹ “Ардын эрх” сонин, 1992.01.14, №9 /313/.

³⁵⁰ Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын архив, данс №1-91, 167-190 дэх тал.

³⁵¹ “Ардын эрх” сонин, 1991.06.05, №86 /158/.

³⁵² Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын архив, данс №1-92, 165-199 дэх тал.

³⁵³ Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын архив, данс №1-92, 200-234 дэх тал.

[illegible]

[illegible]

Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож байсан болно.	Хуулийн төслийн 33-р хэсэгт тусгагдсан байна: Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.	7.Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.	7.Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.
32 дугаар зүйл	Гучин тавдугаар зүйл		
Монгол Улсын Ерөнхийлөгч нь Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын газрын гишүүн, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь ул хамаарах бусад албан тушаалыг хавсарч болохгүй.	1.Мөнх-Улсын Ерөнхийлөгч нь Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын газрын гишүүн, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь ул хамаарах бусад албан тушаалыг хавсарч болохгүй.	8.Ерөнхийлөгч нь Улсын Их Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь ул хамаарах бусад албан тушаалыг хавсарч болохгүй.	8.Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь ул хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй.
Хэрэв Ерөнхийлөгч өөр 2.Хэрэв Ерөнхийлөгч өөр Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж, албан тушаал эрхэлж байгаа сонгууль хүлээж байгаа бол тангараг өргөсөн эхлэн үүргээс чөлөөлөгдөнө.	Хэрэв Ерөнхийлөгч өөр 2.Хэрэв Ерөнхийлөгч өөр Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж, албан тушаал эрхэлж байгаа сонгууль хүлээж байгаа бол тангараг өргөсөн эхлэн үүргээс чөлөөлөгдөнө.	Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж, албан тушаал эрхэлж байгаа сонгууль хүлээж байгаа бол тангараг өргөсөн эхлэн үүргээс чөлөөлөгдөнө.	Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж, албан тушаал эрхэлж байгаа сонгууль хүлээж байгаа бол тангараг өргөсөн эхлэн үүргээс чөлөөлөгдөнө.



Хавсралт 2. Парламентын засаглалтай орнуудын Ерөнхийлөгчийн сонгуулийн хэлбэр

* Холбооны улсуудыг тэмдэглэв.

№	Улсын нэр	Парламентын танхимын тоо	Танхимын нэр	Төрийн тэргүүн	Томилогддог /сонгогддог	Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй субъект	Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцох доод босго
1.	Австрали*	2	- Сенат - Төлөөлөгчдийн танхим	Амбан захирагч	Хатан хаан томилно		
2.	Албани	1	Парламент	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно (5 хүртэлх шатлал бүхий)	Парламентын 20-оос доошгүй гишүүдийн бүлэг	3/5-ын олонхын саналаар (нийт гишүүдийн)
4.	Антигуа ба Барбуда	2	- Сенат - Төлөөлөгчдийн танхим	Амбан захирагч	Хатан хаан томилно		
5.	Армени	1	Үндэсний Ассамблей	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно (2 шатлал бүхий)	Парламентын нийт гишүүдийн 1/4-ээс доошгүй нь	3/4-ын олонхын саналаар (нийт гишүүдийн)
6.	Балба*	2	- Үндэсний Ассамблей - Төлөөлөгчдийн танхим	Ерөнхийлөгч	Сонгогчдын коллегийс сонгоно (2 шатлал бүхий)		Олонхын саналаар (хуралдаанд оролцсон гишүүдийн)
7.	Бангладеш	1	Парламент	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно		
8.	Барбадос	2	- Сенат - Ассамблейн танхим	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно (2 шатлал бүхий)	- Ерөнхий сайд - сөрөг хүчний удирдагч	2/3-ын олонхын саналаар (санал хураалтад оролцсон гишүүдийн)
9.	Бахам	2	- Сенат - Ассамблейн танхим	Амбан захирагч	Хатан хаан томилно		
10.	Белиз	2	- Сенат - Төлөөлөгчдийн танхим	Амбан захирагч	Хатан хаан томилно		
11.	Бельги*	2	- Сенат - Төлөөлөгчдийн танхим	Хаан	Угсаа залгамжилсан		

12.	Болгар	1	Үндэсний Ассамблей	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонгоно (2 шатлал бүхий)	Олонхын саналаар (нийт сонгогчдын)
13.	Босни- Херцеговин*	2	- Ардын танхим - Төлөөлөгчдийн танхим	Тэргүүлэгчид	Бүх нийтийн сонгуулиар сонгоно	Олонхын саналаар
14.	Ботсван	1	Үндэсний Ассамблей	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно (2 шатлал бүхий)	Талаас дээш хувийн саналаар (нийт гишүүдийн)
15.	Вануату	1	Парламент	Ерөнхийлөгч	Сонгогчдын коллегийс сонгоно	2/3-ын олонхын саналаар (нийт гишүүдийн)
16.	Герман*	2	- Бундесрат - Бундестаг	Ерөнхийлөгч	Сонгогчдын коллегийс сонгоно	Олонхын саналаар (нийт гишүүдийн)
17.	Грек	1	Парламент	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно (2 шатлал бүхий)	2/3-ын олонхын саналаар (нийт гишүүдийн)
18.	Гренада	2	- Сенат - Төлөөлөгчдийн танхим	Амбан захирагч	Хатан хаан томилно	
19.	Гүрж	1	Парламент	Ерөнхийлөгч	Сонгогчдын коллегийс сонгоно (2 шатлал бүхий)	Хамгийн олон санал авсан нэр дэвшигч
20.	Дани	1	Парламент	Хаан	Угсаа залгамжилсан	
21.	Доминик	1	Ассамблейн танхим	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно (2 шатлал бүхий)	Олонхын саналаар (нийт гишүүдийн)
22.	Зүүн Тимор	1	Үндэсний Парламент	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонгоно (2 шатлал бүхий)	Олонхын саналаар (хүчинтэй саналын)
23.	ИБУИНХУ	2	- Лордуудын танхим - Нийтийн танхим	Хатан хаан	Угсаа залгамжилсан	
24.	Израил	1	Кнессет	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно (2 шатлал бүхий)	Олонхын саналаар (нийт гишүүдийн)
25.	Ирак*	1	Төлөөлөгчдийн зөвлөл	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно (2 шатлал бүхий)	2/3-ын олонхын саналаар (нийт гишүүдийн)
26.	Ирланд	2	- Сенат	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар	Олонхын саналаар

		- Төлөөлөгчдийн танхим	Ерөнхийлөгч	сонгоно	Сонгуулийн эрх бүхий 1500-3000 иргэд	Олонхын саналаар (нийт сонгогчдын)
27.	Исланд	1 Парламент	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонгоно		
28.	Испани	2 - Сенат - Депутатуудын Конгресс	Хаан	Угсаа залгамжилсан		
29.	Итали	2 - Сенат - Төлөөлөгчдийн танхим	Ерөнхийлөгч	Сонгогчдын коллегийс сонгоно (2 шатлал бүхий)		2/3-ын олонхын саналаар (нийт гишүүдийн)
30.	Кабо-Верде	1 Үндэсний Ассамблей	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонгоно (2 шатлал бүхий)	Сонгуулийн эрх бүхий 1000-4000 иргэд	Олонхын саналаар (хүчинтэй саналын)
31.	Камбож	2 - Сенат - Үндэсний Ассамблей	Хаан	Сонгогчдын коллегийс сонгоно		
32.	Канад*	2 - Сенат - Нийтийн танхим	Амбан захирагч	Хатан хаан томилно		
33.	Кирибати	1 Ассамблейн танхим	Ерөнхийлөгч (Beretenti)	Бүх нийтийн сонгуулиар сонгоно (2 шатлал бүхий)	Парламентын гишүүд	Олонхын саналаар
34.	Латви	1 Сейм	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно		51-ээс багагүй олонхын саналаар (нийт 100 төлөөлөгчдийн)
35.	Лесото	2 - Сенат - Үндэсний Ассамблей	Хаан	Сонгогчдын коллегийс сонгоно		
36.	Лихтенштайн	1 Диет	Хаан	Угсаа залгамжилсан		
37.	Люксембург	1 Депутатуудын танхим	Хаан	Угсаа залгамжилсан		
38.	Маврики	1 Үндэсний Ассамблей	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно	Ерөнхий сайд	Олонхын саналаар (нийт гишүүдийн)
39.	Малайз*	2 - Сенат - Төлөөлөгчдийн танхим	Хаан	Сонгогчдын коллегийс сонгоно		
40.	Мальт	1 Төлөөлөгчдийн танхим	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно		

41. Молдова	1	Парламент	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонгоно (2 шатлал бүхий)		Олонхын саналаар (сонгуульд оролцсон нийт сонгогчдын)
42. Монако	1	Үндэсний Зөвлөл	Хаан	Угсаа залгамжилсан		
43. Монгол	1	Улсын Их Хурал	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонгоно (2 шатлал бүхий)		Олонхын саналаар
44. Нидерланд	2	- Сенат - Төлөөлөгчдийн танхим	Хаан	Угсаа залгамжилсан		
45. Норвег	1	Парламент	Хаан	Угсаа залгамжилсан		
46. Өмнөд Африк	2	- Үндэсний зөвлөл - Үндэсний Ассамблей	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно	Парламентын 2 гишүүн	Олонхын саналаар (хуралдаанд оролцсон)
47. Пакистан*	2	- Сенат - Үндэсний Ассамблей	Ерөнхийлөгч	Сонгогчдын коллегийс сонгоно		
48. Папуа-Шинэ Гвиней	1	Үндэсний Парламент	Хаан	Угсаа залгамжилсан		
49. Португал	1	БНУ-ын Ассамблей	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонгоно (2 шатлал бүхий)	Сонгуулийн эрх бүхий 7500-15000 иргэд	Олонхын саналаар (хүчинтэй саналын)
50. Самоа	1	Хууль тогтоох Ассамблей	Төрийн тэргүүн	Парламентаас сонгоно	Намууд	
51. Сан-Марино	1	Ерөнхий Зөвлөл	Капитан Регент	Парламентаас сонгоно		
52. Сент-Винсент ба Гренадин	1	Ассамблейн танхим	Амбан захирагч	Хатан хаан томилно		
53. Сент-Китс ба Невис*	1	Үндэсний Ассамблей	Амбан захирагч	Хатан хаан томилно		
54. Сент-Люсия	2	- Сенат - Ассамблей	Амбан захирагч	Хатан хаан томилно		
55. Серб	1	Үндэсний Ассамблей	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонгоно		Олонхын саналаар
56. Словак	1	Үндэсний Зөвлөл	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонгоно (2 шатлал бүхий)	Парламент	Олонхын саналаар

57.	Словени	2	- Үндэсний Зөвлөл - Үндэсний Ассамблей	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонго	Олонхын саналаар
58.	Соломоны арлууд	1	Үндэсний Парламент	Амбан захирагч	Хатан хаан томилно	
59.	Тайланд	2	- Сенат - Төлөөлөгчдийн танхим	Хаан	Угсаа залгамжилсан	
60.	Тринидад ба Тобаго	2	- Сенат - Төлөөлөгчдийн танхим	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно	
61.	Тувалу	1	Парламент	Амбан захирагч	Хатан хаан томилно	
62.	Унгар	1	Үндэсний Ассамблей	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно (2 шатлал бүхий)	Парламентын гишүүдийн 1/5-ээс доошгүй нь
63.	Фижи	1	Парламент	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно (2 шатлал бүхий)	- Ерөнхий сайд - сөрөг хүчний удирдагч
64.	Финланд	1	Парламент	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонго (2 шатлал бүхий)	- Парламентад суудал авсан намууд - Сонгуулийн эрх бүхий 20000 иргэдийн бүлэг
65.	Умард Македон	1	БНУ-ын Ассамблей	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонго (2 шатлал бүхий)	- Сонгуулийн эрх бүхий 10000-аас доошгүй иргэд - 30-аас доошгүй төлөөлөгч
66.	Хорват	1	Парламент	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонго (2 шатлал бүхий)	Олонхын саналаар (сонгуульд оролцсон нийт сонгогчдын)
67.	Чех	2	- Сенат - Депутатуудын танхим	Ерөнхийлөгч	Бүх нийтийн сонгуулиар сонго (2 шатлал бүхий)	- Сонгуулийн эрх бүхий 50000-аас доошгүй иргэд - 10-аас доошгүй депутат - 10-аас доошгүй сенатор
68.	Швед	1	Парламент	Хаан	Угсаа залгамжилсан	Олонхын саналаар (сонгуульд оролцсон нийт сонгогчдын)

69.	Швейцар*	2	- Төрийн зөвлөл - Үндэсний зөвлөл Төлөөлөгчдийн танхим	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно		
70.	Шинэ Зеланд	1	Төлөөлөгчдийн танхим	Амбан захирагч	Хатан хаан томилно		
71.	Энэтхэг*	2	- Муж улсуудын зөвлөл - Ардын танхим	Ерөнхийлөгч	Сонгогчдын коллегийос сонгоно		
72.	Эстони	1	Рийгикогу	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно	Парламентын гишүүдийн 1/5-ээс доошгүй нь	2/3-ын олонхын саналаар (нийт гишүүдийн)
73.	Этиоп*	2	- Холбооны танхим - Ардын Төлөөлөгчдийн танхим	Ерөнхийлөгч	Парламентаас сонгоно	Парламент	2/3-ын олонхын саналаар (хоёр танхимын нийт гишүүдийн)
74.	Ямайка	2	- Сенат - Төлөөлөгчдийн танхим	Амбан захирагч	Хатан хаан томилно		
75.	Япон	2	- Зөвлөхүүдийн танхим - Төлөөлөгчдийн танхим	Хаан	Угсаа залгамжилсан		

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хавсралт 3. Парламентын засаглалтай орнуудын Ерөнхийлөгчийн сонгуулийн талаарх Үндсэн хуулийн зохицуулалт

№	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1.	Албани Үндсэн хууль нь 1998 онд батлагдаж, хамгийн сүүлд 2016 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>87.1.Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг Парламентын 20-иос доошгүй гишүүдийн бүлэг Парламентад санал болгоно. Нэг гишүүн нэгээс олон хүний нэрийг дэвшүүлэхгүй.</p> <p>87.2.Парламентаас БНУ-ын Ерөнхийлөгчийг нууц санал хураалтаар, хэлэлцүүлэггүйгээр сонгоно. Парламент Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтыг 5 хүртэлх шаттай явуулна.</p> <p>Ерөнхийлөгчийн сонгууль эхэлснээс хойш 7 хоногийн дотор эхний санал хураалтыг явуулна. Бусад санал хураалтыг өмнөх санал хураалт амжилтгүй болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор явуулна. Санал хураалтад оролцох нэр дэвшигч үлдээгүй байсан ч санал хураалтыг дууссан гэж үзнэ. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хоёр, гурав, дөрөв дэх шатны санал хураалтад шинэ хүн нэр дэвшиж болно.</p> <p>87.3.Нэг, хоёр, гурав дахь шатны санал хураалтаар нэг нэр дэвшигчийг Парламентын нийт гишүүдийн 3/5-аас доошгүйн санал авсан бол Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцно. Дөрөв, тав дахь шатны санал хураалтаар Парламентын нийт гишүүдийн талаас дээш хувийн санал авсан нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцно.</p> <p>87.4.Дөрөв дэх шатны санал хураалтаар нэг ч нэр дэвшигч шаардлагатай олонхын саналыг аваагүй бол тав дахь шатны санал хураалтыг явуулна. Тав дахь шатны санал хураалтыг зөвхөн дөрөв дэх шатны санал хураалтаар хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн хооронд явуулна. Хоёроос дээш нэр дэвшигч ижил тооны санал авсан бол санал хураалтад өрсөлдөх нэр дэвшигчийг сугалаагаар тодруулна.</p> <p>Дөрөв дэх шатны санал хураалтын дараа нэр дэвшигч үлдэхгүй бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шинээр нэр дэвшигчид санал хураалтад оролцож болно. Санал хураалтад хоёроос дээш хүнийг нэр дэвшүүлсэн бол гишүүдээс хамгийн олон санал болгосон хоёр нэр дэвшигчийн хооронд санал хураалтыг явуулна.</p> <p>87.5.Тав дахь шатны санал хураалтаар мөн нэг ч нэр дэвшигч шаардлагатай олонхын саналыг аваагүй, эсхүл дөрөв дэх шатны санал хураалт амжилтгүй болсны дараа шинэ хүний нэрийг дэвшүүлээгүй бол Парламент тарна. Парламент ийнхүү тарснаас хойш 45 хоногийн дотор шинэ сонгуулийг явуулна.</p> <p>87.6.Дараагийн Парламентын нийт гишүүдийн олонхын саналаар БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгоно.</p> <p>(Эх цувралж: https://constituteproject.org/constitution/Albania_2016?lang=en)</p>
2.	Армени Үндсэн хууль нь 1995 онд батлагдаж, хамгийн сүүлд 2015 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>125 дугаар зүйл. БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгох журам</p> <p>1.БНУ-ын Ерөнхийлөгчийг Үндэсний Ассамблей сонгоно.</p> <p>2.БНУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг БНУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн дараа, 40-өөс доошгүй хоногийн өмнө явуулна.</p> <p>3.Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн 1/4-ээс доошгүй нь БНУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй.</p> <p>4.Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн 3/4-аас доошгүйн санал авсан нэр дэвшигч БНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Хэрэв БНУ-ын Ерөнхийлөгч сонгогдоогүй бол хоёр дахь шатны сонгуулийг явуулах ба үүнд эхний шатны сонгуульд оролцсон бүх нэр дэвшигчид оролцож болно. Хоёр дахь шатанд Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн 3/5-аас доошгүйн санал авсан нэр дэвшигч БНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Хэрэв БНУ-ын Ерөнхийлөгч сонгогдоогүй бол гурав дахь шатны сонгуулийг явуулах ба үүнд хоёр дахь шатанд хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигч оролцоно. Гурав дахь шатанд Үндэсний Ассамблейн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигч БНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдоно.</p> <p>5.БНУ-ын Ерөнхийлөгч сонгогдоогүй бол 10 хоногийн дотор БНУ-ын Ерөнхийлөгчийн шинэ сонгуулийг явуулна.</p>

		<p>6.Бүгд Найрамдах Армени Улсын Ерөнхийлөгчийг сонгох нарийвчилсан журмыг Үндэсний Ассамблейн дэгийн тухайн хуулиар зохицуулна. (Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Armenia_2015?lang=en)</p>
3.	<p>Балба* Үндсэн хууль нь 2015 онд батлагдаж, хамгийн сүүлд 2016 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>62 дугаар зүйл. Ерөнхийлөгчийн сонгууль 1.Холбооны Парламентын гишүүд болон Муж улсуудын хурлын гишүүдээс бүрдсэн Сонгуулийн коллeги Ерөнхийлөгчийг сонгоно. Үүнийг Холбооны Парламентын гишүүд болон Муж улсуудын хурлын гишүүдийн саналын жингийн зөрүүг харгалзан хуульд заасан журмын дагуу явуулна. 2.Аль ч муж улсад Муж улсуудын хурлын сонгууль явагдаагүй нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үл харгалзан Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулахын тулд Сонгуулийн коллeги байгуулахад саад болохгүй. 3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан Сонгуулийн коллeгийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санал авсан хүн Ерөнхийлөгчөөр сонгогдоно. 4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу нэр дэвшигчдийн хэн ч олонхын санал аваагүй бол хоёр дахь шатны санал хураалтыг хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн хооронд явуулах ба уг саналын хуудасны 50-аас дээш хувийн санал авсан нэр дэвшигч нь Ерөнхийлөгчөөр сонгогдоно. 5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу явуулсан санал хураалтаар хоёр нэр дэвшигчийн хэн ч 50-аас дээш хувийн санал аваагүй бол гурав дахь шатны санал хураалт явуулна. Гурав дахь шатны санал хураалтад оролцсон гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдоно. (Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Nepal_2016?lang=en)</p>
4.	<p>Бангладеш Үндсэн хууль нь 1972 онд батлагдаж, хамгийн сүүлд 2014 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>48 дугаар зүйл. Ерөнхийлөгч 1.Бангладеш Улс нь хууль тогтоомжийн дагуу Парламентын гишүүдээс сонгогдсон Ерөнхийлөгчтэй байна. 4.Дараах тохиолдолд Ерөнхийлөгчөөр сонгогдох боломжгүй: а) 35 нас хүрээгүй бол; б) Парламентын гишүүнээр сонгогдох эрхгүй бол; в) Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгчийг огцруулсан бол. 50 дугаар зүйл. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 1.Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс хойш 5 жилийн хугацаанд: Бүрэн эрхийн хугацаа нь дууссан ч Ерөнхийлөгчийг залгамжлагчийн бүрэн эрх хэрэгжиж эхлэх хүртэл бүрэн эрхээ үргэлжлүүлнэ. 2.Бүрэн эрхийн хугацаа дараалсан эсэхээс үл хамааран хэн ч Ерөнхийлөгчийн албыг хоёроос дээш хугацаагаар хашиж болохгүй. 55 дугаар зүйл. Засгийн газар Засгийн газрын гүйцэтгэх бүх үйл ажиллагааг Ерөнхийлөгчийн нэрийн өмнөөс хийнэ. (Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Bangladesh_2014?lang=en)</p>
5.	<p>Барбадос Үндсэн хууль нь 1966 онд батлагдаж, хамгийн сүүлд 2021 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>Анхны Ерөнхийлөгчийн сонгууль 14.1.2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор дараах албан тушаалтнууд Барбадос Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг өргөн мэдүүлнэ: а) Ерөнхий сайд; б) сөрөг хүчний удирдагч. 14.2.Ерөнхий сайд, сөрөг хүчний удирдагч хоёр Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх болзол хангасан нэр дэвшигчийг хамтран нэр дэвшүүлэх бол энэ тухайгаа Парламентын даргад бичгээр өргөн мэдүүлнэ. Хэрэв Парламентын дарга тухайн нэр дэвшигчийг зөвшөөрч байгаа бол энэ тухай Парламентын хоёр танхимд мэдэгдэнэ. Хамтарсан хуралдаанаар Парламентын дарга нь гишүүдээс нэр дэвшигчийг зохих ёсоор сонгогдсон гэж зарлахад татгалзаж байгаа эсэхийг асуух ба хэрэв аль нэг гишүүд татгалзсан бол тухайн хуралдааныг завсарлуулж байгааг зарлана. 14.3.Хэрэв энэ зүйлийн 2 дахь дэд хэсэгт заасны дагуу аль нэг гишүүн татгалзсан бол Парламентын дарга нэр дэвшигчийг зохих ёсоор сонгогдсон гэж зарлахгүй ба хамтарсан хуралдааныг түр завсарлуулна. 14.4.Завсарлага авсны дараа танхим бүрийн гишүүд нэн даруй тус тусын танхимдаа хуралдах ба танхим тус бүрийн дарга нар энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан асуудлаар санал хураалт явуулна.</p>

		<p>14.5.Танхим тус бүрд санал хураалтын дүнг зарласны дараа нэн даруй хамтарсан хуралдааныг үргэлжлүүлэх ба Сенатын ерөнхийлөгч, Ассамблейн танхимын дарга нар санал хураалтын дүнг зарлана.</p> <p>14.6.Хэрэв нэр дэвшигч нь <u>танхим тус бүрийн санал хураалтад оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүйн санал авсан бол Парламентын дарга нэр дэвшигчийг зохих ёсоор сонгогдсон гэж зарлана.</u></p> <p>14.7.Хэрэв Ерөнхий сайд болон сөрөг хүчний удирдагч 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлсэн бол Парламентын дарга Ерөнхийлөгчийн сонгууль явуулахын тулд Парламентын хоёр танхимд мэдэгдэнэ.</p> <p>14.8.Парламентын дарга Ерөнхийлөгчийг сонгох тухай зохих мэдэгдлийг “Gazette” сонинд нийтлүүлэх ба энэ мэдэгдлийг дор дурдсан хугацаанд нийтлүүлнэ:</p> <p>а) зөвхөн нэг хүнийг нэр дэвшүүлсэн бол 7 хоногийн дотор;</p> <p>б) нэгээс олон хүнийг нэр дэвшүүлсэн бол 14 хоногийн дотор.</p> <p>14.10.Энэ зүйлд заасны дагуу сонгогдсон хүн 2021 оны 11 дүгээр сарын 30-ний өдөр Ерөнхийлөгчийн албан үүрэгтээ очно.</p> <p>(Эх сурвалж: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2021 он, No2) https://web.archive.org/web/20210921212243/https://www.barbadosparliament.com/uploads/bill_resolution/068a734cb4b6fe4dcf0f60438d58a95c.pdf)</p>
6.	Болгар Үндсэн хууль нь 1991 онд батлагдаж, хамгийн сүүлд 2015 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>93.1.Ерөнхийлөгч хуульд заасан журмын дагуу 5 жилийн хугацаатай шууд сонгогдоно.</p> <p>93.2.Сүүлийн 5 жилд эх орондоо амьдарсан, Үндэсний Ассамблейд сонгогдох эрхтэй 40 нас хүрсэн Болгар Улсын уугуул иргэн Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй.</p> <p>93.3.Ерөнхийлөгчийн сонгуулийг нийт сонгогчдын талаас илүү хувь нь оролцсон бол хүчин төгөлдөр гэж тооцох ба <u>сонгогчдын талаас илүү хувийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид сонгогдсонд тооцно.</u></p> <p>93.4.Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэн нь ч олонхын санал аваагүй бол хоёр дахь шатны сонгуулийг 7 хоногийн дотор хамгийн их санал авсан хоёр нэр дэвшигчийн дунд явуулна. Хамгийн их санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид сонгогдсонд тооцно.</p> <p>93.5.Шинэ Ерөнхийлөгчийн сонгуулийг Ерөнхийлөгчийн бүрэн эрх дууссанаас хойш хоёроос гурван сарын хоорондын 30 хоногийн хугацаанд явуулна.</p> <p>93.6.Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар гарсан аливаа маргааныг Үндсэн хуулийн шүүх сонгууль явуулсан өдрөөс хойш нэг сарын дотор шийдвэрлэнэ.</p> <p>(Эх сурвалж: https://www.parliament.bg/en/const)</p>
7.	Ботсван Үндсэн хууль нь 1966 онд батлагдаж, хамгийн сүүлд 2016 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>32 дугаар зүйл. Үндэсний Ассамблей тарсны дараа Ерөнхийлөгчийг сонгох</p> <p>1.Үндэсний Ассамблей тарах бүрд энэ зүйл болон Үндэсний Ассамблейн тухай хуулийн дагуу Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулна.</p> <p>2.Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх хүсэлтийг Ботсван Улсын хуулийн дагуу, эсхүл хуульд заасан өдөр, цагт санал хураалт хариуцсан Комиссар (цаашид “Комиссар”)–т хүргүүлнэ. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх хүсэлт нь Парламентын тухай хуулийн дагуу Үндэсний Ассамблейн сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгүүлсэн 1000-аас багагүй хүн дэмжсэн бол хүчинтэй.</p> <p>3.Энэ тохиолдолд дор дурдсныг баримтална:</p> <p>а) Үндэсний Ассамблейд нэр дэвшигч нь нэр дэвшихдээ (б)-д заасны дагуу Ерөнхийлөгчийн сонгуульд дэмжиж байгаа нэр дэвшигчээ Парламентын тухай хуулийн дагуу мэдэгдэнэ; нэр дэвшигчийн баримт бичигт ийм мэдэгдэл байхгүй нь Үндэсний Ассамблейд нэр дэвшихэд нь саад болохгүй;</p> <p>б) Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Парламентын тухай хуулийн дагуу Үндэсний Ассамблейд нэр дэвшигчийг өөрийнх нь талд мэдэгдэл хийхийг зөвшөөрөөгүй бол Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар ийм мэдэгдэл хийхгүй;</p>

		<p>г) Комиссар нь (а)-д заасны дагуу Үндэсний Ассамблейд сонгогдсон нийт гишүүдийн талаас дээш хувийн дэмжлэг авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж зарлана; хэрэв тийм хүн байхгүй бол Комиссар нэр дэвшигчдийн хэн ч сонгогдоогүйг мэдэгдэнэ.</p> <p>4.Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх хугацаа дуусах хүртэл шаардлага хангасан нэр дэвшигчийг тодруулаагүй бол Үндэсний Ассамблейгаас Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх хугацааг сунгах тухай шийдвэр гаргаж болно.</p> <p>5.Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх хугацаа дууссаны дараа шаардлага хангасан нэгээс дээш нэр дэвшигч хуулийн дагуу нэр дэвшсэн бол, нэр дэвшигчдийн хэн нэгэн нь Үндэсний Ассамблейн сонгуулийн санал хураалт эхлэхээс өмнө нас барсан бол Үндэсний Ассамблейн сонгуулийн санал хураалтыг зогсоож, энэ зүйлд заасны дагуу тойрог бүрд Үндэсний Ассамблейд нэр дэвшигчдийг шинээр нэр дэвшүүлж, Ерөнхийлөгчийн сонгуулийг шинээр явуулна.</p> <p>6.Шинэ Үндэсний Ассамблей нь Үндэсний Ассамблейн даргын тогтоосон өдөр (сонгуулийн дүн гарснаас хойш 14 хоногийн дотор, эсхүл нэр дэвшигч сонгогдоогүй гэж мэдэгдсэн тохиолдолд) хуралдаж, дараах тохиолдолд Үндсэн хуулийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэг болон Парламентын тухай хуулийн дагуу Ерөнхийлөгчийг сонгоно. Ийм сонгуулийг Үндэсний Ассамблейн Тусгайлан сонгогдсон гишүүд (Specially Elected Members of the National Assembly)-ийг сонгохоос өмнө явуулна.</p> <p>а) Үндэсний Ассамблейн сонгуулийн санал хураалт эхлэхээс сонгуулийн дүн гарах хүртэл Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж зарлагдах байсан нэр дэвшигч нь нас барсан бол;</p> <p>б) Комиссар нь энэ зүйлийн (3) (d) дэд хэсгийн дагуу нэр дэвшигчдийн хэн ч сонгогдоогүйг мэдэгдсэн бол.</p> <p>7.Энэ зүйлд заасны дагуу Ерөнхийлөгчид сонгогдсон хүн сонгогдсон өдрөө үүрэгт ажилдаа орно.</p> <p>33 дугаар зүйл. Ерөнхийлөгчөөр сонгогдох болзол</p> <p>1.Дараах болзлыг хангасан аливаа хүн Ерөнхийлөгчөөр сонгогдох боломжтой:</p> <p>а) төрөлх буюу удам угсаагаараа Ботсван Улсын иргэн бол;</p> <p>б) 30 нас хүрсэн бол;</p> <p>в) Үндэсний Ассамблейн гишүүнээр сонгогдох эрхтэй бол.</p> <p>(Эх сурвалж: https://constitutionproject.org/constitution/Botswana_2016?lang=en)</p>
8.	Вануату Үндсэн хууль нь 1980 онд батлагдаж, хамгийн сүүлд 2013 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>34 дүгээр зүйл. Ерөнхийлөгчийг сонгох</p> <p>1.БНУ-ын Ерөнхийлөгчийг Үндсэн хуулийн Нэгдүгээр хавсралтын дагуу Парламент болон орон нутгийн захиргааны зөвлөлийн дарга нараас бүрдсэн Сонгуулийн коллегийн нууц санал хураалтаар сонгоно.</p> <p>2.БНУ-ын Ерөнхийлөгчийн орон гарсан бол орон гарсан өдрөөс хойш 3-н долоо хоногийн дотор, эсхүл Парламент тарснаас хойш шинэ Парламент бүрэлдэж анхны хуралдаанаа хийснээс хойш 3-н долоо хоногийн дотор БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулна.</p> <p>35 дугаар зүйл. Ерөнхийлөгчид тавигдах шаардлага</p> <p>Парламентад сонгогдох эрхтэй Вануату Улсын уугуул иргэн бүр БНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй.</p> <p>36 дугаар зүйл. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа ба Ерөнхийлөгчийг огцруулах</p> <p>1.БНУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байна.</p> <p><u>ҮНДСЭН ХУУЛИЙН ХАВСРАЛТ 1.</u></p> <p>БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль (34 дүгээр зүйл)</p> <p>1.БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссанаас хойш 3 долоо хоногийн дотор явуулна.</p> <p>2.1.Сонгуулийн коллегийн анхдугаар хуралдаанд гишүүдийн 3/4-аас доошгүй нь хүрэлцэн ирсэн бол БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулж болно.</p> <p>2.2.Хэрэв хуралдааны ирц бүрдээгүй бол Сонгуулийн коллегийн 48 цагийн дараа дахин хуралдаж, тус хуралдаанд гишүүдийн 2/3-оос доошгүй нь хүрэлцэн ирсэн бол БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг хуулийн дагуу явуулна.</p>

		<p>2.3. Сонгуулийн коллегийн гишүүдийн 2/3-ын дэмжлэг авсан нэр дэвшигч БНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдоно.</p> <p>(Эх сурвалж: https://constitutionproject.org/constitution/Vanuatu_2013?lang=en)</p>
9.	<p>Герман*</p> <p>Үндсэн хууль нь 1949 онд батлагдаж, хамгийн сүүлд 2014 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>V. Холбооны улсын Ерөнхийлөгч</p> <p>54.1. Холбооны улсын Ерөнхийлөгчийг Холбооны улсын чуулганаар хэлэлцүүлэхгүйгээр сонгоно. Бундестагийн сонгуульд санал өгөх эрх бүхий, 40 нас хүрсэн герман хүн бүр Холбооны улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй.</p> <p>54.2. Холбооны улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байна. Түүнийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.</p> <p>54.3. Холбооны улсын чуулган нь Бундестагийн нийт гишүүд болон тэдгээртэй тэнцүү тооны муж улс бүрийн ард түмний төлөөллийн байгууллагуудаас хувь тэнцүүлэх зарчмаар сонгогдсон гишүүдээс бүрдэнэ.</p> <p>54.4. Холбооны улсын чуулган нь Холбооны улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө, эсхүл бүрэн эрх нь хугацаанаасаа өмнө дуусгавар болсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор чуулна. Хуралдааныг Бундестагийн Ерөнхийлөгч зарлан хуралдуулна.</p> <p>54.5. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсноос хойш 4 дэх хэсгийн 1 дэх өгүүлбэрт заасан хугацааг Бундестагийн анхдугаар хуралдаанаас эхлэн тоолно.</p> <p>54.6. Холбооны улсын чуулганы гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно. Хоёр удаагийн санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч олонхын санал аваагүй бол дараагийн санал хураалтаар хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно.</p> <p>54.7. Нарийвчилсан зохицуулалтыг Холбооны улсын хуулиар тогтооно.</p> <p>(Эх сурвалж: https://www.btg-bestellservice.de/pdf/80201000.pdf)</p>
10.	<p>Грек</p> <p>Үндсэн хууль нь 1975 онд батлагдаж, хамгийн сүүлд 2008 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>1 дүгээр бүлэг. Ерөнхийлөгчийн сонгууль</p> <p>30 дугаар зүйл.</p> <p>1. БНУ-ын Ерөнхийлөгч нь БНУ-ын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулна. Ерөнхийлөгчийг Парламентаас Үндсэн хуулийн 32, 33 дугаар зүйлд заасны дагуу 5 жилийн хугацаатай сонгоно.</p> <p>2. Ерөнхийлөгчийн алба нь бусад алба, ажил, чиг үүрэгтэй үл нийцнэ.</p> <p>3. Ерөнхийлөгч тангараг өргөсөн үеэс Ерөнхийлөгчийн бүрэн эрх эхэлнэ.</p> <p>4. Дайны үед Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг дайн дуустал сунгана.</p> <p>5. Нэг хүнийг Ерөнхийлөгчөөр зөвхөн нэг удаа улиран сонгоно.</p> <p>31 дүгээр зүйл.</p> <p>БНУ-ын Ерөнхийлөгчөөр 5-аас доошгүй жил Грек Улсын иргэн байсан, эцэг, эх нь грек гаралтай, 40 нас хүрсэн, сонгох эрхтэй хүн сонгогдож болно.</p> <p>32 дугаар зүйл.</p> <p>1. Парламентын Регламентад заасны дагуу одоогийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас нэг сарын өмнө Парламентын даргын зарласан тусгай чуулганаар БНУ-ын Ерөнхийлөгчийг Парламентаас сонгоно.</p> <p>БНУ-ын Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт заасны дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүй болсон, мөн Үндсэн хуулийн дагуу огцорсон, нас барсан, албан үүргээсээ чөлөөлөгдсөнөөс хойш, эсхүл өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор шинэ Ерөнхийлөгчийг сонгох Парламентын тусгай чуулганыг зарлан хуралдуулна.</p> <p>2. БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг бүх тохиолдолд бүрэн явуулна.</p> <p>3. БНУ-ын Ерөнхийлөгчөөр Парламентын нийт гишүүдийн 2/3-ын олонхын саналыг авсан хүн сонгогдоно.</p> <p>Хэрэв шаардлагатай олонхын санал аваагүй бол 5 хоногийн дараа дахин санал хураалт явуулна.</p> <p>Хоёр дахь санал хураалтад шаардлагатай олонхын санал аваагүй бол 5 хоногийн дараа дахин санал хураалт явуулна. БНУ-ын Ерөнхийлөгчөөр Парламентын нийт гишүүдийн 3/5-ын олонхын санал авсан хүн сонгогдоно.</p> <p>4. Гурав дахь санал хураалтаар шаардлагатай олонхын санал аваагүй бол санал хураалт явуулснаас хойш 10 хоногийн дотор Парламентыг тарааж, шинэ Парламентын сонгуулийг товлон зарлана.</p> <p>Ийнхүү шинээр сонгогдсон Парламент бүрдмэгц Парламентын нийт</p>

		<p>гишүүдийн 3/5-ын саналаар БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгоно.</p> <p>Шаардлагатай олонхын санал аваагүй бол 5 хоногийн дотор дахин санал хураалт явуулж, Парламентын нийт гишүүдийн үнэмлэхүй олонхын саналыг авсан хүн БНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Шаардлагатай олонх дахин болж чадаагүй бол 5 хоногийн дараа хамгийн олон санал авсан хоёр хүний хооронд дахин санал хураалт явуулах ба харьцангуй олонх болсон хүнийг БНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцно.</p> <p>5.Парламентын завсарлагаар Парламентын тусгай чуулганыг зарлан хуралдуулж БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгоно.</p> <p>Хэрэв Парламент тарсан бол БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг энэ зүйлийн 3, 4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 20 хоногийн дотор шинэ Парламент бүрэлдэх хүртэл хойшлуулна.</p> <p>Тайлбар заалт. Бүрэн эрхийн хугацаа нь дуусахаас өмнө тэтгэвэрт гарсан БНУ-ын Ерөнхийлөгч нь түүнийг огцорсны үр дүнд болох БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших боломжгүй.</p> <p>(Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Greece_2008?lang=en)</p>
11.	Гүрж Үндсэн хууль нь 1995 онд батлагдаж, хамгийн сүүлд 2018 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>50 дугаар зүйл. Гүрж Улсын Ерөнхийлөгчийг сонгох журам (23.03.2018 N2071)</p> <p>1.<u>Гүрж Улсын Ерөнхийлөгчийг Сонгуулийн коллегийн 5 жилийн хугацаатай, хэлэлцүүлэггүйгээр, нээлттэй санал хураалтаар сонгоно.</u> Нэг хүн Гүрж Улсын Ерөнхийлөгчөөр зөвхөн хоёр удаа сонгогдож болно.</p> <p>2.Гүрж Улсын Ерөнхийлөгчөөр сонгуулийн эрх бүхий, 40 нас хүрснээс хойш Гүрж Улсад 15-аас доошгүй жил амьдарсан иргэн сонгогдож болно.</p> <p>3.<u>Сонгуулийн коллечи нь Гүрж Улсын Парламентын нийт гишүүд, Абхазын болон Аджарын автономит БНУ-уудын төлөөллийн дээд байгууллагуудыг багтаасан 300 гишүүнээс бүрдэнэ.</u> Нутгийн өөрөө удирдах ёсны төлөөллийн байгууллагаас Сонгуулийн коллегийн бусад гишүүдийг органик хуулиар тогтоосон квотоор тухайн улс төрийн намаас нэр дэвшүүлнэ. Квотыг газар зүйн хувь тэнцүүлсэн төлөөллийн зарчмын дагуу явуулсан нутгийн өөрөө удирдах ёсны сонгуулийн үр дүнд үндэслэсэн хэмжээгээр тогтооно. Сонгуулийн коллегийн бүрэлдэхүүнийг Гүрж Улсын Сонгуулийн төв хороо батална.</p> <p>4.Гүрж Улсын Ерөнхийлөгчийн сонгууль Парламентын ордонд болно. Сонгуулийн коллегийн 30-аас доошгүй гишүүн Гүржийн Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй. Сонгуулийн коллегийн нэг гишүүн зөвхөн нэг нэр дэвшигч дэвшүүлж болно. Сонгуулийн коллегийн нэг гишүүн зөвхөн нэг нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө. Сонгуулийн коллегийн нийт гишүүдийн 2/3-оос доошгүйн санал авсан нэр дэвшигчийг сонгуулийн эхний шатанд сонгогдсонд тооцно. Хэрэв Гүрж Улсын Ерөнхийлөгч эхний шатанд сонгогдоогүй бол эхний шатанд хамгийн сайн санал авсан 2 нэр дэвшигчийн хооронд хоёр дахь шатны санал хураалт явагдана. <u>Хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг хоёр дахь шатанд сонгогдсонд тооцно.</u> Сонгогчдын коллегийн нийт бүрэлдэхүүний талаас илүү хувь нь оролцсон бол эхний буюу хоёр дахь шатны сонгуулийг хүчин төгөлдөр гэж үзнэ. Хэрэв сонгууль болоогүй, эсхүл Сонгуулийн коллечи Гүрж Улсын Ерөнхийлөгчийг сонгож чадаагүй бол Гүрж Улсын Ерөнхийлөгчийн дахин сонгууль 30 хоногийн дотор явагдана.</p> <p>5.Гүрж Улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь Гүрж Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан хуанлийн жилийн 10 дугаар сард болно...</p> <p>6.Парламентаас Гүрж Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг товлон зарлана. Парламентын дарга дахин сонгуулийг товлон зарлана.</p> <p>7.Гүрж Улсын Ерөнхийлөгчийг сонгох журам, болзлыг органик хуулиар тогтооно.</p> <p>(Эх сурвалж: https://matsne.gov.ge/ru/document/view/30346?publication=36)</p>
12.	Доминик Үндсэн хууль нь 1978 онд батлагдаж, хамгийн	<p>18 дугаар зүйл. Ерөнхийлөгчийг сонгох</p> <p>1.<u>Доминик Улс нь Ассамблейн танхимаас сонгогддог Ерөнхийлөгчтэй байх ба түүний бүрэн эрх 5 жилийн хугацаатай.</u></p> <p>19 дүгээр зүйл. Сонгууль</p> <p>1.Ерөнхийлөгч албан үүргээсээ чөлөөлөгдөх буюу 90 хоногийн дотор Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусах бүрд <u>Ерөнхий сайд</u></p>

	<p>сүүлд 2014 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p><u>Ерөнхийлөгчид сонгогдох эрхтэй нэр дэвшигчийг хамтран дэвшүүлэх талаар сөрөг хүчний удирдагчтай зөвшилцөнө.</u></p> <p>2.Ерөнхий сайд, сөрөг хүчний удирдагч нар хамтран Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн зөвшөөрсний үндсэн дээр хамтарч нэр дэвшүүлэх ба тухайн нэр дэвшигч зөвшөөрсөн талаар Ассамблейн танхимын даргад бичгээр мэдэгдэнэ. Ассамблейн танхимын дарга энэ талаар Ассамблейн танхимд танилцуулах ба уг асуудлыг санал хураалтад оруулахгүйгээр нэр дэвшигчийг зохих ёсоор сонгогдсон гэж мэдэгдэнэ.</p> <p>3.Ерөнхий сайд сөрөг хүчний удирдагчтай хамтран Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх асуудлаар зөвшилцөж чадахгүй бол энэ тухайгаа Ассамблейн танхимын даргад мэдэгдэнэ. Ассамблейн танхимын дарга нь Ассамблейн танхимд танилцуулна.</p> <p>4.Ассамблейн танхимд мэдэгдсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Ерөнхий сайд, эсхүл сөрөг хүчний удирдагч, эсхүл Ассамблейн танхимын 3 гишүүн Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх тухайгаа Ассамблейн танхимын даргад бичгээр мэдэгдэнэ.</p> <p>Энэ хугацаа дууссаны дараа Ассамблейн танхимын эхний хуралдааны төгсгөлд, Ассамблейн танхим өөр асуудал хэлэлцэж эхлэхээс өмнө Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар, тухайн нэр дэвшигч зөвшөөрсөн талаар Ассамблейн танхимд танилцуулна.</p> <p>5.Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчид нь Ассамблейн танхимын даргын хуралдаанд танилцуулсан нэр дэвшигчид байх ба энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу танилцуулсны дараа (эсхүл Үндсэн хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа Давж заалдах шатны шүүхэд хүлээгдэж байгаа бол түүнийг хянан шийдвэрлэсний дараа Ассамблейн танхимын хуралдаанаар аль болох хурдан) Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулна. Ассамблейн танхимын дарга нь тухайн сонгуульд <u>Ассамблейн танхимын нийт гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг зохих ёсоор Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж зарлана.</u> Ерөнхийлөгчийг сонгох санал хураалтыг нууцаар явуулна.</p> <p>5А.Энэ зүйлийн (5)-д заасан нэг нэр дэвшигч нь Ассамблейн танхимын нийт гишүүдийн олонхын саналыг аваагүй бол Ассамблейн танхимын дарга энэ талаар танхимд танилцуулж, шинэ сонгууль явуулна. Шинэ сонгуулийг энэ зүйлийн (4) болон (5) дэд хэсэгт заасны дагуу явуулна.</p> <p>6.Ерөнхийлөгчид нэр дэвшихийг зөвшөөрсөн нэр дэвшигч нь Ассамблейн танхимын даргад өөрөө бичгээр мэдэгдэнэ.</p> <p>(Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Dominica_2014?lang=en)</p>
<p>13.</p>	<p>Зүүн Тимор Үндсэн хууль нь 2002 онд батлагдсан.</p>	<p>75 дугаар зүйл.</p> <p>1.Ерөнхийлөгчид нэр дэвшигч Зүүн Тимор Улсын иргэн нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <ul style="list-style-type: none"> а) уугуул иргэншилтэй байх; б) 35 нас хүрсэн; в) өөрийн чиг үүргийг гүйцэтгэх бүрэн чадвартай байх; г) 5000-аас доошгүй сонгогчдын саналаар нэр дэвшүүлсэн байх. <p>2.БНУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байх ба түүний бүрэн эрх шинэ Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно.</p> <p>3.БНУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг зөвхөн нэг удаа сунгаж болно.</p> <p>76 дугаар зүйл. Сонгууль</p> <p>1.БНУ-ын Ерөнхийлөгчийг бүх нийтийн, чөлөөт, шууд, нүүц, хувийн саналаар сонгоно.</p> <p>2.БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг хоосон саналын хуудсыг эс тооцвол <u>хүчинтэй олонхын саналаар тооцно.</u></p> <p>3.Хэрэв нэр дэвшигчдийн хэн ч талаас дээш санал аваагүй бол хоёр дахь шатны санал хураалтыг эхний санал хураалт явуулснаас хойш 30 дахь өдөр явуулна.</p> <p>4.Хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигч нь нэрээ татаагүй бол хоёр дахь шатны сонгуульд өрсөлдөнө.</p> <p>(Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/East_Timor_2002?lang=en)</p>

<p>14. Израил Үндсэн хууль нь 1958 онд батлагдаж, хамгийн сүүлд 2013 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p style="text-align: center;">Улсын Ерөнхийлөгч</p> <p>3. Сонгууль ба бүрэн эрхийн хугацаа (а) <u>Ерөнхийлөгч нь Кнессетээс 7 жилийн хугацаатай сонгогдоно.</u> (б) Ерөнхийлөгч зөвхөн нэг удаа сонгогдоно.</p> <p>4. Ерөнхийлөгчид нэр дэвших эрх Израил Улсад оршин суудаг Израилийн иргэн бүр Ерөнхийлөгчид нэр дэвших эрхтэй.</p> <p>5. Ерөнхийлөгчийн сонгуулийн тов Ерөнхийлөгчийн сонгуулийг Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн дараа, 90-ээс дээшгүй хоногийн өмнө явуулна. Хэрэв бүрэн эрхийн хугацаа нь дуусахаас өмнө Ерөнхийлөгчийн орон суларсан бол шинэ Ерөнхийлөгчийн сонгуулийг Ерөнхийлөгчийн орон суларсан өдрөөс хойш 45 хоногийн дотор явуулна. Кнессетийн дарга, дэд дарга нартай зөвшилцсөний үндсэн дээр сонгуулийн өдрийг тогтоох ба энэ тухайгаа Кнессетийн нийт гишүүдэд 3-аас доошгүй долоо хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Хэрэв сонгуулийн өдөр нь Кнессет хуралдаангүй бол Кнессетийн дарга нь Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулахын тулд Кнессетийн хуралдааныг зарлан хуралдуулна.</p> <p>6. Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх санал (а) 1. Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх саналыг нэр дэвшигчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн хамт Ерөнхийлөгчийн сонгуулийн өдөр болохоос 14 хоногийн өмнө Кнессетийн даргад бичгээр өгнө. Кнессетийн гишүүн нэгээс олон нэр дэвшигчийг дэмжихгүй. 2. <u>Энэ хэсгийн 3-т заасны дагуу Кнессетийн гишүүнийг нэрсийн жагсаалтаас хассаны улмаас нэр дэвшигчдийг санал болгосон гишүүдийн тоо нь 10-аас бага болж буурснаас бусад тохиолдолд Кнессетийн 10 ба түүнээс дээш гишүүний санал болгосон нэр дэвшигчийг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлнэ.</u> 3. <u>Хэрэв Кнессетийн гишүүн нь нэгээс олон нэр дэвшигчийг санал болгосон бол тухайн гишүүнийг Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийг санал болгосон гишүүдийн нэрсийн жагсаалтаас хасна.</u> <u>Хэрэв гишүүнийг нэрсийн жагсаалтаас хассаны улмаас Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийг санал болгосон гишүүдийн тоо 10-аас бага болж буурсан бол Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг санал болгоогүй Кнессетийн бусад гишүүд нь Ерөнхийлөгчийн сонгууль явуулахаас 8 хоногийн өмнө нэрсийн жагсаалтад орж болно.</u> (б) Кнессетийн дарга нь Ерөнхийлөгчийн сонгуулийн өдөр болохоос 7-оос доошгүй хоногийн өмнө санал болгосон бүх нэр дэвшигчдийн нэр, тэднийг санал болгосон Кнессетийн гишүүдийн нэрсийг Кнессетийн нийт гишүүдэд бичгээр мэдэгдэх ба сонгууль явуулах хуралдааны нээлтэд нэр дэвшигчдийг зарлана.</p> <p>7. Санал хураалт Ерөнхийлөгчийн сонгуулийг нь зөвхөн Ерөнхийлөгчийг сонгох зорилгоор товлогдсон Кнессетийн хуралдаанд нууцаар санал хураана.</p> <p>8. Олонхын саналаар сонгох (а) <u>Ерөнхийлөгчид 2 ба түүнээс дээш хүн нэр дэвшсэн бол Кнессетийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигч нь Ерөнхийлөгчөөр сонгогдоно.</u> Нэр дэвшигчийн хэн ч олонхын санал аваагүй бол хоёр дахь санал хураалтыг явуулна. Эхний санал хураалтад хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигч хоёр дахь санал хураалтад өрсөлдөнө. Хоёр дахь санал хураалтад Кнессетийн гишүүдийн олонхын санал авсан нэг нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Хэрэв 2 нэр дэвшигчийн авсан саналын тоо тэнцсэн бол санал хураалтыг дахин явуулна. (б) Хэрэв Ерөнхийлөгчид нэг хүн нэр дэвшсэн бол санал хураалтыг түүнийг дэмжих, эсхүл дэмжихгүй гэсэн саналын томъёоллоор явуулна. Түүнийг дэмжсэн саналын тоо нь дэмжээгүй саналын тооноос давсан бол түүнийг Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцно. Хэрэв нэр дэвшигчийг дэмжсэн болон дэмжихгүй саналын тоо тэнцсэн бол санал хураалтыг дахин явуулна.</p>
---	--

		<p>(в) Хэрэв Ерөнхийлөгч энэ хэсгийн (б) дэд хэсэгт заасны дагуу сонгогдоогүй бол энэ зүйлийн 5-7 дахь хэсэг ба энэ дэд хэсэгт заасны дагуу сүүлийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дахин санал хураалт явуулах ба нэр дэвших саналаа сонгууль болохоос 7-оос доошгүй хоногийн өмнө ирүүлнэ.</p> <p>(Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Israel_2013?lang=en)</p>
15.	Ирак* Үндсэн хууль нь 2005 онд батлагдсан.	<p>61 дүгээр зүйл. Төлөөлөгчдийн зөвлөл нь дараах асуудлаар бүрэн эрхтэй: 3.БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль.</p> <p>70 дугаар зүйл. 1.Төлөөлөгчдийн зөвлөлийн гишүүдийн 2/3-ын саналаар БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгоно. 2.Нэр дэвшигчдийн хэн ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигч дахин өрсөлдөж, хоёр дахь шатны санал хураалтаар олонхын санал авсан нэг хүнийг Ерөнхийлөгчөөр зарлана. (Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Iraq_2005?lang=en)</p>
16.	Ирланд Үндсэн хууль нь 1937 онд батлагдаж, хамгийн сүүлд 2019 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>Ерөнхийлөгч</p> <p>12 дугаар зүйл. 1.Ерөнхийлөгчийг ард түмний шууд санал хураалтаар сонгоно. 2.Парламентын сонгуульд санал өгөх эрхтэй иргэн бүр Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох эрхтэй. 3.Санал хураалтыг нууцаар, нэг саналыг шилжүүлэх замаар хувь тэнцүүлсэн тогтолцоогоор явуулна. (Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Ireland_2019?lang=en)</p>
17.	Исланд Үндсэн хууль нь 1944 онд батлагдаж, хамгийн сүүлд 2013 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>3 дугаар зүйл. <u>Исланд Улсын Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгоно.</u></p> <p>4 дүгээр зүйл. 35 нас хүрсэн, оршин суух зөвшөөрөл олгохоос бусад тохиолдолд Парламентын сонгуульд оролцох шаардлагыг хангасан аливаа хүн Ерөнхийлөгчид өрсөлдөж болно.</p> <p>5 дугаар зүйл. Ерөнхийлөгчийг Парламентын сонгуульд санал өгөх эрхтэй хүмүүсээс шууд, нууцаар санал хурааж сонгоно. <u>Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг 1500-аас доошгүй, 3000-аас дээшгүй сонгогчдын саналаар дэвшүүлнэ.</u> Хэрэв хэд хэдэн нэр дэвшигч байгаа бол хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр зохих ёсоор сонгогдсон гэж тооцно. Хэрэв нэг нэр дэвшигч байгаа бол санал хураалтгүйгээр Ерөнхийлөгчөөр зохих ёсоор сонгогдоно. Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, сонгохтой холбоотой нарийвчилсан зохицуулалтыг хуулиар зохицуулна. Мөн хуульд улсын нутаг дэвсгэрийн 1/4 бүрд тэнд байгаа сонгогчдын тоотой хувь тэнцүүлсэн нэр дэвшигчид нь оршин суухыг зааж болно. (Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Iceland_2013?lang=en)</p>
18.	Итали Үндсэн хууль нь 1947 онд батлагдаж, хамгийн сүүлд 2020 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>83 дугаар зүйл. <u>Ерөнхийлөгч нь Парламентын хамтарсан хуралдаанаар сонгогдоно.</u> Сонгуульд үндэсний цөөнхийн төлөөллийг хангахын тулд <u>Бүс нутгийн зөвлөлөөс (орон нутгийн парламент) сонгогдсон муж тус бүрээс 3 төлөөллийг оролцуулна. Валле д'Аостагаас зөвхөн 1 төлөөлөл оролцуулна.</u> <u>Ерөнхийлөгчийг гишүүдийн 2/3-ын олонхын, нууц санал хураалтаар сонгоно.</u> Гурав дахь санал хураалтаар дийлэнх олонхын саналыг авсан байна.</p> <p>84 дүгээр зүйл. Ерөнхийлөгчөөр 50 нас хүрсэн, иргэний болон улс төрийн эрхтэй иргэн сонгогдоно. Ерөнхийлөгч албан үүрэгт нь харшлах ажил, албан тушаал эрхэлж болохгүй. Ерөнхийлөгчийн цалин хөлс, эрх ямбыг хуулиар тогтооно.</p> <p>85 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь 7 жилийн хугацаатай сонгогдоно. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө Төлөөлөгчдийн танхим нь шинэ Ерөнхийлөгчийг сонгох Парламентын болон</p>

		<p>Орон нутгийн төлөөлөгчдийн хамтарсан хуралдааныг зарлана. Парламентыг тараах үеэр, эсхүл татан буулгахаас гурван сарын өмнө, шинэ Парламентын анхдугаар хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор Ерөнхийлөгчийн сонгууль явуулахгүй.</p> <p>Энэ тохиолдолд бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг сунгана.</p> <p>(Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Italy_2020?lang=en)</p>
19.	<p>Кабо-Верде</p> <p>Үндсэн хууль нь 1980 онд батлагдаж, хамгийн сүүлд 1992 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>106 дугаар зүйл. Сонгуулийн тойрог</p> <p>БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулиар улсын нутаг дэвсгэр нь сонгуулийн нэг тойрог байна.</p> <p>117 дугаар зүйл. Сонгууль</p> <p>1.БНУ-ын Ерөнхийлөгчийг хуулийн дагуу дотоод болон гадаадад бүртгэлтэй сонгогчид бүх нийтийн, шууд, нууц санал хураалтаар сонгоно.</p> <p>2.БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн зорилгоор гадаадад бүртгэлтэй сонгогч бүр нэг саналтай байх ба эдгээр саналын нийт тоо нь тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа баталгаажуулсан саналын 1/5-ээс хэтрэхгүй байна.</p> <p>3.Гадаадад байгаа сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчдын санал өмнөх хэсэгт заасан хязгаараас хэтэрсэн бол энэ хязгаартай тэнцэх тоонд шилжүүлж, нэр дэвшигч тус бүрийн авсан саналын нийлбэрийг хувь тэнцүүлэн хөрвүүлнэ.</p> <p>4.БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг тусгай хуулиар зохицуулна.</p> <p>118 дугаар зүйл. Сонгогдох эрх</p> <p>1.БНУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Кабо-Верде Улсын уугуул иргэн, нэр дэвшүүлсэн өдөр 35 нас хүрсэн, тус улсын нутаг дэвсгэрт сонгуулийн өдрөөс өмнөх 3 жил байнга оршин суусан байна.</p> <p>119 дүгээр зүйл. Нэр дэвшигчид</p> <p>1.БНУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэхэд 1000-аас багагүй, 4000-аас ихгүй сонгогч санал болгох ба сонгууль болохоос 60-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд өргөн мэдүүлнэ.</p> <p>121 дүгээр зүйл. Сонгуулийн журам</p> <p>1.БНУ-ын Ерөнхийлөгч нь санал хураалтад оролцсон нийт сонгогчдын олонхын санал авсан нэр дэвшигч болох ба хоосон хуудсыг харгалзан үзэхгүй.</p> <p>2.Нэр дэвшигчдийн хэн нь ч олонхын санал аваагүй бол эхний саналаас 2 долоо хоногийн дараа хоёр дахь шатны санал хураалтыг явуулна. Эхний санал хураалтад хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигч хоёр дахь шатны санал хураалтад өрсөлдөнө.</p> <p>(Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Cape_Verde_1992?lang=en)</p>
20.	<p>Кирибати</p> <p>Үндсэн хууль нь 1979 онд батлагдаж, хамгийн сүүлд 2013 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>32 дугаар зүйл. Ерөнхийлөгч (Beretitenti)-ийн сонгууль</p> <p>1.Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, сонгох ажлыг Үндсэн хуулийн энэ хэсэгт ба хуульд заасан журмаар а) Ассамблейн танхимын сонгуулиас хойш болох түүний анхны хуралдааны дараа, аливаа хуулийн төслийг батлахаас өмнө аль болох хурдан;</p> <p>в) энэ явуулна:</p> <p>Үндсэн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасан нөхцөлд.</p> <p>2.Ассамблейн танхимын дарга сонгогдсоныхоо дараа <u>Ассамблейн танхимын гишүүдээс 3-аас доошгүй, 4-өөс ихгүй нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх</u> ба өөр хэн ч нэр дэвшигч байж болохгүй.</p> <p>3.Ассамблейн танхимын сонгуульд санал өгөх эрхтэй хүн бүр Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгөх эрхтэй.</p> <p>4.Энэ хэсэгт заасны дагуу Ерөнхийлөгчөөр сонгогдсон хүн нь сонгогдсон өдрөө албан үүрэгтээ орно.</p> <p>(Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Kiribati_2013?lang=en)</p>
21.	<p>Латви</p> <p>Үндсэн хууль нь 1991 онд батлагдаж, хамгийн сүүлд 2016</p>	<p>35.<u>Сеймээс Ерөнхийлөгчийг 4 жилийн хугацаатай сонгоно.</u></p> <p>36.<u>Ерөнхийлөгч нь Сеймийн төлөөлөгчдийн 51-ээс багагүй олонхын саналаар, нууц санал хураалтаар сонгогдоно.</u></p> <p>37.Ерөнхийлөгчөөр Латви Улсын бүрэн эрхт 40 нас хүрсэн иргэн сонгогдоно. Ерөнхийлөгчөөр давхар иргэншилтэй хүнийг сонгохгүй.</p> <p>39.Нэг хүн Ерөнхийлөгчийн албан үүргийг дараалан 8-аас дээш жил хашиж үл болно.</p>

	онд нэмэлт, өөрчлөлт орсон.	(Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Latvia_2016?lang=en)
22.	Маврики Үндсэн хууль нь 1968 онд батлагдаж, хамгийн сүүлд 2016 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	28 дугаар зүйл. Ерөнхийлөгч 2.а. <u>Ерөнхийлөгч нь:</u> i) <u>Ерөнхий сайдын санал болгосноор Үндэсний Ассамблейгаас сонгогдох ба Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн олонхын саналаар дэмжигдсэн байна;</u> ii) энэ зүйл болон 30 дугаар зүйлд заасны дагуу Ерөнхийлөгчийн бүрэн эрх 5 жил байх ба дахин сонгогдох эрхтэй. б. (а)-д заасан санал нь Үндэсний Ассамблейгаар хэлэлцэгдэхгүй. 3. Сонгуулийн өмнө 40 нас хүрсэн, Маврики Улсад 5-аас доошгүй жил оршин суусан Маврики Улсын иргэнийг Ерөнхийлөгчөөр сонгоно. (Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Mauritius_2016?lang=en)
23.	Мальт Үндсэн хууль нь 1964 онд батлагдаж, хамгийн сүүлд 2016 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	48.1. Мальт Улс нь Төлөөлөгчдийн танхимын тогтоолоор томилогдсон Ерөнхийлөгчтэй байна. 48.2. Дараах тохиолдолд Ерөнхийлөгчөөр томилогдохгүй: а) Мальт Улсын иргэн биш бол; б) Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон бусад шүүгчээр ажиллаж байгаа, эсхүл ажиллаж байсан бол; в) Үндсэн хуулийн 109, 118, 120 дугаар зүйлд заасны дагуу төрийн аливаа албан тушаалд томилогдох, эсхүл ажиллах эрхгүй бол. (Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Malta_2016?lang=en)
24.	Молдова Үндсэн хууль нь 1964 онд батлагдаж, хамгийн сүүлд 2016 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	78 дугаар зүйл. Ерөнхийлөгчийн сонгууль 1. Бүгд Найрамдах Молдова Улс (БНМУ)-ын <u>Ерөнхийлөгчийг чөлөөт, бүх нийтийн, тэгш, шууд, нууц санал хураалтаар сонгоно.</u> 2. Сонгуульд оролцох эрх бүхий 40-өөс дээш настай, 10-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, төрийн албан ёсны хэлээр ярьдаг БНМУ-ын Молдова Улсын иргэн бүр БНМУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших эрхтэй. 3. <u>Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон нийт сонгогчдын олонхын санал авсан нэр дэвшигч шинэ Ерөнхийлөгчөөр сонгогдоно.</u> 4. Хэрэв эхний шатны санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч дээр дурдсан олонхын санал аваагүй бол уг санал хураалтаас хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчид тэдэнд өгсөн саналын тооны дарааллаар хоёр дахь шатны санал хураалтад өрсөлдөнө. Нэр дэвшигчийг дэмжсэн саналын тоо нь дэмжээгүй саналын тооноос илүү байх бол, хоёр дахь шатны санал хураалтад илүү санал авсан нэр дэвшигчийг шинэ Ерөнхийлөгчөөр зарлана. 6. БНМУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн журмыг органик хуулиар тогтооно. [Үндсэн хуулийн шүүхийн 2016.03.04-ний өдрийн 7 дугаар шийдвэрийг үндэслэн Үндсэн хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсгийн 1, 3, 4 дэх заалтуудыг сэргээсэн.] [Үндсэн хуулийн 78 дугаар зүйлд 2000.07.05-ны өдрийн №1115-XIV хуулиар өөрчлөлт оруулсан.] 79 дүгээр зүйл. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг батламжлах, тангараг өргөх 1. Үндсэн хуулийн шүүх нь БНМУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнг баталгаажуулна. 80 дугаар зүйл. Бүрэн эрхийн хугацаа 1. БНМУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ба энэ хугацаа тангараг өргөсөн өдрөөс эхэлнэ. 2. БНМУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрх дараагийн Ерөнхийлөгч нь тангараг өргөх хүртэл үргэлжилнэ. 3. БНМУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг дайны болон гамшгийн үед органик хуулиар сунгаж болно. 4. БНМУ-ын Ерөнхийлөгчөөр хоёр удаа дараалан үүрэг гүйцэтгэсэн Ерөнхийлөгчийг дахин сонгохгүй.

		<p>[Үндсэн хуулийн 78 дугаар зүйлд 2000.07.05-ны өдрийн №1115-XIV хуулиар нэмэлт оруулсан.]</p> <p>(Эх сурвалж: https://www.constcourt.md/public/files/file/Actele%20Curtii/acte_en/MDA_Constitution_EN.pdf)</p>
25.	Монгол	<p>Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгч</p> <p>Гучдугаар зүйл.</p> <p>1.Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.</p> <p>2.Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.</p> <p>/Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан./</p> <p>Гучин нэгдүгээр зүйл.</p> <p>1.Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна.</p> <p>2.Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ.</p> <p>3.Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргана.</p> <p>4.Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.</p> <p>5.Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхын санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтаар сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.</p> <p>6.Хэрэв хоёр дахь санал хураалтаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхын санал аваагүй бол дахин сонгууль явуулна.</p> <p>7. /Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хүчингүй болсонд тооцсон./</p> <p>8.Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө.</p> <p>Гучин хоёрдугаар зүйл.</p> <p>1.Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхэлж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно.</p>
26.	Өмнөд Африк	<p>86 дугаар зүйл. Ерөнхийлөгчийн сонгууль</p> <p>1.Сонгуулийн дараа анхны хуралдаанаараа, мөн сул оронг нөхөх үед <u>Үндэсний Ассамблей гишүүдээсээ эмэгтэй, эсхүл эрэгтэй хүнийг Ерөнхийлөгчөөр сонгоно.</u></p> <p>2.Ерөнхий шүүгч нь Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулах хуралдааныг даргална, эсхүл өөр шүүгчийг томилно. Ерөнхийлөгчийг сонгоход 3 дугаар хавсралтын А хэсэгт заасан журмыг мөрдөнө.</p> <p>[хадмал гарчиг. (2) 2001 оны 34 дүгээр хуулийн 6 дугаар хэсгийг сольсон.]</p> <p>3.Ерөнхийлөгчийн сул оронг нөхөх сонгуулийг Ерөнхий шүүгчийн тогтоосон цаг, өдөр бөгөөд сул орон гарсан өдрөөс хойш 30-аас багагүй хоногийн дотор явуулна.</p> <p>[хадмал гарчиг. (3) 2001 оны 34 дүгээр хуулийн 6 дугаар хэсгийг сольсон.]</p> <p><u>ҮНДСЭН ХУУЛИЙН ХАВСРАЛТ 3. СОНГУУЛИЙН ЖУРАМ</u></p> <p>А хэсэг - Үндсэн хуулийн албан тушаалтны сонгуулийн журам</p> <p>Албан ёсны шаардлага</p> <p>3. (1) Өргөдлийг 9 дүгээр зүйлд заасан журмын дагуу гаргана.</p> <p>(2) Өргөдөл гаргах маягт дээр гарын үсэг зурсан байна:</p> <p>а.<u>Ерөнхийлөгч</u>, Парламентын дарга, дэд даргыг сонгох бол <u>Үндэсний</u></p>

		<p><u>Ассамблейн хоёр гишүүний саналаар:</u></p> <p>(3) Нэр дэвшсэн хүн нэр дэвшүүлэх маягт, эсхүл бичгээр баталгаажуулсан бусад маягтад гарын үсэг зурж, нэр дэвшүүлэхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн байна.</p> <p>Нэр дэвшигчдийн нэрсийг зарлах</p> <p>4.Энэхүү цагийн хуваарийн дагуу явуулах хуралдаанаар хуралдаан даргалагч нь нэр дэвшсэн хүмүүсийн нэрийг зарлах боловч мэтгэлцэхийг зөвшөөрөхгүй.</p> <p>Нэг нэр дэвшигч</p> <p>5.Зөвхөн нэг хүн нэр дэвшсэн бол хуралдаан даргалагч тухайн нэр дэвшигчийг сонгогдсон гэж зарлана.</p> <p>Сонгуулийн журам</p> <p>6.Нэгээс олон хүн нэр дэвшсэн бол –</p> <p>а.хуралдаан дээр нууц санал хураалтыг явуулна;</p> <p>б.хуралдаанд оролцсон гишүүн бүр ... нэг санал өгнө; болон</p> <p>в.олонхын санал авсан нэр дэвшигчийг хуралдаан даргалагч сонгогдсон гэж зарлана.</p> <p>(Эх сурвалж: https://www.gov.za/documents/constitution/constitution-republic-south-africa-1996-1)</p>
27.	Пакистан* Үндсэн хууль нь 1973 онд батлагдаж, хамгийн сүүлд 2018 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>41.2.Хамгийн багадаа 45 настайдаа лалын шашинтан болоогүй, Үндэсний Ассамблейн гишүүнээр сонгогдох эрхгүй хүн Ерөнхийлөгчөөр сонгогдохгүй.</p> <p>41.3.Ерөнхийлөгчийг Хоёрдугаар Хавсралтад заасны дагуу дараах бүрэлдэхүүнтэй Сонгуулийн коллегийн гишүүд сонгоно:</p> <p>-хоёр танхимын гишүүд;</p> <p>-орон нутгийн Ассамблейн гишүүд.</p> <p>41.4.Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 60 хоногийн өмнө, 30-аас доошгүй хоногийн дараа Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулна.</p> <p>Хэрэв Үндэсний Ассамблей тарсны улмаас дээрх хугацаанд сонгууль явуулах боломжгүй бол Үндэсний Ассамблейн сонгуулийг явуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулна.</p> <p>41.5.Ерөнхийлөгчийн сул оронг нөхөх сонгуулийг тухайн орон сул болсон өдрөөс хойш 30-аас доошгүй хоногийн дотор явуулна.</p> <p>Хэрэв Үндэсний Ассамблейн тарсны улмаас дээрх хугацаанд сонгууль явуулах боломжгүй бол Үндэсний Ассамблейн сонгуулийг явуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулна.</p> <p>(Эх сурвалж: https://na.gov.pk/uploads/documents/1333523681_951.pdf)</p>
28.	Португал Үндсэн хууль нь 1991 онд батлагдаж, хамгийн сүүлд 2015 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>121 дүгээр зүйл. Сонгууль</p> <p>1.БНУ-ын Ерөнхийлөгчийг Португалын нутаг дэвсгэр дээр сонгогчдын жагсаалтад бүртгүүлсэн бүх Португал Улсын иргэд, мөн дараах хэсэгт заасны дагуу гадаадад амьдарч байгаа Португал Улсын бүх иргэдийн нийтээр, шууд, нууцаар санал хураалтаар сонгоно.</p> <p>3.Португал Улсын нутаг дэвсгэрт санал өгөх эрхийг биечлэн хэрэгжүүлнэ.</p> <p>122 дугаар зүйл. Сонгогдох эрх</p> <p>Санал өгөхөөр бүртгүүлсэн, 35 нас хүрсэн португал гаралтай иргэд БНУ-ын Ерөнхийлөгчид сонгогдоно.</p> <p>124 дүгээр зүйл. Нэр дэвшүүлэх</p> <p>1.БНУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэлтэй 7500-аас доошгүй, 15000-аас илүүгүй иргэд нэр дэвшүүлнэ.</p> <p>2.Сонгууль болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө БНУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийг Үндсэн хуулийн шүүхэд хүргүүлнэ.</p> <p>3.Нэр дэвшигч нас барсан, эсхүл БНУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болсон зэрэг нөхцөл байдал үүссэн бол сонгуулийн ажиллагааг хуульд заасан нөхцөлийн дагуу сэргээнэ.</p> <p>126 дугаар зүйл. Сонгуулийн тогтолцоо</p> <p>1.Хүчинтэй саналын талаас илүү хувийг авсан нэр дэвшигч БНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Хоосон саналын хуудсыг зохих журмын дагуу санал өгсөнд тооцохгүй.</p> <p>2.Нэр дэвшигчийн хэн нь ч ийм хэмжээний санал аваагүй бол анхны санал хураалт явуулсан өдрөөс хойш 21 хоногийн дотор дахин санал хураалт явуулна.</p>

		<p>3.Эхний санал хураалтаар олонхын санал авсан, нэрээ татаагүй хоёр нэр дэвшигчийг хоёр дахь шатны санал хураалтад оруулна.</p> <p>(Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Portugal_2005?lang=en)</p>
29.	<p>Самоа</p> <p>Үндсэн хууль нь 1991 онд батлагдаж, хамгийн сүүлд 2015 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>18 дугаар зүйл. Төрийн тэргүүнийг сонгох (Election of Head of State)</p> <p>1.Төрийн тэргүүн нь намуудын, эсхүл засгийн эрхийг барьж байгаа намын санал болгосноор Хууль тогтоох Ассамблейгаас томилогдоно (shall be appointed).</p> <p>2.Дараах хүн төрийн тэргүүний албанд тэнцэхгүй:</p> <p>(а) Парламентын гишүүнээр сонгогдох эрхгүй бол;</p> <p>(б) Хууль тогтоох Ассамблейн тогтоолд заасан бусад ур чадвар эзэмшээгүй бол;</p> <p>(в) энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмнө нь Төрийн тэргүүний албанаас чөлөөлсөн бол.</p> <p>4.Төрийн тэргүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 60 хоногийн өмнө, эсхүл Төрийн тэргүүний сул орон гарсан бол аль болох богино хугацаанд намууд, эсхүл засгийн эрхийг барьж байгаа нам зөвхөн нэг хүний нэрийг Төрийн тэргүүнээр томилохыг зөвлөж Хууль тогтоох Ассамблейн даргад бичгээр мэдэгдэнэ.</p> <p>5.Хууль тогтоох Ассамблейн дарга мэдэгдлийг хүлээн авсны дараа аль болох хурдан дараах арга хэмжээг авна:</p> <p>(а) Хууль тогтоох Ассамблей хуралдаж байгаа бол Төрийн тэргүүнийг томилох тухай мэдэгдлийг Хууль тогтоох Ассамблейд хүргүүлнэ; эсхүл</p> <p>(б) Хууль тогтоох Ассамблей хуралдаагүй бол Төрийн тэргүүнийг томилох Хууль тогтоох Ассамблейн хуралдааныг зарлана хуралдуулна.</p> <p>6.Хууль тогтоох Ассамблейн дарга Төрийн тэргүүнийг томилох тухай тогтоол гаргаж, гарын үсэг зурна.</p> <p>Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Samoa_2017?lang=en)</p>
30.	<p>Серб</p> <p>Үндсэн хууль нь 2006 онд батлагдсан.</p>	<p>114 дүгээр зүйл. Сонгууль</p> <p><u>БНУ-ын Ерөнхийлөгчийг хуульд заасны дагуу шүүд, нүүцаар санал хурааж сонгоно.</u></p> <p>БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг БНУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 90 хоногийн өмнө Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгч товлон зарлах ба уг сонгуулийг 60 хоногийн дотор явуулж дуусгана.</p> <p>(Эх сурвалж: https://www.srbija.gov.rs/tekst/en/130144/constitution-of-serbia.php)</p>
31.	<p>Словак</p> <p>Үндсэн хууль нь 1992 онд батлагдаж, хамгийн сүүлд 2017 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>101.1.Бүгд Найрамдах Словак Улс (БНСУ)-ын тэргүүн нь Ерөнхийлөгч байна. Ерөнхийлөгч нь БНСУ-ыг дотоод болон гадаадад төлөөлж, өөрийн шийдвэрээр Үндсэн хуулийн байгууллагуудын байнгын үйл ажиллагааг хангана. Ерөнхийлөгч нь өөрийн ухамсар, итгэл үнэмшлийнхээ дагуу үүргээ гүйцэтгэх ба тушаалд захирагдахгүй.</p> <p>101.2.БНСУ-ын иргэд Ерөнхийлөгчөө 5 жилийн хугацаатайгаар шүүд, нүүц санал хураалтаар сонгоно. БНСУ-ын Үндэсний Зөвлөлд санал өгөх эрхтэй иргэд Ерөнхийлөгчид санал өгөх эрхтэй.</p> <p>101.3.Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг Үндэсний Зөвлөлийн 15-аас доошгүй гишүүн, эсхүл 15000-аас доошгүй сонгуулийн эрх бүхий иргэдийн гарын үсэгтэй өргөдлийн үндсэн дээр БНСУ-ын Үндэсний Зөвлөлөөс санал болгоно. Саналуудыг сонгууль зарласан өдрөөс хойш 21 хоногийн дотор БНСУ-ын Үндэсний Зөвлөлийн даргад өргөн мэдүүлнэ.</p> <p>101.4.Нэр дэвшигч нь сонгогчдын олонхын санал авсан бол Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч шаардлагатай олонхын саналыг аваагүй бол санал хураалт явуулснаас хойш 14 хоногийн дотор хоёр дахь шатны санал хураалт явуулна.</p> <p>Хамгийн олон хүчинтэй санал авсан хоёр нэр дэвшигч хоёр дахь шатны санал хураалтад оролцоно. Хоёр дахь шатны санал хураалтаар сонгогчдын хүчинтэй хамгийн олон санал авсан нэр дэвшигч нь Ерөнхийлөгчөөр сонгогдоно.</p> <p>101.5.Эхний шатны санал хураалтаар хамгийн олон хүчинтэй санал авсан хоёр нэр дэвшигчдийн аль нэг нь хоёр дахь шатны санал хураалтаас өмнө Ерөнхийлөгчийн сонгуулиас нэрээ татсан, эсхүл нэр дэвшигчийн эрхээсээ татгалзсан бол хамгийн олон хүчинтэй санал авсан дараагийн нэр дэвшигч хоёр дахь шатны санал хураалтад оролцоно. Хоёр дахь шатны санал</p>

		хураалтад хоёр нэр дэвшигч гараагүй бол хоёр дахь шатны санал хураалтыг явуулахгүй. БНСУ-ын Үндэсний Зөвлөлийн Ерөнхийлөгч сонгуулийн шинээр товлон зарлах ба сонгууль зарласан өдрөөс хойш 60 хоногийн дотор явуулна. 101.6.Ерөнхийлөгчид нэг нэр дэвшигч байгаа бол сонгууль явуулах ба нэр дэвшигч нь сонгуульд оролцсон сонгогчдын олонхын санал авсан бол Ерөнхийлөгчөөр сонгогдоно... (Эх сурвалж: https://www.prezident.sk/upload-files/46422.pdf)
32.	Словени Үндсэн хууль нь 1991 онд батлагдаж, хамгийн сүүлд 2016 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	103 дугаар зүйл. БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгох <u>БНУ-ын Ерөнхийлөгчийг бүх нийтийн, шууд, нууц санал хураалтаар сонгоно.</u> Сонгогчдын олонхын санал авсан нэр дэвшигч БНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдоно. БНУ-ын Ерөнхийлөгч нь 5 жилийн хугацаатай сонгогдох ба дээд тал нь хоёр удаа дараалан сонгогдож болно. БНУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дайны болон онц байдлын үед дуусгавар болсон бол уг нөхцөл байдал дууссанаас хойш зургаан сарын дараа Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусна. БНУ-ын Ерөнхийлөгчөөр зөвхөн Словени Улсын иргэн сонгогдоно. Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгч БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг товлон зарлана. БНУ-ын Ерөнхийлөгчийг одоогийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 15-аас доошгүй хоногийн өмнө сонгоно. (Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Slovenia_2016?lang=en)
33.	Тринидад ба Тобаго Үндсэн хууль нь 1976 онд батлагдаж, хамгийн сүүлд 2007 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	28 дугаар зүйл. Сонгуулийн коллеги <u>1.Сонгуулийн коллеги нь Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын нийт гишүүдээс бүрдэнэ.</u> 2.Парламентын дарга Сонгуулийн коллегийг зарлан хуралдуулна. 3.Парламентын дарга Сонгуулийн коллегийн хуралдааныг даргалах ба хуралдаанд эхний саналыг гаргах эрхтэй. 4.Энэ бүлэгт заасны дагуу Сонгуулийн коллеги нь хуралдааны дэгээ тогтоож болох ба хуралдаанаа хойшлуулах, эсхүл завсарлуулах, мөн сонгууль явуулахад гарч болзошгүй хүндрэлийг арилгахад шаардлагатай бусад зохицуулалтыг энэ бүлгийн дагуу тогтоож болно. <u>5.Сонгуулийн коллегийн ирцийг Парламентын дарга, 10 сенатор болон Төлөөлөгчдийн танхимын 12 гишүүн бүрдүүлнэ.</u> 29 дүгээр зүйл. Сонгууль явуулах журам Ерөнхийлөгчийг Сонгуулийн коллеги нууц санал хураалтаар сонгоно. (Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Trinidad_and_Tobago_2007?lang=en)
34.	Унгар Үндсэн хууль нь 2011 онд батлагдаж, хамгийн сүүлд 2016 онд нэмэлт, өөрчлөлт орсон.	Үндэсний Ассамблей 1 дүгээр зүйл. 2.Үндэсний Ассамблейн бүрэн эрх: д) БНУ-ын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч болон гишүүд, Дээд шүүх (Curia)-ийн Ерөнхийлөгч, Үндэсний шүүхийн захиргааны Ерөнхийлөгч, Ерөнхий прокурор, Үндсэн эрхийн асуудал хариуцсан Комиссар, Ерөнхий аудиторыг сонгох; БНУ-ын Ерөнхийлөгч 10 дугаар зүйл. <u>1.Ерөнхийлөгчийг Үндэсний Ассамблейгаас 5 жилийн хугацаагаар сонгоно.</u> 2.Унгар Улсын 35 нас хүрсэн иргэн Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй. 3.Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно. 11 дүгээр зүйл. 1.Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн дараа, 60-аас дээшгүй хоногийн өмнө, эсхүл түүний бүрэн эрх нь хугацаанаасаа өмнө дуусгавар болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулна. Үндэсний Ассамблейн дарга Ерөнхийлөгчийн сонгуулийг товлон зарлана. Үндэсний Ассамблей нь Ерөнхийлөгчийг нууц санал хураалтаар сонгоно. 2.Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө нэр дэвшүүлэх ажиллагаа явагдана. <u>Үндэсний Ассамблейн гишүүдийн 1/5-ээс доошгүй нь бичгээр санал ирүүлсэн бол нэр дэвшүүлэх ажиллагааг хүчин төгөлдөр гэж үзнэ.</u>

		<p>Нэр дэвшигчдийг санал хураахаас өмнө Үндэсний Ассамблейн даргад өргөн мэдүүлнэ. Үндэсний Ассамблейн гишүүн бүр нэг нэр дэвшигчийг санал болгож болно. Хэрэв Үндэсний Ассамблейн гишүүн нэгээс илүү нэр дэвшигчийг санал болгосон бол тухайн гишүүний бүх саналыг хүчингүйд тооцно.</p> <p><u>3.Эхний шатны санал хураалтаар Үндэсний Ассамблейн гишүүдийн 2/3-ын санал авсан нэр дэвшигч нь Ерөнхийлөгчөөр сонгогдоно.</u></p> <p>4.Хэрэв эхний шатны санал хураалтаар сонгуулийн үр дүн шийдвэрлэгдэхгүй бол хоёр дахь шатны санал хураалтыг явуулна. Эхний шатанд хамгийн олон санал авсан эхний 2 нэр дэвшигч хоёр дахь шатны санал хураалтад өрсөлдөнө. Хэрэв эхний шатанд нэр дэвшигчдийн саналын тоо тэнцсэн бол хамгийн олон санал авсан бүх нэр дэвшигчид хоёр дахь шатны санал хураалтад оролцож болно. Хоёр дахь шатны санал хураалтад сонгогчдын тооноос үл хамааран гишүүдийн хүчинтэй саналын олонхыг авсан нэр дэвшигч нь Ерөнхийлөгчөөр сонгогдоно.</p> <p>Хэрэв хоёр дахь шатны санал хураалтаар сонгуулийн үр дүн шийдвэрлэгдэхгүй бол дахин нэр дэвшүүлж шинэ сонгууль явуулна.</p> <p>5.Санал хураалтыг дараалан 2 хоногийн дотор явуулна.</p> <p>6.Шинээр сонгогдсон Ерөнхийлөгч нь өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан, эсхүл сонгуулийн үр дүнг зарласнаас хойш 8 дахь хоногт түүний бүрэн эрх дуусгавар болсны дараа үүрэгт ажилдаа орно. Үүрэгт ажилдаа орохоосоо өмнө Үндэсний Ассамблейд тангараг өргөнө.</p> <p>(Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Hungary_2016?lang=en)</p>
35.	<p>Фижи</p> <p>Үндсэн хууль нь 2013 онд батлагдсан.</p>	<p>84 дүгээр зүйл. Ерөнхийлөгчийн томилгоо (appointment)</p> <p>(1) Ерөнхийлөгчийг энэ хэсэгт заасны дагуу Парламентаас томилно.</p> <p>(2) Ерөнхийлөгчийн сул орон гарсан бол <u>Ерөнхий сайд, сөрөг хүчний удирдагч тус бүр нэг хүний нэрийг дэвшүүлж</u> Парламентын даргад өргөн мэдүүлэх ба тэрхүү хоёр нэр дэвшигчийг Парламентын гишүүдийн санал хураалтад оруулна.</p> <p>(3) <u>Хуралдаанд оролцсон Парламентын гишүүдийн олонхын дэмжлэг авсан хүнийг Ерөнхийлөгчөөр томилно.</u> Парламентын дарга шинэ Ерөнхийлөгчийн нэрийг нийтэд зарлана.</p> <p>(4) Нэр дэвшигчдийн ижил тооны санал авсан бол 24 цагийн дараа Парламентын дарга дахин санал хураалт явуулна. Ерөнхийлөгчид нэр дэвшсэн хүн Парламентын гишүүдийн олонхын дэмжлэг авах хүртэл санал хураалт үргэлжилнэ. Харин гурав дахь шатны санал хураалт явуулсны дараа нэр дэвшигчдийн хэн ч Парламентын гишүүдийн олонхын дэмжлэг аваагүй бол Парламентаас Ерөнхий сайдын өргөн мэдүүлсэн хүнийг Ерөнхийлөгчөөр томилж, Парламентын дарга нийтэд зарлана.</p> <p>(5) Хэрэв Ерөнхий сайд, сөрөг хүчний удирдагч хамтран нэг хүнийг нэр дэвшүүлсэн бол санал хураалт явуулахгүй Парламентаас тэр хүнийг Ерөнхийлөгчөөр томилж, Парламентын дарга нийтэд зарлана.</p> <p>85 дугаар зүйл. Бүрэн эрхийн хугацаа, цалин хөлс</p> <p>(1) Ерөнхийлөгч 3 жилийн хугацаатай томилогдох ба дахин 3 жилийн хугацаагаар томилогдож болно...</p> <p>(Эх сурвалж: https://www.laws.gov.fj/Home/information/constitutionoftherepublicoffiji)</p>
36.	<p>Финланд</p> <p>Үндсэн хууль нь 1999 онд батлагдаж, хамгийн сүүлд 2011 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>V бүлэг. БНУ-ын Ерөнхийлөгч ба Засгийн газар</p> <p>54 дүгээр зүйл. БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгох журам</p> <p><u>БНУ-ын Ерөнхийлөгч нь Финланд Улсын иргэдийн дундаас шууд санал өгөх замаар 6 жилийн хугацаатай сонгогдоно.</u> Нэг хүн Ерөнхийлөгчөөр хоёроос илүүгүй удаа дараалан сонгогдож болно.</p> <p><u>Сонгуульд оролцсон нийт сонгогчдын талаас илүү хувийн санал авсан нэр дэвшигч нь Ерөнхийлөгчөөр сонгогдоно.</u> Нэр дэвшигчдийн хэн ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн хооронд дахин сонгууль явуулна. Шинэ сонгуулиар хамгийн олон санал авсан нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Нэг хүн нэр дэвшсэн бол санал хураахгүйгээр сонгогдоно.</p> <p><u>Нэр дэвшүүлэх эрхийг Парламентын өнгөрсөн сонгуулиар суудал авсан нам, мөн сонгуулийн эрх бүхий 20000 иргэдийн бүлэг эдэлнэ.</u> Сонгуулийг товлон зарлах, Ерөнхийлөгчийг сонгох журмыг хуулиар нарийвчлан тогтооно.</p> <p>(Эх сурвалж: https://oikeusministerio.fi/en/constitution-of-finland)</p>

<p>37. Умард Македон Үндсэн хууль нь 1991 онд батлагдаж, хамгийн сүүлд 2011 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>80 дугаар зүйл. <u>БНУ-ын Ерөнхийлөгчийг бүх нийтийн, шууд, нууц санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно.</u> Нэг хүн БНУ-ын Ерөнхийлөгчөөр хоёроос илүүгүй удаа сонгогдоно. БНУ-ын Ерөнхийлөгч нь сонгуулийн өдөр 40 нас хүрсэн Бүгд Найрамдах Македон Улсын иргэн байна. Хэрэв сонгуулийн өдрийн байдлаар сүүлийн 15 жилийн хугацаанд хамгийн багадаа 10 жил Бүгд Найрамдах Македон Улсад оршин суугаагүй хүн БНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдохгүй.</p> <p>81 дүгээр зүйл. <u>Сонгуулийн эрх бүхий 10000-аас доошгүй иргэд, эсхүл Бүгд Найрамдах Улсын Ассамблейн 30-аас доошгүй төлөөлөгч БНУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлж болно.</u> БНУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь нийт сонгогчдын олонхын дэмжсэн саналаар сонгогдоно. Эхний шатны санал хураалтад нэр дэвшигчдийн хэн нь ч шаардлагатай олонхын санал аваагүй бол хоёр дахь шатны санал хураалтыг эхний шатанд хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчээр хязгаарлана.</p> <p>Эхний шатны санал хураалт дууссанаас хойш 14 хоногийн дотор хоёр дахь шатны санал хураалтыг явуулна. Нэр дэвшигч нь сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдийн талаас дээш хувь нь саналаа өгч, санал хураалтад оролцсон сонгогчдын олонхын саналыг авсан нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Хоёр дахь шатны санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч шаардлагатай олонхын саналыг аваагүй бол сонгуулийн үйл явцыг бүхэлд нь дахин явуулна.</p> <p>БНУ-ын Ерөнхийлөгчид нэг хүн нэр дэвшсэн бол тэрээр эхний шатны санал хураалтаар шаардлагатай олонхын санал аваагүй бол сонгуулийн үйл явцыг бүхэлд нь дахин явуулна.</p> <p>БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааны сүүлийн 60 хоногт болно. БНУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон бол бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш 40 хоногийн дотор шинэ Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийг явуулна...</p> <p>Нэмэлт өөрчлөлт XXXI 1. <u>Нэр дэвшигч нь нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын 40-өөс дээш хувийн олонхын санал авсан бол Ерөнхийлөгчөөр сонгогдоно.</u> 2. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Бүгд Найрамдах Македон Улсын Үндсэн хуулийн 81 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг орлоно. (Эх цурвалж: https://constituteproject.org/constitution/Macedonia_2011?lang=en)</p>
<p>38. Хорват Үндсэн хууль нь 1991 онд батлагдаж, хамгийн сүүлд 2013 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>5 дугаар зүйл. <u>БНУ-ын Ерөнхийлөгчийг бүх нийтийн, тэгш сонгох эрхийн үндсэн дээр шууд, нууц санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно.</u> БНУ-ын Ерөнхийлөгчөөр хоёроос дээш удаа сонгогдохгүй.</p> <p><u>Сонгуульд оролцсон нийт сонгогчдын олонхын саналаар БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгоно.</u> Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч олонхын санал аваагүй бол 14 хоногийн дараа дахин сонгууль явуулна.</p> <p>Эхний шатны санал хураалтаар хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигч нь хоёр дахь шатны санал хураалтад оролцоно. Хэрэв нэр дэвшигчдийн аль нэг нь нэрээ татсан бол хамгийн олон санал авсан дараагийн нэр дэвшигч хоёр дахь шатны санал хураалтад оролцоно.</p> <p>БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг одоогийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн дараа, 60-аас илүүгүй хоногийн өмнө явуулна...</p> <p>(Эх цурвалж: https://www.sabor.hr/en/constitution-republic-croatia-consolidated-text)</p>
<p>39. Чех Үндсэн хууль нь 1991 онд батлагдаж, хамгийн сүүлд 2013 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>54 дүгээр зүйл. 1. БНУ-ын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн байна. 2. БНУ-ын Ерөнхийлөгчийг бүх нийтийн санал хураалтаар шууд сонгоно. 3. БНУ-ын Ерөнхийлөгч үүргээ гүйцэтгэхэд хариуцлага хүлээхгүй.</p> <p>55 дугаар зүйл. БНУ-ын Ерөнхийлөгч тангараг өргөснөөр бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлнэ. БНУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа таван жил ба энэ хугацаа тангараг өргөсөн өдрөөс эхэлнэ.</p>

		<p>56 дугаар зүйл.</p> <p>1.Ерөнхийлөгчийн сонгуулийг бүх нийтийн, тэгш, шууд санал өгөх эрхийн үндсэн дээр нууц санал хураах хэлбэрээр явуулна.</p> <p>2.Хууль ёсны сонгогчдын талаас илүү олонхын санал авсан нэр дэвшигч БНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Ийм нэр дэвшигч байхгүй бол сонгуулийн эхний шатны санал хураалт явуулсан өдрөөс хойш 14 хоногийн дараа сонгуулийн хоёр дахь шатны санал хураалт явуулах ба эхний шатны санал хураалтад хамгийн өндөр амжилт үзүүлсэн хоёр нэр дэвшигч оролцоно. Хэрэв нэр дэвшигчид тэнцүү тооны санал авсан бол хууль ёсны сонгогчдын олонхын санал авсан бүх нэр дэвшигчид хоёр дахь шатны санал хураалтад оролцоно, хэрэв хоёроос доошгүй ийм нэр дэвшигч байгаа бол мөн хууль ёсны сонгогчдын дараагийн хамгийн олон санал авсан нэр дэвшигчид хоёр дахь шатны ын олонхын санал авсан бүх нэр дэвшигчид хоёр дахь шатны санал оролцоно.</p> <p>3.Нэр дэвшигч санал хураалтын хоёр дахь шатанд хууль ёсны сонгогчдын олонхын санал авсан байна. Хэрэв ийм нэр дэвшигч олон байгаа бол БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгохгүй ба 10 хоногийн дотор БНУ-ын Ерөнхийлөгчийн шинэ сонгууль болно.</p> <p>4.Хоёр дахь шатны санал хураалтад оролцсон нэр дэвшигч БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд дахин нэр дэвшихгүй, эсхүл ийм нэр дэвшигч БНУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвших эрхээсээ татгалзсан бол, сонгуулийн эхний шатанд дараагийн хамгийн олон санал авсан нэр дэвшигч хоёр дахь шатны сонгуульд оролцоно.</p> <p><u>5.Бүгд Найрамдах Чех Улс (БНЧУ)-ын 18 нас хүрсэн иргэн бүр Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй. Ийнхүү нэр дэвшүүлэхэд тухайн нэр дэвшигчийг дэмжсэн өргөдөлд БНЧУ-ын Ерөнхийлөгчид санал өгөх эрх бүхий 50000-аас доошгүй иргэний гарын үсэг зурсан байна.</u></p> <p><u>Нэр дэвшигчийг Парламентын 10-аас доошгүй депутат, эсхүл 10-аас доошгүй сенатор санал болгож болно.</u></p> <p>6.18 нас хүрсэн БНЧУ-ын иргэн бүр сонгох эрхтэй.</p> <p>7.Ерөнхийлөгчийн сонгуулийг одоогийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн сүүлийн 60 хоногийн дотор, ингэхдээ одоогийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө явуулна.</p> <p>Хэрэв Ерөнхийлөгчийн орон суларсан бол Ерөнхийлөгчийн сонгуулийг 90 хоногийн дотор явуулна.</p> <p>8.Ерөнхийлөгчийн сонгуулийг БНЧУ-ын Сенатын дарга нь сонгууль явуулахаас 90 хоногийн өмнө товлон зарлана.</p> <p>Хэрэв Ерөнхийлөгчийн орон суларсан бол БНЧУ-ын Сенатын дарга нь ийм сонгууль явуулахаас 10-аас доошгүй хоногийн өмнө, мөн сонгууль явуулахаас 80 хоногийн өмнө нэгэн зэрэг Ерөнхийлөгчийн сонгуулийг зарлана. (Should the office of the President become vacant, the President of the Senate shall announce the election of the President 10 days prior to holding such election at the latest and simultaneously 80 days prior to holding such election.)</p> <p>9.Хэрэв БНЧУ-ын Сенатын даргын суудал сул байх бол Ерөнхийлөгчийн сонгуулийг Төлөөлөгчдийн танхимын дарга товлон зарлана.</p> <p>57 дугаар зүйл.</p> <p>1.Сенатораар сонгогдох эрхтэй аливаа иргэн Ерөнхийлөгчөөр сонгогдож болно.</p> <p>2.Хэн ч БНУ-ын Ерөнхийлөгчөөр хоёроос дээш удаа дараалан сонгогдохгүй.</p> <p>58 дугаар зүйл.</p> <p>Ерөнхийлөгчийн сонгуульд сонгох эрхээ хэрэгжүүлэх, мөн БНУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, сонгуулийг товлон зарлах, явуулах, сонгуулийн дүнг зарлах, сонгуультай холбоотой маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх үйл явцыг хуулиар зохицуулна.</p> <p>(Эх сурвалж: https://www.usoud.cz/en/legal-basis)</p>
40.	Швейцар* Үндсэн хууль нь 1999 онд батлагдаж,	<p>168 дугаар зүйл. Томилгоонууд</p> <p>1.Холбооны Хурал нь Холбооны Зөвлөл (Federal Council)-ийн гишүүд, Холбооны Канцлер, Холбооны Дээд шүүхийн шүүгчид, дайны үед Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийг ("Генерал") сонгоно.</p>

	<p>хамгийн сүүлд 2014 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>2.Холбооны Хуралд бусад томилгоог хийх, батлах эрхийг хуулиар олгож болно.</p> <p>175 дугаар зүйл. Бүрэлдэхүүн ба сонгууль</p> <p>1.Холбооны Зөвлөл долоон гишүүнээс бүрдэнэ.</p> <p>2.<u>Холбооны Зөвлөлийн гишүүд нь Үндэсний Зөвлөл (Парламентын доод танхим)-ийн сонгууль бүрийн дараа Холбооны Хурлаас сонгогдоно.</u></p> <p>3.Холбооны Зөвлөлийн гишүүд 4 жилийн хугацаатай сонгогдоно. Үндэсний зөвлөлийн гишүүнээр сонгогдох эрхтэй аливаа Швейцар Улсын иргэн Холбооны Зөвлөлийн гишүүнээр сонгогдож болно.</p> <p>4.Холбооны Зөвлөлийг сонгохдоо Швейцар Улсын газар зүйн болон хэлний янз бүрийн бүс нутгийг зохих ёсоор төлөөлөхөд анхаарна.</p> <p>176 дугаар зүйл Ерөнхийлөгчийн бүрэн эрх</p> <p>1.Холбооны улсын Ерөнхийлөгч Холбооны Зөвлөлийг тэргүүлнэ.</p> <p>2.Холбооны Зөвлөлийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийг Холбооны Зөвлөлийн гишүүдийн дундаас Холбооны Хурал нэг жилийн хугацаагаар сонгоно.</p> <p>3.Дараагийн жил тэднийг дахин сонгохгүй. Ерөнхийлөгч нь дараагийн жил Дэд Ерөнхийлөгчөөр сонгогдохгүй.</p> <p>(Эх сурвалж: https://www.fedlex.admin.ch/eli/cc/1999/404/en)</p>
<p>41.</p>	<p>Энэтхэг*</p> <p>Үндсэн хууль нь 1949 онд батлагдаж, хамгийн сүүлд 2016 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>I бүлэг. Гүйцэтгэх засаглал</p> <p>Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч</p> <p>54 дүгээр зүйл. Ерөнхийлөгчийн сонгууль</p> <p><u>Ерөнхийлөгчийг дараах гишүүдээс бүрдэх Сонгуулийн коллегииос сонгоно:</u></p> <p>а) <u>Парламентын хоёр танхимын сонгогдсон гишүүд;</u></p> <p>б) <u>муж улсын хууль тогтоох байгууллагын сонгогдсон гишүүд.</u></p> <p>Тайлбар: Үндсэн хуулийн энэ зүйл болон 55 дугаар зүйлд "Муж" гэсэнд Делигийн Үндэсний нийслэлийн нутаг дэвсгэр (the National Capital Territory of Delhi) болон Пондичерригийн Холбооны нутаг дэвсгэр (the Union territory of Pondicherry) орно.</p> <p>55 дугаар зүйл. Ерөнхийлөгчийг сонгох журам</p> <p>1.Ерөнхийлөгчийн сонгуулиар аль болох муж улсуудын төлөөллийн жигд хэмжээг баримтална.</p> <p>2.Муж улсуудын хооронд ийм жигд байдал, муж улсууд болон Холбооны улс хоорондын тэгш байдлыг хангахын тулд муж улс бүрийн Хууль тогтоох хурлын гишүүн тус бүрийн ийм сонгуульд өгөх эрхтэй саналын тоог дараах байдлаар тогтооно:</p> <p>а) муж улсын Хууль тогтоох хурлын сонгогдсон гишүүн бүр тухайн муж улсын хүн амыг хууль тогтоох хурлын гишүүдийн нийт тоонд хуваасан харьцааг нэг мянгад үржүүлсэн саналын эрхтэй байна;</p> <p>б) хэрэв дурдсан нэг мянгатын үржвэрийг нэмсний дараа 500-аас доошгүй үлдсэн бол (а) дэд зүйлд заасан гишүүн бүрийн саналын тоог нэгээр нэмэгдүүлнэ;</p> <p>в) Парламентын хоёр танхимын гишүүн бүр (а) ба (б)-д заасны дагуу муж улсуудын Хууль тогтоох хурлын гишүүдэд олгосон нийт саналын тоог Парламентын хоёр танхимын нийт гишүүдийн тоонд хуваасны үр дүнд гарсан тооны саналын эрхтэй байна: талаас илүү хувийг нэг нэгж гэж тооцох ба бусад хувийг тооцохгүй.</p> <p>3.Ерөнхийлөгчийн сонгуулийг хувь тэнцүүлсэн тогтолцооны дагуу нэг санал шилжүүлэх замаар, нууц санал хураалтаар явуулна.</p> <p>56 дугаар зүйл. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа</p> <p>1.Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байна...</p> <p>57 дугаар зүйл. Дахин сонгогдох эрх</p> <p>Ерөнхийлөгчийн албыг хашиж байгаа, эсхүл хашиж байсан хүн энэ Үндсэн хуульд заасан бусад заалтыг баримтлан уг албанд улиран сонгогдох эрхтэй.</p> <p>58 дугаар зүйл. Ерөнхийлөгчөөр сонгогдоход тавигдах шаардлага</p> <p>1.Дараах тохиолдолд Ерөнхийлөгчөөр сонгогдохгүй:</p> <p>а) Энэтхэг Улсын иргэн биш бол;</p> <p>б) 35 нас хүрээгүй бол;</p> <p>в) Ардын танхимын гишүүнээр сонгогдох эрхгүй бол.</p> <p>(Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/India_2016?lang=en)</p>

42.	<p>Эстони Үндсэн хууль нь 1992 онд батлагдаж, хамгийн сүүлд 2015 онд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p style="text-align: center;">IV бүлэг. Рийгикогу</p> <p>65 дугаар зүйл. Рийгикогу дараах эрх, үүрэгтэй: 3) Үндсэн хуулийн 79 дүгээр зүйлд заасны дагуу БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгох;</p> <p style="text-align: center;">V бүлэг. БНУ-ын Ерөнхийлөгч</p> <p>79 дүгээр зүйл. БНУ-ын Ерөнхийлөгчийг Рийгикогу, эсхүл энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан бол Сонгуулийн коллечи сонгоно. <u>Рийгикогугийн гишүүдийн 1/5-ээс доошгүй нь БНУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй.</u> БНУ-ын Ерөнхийлөгчид 40 нас хүрсэн Эстони Улсын иргэнийг нэр дэвшүүлнэ. БНУ-ын Ерөнхийлөгчийг нууц санал хураалтаар сонгоно. Рийгикогугийн гишүүн бүр нэг саналтай. <u>Рийгикогугийн гишүүдийн 2/3-ын олонхын санал авсан нэр дэвшигч нь БНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдоно.</u> Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч шаардлагатай олонхын санал аваагүй бол шинэ санал хураалтыг дараагийн өдөр нь явуулна. Хоёр дахь санал хураалт эхлэхээс өмнө нэр дэвшигчдийг шинээр тодруулна. Хоёр дахь шатанд нэр дэвшигчдийн хэн нь ч шаардлагатай олонхын санал аваагүй бол хоёр дахь шатны санал хураалтаар хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн хооронд гурав дахь санал хураалтыг тухайн өдөртөө явуулна. Гурав дахь шатны санал хураалтаар БНУ-ын Ерөнхийлөгч мөн сонгогдоогүй бол Рийгикогугийн Ерөнхийлөгч нэг сарын дотор БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгох Сонгуулийн коллечи зарлан хуралдуулна. Сонгуулийн коллечи нь Рийгикогугийн гишүүд болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хурлын төлөөлөгчдөөс бүрдэнэ. Нутгийн өөрөө удирдах байгууллагын хурал бүр нэгээс багагүй Эстони Улсын иргэн болох төлөөлөгчийг Сонгуулийн коллечид сонгоно. Рийгикогу хамгийн олон санал авсан хоёр хүнийг Ерөнхийлөгчид нэр дэвшүүлж байгааг Сонгуулийн коллечид танилцуулна. Сонгуулийн коллечи 21-ээс доошгүй гишүүн Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй. Сонгуулийн коллечиор санал өгсөн гишүүдийн олонхын саналаар БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгоно. Эхний шатны санал хураалтад нэр дэвшигчдийн хэн ч сонгогдоогүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн хооронд хоёр дахь шатны санал хураалтыг тухайн өдөртөө явуулна. БНУ-ын Ерөнхийлөгчийг сонгох нарийвчилсан журмыг БНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар тогтооно.</p> <p>80 дугаар зүйл. БНУ-ын Ерөнхийлөгч 5 жилийн хугацаатай сонгогдоно. Хэн ч БНУ-ын Ерөнхийлөгчөөр дараалан хоёроос дээш удаа сонгогдохгүй. БНУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг БНУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө, 10-аас доошгүй хоногийн дараа явуулна.</p> <p style="text-align: right;">(Эх сурвалж: https://www.riigikogu.ee/wpcms/wp-content/uploads/2015/02/3_Pohiseadus_VENE.pdf)</p>
43.	<p>Этиоп* Үндсэн хууль нь 1994 онд батлагдсан.</p>	<p>70 дугаар зүйл. Ерөнхийлөгчийг нэр дэвшүүлэх, томилох 1. Ардын Төлөөлөгчдийн танхим Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг тодруулна. 2. Ардын Төлөөлөгчдийн танхим болон Холбооны танхимын <u>хамтарсан хуралдаанаар нэр дэвшигчийг 2/3-ын олонхын саналаар дэмжсэн бол Ерөнхийлөгчөөр сонгогдоно.</u> 3. Аль нэг танхимын гишүүн Ерөнхийлөгчөөр сонгогдсон бол суудлаа чөлөөлнө. 4. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Ерөнхийлөгчөөр хоёроос дээш удаа сонгогдохгүй.</p> <p style="text-align: right;">(Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Ethiopia_1994?lang=en)</p>

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээр

- Лүндээжанцан Д., Өлзийсайхан Л. Парламентат ёс. УБ., 2005 он.
- Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
- “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн үүрэг” Дүн шинжилгээ. УБ., 2015 он.
- Товуусүрэн Ц. “Үндсэн хуулиа ойлгохуй”. Хоёр дахь хэвлэл. УБ., 2020 он.
- Удирдлагын академи. Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн байх суурь: Бүрэн эрхийн шинжилгээ. УБ., 2019 он.
- Улсын Их Хурал. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах сэдвийн танилцуулга. УБ., 2017 он.
- Улсын Их Хурал. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт (Товч танилцуулга). УБ., 2021 он.
- Улсын Их Хурал. Үндэсний Статистикийн хороо. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулгын дүн. УБ., 2017 он.
- Улсын Их Хурал. Үндэсний Статистикийн хороо. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах сэдвийн танилцуулга. УБ., 2017 он.
- Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын Ардын Их Хурал ба Монгол Улсын Үндсэн хууль – 1990-1992. Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2016 он.
- Улсын Их Хурлын Тамгын газар. БНМАУ-ын УБХ-ын 1991.10.17-ны өдрийн хуралдааны тэмдэглэл.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Дэлхийн 25 орны сүүлийн 50 жилийн засаглалын хэлбэр, төрийн тэргүүний сонгуулийн тогтолцоо, төрийн тэргүүнээр ажилласан хүмүүс. Мэдээлэл, лавлагаа (СТ-15/420). УБ., 2015 он.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Ерөнхийлөгчийн сонгуулийн хэлбэрийн талаарх парламентын бүгд найрамдах засаглалтай улсуудын Үндсэн хуулийн зохицуулалт. Харьцуулсан судалгаа (СТ-18/207). УБ., 2018 он.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба Монгол Улсын Их цаазын төслүүдийн (1991.VI.05, X.05, XI.07) харьцуулалт. Харьцуулсан судалгаа (СТ-15/206). УБ., 2015 он.
- Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны алба. Парламентын засаглалтай улс орнуудын төрийн эрх мэдлийн хуваарилалт. Харьцуулсан судалгаа (СТ-17/206). УБ., 2017 он.
- Чимид Б. Ардчилсан Үндсэн хууль бол Монголын ард түмний бүтээл. “Ардчилсан Үндсэн хууль-20” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2012.
- Энхбаатар Ч., Монгол Улсын Ерөнхийлөгчийн институцын онцлог, үүсэл, хөгжил. Удирдахуйн онол, практикийн асуудлууд (Эрдэм шинжилгээний асуудлууд). №1 (23). 2020 он.

Англи хэл дээр

- ACE Electoral Knowledge Network. <https://aceproject.org/main/english/es/esi01.htm>
- <https://www.britannica.com/topic/head-of-state>
- International IDEA. Non-Executive Presidents in Parliamentary Democracies. 2017. Second edition.

**ХБНГУ, АНУ-ЫН ХУУЛЬ ЗҮЙН
ТОЛЬ БИЧГИЙН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Б.Буянзаяа, Г.Алтан-О (Ph.D), П.Уранчимээ

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

Нэг. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

- *ХБНГУ-ын Веберийн толь бичиг-ийн тухай*

Хоёр. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

- *АНУ-ын “Black’s law dictionary”-ийн тухай*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “ХБНГУ, АНУ-ын хууль зүйн толь бичгийн талаарх тойм мэдээлэл” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго

ХБНГУ-ын “Веберийн толь бичиг” болон АНУ-ын “Блэкийн толь бичиг”-үүдийн түүхчилсэн танилцуулга, агуулга, ач холбогдол, зохиогчдод тавигдах шаардлага болон толь бичгийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын тухай судлахыг зорилоо.

Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд дараах орнуудыг сонгон судалсан болно. Үүнд:

- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс;
- Америкийн Нэгдсэн Улс зэрэг болно.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

“Толь бичиг”³⁵⁴ гэж “тухайн хэлний үгсийг жагсаан бичиж утга, хэрэглээ, бичлэг, дуудлага зэргийг тайлбарласан, түүнчлэн харь хэлний утга таацах үгтэй нь дүйлгэсэн ном” гэж; “Нэвтэрхий толь” гэж мэдлэг оюуны аль нэг, эсвэл бүх шинжлэх ухааны салбарын мэдлэгийг толь бичиг маягаар системчилсэн лавлах” гэж Монгол хэлний их тайлбар тольд тус тус тайлбарласан байна.

Нэвтэрхий толь нь системчлэн эрэмбэлсэн тодорхой мэдлэгийг агуулсан шинжлэх ухааны лавлагаа-мэдээллийн хэвлэл учраас олон талын ач холбогдолтой юм. Нэвтэрхий толийг түгээмэл (ерөнхий), үндэсний (эх орны), бүс нутгийн, салбарын (тусгай) гэж ангилах бөгөөд хууль зүйн нэвтэрхий толь нь салбарын нэвтэрхий тольд хамаарч байна.

Монгол Улсын хувьд³⁵⁵, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Монголын хууль зүйн нэвтэрхий толь бичиг”-ийг бүтээх ажлыг санаачлан зохион байгуулж анхны хэвлэлтийг 2021 онд нийтийн хүртээл болгосон байна. Энэхүү нэвтэрхий толь бичигт нийтийн (үндсэн хуулийн, захиргааны, санхүүгийн, эрүүгийн, экологийн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа) ба хувийн (иргэний, хөдөлмөрийн, гэр бүлийн), мөн олон улсын нийтийн ба хувийн гэх мэт бүх салбар эрх зүйн тайлбаруудыг багтаасан. Түүнчлэн дэлхийн болон монголын төр, эрх зүйн онол, түүх ба криминологи, шүүхийн шинжилгээ зэрэг хууль зүйн хэрэглээний (хавсарга) судлагдахууны нийт 2200 гаруй шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар өгүүллийг багтаасан байна.

Монгол Улсад хууль зүйн нэр томъёо ба хэллэгийн сан бүрдсэн байдлыг авч үзвэл:

- БНМАУ-ын жилүүдэд зохиосон хууль зүйн толь нь 1986 онд хэвлэгдсэн “Эрх зүйн мэдлэгийн товч толь” байсан. Энэ толь бичиг нь хөдөлмөрчдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн бөгөөд 400 шахам нэр томъёог багтаажээ.
- 2003 онд “Хууль зүйн тайлбар толь” нийтийн хүртээл болсон. “Монгол Улсад хууль зүйн үндсэн асуудлыг хамаарсан толь бичиг урьд өмнө хэвлэгдэн гарч

³⁵⁴ Монгол хэлний их тайлбар толь

³⁵⁵ Монгол Улсын Хууль зүйн анхны нэвтэрхий толь: эрэлт хэрэгцээ, зорилго, агуулга, ач холбогдол, https://mojha.gov.mn/newmojha/?p=6581#_ftn7

байгаагүй учраас энэ удаад уг толь бичигт хууль зүйн шинжлэх ухааны бүх салбаруудыг хамрах зорилго тавиагүй зөвхөн бүх нийтэд хэрэгцээтэй гол гол салбар эрх зүйн үндсэн салбаруудыг тайлбарлах” зорилгыг зохиогчид тавьжээ.

- Хууль зүйн 5500 гаруй нэр томъёоны тайлбарыг багтаасан “Эрх зүйн эх толь бичиг” 2007 онд хэвлэгдэн нийтийн хүртээл болжээ. Эл тайлбар толийг нэмж засварлан 2008 онд хэвлүүлсэн бөгөөд хоёр дахь хэвлэл 6000 гаруй нэр томъёо ба хэллэгтэй болж, 500 гаруйг нэмсэн байна. Нэмж засварласан гурав дахь хэвлэл нь 2011 онд хэвлэгдэж, хууль зүйн 8000 шахам нэр томъёо ба хэллэгтэй болжээ. Энэ тайлбар толь бичгийн нэмж засварласан дөрөв дэх хэвлэлийг 2015 онд хууль зүйн 9000 гаруй нэр томъёо ба хэллэгтэй хэвлүүлжээ.
- Б.Чимид, Д.Пүрэв, Чой.Лувсанжав нар Хууль зүйн нэр томъёо (Улсын нэр томъёоны комиссын мэдээ № 107-108)„ Улаанбаатар, 1978.
- Ж.Амарсанаа, Л.Баасан, Н.Баатаржав, Д.Лүндээжанцан, С.Нарангэрэл нар, Эрх зүйн мэдлэгийн толь, Улаанбаатар, 1986
- Ж.Амарсанаа, С.Нарангэрэл, Г.Совд нар Хууль зүйн тайлбар толь., Улаанбаатар 2003.
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг., Улаанбаатар., 2007
- Ц.Гантулгат, Хуульчилсан нэр томъёоны толь., 2018
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болох legalinfo.mn цахим хуудсанд хуулийн 1453 нэр томъёог тайлбарласан байна.

Веберийн хуулийн толь бичиг: 1763 онд байгуулагдсан ХБНГУ-ын хэвлэлийн салбарын эртний уламжлалт компани болох С.Н.ВЕСК компанийн өв залгамжлагч Ханс Дийтер Бек нь Веберийн хуулийн толь бичиг /Weber (Rechtswörterbuch)/-г 1965 онд анх санаачилж, хуульч Карл Крэйфелдийг зохиогч, редактороор хөлслөн ажиллуулсан бөгөөд эрх зүйн салбарын төрөл бүрийн 13 000 нэр томъёог тайлбарласан 1800 хуудас бүхий нийт 26 /2021 он/ цуврал бүтээлийг хэвлэн гаргаж нийтийн хүртээл болгожээ. Толь бичгийн шинээр гарсан хэвлэл бүрд хамгийн сүүлийн үеийн хууль, хууль эрх зүйн хэлбэр, харилцааны хамгийн чухал нэр томъёо, түлхүүр үг, тайлбаруудыг нэмж оруулан тогтмол сайжруулалт хийж байдгаараа онцлогтой.

Веберийн хуулийн толь бичиг нь ХБНГУ-ын хууль зүйн утга зохиолын салбарт томоохон байр суурийг эзэлдэг бөгөөд өдөр тутмын амьдралдаа хууль эрх зүйн нэр томъёотой тулгарч байдаг хэн бүхэнд Герман Улсын болон олон улсын эрх зүйн тодорхой болон тодорхойгүй нэр томъёонууд, эрх зүйн салбар шинжлэх ухаанд давхацдаг ижил төсөөтэй нэр томъёонууд, түлхүүр үг, хэлэлцүүлэг, ном зохиолын ишлэл, нарийвчилсан ишлэл зэргийг ойлгомжтойгоор тайлбарласан, маш сайн лавлагаа болдог байна.

Уг толь бичгийн зохиогчдын бүрэлдэхүүнд Мюнхений Дээд бүсийн шүүхийн даргалагч шүүгч, Мюнхен хотын Холбооны шүүгч, Лейпциг хотын Санхүүгийн шүүхийн шүүгч, Мюнхен дэх Дээд бүсийн шүүхийн дарга, Бавари мужийн Мюнхен хотын Хууль зүйн яамны Засгийн газрын ахлах зөвлөх, нэр хүндтэй их сургуулийн доктор профессорууд зэрэг мэргэжилтэн, судлаачдыг багтаасан нь энэхүү бүтээлийн үнэ цэнийг нэмэгдүүлж бүтээлийн чанар, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг баталгаажуулдаг гэж үздэг.

Блэкийн хуулийн толь бичиг: Блэкийн хуулийн толь бичиг нь АНУ-д хамгийн өргөн хэрэглэгддэг хуулийн толь бичиг юм.

100 гаруй жилийн өмнө буюу 1891 онд Хенри Кэмпбелл Блэк (Henry Campbell Black) “Блэкийн хуулийн толь бичиг”-ийн анхны хувилбарыг боловсруулан гаргасан байна. Үүнээс хойш 11 удаа (1-р боть 1891, 2-р боть 1910, 3-р боть 1933, 4-р боть 1951, 5-р боть 1957, 6-р боть 1968, 7-р боть 1999, 8-р боть 2004, 9-р боть 2009, 10-р боть 2014, 11-р боть 2019 он) баяжуулан, шинэчлэн хэвлэсэн бөгөөд хамгийн өргөн хүрээтэй практик хэрэглээ бүхий эрдэм шинжилгээний, хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн толь бичигт тооцогдсоор байна. 2019 онд хэвлэгдсэн 11 дэх удаагийн толь бичигт хууль, эрх зүйн 55000 гаруй үг, хэллэгийг багтаасан бөгөөд түүхэн болон өнөө цагийн утга агуулгыг тайлбарлаж өгсөн нь ийм харьцуулсан мэдээлэл өгч байгаа ганц толь бичиг гэдгээрээ онцлогтой байна.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

Нэг. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

- **ХБНГУ-ын “Веберийн толь бичиг”-ийн тухай:**

Танилцуулга:

Веберийн хуулийн толь бичиг ³⁵⁶ /Weber (Rechtswörterbuch)/ нь нэвтэрхий толь хэлбэрээр Бекийн хэвлэлийн газраас эрхлэн гаргадаг эрх зүйн толь бичиг мөн. 2019 онд хэвлэгдсэн 23 дахь удаагийн хэвлэл нь эрх зүйн салбарын төрөл бүрийн 13 000 нэр томьёог тайлбарласан 1800 хуудастай байна. Уг бүтээлийг ХБНГУ-д хууль зүйн утга зохиолын стандарт хэмээн хүлээн зөвшөөрдөг бөгөөд энгийн иргэн, хуульч, компани, татварын зөвлөх, багш, оюутан, сурагчид гэх мэт өдөр тутмын амьдралдаа хууль эрх зүйн нэр томьёотой тулгардаг хэн бүхэнд асуудлуудыг шийдвэрлэх маш сайн лавлагаа, судалгаа болохоос гадна эрх зүйч, хуульчдын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулдаг бүтээл юм.

Хууль эрх зүйн салбар дахь хуулийн хэрэглээ нь тодорхой болон тодорхойгүй хуулийн нэр томьёоны нэгдлээс бүрддэг бөгөөд тэдгээр нэр томьёо, үгсийг тэр бүр нарийн утгаар нь мэдэх боломжгүй байдаг. Эрх зүйн салбар шинжлэх ухаанд ижил нэр томьёоны давхцал цаг ямагт бий болж сүүлийн үеийн хууль тогтоомж, нэр томьёог судлах, тайлбарлах шаардлага тогтмол гардаг.

Веберийн хуулийн толь бичгийг зохиогчид энэхүү асуудлыг шийдэх зорилгоор Герман Улсын болон олон улсын хууль эрх зүйн орчинд хэрэглэгддэг тодорхой болон тодорхойгүй хууль эрх зүйн нэр томьёо, үгсийн арвин нөөц бүхий мэдээллийн сан бүрдүүлж, түлхүүр үг, хуулийн нэр томьёонуудыг аль болох нарийвчлан тайлбарлаж, эх сурвалжийг нэрлэх, практик хууль, хуулийн тусгай ном зохиолын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийг зорьсон бөгөөд энэ нь энгийн иргэн, хуульчдад хуулийг тайлбарлах, ойлгох, баримжаа олгох үйл явцыг хөнгөвчилнө гэж үздэг байна.

Түүх: Ханс Дийтер Бек 1965 онд анх толь бичгийг санаачилж, хуульч Карл Крэйфелдийг зохиогч, редактороор хөлслөн ажиллуулсан байна. Крэйфелд өөрөө эрх зүйн ерөнхий ойлголт болон эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүй, тээврийн эрх зүй, эрх зүйн түүх болон эрх зүйн философи гэсэн салбарын нэр томьёог хариуцан

³⁵⁶ Вебер (Толь бичиг)-Weber (Rechtswörterbuch)
[https://de.wikipedia.org/wiki/Weber_\(Rechtsw%C3%B6rterbuch\)](https://de.wikipedia.org/wiki/Weber_(Rechtsw%C3%B6rterbuch))

ажиллажээ. Анхны хэвлэл 1968 онд хэвлэгдсэн бөгөөд зохиогчдын хувиар Д.Гунц, П.Хенслер, Х.Кауфман, Х.Пуцо, Х.Штер болон А.Вагнер нар хамтран ажилласан юм.

К.Крэйфелд 8 дахь хэвлэл (1986) хүртэл “өөрийн хайртай бүтээл”-ийнхээ эхийг барьсан байна. Түүнийг 1994 онд нас барснаас хойш ч уг толь бичиг нь түүний нэрээр хэвлэгдэн гарч байжээ. Харин 14 дэх хэвлэлээс эхлэн Клаус Веберийн нэрээр гарах болсон байна.

Крэйфелдийн толь бичгийн 15-21 дэх хэвлэл (1999-2014) хүртэл агуулгын адил түвшинд CD-ROM дээр буюу “DIGITAL” хэлбэрээр хэвлэн нийтэлж эхэлсэн байдаг. Мөн “Ковид-19 цар тахал”-ын улмаас цаг үетэй зохицон ажиллах шаардлага гарч шаардлагатай шинэчлэлийн ажлуудыг хийн цахим хэлбэрээр хэвлэн нийтэлж эхэлсэн байна.

С.Н.BECK хэвлэлийн компанийн тухай товч мэдээлэл:

С.Н.BECK групп нь 1763 онд байгуулагдсан ХБНГУ-ын хэвлэлийн салбарын эртний уламжлалт томоохон компани юм.³⁵⁷

Тус компани нь 9000 гаруй бүтээл, олон тооны цахим хэвлэл, 80 орчим тусгай сэтгүүлийг эрхлэн гаргадаг бөгөөд жил бүр 1500 хүртэлх ном, хэвлэл эрхлэн гаргадаг тоон үзүүлэлтээрээ ХБНГУ-ын хэмжээнд тэргүүлдэг.

Зөвхөн Мюнхен дэх хэвлэлийн газрын төв байранд 650 орчим хүн ажилладаг бөгөөд Франкфурт хотод голлох хуулийн сэтгүүлийн редакцтай салбар оффис нь байрладаг.

Эдгээр салбарт 120 гаруй мэргэжилтэн редактор, редакторууд 7500 гаруй идэвхтэй зохиолчдыг хариуцдаг.

Тус компани нь “Хууль - Татвар - Эдийн засгийн” хэлтэс, “Уран зохиол - уран зохиолын бус - шинжлэх ухааны” хэлтэс гэсэн 2 үндсэн хэлтэст хуваагддаг байна.

Клаус Вебер нь 2000 оны 7 дугаар сард төрийн албыг орхин С.Н.Beck группт ажиллан улмаар 2011 оноос эхлэн гүйцэтгэх зөвлөлийн гишүүн буюу удирдлагын багт орж хуулийн хөтөлбөрийг хариуцан ажиллаж байна.

С.Н.BECK компани нь мэргэжилтэн редакторын багийг бүрдүүлэн Вебер хуулийн толь бичгийг эрхлэн гаргадаг бөгөөд тус компанийн удирдлагын багийн гишүүн мөн хуулийн хөтөлбөрийг хариуцан ажилладаг Клаус Вебер нь Вебер хуулийн толь бичгийн төслийн ерөнхий редактороор ажиллан энэхүү толь бичгийг хамтран зохиодог байна.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Клаус Вебер нь толь бичгийн ерөнхий редакторын үүргийг гүйцэтгэж хамтран зохиогчдын багийн бүрэлдэхүүнд багтдаг Мюнхений Дээд бүсийн шүүхийн даргалагч шүүгч, Мюнхен хотын Холбооны шүүгч, Их сургуулийн профессор, Лейпциг хотын Санхүүгийн шүүхийн шүүгч, Берлин хотын чөлөөт их сургууль, Мюнхен дэх Дээд бүсийн шүүхийн дарга, Бавари мужийн Мюнхен хотын Хууль зүйн яамны Засгийн газрын ахлах зөвлөх зэрэг өндөр түвшний мэргэжилтэн, судлаачид нь бүтээлийн үнэ цэнийг нэмэгдүүлж бүтээлийн чанар, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг баталгаажуулдаг гэж үздэг.

³⁵⁷ https://rsw-beck-de.translate.google.verlag/karriere?_x_tr_sl=de&_x_tr_tl=mn&_x_tr_hl=mn&_x_tr_pto=sc

Жишээлбэл: 2019 оны 23 дахь шинэчилсэн хэвлэлийн зохиогчдын бүрэлдэхүүнд:

1. Томас Айчбергер /Хуульч, татварын зөвлөх, доктор/
2. Гуннар Касардт /Мюнхен хотын Баварийн дээд бүсийн шүүхийн шүүгч/
3. Хелмут Данкелман /Оффис менежер Германы тэтгэврийн даатгалын Вестфалиа а. Д., Мюнстер/
4. Жулиан Фукс /Мюнхений дүүргийн шүүхийн шүүгч, доктор /
5. Гуннар Гро, LL.M. /Мюнхен хотын Бавари мужийн Хууль зүйн яамны Засгийн газрын ахлах зөвлөх, доктор /
6. Майкл Хакенберг, LL.M.ет /Триерийн их сургуулийн профессор/
7. Ульф Корсток /Любек хотын Хөдөлмөрийн шүүхийн шүүгч/
8. Андреа Шмидт /Мюнхен хотын дүүргийн шүүхийн дарга, доктор/
9. Клаус Вебер /Хуульч, Аугсбургийн их сургуулийн хүндэт профессор/
10. Райк Вернер /Мюнхений дээд бүсийн шүүхийн шүүгч, доктор/ зэрэг хууль зүйн ухааны доктор, профессоруудаас бүрдсэн баг ажилласан байна.

Мөн шүүхийн дарга, шүүгчид, хууль зүйн яамны зөвлөх албан тушаалтай хүмүүс зохиогчдын бүрэлдэхүүнд багтаж байгаа нь шүүхийн практикт хуулийн нэр томьёог шүүхийн болон хуулийн өдөр тутмын хэрэглээнд тогтмол хэрэглэх хөшүүргийг үүсгэж байдаг тул уг толь бичигт багтаасан тайлбар, ойлголтуудыг хүлээн зөвшөөрөх гол үндэслэл болж байдаг гэж үзэхээр байна.

Бүтцийн хувьд

Веберийн хууль зүйн толь бичигт хууль тогтоох үйл явц, шүүх эрх мэдэл, давж заалдах гомдол, хууль эрх зүйн залгамжлал, бизнес, улс төр, түүхийн нэр томьёо зэргийг багтаасан байдаг.

Толь бичгийн үндсэн агуулга нь хялбар бөгөөд практикт хэрэглэхэд тохиромжтой үндэсний болон олон улсын эрх зүйн чухал үндсэн ойлголтуудыг ойлгомжтойгоор тайлбарлаж, хэлэлцүүлэг, ном зохиолын эшлэл, нарийвчилсан ишлэл хийхэд тохиромжтой байдаг нь толь бичгийг бүтцийн хувьд ойлгож хэрэглэх явцыг хөнгөвчилдөг.

Толь бичиг нь хэрэглэгчдэд зөвхөн анхны чиг баримжаа олгохоос гадна хуульчийн хувьд нарийн төвөгтэй бөгөөд цаг хугацаа шаардсан судалгаа хийх ажиллагааг хөнгөвчлөх боломжийг олгох бөгөөд ойлгомжгүй маргааныг бүхэлд нь нарийвчлан тайлбарладаггүй ч тодорхой зарим жишээгээр товч тайлбарлан дурдсан байдаг.

Зохиогчид толь бичгийн бүтцэд бүтээлийн өмнөх үг, редакторын бүрэлдэхүүн, хэн аль хуулийн чиглэлийг хариуцан ажилласан талаарх жагсаалт, товчилсон үгсийн жагсаалтыг оруулдаг бөгөөд үндсэн хэсэг нь толь бичгийн лексик³⁵⁸ бүтэцтэй хэсэг юм.

³⁵⁸ утгын ойролцоо буюу эсрэгчдэд зарчимд суурилсан үгсийн янз бүрийн хослолууд (синонимын цуваа, антонимик) дээр суурилдаг.

Ерөнхий ойлголт эсвэл эсрэг утгатай;

Загварын шинж чанаруудын ижил төстэй байдал эсвэл эсрэг тэсрэг байдал;

Үг бүтээх ерөнхий төрөл;

Яриа дахь функцууд;

Идэвхтэй эсвэл идэвхгүй үгсийн санд хамаарах

Толь бичгийн зохиогчийн бүрэлдэхүүн нь толь бичигт орсон тодорхой хуулиудын нэр томьёог салбар, чиглэлээр хариуцан авч шаардлагатай редакцыг хийлгэсэн байна.

Жишээлбэл:

1. Хуулийн ерөнхий нөхцөлийг Гуннар Гро, LL.M./Мюнхен хотын Бавари мужийн Хууль зүйн яамны Засгийн газрын ахлах зөвлөх, доктор /;
2. Хөдөлмөрийн тухай хуулийг Ульф Корсток /Любек хотын Хөдөлмөрийн шүүхийн шүүгч/
3. Олон нийтийн /төрийн банк/ банкны хууль: Проф. Майкл Хакенберг, LL.M.em /Триерийн их сургуулийн профессор/;
4. Хувийн банкны хуулийг Андреа Шмидт /Мюнхен хотын дүүргийн шүүхийн дарга, доктор /;
5. Үүргийн хууль, Нийгмийн хуулиудыг Хелмут Данкелман /Оффис менежер Германы тэтгэврийн даатгалын Вестфалиа а. Д., Мюнстер/ гэх мэтээр хариуцан редакторлан ажилласан байна.

Хоёр.АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС


• АНУ-ын “Black’s law dictionary”-ийн тухай

Блэкийн хуулийн толь бичиг нь АНУ-д хамгийн өргөн хэрэглэгддэг хуулийн толь бичиг юм.

Хенри Кэмпбелл Блэк³⁵⁹ (1860-1927) нь Нью-Йоркийн Оссинин хотод төрсөн бөгөөд 1917 оноос 1927 он буюу нас барах хүртлээ “Үндсэн хуулийн тойм” сэтгүүлийн эрхлэгчээр ажилласан байна.

Хенри Кэмпбелл Блэк (Henry Campbell Black) 100 гаруй жилийн өмнө буюу 1891 онд Блэкийн хуулийн толь бичгийн анхны хувилбарыг хэвлүүлсэн. Энэ толь бичиг нь АНУ-д хуульчид болон хуулийн оюутнуудын дунд эрт дээр үеэс хууль зүйн эцсийн толь бичиг хэмээн тооцогдож ирсэн. Блэкийн хуулийн толь бичгийн 2 дахь удаагийн хэвлэл 1910 онд хэвлэгдсэн бөгөөд www.thelawdictionary.org³⁶⁰ сайт нь Блэкийн хуулийн толь бичгийн 2 дахь удаагийн хэвлэлтийг өөрчлөгдөөгүй, засварлагдаагүй хэлбэрээр олон нийтэд нээлттэй, үнэ төлбөргүй хүргэдэг юм. Уг толь бичигт 15 мянга гаруй хууль, эрх зүйн нэр томьёо бий.

Өнөөдөр энэхүү ном нь хууль эрх зүйн шилдэг эх сурвалж гэж хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд олон мянган хуульч, хуульч мэргэжлээр суралцах хүсэлтэй хүмүүст сургалт, судалгааны чухал эх сурвалж болдог.



Тэрээр хуулийн толь бичгийн редактороор ажиллахаас гадна хууль эрх зүйн нууцлаг асуудлууд, цаг үеэ олсон улс төрийн асуудлыг хөндсөн 1000 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байна. Түүний амжилтыг үнэлж 1917 онд Хүндэт хуульч цол олгосон байна. 1927 онд нас барахдаа тэрээр өөрийн үеийн хамгийн хүчирхэг хууль зүйн сэтгэгчдийн нэг гэдгээрээ хүлээн зөвшөөрөгдсөн байв.

2019 онд Блэкийн толь бичгийн 11 дэх удаагийн хэвлэлт нь хэвлэгдсэн бөгөөд хамгийн практик, өргөн хүрээтэй, эрдэм

³⁵⁹ https://en.wikipedia.org/wiki/Henry_Campbell_Black

шинжилгээний, хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн толь бичигт тооцогддог. Уг толь бичигт хууль, эрх зүйн 55000 гаруй үг, хэллэгийг багтаасан бөгөөд түүхэн болон өнөө цагийн утга агуулгыг нь харьцуулан тайлбарлажээ. Энэ нь ийм төрлийн мэдээлэл өгөх цорын ганц толь бичиг гэдгийг тодотгодог байна.

Мөн Блэкийн хуулийн толь бичгийн 11 дэх удаагийн хэвлэлт нь amazon.com онлайн худалдааны компанийн Хуулийн толь бичиг, нэр томъёоны шилдэг борлуулалттай номын жагсаалтын нэгдүгээрт, Толь бичгийн шилдэг борлуулалттай номын жагсаалтын 11-т³⁶¹ тус тус орсон байна.

Блэкийн хуулийн толь бичгийн 11 дэх удаагийн хэвлэлд хариуцлага, урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах, кибер хүч, Исламын хууль, Еврей хууль, хууль зүйн ёс суртахуун, хууль зүйн үндэслэл, ёс суртахууны тэгш байдал, эрхийг сахиулах, алсаас удирдан явуулах дайн, босогчдын эрх зэрэг 3500 орчим шинэ нэр томъёог багтаасан байна.

Блэкийн хуулийн толь бичгийн түүх.³⁶²



- 1) Хэнри Кэмпбелл Блэк анх санаачилсан;
- 2) Анхны хэвлэлийг 1891 онд West Publishing Company-д хэвлүүлсэн;
- 3) 1990 онд Centennial Edition нь Westlaw-ээр дамжуулан онлайн хууль, эрх зүйн хайлтын талаар анх удаа мэдээлсэн болно;
- 4) 1999 оны долоо дахь хэвлэлээс хойш Брайан А.Гарнер ерөнхий редактораар ажиллаж байна;
- 5) 1-р боть 1891, 2-р боть 1910, 3-р боть 1933, 4-р боть 1951, 5-р боть 1957, 6-р боть 1968, 7-р боть 1999, 8-р боть 2004, 9-р боть 2009, 10-р боть 2014, 11-р боть 2019 онуудад тус тус шинэчлэгдэн хэвлэгдсэн байна.

Брайан А.Гарнер³⁶³ (Bryan A.Garner) нь 1958 онд төрсөн бөгөөд хуульч, хэл шинжээч юм. Техасын Их Сургуулийн Хуулийн сургуулийг төгсөөд АНУ-ын Давж заалдах шатны тавдугаар шүүхийн шүүгч Томас М.Ривли (Thomas M. Reavley)-ийн нарийн бичгийн даргаар ажлын гараагаа эхэлсэн. Тэрээр 25 гаруй номын зохиогч бөгөөд хамгийн алдартай нь Гарнерын орчин үеийн англи хэлний хэрэглээ, Уншлагын хууль: Хуулийн текстийн тайлбар, Блэкийн хуулийн толь бичгийн хэвлэлүүд орно.

Түүний номнуудыг Америкийн бүх шатны шүүхүүд, тэр дундаа АНУ-ын Дээд шүүх байнга эш татдаг.

Гарнер Өмнөд Методист Их Сургуулийн Эрдэм шинжилгээний хүндэт профессороор ажилладаг бөгөөд Техасын Их Сургуулийн Хуулийн сургууль, Техасын А&М Хуулийн сургууль, Техасын Техникийн хуулийн сургуульд цагаар багшилдаг.

Гарнер 1992 оноос хойш АНУ-ын Хуулийн хүрээлэнгийн гишүүн бөгөөд тус хүрээлэнгийн дүрмийн зөвлөлийн хорооны ахлах хянагчаар ажиллаж байна. 1992-1999 онд тэрээр АНУ-ын Шүүхийн Бага хурлын Байнгын хорооны холбооны дүрэм, журмыг өөрчлөхөд ажилласан бөгөөд Калифорни, Техас зэрэг бусад муж улсын шүүхийн дүрмийг шинэчилсэн байна.

³⁶¹ <https://www.amazon.com/Best-Sellers-Books-Law-Dictionaries>

Terminology/zgbs/books/10845/ref=zg_bs_nav_books_2_10777

³⁶² <https://legal.thomsonreuters.com/en/products/law-books/blacks-law-dictionary>

³⁶³ <https://lawprose.org/bryan-garner/>

Санал:

Хууль зүйн нэр томъёог эрхлэн гаргаж, хэрэглэж байгаа талаарх олон улсын туршлага, монголын нөхцөлтэй уялдуулан дараах саналыг дэвшүүлж байна.

- **Толь бичгийг эрхлэн гаргах субъектийн хувьд:**

Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” гэж Монгол Улсын Дээд шүүхийн бүрэн эрхийг тогтоож өгсөн, мөн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх хэсэгт Улсын дээд шүүх, түүний бүрэн эрхийг “шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх” гэж тус тус заасан байдаг. Иймд Монгол Улсын Дээд шүүхийн санаачилга дор эрхлэн хэвлэх.

- **Толь бичиг бэлтгэх багийн хувьд:**

Дагнасан шүүх буюу эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шүүгчид, хууль, эрх зүйн салбарын багш, эрдэмтэн, судлаачид, хуульч, өмгөөлөгчдийн бүрэлдэхүүн бүхий хамтарсан баг онол, практикийн хэрэглээнд үндэслэн нэр томьсоны толийг боловсруулах.

Энэ нь салбарт үйл ажиллагаа явуулж байгаа болон суралцаж буй хэн бүхний хэрэгцээ шаардлагыг хангаж хүлээн зөвшөөрөгдөх боломжтой.

- **Хугацааны хувьд:**

Толь бичгийг тогтмол хугацаанд буюу дунджаар 2-5 жилийн давтамжтай шинэчилж хууль зүйн салбар дахь шинэ ойлголт, шинэ нэр томъёо, хуулийн тайлбаруудыг тухай бүр олон нийтэд хүргэх боломжийг бүрдүүлэх.

- **Хүртээмж хэрэглээний хувьд:**

Цаасан болон цахим хэлбэрээр хослуулан гаргаж толь бичгийг хэрэглээний ямар ч нөхцөлд хялбар, шуурхай байдлаар судлах эх сурвалж болгон ашиглах нөхцөлийг бүрдүүлэх.

Веберийн хуулийн толь бичгийн 15-21 дэх хэвлэлийг агуулгын адил түвшинд CD-ROM дээр буюу “DIGITAL” хэлбэрээр хэвлэн олон нийтэд хүргэсэн бөгөөд “Ковид-19 цар тахал”-ын улмаас шаардлагатай шинэчлэлийн ажлуудыг хийн цахим хэлбэрээр хэвлэн нийтэлж эхэлсэн байна. Монгол Улсын хувьд мөн адил Хууль зүйн толь бичгийг эмхтгэн гаргахдаа зөвхөн цаасан хэвлэлээр хязгаарлах биш цахим толь бичиг хэлбэрээр эмхтгэн гаргах нь хэрэглэгчдийн цаг хугацаа хэмнэсэн, ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлсэн зохистой шийдэл болох юм.

- Толь бичигт Шүүхийн шийдвэр, практик түүн дээр үндэслэн гаргасан Монгол Улсын Дээд шүүхийн тайлбарыг хавсаргах;

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Монгол хэлний их тайлбар толь
- Монгол Улсын Хууль зүйн анхны нэвтэрхий толь: эрэлт хэрэгцээ, зорилго, агуулга, ач холбогдол, https://mojha.gov.mn/newmojha/?p=6581#_ftn7
- Вебер (Толь бичиг)-Weber (Rechtswörterbuch)
[https://de.wikipedia.org/wiki/Weber_\(Rechtsw%C3%B6rterbuch\)](https://de.wikipedia.org/wiki/Weber_(Rechtsw%C3%B6rterbuch))
- https://rsw-beck-de.translate.goog/verlag/karriere?_x_tr_sl=de&_x_tr_tl=mn&_x_tr_hl=mn&_x_tr_pto=sc
- <https://thelawdictionary.org/about/>
- https://en.wikipedia.org/wiki/Henry_Campbell_Black
- https://www.amazon.com/Best-Sellers-Books-Law-Dictionaries-Terminology/zgbs/books/10845/ref=zg_bs_nav_books_2_10777
- <https://legal.thomsonreuters.com/en/products/law-books/blacks-law-dictionary>
- <https://lawprose.org/bryan-garner/>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Билгээ, Ц.Ариунаа, Б.Туул

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ

1.Бүгд Найрамдах Сингапур Улс

- 1.1.Төрийн тогтолцоо
- 1.2.Гүйцэтгэх засаглал
- 1.3.Засгийн газар (Танхим)-ын бүтэц

2.Бүгд Найрамдах Финланд Улс

- 2.1.Төрийн тогтолцоо:
- 2.2.Гүйцэтгэх засаглал
- 2.3.Засгийн газрын бүтэц

3.Бүгд Найрамдах Эстони Улс

- 3.1.Төрийн тогтолцоо
- 3.2.Гүйцэтгэх засаглал
- 3.3.Засгийн газрын бүтэц

4.Норвегийн Хаант Улс

- 4.1.Төрийн тогтолцоо
- 4.2.Гүйцэтгэх засаглал
- 4.3.Засгийн газар (Төрийн зөвлөл)-ын бүтэц

5.Шведийн Хаант Улс

- 5.1.Төрийн тогтолцоо
- 5.2.Гүйцэтгэх засаглал
- 5.3.Засгийн газрын бүтэц

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ



СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгааны захиалгын дагуу Сингапур, Финланд, Эстони, Норвег, Швед зэрэг улсуудын Засгийн газрын бүтцийн талаарх мэдээлэл лавлагааг УИХ-ын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

1) Төрийн тогтолцооны онцлог:

Судалгаанд хамрагдсан улсууд нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс хэдий ч, тэдгээрээс 3 улс нь парламентын бүгд найрамдах засаглалтай (Сингапур, Финланд, Эстони), 2 улс нь үндсэн хуульт хаант засаглалтай (Норвег, Швед) байна.

Парламентын бүгд найрамдах засаглал (parliamentary republic) нь бүгд найрамдах улсын засаглалын үндсэн хэлбэр бөгөөд дараах онцлох эрхийг хэрэгжүүлнэ:

- Парламент нь Засгийн газрыг бүрдүүлэх, түүнд улс төрийн хариуцлага тооцох онцгой эрхтэй, зарим улсад ерөнхийлөгчийг сонгох эрхтэй;
- Парламент нь Засгийн газарт үл итгэж байгаагаа илэрхийлбэл, Парламентын олонхын саналаар Засгийн газрыг огцруулах эрхтэй;
- зайлшгүй тохиолдолд Ерөнхийлөгч нь Парламентыг тараах ба хугацаанаас өмнө сонгууль зарлах эрхтэй.

Үндсэн хуульт хаант засаглал (constitutional monarchy) нь дараах шинжээр тодорхойлогдоно:

- Хааны эрх мэдлийг Үндсэн хуулиар хязгаарлагдсан;
- Хууль тогтоох сонгуульт байгууллага буюу парламенттай;
- Хараат бус, бие даасан шүүхтэй.

2) Засгийн газрын нэршлийн хувьд:

Судалгаанд хамрагдсан улсуудад Засгийн газрыг янз бүрээр нэрлэж байна. Тухайлбал, Засгийн газар (Финланд, Швед, Эстони), Танхим (Сингапур), Төрийн зөвлөл (Норвег) гэх мэт.

Зарим улсуудад Засгийн газрыг байгуулах тогтолцооны хувьд Парламентын сонгуулийн үр дүнд Парламентад олонх болсон нам (эвсэл)-ын дарга Ерөнхий сайдаар сонгогдох бөгөөд Ерөнхий сайдын томилсон сайд нар нэг танхим болж хамтын шийдвэр гаргаж, үйл ажиллагаагаа Парламентын өмнө хариуцан тайлагнадаг байна.

Судалгаанд авагдсан улсуудын хувьд гүйцэтгэх мэдлийг хэрэгжүүлэх субъектын тогтолцоо харилцан ялгаатай байна. Тухайлбал, гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгч хэрэгжүүлдэг (Сингапур), Хаан нь Засгийн газартай хамтран хэрэгжүүлдэг (Норвег), Ерөнхий сайдыг Ерөнхийлөгч нь томилдог (Сингапур, Финланд, Эстони), гүйцэтгэх эрх мэдлийг өөр этгээдэд өгч болох (Сингапур) гэх мэт онцлогтой байна.

3) Засгийн газрын бүтцийн онцлог:

Судалгаанд хамрагдсан улсуудын Засгийн газрын бүтцийг авч үзвэл, Сингапур, Норвег зэрэг улс 15 яамтай, Финланд, Швед, Эстони зэрэг улс 11 яамтай ажиллаж байна.

Зүүн өмнөд Ази болон хойд Европын орнуудад (нийт 5 улс) нэг яамыг эрхлэх асуудлын цар хүрэнээс нь хамаарч 2-3 сайд хариуцан ажиллах тохиолдол байна. Эдгээрээс Эстони Улсыг жишээ болгон авч үзвэл, тус улсын Засгийн газрын 11 яамыг 14 сайд хариуцах ба дараах хоёр яамыг 2 сайд хариуцаж байна:

- Сангийн яам нь Сангийн болон Төрийн удирдлагын гэсэн 2 сайдтай;
- Эдийн засаг, харилцаа холбооны яам нь Эдийн засаг, дэд бүтцийн болон Үйлдвэрлэл, мэдээллийн технологийн гэсэн 2 сайдтай.

Яамдын уялдаа холбоог хангах чиглэлд Сингапур Улсын Засгийн газрын бүтэц бусад улсынхаас ялгаатай байна. Тухайлбал:

- Дотоод хэргийн болон Хууль зүйн яамдыг **нэг сайд** хариуцаж байна;
- **5 сайд өөр яамны дэд сайдын** албан үүргийг хавсран хариуцаж байна –
 - o Нийгэм, гэр бүлийн хөгжлийн сайд нь *Эрүүл мэндийн дэд сайдын*;
 - o Харилцаа холбоо, мэдээллийн сайд нь *Дотоод хэргийн дэд сайдын*;
 - o Соёл, олон нийт, залуучуудын сайд нь *Хууль зүйн дэд сайдын*;
 - o Хүний нөөцийн сайд нь *Худалдаа, үйлдвэрлэлийн дэд сайдын*;
- **Ерөнхий сайдын оффисын 2 сайд яамны дэд сайдын** албан үүргийг хавсран хариуцаж байна:
 - o 1 дэх сайд нь *Сангийн болон Үндэсний хөгжлийн дэд сайдын*;
 - o 2 дахь сайд нь *Боловсролын болон Гадаад хэргийн дэд сайдын*.

Финланд Улсын Ерөнхий сайд нь Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдах шаардлагагүй гэж үзвэл Сайд нарын хороод (Ministerial committees)-ыг хуралдуулж болно. Сайд нарын хороодыг Ерөнхий сайд тэргүүлнэ. Хороо нь сайд нараас бүрдсэн гишүүдтэй байх ба тэд өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудал, эсхүл Ерөнхий сайдын хүсэлтээр асуудлыг хэлэлцэнэ. Тухайлбал:

- **Гадаад байдал, аюулгүйн бодлогын сайдын хороо** (Ministerial Committee on Foreign and Security Policy) нь Финланд Улсын бусад улстай харилцах харилцаа, дотоодын аюулгүй байдал, батлан хамгаалахтай холбоотой үндсэн асуудлуудыг хамаарна;
- **Европын холбооны хэрэг эрхлэх сайдын хороо** (Ministerial Committee on European Union Affairs) нь улс төр, эдийн засаг, хууль эрх зүйн хувьд чухал ач холбогдолтой Европын холбооны асуудлуудыг хамаарна;
- **Сангийн сайдын хороо** (Ministerial Finance Committee) нь эдийн засгийн чухал ач холбогдолтой, эсхүл Сангийн сайдын хорооноос санал авах шаардлагатай асуудлуудыг хамаарна;
- **Эдийн засгийн бодлогын сайдын хороо** (Ministerial Committee on Economic Policy) нь улсын санхүүгийн үндсэн чиглэл, эдийн засгийн ерөнхий хөгжил болон эдийн засгийн бодлогын арга хэмжээ авах шаардлагатай бусад асуудлыг Ерөнхий сайдын шийдвэрээр хамаарна.

УИХ-ЫН
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ**ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ****1.БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС****1.1.Төрийн тогтолцоо**

Бүгд Найрамдах Сингапур Улс нь парламентын засаглалтай бүгд найрамдах улс бөгөөд төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс юм. Тус улсын төрийн тогтолцоо нь хууль тогтоох, гүйцэтгэх шүүх гэсэн засаглалын 3 салаа мөчиртэй хэлбэр буюу Вестминстерийн загвартай:

- 1) **Хууль тогтоох эрх мэдлийг** нэг танхимтай Парламент хэрэгжүүлнэ. Парламент нь үндэсний хууль тогтоомж, улсын төсвийг батлах ба Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина (Үндсэн хуулийн §38).

Одоо 14 дэх удаагийн Парламентын бүрэн эрх хэрэгжиж байгаа бөгөөд 103 гишүүнтэйгээр хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж байна. Парламентын гишүүдийн 92 гишүүн нь нэг мандаттай тойргоос, 2 гишүүн олон мандаттай тойргоос тус тус сонгогдсон бол 9 гишүүн нь намын жагсаалтаар орж ирсэн. 2020 оны Парламентын ээлжит сонгуулийн дүнгээр Ардын хөдөлгөөний нам 69.9 хувийн саналаар 83 суудал авч Парламентад олонх болжээ.

Сингапур Улсын улс төрийн гол хүчин нь Ардын хөдөлгөөний нам бөгөөд 1954 онд байгуулагдаж, 1963 онд тус улс тусгаар тогтносны дараа засгийн эрхэнд анх гарч байжээ. 1959-1991 онд тус намыг Ли Куан Ю (тус улсын анхны Ерөнхий сайд) удирдаж байв.

- 2) **Гүйцэтгэх эрх мэдлийг** Сингапур Улсын Ерөнхийлөгч хэрэгжүүлэх ба энэхүү эрх мэдлийг Ерөнхийлөгч өөрөө, эсхүл Танхим (Засгийн газар), эсхүл Танхимаас эрх олгосон сайд хэрэгжүүлэх ба Парламент нь бусад этгээдэд гүйцэтгэх эрх мэдлээ хэрэгжүүлэх чиг үүргийг өгч болохоор Үндсэн хуулиар зохицуулсан онцлогтой байдаг байна. (§23)

Танхим нь Ерөнхий сайд ба бусад сайд нараас бүрдэж Засгийн газрын ерөнхий удирдлага, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Парламентын өмнө хамтын хариуцлага хүлээнэ. (§24)

1991 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийг 6 жилийн хугацаатай бүх нийтээр сонгодог болсон (улиран сонгогдож болно) байна. 2017 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс тус улсын анхны эмэгтэй Ерөнхийлөгч Халима Якоб ажиллаж байна.

Харин Ерөнхий сайдаар Ардын хөдөлгөөний намын дарга Ли Сянь Лун 2019 оноос хойш ажиллаж байна.

- 3) **Шүүх эрх мэдлийг** тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд заасан Дээд шүүх болон доод шатны шүүхүүдэд олгосон байна. (§93)

1.2. Гүйцэтгэх засаглал

1.2.1. Ерөнхийлөгчийн бүрэн эрх

1965 онд батлагдсан Үндсэн хуулиар³⁶⁴ тус улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. (§17.1) Тэрээр зэвсэгт хүчний ерөнхий командлагч³⁶⁵ байх ба Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс бусад хуулийн төсөлд хориг тавих эрхтэй.

1991 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бэлэг тэмдгийн шинжтэй байсан Ерөнхийлөгчийн эрх, үүрэгт зарим нэмэлт, өөрчлөлт орсон ба тэрээр бүрэн эрхээ дараах гурван чиглэлээр хэрэгжүүлнэ:³⁶⁶

- 1) **Танхим, эсхүл Танхимаас эрх олгосон сайдын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх Ерөнхийлөгчийн бүрэн эрх** –Танхим нь Засгийн газар, түүний бодлогыг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавих бөгөөд Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын өгсөн зөвлөмжийн дагуу Засгийн газрын эрхлэх асуудлын хүрээний асуудлаар үйл ажиллагаагаа явуулахаар Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд заасан байдаг.

Ерөнхийлөгч тодорхой нөхцөлд дараах байдлаар Танхимаас хараат бусаар эрх мэдлээ хэрэгжүүлнэ:

- 2) **Ерөнхийлөгчийн зөвлөхүүдийн зөвлөл (Council of Presidential Advisers)-тэй зөвлөлдсөний үндсэн дээр өөрийн үзэмжээр хэрэгжүүлэх бүрэн эрх** – Тухайлбал, Ерөнхийлөгч нь Танхимд Сингапурын санхүүгийн нөөц (Singapore's financial reserves)-ийг ашиглах зөвшөөрлийг олгоно. Сингапурын санхүүгийн нөөц бол олон жилийн турш хуримтлагдсан тус улсын санхүүгийн нөөц хөрөнгө бөгөөд Ерөнхийлөгч тэрхүү нөөцийг зарцуулах зөвшөөрөл олгохдоо Ерөнхийлөгчийн зөвлөхүүдийн зөвлөл (Council of Presidential Advisers)-тэй зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэх ба хэрэв Сингапур Улсын ашиг сонирхолд харшилж байна гэж үзвэл уг нөөцийг ашиглахыг зөвшөөрөхгүй.

Энэхүү хамгаалах механизм (safeguard mechanism)-ыг анх 2009 онд хэрэгжүүлж байжээ. Тухайн үеийн Засгийн газар дэлхийн санхүүгийн хямралын эсрэг тусгай бодлогыг санхүүжүүлэхийн тулд Сингапурын санхүүгийн нөөцийг ашиглахаар шийдвэрлэсэн байна. Тухайн үеийн Ерөнхийлөгч С.Р.Натан уг нөөцөөс 4.9 тэрбум доллар авах зөвшөөрөл олгосноор ажлын байр хадгалах зорилготой “Ажлын байрны зээл олгох хөтөлбөр” (Jobs Credit Scheme)-ийг санхүүжүүлжээ.

- 3) **Ерөнхийлөгчийн өөрийн үзэмжээр хэрэгжүүлэх бүрэн эрх** (Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээний асуудлууд):

Төрийн албан хаагчдыг томилно:

- Ерөнхий шүүгч, давж заалдах шатны шүүгчид, Дээд шүүхийн шүүгч зэрэг шүүх байгууллагын ерөнхий болон ахлах зэргийн шүүгчдийг;
- ерөнхий прокурорыг;
- Ерөнхийлөгчийн дэргэдэх цөөнхийн эрхийн болон шашны зөвлөлийн дарга, гишүүдийг;

³⁶⁴ Constitution of the Republic of Singapore. 2020 revised edition. <https://sso.agc.gov.sg/Act/CONS1963>

³⁶⁵ Сингапурын зэвсэгт хүчний тухай хууль (Singapore Armed Forces Act).

³⁶⁶ A Guide to the Singapore Constitution (2nd ed.). Edited by Grace Morgan. 2016. 33 дахь тал.

- Төрийн албаны болон Шүүхийн комиссын удирдлагууд болон гишүүдийг;
- Ерөнхий аудитор болон Ерөнхий нягтлан бодогчийг;
- батлах хамгаалахын болон армийн холбогдох удирдлагуудыг;
- Цагдаагийн болон Авлигатай тэмцэх газрын удирдлагуудыг;
- бусад албан тушаалтнуудыг.

Засгийн газрыг авлигаас ангид байлгахад Ерөнхийлөгчийн оролцоо чухал байдаг. Тухайлбал, Авлигатай тэмцэх газрын дарга Ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр тодорхой хяналт шалгалт явуулах ба энэ үед Танхимын зүгээс түүнд саад хийх гэж оролдвол Ерөнхийлөгч өөрийн үзэмжээр асуудлыг шийдвэрлэнэ. Хэрэв Ерөнхийлөгч өөрөө хүсвэл Ерөнхийлөгчийн зөвлөхүүдийн зөвлөлтэй зөвлөлдөж болно.

Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн зарим шийдвэрийг тухайлбал, Сингапурын санхүүгийн нөөцийг ашиглах зөвшөөрлийг Парламент хүчингүй болгох эрхтэй. Парламентын нийт гишүүдийн 2/3-оос доошгүйн саналаар Ерөнхийлөгчийн шийдвэрийг хүчингүй болгоно. (Үндсэн хуулийн §371F)

1.2.2. Танхимыг бүрдүүлэх, огцруулах

Гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгчөөс гадна Танхим хэрэгжүүлнэ. Танхим нь төрийн өдөр тутмын хэргийг удирдана.

Танхимын гишүүд ямар нэгэн ашгийн төлөө бизнес эрхлэх, эсхүл аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг хориглох бөгөөд сайдын ажил, үүргийг бүтэн цагаар (full time) үр дүнтэй гүйцэтгэх үүргийг хүлээдэг.³⁶⁷

Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдад Парламентын гишүүд дундаас нэр дэвшүүлэн олонхын санал авсан хүнийг Ерөнхий сайдаар томилно. Практик дээр Ерөнхийлөгч нь Парламентад хамгийн олон суудал авсан улс төрийн намын даргыг Ерөнхий сайдад нэр дэвшүүлдэг.

Мөн Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын санал болгосноор Парламентын гишүүдээс Танхимын бусад гишүүдийг томилно. (§25)

Ерөнхийлөгч нь дараах тохиолдолд Ерөнхий сайдын албыг сул гэж зарлана (§26.1):

- Ерөнхий сайд албан тушаалаасаа огцрох тухай хүсэлтээ Ерөнхийлөгчид хандан бичгээр гаргасан бол;
- Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдыг Парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээхгүй болсон гэж үзсэн бол.

Сайд нар албан тушаалаасаа дараах тохиолдолд чөлөөлөгдөнө (§26.2):

- Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч тухайн сайдын албан тушаалд томилсон зарлигийг хүчингүй болгосон бол;
- тухайн сайд албан тушаалаасаа огцрох тухай хүсэлтээ Ерөнхийлөгчид хандан бичгээр гаргасан бол.

Ерөнхий сайд нь биеийн эрүүл мэнд, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар Сингапур Улсад байхгүй, эсхүл Үндсэн хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу үүрэгт ажлаасаа түр чөлөө авсан (түр эзгүй) бол Ерөнхийлөгч Ерөнхий сайдын чиг үүргийг Танхимын аль нэг сайдад олгоно (олгосон чиг үүргийг зарлигаар хүчингүй болгоно).

³⁶⁷ Мөн тэнд. 36 дахь тал.

1.2.3. Ерөнхийлөгчийн зөвлөхүүдийн зөвлөл

1991 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчид Сингапурын санхүүгийн нөөц болон төрийн албаны шударга байдлыг хамгаалах бүрэн эрхийг олгосон байна. Ерөнхийлөгчийн зөвлөхүүдийн зөвлөл (Council of Presidential Advisers) нь Ерөнхийлөгчид эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай зөвлөгөө өгөх үүрэгтэй.

Зөвлөл нь 8 гишүүн, 2 орлогч гишүүнтэй. Зөвлөлийн гишүүдийг Ерөнхийлөгч 6 жилийн хугацаатай томилох бөгөөд Ерөнхийлөгч 3 гишүүнийг томилох бол Ерөнхий сайд 2 гишүүнийг, Ерөнхий шүүгч болон Төрийн албаны зөвлөл (Public Service Commission)-ын дарга тус бүр 1 гишүүнийг нэр дэвшүүлнэ.

Орлогч гишүүдийн хувьд, Ерөнхийлөгч 1 орлогч гишүүнийг томилно. Харин нөгөө орлогч гишүүнийг нь Ерөнхийлөгч Ерөнхий сайдын зөвлөсний дагуу, Ерөнхий шүүгч, Төрийн албаны зөвлөлийн даргатай зөвшилцсөний үндсэн дээр томилно.

Энэхүү тогтолцоо нь Ерөнхийлөгчийн зөвлөхүүдийн зөвлөлийн төвийг сахих статусыг баталгаажуулдаг байна.³⁶⁸

1.2.4. Ерөнхий прокурор

Сингапур Улсын Засгийн газрын өөр нэг онцлог бол Ерөнхий прокурор (Attorney-General) улсын яллагчаас гадна Засгийн газрын хуулийн ахлах зөвлөхийн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Тэрээр Засгийн газарт хууль зүйн зөвлөгөө өгөх, гэрээний төсөл боловсруулах, баталгаажуулах, иргэний (эрүүгийн бус) шүүхэд төрийг төлөөлнө.

1.3. Засгийн газар (Танхим)-ын бүтэц

Үндсэн хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу Ерөнхий сайд нь сайд нарыг томилох, тэдний хариуцсан асуудлыг тодорхойлсон Мэдэгдэл (Notification)³⁶⁹ гаргадаг. Одоогийн Ерөнхий сайдын гаргасан Мэдэгдэл 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болжээ.

Танхим нь Ерөнхий сайдаас гадна 22 сайдын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна:

- Шадар сайд (Deputy Prime Minister) бөгөөд эдийн засгийн бодлого зохицуулах сайд;
- Тэргүүн сайд (Senior Minister) бөгөөд үндэсний аюулгүй байдлын бодлого зохицуулах сайд;
- Тэргүүн сайд (Senior Minister) бөгөөд нийгмийн бодлого зохицуулах сайд;
- яамд хариуцсан 14 сайд;
- Ерөнхий сайдын оффисын 2 сайд;
- Улсын тэргүүн 3 сайд (Senior Minister of State) багтаж байна.

Засгийн газрын 15 яамыг 14 сайд хариуцан ажилладаг.

Яамдын чиг үүргийн хүрээнд:

- Батлан хамгаалах яам (Ministry of Defence): Сингапур Улсын энх тайван, аюулгүй байдлыг дипломат аргаар бэхжүүлэх, түрэмгийлэгчдэд хариу цохилт өгөх зорилготой бөгөөд иргэний батлан хамгаалах бэлтгэлжилтийг хангах, батлан хамгаалах, аюулгүй байдал, зэвсэгт хүчний бодлогыг хариуцна.

³⁶⁸ Мөн тэнд. 35 дахь тал.

³⁶⁹ Constitution of the Republic of Singapore (Ministerial Responsibility) Notification 2020.
<https://sso.agc.gov.sg/SL/CONS1963-S723-2020?DocDate=20220110&ProvIds=av-#av->

- Боловсролын яам (Ministry of Education): Сингапур Улсын ирээдүйг тодорхойлох иргэдийг сургаж, улс орны ирээдүйг төлөвшүүлэх зорилготой бөгөөд шинжлэх ухааны болон бүх шатны боловсролын хөтөлбөр, боловсролын байгууллагуудыг хариуцна.
- Гадаад хэргийн яам (Ministry of Foreign Affairs): Сингапур Улсын ашиг сонирхлыг дипломат арга замаар гадаад орчинд хамгаалах зорилготой бөгөөд дипломат ба консулын корпус, олон улсын байгууллагууд, хилийн чанад дахь байгууллагууд, Сингапурын хамтын ажиллагааны хөтөлбөрийг хариуцна.
- Нийгэм, гэр бүлийн хөгжлийн яам (Ministry of Social and Family Development): Хөрвөх чадвартай хувь хүн, хүчирхэг гэр бүл, халамжтай нийгмийг төлөвшүүлэх зорилготой бөгөөд хүүхэд, гэр бүлийн хамгаалал, хөгжил, нийгмийн салбарын хөгжил, тэдгээрийг дэмжих үйчилгээнүүд, эмэгтэйчүүдийн хөгжлийн асуудлыг хариуцна.
- Сангийн яам (Ministry of Finance): Санхүүгээр дамжуулан илүү сайн Сингапур Улсыг бий болгох зорилготой бөгөөд төрийн санхүүгийн үйл ажиллагаа, Засгийн газрын санхүүгийн удирдлага, ААН-ын бүртгэл, нягтлан болох бүртгэл, татварын орлого бүрдүүлэлтийг хариуцна.
- Соёл, олон нийт, залуучуудын яам (Ministry of Culture, Community and Youth): Урлаг, спортоор дамжуулан Сингапурын иргэдэд урам зориг өгөх, олон нийтийн холбоог бэхжүүлэх, сайн дурын ажлыг дэмжих зорилготой бөгөөд олон нийтийн урлаг, спортын үйл ажиллагаа, шашин болон залуучуудын асуудлыг хариуцна.
- Тогтвортой хөгжил, байгаль орчны яам (Ministry of Sustainability and the Environment): Цэвэр, тогтвортой орчин, ус, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилготой бөгөөд байгаль орчныг хамгаалах, нийгмийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, усны нөөцийн асуудлыг хариуцна.
- Тээврийн яам (Ministry of Transport): Сингапур Улсын тээврийн ложистикийг бэхжүүлж, эдийн засгийн өрсөлдөх чадвар, амьдралын чанарыг дээшлүүлэх, тээврийн салбарын чадавхыг хөгжүүлэх зорилготой бөгөөд бүх төрлийн тээврийн салбарын бодлого, олон улсын тээвэр, хамтын ажиллагааг хариуцна.
- Үндэсний хөгжлийн яам (Ministry of National Development) Дэлхийн жишигт нийцсэн дэд бүтцийг хөгжүүлэх зорилготой бөгөөд тогтвортой хөгжил, газар ба хот байгуулалт, хотын үйлчилгээ зэрэг асуудлыг хариуцна.
- Харилцаа холбоо, мэдээллийн яам (Ministry of Communications and Information): Хүмүүсийн амьдралын чанарын сайжруулахын тулд хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийгэмлэгүүдийг дэмжих зорилготой бөгөөд хэвлэл мэдээлэл, шуудангийн дэд бүтэц, төрийн албан хэрэг хөтлөлт, номын сангийн асуудлыг хариуцна.
- Худалдаа, үйлдвэрлэлийн яам (Ministry of Trade and Industry): Эдийн засгийн өсөлтийг дэмжих, сайн ажлын байр бий болгох, Сингапурын иргэдэд амьдралаа сайжруулах боломж олгох зорилготой бөгөөд өрсөлдөөн, хэрэглэгчдийн эрх ашиг, стратегийн бараа бүтээгдэхүүний хяналт, эдийн засгийн төлөвлөлт, хөгжил, үйлдвэрлэл зэрэг асуудлыг хариуцна.
- Хүний нөөцийн яам (Ministry of Manpower): Бүтээмжтэй ажиллах хүч, дэвшилтэт ажлын байрыг хөгжүүлж, Сингапур Улсын иргэдийг илүү сайн ажлын байртай болгож, баталгаатай тэтгэвэрт гарах боломж бүрдүүлэх зорилготой

- бөгөөд хүний нөөцийн салбарын хөгжил, ажилчдын нийгмийн асуудал, хөдөлмөр эрхлэлтийн стандартууд, гадаад ажиллах хүчний бодлогыг хариуцна.
- Эрүүл мэндийн яам (Ministry of Health): Эрүүл мэндийг дэмжих, өвчлөлийг бууруулах, Сингапурчуудын хэрэгцээнд нийцсэн чанартай, хямд өртөгтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг хангах, шинэлэг, хүн төвтэй байх зорилготой бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ түүний санхүүжилт, салбарын хүний нөөц, эрүүл мэндийн бодлогын асуудлыг хариуцна.
 - Дотоод хэргийн яам (Ministry of Home Affairs): Сингапурыг аюулгүй, найдвартай, шилдэг улс болгохын тулд олон нийттэй хамтран нэг баг болж ажиллах зорилготой бөгөөд иргэншил, иргэний бүртгэл, цагаачлал, иргэний хамгаалал, гэмт хэрэг, зөрчил, хилийн хамгаалалт зэрэг асуудлыг хариуцна.
 - Хууль зүйн яам (Ministry of Law): Хууль тогтоомжоор дамжуулан шударга ёс, хууль дээдлэх ёсыг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд шүүх засаглал ба шүүх байгууллага, олон нийтийн маргаан, оюуны өмч, олон улсын эрх зүй, газрын асуудал, хууль зүйн туслалцаа, үйлчилгээ зэрэг асуудлыг хариуцдаг.

Танхимын зарим гишүүдийн эрхлэх асуудлын онцлогийг авч үзвэл:

Тухайлбал, Дотоод хэргийн болон Хууль зүйн яамдыг **нэг сайд** хариуцаж байна:

- зарим **сайд өөр яамны дэд сайдын** албан үүргийг хавсран хариуцаж байна:
 - Нийгэм, гэр бүлийн хөгжлийн сайд нь *Эрүүл мэндийн дэд сайдын*;
 - Харилцаа холбоо, мэдээллийн сайд нь *Дотоод хэргийн дэд сайдын*;
 - Соёл, олон нийт, залуучуудын сайд нь *Хууль зүйн дэд сайдын*;
 - Хүний нөөцийн сайд нь *Худалдаа, үйлдвэрлэлийн дэд сайдын*;
- **Ерөнхий сайдын оффисын 2 сайд яамны дэд сайдын** албан үүргийг хавсран хариуцаж байна:
 - 1 дэх сайд нь *Сангийн болон Үндэсний хөгжлийн дэд сайдын*;
 - 2 дахь сайд нь *Боловсролын болон Гадаад хэргийн дэд сайдын*;
- **Улсын тэргүүн 3 сайд** тус бүр 2 яамыг хариуцаж байна:
 - 1 дэх сайд нь *Гадаад хэргийн болон Үндэсний хөгжлийн яамдыг*;
 - 2 дахь сайд нь *Харилцаа холбоо, мэдээллийн болон Эрүүл мэндийн яамдыг*;
 - 3 дахь сайд нь *Батлан хамгаалах болон Хүний нөөцийн яамдыг* хариуцан ажиллаж байна.

2. БҮГД НАЙРАМДАХ ФИНЛАНД УЛС

2.1. Төрийн тогтолцоо:

Бүгд Найрамдах Финланд Улсын Үндсэн хууль³⁷⁰ нь 1999 оны 06 дугаар сарын 11-ний өдөр батлагдаж, 2000 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд Төрийн тогтолцоог тусгасан байна. Үүнд:

- 1) **Хууль тогтоох** дээд байгууллага нь нэг танхимтай, 200 гишүүнтэй парламент байх бөгөөд улсын эдийн засгийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

³⁷⁰ Constitution of Finland. <https://oikeusministerio.fi/en/constitution-of-finland>

Парламентын гишүүдийг хувь тэнцүүлэн, нууц санал хураалтаар шууд сонгох бөгөөд нэг бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна. (Үндсэн хуулийн §24; 25)

2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр явагдсан Парламентын сонгуулийн дүнгээр Социал демократ нам 17,7 хувиар хамгийн их санал буюу 40 суудал авчээ.³⁷¹ Түүний дараа Финландын нам 17,5 хувийн (39 суудал), Үндэсний эвсэл нам 17,0 хувийн (38 суудал) санал тус тус авсан нь анх удаагаа аль ч нам 20 хувиас дээш санал аваагүй байна.

- 2) **Гүйцэтгэх эрх мэдлийг** Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч ба Засгийн газар хэрэгжүүлнэ. Засгийн газар нь Парламентын итгэлийг хүлээсэн байна.

Одоогийн 12 дахь Ерөнхийлөгч Саули Ниинистё нь 2012 оны 03 дугаар сарын 01-ний өдөр тангаргаа өргөж байсан бөгөөд 2018 оны 01 дүгээр сард дахин зургаан жилийн хугацаатай сонгогдсон байна.

2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч тус улсын 76 дахь Засгийн газрын Ерөнхий сайдаар Санна Мариныг (Социал демократ намын дарга) томилсон байна. Санна Марин Засгийн газраа Төвийн нам, Ногоон лиг, Зүүний хүчний холбоо, Шведийн ардын намтай эвсэж байгуулжээ.

- 3) **Шүүх эрх мэдлийг** бие даасан шүүхүүд хэрэгжүүлдэг бөгөөд Дээд шүүх, Захиргааны хэргийн дээд шүүх нь шүүх эрх мэдлийн дээд байгууллага юм.

2.2. Гүйцэтгэх засаглал

2.2.1. Ерөнхийлөгчийг сонгох ба түүний эрх, үүрэг

Үндсэн хуулийн 54 дүгээр зүйлд зааснаар тус улсын Ерөнхийлөгчийг 6 жилийн хугацаагаар дараах журмаар бүх ард түмнээс шууд сонгоно:

- нийт сонгогчдын талаас илүү санал авсан байна;
- хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч олонхын санал авч чадаагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн хооронд дахин сонгууль явуулж, хамгийн олон санал авсан нэр дэвшигч ерөнхийлөгчөөр сонгогдоно;
- хэрэв Ерөнхийлөгчийн сонгуульд нэг хүний нэрийг дэвшүүлбэл, түүнийг сонгуульгүйгээр Ерөнхийлөгчид томилно;
- Парламентад суудалтай аль ч улс төрийн нам, мөн 20000 гишүүнтэй аль ч бүлэг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх эрхтэй;
- нэг хүн Ерөнхийлөгчөөр хоёроос илүүгүй удаа дараалан сонгогдож болно.

Үндсэн хуулийн 58 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн шийдвэртэй холбоотой харилцааг юхицуулсан байна:

- Ерөнхийлөгч Засгийн газраас оруулсан саналыг үндэслэн Засгийн газарт шийдвэр гаргана.
- Засгийн газраас оруулсан саналын дагуу Ерөнхийлөгч шийдвэр гаргахгүй бол уг асуудлыг Засгийн газарт буцааж, Ерөнхийлөгчид дахин оруулах ажлыг хангана.
- дээрх тохиолдолд хууль батлах, албан тушаалтан томилохтой холбоогүй бусад асуудлыг Засгийн газар Парламентад таницуулж болно

⁷¹ Politico research - <https://www.politico.eu/europe-poll-of-polls/finland/>

- үүний дараа Засгийн газраас санал гаргавал уг танилцуулгын үндсэн дээр асуудлыг Парламент шийдвэрлэнэ

Ерөнхийлөгч дор дурдсан асуудлыг Засгийн газрын саналгүйгээр шийдвэрлэнэ:

- Засгийн газар, сайдыг томилох, эсхүл огцруулах;
- Парламентын ээлжит бус сонгууль явуулах тухай захирамж гаргах;
- өршөөл үзүүлэх;
- хуулиар тусгайлан тогтоосон бөгөөд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх шаардлагагүй бусад асуудал шийдвэрлэх;
- Аландын автономийн тухай хуульд заасан Аландын санхүүтэй холбоотойгоос бусад асуудлыг шийдвэрлэх.

Ерөнхийлөгч нь батлан хамгаалахын асуудалтай холбоотой шийдвэрийг холбогдох сайдын оролцоотойгоор гаргана.

2.2.2. Засгийн газрыг бүрдүүлэх ба түүний эрх, үүрэг

Засгийн газар нь Ерөнхий сайд болон шаардлагатай тооны бусад сайдаас бүрдэх ба сайд нар нь үнэнч шударга, ур чадвараараа олон нийтэд танигдсан Финланд Улсын иргэд байхыг Үндсэн хуулийн 60 дугаар зүйлд заажээ.

Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлд заасан журмаар Ерөнхий сайдыг Парламентаас сонгож, Ерөнхийлөгч томилно. Үүнд:

- Ерөнхий сайдыг сонгохоос өмнө Парламент дахь намын бүлгүүд Засгийн газрын хөтөлбөр болон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг зөвшилцөнө;
- зөвшилцлийн дүнд Ерөнхийлөгч нь Парламентын даргын саналыг сонссоны дараа Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Парламентад танилцуулна;
- Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Парламентын ил санал хураалтаар сонгох ба санал хураалтад оролцсон нийт гишүүдийн талаас илүү хувийн саналаар дэмжигдсэн тохиолдолд Ерөнхий сайдаар сонгогдоно;
- нэр дэвшигч шаардлагатай олонхын санал авч чадаагүй бол дээрх журмын адил Ерөнхий сайдад шинээр нэр дэвшүүлнэ;
- шинэ нэр дэвшигч мөн шаардлагатай олонхын санал авч чадаагүй бол Парламентын нээлттэй санал хураалтаар Ерөнхий сайдыг сонгоно. Энэ тохиолдолд хамгийн олон санал авсан хүнийг Ерөнхий сайдад сонгогдсонд тооцно.

Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын санал болгосноор бусад сайд нарыг томилно.

Ерөнхийлөгч хүсэлтийн дагуу Засгийн газрыг, эсхүл аль нэг сайдыг огцруулахыг хүлээн зөвшөөрдөг. Ямар ч тохиолдолд тэрээр Парламентын итгэлийг хүлээхгүй бол Засгийн газрыг, эсхүл аль нэг сайдыг огцруулна. Мөн Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын санал болгосноор аль нэг сайдыг огцруулж болно. (§64)

Зөвхөн Парламентын чуулганы хугацаанд Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох, түүнд томоохон өөрчлөлт оруулах боломжтой. (§61)

Тус улсын Үндсэн хуульд зааснаар Засгийн газар дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагаа, төрийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн талаар жил бүр Парламентад тайлагнах (§46);

- Парламент, байнгын хороонд шаардлагатай мэдээллийг холбогдох сайд нар цаг алдалгүй гаргаж өгөх (§47);
- Үндсэн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна Засгийн газраас томилогдсон төрийн захиргааны байгууллагуудыг удирдан чиглүүлэх (§65);
- Засгийн газрын нэгдсэн хуралдаанаар Засгийн газар болон яамны чухал шаардлагатай, өндөр ач холбогдолтой асуудлаар шийдвэр гаргах (§66).

Ерөнхий сайд нь Засгийн газрын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцэхээр бэлтгэх, хяналт тавих, Засгийн газрын хуралдааныг даргалах, улсаа Европын Зөвлөлд болон Европын Холбоонд төлөөлж оролцоно. Ерөнхий сайдын эзгүйд Шадар сайд, Шадар сайдын эзгүйд туршлагаараа хамгийн ахмад сайд орлоно. (§66)

2.3.Засгийн газрын бүтэц

2.3.1.Засгийн газрын яамдын бүтэц

Үндсэн хуулийн 68 дугаар зүйлд зааснаар Засгийн газар нь шаардлагатай тооны яамтай байна. Яамдын тоо, нэрийг хуульд заасан байдаг. Одоогийн Засгийн газар 11 яамтай бөгөөд тэдгээрийг 19 сайд удирдаж байна.³⁷² Учир нь зарим яамд нэгээс дээш сайдтай байна.

Тус улсын Засгийн газар нь хамгийн залуу, эмэгтэй Ерөнхий сайдтай бөгөөд хамгийн олон буюу 10 эмэгтэй сайдтай ажиллаж байгаагаараа онцлогтой.

Засгийн газар дараах 11 яамтай:

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (Ministry of the Environment and Climate Change) - Уур амьсгал, байгаль орчин, биологийн төрөл зүйл ба байгалийн нөөцийн зохистой хэрэглээ, байгаль орчныг хамгаалах бодлого дүрэм, журмаар ханган ажиллана.³⁷³
- Батлан хамгаалах яам (Ministry of Defence) - Үндэсний батлан хамгаалах бодлого, үндэсний аюулгүй байдал, түүнчлэн батлан хамгаалах бодлогын асуудлаарх олон улсын хамтын ажиллагааг хариуцан ажиллана.³⁷⁴
- Боловсрол, соёлын яам (Ministry of Education and Culture) - Боловсрол, шинжлэх ухаан, соёл, спорт, залуучуудын бодлогыг хөгжүүлэх, эдгээр салбарт олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг хариуцна.³⁷⁵
- Гадаад хэргийн яам (Ministry for Foreign Affairs) - Гадаад аюулгүй байдлын бодлого, худалдааны бодлого, хөгжлийн бодлого, олон улсын харилцааны асуудлыг хариуцах ба Засгийн газрын бусад салбаруудын олон улсын харилцааг зохицуулахад дэмжлэг үзүүлнэ.³⁷⁶
- Дотоод хэргийн яам (Ministry of the Interior) - Цагдаа, аврах алба, яаралтай тусламжийн төвийн үйл ажиллагаа, хилийн хяналт, эрэн хайх, аврах ажиллагаа, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг хариуцан ажиллана.³⁷⁷
- Зам тээвэр, харилцаа холбооны яам (Ministry of Transport and Communications) - зам тээвэр болон, харилцаа холбоо гэсэн хоёр салбарыг хариуцдаг. Зам

³⁷² Финландын Засгийн газрын цахим хуудас - <https://valtioneuvosto.fi/en/marin/ministers>

³⁷³ <https://ym.fi/en/ministry>

³⁷⁴ https://www.defmin.fi/en/ministry_of_defence#6f7820e2

³⁷⁵ <https://okm.fi/en/marin/minister-of-education>

³⁷⁶ <https://um.fi/frontpage>

³⁷⁷ <https://intermin.fi/en/frontpage>

тээврийн салбарт тээврийн систем, сүлжээ, зорчигч ба ачаа тээвэрлэлт, хөдөлгөөний аюулгүй байдал, уур амьсгал, байгаль орчинтой холбоотой асуудлууд багтдаг. Харилцаа холбооны салбарт харилцаа холбооны сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн хамгаалалт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ зэрэг асуудал хамаарна.³⁷⁸

- Нийгэм, эрүүл мэндийн яам (Ministry of Social Affairs and Health) - Эрүүл мэнд, нийгмийн бодлогыг төлөвлөх, удирдан чиглүүлэх, хэрэгжүүлэх ажлыг хариуцна.³⁷⁹
- Сангийн яам (Ministry of Finance) - Улсын эдийн засаг, төсөв, татвар болон санхүүгийн зах зээлийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.³⁸⁰
- Хөдөө аж ахуй, ойн яам (Ministry of Agriculture and Forestry) - Байгалийн нөөцийг зохистой ашиглах бодлогыг хариуцан ажиллана.³⁸¹
- Хууль зүйн яам (Ministry of Justice) - Хууль эрх зүйн дэг журмыг сахиулах, шүүхийн тогтолцооны хэвийн үйл ажиллагааг хангах асуудлыг хариуцна. Эрх зүйн дэг журам, эрх зүйн хамгаалалтыг хөгжүүлж, ардчиллыг бэхжүүлж, иргэдийн үндсэн эрхийг хамгаалах зорилготой.³⁸²
- Эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн яам (Ministry of Economic Affairs and Employment) -Эдийн засаг, нийгэм, байгаль орчны хувьд тогтвортой өсөлтийг бүрдүүлэх зорилготой. Тус яам нь аж үйлдвэрийн бодлого, инновац, технологийн бодлого, зах зээл, өрсөлдөөнийг дэмжих бодлого, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, хөдөлмөрийн орчны асуудал, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахгүй байх, хамтын гэрээ, хөдөлмөрийн маргааныг арбитр, бүс нутгийн хөгжлийн бодлого, эрчим хүчний бодлого, цаг уурын бодлого зэргийг хариуцна.³⁸³

Засгийн газрын зарим гишүүдийн эрхлэх асуудлын онцлогийг авч үзвэл **Ерөнхий сайдын ажлын алба болон дараах яамыг тус бүр 2-3 сайд хариуцаж байна.**³⁸⁴ Үүнд:

Ерөнхий сайдын Ажлын албыг 2 сайд хариуцаж байна –

- Ерөнхий сайд;
- Европын хэрэг эрхэлсэн болон өмчийн асуудал эрхэлсэн сайд (Minister for European Affairs and Ownership) нь Ерөнхий сайдын харьяалаагүй бусад асуудал, төрийн өмчийн асуудлыг хариуцна;

Гадаад хэргийн яамыг 3 сайд хариуцаж байна –

- Нордикийн хамтын ажиллагаа, тэгш байдлын сайд нь Нордикийн хамтын ажиллагааны асуудлыг;
- Хөгжлийн хамтын ажиллагаа, гадаад худалдааны сайд нь Хөгжлийн хамтын ажиллагаа, гадаад худалдаатай холбоотой асуудлыг;
- Гадаад хэргийн сайд нь тус яамны эрхлэх бусад асуудлыг;

³⁷⁸ https://www.valtiolle.fi/en-US/Employers_and_employees/Ministry_of_Transport_and_Communications

³⁷⁹ <https://stm.fi/en/frontpage>

³⁸⁰ <https://vm.fi/en/minister-of-local-government>

³⁸¹ <https://mmm.fi/en/frontpage>

³⁸² <https://oikeusministerio.fi/en/ministry>

³⁸³ <https://tem.fi/en/ministry>

³⁸⁴ <https://valtioneuvosto.fi/en/marin/division-of-responsibilities-between-ministers>

Нийгэм, эрүүл мэндийн яамыг 3 сайд хариуцаж байна –

- **Нордикийн хамтын ажиллагаа, тэгш байдлын сайд** нь эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх асуудлыг;
- **Гэр бүл, нийгмийн үйлчилгээний сайд** нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, нийгмийн халамж, мөрийтэй тоглоомын орлого хуваарилалт, эмийн үйлчилгээтэй холбоотой асуудлыг;
- **Нийгэм, эрүүл мэндийн сайд** нь тус яамны эрхлэх бусад асуудлыг;

Боловсрол, соёлын яамыг 2 сайд хариуцаж байна –

- **Шинжлэх ухаан, соёлын сайд** нь шинжлэх ухаан, дээд боловсролын бодлого, шашны асуудлыг;
- **Боловсролын сайд** нь тус яамны эрхлэх бусад асуудлыг;

Хууль зүйн яамыг 2 сайд хариуцаж байна –

- **Нордикийн хамтын ажиллагаа, тэгш байдлын сайд** нь эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх асуудлыг;
- **Хууль зүйн сайд** нь тус яамны эрхлэх бусад асуудлыг;

Сангийн яамыг 2 сайд хариуцаж байна –

- **Нутгийн удирдлагын сайд** нь орон нутгийн засаг захиргаа, бүс нутгийн удирдлага, ажил олгогч, хүний нөөц, засаглалын бодлого, засгийн газрын санхүүгийн хяналт, статистиктай холбоотой асуудлыг;
- **Сангийн сайд** нь тус яамны эрхлэх бусад асуудлыг;

Эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн яамыг 2 сайд хариуцаж байна –

- **Хөдөлмөр эрхлэлтийн сайд** нь хөдөлмөр эрхлэлт, зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал, бүс нутгийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээтэй холбоотой асуудлыг) **хоёр сайд** хариуцаж байна;
- **Эдийн засгийн асуудал эрхэлсэн сайд** нь тус яамны эрхлэх бусад асуудлыг;

2.3.2. Засгийн газрын Сайд нарын хороо³⁸⁵

Ерөнхий сайд нь Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдах шаардлагагүй гэж үзвэл Сайд нарын хороо (Ministerial committees)-ыг хуралдуулж болно. Дөрвөн Сайд нарын хороог Ерөнхий сайд тэргүүлнэ. Хороо нь сайд нараас бүрдсэн гишүүдтэй байх ба тэд өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудал, эсхүл Ерөнхий сайдын хүсэлтээр асуудлыг хэлэлцэнэ. Сайд нарын хороо бүр байнгын эксперттэй байх бөгөөд тэд голдуу яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар байдаг.

Гадаад аюулгүй байдлын бодлогын сайд нарын хороо (Ministerial Committee on Foreign and Security Policy) нь Финланд Улсын бусад улстай харилцах харилцаа, дотоодын аюулгүй байдал, батлан хамгаалахтай холбоотой үндсэн асуудлууд хамаарна.

Практик дээр тус хороо Ерөнхийлөгчтэй хамт хуралддаг бөгөөд хуралдааныг Гадаад аюулгүй байдлын бодлогын сайд нарын хороо, Ерөнхийлөгчийн хамтарсан хурал гэж нэрлэдэг.

³⁸⁵ <https://valtioneuvosto.fi/en/marin/ministerial-committees>

Тус хорооны бүрэлдэхүүнд нь дараах сайд нар хамаарна:

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
- Батлан хамгаалахын сайд;
- Боловсролын сайд;
- Гадаад хэргийн сайд;
- Дотоод хэргийн сайд;
- Сангийн сайд;
- Хөгжлийн хамтын ажиллагаа, гадаад худалдааны сайд;
- Хууль зүйн сайд.

Хорооны нарийн бичгийн дарга нь Гадаад хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргын орлогч (Гадаад аюулгүй байдлын бодлого хариуцсан) байна.

Европын холбооны асуудал эрхэлсэн сайд нарын хороо (Ministerial Committee on European Union Affairs) нь улс төр, эдийн засаг, хууль эрх зүйн хувьд чухал ач холбогдолтой Европын холбооны асуудлуудыг хамаарна.

Тус хорооны бүрэлдэхүүнд нь дараах сайд нар хамаарна:

- Боловсролын сайд;
- Гадаад хэргийн сайд;
- Европын хэрэг болон өмчийн асуудал эрхэлсэн сайд;
- Сангийн сайд;
- Хөгжлийн хамтын ажиллагаа, гадаад худалдааны сайд;
- Хөдөө аж ахуй, ойн яамны сайд;
- Хууль зүйн сайд;
- Эдийн засгийн сайд.

Хорооны нарийн бичгийн дарга нь Ерөнхий сайдын Ажлын албаны Ерөнхий захирал буюу Европын асуудал эрхэлсэн төрийн нарийн бичгийн дарга байна.

Сангийн сайд нарын хороо (Ministerial Finance Committee) нь эдийн засгийн чухал ач холбогдолтой, эсхүл Сангийн сайдын хорооны санал авах шаардлагатай асуудлуудыг хамаарна.

Тус хорооны бүрэлдэхүүнд нь дараах сайд нар хамаарна:

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
- Боловсролын сайд;
- Нутгийн удирдлагын сайд;
- Сангийн сайд;
- Хууль зүйн сайд;
- Эдийн засгийн сайд.

Хорооны нарийн бичгийн дарга нараар яамдын төрийн байнгын нарийн бичгийн дарга нар, Төсвийн газрын Ерөнхий захирлын орлогч нар зэрэг 5 албан тушаалтан ажиллаж байна.

Эдийн засгийн бодлогын сайд нарын хороо (Ministerial Committee on Economic Policy) нь улсын санхүүгийн үндсэн чиглэл, эдийн засгийн ерөнхий хөгжил болон эдийн засгийн бодлогын арга хэмжээ авах шаардлагатай бусад асуудлыг Ерөнхий сайдын шийдвэрээр шийдвэрлэдэг.

Тус хорооны бүрэлдэхүүнд нь дараах сайд нар хамаарна:

- Хууль зүйн сайд;
- Сангийн сайд;
- Нутгийн удирдлагын сайд;
- Боловсролын сайд;
- Эдийн засгийн сайд.
- Хөдөлмөр эрхлэлтийн сайд;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
- Европын хэрэг болон өмчийн асуудал эрхэлсэн сайд.

Хорооны нарийн бичгийн дарга нар нь Төсвийн газрын Ерөнхий захирал, түүний орлогч болон Эдийн засгийн газрын Ерөнхий захирал зэрэг 3 албан тушаалтан байна.

3.БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛС

3.1.Төрийн тогтолцоо

Бүгд Найрамдах Эстони Улс нь парламентын засаглалтай бүгд найрамдах улс бөгөөд төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс юм.

1992 онд батлагдсан Эстони Улсын Үндсэн хуульд³⁸⁶ зааснаар Ерөнхийлөгч нь Эстони Улсын төрийн тэргүүн байна. Ерөнхийлөгчийг тус улсын Парламент буюу Рийгикогу, эсхүл сонгуулийн коллегияр сонгоно. Рийгикогугийн гишүүдийн 1/5-ээс доошгүйн саналаар Ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшүүлнэ. Ерөнхийлөгчийг Рийгикогугийн нууц санал хураалтаар сонгоно. Рийгикогугийн гишүүдийн олонхын буюу 2/3-ын санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид сонгогдсонд тооцно. (§77; 79)

2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс Ерөнхийлөгчөөр Алар Карис сонгогдон ажиллаж байна. Шинэчлэлийн нам болон Төвийн намаас түүний нэрийг Ерөнхийлөгчид дэвшүүлжээ.

Эстони Улсад:

- 1) **Хууль тогтоох эрх мэдлийг** Парламент (Рийгикогу) хэрэгжүүлнэ. Рийгикогугийн 101 гишүүнийг пропорционал зарчмын үндсэн дээр чөлөөт сонгуулиар жилийн хугацаатай сонгодог. (Үндсэн хуулийн §59; 60) Рийгикогугийн үүрэг бол хууль тогтоомж батлах, парламентын хяналтыг хэрэгжүүлэх, олон улсын харилцааг хөгжүүлэх явдал юм. 2019 оны 03 дугаар сарын 03-ны өдөр явагдсан Рийгикогугийн сонгуулийн дүнгээр Шинэчлэлийн нам 28,9 хувиар хамгийн их санал буюу 34 суудал авчээ.³⁸⁷
- 2) **Гүйцэтгэх эрх мэдлийг** Засгийн газар хэрэгжүүлэх ба Засгийн газар нь Ерөнхий сайд болон бусад сайд нараас бүрдэнэ. (§86; 88) Кая Каллас тэргүүтэй Засгийн газар 2020 оны 01 дүгээр сарын 26-ний өдрөөс ажиллаж байна. Тус Засгийн газрыг Шинэчлэлийн нам болон Төвийн нам хамтран байгуулжээ.

³⁸⁶ Конституция (Основной закон) Эстонской Республики. Принята 28 июня 1992 года. Вступила в силу 3 июля 1992. года https://www.riigikogu.ee/wpcms/wp-content/uploads/2015/02/3_Pohiseadus_VENE.pdf

³⁸⁷ Politico research - <https://www.politico.eu/europe-poll-of-polls/estonia/>

- 3) **Шүүх эрх мэдлийг** гагцхүү шүүх хэрэгжүүлэх ба шүүх үйл ажиллагаагаа хараат бус бөгөөд Үндсэн хууль болон бусад хуульд заасан журмын дагуу явуулна. (§146)

3.2.Гүйцэтгэх засаглал

3.2.1.Засгийн газрыг байгуулах

1992 онд батлагдсан Эстони Улсын Үндсэн хуулийн 89 дүгээр зүйлд³⁸⁸ зааснаар тус улсын Ерөнхийлөгч нь өмнөх Засгийн газрыг огцорсноос хойш Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх ба нэр дэвшигч нь 14 хоногийн дотор шинэ Засгийн газраа байгуулах үүрэг хүлээдэг. Иймд Ерөнхий сайдад нэр дэвшигч нь энэхүү үүргээ хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шинэ Засгийн газрыг байгуулах тухай тайлангаа Рийгикогуд өргөн барина.

Рийгикогу нь нэр дэвшигчид шинэ Засгийн газар байгуулах эрх олгох эсэх асуудлыг үл мэтгэлцэх зарчмаар, нээлттэй санал хураалтаар шийдвэрлэнэ.

Рийгикогугаас Засгийн газар байгуулах эрх авсан Ерөнхий сайдад нэр дэвшигч нь 7 хоногийн дотор шинэ Засгийн газрын бүрэлдэхүүнээ Ерөнхийлөгчид танилцуулах бөгөөд Ерөнхийлөгч 3 хоногийн дотор Засгийн газрыг томилно.

Дараах тохиолдолд Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ:

- нэр дэвшигч нь Рийгикогуд олонхын санал аваагүй бол;
- нэр дэвшигч нь Засгийн газраа байгуулж чадаагүй, эсхүл байгуулахаас татгалзсан бол.

Ерөнхийлөгчийн Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх эрх дараах тохиолдолд Рийгикогуд шилжинэ:

- Ерөнхийлөгч нь 7 хоногийн дотор өөр хүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлээгүй, нэр дэвшүүлэхээс татгалзсан бол;
- 2 дахь нэр дэвшигч нь Рийгикогу-д олонхын санал аваагүй бол;
- 2 дахь нэр дэвшигч нь Засгийн газраа байгуулж чадаагүй, эсхүл байгуулахаас татгалзсан бол.

Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх эрх Рийгикогуд шилжсэн тохиолдолд тухайн нэр дэвшигч нь Засгийн газрын бүрэлдэхүүнээ Ерөнхийлөгчид танилцуулна. Хэрэв Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх эрх нь Рийгикогуд шилжсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Засгийн газрын бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгчид танилцуулаагүй бол Ерөнхийлөгч Рийгикогугийн ээлжит бус сонгууль зарлана. (§89)

3.2.2.Засгийн газрын эрх, үүрэг

Үндсэн хуулийн 87 дугаар зүйлд Засгийн газрын эрх, үүргийг дараах байдлаар тогтоосон байна:

- төрийн гадаад, дотоод бодлогыг хэрэгжүүлэх;
- Засгийн газрын агентлагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах, удирдах;
- хууль, Рийгикогугийн тогтоол, Ерөнхийлөгчийн зарлигийн биелэлтийг хангах;

³⁸⁸ Конституция (Основной закон) Эстонской Республики. Принята 28 июня 1992 года. Вступила в силу 3 июля 1992. года https://www.riigikogu.ee/wpcms/wp-content/uploads/2015/02/3_Pohiseadus_VENE.pdf

- Рийгикогуд хуулийн төсөл оруулах, олон улсын гэрээ батлуулах болон хүчингүй болгуулахаар өргөн мэдүүлэх;
- Улсын төсвийн төслийг боловсруулах, Рийгикогуд мэдүүлэх, улсын төсвийн гүйцэтгэлийн тайланг Рийгикогуд өргөн мэдүүлэх;
- Хуулийг дагаж мөрдөх, хэрэгжилтийг хангахаар дүрэм, журам боловсруулах;
- бусад улстай гадаад харилцааг зохион байгуулах;
- байгалийн гамшиг, гэнэтийн аюул, халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мужид болон түүний зарим хэсэгт онц байдал зарлах;
- Засгийн газрын эрхлэх асуудлын хүрээнд Үндсэн хууль, бусад хуулиар олгосон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

3.3.Засгийн газрын бүтэц

Эстони Улсын Засгийн газрыг эмэгтэй Ерөнхий сайд Кая Каллас тэргүүлж байна. Засгийн газрын 11 яамыг 14 сайд хариуцан ажиллаж байгаа бөгөөд тэдний 7 нь эмэгтэй сайд байна.

Засгийн газрын 11 яамыг дурдвал:

- Батлан хамгаалах яам (Ministry of Defence) – Эстони Улсын үндэсний батлан хамгаалах, зэвсэгт хүчний талаарх Засгийн газрын бодлогыг хариуцна;³⁸⁹
- Боловсрол, судалгааны яам (Ministry of Education and Research) - боловсролын тогтолцоог удирдан чиглүүлэх, хөгжүүлэх, үндэсний хэмжээнд судалгаа, хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулна;³⁹⁰
- Байгаль орчны яам (Ministry of the Environment) - уур амьсгал, хүрээлэн буй орчин, ан агнуур болон нөөцийн талаарх бодлогыг хариуцна;³⁹¹
- Гадаад хэргийн яам (Ministry for Foreign Affairs) - гадаад бодлого болон Засгийн газрын түвшний төрийн байгууллагын гадаад харилцааг хариуцна;³⁹²
- Дотоод хэргийн яам (Ministry of the Interior) - хилийн асуудлыг шийдвэрлэх гадаад иргэдэд оршин суух эрх олгох, болон цахим визний асуудлыг хариуцна;³⁹³
- Нийгмийн хамгааллын яам (Ministry of Social Affairs) - Засгийн газрын нийгмийн хамгааллын бодлогыг хариуцна;³⁹⁴
- Хууль зүйн яам (Ministry of Justice) - Шүүхийн тогтолцоог дэмжих, шинэ хууль тогтоомж боловсруулахад мэргэшлийн эрх зүйн дэмжлэг үзүүлнэ;³⁹⁵
- Орон нутаг хариуцсан яам (Ministry of Rural Affairs) - хөдөө аж ахуйн бодлого, загас агнуурын салбарыг бодлого, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааны бодлого, хүнсний аюулгүй байдал, хэрэгжилтийг хангах зэрэг ажлуудыг зохион байгуулах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулна;³⁹⁶
- Соёлын яам (Ministry of Culture) - соёлын бодлого, хэрэгжүүлэх, өв соёл түүнийг сурталчлах, хөгжүүлэхэд эрх зүйн мэргэшлийн дэмжлэг үзүүлнэ.³⁹⁷

Тус улсын хоёр яам нь 2 сайдтай байна:

³⁸⁹ <https://kaitseministeerium.ee/en>

³⁹⁰ <https://www.hm.ee/en>

³⁹¹ <https://envir.ee/en>

³⁹² <https://vm.ee/en>

³⁹³ <https://www.siseministeerium.ee/en>

³⁹⁴ <https://www.sm.ee/en>

³⁹⁵ <https://www.just.ee/en>

³⁹⁶ <https://www.agri.ee/en>

³⁹⁷ <https://www.kul.ee/en>

- Сангийн яам (Ministry of Finance) - Үндэсний санхүүгийн талаарх Засгийн газрын бодлогыг зохицуулна.³⁹⁸ Яам нь Сангийн болон Төрийн удирдлагын гэсэн хоёр сайдтай;
- Эдийн засаг, харилцаа холбооны яам (Ministry of Economic Affairs and Communications) - Эстони Улсын эдийн засгийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх түүний үр дүнг үнэлэн, эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг хангах үүрэгтэй. Яам нь Эдийн засаг, дэд бүтцийн болон Үйлдвэрлэл, мэдээллийн технологийн гэсэн хоёр сайдтай.

4.НОРВЕГИЙН ХААНТ УЛС

4.1.Төрийн тогтолцоо

Норвегийн Хаант Улс нь үндсэн хуульт хаант засаглалтай, төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс юм. Тус улсад:

- 4) **Хууль тогтоох эрх мэдлийг** Парламент (Storting) хэрэгжүүлнэ. (Үндсэн хуулийн “С бүлэг”) Парламент нь 4 жилийн хугацаатай сонгогдох 169 гишүүнтэй. Үндсэн хуульд Парламентын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай тусгаагүйгээс үзэхэд, Парламентыг Хаан, эсхүл Засгийн газар тараах эрхгүй. Норвег Улсын энэ онцлог нь Европын бусад орнуудаас ялгаатай байдаг.

2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр явагдсан Парламентын сонгуулийн дүнгээр Хөдөлмөрчдийн нам 26,4 хувиар хамгийн их санал буюу 48 суудал авчээ.³⁹⁹ 1887 онд байгуулагдсан Хөдөлмөрчдийн нам нь социал демократ чиг баримжаатай аж. Тус нам нь анх 1903 онд Парламентад суудал авч, 1928 онд засгийн газраа байгуулж байсан бөгөөд засгийн эрхийг нийт 44 жил барьж (тэр дундаа 1935-1965 оны хооронд тасралтгүй 30 гаруй жил) байна.⁴⁰⁰

- 5) **Гүйцэтгэх эрх мэдлийг** Хаан болон Төрийн зөвлөл хэрэгжүүлнэ (Үндсэн хуулийн “В бүлэг”).

V Харальд хаан 1991 оноос хойш Хаан ширээнд сууж байна.

Төрийн зөвлөл нь Ерөнхий сайд болон бусад сайдаас бүрдэнэ. 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Хаан Ерөнхий сайд Йонас Гар Стёре-г томилжээ. Тэрээр 2014 оноос хойш Хөдөлмөрчдийн намын даргын албыг хашиж байна. Одоогийн Төрийн зөвлөлийг Хөдөлмөрчдийн нам болон Төвийн нам бүрдүүлж байна.

- 6) **Шүүх эрх мэдлийг** шүүх хэрэгжүүлэх ба түүний дээд байгууллага нь Дээд шүүх байна. (Үндсэн хуулийн “D бүлэг”)

Норвег Улс нь Европын чөлөөт худалдааны нийгэмлэг (EFTA)-ийн гишүүн бусад гурван улс (Исланд, Лихтенштейн, Швейцар)-ын адил өнөөг хүртэл Европын Холбооны бүрэлдэхүүнд ороогүй байна. 1972, 1994 онд явуулсан бүх нийтийн санал асуулгаар тус улсын иргэд Европын Холбоонд нэгдэхээс татгалзжээ.⁴⁰¹ Мөн 2018 оны Европын

³⁹⁸ <https://www.fin.ee/en>

³⁹⁹ Politico research - <https://www.politico.eu/europe-poll-of-polls/norway/>

⁴⁰⁰ Норвег Улсын Хөдөлмөрчдийн намын цахим хуудас - <https://www.arbeiderpartiet.no/om/information-in-english/>

⁴⁰¹ 1994: Norway votes 'no' to Europe. BBC News.

нийгмийн судалгаа (ESS)-гаар Норвегчуудын зөвхөн 21.5 хувь нь Европын Холбоонд нэгдэхийг дэмжсэн байна.

4.2. Гүйцэтгэх засаглал

4.2.1. Төрийн зөвлөлийг бүрдүүлэх

1814 онд батлагдсан Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд⁴⁰² зааснаар гүйцэтгэх эрх мэдлийг угсаа залгамжилсан Хаан (хатан хаан) эзэмшинэ. Тэрээр Норвег Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч, сүмийн тэргүүн байх бөгөөд гадаад улсад улсаа төлөөлнө.

Хаан хууль тогтоох хүрээнд Парламентын шинэ чуулганыг нээх ба Парламентаас баталсан хуулийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх эрхтэй. Тодруулбал, Хаан тухайн хуулийг зөвшөөрвөл гарын үсэг зурж баталгаажуулна, харин эс зөвшөөрвөл тухайн хуулийг Парламент руу буцаана. Энэ тохиолдолд Парламентаас уг хуулийн төслийг Хаанд дахин танилцуулахгүй.

Засгийн газрын хамтын шийдвэр гаргах кабинет нь Төрийн зөвлөл (State of Council) байна. Өөрөөр хэлбэл, Хаан гүйцэтгэх эрх мэдлээ Төрийн зөвлөлөөр дамжуулан хэрэгжүүлдэг.

Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн дагуу Төрийн зөвлөл нь Ерөнхий сайд болон 7-оос доошгүй сайд нараас бүрдэх ба “Хаан өөрөө саналын эрхтэй Норвег Улсын иргэдээс Төрийн зөвлөлийг сонгоно”. Гэхдээ бодит байдал дээр Парламентын сонгуулийн үр дүнд олонх болсон нам, эсхүл эвсэл Төрийн зөвлөлийг бүрдүүлнэ.⁴⁰³

Төрийн зөвлөлийг дараах журмаар бүрдүүлнэ.⁴⁰⁴

- 1) Бүрэн эрх нь дуусгавар болж байгаа Засгийн газраас огцрох өргөдлөө Парламентад өргөн мэдүүлнэ. Үүний дараа уг асуудлыг Төрийн зөвлөлийн хуралдаанд оруулна.

Хаан уг өргөдлийг хүлээн авсны дараа бүрэн эрх нь дуусгавар болж байгаа Засгийн газраас шинэ Засгийн газар байгуулагдах хүртэл түр Засгийн газрын үүргийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хүсэлт гаргана.

Хаан бүрэн эрх нь дуусгавар болж байгаа Ерөнхий сайдаас шинэ Засгийн газар байгуулах асуудлаар хэнд хандах тухай зөвлөгөө авдаг. Ерөнхий сайд Хаанд ихэвчлэн Парламентын удирдлагуудын хэн нэгэнд, эсхүл олонх буюу цөөнхийн даргад хандахыг зөвлөдөг.

- 2) Ихэнх тохиолдолд Хаан Ерөнхий сайдын энэхүү зөвлөгөөг дагаж, Парламентын удирдлагуудын хэн нэгэнд, эсхүл олонх буюу цөөнхийн даргад шинэ Засгийн газар байгуулахыг даалгана.
- 3) Ийнхүү даалгавар авсан хүн шинэ Засгийн газар томилогдоход бэлэн болсон талаар Хаанд мэдэгдсэнээр Төрийн зөвлөлийн хуралдаанаар шинэ Засгийн газрыг томилно.

⁴⁰² http://news.bbc.co.uk/onthisday/hi/dates/stories/november/28/newsid_4208000/4208314.stm

⁴⁰³ Норвег Улсын Үндсэн хууль - <https://lovdata.no/dokument/NLE/lov/1814-05-17>

⁴⁰⁴ Норвег Улсын Парламентын цахим хуудас - <https://www.stortinget.no/en/In-English/About-the-Storting/Downloads/>. Норвег Улсын Засгийн газрын цахим хуудас - <https://www.regjeringen.no/en/the-government/the-government-at-work1/the-government-at-work1/id2564958/>

⁴⁰⁴ Норвег Улсын Засгийн газрын цахим хуудас - <https://www.regjeringen.no/en/the-government/the-government-at-work1/change-of-government/id270340/>

Төрийн зөвлөлийн энэхүү хуралдаанаар Хаан, бүрэн эрх нь дуусгавар болж байгаа Засгийн газар, шинэ Засгийн газрыг томилно. Үүний дараа Хаан өмнөх Засгийн газрын огцрох өргөдлийг хүлээн авснаар өмнөх Засгийн газрын бүрэн эрх дуусгавар болно.

4) Төрийн зөвлөлийн анхны хуралдаанаар Засгийн газрын гишүүдийг томилно.

4.2.2. Төрийн зөвлөлийн эрх, үүрэг

Төрийн зөвлөл нь төсвийн төсөл болон Засгийн газрын санаачилсан хуулийн төслүүдийг Парламентад өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төрийн өндөр албан тушаалтнуудыг томилох, чөлөөлөх, өршөөл үзүүлэх, олон улсын гэрээг батална.

Төрийн зөвлөл нь төрийн асуудлыг хуралдаанаараа хэлэлцэх ба асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ. Харин санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий сайд хоёр саналын эрхтэй байхаар Үндсэн хуулийн 13 дугаар зүйлд зохицуулсан онцлогтой.

Хаан Төрийн зөвлөлийн хуралдааныг тэргүүлж, гарсан шийдвэрийг батална. Шийдвэр нь “Зөвлөл дэх Хаан” (“King-in-Council”) гэсэн хэвлэмэл хуудас дээр гардаг. Энэ нь Хааныг буруутгахгүй ба түүний хариуцлагыг Төрийн зөвлөл хүлээнэ гэсэн Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд заасан онцлог зохицуулалттай холбоотой.

Төрийн зөвлөлийн аливаа гишүүн нь Хааны шийдвэрийг засаглалын хэлбэр, эсхүл тус улсын хууль тогтоомжид харшилж байна хэмээн үзвэл тухайн шийдвэрийг эсэргүүцэх, саналаа хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх эрхтэй хэмээн Үндсэн хуулийн 30 дугаар зүйлд заажээ. Хожим нь Төрийн зөвлөлийн шийдвэр тус улсын хууль тогтоомжид харшилсан нь тогтоогдвол тухайн шийдвэрийг эсэргүүцээгүй Төрийн зөвлөлийн гишүүнийг Парламент огцруулна. Иймд Төрийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд түүний бүх гишүүд гарын үсэг зурдаг.

Төрийн зөвлөл нь Парламент болон Хааны өмнө хариуцлага хүлээнэ. Тухайлбал, Парламент нь Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх талаар Үндсэн хуулийн 15 дугаар зүйлд заасан байна: “Хэрэв Парламент нь Төрийн зөвлөлийн аль нэг гишүүнд, эсхүл Засгийн газарт итгэл үзүүлэхгүй гэж шийдвэрлэсэн бол Төрийн зөвлөлийн бүх гишүүн огцрох өргөдлөө өгнө.” Харин Үндсэн хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу Хаан Төрийн зөвлөлийг тараах эрхтэй байдаг.

Хаан өөрийн түр эзгүйд Төрийн зөвлөлд улсыг удирдах эрхийг шилжүүлж болох ба энэ тохиолдолд Төрийн зөвлөл нь Үндсэн хуулийн хүрээнд Хааны нэрийн өмнөөс улсыг удирдаж түүний эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.3. Засгийн газар (Төрийн зөвлөл)-ын бүтэц

Одоогийн Засгийн газар дараах 15 яамтай ажиллаж байна.⁴⁰⁵ Үүнд:

- Батлан хамгаалах яам (Ministry of Defence) - Норвегийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогыг бүрдүүлэх, хэрэгжүүлэх асуудлыг хариуцна;
- Газрын тос, эрчим хүчний яам (Ministry of Petroleum and Energy) - Норвегийн эрчим хүчний нөөцийг үр ашигтай, байгаль орчинд ээлтэй менежментээр дамжуулан өндөр үнэ хүргэх асуудлыг хариуцна;

⁴⁰⁵ Норвег Улсын Засгийн газрын цахим хуудас - <https://www.regjeringen.no/en/dep/id933/>

- Нутгийн захиргаа, шинэчлэлийн яам (Ministry of Local Government and Modernisation) - орон нутгийн засаг захиргааны санхүү, нутгийн удирдлага, мэдээлэл, харилцаа холбооны технологийн бодлого, төрийн салбарын шинэчлэл, бүс нутгийн бодлого, Засгийн газрын ажил олгогчийн бодлого, Сами болон цөөнхийн асуудал, геомэдээллийн бодлогыг хариуцна;
- Сангийн яам (Ministry of Finance) - Норвегийн эдийн засгийн бодлогыг төсөвтэй уялдуулан төлөвлөх, хэрэгжүүлэх, зохицуулах асуудлыг хариуцна;
- Соёлын яам (Ministry of Culture) - соёл, эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхалт, зохиогчийн эрх, хэвлэл мэдээлэл, спорт, сайн дурын салбарыг хариуцна;
- Тээврийн яам (Ministry of Transport) - иргэний агаарын тээвэр, авто зам, төмөр зам, усан замын тээврийг хариуцна;
- Уур амьсгал, байгаль орчны яам (Ministry of Climate and Environment) - Засгийн газраас баримталж буй байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх асуудлыг хариуцна;
- Хөдөлмөр, нийгмийн харилцааны яам (Ministry of Labour and Social Affairs) - хөдөлмөрийн зах зээлийн бодлого, ажиллах орчин, тэтгэвэр, нийгмийн халамжийн бодлогыг хариуцна;
- Хөдөө аж ахуй, хүнсний яам (Ministry of Agriculture and Food) - хоол хүнс, ойн аж ахуй, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн худалдаа, ногоон байгууламжийн арчилгаа, хөрс хамгаалал, цаа бугын аж ахуйн асуудлыг хариуцдаг;
- Хууль зүй, нийтийн аюулгүй байдлын яам (Ministry of Justice and Public Security) - хууль дээдлэх үндсэн баталгааг хадгалах, хэрэгжүүлэх асуудлыг хариуцна;
- Хүүхэд, гэр бүлийн яам (Ministry of Children and Families) - хүүхдийн халамж, гэр бүлийн харилцаа, шашин шүтлэг, амьдралын хэв маяг зэрэг асуудлыг хариуцна;
- Эрүүл мэнд, тусламж үйлчилгээний яам (Ministry of Health and Care Services) - Норвегийн хүн амд эрүүл мэнд, халамжийн үйлчилгээг тэгш, сайн хүргэх үүрэгтэй.

Засгийн газрын гурван яам нь 2 сайдтай ажилладаг онцлогтой. Үүнд:

- Боловсрол, судалгааны яам (Ministry of Education and Research) - бүх шатны боловсролын байгууллага болон соёлын сургууль, мэргэжлийн боловсрол, насанд хүрэгчдийн сургалтыг хариуцна. Яам нь Боловсролын болон Судалгаа, дээд боловсролын гэсэн 2 сайдтай;
- Гадаад харилцааны яам (Ministry of Foreign Affairs) - Олон улстай харилцах, Норвегийн эрх ашгийг олон улсын хэмжээнд хамгаалах, сурталчлах ажлыг хариуцна. Яам нь Гадаад хэргийн болон Олон улсын хөгжлийн гэсэн 2 сайдтай;
- Худалдаа, үйлдвэрлэл, загас агнуурын яам (Ministry of Trade, Industry and Fisheries) - Тус яам нь Худалдаа, үйлдвэрлэлийн (Minister of Trade and Industry) болон Загас агнуур, далайн бодлогын (Minister of Fisheries and Ocean Policy) гэсэн 2 сайдтай.

5.ШВЕДИЙН ХААНТ УЛС

5.1.Төрийн тогтолцоо

Шведийн Хаант Улсын Үндсэн хуулиар тус улсыг хэрхэн удирдахыг тодорхойлдог. Тодруулбал, шийдвэр гаргах болон гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын харилцааг зохицуулахаас гадна иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг зохицуулдаг. Үндсэн хуулийг

дараах 4 үндсэн хууль бүрдүүлдэг.⁴⁰⁶

- Засгийн газрын тухай хууль (Instrument of Government) – 1974 онд батлагдсан энэхүү хуульд иргэд чөлөөтэй мэдээлэл авах, жагсаал цуглаан хийх, улс төрийн нам байгуулах, шашин шүтэх эрхийг баталгаажуулсан;
- Хаан ширээ залгамжлах тухай хууль (Act of Succession) – 1810 онд батлагдсан энэхүү хууль нь хааны гэр бүл болох Бернадоттын ордны гишүүдийн Хаан ширээнд суух эрхийг зохицуулдаг;
- Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль (Freedom of the Press Act) – 1949 онд батлагдсан энэхүү хуульд Парламент, Засгийн газар, төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой албан ёсны баримт бичгүүдийг олон нийтэд нээлттэй хүргэх зарчмыг тогтоосон. Энэ хуулиар иргэд хүссэн үедээ албан ёсны бичиг баримтыг судлах боломжтой болсон;
- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай суурь хууль (Fundamental Law on Freedom of Expression) – 1991 онд батлагдсан энэ хуулиар аливаа цензурыг хориглох, харилцах эрх чөлөө, нэрээ нууцлах эрхийн талаар зохицуулжээ.

Швед Улс нь үндсэн хуульт хаант засаглалтай, төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс юм.

Швед Улсын Хаан ширээ залгамжлах тухай хуулийн дагуу залсан Хаан буюу Хатан хаан Төрийн тэргүүн байна хэмээн тус улсын Үндсэн хуулийн 5 дугаар бүлгийн 1 дүгээр зүйлд заажээ.⁴⁰⁷ Тус улсын төрийн тэргүүн нь Карл XVI Густаф хаан бөгөөд тэрээр ёслолын болон төлөөллийн үүргийг гүйцэтгэдэг.⁴⁰⁸

Швед Улсад:

- 1) **Хууль тогтоох эрх мэдлийг** нэг танхимтай Парламент (Riksdag) хэрэгжүүлнэ. Парламентын 349 гишүүд нь 4 жилийн хугацаагаар сонгогдоно. Гишүүдийг шууд төлөөллийн зарчмаар бүх иргэдийн сонгох эрхийн үндсэн дээр сонгодог. Улс орны хэмжээнд улс төрийн намуудад өгсөн саналтай нь тэнцүүлэн суудал хуваарилдаг.

Үндэсний пропорционал дүрэмд үл хамаарах нэг зүйл бий: нам нь парламентад төлөөлөлтэй болохын тулд сонгуульд нийт сонгогчдын 4-өөс доошгүй хувийн санал авах ёстой бөгөөд энэ нь маш жижиг намуудыг парламентад оруулахгүй байх зорилготой дүрэм юм.⁴⁰⁹

2018 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр явагдсан Парламентын сонгуулийн дүнгээр Социал Демократ нам 26,4 хувиар хамгийн их санал буюу 100 суудал авчээ.⁴¹⁰

- 2) **Гүйцэтгэх эрх мэдлийг** тус улсын Засгийн газар хэрэгжүүлнэ. Засгийн газар бол Швед Улсын төрийн эрх мэдлийн гүйцэтгэх дээд байгууллага болох үндэсний сайд нарын танхим юм.

Одоогийн Ерөнхий сайдын албыг Социал Демократ намын дарга болох Магдалена Андерссон 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс хашиж эхэлсэн.

⁴⁰⁶ Sweden - <https://sweden.se/life/democracy/swedish-government>

⁴⁰⁷ The Constitution of Sweden. <https://www.riksdagen.se/globalassets/07.-dokument--lagar/the-constitution-of-sweden-160628.pdf>

⁴⁰⁸ Sweden - <https://sweden.se/life/democracy>

⁴⁰⁹ Sweden - <https://sweden.se/life/democracy>

⁴¹⁰ Politico research - <https://www.politico.eu/europe-poll-of-polls/sweden/>

Засгийн газрыг Социал демократ нам болон Ногоон нам хамтран байгуулсан.

- 3) **Шүүх эрх мэдлийг** шүүх хэрэгжүүлэх ба түүний дээд байгууллага нь Дээд шүүх байна.

5.2. Гүйцэтгэх засаглал

5.2.1. Засгийн газрыг байгуулах

Швед Улсын Үндсэн хуулийн 6 дугаар бүлэгт⁴¹¹ Засгийн газрын талаар зохицуулсан байна. Засгийн газар нь Ерөнхий сайд болон бусад сайд нараас бүрдэнэ. Парламент Ерөнхий сайдыг томилж, чөлөөлөх бол Ерөнхий сайд Засгийн газрын бусад гишүүдийг томилж, чөлөөлнө.

Парламент Ерөнхий сайдыг дараах журмаар томилно:

- Парламентын дарга, Парламентын бүлгүүдийн төлөөлөл, дэд дарга нартай зөвшилцөн Парламентаар хэлэлцүүлэн нийт гишүүдийн олонхын саналаар томилно;
- Парламентын даргын оруулсан саналыг Парламент хүлээн аваагүй бол дээрх журмаар дахин Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ;
- Парламентын даргын оруулсан саналыг 4 удаа буцаавал Парламентын шинэ сонгуулийг зарлах нөхцөл үүсдэг байна.

Шинэ Ерөнхий сайд Засгийн газрын гишүүдийг биечлэн сонгох, тэдний эрхлэх асуудлыг шийднэ. Ийнхүү Ерөнхий сайд Засгийн газраа эмхлэн байгуулахдаа Парламентад авсан намууд суудлын харьцааг харгалзан үзнэ.

Засгийн газар Парламентын өмнө хариуцлага хүлээнэ. Парламент нь Засгийн газарт, эсхүл Ерөнхий сайдад, эсхүл аль нэг сайдад итгэл үзүүлэх эсэх тухай санал хураалт явуулна. Хэрэв итгэл үзүүлэхгүй гэж үзвэл Засгийн газар огцорно.

Мөн эсрэгээрээ Засгийн газар нь Парламентын ээлжит бус сонгууль явуулах шийдвэр гаргах боломжтой. Парламентаас Засгийн газарт итгэл үзүүлэхгүй гэж үзсэнээс хойш 7 хоногийн дотор Засгийн газраас ээлжит бус сонгууль явуулахаар шийдвэрлэсэн бол тухайн Засгийн газрыг огцруулах шийдвэр үйлчлэхгүй. Дараагийн Парламентаар шинэ Ерөнхий сайдыг томилно. Практик дээр Парламент ч, Засгийн газар ч энэ эрхээ хэрэгжүүлээгүй буюу зөвшилцөлд хүрч байжээ.

5.2.2. Засгийн газрын эрх, үүрэг

Швед Улс нь Парламентын засаглалтай, Үндсэн хуульт хаант улс юм. Швед нэгдмэл Үндсэн хуульгүй, Үндсэн хуулийн эрх бүхий актуудаар орлуулдаг улс юм. Шведийн Үндсэн хууль нь Удирдлагын хэлбэрийн тухай акт (Instrument of Government), Хаан ширээ залгамжлах тухай акт (Act of Succession), Хэвлэлийн эрх чөлөөний тухай акт (Freedom of the Press Act), Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай (Fundamental Law on Freedom of Expression) тулгуур хууль зэргээс бүрдэнэ. Хаан нь төрийн тэргүүн, ёс төдий Засгийн газрын тэргүүн бөгөөд Парламентын чуулганыг нээх зэрэг ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд оролцдог байна. Шаардлагатай үед Засгийн газрын хуралдааныг зарлан хуралдуулж, өөрөө удирдана.

⁴¹¹ The Constitution of Sweden. <https://www.riksdagen.se/globalassets/07.-dokument--lagar/the-constitution-of-sweden-160628.pdf>

Шведийн Засгийн газар нь Ерөнхий сайдаас гадна Европын холбооны асуудал эрхэлсэн сайд болон яамд хариуцсан хорин хоёр сайдаас бүрддэг. Шведийн одоогийн Засгийн газрын бүтэц дор дурдсан 11 яам ажиллаж байна.⁴¹² Үүнд:

- Батлан хамгаалах яам (Ministry of Defence) - үндэсний болон олон улсын батлан хамгаалах, аюулгүй байдлын хамтын ажиллагаа, гадаад тагнуулын үйл ажиллагаа зэвсэгт мөргөлдөөний олон улсын эрх зүйн орчныг бүрдүүлнэ;
- Байгаль орчны яам (Ministry of the Environment) - орчны бохирдлыг бууруулах, хорт бодисгүй орчинг бүрдүүлэх, хог хаягдал, цацрагийн аюулгүй байдал, хамгаалалт, олон улсын байгаль орчны хамтын ажиллагааг хариуцна;
- Соёлын яам (Ministry of Culture) - соёл урлаг, хэвлэл мэдээлэл, Самигийн уугуул иргэд болон үндэсний цөөнх, иргэний нийгэм, спорт, шашин шүтлэг, залуучуудыг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

Тус улсын зургаан яам нь **2 сайдтай** байна:

- Боловсрол, судалгааны яам (Ministry of Education and Research) - бүх шатны боловсролын асуудлыг хариуцаж, судалгааны нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ. Яам нь Боловсролын сайд болон Сургууль, судалгааны гэсэн хоёр сайдтай;
- Хөдөлмөр эрхлэлтийн яам (Ministry of Employment) - хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрийн хууль ба ажиллах орчин, хүн амын өсөлтийг дэмжин ажиллана. Яам нь Хөдөлмөр эрхлэлт, жендэрийн тэгш байдлын болон Орон сууц, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гэсэн хоёр сайдтай;
- Аж ахуй, инновацын яам (Ministry of Enterprise and Innovation) - төрийн өмчит үйлдвэрийн газар, үйлдвэр худалдаа, хөдөө орон нутаг, газар усны эх үүсвэрт тулгуурласан үйлдвэрүүд, бүс нутгийн хөгжлийг 7 нь дэмжинэ. Яам нь Бизнес, үйлдвэрлэл, инновацын болон Хөдөө орон нутгийн гэсэн хоёр сайдтай;
- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам (Ministry of Health and Social Affairs) - нийгмийн халамж, эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлийн асуудал, нийгмийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын асуудлыг хариуцан ажиллана. Яам нь Эрүүл мэнд, нийгмийн асуудал эрхэлсэн болон Нийгмийн хамгааллын гэсэн хоёр сайдтай;
- Дэд бүтцийн яам (Ministry of Infrastructure) - тээвэр, дэд бүтэц, цахим бодлого ба мэдээллийн технологи, шуудан харилцаа холбоо, эрчим хүчний асуудлыг хариуцна. Яам нь Дэд бүтцийн болон Эрчим хүч, цахим хөгжлийн гэсэн хоёр сайдтай;
- Хууль зүйн яам (Ministry of Justice) - шүүхийн тогтолцоо, шилжилт хөдөлгөөнийг хариуцах, орогнол олгох асуудал, хямралын үеийн бэлэн байдлыг хариуцна. Яам нь Хууль зүй, дотоод хэргийн болон Интеграц, шилжилт хөдөлгөөн, спорт хариуцсан гэсэн хоёр сайдтай.

Тус улсын хоёр яам нь **3 сайдтай** байна:

- Сангийн яам (Ministry of Finance) - Засгийн газрын санхүү, түүний дотор Засгийн газрын төсвийн зохицуулалт, татварын асуудлыг хариуцна. Яам нь Сангийн, Санхүүгийн зах зээлийн болон Төрийн удирдлагын гэсэн гурван сайдтай;
- Гадаад харилцааны яам (Ministry of Foreign Affairs) - Шведийн гадаад хөгжил, хамтын ажиллагаа, худалдааны бодлогыг хариуцна. Яам нь Гадаад хэргийн, Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны болон Гадаад худалдаа, Нордикийн асуудал эрхэлсэн гэсэн гурван сайдтай.

⁴¹² Шведийн Засгийн газрын цахим хуудас - <https://www.government.se/government-of-sweden/>

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Сингапур улс

- Constitution of the Republic of Singapore. 2020 revised edition.
<https://sso.agc.gov.sg/Act/CONS1963>
- Constitution of the Republic of Singapore (Ministerial Responsibility) Notification 2020. <https://sso.agc.gov.sg/SL/CONS1963-S723-2020?DocDate=20220110&ProvIds=av-#av->
- A Guide to the Singapore Constitution (2nd ed.). Edited by Grace Morgan. 2016.
- Сингапур Улсын Засгийн газрын цахим хуудас <https://www.sgdi.gov.sg/ministries>

Финланд улс

- Constitution of Finland - <https://oikeusministerio.fi/en/constitution-of-finland>
- Ministry of Defence - https://www.defmin.fi/en/ministry_of_defence#6f7820e2
- Ministry of the Environment and Climate Change - <https://ym.fi/en/ministry>
- Ministry of Education and culture - <https://okm.fi/en/marin/minister-of-education>
- Ministry for Foreign Affairs - <https://um.fi/frontpage>
- Ministry of Social Affairs and Health - <https://stm.fi/en/frontpage>
- Ministry of Transport and Communications - https://www.valtiolle.fi/en-US/Employers_and_employees/Ministry_of_Transport_and_Communications
- Ministry of Finance - <https://vm.fi/en/minister-of-local-government>
- Ministry of the Interior - <https://intermin.fi/en/frontpage>
- Ministry of Justice - <https://oikeusministerio.fi/en/ministry>
- Ministry of Economic Affairs and Employment - <https://tem.fi/en/ministry>
- Ministry of Agriculture and Forestry - <https://mmm.fi/en/frontpage>
- Politico research - <https://www.politico.eu/europe-poll-of-polls/estonia/>

Эстони улс

- Конституция (Основной закон) Эстонской Республики. Принята 28 июня 1992 года. Вступила в силу 3 июля 1992. года https://www.riigikogu.ee/wp-content/uploads/2015/02/3_Pohiseadus_VENE.pdf
- Ministry of Defence - <https://kaitseministeerium.ee/en>
- Ministry of Education and Research - <https://www.hm.ee/en>
- Ministry of the Environment - <https://envir.ee/en>
- Ministry for Foreign Affairs - <https://vm.ee/en>
- Ministry of the Interior - <https://www.siseministeerium.ee/en>
- Ministry of Social Affairs - <https://www.sm.ee/en>
- Ministry of Culture - <https://www.kul.ee/en>
- Ministry of Finance - <https://www.fin.ee/en>
- Ministry of Justice - <https://www.just.ee/en>
- Ministry of Rural Affairs - <https://www.agri.ee/en>
- Ministry of Economic Affairs and Communications - <https://www.mkm.ee/en>

Норвег улс

- Норвег Улсын Үндсэн хууль - <https://lovdata.no/dokument/NLE/lov/1814-05-17>
- Норвег Улсын Засгийн газрын цахим хуудас - <https://www.regjeringen.no/en/dep/id933/>
- Норвег Улсын Парламентын цахим хуудас - <https://www.stortinget.no/en/In-English/About-the-Storting/Downloads/>

**ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО, ПАРЛАМЕНТЫН
ГИШҮҮДИЙН ТОО БА ТҮҮНИЙГ ТОГТООХ, ТООЦОХ ЗАРЧИМ**

(Мэдээлэл, лавлагаа)

Д.Халиун, Г.Билгээ

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1.ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

1.1.Сонгуулийн тогтолцоо, ангилал

1.2.Дэлхийн улс орнуудын сонгуулийн тогтолцоо

1.3.Сонгуулийн тогтолцоог үндсэн хуульдаа тусгасан орнууд

2.ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ТОО, ТҮҮНИЙГ ТОГТООХ, ТООЦОХ ЗАРЧИМ

2.1.“Куб язгуурын хууль”

2.2.Парламентын нэг танхимтай улс орнуудын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулсан байдал

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НЭГ. ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Судалгааны энэхүү хэсэгт дэлхийн улс орнуудын сонгуулийн тогтолцоо, түүний ангилал мөн улс орнууд хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн тогтолцоог Үндс хуульдаа хэрхэн тусгасан талаар авч үзсэн болно.⁴¹³

1.1. Сонгуулийн тогтолцоо, ангилал⁴¹⁴

Сонгуулийн тогтолцоо (буюу санал хураах тогтолцоо) гэдэг нь сонгогч тодорх хувилбаруудаас өөрийн сонголтыг хийхтэй холбогдсон харилцаа юм. Сонгуулий тогтолцоо нь санал хураах, санал тоолох, эцсийн дүнг нэгтгэн тооцох дүрэм журм өөртөө агуулж байдаг. Сонгуулийн тогтолцоог судалдаг онолыг *сонгуулийн эрх зүй* г хэлбэр талаас нь тодорхойлж болох бөгөөд түүний цаана улс төр судлал, эдийн зас математикийн агуулга оршиж байдаг.

Сонгуулийн саналын агуулга, тойргийн хэмжээ, санал хураалтын дүнг мандат шилжүүлэн тооцох журам, саналаа тухайлсан нэр дэвшигчийн төлөө, эсхүл түүн хамруулж байгаа нам, эвсэл (нэрсийн жагсаалт)-ийн төлөө өгөх зэрэг хувьсах чанарт үзүүлэлтүүдийг харгалзан сонгуулийн тогтолцоог дор дурдсанаар ангилна.

Дэлхийн улс орнуудад сонгуулийн тогтолцооны маш олон хувилбар үйлчилж байг бөгөөд тэдгээр нь дотроо олон хувилбартай байгаа юм. Үүнийг хялбарчлан сонгуули *олонхыг төлөөлөх тогтолцоо*, сонгуулийн *хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцо* сонгуулийн *холимог тогтолцоо* гэсэн гурван ангилалд авч үздэг. Эдгээрийн алинд хамааруулж болохооргүй үл шилжих нэг саналын, *хязгаарлагдмал саналын, санал дугаарлаж өгөх Бордогийн тооцооны* арга гэсэн сонгуулийн тогтолцооны ангилал б байдаг.

а. Олонхыг төлөөлөх тогтолцоо: Тодорхой нэр дэвшигчээр дамжуулан сонгуули байгуулагддаг эрх барих байгууллагыг бүрдүүлдэг тогтолцоог олонхыг төлөөл тогтолцоо гэнэ.

Энэ тогтолцоо нь харьцангуй олонхын, багц саналын, намын багц саналын, дараал тогтоож саналаа өгөх альтернатив саналын, хоёр шатлалтай саналын гэх м хувилбаруудтай. Сонгогчдын олонхын санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцогд бөгөөд туйлын олонх (50+1), харьцангуй олонх (хамгийн олон санал авсан), дийлэ (2/3) болон үнэмлэхүй олонх (3/4)-ийн саналаар сонгогдох гэж ангилдаг.

б. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо: Нам эвслийн төлөөллөөр дамжуула сонгуулиар байгуулагддаг эрх барих байгууллагыг бүрдүүлдэг тогтолцоог ху тэнцүүлэн хуваарилах тогтолцоо гэнэ. Нам эвслийн авсан саналын хувьтай мандат тоо нь уялдаж байх ёстой. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо нь жагсаалт (нээлтт ба хаалттай)-ын, шилжих бололцоотой нэг саналын гэх мэт олон хувилбартай. Ху тэнцүүлэн хуваарилах тогтолцоонд:

- нам эвслүүдэд суудал хуваарилах тооцоо нь давуу тал олонтой ч зар талаар хүндрэлтэй;
- ихэнх тохиолдолд сонгуулийн босго тогтоох замаар суудлыг хуваарилдаг;

⁴¹³ “Сонгуулийн эрх зүйн тогтолцооны онол, арга зүйн үндэслэл, зохистой хувилбарыг сонгох зарчим” судалгааны тайлан, СТ-10/217. Ц.Товуусүрэн. 2010 он.

⁴¹⁴ Мөн тэнд.

- сонгуулийн босгыг ихэнхдээ тухайн тойрог/улсын хэмжээнд/-ийн сонгуулийн хүчинтэй саналын тоог мандатын тоонд харьцуулж тодорхойлдог;
- намын нэрийн жагсаалтаас хэдэн хүнд мандат хуваарилагдах вэ гэдэг н босго саналын тоо тухайн намын авсан саналын тоонд хэд дахин багтаа байгаагаар илэрхийлэгдэнэ;
- үлдэгдэл саналыг хэрхэн хуваарилах нь хамгийн том асуудал.

в.Холимог тогтолцоо: Олонхыг төлөөлөх, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоон аль алиных нь шинжийг агуулдаг. Энэхүү тогтолцоог *холимог хувь тэнцүүлсэн зэрэгцээ* (параллель) гэж ангилж болно.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд сонгогчдын өгсөн нэг саналаар хоёр өө тогтолцооны суудал хуваарилах аргыг хэрэглэдгээрээ онцлог юм. Зэрэгцээ (параллель саналын арга нь сонгогч олонхыг төлөөлөх хэсэгт 1 санал, хувь тэнцүүлэн хуваарила хэсэгт нэг санал өгдгөөрөө ялгаатай.

Сонгуулийн янз бүрийн тогтолцооны эцсийн үр дүн нь олон янз байж болох бөгөө ялангуяа илэрхий олонх байхгүй тохиолдолд бүр ч илүү мэдрэгддэг. Иймээс сонгуулий тогтолцоог сонгохдоо хэлбэр талаас нь биш агуулгаар нь авч үзэхийг онолын талаас н шаардах болжээ.

Сонгуулийн тогтолцооны агуулгад дор дурдсан хүчин зүйлүүдийг зайлшгүй тооц хэрэгтэй байдаг.

1.Сонгуулийн тогтолцооны агуулгад:

- саналаа илэрхийлэх хэлбэр;
- нэр дэвшигчийн асуудал;
- санал адил жинтэй байх шаардлага;
- саналын босго тогтоох арга;
- сонгуулийн тойрог, сонгогчид хамаарах үндэсний болон хүйсийн онцлогий тооцож үзэх шаардлага.

2.Олон ялагчдыг тодруулах арга:

- хувь тэнцүүлэн хуваарилах арга;
- хагас хувь тэнцүүлэх арга;
- холимог тогтолцооны арга.

3.Ганц ялагчийг тодруулах арга:

- нэг болон дараалалд оруулсан саналын арга;
- шилдгийг тодруулах олон шатлалтай саналын арга;
- зэрэглэх саналын арга (саналаа дугаарлаж өгөх, хэлэлцүүлэгтэй санал өгөх);
- нэг ялагчийг шалгаруулах үнэлгээний шалгуур зэргийг харгалзан үзэх хэрэгтэй

ИИХ МН
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 1. Сонгуулийн хүчин зүйлийн нөлөөлөл

Сонгуулийн тогтолцооны нөлөөлөл			Сонгогч саналаа гаргах чиглэлийн нөлөөлөл			
Олонхыг төлөөлөх	Хувь тэнцүүлэн хуваарилах	Холимог	Намын нэрийн жагсаалтад	Нэр	Тухайлсан нэр дэвшигчид	
					Олонхыг төлөөлөх	Хувь тэнцүүлэн хуваарилах
Давуу талууд						
Том намуудад давуу тал үүсгэдэг. Төрийн эрхийг том намууд тогтвортой барих нөхцөл бүрдүүлнэ.	Парламент олон нам суудал авах нөхцөл бүрдүүлнэ. Аливаа үзэл бодол, үнэт зүйл нэг танхимд хэлэлцэгдэх боломж бүрдүүлнэ.	Олонхыг төлөөлөх, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны давуу талуудыг товойлгох, дутагдалтай талуудыг хязгаарлах бололцоо бүрдүүлнэ. Том улсуудад болон үндэсний асуудал тавигддаг улсуудад тохиромжтой.	Жижиг намуудад давуу тал үүсгэдэг. Хувь тэнцүүлсэн шинж улам тодорх, санал адил жинтэй байх, санал өгөх, тооцоход хялбар, хүйсийн тэгш байдал, үндэстний асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдүүлнэ.	Намын нээлттэй нэрийн жагсаалт байдгаараа сонгогчид илүү ойлгомжтой. Жижиг намуудад суудал ногдох боломж давуутай.	Цөөн намын нөлөөг нэмэгдүүлж, олонхын Засгийн газар бүрдэж, хариуцлага, нэг хүчинд төвлөрнө.	Парламентад хэд хэдэн нам орж, ялангуяа жижиг нам суудал авах өснө. Намын доторх нэр дэвшигчдийн сонгогдох дараалалд сонгогч нөлөөлөх боломж бүрдүүлнэ.
Дутагдалтай талууд						
Сонгогчдын саналын багагүй хэсэг парламентад тусгалаа олохгүй байх сул талтай.	Засгийн газраа намууд нэгдэж байгуулах, хариуцлага хүлээх зээн тодорхойгүй болох, Засгийн газар огцрох магадлал өснө.	Бүс нутгийн болон үндэсний хэмжээний асуудлын зааг ялгарч, Парламентад өөр өөр ашиг сонирхол зөрчилдөх магадлалтай.	Орон нутаг, парламентын гишүүдийн амьд холбоо сулрах, намын лидерүүдийн давамгайл байдал тогтох, эсвэл нөлөө багатай, үгнээс гардаггүй хүмүүсийг жагсаалтаа оруулах, намын доторх эрүүл санал бодлыг үл хүндэтгэх талтай.	Парламент олон намын оролцоотой болж, Засгийн газрыг намууд хамтарч бүрдүүлэх тохиолдол элбэг байдаг.	Сонгогчийн өгсөн саналын нэлээд хэсэг нь парламентад тусгалаа олохгүй гадна талд нь үлддэг.	Намын нээлттэй нэрсийн жагсаалтаас сонголт хийх нь Сонгуульд оролцож байгаа нам бүрээр нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт гаргаж сонгогч бүр түүнээс сонголт хийхэд төвөгтэй.

1.2.Дэлхийн улс орнуудын сонгуулийн тогтолцоо

Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (*Internatioanl IDEA*)-ийн мэдээллийн сангаас авсан мэдээллийн дагуу өдгөө дэлхийн 219 улсаас:

- сонгуулийн холимог тогтолцоотой – 32 улс (14.7%);
- олонхыг төлөөлөх тогтолцоотой – 86 улс (39.6%);
- хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой – 83 улс (38.2%);
- бусад – 8 улс (3.7%);
- шилжилтийн тогтолцоотой – 1 улс (0.5%);
- шууд сонгуульгүй – 7 улс (3.2%);
- мэдээлэл байхгүй – 2 улс байна.


Хүснэгт 2. Дэлхийн улс орнуудын сонгуулийн тогтолцоо⁴¹⁵

Сонгуулийн тогтолцоо	Улсын тоо, эзлэх хувь	Улсын нэр
Сонгуулийн холимог тогтолцоотой	32 улс (14.7%)	Андорра, Боливи, Венесуэл, Гвиней, Герман, Гүрж, Жибути, Зимбабве, Итали, Киргиз, Лесото, Ливи, Литва, Мавритани, Мексик, Монако, Непал, ОХУ, Өмнөд Солонгос, Пакистан, Палестин, Сейшелийн Арлууд, Сенегал, Судан, Тажикистан, Тайвань, Тайланд, Украин, Унгар, Филиппин, Шинэ Зеланд, Япон
Олонхыг төлөөлөх тогтолцоотой	86 улс (39.6%)	Австрали, Азербайжан, Ангилья, Антигуа ба Барбуда, АНУ, Бангладеш, Барбадос, Бахам, Бахрейн, Беларусь, Белиз, Бермуда, БНАКонго Улс, БНКонго Улс, Ботсвана, Бутан, Виржинийн Арлууд, Вьетнам, Габон, Гамби, Гана, Гернси, Гренада, Гэгээн Елена Арал, Доминик, Египет, Жерси, Замби, Ирак, Иран, Их Британи, Йемен, Кайманы Арлууд, Камерун, Канад, Катар, Кени, Кирибати, Коморос, Кот д'Ивуар, Куба, Кукийн Арлууд, Лаос, Либер, Маврики, Малави, Малайз, Мали, Мальдив, Маршаллын Арлууд, Микронез, Монгол, Монцеррат, Мьянмар, Мэн Арал, Нигери, Ниуэ, Оман, Палау, Папуа Шинэ Гвиней, Самоа, Сент Винсент ба Гренадин, Сент Китс ба Невис, Сент Люсиа, Сингапур, Сири, Соломоны Арлууд, Сьерра Леон, Танзани, Токелау, Тонга, Төв Африкийн БНУ, Тринидад ба Тобаго, Тувалу, Туркменистан, Туркс ба Кайкосын Арлууд, Уганда, Узбекистан, Фолклендын Арлууд, Франц, Хаити, Хойд Солонгос, Чад, Энэтхэг, Эсватини, Этиоп, Ямайка
Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой	83 улс (38.2%)	Австри, Албани, Алжир, Ангол, Аргентин, Армени, Аруба, Бельги, Бенин, Болгар, Босни-Херцеговин, Бразил, Буркина Фасо, Бурунди, Гватемал, Гайана, Гвиней-Бисау, Гондурас, Грек, Гренланд, Дани, Доминикан, Зүүн Тимор, Израил, Индонез, Ирланд, Исланд, Испани, Йордан, Кабо Верде, Казахстан, Камбож, Кипр, Кипр (Хойд), Колумби, Косово, Коста Рика, Латви, Ливан, Лихтенштайн, Люксембург, Мальта, Марокко, Мозамбик, Молдова, Монтенегро, Намиби, Нигер, Нидерланд, Нидерландын Антилын Арлууд, Никарагуа, Норвег, Өмнөд Африк, Панам, Парагвай, Перу, Польш, Португал, Руанда, Румын, Сан Марино, Сан Томе ба Принсип, Серб, Словак, Словени, Суринам, Того, Тунис, Турк, Уругвай, Фижи, Финланд, Хойд Македон, Хорват, Чех, Чили, Швед, Швейцар, Шри Ланка, Эквадор, Экваторын Гвиней, Эль Сальвадор, Эстони

⁴¹⁵ <https://www.idea.int/data-tools/world-view/44>

Бусад	8 улс (3.7%)	Афганистан, Вануату, Гибралтар, Кувейт, Науру, Питкэрний Арлууд, Мадагаскар
Шууд сонгуульгүй	7 улс (3.2%)	АНЭУ, Бруней, Ватикан, Саудын Араб, Сомали, Хятад, Эритрей
Шилжилтийн тогтолцоотой	1 улс (0.5%)	Өмнөд Судан

Зураг 1. Хууль тогтоох дээд байгууллагыг бүрдүүлэх сонгуулийн тогтолцоо⁴¹⁶



Тогтолцооны нэр		Улсын тоо, эзлэх хувь
	FPTP	59 (27.2%)
Хоёр шатлалтай саналын	TRS	17 (7.8%)
Альтернатив санал	AV	2 (0.9%)
Блок саналын	BV	15 (6.9%)
Намын багц саналын	PBV	4 (1.8%)
Параллель	Parallel	23 (10.6%)
Пропорционалиар сонгогдсон холимог гишүүд	MMP	9 (4.1%)
Пропорциональ төлөөлөл нэрсийн жагсаалтаар	List PR	85 (39.2%)
Шилжих бололцоотой нэг саналын	STV	2 (0.9%)
Үл шилжих нэг санал	SNTV	5 (2.3%)
Хязгаарлагдмал санал	LV	1 (0.5%)
Шууд сонгуульгүй		7 (3.2%)
Шилжилтийн тогтолцоотой		1 (0.5%)
	Бусад	1 (0.5%)
	Бүгд	217

1.3. Сонгуулийн тогтолцоог үндсэн хуульдаа тусгасан орнууд


Парламентын сонгуулийн үндсэн зарчмыг тогтоосон гол эх сурвалж нь тухайн улсын Үндсэн хууль байдаг. Тэр дундаа сонгуулийн тогтолцооны талаар гадаад орнуудын Үндсэн хуулиар зохицуулсан хэм хэмжээ нь харилцан адилгүй байдаг.

Гэхдээ сонгуулийн талаарх илүү нарийвчилсан зохицуулалтыг хууль тогтоох байгууллагаас баталсан сонгуулийн тухай хууль, эсхүл хууль тогтоох байгууллагын танхимаас баталсан регламентууд байдаг.

⁴¹⁶ <https://www.idea.int/data-tools/world-view/44>

Дэлхийн 83 улсын Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог тогтоосон байна. Үүнд олонхыг төлөөлөх тогтолцоотой 34 улс, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой 34 улс, холимог тогтолцоотой 15 улс тус тус орсон байна.⁴¹⁷

Зураг 2. Үндсэн хуульдаа сонгуулийн тогтолцоог тогтоосон орнууд, (танхимын тоо)



Хүснэгт 3. Үндсэн хуульдаа сонгуулийн тогтолцоог тогтоосон орнуудын жагсаалт

	Нэг танхимтай	Хоёр танхимтай
Олонхыг төлөөлөх тогтолцоо Нэг танхимтай – 16 улс Хоёр танхимтай – 18 улс	Азербайжан Вануату Вьетнам Куба Мальдив Маршаллын Арлууд Науру Невис Папуа Шинэ Гвиней Самоа Сент-Винсент ба Гренадин Соломоны Арлууд Тувалу Туркменистан Хойд Солонгос Хятад	Австрали Антигуа ба Барбуда АНУ Барбадос Белиз Бутан Гаити Гренада Канад Малайз Палау Сент Люсия Тринидад ба Тобаго Фижи Филиппин Чех Энэтхэг Ямайка
Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо Нэг танхимтай – 20 улс Хоёр танхимтай – 14 улс	Албани Зүүн Тимор Исланд Киргиз Коста-Рика Лаос Латви	Австри Аргентин Бельги Боливи Бразил Доминиканы БНУ Испани

⁴¹⁷ Выборы в мире: Избирательные системы. И.Б.Борисов, А.Г.Головин, А.В.Игнатов. Российский общественный институт избирательного права, Избирательная комиссия ленинградской области. Санкт-Петербург. 2015. 36-39 дэх тал.

	Лихтенштайн Люксембург Никарагуа Норвег Панам Перу Португал Сальвадор Суринам Финланд Швед Шри Ланка Эстони	Колумби Нидерланд Парагвай Польш Тайланд Уругвай Швейцар
Холимог тогтолцоо <i>Нэг танхимтай – 8 улс</i> <i>Хоёр танхимтай – 7 улс</i>	Венесуэл Гватемал Гондурас Гүрж Микронез Шинэ Зеланд Өмнөд Солонгос Эквадор	Камбож Мексик Мьянмар Пакистан Тайланд Чили Япон

Тайлбар: Судалгаанд парламентын хоёр танхимтай орнуудын хувьд доод танхимыг сонгосон болно.

ХОЁР. ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ТОО, ТҮҮНИЙГ ТОГТООХ, ТООЦОХ ЗАРЧИМ

2.1. Куб язгуурын хууль

Парламентын гишүүдийн тоо улс төрийн намуудын төлөөлөлд тодорхой нөлөө үзүүлдэг. Ялангуяа жижиг тогтолцоонд (нэг мандаттай тойрог, олон мандаттай жижиг тойрог г.м.) олон суудалтай байна гэдэг нь орон нутгийн дэмжлэгтэй жижиг намуудын төлөөллийг нэмэгдүүлэх боломжтой гэсэн үг. Тиймээс улс орны хувьд хэтэрхий жижиг парламент нь чухал эрх ашгийг хааж болох талтай. Нөгөө талаар, хэт том парламент нь хууль тогтоох нүсэр үйл явцыг бий болгох, парламентын дотоод буюу хороодын бүтцийг илүү төвөгтэй болгох, эсхүл хууль тогтоох дийлэнх эрх мэдлийг гүйцэтгэх засаглалд шилжүүлэхэд түлхэц болох талтай.⁴¹⁸

Хууль тогтоогчийн хамгийн чухал үйл ажиллагааны нэг бол харилцаа холбоо юм. Тэдний ажлын хамгийн чухал шинж чанар нь төлөөллийн чиг үүрэг буюу сонгогчидтой харилцах, мөн хууль тогтоох чиг үүрэг буюу бусад хууль тогтоогчидтой харилцах явдал юм. Тухайн улсын хувьд жижиг парламенттай байх нь хууль тогтоогчид хоорондын харилцааны сувгийг багасгаж, улмаар хууль тогтоох чиг үүргийг хялбарчлах боловч сонгогчидтой харилцах сувгийг нэмэгдүүлдэг. Эсрэгээрээ том парламенттай байх нь сонгогчидтой харилцах сувгийг хумих ба төлөөллийг “сайжруулах” боловч бусад хууль тогтоогчидтой харилцах сувгийг нэмэгдүүлэх замаар хууль боловсруулах үйл явцыг үр ашиггүй болгодог.

Парламентын гишүүдийн зохистой хэмжээг тогтоох “куб язгуурын хууль” (cube root formula)⁴¹⁹-ийг анх 1972 онд Эстонийн улс төр судлаач Рейн Таагепера томьёолсон

⁴¹⁸ Electoral Systems. Parliamentary Size. ACE, The Electoral Knowledge Network.
<http://aceproject.org/electoral-advice/archive/questions/replies/760379812>


⁴¹⁹ Parliaments Shapes and Sizes, Raphael Godefroy and Nicolas Klein* January 6, 2017.
<https://nicolasklein.com/data/documents/parliaments010617.pdf>

байдаг. Энэ нь парламентын гишүүдийн тоо нь хүн амын тооноос куб язгуур гаргасан тоотой ойролцоо байвал зохимжтой гэсэн үзэл санаа бөгөөд (Taagepera, 1972; Taagepera and Shugart, 1989; Taagepera and Recchia, 2002; Taagepera, 2007) төлөөллийн пропорционал хэмжээ алдагдахаас сэргийлэхэд чиглэгдсэн байна (Lijphart 2012).⁴²⁰

Практикт парламентын гишүүдийн тоог тогтоох ерөнхий/нийтлэг томьёолол байхгүй. Парламентын хэмжээ буюу гишүүдийн тоо нь тухайн улс орны нөхцөл байдал, хөгжлийн түвшингээс хамааран янз бүр байх ба парламентын гишүүдийн зохистой тоо хэмжээг тогтооход тухайн улсын парламентын түүхэн уламжлал, улс орны хэмжээ, хүн амын хэмжээ (сонгуулийн эрх бүхий иргэний тоо болон бичиг үсэг мэддэг хүний тоо), газар зүй, нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжүүдийн тоо зэрэг нь нөлөөлөх хүчин зүйлүүд байж болох юм.⁴²¹

Улс орнуудын парламентын гишүүдийн тоог хүн амын хэмжээтэй харьцуулбал (куб язгуурын хуулиар) дараах байдалтай байна:

Зураг 3. Парламентын гишүүдийн тоог хүн амын хэмжээтэй харьцуулсан байдал



- Парламентын гишүүдийн тоо хэт өндөр улс орнууд (тухайлбал, Франц, Итали, Герман, Их Британи, Швед г.м. Эндээс Францыг авч үзвэл, Үндэсний Ассамблей болон Сенат нийлээд 898 гишүүнтэй байх ба куб язгуурын

⁴²⁰ Explaining reforms of assembly sizes, Reassessing the cube root law relationship between population and assembly size, Kristof Jacobs, Institute of Management Research, Radboud University (NL) Simon Otjes, Documentation Centre Dutch Political Parties, University of Groningen (NL) <https://ecpr.eu/Filestore/PaperProposal/3bc100be-56fe-4efc-8d8c-a1f0b85e7f24.pdf>

⁴²¹ Electoral Systems. Parliamentary Size. ACE, The Electoral Knowledge Network. <http://aceproject.org/electoral-advice/archive/questions/replies/760379812>
Formula for the number of Members of Parliament? ACE, The Electoral Knowledge Network, June 24, 2013. <http://aceproject.org/main/english/es/esc03.htm>

хуулиар зохистой тоо хэмжээ нь 405 байгаа юм. Италийн хувьд зохистой хэмжээ 395 байх бол практик дээр 951 гишүүнтэй байна);

- Парламентын гишүүдийн тоо зохистой хэмжээтэй ойролцоо улс орнууд (Испани, Дани, Швейцар, Португал, Мексик г.м.);
- Парламентын гишүүдийн тоо хэт цөөн улс орнууд (Колумби, Чили, Энэтхэг, Австрали, Нидерланд, Израил, АНУ г.м.).

Аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад ардчилсан төлөөллийг судлахад тухайн улсын хүн амын болон парламентын төлөөллийн тоо хоорондын куб язгуурын үндсийг дараах байдлаар тооцно:

$$S = P^{1/3}$$

Энд “**S**” нь парламент (эсхүл парламентын доод танхим)-ын суудал, харин “**P**” нь улсын нийт хүн ам болно. Хөгжиж буй орнуудын хувьд энэхүү энгийн тооцоогоор парламент дахь төлөөллийн тоог гарсан байна. Үнэн хэрэгтээ энд нийт хүн амын тоо бус, харин “**Pa**” буюу “идэвхтэй” хүн амын тоо чухал юм. Идэвхтэй хүн ам нь зах зээлийн эргэлтэд оролцож болох бөгөөд ингэснээр улс төрийн төлөөллийг эрэлхийлж болох хэсэг гэж тооцож болно:

$$Pa = PLW$$

Энд “**L**” нь хүн амын бичиг үсэгт тайлагдсан хувь, “**W**” нь хүн амын хөдөлмөрийн насны хувь болно. Иймд хэрэв 10 сая хүн амтай, тэдгээрийн 90% нь бичиг үсэгт тайлагдсан, 55% нь хөдөлмөрийн насных бол “**Pa**” буюу “идэвхтэй” хүн амын тоо 4,950,000 болно.

$$Pa = 10,000,000 \times .90 \times .55 = 4,950,000$$

Харин 10 сая хүн амтай, тэдгээрийн 55% нь хөдөлмөрийн насны хүн, харин бичиг үсэгт тайлагдсан байдал нь зөвхөн 75% байсан бол идэвхтэй хүн амын тоо нь 4,125,000 болно.

$$Pa = 10,000,000 \times .75 \times .55 = 4,125,000$$

Хөгжингүй орнуудад идэвхтэй болон нийт хүн амын хооронд ялгаа бага байдаг боловч хөгжиж буй орнуудад том ялгаатай байж болно.

Бүх улсуудыг парламентын хамт судлахад идэвхтэй хүн амын тоо болон парламентын суудлын тооны хооронд дараах харьцаа илэрсэн байна:

$$S = (2Pa)^{1/3}$$

Дээрх хоёр жишээг авч үзвэл, 4,950,000 идэвхтэй хүн амтай улсын парламент нь 215 гишүүнтэй байхаар тооцох бол 4,125,000 идэвхтэй хүн амтай улсын парламент нь 202 гишүүнтэй байхаар тооцож байна.

Энэхүү тэгшитгэлээр тооцоолоход цөөн тооны улсуудад тооцоолсон хэмжээнээс 2 дахин олон, эсхүл талаас бага тооны парламентын суудалтай байна. Тэгэхээр тухайн тэгшитгэлийг тухайн улс орны идэвхтэй хүн амын тодорхойлогдох боломжтой бол тухайн орны чуулганы тохиромжтой хэмжээг урьдчилан таамаглах боломжтой гэж үзэж байна.

2.2. Парламентын нэг танхимтай улс орнуудын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулсан байдал

Судалгааны энэ хэсэгт парламентын нэг танхимтай 140 улсыг хамруулав. Эдгээр улсын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулан, мөн парламентад нэг гишүүний төлөөлөх иргэдийн тоог 8 багц болгон хүснэгтээр харуулав.

Судалгаанд хамрагдсан нийт 140 улсын 31 улсад парламентын нэг гишүүн нь 20.001-50.000 иргэнийг төлөөлж байгаа нь хамгийн их буюу 22.1 хувийг эзэлж байна. Дөрвөн улсад парламентын нэг гишүүн нь 200.001-ээс дээш иргэнийг төлөөлж байгаа нь хамгийн бага буюу 2.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Парламентын нэг танхимтай улсуудын хүн амын тоо

Д/д	Иргэдийн тоо	Улсын тоо	Эзлэх хувь
1.	200.001-ээс дээш	4	2.9
2.	100.001-200.000	16	11.4
3.	50.001-100.000	25	17.9
4.	20.001-50.000	31	22.1
5.	10.001-20.000	15	10.7
6.	5.001-10.000	10	7.1
7.	1.001-5.000	24	17.1
8.	1.000 хүртэл	15	10.7

Харин ойролцоо үзүүлэлттэй 2 багц улсыг авч үзвэл, 25 улсад (17.9 хувь) парламентын нэг гишүүн нь 50.001-100.000 иргэнийг, 24 улсад (17.1 хувь) парламентын нэг гишүүн нь 1.001-5.000 иргэнийг тус тус төлөөлж байна.

Хүснэгт 5. Парламентын нэг танхимтай улс орнуудын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулсан байдал

Д/д	Улсын нэр	Хүн амын тоо	Гишүүдийн тоо	Нэг гишүүний төлөөлөх иргэдийн тоо
1. 200.001-ээс дээш иргэдийг				
1.	Бангладеш	166,280,712	300	554,269
2.	Иран	80,840,713	290	278,761
3.	Перу	30,147,935	130	231,907
4.	Хятад	1,355,692,576	2,980	454,930
2. 100.001-200.000 иргэдийг				
5.	Арабын Нэгдсэн Эмират	5,628,805	40	140,720
6.	Бенин	10,160,556	83	122,416
7.	Буркина Фасо	18,365,123	127	144,607
8.	Венесуэл	28,868,486	165	174,961
9.	Вьетнам	93,421,835	500	186,844
10.	Гвиней	11,474,383	114	100,652
11.	Египет	86,895,099	Доод тал нь 450	193,100
12.	Ирак	32,585,692	325	100,264
13.	Мали	16,455,903	160	102,849
14.	Нигер	17,466,172	113	154,568
15.	Өмнөд Солонгос	49,039,986	300	163,467
16.	Саудын Араб	27,345,986	150	182,307
17.	Танзани	49,639,138	357	139,045

18.	Турк	81,619,392	600	136,032
19.	Хонгконг	7,112,688	70	101,610
20.	Эквадор	15,654,411	137	114,266
3. 50.001-100.000 иргэдийг				
21.	Азербайжан	9,686,210	125	77,490
22.	Ангол	19,088,106	220	86,764
23.	Гана	25,758,108	275	93,666
24.	Гватемал	14,647,083	158	92,703
25.	Замби	14,638,505	158	92,649
26.	Израил	7,821,850	120	65,182
27.	Коста-Рика	4,755,234	57	83,425
28.	Лаос	6,803,699	132	51,543
29.	Малави	17,377,468	193	90,039
30.	Мозамбик	24,692,144	250	98,769
31.	Никарагуа	5,848,641	92	63,572
32.	Панам	3,608,431	71	50,823
33.	Папуа Шинэ Гвиней	6,552,730	111	59,034
34.	Сенегал	13,635,927	150	90,906
35.	Сингапур	5,567,301	87	63,992
36.	Сири	17,951,639	250	71,807
37.	Того	7,351,374	91	80,784
38.	Төв Африк	5,277,959	105	50,266
39.	Тунис	10,937,521	217	50,403
40.	Уганда	35,918,915	375	95,784
41.	Украин	44,291,413	450	98,425
42.	Хондурас	8,598,561	128	67,176
43.	Чад	11,412,107	188	60,703
44.	Шри Ланка	21,866,445	225	97,184
45.	Эль Сальвадор	6,125,512	84	72,923
4. 20.001-50.000 иргэдийг				
46.	Албани	3,020,209	140	21,573
47.	Армени	3,060,631	Доод тал нь 101	23,364
48.	Болгар	6,924,716	240	28,853
49.	Ботсвана	2,155,784	63	34,218
50.	Гамби	1,925,527	53	36,331
51.	Грек	10,775,557	300	35,919
52.	Гүрж	4,935,880	150	32,906
53.	Дани	5,569,077	179	31,112
54.	Катар	2,123,160	45	47,181
55.	Киргиз	5,604,212	120	46,702
56.	Коморос	766,865	33	23,238
57.	Кувейт	2,742,711	65	42,196
58.	Латви	2,165,165	100	21,652
59.	Лебанон	5,882,562	128	45,958
60.	Ливи	6,244,174	200	31,221
61.	Мавритани	3,516,806	146	24,087
62.	Молдова	3,583,288	101	35,478
63.	Монгол	3,357,542⁴²²	76	44,178
64.	Норвег	5,147,792	169	30,460
65.	Португал	10,813,834	230	47,017
66.	Серби	7,209,764	250	28,839
67.	Словак	5,443,583	150	36,291
68.	Сьерра Леон	5,743,725	124	46,320
69.	Туркменистан	5,171,943	125	41,376

⁴²² 2020 оны Монгол Улсын хүн амын тоо. Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

70.	Унгар	9,919,128	199	49,845
71.	Финланд	5,268,799	200	26,344
72.	Хойд Солонгос	24,851,627	687	36,174
73.	Хорват	4,470,534	151	29,606
74.	Швед	9,723,809	349	27,862
75.	Шинэ Зеланд	4,401,916	120 usually	36,682
76.	Эритрей	6,380,803	150	42,539
5. 10.001-20.000 иргэдийг				
77.	Бруней	422,675	33	12,808
78.	Гайана	735,554	65	11,316
79.	Гвиней-Бисау	1,693,398	102	16,602
80.	Гуам	161,001	15	10,733
81.	Жибути	810,179	65	12,464
82.	Кипр	1,172,458	80	14,656
83.	Косово	1,859,203	120	15,493
84.	Куба	11,047,251	612	18,051
85.	Литви	2,848,000	141	19,863
86.	Мавритус	1,331,155	70	19,017
87.	Макао	587,914	33	17,816
88.	Македони	2,091,719	123	17,006
89.	Соломоны арлууд	609,883	50	18,064
90.	Суринам	573,311	51	11,241
91.	Эстони	1,257,921	101	12,455
6. 5.001-10.000 иргэдийг				
92.	АНУ-ын Виржин арлууд	104,170	15	6,945
93.	Аруба	110,663	21	5,270
94.	Вануату	266,937	52	5,133
95.	Зүүн Тимор	1,201,542	52-оос 65	9,242
96.	Исланд	317,351	63	5,037
97.	Кабо-Верде	538,535	72	7,480
98.	Люксембург	520,672	60	8,678
99.	Микронез	105,681	14	7,549
100.	Монтенегро	650,036	81	8,025
101.	Фижи	903,207	50	8,769
7. 1.001-5.000 иргэдийг				
102.	Ангуилла	16,086	11	1,462
103.	Андорра	85,458	Доод тал нь 28	3,052
104.	Гибралтар	29,185	18	1,621
105.	Гринланд	57,728	31	1,862
106.	Гуэрнсей	65,849	45	1,463
107.	Доминик	73,449	32	2,295
108.	Жерси	96,513	58	1,664
109.	Кеймен арлууд	54,914	21	2,615
110.	Кирибати	104,488	46	2,271
111.	Лихтенштайн	37,313	25	1,493
112.	Мальдив	393,595	85	4,631
113.	Мальта	412,655	65	3,174
114.	Маршаллын арлууд	70,983	33	2,151
115.	Монако	30,508	24	1,271
116.	Самоа	196,628	49	4,013
117.	Сан Китс-Невис	51,538	14	3,681
118.	Сан Мартин	31,530	23	1,371
119.	Сан-Томе ба Принсипи	190,428	55	3,462
120.	Сейшелийн арлууд	91,650	34	2,696

121.	Сент-Винсент ба Гренадин	102,918	21	4,901
122.	Синт-Мартен	39,689	15	2,646
123.	Теркс-Кайкосын арлууд	49,070	19	2,583
124.	Тонга	106,440	26	4,094
125.	Шинэ Каледониа	267,840	54	4,960
8. 1000 хүртэл иргэдийг				
126.	Ватикан	842	7	120
127.	Вуоллис-Футуна	15,561	20	778
128.	Кокос арлууд	596	7	85
129.	Крисмас арлууд	1,530	9	170
130.	Монцеррат	5,215	11	474
131.	Науру	9,488	19	499
132.	Ниуэ	1,190	20	60
133.	Норфолкын арлууд	2,210	9	246
134.	Питкэрн арлууд	48	10	5
135.	Сан Бартелеми	7,267	19	382
136.	Сан Марино	32,742	60	546
137.	Сан Хелена	7,776	17	457
138.	Сан-Пьер Микүэллон	5,716	19	301
139.	Токелау	1,337	20	67
140.	Тувалу	10,782	15	719

Монгол Улсын хувьд, Улсын Их Хурал (УИХ)-ын нэг гишүүн нь 20.001-50.000 иргэнийг төлөөлж байгаа багцад хамаарч байна.

Монгол Улс 1990 оноос хойш төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлыг найман удаа бүх нийтийн, шууд, чөлөөт, ардчилсан сонгуулиар байгуулаад байна.

Манай улсын нийт хүн ам 1992 онд 2,115.0 мянган байсан бол 2020 онд 3,296.9 мянга болж 52 хувиар өссөн байна. Энэ нь:


- 1992 онд УИХ-ын нэг гишүүн 29.145 иргэнийг төлөөлж байсан;
- 2020 онд УИХ-ын нэг гишүүн 44.178 иргэнийг төлөөлж байсан.

Харин сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хүний тоо 1992 онд УИХ-ын анхны сонгуулийг явуулснаас хойш 2020 онд 85 хувиар өссөн байна. Энэ нь:

- 1992 онд УИХ-ын нэг гишүүн 14.368 иргэнийг төлөөлж байсан;
- 2020 онд УИХ-ын нэг гишүүн 26.368 иргэнийг төлөөлж байсан.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Зураг 4. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хүний тооны өсөлт,
мянган хүн



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

ХАВСРАЛТ

Дэлхийн улсуудын сонгуулийн тогтолцоо (хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн систем, гишүүдийн тоо)⁴²³

Улсын нэр	Хамгийн сүүлд явагдсан сонгуулийн огноо	Сонгуулийн тогтолцоо	Хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн тогтолцоо	Шатлал	Хууль тогтоох дээд байгууллагын гишүүдийн тоо (шууд сонгогддог)	Хууль тогтоох дээд байгууллагын гишүүдийн тоо
Австрали	2019	Олонхыг төлөөлөх	AV	1	151	151
Австри	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	3	183	183
Азербайжан	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1	125	125
Албани	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	140	140
Алжир	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	407	407
Ангилья	2020	Олонхыг төлөөлөх	#FPTP #BV	2	11	13
Ангол	2017	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	220	220
Андорра	2019	Холимог	Parallel	2	28	28
Антигуа ба Барбуда	2014	Олонхыг төлөөлөх	FPTP	1	17	17
АНУ	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1	435	435
АНЭУ	2019		Шууд сонгуульгүй			
Аргентин	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	257	257
Армени	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	107	107
Аруба	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	21	21
Афганистан	2018	Бусад	SNTV	1	250	250
Бангладеш	2018	Олонхыг төлөөлөх	FPTP	1	300	350
Барбадос	2022	Олонхыг төлөөлөх	FPTP	1	30	30
Бахам	2021	Олонхыг төлөөлөх	FPTP	1	39	39
Бахрейн	2018	Олонхыг төлөөлөх	TRS	1	40	40
Беларусь	2019	Олонхыг төлөөлөх	FPTP	1	110	110
Белиз	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1	31	31
Бельги	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	150	150
Бенин	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	83	83
Бермуда	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1	36	36
БНАКонго Улс	2018	Олонхыг төлөөлөх	#FPTP #List PR	H	500	500
БНКонго Улс	2017	Олонхыг төлөөлөх	TRS	1	151	151
Болгар	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	240	240
Боливи	2020	Холимог	MMP	3	130	130
Босни-Херцеговин	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	42	42
Ботсвана	2019	Олонхыг төлөөлөх	FPTP	1	57	63
Бразил	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	513	513
Бруней	2017		Шууд сонгуульгүй			
Буркина Фасо	2020	Хувь тэнцүүлэн	List PR	2	127	127

⁴²³ <https://www.idea.int/data-tools/world-view/44>

		хуваарилах				
Бурунди	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	100	124
Бутан	2018	Олонхыг төлөөлөх	FPTP	1	47	47
Вануату	2020	Бусад	SNTV	H	52	52
Ватикан	2017		Шууд сонгуульгүй			
Венесуэл	2020	Холимог	Parallel	2	277	280
Виргинийн Арлууд	2019	Олонхыг төлөөлөх	FPTP	2	13	13
Вьетнам	2021	Олонхыг төлөөлөх	TRS	1	500	500
Габон	2018	Олонхыг төлөөлөх	TRS	1	143	143
Гамби	2022	Олонхыг төлөөлөх	FPTP	1	53	58
Гана	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1	275	275
Гватемал	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	160	160
Гайана	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	65	65
Гвиней	2020	Холимог	Parallel	2	114	114
Гвиней-Бисау	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	102	102
Герман	2021	Холимог	MMP	2	736	736
Гернси	2020	Олонхыг төлөөлөх	BV	1	38	40
Гибралтар	2019	Бусад	LV	1	17	17
Гондурас	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	128	128
Грек	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	300	300
Гренада	2018	Олонхыг төлөөлөх	FPTP	1	15	15
Гренланд	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	31	31
Гүрж	2020	Холимог	Parallel	2	150	150
Гэгээн Елена Арал	2021	Олонхыг төлөөлөх	BV	1	12	15
Дани	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	179	179
Доминик	2019	Олонхыг төлөөлөх	FPTP	1	21	32
Доминикан	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	3	190	190
Египет	2020	Олонхыг төлөөлөх	#TRS #PBV	2	568	596
Жерси	2014	Олонхыг төлөөлөх	#FPTP #BV	H	49	49
Жибути	2018	Холимог	MMP	1	65	65
Замби	2021	Олонхыг төлөөлөх	FPTP	1	156	167
Зимбабве	2018	Холимог	Parallel	2	270	270
Зүүн Тимор	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	65	65
Израил	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	120	120
Индонез	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	575	575
Ирак	2021	Олонхыг төлөөлөх	SNTV	1	329	329
Иран	2020	Олонхыг төлөөлөх	TRS	1	290	290
Ирланд	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	STV	1	159	160
Исланд	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	63	63
Испани	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	350	350

Итали	2018	Холимог	Parallel	2	630	630
Их Британи	2019	Олонхыг төлөөлөх	FPTP	1	650	650
Йемен	2003	Олонхыг төлөөлөх	FPTP	1	301	301
Йордан	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	130	130
Кабо Верде	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	72	72
Казахстан	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	98	107
Кайманы Арлууд	2021	Олонхыг төлөөлөх	FPTP	1	19	19
Камбож	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	125	125
Камерун	2020	Олонхыг төлөөлөх	List PR	H	180	180
Канад	2021	Олонхыг төлөөлөх	FPTP	1	338	338
Катар	2021	Олонхыг төлөөлөх	FPTP	1	30	45
Кени	2017	Олонхыг төлөөлөх	FPTP	2	337	350
Кипр	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	56	56
Кипр (Хойд)	2022	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	50	50
Киргиз	2021	Холимог	Parallel	2	90	90
Кирибати	2020	Олонхыг төлөөлөх	TRS	1	44	46
Колумби	2022	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	166	166
Коморос	2020	Олонхыг төлөөлөх	TRS	1	24	33
Косово	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	120	120
Коста Рика	2022	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	57	57
Кот д'Ивуар	2021	Олонхыг төлөөлөх	#FPTP #PBV	H	255	255
Куба	2018	Олонхыг төлөөлөх	TRS	1	612	612
Кувейт	2020	Бусад	SNTV	1	50	65
Куйкин Арлууд	2018	Олонхыг төлөөлөх	FPTP	1	24	24
Лаос	2021	Олонхыг төлөөлөх	BV	1	164	164
Латви	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	100	100
Лесото	2017	Холимог	MMP	2	120	120
Либерии	2017	Олонхыг төлөөлөх	FPTP	1	73	73
Ливан	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	128	128
Ливи	2014	Холимог	Parallel	3	200	200
Литва	2020	Холимог	Parallel	2	141	141
Лихтенштайн	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	25	25
Люксембург	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	60	60
Маврики	2019	Олонхыг төлөөлөх	BV	1	62	70
Мавритани	2018	Холимог	Parallel	3	157	157
Мадагаскар	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах болон Олонхыг төлөөлөх	#FPTP #List PR	1	151	151
Малави	2019	Олонхыг төлөөлөх	FPTP	1	193	193
Малайз	2018	Олонхыг төлөөлөх	FPTP	1	222	222
Мали	2020	Олонхыг төлөөлөх	TRS	1	147	147
Мальдив	2019	Олонхыг төлөөлөх	FPTP	1	87	87

Мальта	2022	Хувь тэнцүүлэн хуваарилах	STV	1	67	67
Марокко	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	395	395
Маршаллын Арлууд	2019	Олонхыг төлөөлөх	#FPTP #BV	H	33	33
Мексик	2021	Холимог	MMP	2	500	500
Микронез	2021	Олонхыг төлөөлөх	FPTP	2	14	14
Мозамбик	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	250	250
Молдова	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	101	101
Монако	2018	Холимог	Parallel	2	24	24
Монгол	2020	Олонхыг төлөөлөх	BV	1	76	76
Монтенегро	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	81	81
Монцеррат	2019	Олонхыг төлөөлөх	TRS	1	9	11
Мьянмар	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1	330	440
Мэн Арал	2021	Олонхыг төлөөлөх	BV	1	24	24
Намиби	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	96	96
Науру	2019	Бусад	Modified BC	1	19	19
Непал	2017	Холимог	Parallel	2	275	275
Нигер	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	H	171	171
Нигери	2019	Олонхыг төлөөлөх	FPTP	1	360	360
Нидерланд	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	150	150
Нидерландын Антилын Арлууд	2010	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	22	22
Никарагуа	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	90	90
Ниуэ	2020	Олонхыг төлөөлөх	#FPTP #BV	2	20	20
Норвег	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	169	169
Оман	2019	Олонхыг төлөөлөх	#FPTP #BV	H	86	86
ОХУ	2021	Холимог	Parallel	2	450	450
Өмнөд Африк	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	400	400
Өмнөд Солонгос	2020	Холимог	MMP	2	300	300
Өмнөд Судан	2016	Шилжилтийн	Шилжилтийн			
Пакистан	2018	Холимог	Parallel	2	342	342
Палау	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1	16	16
Палестин	2006	Холимог	Parallel	2	132	132
Панам	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	#FPTP #List PR	H	71	71
Папуа Шинэ Гвиней	2017	Олонхыг төлөөлөх	AV	2	111	111
Парагвай	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	80	80
Перу	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	130	130
Питкэрний Арлууд	2005	Бусад	SNTV	1	6	8
Польш	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	460	460
Португал	2022	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	230	230
Руанда	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	53	80

Румын	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	312	329
Самоа	2021	Олонхыг төлөөлөх	FPTP	1	51	51
Сан Марино	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	60	60
Сан Томе ба Принсип	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	55	55
Саудын Араб	2021		Шууд сонгуульгүй			
Сейшелийн Арлууд	2020	Холимог	Parallel	2	35	35
Сенегал	2017	Холимог	Parallel	3	165	165
Сент Винсент ба Гренадин	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1	15	23
Сент Китс ба Невис	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1	11	15
Сент Люсия	2021	Олонхыг төлөөлөх	FPTP	1	17	17
Серби	2022	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	250	250
Сингапур	2020	Олонхыг төлөөлөх	#FPTP #PBV	H	93	104
Сири	2020	Олонхыг төлөөлөх	BV	1	250	250
Словак	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	150	150
Словени	2022	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	90	90
Соломоны Арлууд	2019	Олонхыг төлөөлөх	FPTP	1	50	50
Сомали	2022		Шууд сонгуульгүй			
Судан	2015	Холимог	Parallel	3	450	450
Суринам	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	51	51
Сьерра Леон	2018	Олонхыг төлөөлөх	FPTP	1	132	146
Тажикистан	2020	Холимог	Parallel	2	63	63
Тайвань	2020	Холимог	Parallel	3	113	113
Тайланд	2019	Холимог	MMP	2	500	500
Танзани	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1		
Того	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	91	91
Токелау	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1	22	22
Тонга	2021	Олонхыг төлөөлөх	FPTP	1	17	26
Төв Африкийн БНУ	2020	Олонхыг төлөөлөх	TRS	1	140	140
Тринидад ба Тобаго	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1	41	41
Тувалу	2019	Олонхыг төлөөлөх	BV	1	16	16
Тунис	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	217	217
Турк	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	600	600
Туркменистан	2018	Олонхыг төлөөлөх	TRS	1	125	125
Туркс ба Кайкосын Арлууд	2021	Олонхыг төлөөлөх	#FPTP #BV	2	15	19
Уганда	2021	Олонхыг төлөөлөх	FPTP	1	499	529
Узбекистан	2019	Олонхыг төлөөлөх	TRS	1	150	150
Украин	2019	Холимог	Parallel	2	424	424
Унгар	2022	Холимог	MMP	2	199	199
Уругвай	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	99	99
Фижи	2018	Хувь тэнцүүлэн	List PR	1	51	51

		хуваарилах				
Филиппин	2019	Холимог	Parallel	2	306	306
Финланд	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	200	200
Фолклендын Арлууд	2021	Олонхыг төлөөлөх	BV	1	8	8
Франц	2017	Олонхыг төлөөлөх	TRS	1	577	577
Хаити	2021	Олонхыг төлөөлөх	TRS	1		
Хойд Македон	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	120	120
Хойд Солонгос	2005	Олонхыг төлөөлөх	TRS	1	687	687
Хорват	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	151	151
Хятад	2017		Шууд сонгуульгүй			
Чад	2011	Олонхыг төлөөлөх	#FPTP #PBV #List PR	H	188	188
Чех	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	200	200
Чили	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	155	155
Швед	2018	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	349	349
Швейцар	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	200	200
Шинэ Зеланд	2020	Холимог	MMP	3	120	120
Шри Ланка	2020	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	225	225
Экватор	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	3	137	137
Экваторын Гвиней	2017	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	100	100
Эль Сальвадор	2021	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	1	84	84
Энэтхэг	2019	Олонхыг төлөөлөх	FPTP	1	543	545
Эритрей	2017		Шууд сонгуульгүй			
Эсватини	2018	Олонхыг төлөөлөх	FPTP	1	59	70
Эстони	2019	Хувь тэнцүүлэн хуваарилах	List PR	2	101	101
Этиоп	2021	Олонхыг төлөөлөх	FPTP	1	547	547
Ямайка	2020	Олонхыг төлөөлөх	FPTP	1	63	63
Япон	2021	Холимог	Parallel	2	465	465

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Taagepera, Rein. 1973. "Seats and Votes: A Generalization of the Cube Law of Elections." *Social Science Research* 2:257-275. 29 Theil, H. 1969. "The Cube Law Revisited."
- Parliaments Shapes and Sizes, Raphael Godefroy and Nicolas Klein* January 6, 2017 <https://nicolasklein.com/data/documents/parliaments010617.pdf>
- Explaining reforms of assembly sizes, Reassessing the cube root law relationship between population and assembly size, Kristof Jacobs, Institute of Management Research, Radboud University (NL) Simon Otjes, Documentation Centre Dutch Political Parties, University of Groningen (NL) <https://ecpr.eu/Filestore/PaperProposal/3bc100be-56fe-4efc-8d8c-a1f0b85e7f24.pdf>
- <http://aceproject.org/electoral-advice/archive/questions/replies/760379812>
- <https://www.idea.int/data-tools/world-view/44>
- Formula for the number of Members of Parliament? ACE, The Electoral Knowledge Network, June 24, 2013. <http://aceproject.org/main/english/es/esc03.htm>
- <https://fruitsandvotes.wordpress.com/category/electoral-rules/cube-root-law/>
- Electoral Systems. Parliamentary Size. ACE, The Electoral Knowledge Network. <http://aceproject.org/electoral-advice/archive/questions/replies/760379812>
- <https://voxeu.org/article/optimal-number-representatives-democracy>
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
- Сонгуулийн тогтолцоо, ангилал болон сонгуулийн тогтолцоог Үндсэн хуульдаа тусгасан орнуудын талаарх лавлагаа. СТ-19/419. УИХ-ын Тамгын газрын Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба. 2019 он.
- Төлөөллийн эрх мэдлийн байгууллагын төлөөллийн тоог тогтоох, тооцох зарчмын талаарх лавлагаа (куб язгуурын хууль). СТ-19/418. УИХ-ын Тамгын газрын Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба. 2019 он.
- Парламентын нэг танхимтай улс орнуудын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулсан байдал. СТ-19/417. УИХ-ын Тамгын газрын Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба. 2019 он.



**УЛС ТӨРИЙН НАМЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ДЭЛХИЙ НИЙТИЙН ЧИГ ХАНДЛАГА, УЛС
ТӨРИЙН НАМ БАЙГУУЛАХ БОСГО, ГИШҮҮНЧЛЭЛ БОЛОН СОНГУУЛИЙН
ПРОПОРЦИОНАЛЬ СИСТЕМ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА**

(Мэдээлэл, лавлагаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Г.Билгээ, Д.Аюуш,
Б.Буянзаяа, П.Уранчимэг, Б.Туул, Р.Дэлгэрмаа*

АГУУЛГА

Асуулт 1. Улс төрийн намын үзэл баримтлал, дэлхий нийтийн чиг хандлага

Асуулт 2. Улс төрийн намын гишүүнчлэл, тоо

Асуулт 3. Сонгуулийн пропорционал систем

Асуулт 4. Улс төрийн нам байгуулах босго

**Асуулт 1. УЛС ТӨРИЙН НАМЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ДЭЛХИЙ НИЙТИЙН ЧИГ
ХАНДЛАГА**

а/ Улс төрийн үндсэн номлолууд

Өндөр түвшинд системчлэгдэж, ихэвчлэн онолын дүгнэлтийн хэлбэртэй байгаа үзэл санааны цогцсыг номлол гэдэг. Үзэл суртал нь улс төрийн, эрх зүйн, шашны, ёс суртахууны зэрэг нийгмийн ухамсрын аль нэг хэлбэрээр илэрч, оршиж байдаг. Эдгээрийн дотроос улс төрийн үзэл суртал нь улс төрийн харилцаа, юуны өмнө улс төрийн засаглалын харилцааг тусгаж, уг харилцаанд оролцогч хүчнүүдийн ашиг сонирхлыг илэрхийлж байдаг тул хамгийн чухал юм. Аль нэг улс төрийн номлол нь төрийн Үндсэн хууль, улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр, улс төрийн хүчнүүдийн үйл ажиллагааны зорилго, арга замыг тодорхойлсон бусад баримт бичгүүдэд ямар нэг хэмжээгээр тусгагддаг.

Онол, улс төрийн номлолын хувьд дэлхий дээр дараах үзэл баримтлалууд бүрэлдэн бий болсон. Үүнд:

ЛИБЕРАЛИЗМ

“Либерализм” гэдэг бол уугаа “эрх чөлөө” гэсэн утга бүхий латин гаралтай нэр томъёо. Либерализм өөртөө маш олон үзэл санааг багтаана. Үүнд: чөлөөт шүүмжлэл, сэтгэлгээний өөр хэв загварыг хүлээн зөвшөөрөх, олон янзын үзэл бодолд хүлээцтэй хандахыг дадал заншил болгон зан суртахууны зарчмын хэмжээнд үзэх, хувь хүнийг албадах аливаа хэлбэрийг эсэргүүцдэг чөлөөт өрсөлдөөний үзэл санаа зэрэг орно.

Уг үзэл баримтлалын гарал, үүслийг нэн түрүүнд Английн эрдэмтэн Жон Локк, Адам Смит нарын үзэл санаатай холбон үздэг. Тэр үед либерал үзэл санааг Англичад эдийн засгийн талаас нь үндэслэхэд илүүтэй анхаарч байсан учраас улс төрийн асуудалтай холбоотой чиглэлээс ялган эдийн засгийн либерализмыг онцолдог.

Хувь хүний эрх чөлөөг хангах үндэс бол хувийн өмчийн болон чөлөөт өрсөлдөөний эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, уг эрхийг хуулиар хамгаалах явдал нь либерал үзэл санааны үндэс гэж либералууд үздэг. Хувийн өмч гэдэгт:

- Өмчлөгч хүн өмчөө чөлөөтэй захиран зарцуулах;
- Түүнийгээ үйлдвэрлэлийн хэрэгсэл буюу капитал болгон хувиргах эрхтэй
- Хөрөнгөө хэрхэн зарцуулж амжилт, үр дүнд хүрэхээ тухайн хүн бүрэн хариуцах ёстой хэмээх үзэл санаа

Либерал ойлголтоор хүмүүсийн эдийн засгийн үйл ажиллагаа тэдний өөрсдийнх нь үйл хэрэг байж, хувь хүн аж ахуйн үйл ажиллагаа явуулахдаа хэнээс ч үл хамаарах ёстой ажээ. Эдийн засгийн либерализмын төлөөлөгчид чөлөөт зах зээлийн нөхцөлд амжилт олох эсэх нь гагцхүү хувь хүний авхаалж самбаанаас л шалтгаална гэдгийг иш үндэс болгож байв.

КОНСЕРВАТИЗМ

Нийгэм, эдийн засгийн үйл явцыг зохицуулах зах зээлийн ба төрийн зохицуулалтын харьцаа ямар байх ёстой вэ? гэдэг үзэл суртлын маргаанаас үүдэн бий болсон.

Либералуудын эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаанд төрийн зүгээс оролцох явдлыг эсэргүүцэн үзэж, эдийн эргэлтийн эсрэг үзэл санааны баримтлал болж консерватизм үүсчээ. Тэр үеийн Английн гүн ухаантан Э.Берк, Францын улс төрийн зүтгэлтэн Ф.Шатобриан нарын бүтээлд энэхүү баримтлал онолын хувьд цэгцтэй сургаал болсон байна.

Консерватизм ерөнхийдөө оршин буй нийгмээ бүрэн эвдэхийн эсрэг чиглэсэн үзэл санааны цогц гэж ойлгогдож ирсэн юм.

Консерватив үзэл санааны үндэс:

- Хүн бүр өөрт ногдсон, хатуу чанд тогтоогдсон байраа эзэлдэг нийгмийн шаталсан бүтцийн тухай үзэл санаа;
- Чөлөөт зах зээл, чөлөөт өрсөлдөөний үзэл санаа;
- Дотоод төгөлдөр холбоо бүхий нэгдмэл нийгмийн тухай үзэл санаа.

Консерватив үзэл баримтлал ихээхэн зөрчилтэй замыг туулж иржээ. Жишээлбэл, иргэн бүрийн хувийн эрх чөлөө, парламентат ёс зэргийг зөвшөөрдөггүй байсан бол одоо энэ нь үзэл санааны үнэт зүйл гэж тооцогдох болсон юм.

Консерватив үзэлтнүүд:

- Хувийн талыг илүү бодогч мөртлөө нийгмийн талыг хамгаална.
- Дангаар захирах ёсыг талархагчид мөртлөө эрх чөлөөт байдлыг эрхэмлэнэ.
- Далдын хүчинд итгэн бишрэгчид (иррационализм) мөртлөө ухаалаг практик үйл ажиллагааг илүүд үнэлнэ гэхчлэн консерватизмд зөрчил ихэд түгээмэл илэрнэ.

НЕОКОНСЕРВАТИЗМ

Далаад оны үеэс хөгжингүй орнуудад неоконсерватизм нэлээд хүчтэй дэлгэрэх болсон юм. Америкийн эрдэмтэн Ф.Штейнфельц “неоконсерватизм бол дэвшилтэт зүйлсийг боловсруулж бий болгохоосоо илүү аливаа буруу ташаа гэгдэх юмсыг арилгахад чиглэгдсэн шүүмжлэлт сөрөг үзэл” юм гэж тодорхойлжээ. Ингэснээр консерватизм нь:

- Улс төрийн хүрээнд неолиберализмын “нийгмийн төрийн” тухай онолын эсрэг хязгаарлагдмал эрхт төрийн үзэл баримтлалыг сэргээн тавьсан.
- Эдийн засгийн хүрээнд Кейнсийн онолын эсрэг Фридманы “монетаризмын” онолыг дэвшүүлсэн болно.
- Төр нь иргэний нийгмийн дээр байж болохгүй,
- Эдийн засгийн амьдралд оролцохдоо төр нь мөнгөний эргэлтийн хэмжээг зохицуулах, инфляцтай тэмцэх, бүтцийн бодлого баримтлах л үүрэгтэй.
- Монопольт хэвшлийг хязгаарлах, дахин хувьчлах, бага татварын бодлого явуулах
- Төрийн зүгээс явуулах нийгмийн бодлогыг аль болохоор багасгаж, хүнийг өөрөө өөрийнхөө төлөө зүтгэгч болгох бэлэнчлэх сэтгэлгээг халах,
- Нийгмийн тэгш биш байдал гэж байдаггүй, харин тэгш биш байдалтай байх эрх нь хүнд бий. Энэ нь түүний бусдаасаа ялгагдах үндэс болох ёстой.

Энэ бүгдээс үндэслэн нийгмийг зохион байгуулахдаа тэгш бус зарчмыг баримтлах нь шударга байдалтай нийцнэ гэж консерватизмын талынхан үздэг байна. Ингэснээрээ консерватизм нь либерализм, социал-реформизм, тэр тусмаа коммунизмын эсрэг байр суурь баримталж нийгмийн тэгшитгэлийн үзэл санаа, нийгмийн шинэтгэлийн хэт хувьсгалч хандлагын эсрэг байдаг байна.

СОЦИАЛ-ДЕМОКРАТ НОМЛОЛ

Социал-демократ номлол нь онолын уг сурвалжийн хувьд марксизмтай холбоотой. К.Марксын өртгийн онол, ангийн тэмцлийн тухай сургаал, коммунист нийгэм эдийн засгийн байгууллын тухай марксист үндэслэлүүд хөгжилтэй орнуудад бий болж буй бодит үйл явцтай зөрчилдөж, хэрэгжих чадваргүйгээ харууллаа гэж Э.Бернштейн, К.Каутский, Р. Гильфердинг нарын эрдэмтэд үзэж социал-демократ урсгалд нэгджээ.

Социал-демократ хөдөлгөөний үзэл суртал, улс төрийн номлол бол “Ардчилсан социализм” юм. Ардчилсан социализмыг нийгмийг өөрчлөх урт удаан хугацааны үйл явц, эдүгээ болон ирээдүйн нийгмийн нөхцөлд явуулах үйл ажиллагааны зарчим хэмээн үздэг байна. Ардчилсан социализмын тухай тогтсон нэг ойлголт байдаггүй, мөн түүнд хүрэх тодорхой цаг хугацаа ч тогтоодоггүй. Ардчилсан социалист нийгмийг нэг оронд байгуулж болохгүй, энэ нь хүн төрөлхтний соёл иргэншлийн шинэ үе шат юм гэдгийг социал-демократууд байнга онцолно. Эдүгээ нийгмийг шинэ төлөв байдалд хүргэх нийгмийн өөрчлөлт, шинэчлэлийн тасралтгүй үргэлжлэх үйл явц юм гэж ардчилсан социализмын үзэл санааг ойлгодог байна.

Ардчилсан социализм яаж бүрдэх вэ? (Соц интерний гол баримт бичгүүдээс үзэхэд)

Үе шат:

- Улс төрийн ардчиллыг хэрэгжүүлэх;
- Эдийн засгийн ардчиллыг бий болгох;
- Сайн сайхан амьжиргааны улс байгуулах;
- Социал ардчиллыг тогтоох явдал юм.

Эдгээр ойлголтын агуулга, үзэл санааг авч үзье.

Улс төрийн ардчилал

Үүнд юуны өмнө олон намын системтэй байх, сөрөг үйл ажиллагаа явуулах эрх чөлөөг хангах, засгийн эрхэнд байгаа намууд халагдаж солигдох боломж зэргийг багтааж ойлгодог. Дарангуйллын аливаа хэлбэр, нэг намын засаглал улс төрийн ардчилалтай үл нийцнэ гэж үздэг. Үүнээс гадна хүний эрх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, Үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний бие даасан байдал, эрх зүйт төрийн тухай ойлголт улс төрийн ардчиллын бүрэлдэхүүн хэсэг хэмээн үздэг нь агуулгын хувьд улс төрийн бусад ойлголттой ойролцоо юм.

Эдийн засгийн ардчилал

Үүнд, орчин үеийн өрнөдөд тогтсон аж ахуйн бүхий л механизмыг ардчилах, ардчилсан зарчмуудыг нэвтрүүлэхийг ойлгодог юм. Энэхүү баримтлалыг Э. Бернштейн, 20-иод оны үед К. Реннер, Ф. Нафтали нар боловсруулж иржээ.

Эдийн засгийн ардчилал нь макро болон микро түвшинг хамрах ёстой. Микро түвшинд, хувийн болон улсын үйлдвэрийг удирдахад хөдөлмөрчдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг зорилтууд юм. Энэ бүгд нь “социал түншлэлийн” зарчимд тулгуурласан нийгмийн тухай ойлголтыг гаргаж ирсэн билээ.

Эдийн засгийн ардчиллыг функционал үүднээс авч үзвэл аж ахуйн үйл ажиллагааны ихэнх хүрээнд үйлдвэрлэлийн зөвлөлүүдийн тавих хяналтыг бий болгох ёстой гэж үзнэ. Хөдөлмөрчин хүнийг эдийн засгийн хүрээнд шийдвэр гаргахад оролцуулдаг болсноор эдийн засгийн ардчилал нь зах зээлийн аж ахуйн нэгэн альтернатив болно гэж дүгнэдэг байна.

Сайн сайхан амьжиргааны улс

Энэ ойлголтоор орчин үеийн нийгмийн социал институтын цогцыг илэрхийлнэ. Энд, төрөөс эдийн засгийн хүрээ, нийгмийн бодлого, ангиудын харилцааг зохицуулж, амьжиргаа, хүн амын давхаргын нийгмийн болон материаллаг хангамжийг дээшлүүлэх тухай яригддаг байна. Төрийн үйл ажиллагаа юуны түрүүнд нийгмийн социал хүрээнд хамаатай гэж үздэг. (Үүнд: нийгмийн хангамж, баталгаа, орон сууц, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр хамгаалал, соёлын бодлого зэрэг орно) Эдийн засгийн хүрээнд төрийн зүгээс оролцох явдлыг зарим талаар багасгах боломжтой гэж үзэх боловч нийгмийн үндсэн асуудлыг шийдвэрлэхэд төрийн оролцоог чухлаар үздэг байна.

Социал ардчилал

Үүнийг ардчилсан социализмын *синоним* гэж ихэвчлэн ойлгодог. Нийгмийн бүх хүрээг ардчилсан байх энэ үе шат нь нийгмийн өөрчлөлтийн дээд шат юм гэж үздэг. Уг баримтлалын төвд бие хүний үндсэн эрх, эрх чөлөөг эргэлт буцалтгүй хангасан байх тухай асуудлыг тавьдаг байна. Үүгээрээ, тухайлбал консерватив үзлээс ялгагдана гэж социал-демократууд үздэг.

Эцэст нь тэмдэглэхэд, Социал-демократууд капиталист нийгмийг ардчилсан социализм болгон хувьсгах үндсэн арга нь реформ, шинэчлэл юм гэж үздэг. Нийгмийг өөрчлөх чухам энэ хэлбэр, аргыг түүхийн үүднээс тууштай баримталж, олон талаас боловсруулж ирснээрээ Социал-демократууд улс төрийн бусад чиглэлүүдийн реформыг үзэх үзлээс ялгагдана.

ФАШИЗМ

Үзэл суртал дотроос өөрийн агуулга, үзэл санааны хувьд хэт туйлын байр суурь эзлэх фашизмын түүхэн ба философийн уг үндэс нь ХХ зууны эхэн үе буюу дэлхийн I дайны үед бүрэлджээ. Дайны уршгаар тухайн үеийн капиталист улс оронд үүссэн хямрал, үгүйрэл либерал ардчилалд нэлээд бэрхшээл учруулжээ. Энэ байдал болон үүний улмаас үүссэн зөрчил нь фашист үзэл санааг газар авахад түлхэц болсон гэж үздэг. 1920-1930-аад оны тэр бэрхшээлтэй үед олон түмний өмнө тулгамдсан асуудлыг шийдэх ямар нэгэн шийдвэр. Улс төрийн бодлогыг ардчилал гаргаж чадаагүй нь олон түмэн фашист үзэл санаанд автагдахад нөлөөлжээ.

Фашист системийг бүхэлд нь нэгтгэдэг гурван гол түгээмэл шинж нь:

- Иррационализм (хүний оюунд итгэхгүй байх)
- Тоталитар (бүх нийтийн хяналт шүүлт)
- Үндсэрхэг милитарист үзэл юм.

ИРРАЦИОНАЛИЗМ

Фашизм бол бодит шинжлэх ухаан, оюун ухаан хоёрыг үгүйсгэдэг. Амьдрал бол маш нарийн бөгөөд тааж мэдэхэд маш хүнд учраас түүнийг жирийн хүмүүс ойлгож чадахгүй гэж фашистууд үзнэ. Бодит үнэн гэдэг бол хуурамч зүйл, учир нь амьдрал бол хоорондоо ямар нэгэн логик холбоо хэлхээгүй, цэгцтэй бус үзэгдлээс бүрдэнэ. Иймд оюун ухаанаар энэ бүгдийг тайлж мэднэ гэдэгт итгэдэг хүмүүс төөрөгдөж байгаа бөгөөд хуурамч үзэгдэлд хөтлөгддөг гэж тэд үздэг байна.

Үнэн гэдэг нь цэвэр субъектив ойлголт юм. Нөгөө талаас үнэн гэдгийг өөрийн ямар нэгэн онцгой чанараараа олон түмнээс дээгүүр байдаг “авьяас” бүхий хүмүүсийн ойлгож мэдэх л зүйл. Эдгээр хүмүүс өөрийн “зөн билгээрээ” зөв замыг тогтоож чадна, харин ийм авьяас заяагдаагүй бусад олонхын тэдгээрийг сонсож, тогтоогдсон дэглэмд захирагдах ёстой гэж үзнэ. Эдгээр авьяас бүхий хүмүүс бас тэр болгон өөрсдийн мэдлэгээрээ үнэнийг тогтоож чаддаггүй. Үнэнийг тогтоох явдал эцсийн дүндээ инстинкттэй л холбоотой.

Иррационализмыг өөрийн хөдөлгөөндөө нэвтрүүлэхдээ тухайлбал, Муссолини бол Жоржес Сорелийн (1847-1922) үзэл бодолд тулгуурласан юм. Сорел нь үлгэр домог бол улс төрийн маш их нөлөөлөл үзүүлж чадах хэрэгсэл болдог гэсэн онолыг дэвшүүлсэн юм. Үлгэр домгийн үзэл санааг баталж эсвэл үгүйсгэж болдоггүй. Үлгэр домог нь олон түмнийг нэгтгэж, хөдөлгөж чадах бөгөөд хувь хүмүүсийг хамтран ажиллах зорилгод итгэх итгэл өгснөөр нэгэн бүхэллэг үүсгэдэг байна. Үлгэр домгийг ашиглаж улс төрийн том амжилтанд хүрсэн хүмүүс бол Муссолини, Гитлер хоёр юм. Үлгэр домог нь олон түмнийг үйл ажиллагаа явуулах чиглэл рүү дайчлан залах зорилготой юм. Иррационализмыг гол болгосноор үйл ажиллагааны зорилго чухал ач холбогдолгүй болно гэж Муссолини тунхаглаж байжээ. Тэмцэл бол олон түмнийг дайчлах үлгэр домогтой адил чухал зүйл юм. Тэмцлийн утга агуулга нь зорилгоос бус үйл ажиллагаанаас урган гарна. Муссолинигийн гол уриа бол “МЭДЭР, БҮҮ СЭТГЭ” хэмээх утгатай байжээ.

ТОТАЛИТАР ҮЗЭЛ

Тоталитар төрийг бий болгосон хүмүүсийн нэг нь гарцаагүй Муссолини юм. Тэрээр төр, тэр дотроо төрийн удирдагч нь хүмүүсийн амьдралыг бүрэн хянаж чадна гэдэгт итгэж байжээ. Ингэснээр Сталин, Гитлер, Маогийн нэгэн адил төрийн засаглалыг хүчтэй болгож жирийн иргэний хувийн амьдралын дийлэнх хэсэгт түүнийг шургуулах

оролдлого хийсэн юм. Төрийн тухай ойлголтыг бүрдүүлэхдээ Муссолини Гегелийн онолд тулгуурласан юм. Гегель бол идеалист философич бөгөөд тэрээр түүх бол бурхны төлөвлөгөөний биелэл гэж үзэж байсан юм. Бурхны төлөвлөгөөний биелэлийн нэгэн үе төртэй холбоотой юм. Ийм учраас олон түмэн төрдөө захирагдаж түүнийг шүтэж байх учиртай.

Гэхдээ Гегель тоталитар төрийн санааг дэвшүүлж байгаагүй. Муссолини Гегелийн философиос өөртөө хэрэгтэй гэсэн хэсгийг л сугалж авсан. Католик голдуу шашинтай нийгэмд төрийн үүслийг Бурхантай холбох нь Муссолинид ашигтай байж. Иймээс ч төр бол “Хүслийн дээд хүсэл” гэсэн санааг гол уриа болгон, хувь хүн төрд хамаарч байж л амьдралаа дээшлүүлж чадна гэж сурталчилж байсан юм. “Бүх зүйл төрийн төлөө, төрийн эсрэг юу ч байдаггүй, төрөөс гадна юу ч оршдоггүй” гэж Муссолини тунхаглажээ. Үзэл суртлыг ашиглан төрийн тухай дээрх ойлголтоор *“олон түмнийг хүлцэнгүй болгох, төр, түүний удирдагчийн хэлсэн үг эцсийн үнэнийг тогтоодог”* гэсэн үзлийг дэлгэрүүлснээр тоталитар системийг бүрэлдүүлэх нөхцөл бий болсон байна.

Муссолинигийн дээд зорилго нь нарийн дэв зэрэг, шаталсан зохион байгуулалт бүхий нийгэм байгуулах явдал байсан юм. Хүн бүр ногдсон байртай, хийх ажилтай, гүйцэтгэх үүрэгтэй. Аль ч нийгэмд төрийг удирдаж чадах цөөн тооны хүмүүс байдаг. Тэд л нийгмээ жолоодохоос биш олон түмнийг оролцуулах нь утга учиргүй. Иймд аливаа нийгэм “сонгомол элитээр” жолоодуулж байх ёстой. Тухайн удирдагчийн бусад олноос ялгагдаж үр ашигтай удирдлага явуулах чанар бол төр улсынхаа хүсэл эрмэлзлийг мэдрэх зөн билгийн мэдрэмж юм гэжээ. Ингэснээр удирдагч гэдэг бол өөрөө төр, төр бол удирдагч юм. Иймд хүн ам түүний тушаалыг үг дуугүй биелүүлэхээс өөр замгүй. Иймэрхүү байдлаар төрийн хяналт шүүлтийг хүчтэй болгохын зэрэгцээ төрийн эрх мэдлийг хязгааргүй өргөжүүлж тоталитар үзлийг хэрэгжүүлж байсан юм.

ҮНДСЭРХЭГ МИЛИТАРИСТ ҮЗЭЛ

Улс төрийн аливаа онол нийгмийн тодорхой нэг хэсэгт анхаарлаа илүү төвлөрүүлдэг. Ардчилсан онол хувь хүнийг онцолдог бол марксизм ангийн тэмцлийг, национал-социализм нь расизмыг анхаарлын төвд тавьдаг. Харин үндсэрхэг үзлийг фашистуудаас илүү онцлон үздэг номлол байхгүй юм. Фашист номлолоор бол аливаа нийгэм нэг нэгнээсээ дээр гарах гэсэн эрмэлзэлтэй хувь хүмүүсээс бүтсэн учраас нийгэм бол оройддоо өөрийн хувийн хүчтэй шинжээрээ тодорсон хувь хүн бүхий пирамид юм. Үүнтэй адил үндэстнүүд өөр өөрийн хүсэл сонирхлоороо ялгагдана. Үүгээрээ тэд тэгш биш юм. Аль нэг дээд шинжийн үндэстэн нь бусдаас дээгүүр байх учиртай. Энэ утгаараа фашист төрийн дээд зорилго империализмтай холбоотой юм. (Империализм гэдэг нь нэг үндэстэн бусдыг өөрсдийн эрхшээлд оруулах үзэл санааг илэрхийлнэ.)

Фашизмын империалист үзлийн гол хэрэгсэл нь милитаризм байсан юм. Дэлхий ертөнц бол угаасаа дайсангалцсан бүлэглэлүүдийн өрсөлдөөний илрэл болдог гэж үзэж нийгэм дотор хувь хүмүүс хоорондоо тэмцдэгтэй адил үндэстнүүд бас хоорондоо байнга тэмцдэг. Ийм учраас милитаризм бол аль ч төрийн мөн чанартай холбоотой бөгөөд дайнд байнгын бэлэн байдалтай байна гэдэг нь фашист төрийн үйл ажиллагааны томоохон чиглэл болж байжээ. Фашист үзэл сурталд дайн бол нийгмийн үндсэн зорилгын нэг нь гэж томъёологддог. Дайн бол амьдралыг бүтээх гол хүчин зүйлс. Нэг дээд үндэстэн бусдыг өөрийн эрхшээлд бүрэн оруулсан тохиолдолд л дайн дуусч болно. Энхтайван гэдэг бол тэмцэж буй үндэстнүүдийн хоорондын зөвхөн оршил эсвэл завсарлага юм гэж фашист номлол үздэг байна.

Эх сурвалж: <https://academy.edu.mn/content/орчин-үеийн-үлс-төрийн-үндсэн-номлолу/>

б/ Улс төрийн намын үзэл баримтлалын орчин үеийн шинэ хандлага

Улс төрийн намууд баялгийн засаглалд гол тоглогч болох учир шалтгаан

Байгалийн баялаг ихтэй улс орнууд уг баялгаа урт хугацааны тогтвортой хөгжил болгон хувиргах боломжтой. Харамсалтай нь ийм улс оронд институци сул, зөрчилдөөн үүсэх илүү магадлалтай, эдийн засаг хэвийн бус бөгөөд олон тохиолдолд эрдэс баялаг шавхагдсаны дараа хөгжил дорой үлдсэн байдгийг судлан тогтоосон байдаг.

Баялаг ихтэй улс орны хувьд урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэхэд улс төрийн намууд голлох үүргийг гүйцэтгэх боломжтой.

АСДҮОУХ-ийн Даян дэлхийн ардчиллын төлөв байдлын индексээр хэмжигдэх улс төрийн төлөөллийн түвшин нь байгалийн баялгийн үнэ цэнийг хүртэх болон орлогыг үр дүнтэй удирдах зэрэг ББЗХ-ийн Баялгийн засаглалын индексээр хэмжигдэх баялгийн засаглалын үзүүлэлтүүдтэй хүчтэй корреляц хамааралтай байдаг. Өөрөөр хэлбэл, намууд зохион байгуулалтад орж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй бөгөөд нэр дэвшигчдийг ард иргэд чөлөөтэй, шударгаар сонгох боломжтой бол баялгийн засаглал илүү сайн байдаг гэсэн нотолгоог бид олж харж байна.

ХӨТӨЛБӨРТ СУУРИЛСАН УЛС ТӨРИЙН НАМ гэж гол төлөв бодлого боловсруулж, сонгуулиар дэмжлэг хүлээн, уялдаатай, цогц үзэл суртлын байр сууринаас засагладаг намыг хэлнэ.

Хөтөлбөрт суурилсан улс төрийн намууд буюу сонгуульд оролцох, бодлого боловсруулалтыг мэдээллээр хангах, сонгогчидтой харилцах зэрэгт ашиглах иж бүрэн бодлогын байр суурьтай намууд баялгийн засаглалыг сайжруулах онцгой боломжтой гэж бид үзэж байна. Ийм намууд урт хугацааны хөгжлийн бодлогод хувь нэмэр болох хүртээмжтэй, эгэх хариуцлагатай засаглалыг бүрдүүлэх боломжтой байдгийг улс төр судлалын эрдэмтэд олж тогтоосон байдаг. Бодлогоор голлон өрсөлддөг намуудтай улс оронд институц хүчтэй байж, нийгэм эдийн засгийн амжилтад хүрэх магадлал илүү өндөр байдаг.

Нөөц баялагтай холбоотой улс төрийн сорилтууд: Дээд давхаргын эзэгнэлийн нөхцөлд ардчиллыг хөхиүлэн дэмжих нь Авторитар байдал руу тэмүүлэх хандлагаас эхлүүлээд орон нутагт үүсэх гомдол болон нөлөөг хэрхэх зэрэг байгалийн нөөц, баялагтай холбоотойгоор үүсдэг улс төрийн олон сорилтуудыг шийдвэрлэх онцгой боломж улс төрийн намуудад бий. Зарим сорилт, мөн эрсдэлийг бууруулах болон боломжуудыг ашиглах талаар улс төрийн намуудын гүйцэтгэж болох үүргийн тухай энэ хэсэгт авч үзнэ.

Намууд мэдээлэлтэй олон нийтийн мэтгэлцээнийг дэмжиж, авторитар байдал руу тэмүүлэх хандлагыг багасгах боломжтой

Байгалийн баялаг ихтэй улс орнууд авторитар удирдлагатай байх харьцангуй өндөр эрсдэлтэй байдаг. Олон жилийн өмнөөс судлагдсан энэ байдлыг АСДҮОУХ-ийн Даян дэлхийн ардчиллын төлөв байдлын индексийн саяхны өгөгдөл бататгаж байна. Уг индексийн дундаж дүнгээр баялаг багатай улс орнуудтай харьцуулахад улс төрийн төлөөллийн хувьд баялаг ихтэй хөгжиж буй улс орнууд ихээхэн доогуур үнэлгээтэй байв. Үүний нэг тайлбар бол төр засаг цөөн тооны компаниас их хэмжээний орлого авч

байгаа нөхцөлд иргэдийн төлж байгаа татвараас хамаарах нь багасаж, эргээд иргэддээ тайлагнах явдал буурдаг байна (Зураг 1.1-ийг үзнэ үү).

Харин идэвхтэй, мэдээлэлтэй улс төрийн намууд мэтгэлцэх боломжийг нэмэгдүүлж, сөрөг хүчин байхдаа асуудал дагуулсан бодлого, засаглалтай холбоотой шийдвэрүүдийг эсэргүүцэх боломжтой. Жишээ нь Израил улсад сөрөг хүчний нам лиценз олголт болон монополийн эсрэг хууль дүрмийн талаарх мэдлэгээ ашиглан тухайн асуудлаар дээд шүүхэд хандсанаар ерөнхий сайд Бенжамин Нетаняхугийн дэмжиж байсан бүтээгдэхүүний гэрээг эцсийн дүндээ цуцлуулж чадсан.

Улс төрийн намууд ба иргэний чөлөөт орон зай. 2017 оны Баялгийн засаглалын индекс нь баялгийн засаглал, иргэний хязгаарлагдмал орон зай хоёрын хооронд корреляци хамаарал байгааг тогтоосон. Өөрөөр хэлбэл, баялгийн засаглалын талаар тааруухан бодлоготой улс оронд төр засаг, корпорацуудтай холбоотой асуудлыг хөндөх талаар иргэний нийгэм болон хэвлэл мэдээллийнхэн хууль эрх зүйн болон биет орон зайгаар хавчигдмал нөхцөлд байдаг байна. Баялгийн засаглалыг сайжруулахын төлөө ажиллаж буй иргэний нийгмийн бүлгүүд болон сэтгүүлчид амь насанд нь заналхийлэх, цахим аюулгүй байдал, үг хэлэх эрх чөлөө болон эвлэлдэн нэгдэх чадавхтай холбоотой асуудлуудтай тулгардаг. Эцсийн дүндээ эгэх хариуцлага болон бодлогын өөрчлөлт хамгийн их хэрэгтэй байгаа улс орнуудад яриа хэлэлцүүлэг өрнүүлэх орон зай тун бага байна.

Иргэний орон зай хавчигдмал байх нь улс төрийн намуудад нөлөөлөх нь бий. Сөрөг хүчний олон нам иргэний нийгэм, хэвлэл мэдээллийнхэнтэй ойр харилцаатай байдаг тул тэдгээр албан бус хяналтын үүргийг гүйцэтгэгчдийн орон зай хумигдахын хэрээр сөрөг хүчний намуудын сонгогчидтойгоо харилцах, үзэл бодлын өөр хувилбаруудыг илэрхийлэх, төр засгийг шүүмжлэх нөөц боломж болон орон зай мөн өөрчлөгддөг. Жишээ нь Малайз улсад сөрөг хүчний нам өөрийн байр суурийг тодорхойлохын тулд сонирхогч бүх талуудыг бүрэн хамруулахыг зорьсон боловч шаардлагатай нөөц, хөрөнгө олох сорилттой тулгарч байсан.

Иргэний орон зайг хамгаалах заалтуудыг мөрийн хөтөлбөртөө тусгаж, хавчигдмал нөхцөлд гарч ирэхгүй санаа, дуу хоолойг олж сонсох хэлэлцүүлгийг зохион байгуулах замаар тус орон зайг хөгжүүлэн хамгаалах боломж улс төрийн намуудад бий.

Намууд институцийг бэхжүүлж, бодлого болон түүний хэрэгжилтийн зөрүүг арилгахад оролцох боломжтой. 2017 оны Баялгийн засаглалын индекс баялгийн засаглалтай холбоотой бодлого болон түүнийг хэрэгжүүлж, хянаж байгаа байдал хоёрын хооронд ихээхэн зөрүү байгааг олж тогтоосон. Засаглалын хувьд тааруу үзүүлэлттэй улс оронд уг зөрүү улам бүр нэмэгдэж байгааг индекс харуулсан байна. Үүнийг: (а) баялаг ихтэй улс оронд чадавхтай холбоотой тулгарч буй сорилтууд; (b) хэрэгжүүлэхэд шаардагдах институцуудын дэмжлэг; мөн (с) хууль гаргах хөндлөнгийн ашиг сонирхол зэргээр тайлбарласан.

Эх сурвалж: <https://resourcegovernance.org/sites/default/files/documents/political-parties-and-natural-resource-governance-mongolian.pdf>

2.1. Улс төрийн намын гишүүнчлэл

Дэлхий нийтийн чиг хандлагаас харахад улс орнуудад намын гишүүнчлэл буурах хандлага руу оржээ. Улс төрийн намуудын уламжлалт бүтцэд өөрчлөлт орж, шинэчлэгдэх шаардлага тулгарч эхэлсэн байна. Иймээс намууд улс орныг бүхэлд нь буюу массыг хамарсан гишүүнчлэлийн оронд цомхон бүтэцтэй болж эхэлж байна. Эдгээр шинэ хэлбэрүүд нь гишүүний байнгын оролцоо шаардахгүй, түүнчлэн гишүүнчлэлийн татваргүй зэрэг онцлогуудтай байна. Намууд мөн гишүүддээ улс төрийн үйл ажиллагаан дахь оролцооны шинэ хэлбэр дижитал гишүүнчлэлийг бий болгож байна.

Улс төрийн намуудын хэв маяг, гишүүнчлэл:

Улс төрийн намын тогтолцооноос хамааран гишүүнчлэл нь янз бүр байна. Хэдэн зуун мянган гишүүд бүхий уламжлалт намын тогтолцооны зэрэгцээ огт гишүүнчлэлгүй, интернетэд суурилсан, ганц лидерт төвлөрдөг зэрэг шинэлэг хэв маяг, бүтэц бүхий намууд (цахим нам) шинээ рбий болж байна.

Хүснэгт. Намын гишүүнчлэлийн хэв маяг

Хэв маяг	Гишүүнчлэл
Бүлэг маягийн нам (Кокус нам)	Цөөхөн элитүүд
Олон түмний нам (Массын)	Намын батлах бүхий олон тооны гишүүдтэй
Бүхнийг шүүрэгч нам (Catch-all)	Гишүүнчлэл хүссэн хүн бүрд нээлттэй, гишүүдэд хатуу үүрэг хүлээлгэдэггүй
Хоршсон нам (Картел)	Намын гишүүн ба гишүүн бус хүмүүсийн хоорондын ялгаа багасч гишүүдийн эрх, үүрэг аль аль нь байхгүй болсон
Цахим нам	Цөөн тооны сул гишүүдтэй, бүх сонгогчдыг дэмжигч гэж тооцдог

Намын гишүүнчлэлийн хэлбэр:

Намын гишүүнчлэлийг хатуу болон сул гишүүнчлэлтэй гэж ангилдаг. Хатуу гишүүнчлэлийн зохицуулалтын үед чанд дүрэм, журмын дагуу гишүүн элсүүлж, гишүүний татварыг зайлшгүй төлөх үүрэг хүлээж, гишүүнд өндөр хариуцлага (намаас хөөх) үүрэгжүүлж, гишүүд намын хамтын шийдвэрийг биелүүлдэг байна. Харин сул гишүүнчлэлийн зохицуулалтын үед хүний эрхийн суурь зарчимд тулгуурлаж гишүүн элсүүлж, гишүүд татварыг сайн дураараа төлж, дүрмийн хүрээнд хариуцлага ногдуулдаг байна. Олон улсад намын гишүүнчлэлийн хэлбэр нь дараах нийтлэг байдалтай байдаг. (Хүснэгт 2)

ПАРЛАМЕНТ
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт. Намын гишүүнчлэлийн хэлбэр

Утга	Хатуу гишүүнчлэл	Сул гишүүнчлэл
Гишүүн элсүүлэх шалгуур	Үндсэн хууль ба бусад хууль, намын дүрэмд заасан зохих шалгуурыг баримтлана.	Үндсэн хуулинд заасан хүний эрхийг суурь зарчим болгоно.
Гишүүний татвар	Дүрмээр заасан татварыг зайлшгүй төлөх үүрэгтэй.	Намын жирийн гишүүн хүн сайн дураараа төлөх эрхтэй.
Гишүүний хариуцлага	Дүрмийн хүрээнд гишүүдэд өндөр хариуцлага ногдуулна. Шаардлагатай гэж үзвэл намаас хөөнө.	Дүрмийн хүрээнд гишүүдэд өндөр хариуцлага ногдуулна.
Шийдвэр гаргах түвшин дэх гишүүний оролцоо	Намын бүх шатны удирдлагууд дангаар шийдвэр гаргана. Гишүүд дуулгавартай байх үүрэгтэй.	Шийдвэр гаргах түвшин дэх гишүүдийн оролцоо нээлттэй.

1980-аад оноос эхлэн Европын орнуудад иргэдийн улс төрийн намд итгэх итгэл унаж, намын гишүүнчлэл 30-50%-аар унасан байна. Тухайлбал, Норвегийн улс төрийн намын гишүүдийн идэвх, оролцоо буурч, гишүүнчлэл 50%-аар буурсныг 2000 оны судалгаагаар тогтоосон байдаг. Норвегийн хувьд цагаан арьстнууд намын шийдвэр гаргах түвшин дэх оролцоо харьцангуй өндөр байдаг. Судлаач Нейдар болон Бернارد /2005/ улс төрийн намын үйл ажиллагаанд гишүүдийн оролцоо нь нас, хүйс, орлогын түвшнээс шалтгаалж өөр өөр байдгийг нотолжээ. Мөн судлаач Сузан Скарроу “Улс төрийн намууд ба намын гишүүд” /2005/ зохиолдоо жирийн гишүүдийг идэвхтэй ба идэвхгүй гэж хуваасан нь орчин үед улс төрийн намууд сул гишүүнчлэлийг сонгох болсонтой шууд холбоотой юм.

2000 оны судалгаагаар Дани болон Норвегийн намын гишүүдийн идэвхийг харьцуулахад Норвегийн хувьд гишүүдийн 51% нь сүүлийн жилд ямар ч ажилд оролцоогүй байхад Данийн гишүүдийн 42% нь өөрсдийн хүсэлтээр орон нутгийн намын байгууллагын хуралд суусан байна. Норвегт Хөдөлмөрийн нам болон Социалист намын гишүүдийн 59% нь хамгийн багадаа гэхэд жилд 1 үйл ажиллагаанд оролцдог байхад, Данийн Консерватив намын гишүүдийн 37% нь 2 ба түүнээс дээш удаа намын үйл ажиллагаанд оролцсон статистик гарчээ.

Шведийн Ардчилал Сонгуульд туслах Олон улсын хүрээлэн (International IDEA) 2012 онд Монголын улс төрийн намуудад гишүүнчлэлийн асуудалд зөвлөмж өгсөн. Үүнд гишүүнчлэл бол улс төрийн намын хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ асуудалд өнгөц хандаж болохгүйг сануулсан. Учир нь улс төрийн нам гишүүнтэй байх нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- Гишүүд дэмжигчид нь намд хэрэгцээтэй төрөл бүрийн нөөцийг бий болгодог;
- Сонгуулийн кампанит ажлын үед илүү амжилт олох магадлал нэмэгдэнэ;
- Шинэ гишүүн, дэмжигчдийг олж авахад туслана;
- Гишүүнчлэлийн татвараас орлогын нэг эх үүсвэр бүрдэнэ;
- Боловсролтой, чадварлаг боловсон хүчин, нэр дэвшигчдийг бүрдүүлнэ;
- Намын үзэл суртал, мөрийн хөтөлбөрт дэмжлэг авна;
- Нийгмийн бүлэг, сонгогчидтой холбогдох гүүр болно;
- Нам дахь сайн дурын хөдөлмөр эрхлэлт буюу идэвхтэй гишүүд дэмжигчдийн оролцоог ашиглан сонгууль, улс төрийн ажил хийх зэрэг давуу байдлыг олж авахад дэмжлэг болно.

Намын гишүүнчлэлийн оролцооны түвшинг ангилвал:

- **Намын кадр:** сонгогдсон албан тушаалтан буюу намд алба хашдаг гишүүд;
- **Идэвхтэй гишүүд:** бодлого боловсруулах хуралд оролцож олон нийтэд хүрэх, тэднийг дагуулах, улс төрийн намыг өргөжүүлэн тэлэх ажилд оролцдог гишүүд;
- **Оролцоо бүхий гишүүд:** голцуу намын зөвлөлдөх хурал зэрэг чухал хурлуудад оролцдог гишүүд;
- **Дэмжигч гишүүд:** гишүүнчлэлийн төлбөр төлдөг ч бусад байдлаар намын үйл ажиллагаанд төдийлөн оролцдоггүй гишүүд;
- **Албан бус дэмжигчид:** намд албан ёсны гишүүнчлэлгүй ч тухайн намын төлөө саналаа өгч, мөнгө хандивлах болон сонгуулийн компанит ажилд тухайн намыг дэмжиж ажилладаг.

Улс төрийн намын гишүүнчлэлийн бууралтын шалтгаан

Техник технологийн үсрэнгүй хөгжил, цахим орчны нөлөөгөөр хүмүүсийн сонгуулийн санал өгөлт, үнэт зүйлийн чиг хандлагад ихээхэн өөрчлөлт гарч байна. Мөн анги бүлэг, орлого, арьс өнгө зэрэг социал бүтцийн ялгаатай байдал буурснаар улс төрийн намыг дэмжих уламжлалт хандлага багасаж байна.

Улс төрийн намын гишүүнчлэлийн бууралтын шалтгааныг Дэлхийн ардчилсан 36 орны улс төрийн намуудын гишүүнчлэлийн төлөв байдлыг судалсан судалгаа (Pauk Whiteley 2004)-нд дурдахдаа:

1. Төр, нам хоёрын харилцаа улам ойртсон
2. Улс төрийн нам дахь оролцоо шинэ хэлбэрийн оролцоонд дарагдах болсонтой холбожээ.

Мөн нийгмийн макро болон мезо түвшинд авч үзэхдээ:

Макро түвшний тайлбар	Мезо түвшний тайлбар
Нийгмийн өөрчлөлт	Намуудын бүтэц, зохион байгуулалтын хувьсал
Индивидуализм (нийгэм, бүлгээс хараат бус)	Мэргэшсэн
Секуляризаци	Personification (хувийн шинж чанар сайн төлөвшсөн)
Ажилчин ангийн бууралт	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
Нийгмийн холбоос суларсан	Гишүүдийн хэрэгцээ багассан

Эх сурвалж:

- “Улс төрийн намын бодлого, гишүүнчлэл, санхүүжилтийн асуудал” сэдэвт тойм судалгаа. ПСХ. 2020 он.
- Мэдээлэл судалгаа - Дугаар 30.

Асуулт 3. СОНГУУЛИЙН ПРОПОРЦИОНАЛ СИСТЕМ

Дэлхийд пропорционал тогтолцоогоор сонгууль явуулдаг нийт 82 орон байна. Үүнээс 80 улс нь намын жагсаалтаас санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоогоор, харин Мальт болон Ирланд улс санал шилжүүлэх тогтолцоо бүхий хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгуулиа зохион байгуулж байна.

Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцооны хамгийн энгийн хэлбэр нь намууд олон мандаттай тойрогт нэр дэвшигчдийн жагсаалтыг танилцуулдаг хэлбэр юм. Ингэснээр сонгогч аль нэгэн намын төлөө саналаа өгөх ба намууд тухайн сонгуулийн тойрогт авсан саналынхаа хувьтай тэнцүү суудал авна. Нэр дэвшигчдийг намын жагсаалтад орсон дарааллын дагуу ялагчаар тодруулдаг.

Намын жагсаалт нь:

- Нээлттэй
- Хаалттай
- Чөлөөт гэх хэлбэртэй.

Нээлттэй намын жагсаалт нь дан ганц нам төдийгүй тухайн намаас нэр дэвшиж буй нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаас сонгогч сонголтоо хийх боломжит хувилбар юм. Баруун европийн орнууд ихэвчлэн энэ хувилбарыг сонгодог. Хаалттай намын жагсаалт гэдэг нь намын жагсаалтаар сонгогдох нэр дэвшигчдийн дарааллыг нам тогтооно. Энэ тохиолдолд сонгогч тодорхой нэг нэр дэвшигчийг сонгох боломжгүй юм.

Мальт болон Ирланд улсын сонгосон санал шилжүүлэх тогтолцоо гэдэг нь олон мандаттай тойргоор сонгуулийг явуулах бөгөөд сонгогчид саналын хуудсыг бөглөхдөө альтернатив саналын тогтолцоотой адил нэр дэвшигчдийг сонголтын дарааллаар нь дугаарлаж тэмдэглэдэг. Энэ нь сонгогч заавал бүх нэр дэвшигчийг дугаарлах шаардлагагүй бөгөөд хэдэн хүнийг сонгохоо сонгогч өөрөө мэдэх хувилбар бүхий тогтолцоо юм.

Саналын хуудаснаас эхний буюу нэгдүгээр сонголт бүхий саналуудыг тоолж дүнг гаргасны дараа суудалд хүрэхийн тулд нэр дэвшигчдийн авах шаардлагатай саналын

$$| \text{Квот} = \frac{\text{саналын тоо}}{\text{суудлын тоо}} + 1$$

квотыг тооцно. Ингэхдээ дараах энгийн томъёог ашиглана. Үүнд:

Энэ тогтолцоог Ирланд Улс 1921 оноос хойш, Мальт Улс 1949 оноос хойш хэрэглэж байна.

Лавлагаа мэдээлэлд судалгаанд хамрагдсан пропорционал тогтолцоо бүхий 82 орны:

- намын болон нэр дэвшигчдийн жагсаалтын хэлбэр,
- саналын босгын хувь,
- суудал хуваарилах арга,
- тойргийн хэлбэр,
- суудлын тоо зэргийг харьцуулсан мэдээллийг хүснэгтээр оруулав.

Хүснэгт. Сонгуулийн пропорционал тогтолцоо бүхий улс орнуудын суудал хуваарилах арга, босгын хувь болон тойргийн хэлбэр

№	Улсын нэр	Хагсаалтын хэлбэр	Босгын %	Суудал хуваарилах арга	Тойргийн хэлбэр	Суудлын тоо
1.	Австрали -дээд танхим	Нээлттэй	нуугдмал	D'Hondt	12 мандаттай 6 тойрог, 2 мандаттай 2 тойрог	76
2.	Австри -доод танхим -дээд танхим	Хаалттай Хаалттай	4% нуугдмал	D'Hondt Харе D'Hondt Харе	3-12 мандаттай 9 тойрог 7-36 мандаттай 9 тойрог	183 62
3.	Албани	Хаалттай	Нам -3% Эвсэл -5%	D'Hondt Сент Лагийн арга	4-32 мандаттай 12 тойрог	140
4.	Алжир -доод танхим	Нээлттэй	нуугдмал	Сент Лагийн их үлдэгдлийн	Олон мандат бүхий 48 тойрог	389
5.	Ангол	Хаалттай	нуугдмал	D'Hondt	Үндэсний 1 тойрог	220
6.	Аргентин -доод танхим -дээд танхим	Нээлттэй Нээлттэй	3% -	D'Hondt Тойрогтоо хамгийн их санал авсан намд 2 суудал, дараагийнхад нь 1 суудал хуваарилдаг	Олон мандаттай 24 тойрог 3 мандаттай 24 тойрог	257 72
7.	Бельги -доод танхим -дээд танхим	Нээлттэй Нээлттэй	нуугдмал нуугдмал	D'Hondt D'Hondt	Олон мандаттай 11 тойрог Олон мандаттай 3 тойрог	150 40
8.	Бенин	-	-	-	Олон мандаттай 24 тойрог	83
9.	Болгар	Хаалттай	4%	Харе	Холимог: Олон мандаттай 31 тойрог 31 суудал – мажоритар /харьцангуй олонх/ 209 суудал- намын жагсаалтаар санал хураах пропорционал тогтолцоо	240
10.	Босни Герцеговин	Нээлттэй	3%	-	-	42
11.	Бразил -доод танхим	Нээлттэй	нуугдмал	D'Hondt	8-70 мандаттай 24 тойрог	513
12.	Буркина- Фасо	Нээлттэй	нуугдмал	Их үлдэгдлийн	15 мандаттай үндэсний хэмжээний 1 тойрог, 2-10 мандаттай 13 тойрог	111
13.	Бурунди -доод танхим	Хаалттай	нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 17 тойрог	118/100
14.	Гайана	Хаалттай	нуугдмал	Харегийн хамгийн их үлдэгдлийн	10 тойрогт 2: суудал, 40 мандаттай үндэсний 1 тойрог	65
15.	Гватемал	Хаалттай	-	D'Hondt	Холимог: 127 суудал- Олон мандаттай 22 тойрог 31 суудал- Үндэсний 1 тойрог	158
16.	Гвиней-Бисау	Нээлттэй	нуугдмал	Их үлдэгдлийн	Олон мандаттай 27 тойрог	102
17.	Гондурас	Хаалттай	-	Харе	Холимог: 18 тойрог	128
18.	Грек	Нээлттэй	3%	Хагенбах Бишхофф	Олон мандаттай 56 тойрог, 12 мандаттай үндэсний 1 тойрог	300
19.	Дани	Нээлттэй	нуугдмал	Сент Лагийн	Олон мандаттай 10 тойрог	179
20.	Доминикан -доод танхим	Хаалттай	нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 29 тойрог, Үндэсний 1 тойрог	183
21.	Зүүн Тимор	-	3%	D'Hondt	Үндэсний 1 тойрог	65
22.	Израил	Хаалттай	2%	D'Hondt	120 мандаттай үндэсний 1 тойрог	120
23.	Индонез -доод танхим	Нээлттэй	2,5%	Заяцын хүчин зүйл	Олон мандаттай 33 тойрог	560

24.	Ирак	Нээлттэй	нуугдмал		7-70 мандаттай 18 тойрог	325/318
25.	Ирланд	-	-	-	Санал шилжүүлэх тогтолцоо 3-5 мандаттай 43 тойрог	166
26.	Исланд	Хаалттай	5%	D'Hondt	10-11 мандаттай тойргууд	63
27.	Испани	Хаалттай	Нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 50 тойрог	350
	-доод танхим	Хаалттай	Байхгүй	Шууд бус	Олон мандаттай 52 тойрог	208
28.	Итали	Хаалттай	2-4%	Олон суудлыг урамшуулах	Олон мандаттай 26 тойрог	630
	-доод танхим					
	-дээд танхим					
29.	Кабо-Верде	Хаалттай	нуугдмал	D'Hondt	2-15 мандаттай 16 тойрог	72
30.	Казахстан	-	7%	Их үлдэгдэл	Пропорционал: 98 суудал- Үндэсний 1 тойрог 9 суудал – Ардын Чуулга	107
	-доод танхим					
31.	Камбож	Хаалттай	нуугдмал	Харе	Олон мандаттай 21 тойрог	123
32.	Кипр	Нээлттэй	нуугдмал	Харе	Олон мандаттай 6 тойрог	80
33.	Кипр /Хойд/	Нээлттэй	-	-	-	50
34.	Колумби	Хаалттай	Нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 33 тойрог	166
	-доод танхим	Хаалттай	нуугдмал	D'Hondt	100 мандаттай үндэсний тойрог, 2 мандаттай тусгай тойрог	102
	-дээд танхим					
35.	Косово	-	5%	-	-	120
36.	Коста-Рика	Хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	4-21 мандаттай 7 тойрог	57
37.	Кыргызстан	-	7%	-	Үндэсний 1 тойрог	120
38.	Латви	Нээлттэй	5%	Сент лагийн	14-29 мандаттай 5 тойрог	100
39.	Лихтенштайн	Нээлттэй	8%	Хамгийн их үлдэгдлийн арга	10,15 мандаттай 2 тойрог	25
40.	Люксембург	Нээлттэй	нуугдмал	Хагенбах Бишхофф	7-23 мандаттай 4 тойрог	60
41.	Македон	-	-	-	-	120-140
42.	Мальта	Нээлттэй	нуугдмал	Үлдэгдлийг дахин хуваарилах	Санал шилжүүлэх тогтолцоо 5 мандаттай 13 тойрог	65
43.	Мозамбик	-	5%	D'Hondt	12-50 мандаттай 11 тойрог 1 мандаттай 2 тойрог	250
44.	Молдова	Хаалттай	Нам-5% Бие даагч-3%	D'Hondt	Үндэсний 1 тойрог	101
45.	Марокко	Хаалттай	6% 3%	-	305 суудал- сонгуулийн тойрог 90 суудал- Үндэсний 1 тойрог	395
	-доод танхим					
46.	Намиби	Хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Үндэсний 1 тойрог	72
47.	Нигер	-	-	-	Холимог: 105 суудал- Олон мандаттай 8 тойрог / намын жагсаалтаар санал хураах пропорционал тогтолцоо/ 8 суудал – 8 тусгай тойрог /мажоритар: энгийн олонх/	113
48.	Нидерланд	Хаалттай	0,67%	D'Hondt	Олон мандаттай 18 тойрог	150
	-доод танхим	Хаалттай			12 мужийн зөвлөл	75
	-дээд танхим					
49.	Нидерландын Антилья	-	-	-	-	22
50.	Никарагуа	Хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	20 мандаттай Үндэсний 1 тойрог, 2-19 мандаттай 17 тойрог	90
51.	Норвег	Нээлттэй	4%*	Шинэчилсэн Сент Лагийн арга	150 суудал - 3-17 мандаттай 19 тойрог 19 суудал – Үндэсний 1 тойрог	169
52.	ОХУ	Нээлттэй	7%	Харе	Үндэсний 1 тойрог	450
	-доод танхим					
53.	ӨАБНУ	Хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	4-43 мандаттай 9 тойрог	400
	-доод танхим					
54.	Палестин	-	-	-	-	132

55.	Парагвай -доод танхим -дээд танхим	Хаалттай	Нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 18 тойрог, Үндэсний нэг тойрог	80
56.	Перу	Хаалттай	Нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 25 тойрог	120
57.	Польш -Сейм	Нээлттэй	5%	D'Hondt	7-19 мандаттай 41 тойрог	460
58.	Португал	Нээлттэй		D'Hondt	Олон мандаттай 22 тойрог	230
59.	Руанда -доод танхим	Хаалттай	5%	Их үлдэгдэл	Үндэсний 1 тойрог	53
60.	Сан Марино	Нээлттэй	>3.5%	D'Hondt	Нэг болон олон мандаттай 33 тойрог	60
61.	Сан-Томе ба Принсип	Хаалттай	нуугдмал	D'Hondt	Олон мандат 7 тойрог	55
62.	Серби	Хаалттай	5%	D'Hondt	Үндэсний 1 тойрог	250
63.	Словак	Нээлттэй	5%	Хагенбах Бишхофф	Үндэсний 1 тойрог	150
64.	Словени -доод танхим -дээд танхим	Нээлттэй	4%	D'Hondt	11 мандаттай 88 тойрог, Италичуудад зориулсан 2 мандаттай 1 тойрог	90
65.	Суринам	Хаалттай	нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 10 тойрог	51
66.	Того	Хаалттай	Байхгүй	-	2-10 мандаттай 30 тойрог	81
67.	Тунис	-	-	Их үлдэгдлийн	33 тойрог: 4-10 мандаттай 27 тойрог 18 суудал -6 тойрог /гадаад дахь төлөөлөл/	217
68.	Турк	Нээлттэй	10%	D'Hondt	Олон мандаттай 79 тойрог	550
69.	Уругвай -доод танхим -дээд танхим	Хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Олон мандаттай 19 тойрог, 30 мандаттай үндэсний 1 тойрог	99 31/30
70.	Фижи	Нээлттэй	Бие даагч - 5% Нам -5%	-	Үндэсний 1 тойрог	50
71.	Финланд	Нээлттэй	нуугдмал	D'Hondt	6-33 мандаттай 14 тойрог	200
72.	Хорват	Нээлттэй	5%	D'Hondt	14 мандаттай 10 тойрог, 8 мандаттай үндэсний тойрог, гадаад оршин суугчдад зориулсан тойрог /мандатын тоо заагаагүй/	153
73.	Чех -доод танхим	Нээлттэй	Нам-5% Эвсэл (2 нам)-10% Эвсэл (3 нам)-15% Эвсэл (4 нам)-20%	D'Hondt	Олон мандаттай 14 тойрог	200
74.	Чили -дээд танхим -доод танхим	Хаалттай	-	Намын олонхын систем	13 олон мандаттай тойрог, 60 олон мандаттай тойрог	38 120
75.	Чрна Гора	Хаалттай	3%	D'Hondt	Үндэсний 1 тойрог	81
76.	Швед -Риксдаг	Нээлттэй	4% - үндэсний хэмжээнд, 12%тойрог	Сент Лаг	2-34 мандаттай 29 тойрог, 39 мандаттай үндэсний 1 тойрог	349
77.	Швейцар -доод танхим	Нээлттэй	нуугдмал	Хагенбах Бишхофф	Олон тандаттай 26 тойрог	200
78.	Шри Ланк	Хаалттай	1/8 тойрогтоо	-	4-20 мандаттай 22 тойрог, 29 мандаттай үндэсний 1 тойрог	225
79.	Эквадор	-	-	-	Холимог: 116 суудал-мажоритар /харьцангуй олонх/ 15 суудал- олон мандаттай 3 тойроос пропорционал тогтолцоо + 8 суудал- олон мандаттай тойрог /гадаад дахь иргэдийн төлөөлөл/	137
80.	Экваторын Гвиней	Хаалттай	нуугдмал	D'Hondt	Мужийн тоогоор олон мандаттай тойрог	100
81.	Эль Сальвадор	Хаалттай	-	-	64 суудал- 3-16 мандаттай 14 тойрог 20 суудал- Үндэсний 1 тойрог	84
82.	Эстони	Нээлттэй	5%	D'Hondt	6-13 мандаттай 13 тойрог	101

Асуулт 4. УЛС ТӨРИЙН НАМ БАЙГУУЛАХ БОСГО

Дэлхийн 121 улсын Үндсэн хуульд улс төрийн нам байгуулах тухай асуудлыг тусгасан байна.

Үүнд, Азербайжан, Албани, Алжир, Ангол, Андорра, Аргентин, Армен, Афганистан, Багамын арлууд, Барбадос, Белиз, Бенин, Болгар, Боливи, Бразил, Буркина Фасо, Бурунди, Бутан, Вануату, Венесуэль, Габон, Гаити, Гамби, Гана, Гватемал, Гайана, Гвиней, Гвиней-Бисау, Герман, Гондурас, Грек, Гүрж, Доминикан, Египет, Жибути, Замби, Зимбабве, Зүүн Тимор, Ирак, Иран, Испани, Итали, Йемен, Йордан, Кабо Верде, Камбож, Кени, Киргиз, Колумби, Коморос, Конго (Бүгд Найрамдах Ардчилсан), Коста-Рика, Кот д'Ивуар, Латви, Либерии, Ливи, Литва, Мавритани, Мадагаскар, Македон, Малави, Мали, Мальдив, Марокко, Мексик, Мозамбик, Молдова, Монгол, Монтенегро, Мьянмар, Намиби, Непал, Нигер, Нигери, Никарагуа, Норвег, Өмнөд Африк, Өмнөд Солонгос (БНСУ), Өмнөд Судан, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Парагвай, Перу, Польш, Португал, Руанда, Румын, Сальвадор, Сан-Томе Принсипи, Сейшелийн арлууд, Сент-Китс ба Невис, Сент-Луис, Сербии, Сири, Словак, Соломоны арлууд, Сомали, Судан, Суринам, Сьерра-Леон, Тажикистан, Тайланд, Танзани, Того, Тувалу, Тунис, Турк, Туркменистан, Уганда, Узбекистан, Украин, Унгар, Фижийн арлууд, Франц, Хорват, Чад, Чех, Эквадор, Экваторын Гвиней, Эстони, Этиоп зэрэг улсууд байна.

Эдгээр улсууд улс төрийн нам байгуулах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг нэгтгэн авч үзвэл, иргэд сайн дураарын үндсэн дээр эвлэлдэн нэгдэн улс төрийн нам (эсхүл улс төрийн байгууллага)-ыг чөлөөтэй байгуулах эрхтэй байна.

Ингэхдээ Үндсэн хуульд дараах зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

- төрөөс намын үйл ажиллагааны эрх чөлөөг хангах;
- намын зорилго нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцэх;
- нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг тодорхойлох, илэрхийлэх;
- нам нь үндэсний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хууль дээдлэх ёс болон ардчиллын зарчмуудад тулгуурлах;
- нам бол улс төрийн олон ургальч үзлийг илэрхийлэх;
- хэн ч албан хүчээр намын гишүүн болохгүй байх.

Хүснэгт 2. Улс төрийн нам байгуулах тухай Үндсэн хуулийн зохицуулалт / бусад орнуудад/

№	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1.	Армен	8.2.Нам чөлөөтэй байгуулж, үйл ажиллагаа явуулна. Намуудын үйл ажиллагааны эрх тэгш байдлыг хуулиар баталгаажуулна. 46.1.Иргэн бүр бусад иргэнтэй хамтран нам байгуулах, намын гишүүн болох эрхтэй. Хэн ч албан хүчээр намын гишүүн болох ёсгүй.
2.	Герман	21.1.Улс төрийн намууд нь ард түмний улс төрийн хүсэл зоригийг тодорхойлоход оролцоно. Тэд чөлөөтэй нам байгуулж болно. Тэдний дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн байх ёстой. Тэд өөрийн хөрөнгө, эх үүсвэр болон зардлыг олон нийтэд мэдээлэх ёстой.
3.	Испани	6.Улс төрийн нам бол улс төрийн олон ургальч үзлийг илэрхийлэх, ард түмний хүсэл зоригийг тодорхойлох, илэрхийлэх улс төрийн оролцооны чухал хэрэгсэл мөн. Тэдний үйл ажиллагаа эхлүүлэх, хэрэгжүүлэх үйл явц нь Үндсэн хууль болон бусад хуулийг хүндэтгэх тул үнэ төлбөргүй. Тэдний дотоод бүтэц, зохион байгуулалт нь ардчилсан байх ёстой.

№	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1.	Армен	8.2.Нам чөлөөтэй байгуулж, үйл ажиллагаа явуулна. Намуудын үйл ажиллагааны эрх тэгш байдлыг хуулиар баталгаажуулна. 46.1.Иргэн бүр бусад иргэнтэй хамтран нам байгуулах, намын гишүүн болох эрхтэй. Хэн ч албан хүчээр намын гишүүн болох ёсгүй.
2.	Герман	21.1.Улс төрийн намууд нь ард түмний улс төрийн хүсэл зоригийг тодорхойлоход оролцоно. Тэд чөлөөтэй нам байгуулж болно. Тэдний дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн байх ёстой. Тэд өөрийн хөрөнгө, эх үүсвэр болон зардлыг олон нийтэд мэдээлэх ёстой.
3.	Испани	6.Улс төрийн нам бол улс төрийн олон ургальч үзлийг илэрхийлэх, ард түмний хүсэл зоригийг тодорхойлох, илэрхийлэх улс төрийн оролцооны чухал хэрэгсэл мөн. Тэдний үйл ажиллагаа эхлүүлэх, хэрэгжүүлэх үйл явц нь Үндсэн хууль болон бусад хуулийг хүндэтгэх тул үнэ төлбөргүй. Тэдний дотоод бүтэц, зохион байгуулалт нь ардчилсан байх ёстой.
4.	Итали	49.Ямар ч иргэн ардчилсан үйл явцаар дамжуулан үндэсний бодлогыг тодорхойлоход хувь нэмрээ оруулах намыг чөлөөтэй байгуулах эрхтэй.
5.	Камбож	42.Кхмер иргэд холбоод, улс төрийн намууд байгуулах эрхтэй. Энэхүү эрхийг хуулиар тогтооно. Кхмер иргэд үндэсний ололт, нийгмийн дэг журмыг хамгаалахын тулд хамтын ажиллагааны төлөө өргөн нийтийн байгууллагын үйл ажиллагаанд оролцож болно.
6.	Молдова	41.1.Бүх иргэд нам, нийгэм-улс төрийн бусад байгууллагад чөлөөтэй нэгдэх эрхтэй. Эдгээр байгууллагууд нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг тодорхойлох болон илэрхийлэх, хууль дээдлэх ёсны дагуу сонгуулийн үйл явцад оролцоход хувь нэмрээ оруулна.
7.	Португал	51.1.Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө гэдэгт улс төрийн холбоо, намуудыг байгуулах, эсхүл түүний үйл ажиллагаанд оролцох бөгөөд тэдгээрээр дамжуулан ард түмний хүсэл зоригийг тодорхойлох болон улс төрийн зохион байгуулалтад оруулахаар ардчилсан ёсны дагуу хамтран ажиллахыг ойлгоно. 51.5.Улс төрийн намууд нь ил тод, ардчилсан зохион байгуулалт, удирдлага, бүх гишүүдийн оролцоог хангах зарчмыг удирдлага болгоно. 51.6.Улс төрийн намуудын санхүүжилт, ялангуяа улсын төсвийн санхүүжилтэд тавигдах шаардлага, хязгаарлалт, мөн тэдгээрийн хөрөнгө болон түүний тайланг олон нийтэд мэдээлэхийг хуулиар зохицуулна.
8.	Румын	8.2.Улс төрийн намуудыг байгуулах, тэд өөрсдийн үйл ажиллагаагаа хуульд заасан журмын дагуу явуулна. Улс төрийн намууд нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг тодорхойлох, илэрхийлэх, үндэсний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хууль дээдлэх ёс болон ардчиллын зарчмуудыг хүндэтгэхэд хувь нэмэр оруулна.

9.	Суринам	<p>53.1.Төр нь хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд иргэдийн улс төрийн байгууллага байгуулах эрх чөлөөг хүлээн авна.</p> <p>53.2.Улс төрийн байгууллага нь үндэсний тусгаар тогтнол, ардчиллыг хүндэтгэх ёстой.</p> <p>53.3.Улс төрийн байгууллага эрхээ хэрэгжүүлэхдээ дараах зүйлийг харгалзан үзнэ:</p> <p>а) тэдний зорилго нь Үндсэн хууль болон бусад хуулиудтай зөрчилдөхгүй байх;</p> <p>б) байгууллага нь хуулиар тогтоосон шалгуурыг хангасан Суринам иргэнд нээлттэй байх энэ тохиолдолд тэрээр намын үндсэн зарчмыг хүлээн зөвшөөрсөн байна.</p> <p>в) байгууллагын дотоод арга хэмжээ нь ардчилсан байх ёстой бөгөөд үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - хорооны сонгууль тогтмол байх; - төлөөлөгчдийн танхимаас нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийг намын бүтцээр сонгох урьдчилсан нөхцөл; <p>г) сонгогчдод улс төрийн хөтөлбөр, улс төрийн байгууллагын сонгуулийн хөтөлбөрийн талаар мэдээлэх;</p> <p>д) жил бүр орлогын эх үүсвэр, тайланг Бүгд Найрамдах Суринам Улсын Албан ёсны сонин, мөн хамгийн багадаа нэг сонинд нийтлэх;</p> <p>е) тэдний зохион байгуулалт нь нээлттэй, ил тод байдлыг хангахын тулд сайн засаглалын зарчмууд болон хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу хэрэгжих;</p> <p>ё) үндэсний ашиг сонирхлыг хөхиүлэн дэмжихийн тулд нэгдсэн зорилготой хөтөлбөр боловсруулах.</p>
10.	Польш	<p>11.1.Бүгд Найрамдах Польш Улс улс төрийн намуудыг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд эрх чөлөөг хангана. Улс төрийн намууд Польшийн иргэдийн сайн дурын үндсэн дээр болон тэгш эрхийн зарчимд үндэслэгдэх бөгөөд тэдгээрийн зорилго нь төрийн бодлогыг ардчилсан аргаар тодорхойлоход нөлөөлөх ёстой.</p>

(Эх сурвалж: “Гадаадын зарим улсын үндсэн хуулийн улс төрийн намын талаарх зохицуулалт ба намын санхүүжилт” СТ-18/2006. ПСХ. 2018 он)